



**МОНГОЛ УЛСЫН ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛ,
ХААИС, МУИС-ИЙН ХАМТАРСАН СУДАЛГААНЫ БАГ**



**ШҮҮГЧИЙН АЖЛЫН АЧААЛАЛ ТООЦОХ, ХЭРГИЙН КОЭФФИЦИЕНТ ТОДОРХОЙЛОХ,
БАТАЛГААЖУУЛАХ СУДАЛГАА**

АГУУЛГА

УДИРТГАЛ.....	5
ТОВЧИЛСОН ҮГСИЙН ЖАГСААЛТ	7
1.1 Эрүүгийн хавтаст хэргийн материалд хийсэн шинжилгээ	10
1.1.1 Эрүүгийн хавтаст хэргийн танилцуулга	10
1.1.2 Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үе шатуудад хийх шинжилгээ.....	11
1.1.3 Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны процесст хийх шинжилгээ.....	13
1.1.4 Давж заалдах шатны эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үе шатуудад хийх шинжилгээ.....	15
1.1.5 Эрүүгийн хавтаст хэргийн материалд хийсэн шинжилгээ бүлгийн дүгнэлт	17
1.2 Эрүүгийн хэргийн шүүхийн шүүгч нараас авсан асуумжид хийх шинжилгээ	18
1.2.1 Хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэсэн эрүүгийн хэргийн асуумжийн өгөгдөлд хийх шинжилгээ.....	19
1.2.2 Ердийн журмаар хянан шийдвэрлэсэн эрүүгийн хэргийн асуумжийн өгөгдөлд хийх шинжилгээ.....	28
1.2.3 Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхээс ирүүлсэн асуумжийн өгөгдөлд хийх шинжилгээ.....	30
1.3 Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх үйл ажиллагааны ажиглалтын өгөгдөлд хийх шинжилгээ.....	36
1.3.1 Хялбаршуулсан журмаар эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх үйл ажиллагааны ажиглалтын өгөгдөлд хийх шинжилгээ	36
1.3.2 Ердийн журмаар хянан шийдвэрлэсэн эрүүгийн хэргийн ажиглалтын өгөгдөлд хийх шинжилгээ.....	43
1.3.3 Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн хянан шийдвэрлэсэн хэргийн ажиглалтын өгөгдөлд хийх шинжилгээ.....	52
2.1 Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгч нараас авсан зөрчлийн хэргийн асуумжид хийх шинжилгээ.....	61
2.1.1 Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээр хянан шийдвэрлэсэн зөрчлийн хэргийн асуумжийн өгөгдөлд хийх шинжилгээ.....	61
2.1.2 Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгч нараас авсан зөрчлийн хэргийн асуумжид хийх шинжилгээ.....	64
2.2 Зөрчлийн хэргийн ажлын байрны ажиглалтын хүрээнд ирүүлсэн мэдээлэлд хийх шинжилгээ.....	70
2.2.1 Зөрчлийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үе шатуудад хийх шинжилгээ.....	70
2.2.2 Зөрчлийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд зарцуулах хугацааны өгөгдөлд хийх шинжилгээ.....	72
2.2.3 Давж заалдах шатны шүүхийн зөрчлийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үе шатанд хийх шинжилгээ	76
2.2.4 Зөрчлийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд зарцуулах хугацааны өгөгдөлд хийх шинжилгээ.....	78

2.2.5	Зөрчлийн хэргийн ажлын байрны ажиглалтын хүрээнд ирүүлсэн мэдээллийн дүгнэлт	84
3.1	Иргэний хавтаст хэргийн материалд хийсэн шинжилгээ	85
3.1.1	Ердийн журмаар шийдвэрлэсэн иргэний хавтаст хэргийн танилцуулга	85
3.1.2	Бага үнийн дүнтэй иргэний хавтаст хэргийн материалд хийсэн шинжилгээ.....	100
3.1.3	Хялбаршуулсан журмаар шийдвэрлэсэн иргэний хавтаст хэргийн анхан шатны шүүхийн ажиллагааны хавтаст хэргийн материалд хийсэн шинжилгээ	108
3.1.4	Иргэний хавтаст хэргийн материалд хийсэн шинжилгээний дүгнэлт	112
3.2	Иргэний хэргийн шүүхийн шүүгч нараас авсан асуумжид хийх шинжилгээ	114
3.2.1	Бага үнийн дүнтэй хэргийг хянан шийдвэрлэсэн иргэний хэргийн асуумжийн өгөгдөлд хийх шинжилгээ	114
3.2.1.1	Бага үнийн дүнтэй хэргийг хянан шийдвэрлэсэн иргэний хэргийн асуумжийн тухай	114
3.2.1.1	Бага үнийн дүнтэй иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үе шатуудад хийх шинжилгээ	115
3.2.2	Хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэсэн иргэний хэргийн асуумжийн өгөгдөлд хийх шинжилгээ	116
3.2.2.1	Хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэсэн иргэний хэргийн асуумжийн тухай	116
3.2.2.2	Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үе шатуудад хийх шинжилгээ	117
3.2.3	Ердийн журмаар хянан шийдвэрлэсэн иргэний хэргийн асуумжийн өгөгдөлд хийх шинжилгээ.....	118
3.2.3.1	Ердийн журмаар хянан шийдвэрлэсэн иргэний хэргийн асуумжийн тухай	118
3.2.3.2	Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үе шатанд хийх шинжилгээ ...	119
3.2.4	Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхээс ирүүлсэн асуумжийн өгөгдөлд хийх шинжилгээ.....	120
3.2.4.2	Давж заалдах шатны шүүхийн иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үе шатанд хийх шинжилгээ	121
3.2.4.3	Давж заалдах шатны шүүхийн иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үе шатны өгөгдөлд хийх шинжилгээ	122
3.2.5	Иргэний хэргийн анхан болон давж заалдах шатны шүүхээс ирүүлсэн асуумжийн дүгнэлт	124
3.3	Иргэний хэрэг хянан шийдвэрлэх үйл ажиллагааны ажиглалтын өгөгдөлд хийх шинжилгээ.....	126
3.3.1	Хялбаршуулсан журмаар иргэний хэрэг хянан шийдвэрлэх үйл ажиллагааны ажиглалтын өгөгдөлд хийх шинжилгээ	126
3.3.2	Ердийн журмаар хянан шийдвэрлэсэн иргэний хэргийн ажиглалтын өгөгдөлд хийх шинжилгээ	132
3.3.3	Бага үнийн дүнтэй иргэний хэргийн ажиглалтын өгөгдөлд	140
	хийх шинжилгээ	140

3.3.4 Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн хянан шийдвэрлэсэн хэргийн ажиглалтын өгөгдөлд хийх шинжилгээ	147
4.1 Захиргааны хавтаст хэргийн материалд хийсэн шинжилгээ	154
4.1.1 Хялбаршуулсан журмаар шийдвэрлэсэн захиргааны хавтаст хэргийн материалд хийх шинжилгээ.....	154
4.1.1.1 Хялбаршуулсан журмаар шийдвэрлэсэн захиргааны хавтаст хэргийн танилцуулга	154
4.1.1.2 Хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэсэн захиргааны хэргийн ажиллагааны төрөлд хийх шинжилгээ	156
4.1.2 Ердийн журмаар шийдвэрлэсэн захиргааны хавтаст хэргийн материалд хийх шинжилгээ.....	159
4.1.2.1 Ердийн журмаар шийдвэрлэсэн захиргааны хавтаст хэргийн танилцуулга	159
4.1.2.2 Ердийн журмаар шийдвэрлэсэн захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хийх шинжилгээ	163
4.1.3 Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн хавтаст хэргийн материалд хийх шинжилгээ.....	169
4.1.3.1 Давж заалдах шатны шүүхээс шийдвэрлэсэн захиргааны хавтаст хэргийн танилцуулга	169
4.1.3.2 Давж заалдах шатны шүүхийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хийх шинжилгээ	172
4.1.4 Захиргааны хавтаст хэргийн материалд хийсэн шинжилгээний дүгнэлт.....	176
4.2 Захиргааны хэргийн шүүхийн шүүгч нараас авсан асуумжид хийх шинжилгээ.....	182
4.2.1 Хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэсэн захиргааны хэргийн асуумжийн өгөгдөлд хийх шинжилгээ	182
4.2.1.1 Хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэсэн захиргааны хэргийн асуумжийн тухай.....	182
4.2.1.2 Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үе шатуудад хийх шинжилгээ	184
4.2.2 Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн хянан шийдвэрлэсэн хэргийн ажиглалтын өгөгдөлд хийх шинжилгээ.....	184
4.2.2.1 Давж заалдах шатны шүүхийн ажиглалтын өгөгдлийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны ерөнхий дүн ба үе шатуудын хувьд хийх шинжилгээ	184
4.2.2.2 ЗХДЗШШ-ийн гомдол хянан шийдвэрлэх ажиллагааны 1-3-р үе шатанд зарцуулах хугацааны өгөгдөлд хийх шинжилгээ.....	186
4.2.3 Ердийн журмаар хянан шийдвэрлэсэн захиргааны хэргийн асуумжийн өгөгдөлд хийх шинжилгээ.....	189
4.2.3.1 Ердийн журмаар хянан шийдвэрлэсэн захиргааны хэргийн асуумжийн тухай ...	189
4.2.3.2 Ердийн журмаар захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үе шатанд хийх шинжилгээ	190
4.2.3.3 Ердийн журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд зарцуулах хугацааны өгөгдөлд хийх шинжилгээ.....	192

4.2.4 Захиргааны хэргийн анхан болон давж заалдах шатны шүүхээс ирүүлсэн асуумжийн дүгнэлт.....	194
4.3 Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх үйл ажиллагааны ажиглалтын өгөгдөлд хийх шинжилгээ.....	195
4.3.1 ЗХАШШ-ийн хэрэг хянан шийдвэрлэх үйл ажиллагааны ажиглалтын өгөгдөлд хийх шинжилгээ.....	196
4.3.1.1 Ажиглалтын өгөгдлийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны ерөнхий дүн ба үе шатуудын хувьд хийх шинжилгээ.....	196
4.3.1.2 Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны 1-4-р үе шатанд зарцуулах хугацааны өгөгдөлд хийх шинжилгээ.....	198
4.3.2 Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн хянан шийдвэрлэсэн хэргийн ажиглалтын өгөгдөлд хийх шинжилгээ.....	204
5. Шүүгчийн ажлын ачаалал болон хэргийн коэффициент тодорхойлох шинжилгээ	208
5.1 Эрүүгийн хэргийн шүүгчийн ажиллагаанд зарцуулах хугацаа тооцох коэффициентийн шинжилгээ.....	208
5.2 Зөрчлийн хэрэг хянан шийдвэрлэсэн шүүгчийн ажлын ачаалал тооцох коэффициентийн шинжилгээ.....	212
5.3 Иргэний хэргийн шүүгчийн ажлын ачаалал тооцох коэффициентийн шинжилгээ.....	214
5.4 Захиргааны хэргийн шүүгчийн ажлын ачаалал тооцох коэффициентийн шинжилгээ	217
5.5 Шүүгчийн ажлын ачааллын дүгнэлт	220
ДҮГНЭЛТ	224
САНАЛ.....	229
ЗӨВЛӨМЖ.....	231
ХАВСРАЛТ 1.	233
ХАВСРАЛТ 2.	233
ХАВСРАЛТ 3.	234
ХАВСРАЛТ 4.	236
ХАВСРАЛТ 5.	240
ХАВСРАЛТ 6.	248
ХАВСРАЛТ 7.	252

УДИРТГАЛ

Шүүхийн ерөнхий зөвлөл нь нийслэлийн анхан шатны 19, аймгийн анхан шатны 63, сум дундын 8, давж заалдах шатны 26, нийт 116 анхан болон давж заалдах шатны шүүхийг удирдлага, хүний нөөц, бодлого төлөвлөлтөөр бүрэн хангахын тулд тасралтгүй судалгаа, шинжилгээ хийх хэрэгцээ шаардлага бий. Шүүгчийн ажлын ачааллыг зөв тодорхойлж, шүүгчийн нэг жилд хянан шийдвэрлэх хэргийн тооны жишиг нормыг бодитой тооцсоноор шүүгчийн хөдөлмөрийн хуваарилалт тэгш байх нөхцөлийг бүрдүүлэх суурь болох юм. Мөн шүүхээс иргэдэд шударга, ил тод, шуурхай, чанартай үйлчилгээ үзүүлэх боломжоор хангах нөхцөл шүүгчийн ажлын ачаалалтай салшгүй холбоотой ойлголт юм.

Шүүхийн салбарт хүний нөөц, шүүхүүдийн дотоод бүтцийн зөв зохион байгуулалт, ажил үүргийн оновчтой хуваарилалт, шүүхийн байр, барилга байгууламжийн хүрэлцээтэй байдал, шүүхийн үйлчилгээ үзүүлэх буюу ажлын байрны хангалттай талбай зэрэг тулгамдаж буй олон асуудал байна.

Шүүгчийн ажил үүрэг, хөдөлмөрийн оновчтой хуваарилалтыг судалж шүүгчийн нэг жилд хянан шийдвэрлэх хэргийн тооны жишиг нормыг тооцож, эрүү, зөрчил, иргэн, захиргааны нэг хэргийг хянан шийдвэрлэхэд шаардагдах хугацааны тухай санал дэвшүүлэхийн тулд хавтаст хэргийн материалд уншилт хийсэн өгөгдөл, шүүхүүдээс ирүүлсэн асуумжийн өгөгдөл, шүүгчийн ажлын байрны зураг авалтын өгөгдөл зэргийг ашиглан боловсруулалт ба шинжилгээ хийсэн үр дүнг энэхүү тайланд танилцуулж байна.

Судалгааны ажилд орхигдсон тайлбар, дутуу дүгнэлт, хэллэг байвал тухайн хэсгийг хариуцаж хийсэн ажилтан, судлаачтай шууд холбогдох боломжтой.

Судалгааны багт хамтран ажилласан МУИС, ХААИС-ийн багш нар, Шүүхийн ерөнхий зөвлөлийн ажлын албаны хамт олонд талархал илэрхийлье.

Судалгааны ажлын бүлгүүд дээр дараах багш нар болон Шүүхийн ерөнхий зөвлөлөөс томилогдсон ажлын хэсгийн гишүүд ажиллав. Тодруулах, лавлах зүйл, шүүмж, санал хүсэлтийг дараах цахим хаяг болон холбоо барих дугаараар холбогдож ирүүлнэ үү. Та бүхний санал, хүсэлт, зөвлөгөө, шүүмж бидэнд үнэтэй байх болно.

1-р бүлгийн агуулгыг	Д.Цэвээннамжил tseveennamjil.d@mul.s.edu.mn/ 99065089
2-р бүлгийн агуулгыг	Э.Ганцэцэг gantsetseg@judcouncil.mn/ 90900407
3-р бүлгийн агуулгыг	З.Баянсүрэн bayansuren@judcouncil.mn/ 88782404 П.Ангарагсайхан angaragsaikhan@judcouncil.mn/ 88058056 Д.Цэвээннамжил tseveennamjil.d@mul.s.edu.mn/ 99065089
4-р бүлгийн агуулгыг	М.Цэдэвсүрэн tsedevsuren@judcouncil.mn/ 93139666 Т.Түвшинбаяр tuvshinbayar@judcouncil.mn/

	91507080
	Д.Цэвээннамжил /tseveennamjil.d@mul.s.edu.mn/ 99065089
5-р бүлгийн агуулгыг	Д.Цэвээннамжил /tseveennamjil.d@mul.s.edu.mn/ 99065089
	Б.Барсболд / barsbold@seas.num.edu.mn / 99166212
Дүгнэлтийн агуулгыг	Д.Цэвээннамжил /tseveennamjil.d@mul.s.edu.mn/ 99065089
	Э.Ганцэцэг /gantsetseg@judcouncil.mn/ 90900407
	П.Ангарагсайхан /angaragsaikhan@judcouncil.mn/ 88058056
	М.Цэдэвсүрэн /tsedevsuren@judcouncil.mn/ 93139666
	З.Баянсүрэн /bayansuren@judcouncil.mn/ 88782404
	Т.Түвшинбаяр /tuvshinbayar@judcouncil.mn/ 91507080

ТОВЧИЛСОН ҮГСИЙН ЖАГСААЛТ

АШШ- Анхан шатны шүүх

АЭХАШШ-Аймгийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүх

ДЗШШ- Давж заалдах шатны шүүх

ДИХАШШ- Дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүх

ДЭХАШШ- Дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүх

ЗХАШШ- Захиргааны хэргийн анхан шатны шүүх

ИХАШШ- Иргэний хэргийн анхан шатны шүүх

СДИХАШШ- Сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх

СДЭХАШШ- Сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх

СДШ- Сум дундын шүүх

ИХШХШТХ-Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль

ХХША- Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа

ЕШ- Ерөнхий шүүгч

ЗХДЗШШ- Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх

ЗХХША- Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа

НБ- Нотлох баримт

УХ- Урьдчилсан хэлэлцүүлэг

ХХША- Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа

ШЗ- Шүүгчдийн зөвлөгөөн

ШИНБ- Шинээр илэрсэн нөхцөл байдлын хүсэлт

ШХ- Шүүх хуралдаан

ШЗтогтоол-Шүүгчдийн зөвлөгөөний тогтоол

ШХтэмдэглэл-Шүүх хуралдааны тэмдэглэл

ЕШзахирамж-Ерөнхий шүүгчийн захирамж

ШШГТХ-Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль

Дгомдол-Давж заалдах гомдол

Хгомдол-Хяналтын гомдол

ШТдавах-Шүүхийн тогтоол /давж заалдах шатны/

АМ - Ашигт малтмалын маргаан

НД - Нийгмийн даатгалтай холбоотой маргаан

УБ - Улсын бүртгэлтэй холбоотой маргаан

ЭМ - Нийтийн эрүүл мэндтэй холбоотой маргаан

СЗХ - Санхүүгийн зохицуулах хороотой холбоотой маргаан

ӨМЧ - Нийтийн өмчийг хамгаалахтай холбоотой маргаан

ТБОН - Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авахтай холбоотой маргаан

ГААЛЬ -Гаальтай холбоотой маргаан

ГАЗАР - Газрын маргаан

ОЮУНЫ -Оюуны өмчтэй холбоотой маргаан

ТАТВАР -Татварын маргаан

ТЭЭВЭР -Зам тээвэртэй холбоотой маргаан

ХҮҮХЭД -Хүүхдийн эрхтэй холбоотой маргаан

БАЙГАЛЬ -Байгаль орчныг хамгаалахтай холбоотой маргаан

БАРИЛГА -Барилгын эрх зүйн маргаан

ЗОХИОГЧ - Зохиогчийн эрх, барааны тэмдэгтэй холбоотой маргаан

БАЙЦААГЧ -Улсын байцаагчийн акттай холбоотой маргаан

БОЛОВСРОЛ -Боловсролтой холбоотой маргаан

ЗӨВШӨӨРӨЛ - Тусгай зөвшөөрөлтэй холбоотой маргаан

ӨРСӨЛДӨӨН - Шударга бус өрсөлдөөнийг хянан зохицуулах, хэрэглэгчийн эрх ашигтай холбоотой маргаан

ТӨРИЙН АЛБА - Төрийн албаны маргаан

ТӨРИЙН ХЯНАЛТ -Төрийн хяналт, шалгалттай холбоотой маргаан

ХХША – Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа

АЛБАДАН -Албадан гүйцэтгэх захирамж хянаж, гарын үсэг зурах

ГХУУДАС - Гүйцэтгэх хуудас хянаж гарын үсэг зурах

ЭМХЭТГЭХ -Хэргийг эмхэтгэснийг хянаж, гарын үсэг зурах

УТХ ШАЛГАХ -Улсын тэмдэгтийн хураамж төлсөн эсэхийг шалгах

НЭХЭМЖЛЭЛТЭЙ ТАНИЛЦАХ -Нэхэмжлэл, түүнд хавсаргасан баримттай уншиж танилцах

ТУСЛАХЫН АЖЛЫГ ХЯНАХ - Нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах үндэслэл байгаа эсэхийг шалгасан туслахын ажиллагааг хянах

НЭХЭМЖЛЭЛИЙН БҮРДҮҮЛБЭР ХАНГУУЛАХ - Нэхэмжлэлийн бүрдүүлбэр хангуулах хугацаа тогтоох, хэрэг үүсгэх, буцаах, татгалзах тухай захирамж гаргах

ХЭЛЭЛЦҮҮЛЭХ - Хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцүүлэх тухай захирамжийг хянах, гарын үсэг зурах

ТЭМДЭГЛЭЛ – Шүүх хуралдааны тэмдэглэл хянаж, гарын үсэг зурах

ХУРАЛДААН –Шүүх хуралдаан

ИТӨЛӨӨЛӨГЧ –Шүүхийн иргэдийн төлөөлөгчид мэдээлэл өгсөн баримтыг хянаж, гарын үсэг зурах

ТОВ МЭДЭГДЭХ -Хэргийн оролцогчдод шүүх хуралдааны тов мэдэгдэх хуудсыг хянаж, гарын үсэг зурах

ДАН – дангаар

ҮНДЭСЛЭЛ – Шүүхээс гарсан шийдвэрийн тогтоох хэсгийг танилцуулах, үндэслэлийг тайлбарлах

ДАРГАЛСАН –Бүрэлдэхүүнд даргалсан



1.1 Эрүүгийн хавтаст хэргийн материалд хийсэн шинжилгээ

Эрүүгийн хэргийн шүүгчийн хянан шийдвэрлэсэн хэргийн ажиллагааны ачааллыг бодитой зөв тодорхойлохын тулд ШЕЗ-ийн судалгаа шинжилгээний баг эрүүгийн хэргийн 12 зүйл, хэсэгт заасан нийт 30 хавтаст хэргийн материалтай уншиж танилцан, тоон мэдээлэл цуглуулж шинжилгээ хийсэн үр дүнг энэ бүлэг танилцуулна. Судалгаанд дараах гэмт хэргийн төрөлд хамаарах хавтаст хэргүүдийг сонгон судалсан. Үүнд:

11.1-1 - Хүний эрүүл мэндэд хүнд хохирол санаатай учруулах

11.4-1 - Хүний эрүүл мэндэд хүндэвтэр хохирол санаатай учруулах

11.6-1, 2 - Хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол санаатай учруулах

17.1-1, 2 - Хулгайлах

17.3-1 - Залилах

17.5-1 - Алдаатай гүйлгээ, андуурагдсан илгээмж, гээгдэл эд хөрөнгө, алдуул мал завиших


20.7-1- Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах

17.12.1- Мал хулгайлах


27.10-1, 2- Авто тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих

1.1.1 Эрүүгийн хавтаст хэргийн танилцуулга


Эрүүгийн хуулийн зүйл, ангиар хавтаст хэргийн ажиллагааны тоог дараах зургаар харуулав. Зураг 1.1.1-ээс харвал 11.6-1-ийн нийт 5 хавтаст хэргийн дотроос 1-р хавтаст хэрэг хамгийн олон буюу 28 ажиллагаа хийгдсэн байна. Эдгээр 30 хэргээс хамгийн бага буюу 14 ажиллагаатай 4 хэрэг судалгаанд сонгогдсон байна.



Эрүүгийн хуулийн зүйл, ангиар хавтаст хэргийн хуудасны тоог доорх зургаар харуулав. Зураг 1.1.2-оос харвал 11.1-1-ийн 1-р хавтаст хэрэг, 17.3-1-ийн 2, 3-р хавтаст хэрэг хамгийн олон хуудастай байсан байна. Эдгээр 30 хэргээс хамгийн цөөн буюу 23-25 хуудастай 4 хавтаст хэрэг судалгаанд сонгогдсон байна.




Эрүүгийн хуулийн зүйл, ангиар хавтаст хэргийн ажиллагаанд зарцуулсан хугацааг хоногоор хуудасны тоог дараах зургаар харуулав. Зураг 1.1.3-аас харвал 11.1-1-ийн 1-р хавтаст хэрэг хамгийн олон буюу 165.4 хоног зарцуулсан хэрэг байна. Харин 17.5-1-ийн 1-р хавтаст хэрэг 38.9 хоног зарцуулсан нь бусдаасаа хамгийн цөөн хоног зарцуулсан байна.



Зураг 1.1.3 Хавтаст хэргийн ажиллагаанд зарцуулсан хугацаа, хоногоор

1.1.2 Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үе шатуудад хийх шинжилгээ

Эрүүгийн хавтаст хэргийн танилцуулга бүлэгт дурдсан 30 хавтаст хэргийн мэдээллийг эрүүгийн хуулийн зүйл, анги тус бүрээр дундажлаж илэрхийлсэн мэдээллийг Зураг 1.1.4-д харуулав. Дараах зургийн анхаарал татсан хэргийн хувьд 11.6-2-ийн 27 ажиллагаатай, 60 хуудастай, 99.6 хоног зарцуулсан хэрэг судалгаанд сонгогдсон байна. Мөн 27.10-2-ийн 25 ажиллагаатай, 51 хуудастай, 147.7 хоног зарцуулсан хавтаст хэрэг судалгаанд сонгогдсон байна. Судалгаанд сонгогдсон хавтаст хэргийг ерөнхийд нь дүгнэвэл дунджаар 16.5-27 ажиллагаатай, 28.3-60 хуудастай, 56-147.7 хоног зарцуулж шийдвэрлэгдсэн хэргүүд эрүүгийн хавтаст хэргийн ачааллыг тодорхойлох зорилгын хүрээнд сонгогдсон байна.



Зураг 1.1.4 Хавтаст хэргийн мэдээлэл

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үе шатуудад хийсэн 2 ба 3 хүчин зүйлийн дисперсийн шинжилгээний программын үр дүн дээр тулгуурлан хамаарлын коэффициентуудыг тооцов.

№	Үзүүлэлт	Детерминацийн коэффициент	Корреляцийн коэффициент	Вариацийн коэффициент	Дундаж
1	Эрүүгийн хэрэг	-	-	-	18.3
2	Хэргийн үе	0.04	0.20	175%	6.1
3	Ажиллагаа	0.03	0.16	263%	1.7

Хүснэгт 1.1.1 Хавтаст хэргийн ажиллагааны тоонд нөлөөлөх хүчин зүйлүүд

Хүснэгт 1.1.1-ийн 2-р мөрийн утгыг тайлбарлая. Эрүүгийн хавтаст хэргийн ажиллагааны тооны өөрчлөлтийн 0.04 нь хэргийн үеэс хамаарч байна. Эрүүгийн хавтаст хэргийн ажиллагааны тоо хэргийн үеэс 0.20 буюу сул хамааралтай байна. Вариацийн коэффициент 175% байгаа нь тоон үзүүлэлтүүд нэгэн төрлийн биш бөгөөд дунджийн төлөөлөх чадвар сул байна.

№	Үзүүлэлт	Детерминацийн коэффициент	Корреляцийн коэффициент	Вариацийн коэффициент	Дундаж
1	Эрүүгийн хэрэг	0.64	0.80	22%	36
2	Хэргийн үе	0.02	0.12	424%	12
3	Ажиллагаа	0.05	0.21	319%	3.3


Хүснэгт 1.1.2 Хавтаст хэргийн хуудасны тоонд нөлөөлөх хүчин зүйлүүд



№	Үзүүлэлт	Детерминацийн коэффициент	Корреляцийн коэффициент	Вариацийн коэффициент	Дундаж
1	Эрүүгийн хэрэг	0.39	0.63	30%	69
2	Хэргийн үе	0.01	0.10	559%	23
3	Ажиллагаа	0.07	0.26	553%	7.2


Хүснэгт 1.1.3 Хавтаст хэргийн ажиллагаанд зарцуулах хугацаанд нөлөөлөх хүчин зүйлүүд

Зураг 1.1.5-ын эхний зургаас харвал хэрэг хүлээн авснаас хойших ажиллагааны үе шатанд дунджаар нэг хэргийн нийт ажиллагааны 21.3% буюу 3.9 ажиллагаа, хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхэд бэлтгэх ажиллагааны үе шатанд 41% буюу 7.5 ажиллагаа, хэргийг эцэслэн шийдвэрлэсний дараах ажиллагааны үе шатанд 37.7% буюу 6.9 ажиллагаа явуулсан байна. Зураг 1.1.5-ын хоёрдугаар зургийн хувьд хэрэг хүлээн авснаас хойших ажиллагааны үе шатанд дунджаар нэг хэргийн нийт материалын 15.9% буюу 5.7 хуудас, хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхэд бэлтгэх ажиллагааны үе шатанд 63.2% буюу 22.7 хуудас, хэргийг эцэслэн шийдвэрлэсний дараах ажиллагааны үе шатанд 20.9% буюу 7.5 хуудас материалаас бүрдсэн байна.




Зураг 1.1.5 Хавтаст хэргийн ажиллагааны үе шатын мэдээлэл

Зураг 1.1.5-ын сүүлийн зургийн хувьд хэрэг хүлээн авснаас хойших ажиллагааны үе шатанд дунджаар нэг хэрэгт зарцуулсан нийт хугацааны 15.8% буюу 10.9 хоног, хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхэд бэлтгэх ажиллагааны үе шатанд 11.6% буюу 8 хоног, хэргийг эцэслэн шийдвэрлэсний дараах ажиллагааны үе шатанд 72.6% буюу 50 хоног тус тус зарцуулсан байна.




Зураг 1.1.6 Хэрэг хянан шийдвэрлэх үе шатанд хамаарах ажиллагааны тоо, хэргийн төрлөөр

Зураг 1.1.5-д харуулсан ерөнхий мэдээллийг гэмт хэргийн төрөл тус бүрээр Зураг 1.1.6-1.1.8-д дэлгэрэнгүй харуулав. Зураг 1.1.6-аас харвал хэрэг хянан шийдвэрлэх 1-р үе шатанд 11.6-2-ийн ажиллагаа хамгийн их буюу 12 бөгөөд бусад гэмт хэргийн ажиллагааны тоо 2.5-5 буюу ойролцоо ажиллагаа явуулсан байна. 2-р үе шатанд 27.10-1,2-д заасан гэмт хэргийн ажиллагаа хамгийн их буюу 9.7, 15 байна. Энэ үе шатанд бусад гэмт хэргийн ажиллагаа тоо 6-8 буюу ойролцоо байна. 3-р үе шатанд гэмт хэргийн төрлөөс үл хамаарч ажиллагаа ойролцоо явагдсан байна.



Зураг 1.1.7 Хэрэг хянан шийдвэрлэх үе шатанд хамаарах хавтаст хэргийн материал, хуудасны тоогоор

Зураг 1.1.7-оос харвал хэрэг хянан шийдвэрлэх 1-р үе шатанд 11.6-2-ийн материалын хуудасны тоо хамгийн их буюу 21 байна. Бусад гэмт хэргийн материалын хуудасны тоо 4-8 хуудас байна. 2-р үе шатанд 11.1-1, 17.3-1, 27.10-2-д заасан гэмт хэргийн материалын хуудасны тоо хамгийн их буюу 31-42 байна. Энэ үе шатанд бусад гэмт хэргийн материалын хуудасны тоо 16-25 байна. 3-р үе шатанд гэмт хэргийн төрлөөс үл хамаарч материалын хуудасны тоо ойролцоо байна.




Зураг 1.1.8 Хэрэг хянан шийдвэрлэх үе шатанд хамаарах хавтаст хэрэгт зарцуулсан хугацаа, хоногоор


Зураг 1.1.8-аас харвал хэрэг хянан шийдвэрлэх 1-р үе шатанд 11.6-2-ын ажиллагаанд зарцуулсан хугацаа хамгийн их буюу 44.5 хоног байна. Энэ үе шатанд 17.1-2, 17.3-1, 17.12-1-ийн ажиллагаанд зарцуулсан хугацаа хамгийн бага буюу 1.2-5.2 хоног байна. Бусад гэмт хэргийн ажиллагаанд зарцуулсан хугацаа 7.6-18.1 хоног байна. 2-р үе шатанд 11.1-1, 27.10-1,2-ын ажиллагаанд зарцуулсан хугацаа хамгийн их буюу 16-43.9 хоног байна. 3-р үе шатанд судалгаанд хамрагдсан гэмт хэргийн төрлийн хувьд ажиллагаанд зарцуулсан хугацаа өмнөх 1, 2-р үе шатнаас эрс өндөр дүнтэй байна. Үүний дотор 17.12-1, 27.10-2-ын ажиллагаанд зарцуулсан хугацаа хамгийн их буюу 73.5-86.2 хоног байна.

1.1.3 Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны процесст хийх шинжилгээ

Өмнөх бүлгийн Зураг 1.1.6-1.1.8-д харуулсан хэрэг хянан шийдвэрлэх үе шатыг ямар төрлийн ажиллагаанаас хамаарч харилцан адилгүй үзүүлэлттэй байгааг хэргийн ажиллагаа тус бүрээр дэлгэрэнгүй тайлбарлан харуулъя.



Зураг 1.1.9 Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны тоо, хэргийн үе шатаар




Криминал гэмт	1-р үе шат	2-р үе шат	3-р үе шат
Баримт	1.3	4	5.2
Хүсэлт	1	1.3	1
Бүртгэл	0	1	1
Дүгнэлт	0	2.1	0
Захирамж	2.7	2.3	2
Тэмдэглэл	1	1	1.1
Албан бичиг	1.2	0	1.1
ЕШЗахирамж	0	0	0
Давах гомдол	0	0	2
ШХТэмдэглэл	5.5	6.6	2.3
Нотлох баримт	0	7.3	0
Шийтгэх тогтоол	0	7.6	0
Прокурорын санал	0	1	0
Шүүхэд шилжүүлэх	0	1	0
Прокурорын эсэргүүцэл	0	0	0

Зураг 1.1.11 Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны материалын хуудас, хэргийн үе шатаар

Enterprise Type	Barimt	Шүүх хуралдааны тэмдэглэл	Нотлох баримт	Шийтгэх тогтоол
11.1-1	3	10	4	12
11.4-1	3.7	5.7	4	5.7
11.6-1	3.5	6.2	2	6.6
11.6-2	5	4.5	0	8
17.1-1	3.3	5	3	5.3
17.1-2	3.7	6	4	5.3
17.3-1	3.3	6.7	20	13.7
17.5-1	2.5	5	1	5.3
17.10-1	4	6	0	8
17.10-2	4.7	8	0	7.5
20.7-1		6.3		11
27.10-1		12		


*Зураг 1.1.12 Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны материалын хуудасны хувьд нөлөөлөх үзүүлэлт,
хэргийн төрлөөр*

Зураг 1.1.8-ын үр дүнг Зураг 1.1.13-д хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны төрлийг зарцуулсан хоногоор задлан харуулав.



Зураг 1.1.13 Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд зарцуулсан хоног, хэргийн үе шатаар

Зургаас харвал хэрэг шийдвэрлэх үйл ажиллагаанд зарцуулсан хоногийн хувьд 1, 3-р үеийн албан бичиг, 3-р үеийн баримт хамгийн их хугацаа зарцуулсан болох нь харагдаж байна. Эдгээр үеүдэд хамгийн их ажиллагаа орсон баримт, албан бичиг зэрэг нь ямар хэргийн зүйл, анги дээр хамгийн их байгааг Зураг 1.1.14-д (программын үр дүн) харуулав.




Зураг 1.1.14 Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд зарцуулсан хоногийн хувьд нөлөөлөх үзүүлэлт, хэргийн төрлөөр¹

Зураг 1.1.14-өөс харвал гэмт хэргийн судалгаанд авч үзсэн хавтаст хэргийн баримтад зарцуулсан хугацааны хувьд 17.12-1-д 25 хоног, 27.10-2-д 32 хоног байна. Албан бичгийн хувьд 11.1-1-д 30 хоног зарцуулсан байна. Ерөнхий шүүгчийн захирамжийн хувьд 11.6-2-д хамгийн их буюу 32 хоног тус зарцуулсан байна.

1.1.4 Давж заалдах шатны эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үе шатуудад хийх шинжилгээ

Өмнөх дэд бүлгүүдэд шинжилгээ хийгдсэн эрүүгийн 30 хавтаст хэргээс давж заалдах шатны шүүхэд шилжсэн 3 хэргийн материал дээр ШЕЗ-ийн судалгааны баг ажилласан үр дүнг энэ дэд бүлэгт танилцуулна. Зураг 1.1.15-аас харвал жишээ нь 11.1-1 хавтаст хэрэгт 14 ажиллагаа явагдсан бөгөөд 29 хуудастай 82.4 хоног зарцуулсан байна.




Зураг 1.1.15 Давж заалдах шатны шүүхийн эрүүгийн хавтаст хэргийн материалын мэдээлэл

Давж заалдах шатны эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үе шатад дисперсийн шинжилгээний үр дүнг дараах зургаар харуулав. Зураг 1.1.16-гийн эхний зургаас харвал хэрэг хянан шийдвэрлэх үйл ажиллагаа 2 шаттай явагдсан бөгөөд үүнээс хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхэд бэлтгэх үе шатанд нэг хэргийн нийт ажиллагааны 48.2% буюу 5.3 ажиллагаа, хэргийг эцэслэн шийдвэрлэсний дараах үе

¹ Хавтаст хэргийн судалгааны ажиллагаанд зарцуулагдаж байгаа хугацаа буюу хоногийг тооцохдоо эхний ажиллагааны он, сар, өдрөөс дараагийн ажиллагааны он сар өдөр дээр үндэслэн тооцож гарсан бөгөөд тухайн ажиллагааг боловсруулсан хугацаа биш болохыг анхаарна уу. Өөрөөр хэлбэл хавтаст хэргийн судалгааны ажиллагаанд зарцуулсан хоног гэдэгт боловсруулснаас танилцуулах хүртэлх хугацааг илэрхийлнэ.



шатанд нэг хэргийн нийт ажиллагааны 51.8% буюу 5.7 ажиллагаа явуулсан байна. Дараагийн зургийн хувьд хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхэд бэлтгэх үе шатанд нэг хэргийн нийт материалын 70% буюу 14 хуудас, хэргийг эцэслэн шийдвэрлэсний дараах үе шатанд нэг хэргийн нийт материалын 30% буюу 6 хуудас материалаас бүрдсэн байна.




Ажиллагаа Хуудас Хугацаа

Зураг 1.1.16 Давж заалдах шатны шүүхийн эрүүгийн хэргийн ажиллагааны үе шат


Зураг 1.1.16-гийн сүүлийн зургийн хувьд хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхэд бэлтгэх үе шатанд 25.9% буюу 14.3 хоног, хэргийг эцэслэн шийдвэрлэсний дараах үе шатанд 74.1% буюу 41 хоног тус тус зарцуулсан байна.

Зураг 1.1.16-д харуулсан ерөнхий мэдээллийг гэмт хэргийн төрөл тус бүрээр Зураг 1.1.17-д дэлгэрэнгүй оруулав. Зураг 1.1.17-гийн эхний зургаас харвал давж заалдах шатны хэрэг хянан шийдвэрлэх 1-р үе шатанд ажиллагаа хийгдээгүй бөгөөд 2-р үе шатанд 11.1-1-д 5, 17.1-1-д 7 ажиллагаа хийгдэж, 11.6-2-д 4 буюу хамгийн бага ажиллагаа явуулсан байна.




Зураг 1.1.17 ДЗШШ-ийн хэрэг хянан шийдвэрлэх үе шатанд хамаарах ажиллагааны тоо, хэргийн төрлөөр

Зураг 1.1.17-гийн 2-р зургаас харвал давж заалдах шатны хянан шийдвэрлэх 2-р үе шатанд 11.1-1-д 19, 17.1-1-д 14 хуудас материал үйлдэгдсэн байна. 3-р үе шатанд 11.1-1-д 10 хуудас буюу хамгийн их материал үйлдэгдсэн байна. 3-р зургаас харвал 3-р үе шатанд 11.1-1-д 63 хоног, 17.1-1-д 52 хоног буюу хамгийн олон хоног зарцуулсан байна.



Зураг 1.1.18 ДЗШШ-ийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны тоо, нөлөөлөх үзүүлэлт

Зураг 1.1.17-д харуулсан давж заалдах шатны шүүхийн хэрэг хянан шийдвэрлэх үе шатуудыг хэргийн ажиллагаа тус бүрээр Зураг 1.1.18-1.1.20-д ажиллагааны төрөл тус бүрээр задлан харуулъя. Зураг 1.1.18-ын эхний зургаас харвал давж заалдах шатны хэрэг шийдвэрлэх үйл ажиллагааны тооны хувьд 2 ба 3-р үеийн баримт, 3-р үеийн албан бичиг хамгийн их ажиллагаа шаарддаг болох нь харагдаж байна. Дараагийн зургаас харвал 11.1-1 ба 17.1-1-ийн баримт 3-4 ажиллагаатай байна. Албан бичгийн хувьд 11.1-1-д хамгийн их буюу 4 ажиллагаа орсон байна.



Зураг 1.1.19 ДЗШШ-ийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хуудасны тоо, нөлөөлөх үзүүлэлт

Зураг 1.1.19-ийн эхний зургаас харвал давж заалдах шатны шүүхийн хэрэг шийдвэрлэх үйл ажиллагааны материалын хуудасны хувьд 2-р үеийн магадлал, 3-р үеийн баримт хамгийн их хуудастай байсан байна. Зураг 1.1.19-ийн дараагийн зургаас харвал 11.1-1-д 4.5 хуудас баримт байсан байна. Магадлалын хувьд 11.1-1-д 11 хуудас буюу хамгийн олон хуудас баримт байсан байна. Нэр дурдсан хэргийн материалууд хуудасны тоог харьцангуй өндөр харагдуулах нөхцөлийг бүрдүүлсэн байна.



Зураг 1.1.20 ДЗШШ-ийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд зарцуулсан хугацаа, нөлөөлөх үзүүлэлт

Зураг 1.1.20-ийн эхний зургаас харвал давж заалдах шатны хэрэг шийдвэрлэх үйл ажиллагаанд зарцуулсан хугацааны хувьд 2-р үеийн ерөнхий шүүгчийн захирамж, 3-р үеийн баримт, албан бичигт хамгийн их хугацаа зарцуулсан байна. Зураг 1.1.20-ийн дараагийн зургаас харвал 17.1-1-ийн баримт бүрдүүлэхэд 12 хоног, ерөнхий шүүгчийн захирамж бүрдүүлэхэд 9 хоног зарцуулсан байна. 11.1-1-д албан бичиг бүрдүүлэхэд хамгийн их буюу 53 хоног зарцуулсан байна. Нэр дурдсан хэргийн материалууд хэрэг хянан шийдвэрлэх үйл ажиллагаанд зарцуулсан хугацааг харьцангуй өндөр харагдуулах нөхцөлийг бүрдүүлсэн байна.

1.1.5 Эрүүгийн хавтаст хэргийн материалд хийсэн шинжилгээ бүлгийн дүгнэлт

Эрүүгийн хэргийн анхан болон давж заалдах шатны шүүхийн хавтаст хэргийн материалын өгөгдөлд хийсэн шинжилгээний үр дүнг дараах хүснэгтэд харьцуулан харуулъя.

№	Хэргийн үе	Ажиллагаа		Хуудас		Хоног	
		Анхан	Давах	Анхан	Давах	Анхан	Давах
1	Хэрэг хүлээн авснаас хойших үе	21.3%	-	15.9%	-	15.8%	-
2	Хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхэд бэлтгэх үе	41%	48.2%	63.2%	70%	11.6%	25.9%
3	Хэргийг эцэслэн шийдвэрлэсний дараах үе	37.7%	51.8%	20.9%	30%	72.6%	74.1%

Хүснэгт 1.1.4 Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үе шатуудын харьцуулалт

Өмнөх дэд бүлгүүдэд тайлбарласан шинжилгээний үр дүнгүүд дээр үндэслэн ямар төрлийн хэргийн хэддүгээр үе дээр хэргийн ямар ажиллагааны тоо, хавтаст хэргийн хуудас, хэрэг хянан шийдвэрлэсэн хугацаа зэрэг нь өндөр утгатай байгааг дараах хүснэгтээс харна уу.



№	Хэргийн ажиллагаа	Хэргийн үе	Хэрэг	Ажиллагаа		Хуудас		Хоног	
				Анхан	Давах	Анхан	Давах	Анхан	Давах
1	Баримт	2	27.10-2	8	-	9	-	22	-
			11.1-1	5	5	5	6	1	10
		3	17.1-1	5	4	5	4	35	24
			17.1-2	6	-	6	-	49	-
			17.12-1	5	-	5	-	73	-
			27.10-1	5	-	6	-	49	-
			27.10-2	4	-	4	-	74	-
2	Магадлал	2	11.1-1	-	1	-	10	-	0.1
3	Албан бичиг	1	11.6-1	1	-	1	-	14	-
		3	11.1-1	-	4	-	4	-	53
			20.7-1	2	-	2	-	24	-
4	Ерөнхий шүүгчийн захирамж	1	11.6-2	2	-	2	-	32	-
		2	11.1-1	-	-	-	-	-	15
			17.1-1	-	-	-	-	-	9
5	Шүүх хуралдааны тэмдэглэл	2	11.1-1	1	-	10	-	12	-
6	Нотлох баримт	2	11.1-1	4	-	11	-	-	-
			17.3-1	1	-	20	-	-	-
7	Шийтгэх тогтоол	2	17.3-1	14	-	14	-	0.1	-

Хүснэгт 1.1.5 Хавтаст хэргийн ажиллагааны дүгнэлт

Хүснэгт 1.1.5-ын эхний мөрийн утгыг тайлбарлая. 27.10-2-ийн хэрэг хянан шийдвэрлэх 2-р үе шатны баримт нь 8 ажиллагаатай 9 хуудастай хэрэг байсан бөгөөд 22 хоногт уг баримтуудыг бүрдүүлсэн байна. Бусад мөрийн утгыг тайлбар өгсөнтэй ижил утгаар ойлгоно.

1.2 Эрүүгийн хэргийн шүүхийн шүүгч нараас авсан асуумжид хийх шинжилгээ

Эрүүгийн хэргийн шүүгчийн хянан шийдвэрлэсэн хэргийн ажиллагааны ачааллыг бодитой тодорхойлохын тулд ШЕЗ-ийн судалгаа шинжилгээний баг Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан 10 төрлийн гэмт хэргийн зүйл ангид заасан үзүүлэлтийн хүрээнд шүүгч нараас асуумж авч тоон мэдээлэл цуглуулан шинжилгээ хийсэн үр дүнг энэ бүлэгт танилцуулна. Судалгаанд дараах гэмт хэргийн төрөлд хамаарах асуумжийг авсан. Үүнд:

10.1-1 - Хүнийг алах

11.1 - Хүний эрүүл мэндэд хүнд хохирол учруулах

11.4-1 - Хүний эрүүл мэндэд хүндэвтэр хохирол санаатай учруулах

11.6-1, 2 - Хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол санаатай учруулах

12.1 - Хүчиндэх

17.1-1 - Хулгайлах

17.3-1 - Залилах

17.5-1 - Алдаатай гүйлгээ, андуурагдсан илгээмж, гээгдэл эд хөрөнгө, алдуул мал завиш

17.12.1- Мал хулгайлах

20.7-1- Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах

22.4- Хахууль авах

24.6-1- Хууль бусаар мод бэлтгэх

27.10-1- Авто тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих



1.2.1 Хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэсэн эрүүгийн хэргийн асуумжийн өгөгдөлд хийх шинжилгээ

1.2.1.1 Хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэсэн эрүүгийн хэргийн асуумжийн тухай

Эрүүгийн хэргийн ажиллагааны ачааллын асуумжид шинжилгээ хийхэд ашигласан өгөгдлийн танилцуулгыг дараах хүснэгтээр харуулъя.

№	Шүүх	Гэмт хэргийн төрөл										Дүн
		11.4.1	11.6.1	11.6.2	17.1.1	17.3.1	17.5.1	17.12.1	22.4	24.6.1	27.10.1	
1	Хан-Уул	1	1	1	1	1	1	1	1	1	1	10
2	Сонгинохайрхан	9	7	9	9	8	9	9	9	9	9	87
3	Чингэлтэй	8	8	7	8	7	8	8	8	8	8	78
4	Баянгол	9	10	10	9	10	10	10	10	9	10	97
5	Багахангай	1	1	1	1	1	1	1	1	1	1	10
6	Налайх	3	3	3	3	3	3	3	3	3	3	30
7	Архангай	3	2	2	2	2	2	2	2	2	2	21
8	Баянхонгор	1	2	1	1	1	1	1	1	1	1	11
9	Булган	2	2	2	2	2	2	2	2	2	2	20
10	Говь-Алтай	3	3	3	3	3	3	3	3	3	3	30
11	Дархан-Уул	1	1	1	1	1	1	1	1	1	1	10
12	Дорноговь	3	3	3	3	3	3	3	3	3	3	30
13	Дундговь	1	1	1	1	1	1	1	1	1	1	10
14	Завхан	3	3	3	3	3	3	3	3	3	3	30
15	Орхон	2	2	2	2	2	2	2	2	2	2	20
16	Өмнөговь	2	2	2	2	2	2	2	2	2	2	20
17	Сүхбаатар	2	2	2	2	2	2	2	2	2	2	20
18	Сэлэнгэ	2	2	2	2	2	2	2	2	2	2	20
19	Төв	1	2	2	2	2	2	2	2	2	2	19
20	Ховд	1	1	1	1	1	1	1	1	1	1	10
21	Хөвсгөл	2	2	2	2	2	2	2	2	2	2	20
22	Бор-Өндөр	2	1	2	2	2	2	2	2	2	2	19
23	Тосонцэнгэл	3	3	3	3	3	3	3	3	3	3	30
24	Замын-Үүд	1	1	1	1	1	1	1	1	1	1	10
25	Сайхан	4	1	4	4	4	4	4	4	4	4	37
26	Ховд-Булган	3	3	3	3	3	3	3	3	3	3	30
27	Хархорин	2	2	2	2	2	2	2	2	2	2	20
Дүн		74	70	74	74	73	75	75	75	74	75	739

Хүснэгт 1.2.1. Хялбаршуулсан журмаар эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд зарцуулах хугацааны асуумжийн судалгаанд оролцсон шүүгчийн мэдээлэл

Монгол улсад Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх үйл ажиллагаа явуулдаг 38 шүүхээс Баян-Өлгий, Говьсүмбэр, Дорнод, Өвөрхангай, Увс, Хэнтий аймгийн шүүхүүд, Өмнөговь аймгийн Ханбогд, Сэлэнгэ аймгийн Мандал сум дахь сум дундын шүүхүүд тус тус асуумжийн судалгааг явуулаагүй байна.

№	Шүүх	Гэмт хэргийн төрөл										Дүн
		11.4.1	11.6.1	11.6.2	17.1.1	17.3.1	17.5.1	17.12.1	22.4	24.6.1	27.10.1	
1	Сонгинохайрхан	8	7	9	6	8	9	8	8	6	8	77
2	Чингэлтэй	4	4	4	4	2	4	2	2	4	5	35
3	Баянгол	6	7	10	6	5	8	6	6	5	6	65
4	Багахангай	0	0	0	0	1	1	0	0	0	0	2
5	Налайх	3	3	3	3	3	3	3	3	3	3	30
6	Архангай	2	2	2	2	2	2	2	2	2	2	20
7	Булган	1	1	1	1	1	1	1	1	1	1	10
8	Говь-Алтай	1	1	1	1	1	1	1	1	1	1	10
9	Дархан-Уул	1	1	1	1	1	1	1	1	1	1	10
10	Дорноговь	1	1	1	1	1	1	1	1	1	1	10
11	Дундговь	1	1	1	0	1	1	0	1	1	1	8
12	Завхан	2	2	2	2	2	2	2	2	2	2	20



13	Орхон	2	2	2	2	2	2	2	2	2	2	20
14	Өмнөговь	1	2	2	2	2	2	2	2	2	2	19
15	Сүхбаатар	2	2	2	2	2	2	2	2	2	2	20
16	Сэлэнгэ	2	2	2	2	2	2	2	2	2	2	20
17	Төв	0	0	0	0	0	1	0	0	0	0	1
18	Хөвсгөл	2	2	2	2	2	2	2	2	2	2	20
19	Бор-Өндөр	2	1	2	2	2	2	2	2	2	2	19
20	Тосонцэнгэл	1	1	1	1	1	1	1	1	1	2	11
21	Замын-Үүд	1	1	1	1	1	1	1	1	1	1	10
22	Ховд-Булган	2	2	2	2	2	2	2	2	3	3	22
23	Хархорин	1	1	1	1	1	1	1	1	1	1	10
Дүн		46	46	52	44	45	52	44	45	45	50	469

Хүснэгт 1.2.2. Судалгаанд ашигласан өгөгдлийн мэдээ

Судалгаанд оролцсон 27 шүүхийн 75 шүүгч Эрүүгийн хэргийн 10 төрөл, зүйл ангийн хувьд 739 асуумж өгснөөс 23 шүүхийн 47 шүүгчийн 469 өгөгдлийг судалгаанд ашиглав. Үүнээс Хан-Уул, Баянхонгор, Ховд, Сэлэнгийн Сайханы шүүхийн асуумжийн өгөгдлийг судалгаанаас хасав. Асуумжийг хассан шалтгааныг дараах программын үр дүнгээр тайлбарлая.

	DF	SumOfSq	MeanSq	FRatio	PValue	All	653.75
Дүүрэг	3	2.71112×10^7	9.03705×10^6	223.828	2.84355×10^{-13}	Дүүрэг [ХанУул]	5727.
Error	16	645 998.	40 374.9			, CellMeans → Дүүрэг [Баянгол]	414.429
Total	19	2.77572×10^7				Дүүрэг [Чингэлтэй]	411.75
						Дүүрэг [Сонгинохайрхан]	350.

Программын үр дүн 1. Хялбаршуулсан журмаар 11.4-1 эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд зарцуулах хугацааны асуумжийн өгөгдөлд хийсэн дисперсийн шинжилгээний үр дүн, дүүргээр

Шинжилгээний үр дүнгээс харвал PValue 0-тэй ойролцоо байгаа нь асуумж өгсөн дүүргүүдийн 11.4-1 хэргийг хянан шийдвэрлэхэд зарцуулах хугацаа харьцуулагдахуйц биш хэт ялгаатай гэсэн мэдээллийг бидэнд өгч байна. CellMeans-ийн утгыг харвал Хан-Уул дүүрэг 11.4-1 хэргийг хянан шийдвэрлэхэд 5727 минут буюу 96 цаг (11.9 өдөр, ажлын 8 цагаар тооцоход)-т шийдвэрлэнэ гэж асуумжид хариулсан байна. Бусад дүүргүүд ажлын 6-10 цагийн дотор шийдвэрлэнэ гэх мэт асуумж өгсөн шалтгаанаар хэт ялгаатай зарим шүүхийн асуумжийг судалгаанд оруулахгүй хассан болно.

	DF	SumOfSq	MeanSq	FRatio	PValue	All	337.176
Дүүрэг	2	12 805.	6402.49	0.932419	0.416722	Дүүрэг [Баянгол]	301.833
Error	14	96 131.5	6866.54			, CellMeans → Дүүрэг [Чингэлтэй]	373.667
Total	16	108 936.				Дүүрэг [Сонгинохайрхан]	350.

Программын үр дүн 2. Зассан өгөгдөлд хийсэн дисперсийн шинжилгээний үр дүн


Асуумжийн өгөгдлөөс Хан-Уул дүүргийн 5727 минутыг хасаж шинжилгээ хийхэд PValue 0.42 байгаа нь асуумж өгсөн дүүргүүдийн 11.4-1 хэргийг хянан шийдвэрлэхэд зарцуулах хугацаа харьцуулагдахуйц бөгөөд ойролцоо гэсэн мэдээллийг бидэнд өгч байна.

1.2.1.2 Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үе шатанд хийх шинжилгээ

Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан зүйл, анги тус бүрийн ажиллагаанд зарцуулах хугацааны тухай нийслэл, аймаг, сум дундын шүүхийн Эрүүгийн хэргийн шүүгчдийн өгсөн 461 асуумжийн өгөгдөлд хийсэн 2 хүчин зүйлийн дисперсийн шинжилгээний үр дүнг Зураг 1.2.1-д харуулав. Зургаас харвал нийслэлийн Эрүүгийн хэргийн шүүгч нар 1 эрүүгийн хэргийг хялбаршуулсан журмаар шийдэхэд 475 минут, Сум дундын шүүхийн шүүгчид 638 минут зарцуулдаг гэсэн байна. 1 эрүүгийн хэргийг




хялбаршуулсан журмаар шийдэхэд зарцуулах хугацааг Эрүүгийн хэргийн зүйл анги тус бүрээр нь задалж харуулсан зургаас харвал 17.3-1-д хамгийн их буюу 617 минут зарцуулдаг гэж асуумжид хариулсан байна. Бусад хэргүүдийн хувьд 443-597 минут зарцуулдаг гэсэн байна.



Зураг 1.2.1. Хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэсэн хэрэгт зарцуулах хугацааны тухай асуумжийн ерөнхий мэдээлэл

Дисперсийн шинжилгээний хамтын нөлөөллийн үр дүнгээр Зураг 1.2.2-д харуулав. Зургаас харвал нийслэлийн Эрүүгийн хэргийн шүүгчид хялбаршуулсан журмаар 17.3-1-ийн эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэхэд 728 минут зарцуулдаг гэж үзсэн байна.




Зураг 1.2.2. Хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэсэн хэрэгт зарцуулах хугацаа, хэргийн зүйл ангиар

Дисперсийн шинжилгээний программын үр дүнгээр детерминац, корреляц, вариацийн коэффициентийг тооцов.

№	Үзүүлэлт	Детерминацийн коэффициент	Корреляцийн коэффициент	Вариацийн коэффициент	Дундаж
1	Шүүх	0.08	0.29	140%	513
2	Хэрэг	0.25	0.50	81%	
3	Шүүх, Хэрэг	0.52	0.72	56%	

Хүснэгт 1.2.3. Хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэхэд зарцуулах хугацаанд нөлөөлөх хүчин зүйлүүд

Хүснэгт 1.2.3-ийн эхний мөрийн утгыг тайлбарлая. Хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэсэн хэрэгт зарцуулах хугацааны өөрчлөлтийн 0.08 нь шүүхийн байрлалаас хамаарч байна. Хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэсэн хэрэгт зарцуулах хугацаа эрүүгийн хэргийн төрлөөс 0.29 буюу сул хамааралтай байна. Вариацийн коэффициент 140% байгаа нь тоон үзүүлэлтүүд нэгэн төрлийн биш бөгөөд дунджийн нөлөөлөх чадвар сул тул тус тусад нь дунджийн тухай авч үзэх нь (Зураг 1.2.1-ийг ашиглах) зохимжтой. Тухайн шүүхийн тухайн хэргийн зүйл ангид зарцуулах хугацааны хувьд дундаж утгыг судалгаанд цааш ашиглах боломжтой.




Зураг 1.2.3. Хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэх хэргийн ажиллагааны үе шат

Зураг 1.2.3-аас харвал хэргийн материалтай танилцах үе шатанд дунджаар нэг хэргийг хянан шийдвэрлэхэд нийт хугацааны 38% буюу 195 минут, хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхэд бэлтгэх үе шатанд 12.9% буюу 66 минут, шийдвэр боловсруулах, хянах, гарын үсэг зурах үе шатанд 36% буюу 188 минут, хэргийг эцэслэн




шийдвэрлэсний дараах ажиллагааны үе шатанд 12.5% буюу 64 минут зарцуулдаг байна.




Зураг 1.2.4. Хэрэг хянан шийдвэрлэх үе шатанд хамаарах ажиллагааны тоо, хэргийн төрлөөр

Зураг 1.2.3-д харуулсан ерөнхий мэдээллийг Эрүүгийн хэргийн төрөл тус бүрээр Зураг 1.2.4-д дэлгэрэнгүй оруулав. Зургаас харвал хэрэг хянан шийдвэрлэх 1-р үе шатанд 22.4-ийн ажиллагаанд зарцуулах хугацаа хамгийн их буюу 413 минут байна. Энэ үе шатанд бусад хэргийн зүйл ангийн ажиллагаанд зарцуулах хугацаа 157-227 минут байна. Хэрэг хянан шийдвэрлэх 2-р үе шатанд судалгаанд авсан бүх зүйл ангийн ажиллагаанд зарцуулах хугацаа ойролцоо буюу 60-72 минут байна. Хэргийн 3-р үе шатанд бүх хэргийн зүйл ангийн ажиллагаанд зарцуулах хугацаа 160-207 минут орчим гэж дүгнэгдсэн байна. Хэргийн 4-р үе шатанд бүх хэргийн зүйл ангийн ажиллагаанд зарцуулах хугацаа 53-80 минут орчим гэж дүгнэгдсэн байна. Хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх 2, 3, 4-р үеийн шатны үйл ажиллагаанд зарцуулах хугацаа нь бүх хэргийн зүйл, ангийн хувьд ойролцоо дүнтэй харагдаж байна. Зураг 1.2.4-д харуулсан ерөнхий мэдээллийг Эрүүгийн хэргийн төрөл тус бүрээр Зураг 1.2.5-1.2.9-д шүүхийн тогтолцоогоор задалж харуулав.



Зураг 1.2.5. Дүүргийн шүүхийн хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэх хэргийн ажиллагааны үе


Зураг 1.2.5-аас харвал дүүргийн Эрүүгийн шүүхийн шүүгчийн хэргийн материалтай танилцах үе шатанд дунджаар нэг хэргийг хянан шийдвэрлэхэд нийт хугацааны 42% буюу 207 минут, хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхэд бэлтгэх үе шатанд 12.4% буюу 61 минут, шийдвэр боловсруулах, хянах, гарын үсэг зурах үе шатанд 33.7% буюу 166 минут, хэргийг эцэслэн шийдвэрлэсний дараах ажиллагааны үе шатанд 11.8% буюу 58 минут зарцуулдаг байна.



Зураг 1.2.6. Дүүргийн шүүхийн хэрэг хянан шийдвэрлэх үе шатанд хамаарах ажиллагааны тоо, хэргийн төрлөөр


Зураг 1.2.5-д харуулсан ерөнхий мэдээллийг Эрүүгийн хэргийн төрөл тус бүрээр Зураг 1.2.6-д задалж харуулав. Зургаас харвал хэрэг хянан шийдвэрлэх 1-р үе шатанд 11.6-2, 22.4-ийн ажиллагаанд зарцуулах хугацаа хамгийн их буюу тус тус 371, 413 минут байна. Энэ үе шатанд бусад хэргийн зүйл ангийн ажиллагаанд зарцуулах хугацаа 102-208 минут байна. Хэрэг хянан шийдвэрлэх 2-р үе шатанд судалгаанд авсан бүх зүйл ангийн ажиллагаанд зарцуулах хугацаа ойролцоо буюу 52-72 минут байна. Хэргийн 3-р

үе шатанд бүх хэргийн зүйл ангийн ажиллагаанд зарцуулах хугацаа 121-203 минут орчим гэж дүгнэгдсэн байна. Хэргийн 4-р үе шатанд бүх хэргийн зүйл ангийн ажиллагаанд зарцуулах хугацаа 53-78 минут орчим гэж дүгнэгдсэн байна. Хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх 2, 3, 4-р үеийн шатны үйл ажиллагаанд зарцуулах хугацаа нь бүх хэргийн зүйл, ангийн хувьд ерөнхий дүгнэлттэй адил ойролцоо дүнтэй харагдаж байна.




Зураг 1.2.7. Аймгийн шүүхийн хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэх хэргийн ажиллагааны үе шат

Зураг 1.2.7-оос харвал аймгийн Эрүүгийн шүүхийн шүүгчийн хэргийн материалтай танилцах үе шатанд дунджаар нэг хэргийг хянан шийдвэрлэхэд нийт хугацааны 34% буюу 175 минут, хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхэд бэлтгэх үе шатанд 14% буюу 72 минут, шийдвэр боловсруулах, хянах, гарын үсэг зурах үе шатанд 39.5% буюу 203 минут, хэргийг эцэслэн шийдвэрлэсний дараах ажиллагааны үе шатанд 12.5% буюу 64 минут зарцуулдаг байна.



Зураг 1.2.8. Аймгийн шүүхийн хэрэг хянан шийдвэрлэх үе шатанд хамаарах ажиллагааны тоо, хэргийн төрлөөр


Зураг 1.2.7-д харуулсан ерөнхий мэдээллийг Эрүүгийн хэргийн төрөл тус бүрээр Зураг 1.2.8-д задалж харуулав. Зургаас харвал аймгийн Эрүүгийн хэргийн шүүхийн хэрэг хянан шийдвэрлэх 1-р үе шатанд судалгаанд авсан бүх зүйл ангийн ажиллагаанд зарцуулах хугацаа ойролцоо буюу 154-201 минут байна. Хэрэг хянан шийдвэрлэх 2-р үе шатанд судалгаанд авсан бүх зүйл ангийн ажиллагаанд зарцуулах хугацаа ойролцоо буюу 66-81 минут байна. Хэргийн 3-р үе шатанд 22.4-ийн ажиллагаанд зарцуулах хугацаа хамгийн их буюу 294 минут байна. Энэ үе шатанд бусад хэргийн зүйл ангийн ажиллагаанд зарцуулах хугацаа 161-228 минут байна. Хэргийн 4-р үе шатанд бүх хэргийн зүйл ангийн ажиллагаанд зарцуулах хугацаа 34-83 минут орчим гэж дүгнэгдсэн байна. Хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх 1, 2, 4-р үеийн шатны үйл ажиллагаанд зарцуулах хугацаа нь бүх хэргийн зүйл, ангийн хувьд ерөнхий дүгнэлттэй адил ойролцоо дүнтэй харагдаж байна.



Зураг 1.2.9. Захын дүүргийн шүүхийн хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэх хэргийн ажиллагааны үе шат




Зураг 1.2.9-өөс харвал захын дүүргийн Эрүүгийн шүүхийн шүүгчийн хэргийн материалтай танилцах үе шатанд дунджаар нэг хэргийг хянан шийдвэрлэхэд нийт хугацааны 42.4% буюу 226 минут, хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхэд бэлтгэх үе шатанд 8.4% буюу 45 минут, шийдвэр боловсруулах, хянах, гарын үсэг зурах үе шатанд 41.3% буюу 220 минут, хэргийг эцэслэн шийдвэрлэсний дараах ажиллагааны үе шатанд 7.9% буюу 42 минут зарцуулдаг байна.




Зураг 1.2. 10. Захын дүүргийн шүүхийн хэрэг хянан шийдвэрлэх үе шатанд хамаарах ажиллагааны тоо, хэргийн төрлөөр

Зураг 1.2.9-д харуулсан захын дүүргийн шүүхийн ерөнхий мэдээллийг Эрүүгийн хэргийн төрөл тус бүрээр Зураг 1.2.10-д задалж харуулав. Захын дүүргийн Эрүүгийн хэрэг шийдвэрлэдэг шүүгчид зарим хэрэг хянан шийдвэрлэх үйл ажиллагааны асуумжийг бөглөөгүй тул 0 гэсэн тэмдэглэгээг оруулсан болно. Хэрэг хянан шийдвэрлэх 1-р үе шатанд шатанд судалгаа бөглөсөн зүйл ангийн ажиллагаанд зарцуулах хугацаа ойролцоо буюу 215-237 минут байна. Хэрэг хянан шийдвэрлэх 2-р үе шатанд судалгаанд авсан бүх зүйл ангийн ажиллагаанд зарцуулах хугацаа 45 минут байна. Хэргийн 3-р үе шатанд зарим хэргийн зүйл ангийн ажиллагаанд зарцуулах хугацааг 220 минут гэж асуумж өгсөн байна. Хэргийн 4-р үе шатанд хэргийн зүйл ангийн ажиллагаанд зарцуулах хугацаа 42 минут гэж үзсэн байна.



Зураг 1.2.11. Сум дундын шүүхийн хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэх хэргийн ажиллагааны үе шат

Зураг 1.2.11-ээс харвал сум дундын шүүгчийн хэргийн материалтай танилцах үе шатанд дунджаар нэг хэргийг хянан шийдвэрлэхэд нийт хугацааны 34.3% буюу 224 минут, хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхэд бэлтгэх үе шатанд 11.9% буюу 78 минут, шийдвэр боловсруулах, хянах, гарын үсэг зурах үе шатанд 39.3% буюу 256 минут, хэргийг эцэслэн шийдвэрлэсний дараах ажиллагааны үе шатанд 14.5% буюу 86 минут зарцуулдаг байна.



Зураг 1.2. 12. Сум дундын шүүхийн хэрэг хянан шийдвэрлэх үе шатанд хамаарах ажиллагааны тоо, хэргийн төрлөөр


Зураг 1.2.12-д харуулсан сум дундын шүүхийн ерөнхий мэдээллийг Эрүүгийн хэргийн төрөл тус бүрээр Зураг 1.2.12-д задалж харуулав. Сум дундын шүүхийн



Эрүүгийн хэрэг шийдвэрлэдэг шүүгчид зарим хэрэг хянан шийдвэрлэх үйл ажиллагааны асуумжийг бөглөөгүй тул 0 гэсэн тэмдэглэгээг оруулсан болно. Хэрэг хянан шийдвэрлэх 1-р үе шатанд шатанд судалгаа бөглөсөн зүйл ангийн ажиллагаанд зарцуулах хугацаа ойролцоо буюу 197-270 минут байна. Хэрэг хянан шийдвэрлэх 2-р үе шатанд судалгаа өгсөн зүйл ангийн ажиллагаанд зарцуулах хугацаа 61-97 минут байна. Хэргийн 3-р үе шатанд хэргийн зүйл ангийн ажиллагаанд зарцуулах хугацааг 212-313 минут гэж асуумж өгсөн байна. Хэргийн 4-р үе шатанд хэргийн зүйл ангийн ажиллагаанд зарцуулах хугацааг 65-102 минут гэж үзсэн байна.


1.2.1.3 Хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд зарцуулах хугацааны өгөгдөлд хийх шинжилгээ

Өмнөх бүлгийн Зураг 1.2.3-д харуулсан хэрэг хянан шийдвэрлэх үе шатыг ямар төрлийн ажиллагаанаас хамаарч харилцан адилгүй хугацаа зарцуулж байгааг хэргийн ажиллагаа тус бүрээр задалж харуулсан үр дүнг танилцуулъя.



Зураг 1.2.13. Хялбаршуулсан журмаар хэргийн материалтай танилцах үеийн ажиллагааны задаргаа

Зураг 1.2.13-аас харвал Эрүүгийн хэргийн шүүгч хэргийн материалтай танилцах үе шатанд зарцуулах нийт хугацааны 44.1% буюу 86 минутыг хэргийн материалтай уншиж танилцах, түүвэр гаргахад 17.4% буюу 34 минут, шаардлагатай хууль тогтоомжийг судлахад 25.1% буюу 49 минут, шүүхийн практик судлахад 13.3% буюу 26 минут тус тус зарцуулдаг байна.



Зураг 1.2.14. Хялбаршуулсан журмаар хэргийн материалтай танилцах үеийн ажиллагаанд зарцуулах хугацаа, хэргийн төрлөөр

Зураг 1.2.13-д харуулсан Эрүүгийн хэргийн шүүгч хэргийн материалтай танилцах үе шатанд зарцуулах нийт хугацааг хэргийн төрөл тус бүрээр Зураг 1.2.14-д задалж харуулав. Хэрэг хянан шийдвэрлэх 1-р үе шат болох хэргийн материалтай танилцах үе шатны хэргийн материалыг уншиж судлах ажиллагааны Эрүүгийн хэргийн 22.4 төрөлд зарцуулах хугацаа хамгийн их буюу 126 минут гэж судалгаа өгсөн байна. Түүвэр гаргах ажиллагааны хувьд Эрүүгийн хэргийн 22.4 төрөлд зарцуулах хугацаа хамгийн их буюу 104 минут гэж үзсэн байна. Шаардлагатай хууль тогтоомжийг судлахад ажиллагаанд зарцуулах хугацааг бүх гэмт хэргийн төрлийн хувьд ойролцоо буюу 27-45 минут гэсэн байна. Шүүхийн практик судлах ажиллагаанд зарцуулах хугацааг бүх гэмт хэргийн төрлийн хувьд мөн адил ойролцоо буюу 22-33 минут гэж үзсэн байна.




Зураг 1.2. 15. Хялбаршуулсан журмаар хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхэд бэлтгэх үеийн ажиллагааны задаргаа

Зураг 1.2.15-аас харвал Эрүүгийн хэргийн шүүгч хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхэд бэлтгэх үе шатанд зарцуулах нийт хугацааны 13.5% буюу 9 минутыг шүүх хуралдааны тов мэдэгдэх хуудсанд гарын үсэг зурахад, 9.8% буюу 7 минутыг нөлөөллийн мэдүүлэг хөтөлдөг талаар мэдээлэл өгсөн баримтыг хянаж, гарын үсэг зурахад, 76.71% буюу 51 минутыг шүүх хуралдаанд тус тус зарцуулдаг гэсэн байна.




Зураг 1.2. 16. Хялбаршуулсан журмаар хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхэд бэлтгэх үеийн ажиллагаанд зарцуулах хугацаа, хэргийн төрлөөр

Зураг 1.2.15-д харуулсан Эрүүгийн хэргийн шүүгч хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхэд бэлтгэх үе шатанд зарцуулах нийт хугацааг хэргийн төрөл тус бүрээр Зураг 1.2.16-д задалж харуулав. Хэрэг хянан шийдвэрлэх 2-р үе шатны шүүх хуралдааны тов мэдэгдэх хуудсанд гарын үсэг зурахад бүх гэмт хэргийн төрлийн хувьд 7-11 минут зарцуулна гэсэн байна. Нөлөөллийн мэдүүлэг хөтөлдөг талаар мэдээлэл өгсөн баримтыг хянаж, гарын үсэг зурахад 6-9 минут зарцуулдаг гэж үзсэн байна. Шүүх хуралдаанд бүх гэмт хэргийн төрлийн хувьд 46-58 минут зарцуулна гэсэн байна. Хэрэг хянан шийдвэрлэх 2-р үе шатны ажиллагаа тус бүр бүх хэргийн төрөл зүйлийн хувьд ойролцоо хугацаа зарцуулна гэсэн байна. Шүүх хуралдаан дотроо дараах 3 хэсгээс бүрдсэн байхаар асуумжийг задалж авсан тул үзүүлэлт бүрийн хувьд тооцсон үр дүнг дурдъя.




Зураг 1.2.17. Шүүх хуралдааны ажиллагааны задаргаа

Зураг 1.2.15-д шүүх хуралдаанд 51 минут зарцуулдаг гэж үзсэн ерөнхий дүнг дэд ажиллагаа тус бүрээр задалж үзэхэд зөвлөлдөхөд 25 минут, завсарлуулахад 8 минут, шүүхээс гарсан шийдвэрийг тогтоох хэсгийг танилцуулах, үндэслэлийг тайлбарлахад 18 минут зарцуулдаг гэж Эрүүгийн хэргийн шүүгч нар үзсэн байна. Зураг 1.2.18-д Эрүүгийн хэргийн шүүгчийн шийдвэр боловсруулах үе шатанд зарцуулах нийт хугацааг тус шатны ажиллагаа тус бүрээр задалж тооцсон үр дүнг харуулав. Энэ үе шатны шүүх хуралдааны тэмдэглэл хянаж, гарын үсэг зурахад 31 минут, ерөнхий шүүгчийн захирамжид 12 минут, шүүгчийн захирамжид 23 минут, шүүхийн шийтгэвэрт 21 минут, шийтгэх, цагаатгах тогтоолд 101 минутыг тус тус зарцуулдаг гэсэн байна.



Зураг 1.2.18. Хялбаршуулсан журмаар шийдвэр боловсруулах үеийн ажиллагааны задаргаа

Зураг 1.2.18-д харуулсан Эрүүгийн хэргийн шүүгчийн шийдвэр боловсруулах үе шатанд зарцуулах нийт хугацааг хэргийн төрөл тус бүрээр Зураг 1.2.19-д задалж харуулав.



Зураг 1.2. 19. Хялбаршуулсан журмаар шийдвэр боловсруулах үеийн ажиллагаанд зарцуулах хугацаа, хэргийн төрлөөр

Хэрэг хянан шийдвэрлэх 3-р үе шатны эхний 4 ажиллагаанд зарцуулах хугацаа гэмт хэргийн бүх төрлийн хувьд ойролцоо дүнтэй байна. Харин шийтгэх, цагаатгах тогтоолын хувьд 22.4 хэргийн хувьд харьцангуй их хугацаа зарцуулна гэсэн байна. Зурагт 0-ээр тэмдэглэсэн хэргийн төрлийн ажиллагааны хувьд ямар нэгэн санал өгөөгүй, судалгаа хоосон байсан гэсэн үг юм. Хэрэг хянан шийдвэрлэх 3-р үе шатны ихэнх ажиллагааны асуумжийг задалж авсан тул задаргаатай орж ирсэн үзүүлэлт бүрийн хувьд тооцсон үр дүнг дурдъя.



Зураг 1.2. 20. Шийдвэр боловсруулах үеийн зарим ажиллагааны задаргаа

Зураг 1.2.20-д дурдсан ерөнхий шүүгчийн захирамжид 12 минут зарцуулдаг гэсэн асуумжийн үр дүнг задалж үзэхэд ерөнхий шүүгчийн захирамжийг хянахад 7 минут, боловсруулахад 5 минут тус тус зарцуулдаг болох нь тооцоогоор гарав. Бусад ажиллагааны үзүүлэлтийг мөн адил ойлгоно.




Зураг 1.2.21. Хэрэг хянан шийдвэрлэсний дараах үеийн ажиллагааны задаргаа

Зураг 1.2.21-д Эрүүгийн хэргийн шүүгчийн хэрэг хянан шийдвэрлэсний дараах үе шатанд зарцуулах нийт хугацааг тус шатны ажиллагаа тус бүрээр задалж тооцсон үр дүнг харуулав. Энэ үе шатны гүйцэтгэх хуудас хянаж, гарын үсэг зурахад 14 минут,




эрүүгийн хариуцлага хүлээлгэсэн тухай тэмдэглэл хянаж, гарын үсэг зурахад 11 минут, эмхэтгэсэн хэргийг хянаж баримтад гарын үсэг зурахад 17 минут, шүүгчийн залруулгын захирамж гаргахад 22 минут тус тус зарцуулдаг гэсэн байна.



Зураг 1.2. 22. Хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэсний дараах үеийн ажиллагаанд зарцуулах хугацаа, хэргийн төрлөөр

Хэрэг хянан шийдвэрлэх 4-р үе шатны бүх ажиллагаанд зарцуулах хугацаа гэмт хэргийн бүх төрлийн хувьд ойролцоо дүнтэй байна.



Зураг 1.2. 23. Шүүгчийн залруулгын захирамж ажиллагааны задаргаа

Зураг 1.2.23-д дурдсан шүүгчийн залруулгын захирамжийг хянахад 9 минут, боловсруулахад 13 минут тус тус зарцуулдаг болох нь тооцоогоор гарав.

1.2.2 Ердийн журмаар хянан шийдвэрлэсэн эрүүгийн хэргийн асуумжийн өгөгдөлд хийх шинжилгээ

1.2.2.1 Ердийн журмаар хянан шийдвэрлэсэн эрүүгийн хэргийн асуумжийн тухай

Ердийн журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны ачааллын асуумжид шинжилгээ хийхэд ашигласан өгөгдлийн танилцуулгыг дараах хүснэгтээр харуулъя.

№	Шүүх	Гэмт хэргийн төрөл										Дүн
		10.1	11.1	11.6	12.1	17.1	17.3	20.7	22.4	24.6	27.10	
1	Хан-Уул	1	1	1	1	1	1	1	1	1	1	10
2	Сонгинохайрхан	9	11	11	9	9	9	9	14	9	9	99
3	Чингэлтэй	8	8	8	8	8	8	8	11	8	8	83
4	Баянгол	10	10	10	10	10	10	10	10	10	10	100
5	Хан-Уул	1	1	-	-	-	-	-	-	-	-	2
6	Багахангай	0	0	1	0	1	0	0	0	1	0	3
7	Налайх	3	3	3	3	3	3	3	3	3	3	30
8	Архангай	3	3	3	3	3	3	3	3	3	3	30
9	Баянхонгор	2	2	2	2	2	2	2	2	2	2	20
10	Булган	3	3	3	3	3	3	3	3	3	3	30
11	Говь-Алтай	3	3	3	3	3	3	3	3	3	3	30
12	Дархан-Уул	1	1	1	1	1	1	1	1	1	1	10
13	Дорноговь	3	3	3	3	3	3	3	3	3	3	30
14	Дундговь	1	1	1	1	1	1	1	1	1	1	10
15	Завхан	3	3	3	3	3	3	3	3	3	3	30
16	Орхон	2	2	2	2	2	2	2	2	2	2	20
17	Өмнөговь	2	2	2	2	2	2	2	2	2	2	20
18	Сүхбаатар	2	2	2	2	2	2	2	2	2	2	20
19	Сэлэнгэ	2	2	2	2	2	2	2	2	2	2	20
20	Төв	2	2	2	2	2	2	2	2	2	2	20
21	Увс	2	2	2	2	2	2	2	2	2	2	20



ЭРҮҮГИЙН ХЭРГИЙН СУДАЛГАА

22	Ховд	1	1	1	1	1	1	1	1	1	1	10
23	Хөвсгөл	2	2	2	2	2	2	2	2	2	2	20
24	Бор-Өндөр	2	2	2	2	2	2	2	2	2	2	20
25	Тосонцэнгэл	3	3	3	3	3	3	3	3	3	3	30
26	Замын-Үүд	2	2	2	2	2	2	2	2	2	2	20
27	Сайхан	4	4	4	4	4	4	4	4	4	4	40
28	Ховд-Булган	3	3	3	3	3	3	2	2	2	2	27
29	Хархорин	2	2	2	2	2	2	2	2	2	2	20
Дүн		82	84	84	81	82	81	81	88	81	80	824

Хүснэгт 1.2. 4. Ердийн журмаар эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд зарцуулах хугацааны асуумжийн судалгаанд оролцсон шүүхийн мэдээлэл

Монгол улсад Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх үйл ажиллагаа явуулдаг 33 шүүхээс Баян-Өлгий, Говьсүмбэр, Дорнод, Өвөрхангай, Хэнтий аймгийн шүүхүүд асуумжийн судалгааг явуулаагүй байна.

№	Шүүх	Гэмт хэргийн төрөл										Дүн
		10.1	11.1	11.6	12.1	17.1	17.3	20.7	22.4	24.6	27.10	
1	Хан-Уул	0	0	0	0	0	0	0	1	0	0	1
2	Сонгинохайрхан	7	7	9	7	6	7	5	8	6	7	69
3	Чингэлтэй	3	3	4	3	4	4	5	3	2	3	34
4	Баянгол	9	9	9	6	6	7	6	6	5	6	69
5	Багахангай	0	0	1	0	1	0	0	0	1	0	3
6	Налайх	3	3	3	3	3	3	3	3	3	3	30
7	Архангай	3	3	3	3	3	3	3	3	3	3	30
8	Баянхонгор	1	1	2	2	1	1	1	2	1	1	13
9	Булган	2	3	3	3	3	3	3	3	3	3	29
10	Говь-Алтай	2	2	2	2	2	2	2	2	2	3	21
11	Дархан-Уул	1	1	1	1	1	1	1	1	1	1	10
12	Дорноговь	1	1	1	1	1	2	1	1	2	1	12
13	Дундговь	1	1	1	1	1	1	1	1	1	1	10
14	Завхан	3	3	3	3	3	3	3	3	3	3	30
15	Орхон	2	2	2	2	2	2	2	2	2	2	20
16	Өмнөговь	2	2	2	2	2	2	2	2	2	2	20
17	Сүхбаатар	2	2	2	2	2	2	2	2	2	2	20
18	Сэлэнгэ	2	2	2	2	2	2	2	2	2	2	20
19	Төв	1	2	2	2	2	2	2	2	2	2	19
20	Увс	2	2	2	2	2	2	2	2	2	2	20
21	Ховд	0	1	1	1	1	1	1	1	1	1	9
22	Хөвсгөл	2	2	2	2	2	2	2	2	2	2	20
23	Бор-Өндөр	2	2	2	2	2	2	2	2	2	2	20
24	Тосонцэнгэл	3	3	3	3	3	3	3	3	3	3	30
25	Замын-Үүд	1	1	1	2	1	1	1	1	1	1	11
26	Сайхан	2	2	2	2	2	2	2	2	2	2	20
27	Ховд-Булган	3	3	3	3	3	3	3	2	2	2	27
28	Хархорин	2	2	2	2	2	2	2	2	2	2	20
Дүн		62	65	70	64	63	65	62	64	60	62	637

Хүснэгт 1.2. 5. Судалгаанд ашигласан өгөгдлийн мэдээ


Судалгаанд оролцсон 29 шүүхийн 82 шүүгч Эрүүгийн хэргийн 10 төрөл, зүйл ангийн хувьд 824 асуумж өгснөөс 28 шүүхийн 64 шүүгчийн 637 өгөгдлийг судалгаанд ашиглав. Үүнээс зарим шүүхийн асуумжийн өгөгдлийг судалгаанаас хассан шалтгааныг 1.2.1.1-р бүлгийн программын үр дүн 1, 2-т тайлбарласан тул шалтгааныг жишээ болгож дурдахгүйгээр дараагийн судалгаанд шилжье.

1.2.2.2 Ердийн журмаар эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үе шатанд хийх шинжилгээ

Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан зүйл, анги тус бүрийн ажиллагаанд зарцуулах хугацааны тухай нийслэл, аймаг, сум дундын шүүхийн Эрүүгийн хэргийн шүүгчдийн өгсөн 624 асуумжийн өгөгдөлд хийсэн 2 хүчин зүйлийн дисперсийн




шинжилгээний үр дүнг Зураг 1.2.24-д харуулав. Зургаас харвал дүүргийн Эрүүгийн хэргийн шүүгч нар 1 эрүүгийн хэргийг ердийн журмаар шийдэхэд 7312 минут буюу 122 цаг, захын дүүргийн шүүхийн шүүгчид 2127 минут буюу 35 цаг зарцуулдаг гэсэн байна. 1 эрүүгийн хэргийг ердийн журмаар хянан шийдвэрлэхэд зарцуулах хугацааг Эрүүгийн хэргийн зүйл анги тус бүрээр нь задалж харуулсан зургаас харвал 11.6-д хамгийн их буюу 7117 минут зарцуулдаг гэсэн асуулга өгсөн байна. Эрүүгийн 11.6 хэргийн хувьд хамгийн бага буюу 4142 минут зарцуулдаг бөгөөд бусад хэргүүдийн хувьд 5028-6720 минут зарцуулдаг гэж үзсэн байна.



Зураг 1.2.24. Ердийн журмаар хянан шийдвэрлэсэн хэрэгт зарцуулах хугацааны тухай асуумжийн ерөнхий мэдээлэл

Дисперсийн шинжилгээний хамтын нөлөөллийн үр дүнгээр Зураг 1.2.25-д харуулав. Зургаас харвал дүүргийн Эрүүгийн хэргийн шүүгчид ердийн журмаар 11.6-гийн хэрэг хянан шийдвэрлэхэд 3727 минут зарцуулдаг гэж үзсэн байна. Бусад эрүүгийн хэргийн төрөл, зүйл ангийн хувьд 5031-10258 минут зарцуулдаг байна. Аймгийн Эрүүгийн хэргийн шүүгчид хэргийн бүх төрөл, зүйл ангийн хувьд ердийн журмаар хэрэг хянан шийдвэрлэхэд 4636-7194 минут зарцуулдаг гэсэн байна. Сумын шүүгчид ердийн журмаар 10.1, 11.1-ийн хэрэг хянан шийдвэрлэхэд 4463-4853 минут зарцуулдаг гэж үзсэн байна. Үлдсэн эрүүгийн хэргийн төрөл, зүйл ангийн хувьд ердийн журмаар хэрэг хянан шийдвэрлэхэд 1091-1909 минут зарцуулдаг гэсэн байна.



Зураг 1.2.25. Ердийн журмаар хянан шийдвэрлэсэн хэргийн ажиллагаанд зарцуулах хугацаа, хэргийн зүйл ангиар

Шүүгчийн ажлын туршлага, хэрэг хянан шийдвэрлэх хугацааны тухай бодит практик баримжаа, санал бодлыг энэхүү судалгаанд аль болох тусгаж оруулахыг судалгааны баг зорьсон ч ердийн журмаар хэрэг хянан шийдвэрлэх асуумжийн өгөгдлийн судалгааг цааш үргэлжлүүлэх шаардлагагүй болсон тул шинжилгээг зогсоов. Учир нь 5-р бүлгийн шүүгчийн ажлын ачаалал тооцох, хэргийн коэффициент тодорхойлох судалгаанд ердийн журмаар хэрэг хянан шийдвэрлэх асуумжийн үр дүн шаардлага хангахгүй өгөгдөлд шилжиж байгаа тул бүтцийн болон дисперсийн шинжилгээг үргэлжлүүлэн хийх шаардлагагүй болов.


1.2.3 Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхээс ирүүлсэн асуумжийн өгөгдөлд хийх шинжилгээ

1.2.3.1 Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхээс ирүүлсэн асуумжийн тухай


Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн эрүүгийн хэргийн ажиллагааны ачааллын асуумжид шинжилгээ хийхэд ашигласан өгөгдлийг танилцуулъя. Монгол улсад эрүүгийн хэргийн давж заалдах шатанд үйл ажиллагаа явуулдаг 22 шүүхээс 13



шүүх асуумжийн судалгаанд хамрагдсан. 9 аймгийн шүүхүүд асуумжийн судалгаанд хамрагдаагүй байна. Үүнээс Дундговь аймгийн эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхээс ирүүлсэн асуумжийн хариулт шаардлага хангахгүй байсан тул шинжилгээнээс хасагдав. Судалгаанд оролцсон 13 шүүхийн 15 шүүгчийн ирүүлсэн Эрүүгийн хэргийн 13 төрөл, зүйл ангийн 194 өгөгдлийн үр дүнг дараах зургаар харуулъя.



Зураг 1.2.26. Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн хэргийн ажиллагаанд зарцуулах хугацааны тухай асуумжийн ерөнхий мэдээлэл




Зураг 1.2.27. Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн хэргийн ажиллагаанд зарцуулах хугацаа, хэргийн зүйл ангиар

Зураг 1.2.27-аас харвал нийслэлийн эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүх нь бүх хэргийн төрөл, зүйл ангийн хувьд аймгийн шүүхээс 7-8 дахин их хугацааг хэргийн ажиллагаанд зарцуулдаг гэж үзсэн байна. Нийслэлийн шүүхээс ирүүлсэн өгөгдөл харьцуулагдахуйц хэмжээнд биш байгаа тул өгөгдлийг судалгаанаас хасав.


1.2.3.2 Давж заалдах шатны шүүхийн эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үе шатуудад хийх шинжилгээ

Асуумжийн өгөгдлөөс нийслэлийн эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн өгөгдлийг хасаж аймгийн шүүхүүдээс ирүүлсэн асуумжийн өгөгдөл дээр хэрэг хянан шийдвэрлэх үе шатуудын хувьд шинжилгээ хийсэн үр дүнг дараах зургаар харуулав.



Зураг 1.2.28. АДЗШШ-ийн эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үе шатуудад зарцуулах хугацаа

Зургаас харвал аймгийн давж заалдах шатны Эрүүгийн хэргийн шүүгч нар 1 эрүүгийн хэргийг шийдэхэд хэргийн материалтай танилцах үе шатанд дунджаар нэг хэргийг хянан шийдвэрлэхэд нийт хугацааны 57% буюу 1868 минутыг хэргийн материалтай танилцахад, 4.4% буюу 144 минутыг хэрэг хүлээн авснаас хойших ажиллагаанд, 8.6% буюу 282 минутыг хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхэд бэлтгэх үе шатанд, 28.2% буюу 928 минутыг шийдвэр боловсруулах, хянах, гарын үсэг зурах үе шатанд, 2% буюу 70 минутыг хэргийг эцэслэн шийдвэрлэсний дараах ажиллагаанд тус тус зарцуулдаг байна.




Зураг 1.2.29. АДЗШШ-ийн эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үе шатанд зарцуулах хугацаа, хэргийн төрлөөр

Зураг 1.2.29-өөс харвал хэрэг хянан шийдвэрлэх 1-р үе шатанд бүх эрүүгийн хэргийн төрөл, зүйл ангид зарцуулах хугацаа их буюу 1407-2437 минут байна. 3-р үе шатанд бүх эрүүгийн хэргийн төрөл, зүйл ангид зарцуулах хугацаа 745-1141 минут байна. 2-р үе шатанд бүх эрүүгийн хэргийн төрөл, зүйл ангид зарцуулах хугацаа 121-173 минут байна. Хэрэг хянан шийдвэрлэх 4-р үе шатанд бүх эрүүгийн хэргийн төрөл, зүйл ангид зарцуулах хугацаа их буюу 245-323 минут байна. 5-р үе шатанд бүх эрүүгийн хэргийн төрөл, зүйл ангид зарцуулах хугацаа их буюу 35-97 минут орчим гэж дүгнэгдсэн байна. Давж заалдах шатны Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх 1-5-р үеийн шатны үйл ажиллагаанд зарцуулах хугацаа нь бүх хэргийн зүйл, ангийн хувьд ойролцоо дүнтэй харагдаж байна.


1.2.3.3 Давж заалдах шатны шүүхийн эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд зарцуулах хугацааны өгөгдөлд хийх шинжилгээ


Зураг 1.2.28-д харуулсан хэрэг хянан шийдвэрлэх үе шатыг ямар төрлийн ажиллагаанаас хамаарч харилцан адилгүй хугацаа зарцуулж байгааг хэргийн ажиллагаа тус бүрээр задалж харуулсан үр дүнг танилцуулъя.



Зураг 1.2.30. ДЗШШШ-ийн хэргийн материалтай танилцах үеийн ажиллагаанд зарцуулах хугацаа, эзлэх хувь ба минутаар


Зураг 1.2.30-аас харвал Эрүүгийн хэргийн шүүгч хэргийн материалтай танилцах үе шатанд зарцуулах нийт хугацааны 4.9% буюу 92 минутыг хэргийн материалтай уншиж танилцах, хэрэг хянан шийдвэрлэх үйл ажиллагааг төлөвлөхөд 45% буюу 853 минут, түүвэр гаргахад 19.5% буюу 369 минут, шаардлагатай хууль тогтоомжийг судлахад 13.7% буюу 259 минут, шүүхийн практик судлахад 16.9% буюу 321 минут тус тус зарцуулдаг байна.





Зураг 1.2.31. ДЗШШШ-ийн хэргийн материалтай танилцах үеийн ажиллагаанд зарцуулах хугацаа, хэргийн төрлөөр

Зураг 1.2.30-д харуулсан Эрүүгийн хэргийн шүүгч хэргийн материалтай танилцах үе шатанд зарцуулах нийт хугацааг хэргийн төрөл тус бүрээр Зураг 1.2.31-д задалж харуулав. Хэрэг хянан шийдвэрлэх 1-р үе шат болох хэргийн материалтай танилцах ажиллагааны уншиж судлах шатанд зарцуулах хугацааг бүх хэргийн төрөл, зүйл анги бүрийн хувьд хамгийн их хугацааг зарцуулдаг гэж үзсэн байна. Хэргийн материалыг уншиж судлах ажиллагаа хувилбартай асуумжтай байсан тул шинжилгээ хийж задалж харуулъя.




Зураг 1.2.32. Хавтаст хэргийн ажиллагаанд зарцуулах хугацаа

Зураг 1.2.32-д 1-5 хавтастай хэргийг уншиж танилцахад 339 минут, 6-14 хавтастай хэргийг уншиж танилцахад 780 минут, 15-аас дээш хавтастай хэргийг уншиж танилцахад 1452 минут зарцуулдаг гэж үзсэн байна.



Зураг 1.2.33. ДЗШШШ-ийн хэрэг хүлээн авснаас хойших үеийн ажиллагаанд зарцуулах хугацаа, эзлэх хувь ба минутаар

Зураг 1.2.33-оос харвал Эрүүгийн хэргийн шүүгч хэргийг хүлээн авснаас хойших үеийн ажиллагаанд зарцуулах нийт хугацааны 43.8% буюу 63 минутыг ТСАХ-тэй холбоотой хүсэлтийг шийдвэрлэхэд, 56.2% буюу 81 минутыг хэргийг түдгэлзүүлэх үндэслэл бий болсон эсэхийг шийдвэрлэсэн шүүхийн тогтоолд тус тус зарцуулдаг байна.




Зураг 1.2.34. ДЗШШШ-ийн хэрэг хүлээн авснаас хойших үеийн ажиллагаанд зарцуулах хугацаа, хэргийн төрлөөр

Хэрэг хянан шийдвэрлэх 2-р үе шатны бүх хэргийн төрөл, зүйл ангийн хувьд ТСАХ-тэй холбоотой хүсэлтийг шийдвэрлэхэд 56-97 минут зарцуулна гэсэн байна. Хэргийг түдгэлзүүлэх үндэслэл бий болсон эсэхийг шийдвэрлэсэн шүүхийн тогтоолд 77 эсвэл 81 минут зарцуулна гэж дүгнэсэн байна.




Зураг 1.2.35. Хэрэг хүлээн авснаас хойших үеийн ажиллагаанд зарцуулах хугацааны задаргаа




Зураг 1.2.36. ДЗШШШ-ийн хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхэд бэлтгэх, хэлэлцэх ажиллагаанд зарцуулах хугацаа, эзлэх хувь ба минутаар

Зураг 1.2.36-аас харвал Эрүүгийн хэргийн шүүгч хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхэд бэлтгэх, хэлэлцэх үе шатанд зарцуулах нийт хугацааны 22.3% буюу 63 минутыг шүүх хуралдаанд илтгэх, 29.4% буюу 83 минутыг шүүх хуралдааныг даргалах, 22.7% буюу 64 зөвлөлдөх, 17.7% буюу 50 минутыг шүүх хуралдааныг завсарлуулах, 7.8% буюу 22 минутыг шүүхээс гарсан магадлалын тогтоох хэсгийг танилцуулах, үндэслэлийг тайлбарлахад тус тус зарцуулдаг байна. Эрүүгийн хэргийн шүүгч хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхэд бэлтгэх, хэлэлцэх шатанд зарцуулах нийт хугацааг хэргийн төрөл тус бүрээр Зураг 1.2.37-д задалж харуулав.



Зураг 1.2.37. ДЗШШШ-ийн хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхэд бэлтгэх, хэлэлцэх ажиллагаанд зарцуулах хугацаа, хэргийн төрлөөр

Хэрэг хянан шийдвэрлэх 3-р үе шатны бүх ажиллагаанд зарцуулах хугацаа гэмт хэргийн бүх төрлийн хувьд ойролцоо дүнтэй байна.




Зураг 1.2.38. ДЗШШШ-ийн шийдвэр боловсруулах, хянах, гарын үсэг зурах үеийн ажиллагаанд зарцуулах хугацаа, эзлэх хувь ба минутаар

Зураг 1.2.38-д Эрүүгийн хэргийн шүүгчийн шийдвэр боловсруулах, хянах, гарын үсэг зурах үе шатанд зарцуулах нийт хугацааг тус шатны ажиллагаа тус бүрээр задалж тооцсон үр дүнг харуулав. Энэ үе шатанд шүүх хуралдааны тэмдэглэл хянаж, гарын зурахад энэ үеийн нийт ажиллагааны 5.5% буюу 51 минут, шүүгчийн захирамжид 35.9%




буюу 333 минут, шүүхийн тогтоолд 8.5% буюу 79 минут, магадлалд 50.1% буюу 465 минут тус тус зарцуулдаг байна.



Зураг 1.2.39. ДЗШШШ-ийн шийдвэр боловсруулах, хянах, гарын үсэг зурах үеийн ажиллагаанд зарцуулах хугацаа, хэргийн төрлөөр

Хэрэг хянан шийдвэрлэх 4-р үе шатны бүх ажиллагаанд зарцуулах хугацаа гэмт хэргийн бүх төрлийн хувьд ойролцоо дүнтэй байна. Шүүгчийн захирамж, шүүхийн тогтоол, магадлал зэргийг хянаж боловсруулсан хугацаагаар нь задалж харуулсан шинжилгээний үр дүнг дараах зургаас харна уу.




Зураг 1.2.40. Шүүгчийн шийдвэр боловсруулах, хянах, гарын үсэг зурах үе шатанд зарцуулах ажиллагааны зарим үзүүлэлтийн задаргаа

Зураг 1.2.40-өөс харвал шүүгчийн залруулгын захирамжийг хянахад 9 минут, боловсруулахад 13 минут тус тус зарцуулдаг байна.




Зураг 1.2.41. ДЗШШШ-ийн хэрэг хянан шийдвэрлэсний дараах үеийн ажиллагаанд зарцуулах хугацаа, эзлэх хувь ба минутаар

Зураг 1.2.41-д Эрүүгийн хэргийн шүүгчийн хэрэг хянан шийдвэрлэсний үе шатанд зарцуулах нийт хугацааг тус шатны ажиллагаа тус бүрээр задалж тооцсон үр дүнг харуулав. Энэ үе шатанд мэдэгдэх хуудас хянаж, гарын үсэг зурахад энэ үеийн нийт ажиллагааны 76% буюу 54 минут, шүүхийн залруулгын тогтоолд 24% буюу 17 минут тус тус зарцуулдаг байна.



Зураг 1.2.42. ДЗШШШ-ийн хэрэг хянан шийдвэрлэсний дараах үеийн ажиллагаанд зарцуулах хугацаа, хэргийн төрлөөр

Хэрэг хянан шийдвэрлэх 5-р үе шатны бүх ажиллагаанд зарцуулах хугацаа гэмт хэргийн бүх төрлийн хувьд ойролцоо дүнтэй байна. Шүүхийн залруулгын тогтоолыг хянаж боловсруулсан хугацаагаар нь задалж харуулсан шинжилгээний үр дүнг дараах зургаас харна уу.



Зураг 1.2.4327. Шүүхийн залруулгын тогтоолыг боловсруулах, хянахад зарцуулах хугацаа

1.3 Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх үйл ажиллагааны ажиглалтын өгөгдөлд хийх шинжилгээ

Эрүүгийн хэргийн шүүгчийн хянан шийдвэрлэсэн хэргийн ажиллагааны ачааллыг бодитой тодорхойлохын тулд ШЕЗ-ийн судалгаа шинжилгээний баг Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан дараах төрлийн гэмт хэргийн үзүүлэлтийн хүрээнд шүүгчийн ажлын байрны зураг авалт хийж, цуглуулсан өгөгдөлд хийсэн шинжилгээний үр дүнг энэ бүлэг танилцуулна. Судалгаанд дараах гэмт хэргийн төрөлд хамаарах ажлын байрны зураг авалтыг хийсэн байна. Үүнд:

10.1-1 - Хүнийг алах

11.1 - Хүний эрүүл мэндэд хүнд хохирол учруулах

11.4-1 - Хүний эрүүл мэндэд хүндэвтэр хохирол санаатай учруулах

11.6-1, 2 - Хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол санаатай учруулах

12.1 - Хүчиндэх

17.1-1 - Хулгайлах

17.3-1 - Залилах

17.5-1 - Алдаатай гүйлгээ, андуурагдсан илгээмж, гээгдэл эд хөрөнгө, алдуул мал завиших

17.12.1- Мал хулгайлах

20.7-1- Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах

22.4- Хахууль авах


24.6-1- Хууль бусаар мод бэлтгэх

27.10-1- Авто тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих

1.3.1 Хялбаршуулсан журмаар эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх үйл ажиллагааны ажиглалтын өгөгдөлд хийх шинжилгээ

1.3.1.1 Ажиглалтын өгөгдлийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны ерөнхий дүн ба үе шатуудын хувьд хийх шинжилгээ

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэдэг шүүгчийн ажлын ажиллагааны ачааллыг бодитой тодорхойлохын тулд Баянзүрх, Налайх дүүргийн тус тус нэг шүүгчийн хялбаршуулсан журмаар эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх үйл ажиллагаанд ажлын байрны зураг авалт хийж, өгөгдөл цуглуулан шинжилгээ хийсэн үр дүнг танилцуулж байна.




Зураг 1.3.1 Хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэхэд зарцуулах хугацааны тухай ажиглалтын өгөгдлийн ерөнхий мэдээлэл

Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан зүйл, анги тус бүрийн ажиллагаанд зарцуулах хугацааны тухай Баянзүрх, Налайх дүүргийн Эрүүгийн хэргийн хоёр шүүгчийн ажлын байрны зураг авалтын үр дүнд цуглуулсан 40 өгөгдөлд хийсэн 3 хүчин зүйлийн дисперсийн шинжилгээний үр дүнг Зураг 1.3.1-д харуулав. Зургаас харвал



Налайх дүүргийн Эрүүгийн хэргийн шүүгч 1 эрүүгийн хэргийг хялбаршуулсан журмаар шийдэхэд 515 минут, Баянзүрх, Налайх дүүргийн шүүгч 259 минут зарцуулдаг байна. Харин шүүгч 1 эрүүгийн хэргийг хялбаршуулсан журмаар шийдэхэд 367 минут зарцуулдаг бол ерөнхий шүүгч 406 минут зарцуулдаг байна. Хэрэг хянан шийдвэрлэх хугацааг Эрүүгийн хэргийн зүйл анги тус бүрээр нь задалж харуулсан зургаас харвал судалгаанд хамрагдсан хэргийн зүйл ангиудын хувьд ойролцоо буюу 357-433 минут зарцуулдаг байна. Зураг авалтад хамрагдсан хоёр дүүргийн шүүхийн хувьд Налайх дүүргийн шүүгч судалгаанд хамрагдсан хэргийн зүйл ангиудын хувьд 483-595 минут зарцуулдаг байхад Баянзүрх дүүргийн шүүгч 195-345 минут зарцуулдаг төлөв ажиглагдсан байна.



Зураг 1.3.2 Хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэхэд зарцуулах хугацааны тухай ажиглалтын өгөгдөл, хэргийн зүйл анги ба дүүргээр


Дисперсийн шинжилгээний программын үр дүнгээр детерминац, корреляц, вариацийн коэффициентийг тооцсон үр дүнг дараах хүснэгтээр харуулъя.

№	Үзүүлэлт	Детерминацийн коэффициент	Корреляцийн коэффициент	Вариацийн коэффициент	Дундаж
1	Хэрэг	0.52	0.72	109%	387
2	Шүүгч	0.06	0.25	32%	
3	Шүүх, Хэрэг	0.28	0.52	15%	

Хүснэгт 1.3. 1 Ажиглалтын өгөгдлийн хэрэг хянан шийдвэрлэх хугацаанд нөлөөлөх хүчин зүйлүүд


Хүснэгтийн зөвхөн эхний мөрийн утгыг тайлбарлая. Хэргийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэхэд зарцуулах хугацааны өөрчлөлтийн 0.52 нь хэргийн төрлөөс хамаарч байна. Хэргийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэхэд зарцуулах хугацаа эрүүгийн хэргийн төрлөөс 0.72 буюу хүчтэй хамааралтай байна. Вариацийн коэффициент 109% байгаа ч корреляцийн коэффициент хүчтэй хамааралтай тул тоон үзүүлэлтүүд нэгэн төрлийн бөгөөд дунджийг бусад тоон утгыг төлөөлөх чадвартай гэж үзнэ. Мөн шүүгчийн ангилал (ерөнхий шүүгч, шүүгч), шүүхийн тогтолцоо ба хэргийн төрөл, зүйл ангид зарцуулах хугацааны хувьд дундаж утгыг судалгаанд цааш нь ашиглах боломжтой.

Хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үе шат дараах үндсэн дөрвөн үе шатаас бүрдэх бөгөөд шинжилгээний үр дүнг харуулъя.




Зураг 1.3.3 Хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үндсэн үе шат

Зураг 1.3.3-аас харвал хэргийн материалтай танилцах үе шатанд дунджаар нэг хэргийг хянан шийдвэрлэхэд нийт хугацааны 38.1% буюу 148 минут, хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхэд бэлтгэх үе шатанд 11.3% буюу 44 минут, шийдвэр боловсруулах, хянах, гарын үсэг зурах үе шатанд 37.9% буюу 147 минут, хэргийг эцэслэн шийдвэрлэсний дараах ажиллагааны үе шатанд 12.6% буюу 49 минут зарцуулдаг байна.



Зураг 1.3.4 Дүүргүүдийн хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд зарцуулах хугацаа, үе шатаар

Зураг 1.3.3-д харуулсан үр дүнг судалгаанд хамрагдсан шүүх тус бүрээр задалж харуулбал хэргийн 1-р үед шатанд Налайх дүүрэг Баянзүрх дүүргээс 4.7 дахин их хугацаа, хэргийн 3-р үед шатанд 1.6 дахин их хугацаа зарцуулдаг байна. Хэргийн 2-р үед хоёр дүүрэг ижил хугацаа зарцуулдаг байхад 4-р үед Баянзүрх дүүрэг Налайх дүүргээс 1.5 дахин их хугацаа зарцуулдаг байна.




Зураг 1.3.5 Хэрэг хянан шийдвэрлэх үе шатанд хамаарах ажиллагааны хугацаа, хэргийн төрлөөр

Зураг 1.3.3-д харуулсан ерөнхий мэдээллийг Эрүүгийн хэргийн төрөл тус бүрээр Зураг 1.3.5-д дэлгэрэнгүй оруулав. Хэрэг хянан шийдвэрлэх 1-р үе шатанд бүх хэргийн төрөл, зүйл ангийн ажиллагаанд зарцуулах хугацаа 127-167 минут байна. Хэрэг хянан шийдвэрлэх 2-р үе шатанд судалгаанд авсан бүх зүйл ангийн ажиллагаанд зарцуулах хугацаа ойролцоо буюу 40-55 минут байна. Хэргийн 3-р үе шатанд бүх хэргийн зүйл ангийн ажиллагаанд зарцуулах хугацаа 138-162 минут орчим байна. Хэргийн 4-р үе шатанд бүх хэргийн зүйл ангийн ажиллагаанд зарцуулах хугацаа 45-52 минут байна. Хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх 1-4-р үеийн шатны үйл ажиллагаанд зарцуулах хугацаа нь бүх хэргийн зүйл, ангийн хувьд ойролцоо дүнтэй байна.

1.3.1.2 Хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны 1-4-р үе шатанд зарцуулах хугацааны өгөгдөлд хийх шинжилгээ

- Хэргийн материалтай танилцах үе шат

Өмнөх бүлгийн Зураг 1.3.3-д харуулсан хэрэг хянан шийдвэрлэх үе шатыг ямар төрлийн ажиллагаанаас хамаарч харилцан адилгүй хугацаа зарцуулж байгааг 1-р үеийн хэргийн ажиллагаа тус бүрээр задалж харуулсан үр дүнг танилцуулъя.




Зураг 1.3.6 Хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх үеийн хэргийн материалтай танилцах үеийн ажиллагааны задаргаа

Зураг 1.3.6-аас харвал Эрүүгийн хэргийн шүүгч хэргийн материалтай танилцах үе шатанд зарцуулах нийт хугацааны 63.2% буюу 115 минутыг хэргийн материалтай уншиж танилцах, түүвэр гаргахад 11% буюу 20 минут, шаардлагатай хууль тогтоомжийг судлахад 15.4% буюу 28 минут, шүүхийн практик судлахад 10.4% буюу 19 минут тус тус зарцуулдаг байна.



Зураг 1.3.7 Дүүргүүдийн хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хэргийн материалтай танилцах үеийн ажиллагаанд зарцуулах хугацаа

Зураг 1.3.6-д харуулсан үр дүнг судалгаанд хамрагдсан шүүх тус бүрээр задалж харуулбал хэргийн материалыг уншиж судлах ажиллагааны хувьд Налайх дүүрэг Баянзүрх дүүргээс 3.4 дахин их хугацаа зарцуулдаг байна. Харин түүвэр гаргах, шаардлагатай хууль тогтоомжийг судлах, шүүхийн практик судлах ажиллагааны хувьд зөвхөн Налайх дүүргийн мэдээлэл ирсэн байна. Баянзүрх дүүргийн шүүхийн ажиглалтын мэдээлэл судалгааны багт задарч ирээгүй болно.



Зураг 1.3.8 Ажиглалтын өгөгдлөөр хялбаршуулсан журмаар хэргийн материалтай танилцах үеийн ажиллагаанд зарцуулах хугацаа, хэргийн төрлөөр


Зураг 1.3.6-д харуулсан Эрүүгийн хэргийн шүүгч хэргийн материалтай танилцах үе шатанд зарцуулах нийт хугацааг хэргийн төрөл тус бүрээр Зураг 1.3.8-д задалж харуулав. Хэрэг хянан шийдвэрлэх 1-р үе шат болох хэргийн материалтай танилцах үе шатны хэргийн материалыг уншиж судлах ажиллагааны Эрүүгийн хэргийн бүх төрөл, зүйл ангийн хувьд 94-132 минут зарцуулсан байна. Шаардлагатай хууль тогтоомжийг судлахад ажиллагаанд зарцуулах хугацаа бүх гэмт хэргийн төрлийн хувьд ойролцоо буюу 16-24 минут байна. Түүвэр гаргах ажиллагаанд 25-30 минут зарцуулсан байна. Шүүхийн практик судлах ажиллагаанд зарцуулах хугацааг бүх гэмт хэргийн төрлийн хувьд мөн ойролцоо буюу 17-21 минут зарцуулсан байна.

- Хялбаршуулсан журмаар хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхэд бэлтгэх үе




Зураг 1.3.9 Хялбаршуулсан журмаар хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхэд бэлтгэх үеийн ажиллагааны задаргаа

Зураг 1.3.9-өөс харвал Эрүүгийн хэргийн шүүгч хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхэд бэлтгэх үе шатанд зарцуулах нийт хугацааны 15.9% буюу 7 минутыг шүүх хуралдааны тов мэдэгдэх хуудсанд гарын үсэг зурахад, 11.4% буюу 5 минутыг нөлөөллийн мэдүүлэг хөтөлдөг талаар мэдээлэл өгсөн баримтыг хянаж, гарын үсэг зурахад, 72.7% буюу 32 минутыг шүүх хуралдаа хийхэд тус тус зарцуулдаг байна.




Зураг 1.3.10 Дүүргүүдийн хялбаршуулсан журмаар хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхэд бэлтгэх үеийн ажиллагаанд зарцуулах хугацаа

Зураг 1.3.9-д харуулсан үр дүнг судалгаанд хамрагдсан шүүх тус бүрээр задалж харуулбал шүүх хуралдааны тов мэдэгдэх хуудсанд гарын үсэг зурахад Баянзүрх дүүрэг Налайх дүүргээс 2 дахин их хугацаа, нөлөөллийн мэдүүлэг хөтөлдөг талаар мэдээлэл өгсөн баримтыг хянаж, гарын үсэг зурахад хоёр дүүрэг ижил хугацаа, шүүх хуралдаанд Налайх дүүрэг Баянзүрх дүүргээс 1.4 дахин их хугацаа зарцуулдаг байна.



Зураг 1.3.11 Ажиглалтын өгөгдлөөр хялбаршуулсан журмаар хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхэд бэлтгэх үеийн ажиллагаанд зарцуулах хугацаа, хэргийн төрлөөр


Зураг 1.3.9-д харуулсан Эрүүгийн хэргийн шүүгч хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхэд бэлтгэх үе шатанд зарцуулах нийт хугацааг хэргийн төрөл тус бүрээр Зураг 1.3.11-д задалж харуулав. Хэрэг хянан шийдвэрлэх 2-р үе шатны шүүх хуралдааны тов мэдэгдэх хуудсанд гарын үсэг зурахад бүх гэмт хэргийн төрлийн хувьд 6-9 минут зарцуулдаг байна. Нөлөөллийн мэдүүлэг хөтөлдөг талаар мэдээлэл өгсөн баримтыг хянаж, гарын үсэг зурахад 5-6 минут зарцуулдаг байна. Шүүх хуралдаанд бүх гэмт хэргийн төрлийн хувьд 29-42 минут байна. Хэрэг хянан шийдвэрлэх 2-р үе шатны ажиллагаа тус бүр бүх хэргийн төрөл зүйлийн хувьд ойролцоо хугацаа зарцуулдаг байна. Шүүх хуралдаан дотроо дараах 3 хэсгээс бүрдсэн байхаар ажиглалт явуулсан байсан тул үзүүлэлт бүрийн хувьд тооцсон үр дүнг дурдъя.



Зураг 1.3.12 Шүүх хуралдааны ажиллагааны задаргаа


Зураг 1.3.9-д шүүх хуралдаанд 32 минут зарцуулдаг гэж үзсэн ерөнхий дүнг ажиллагаа тус бүрээр задалж үзэхэд зөвлөлдөхөд 17 минут, шүүхээс гарсан шийдвэрийн тогтоох хэсгийг танилцуулах, үндэслэлийг тайлбарлахад 15 минут зарцуулдаг байна. Харин завсарлуулах ажиглалтын мэдээлэл судалгааны багт задарч ирээгүй хоосон байсан болно.

- *Хэргийн шийдвэр боловсруулах, хянах, гарын үсэг зурах үе шат*




Зураг 1.3.13 Хялбаршуулсан журмаар шийдвэр боловсруулах үеийн ажиллагааны задаргаа

Зураг 1.3.13-д Эрүүгийн хэргийн шүүгчийн шийдвэр боловсруулах үе шатанд зарцуулах нийт хугацааг тус шатны ажиллагаа тус бүрээр задалж тооцсон үр дүнг харуулав. Энэ үе шатны шүүх хуралдааны тэмдэглэл хянаж, гарын үсэг зурахад 29 минут, шүүгчийн захирамж гаргахад 21 минут, ерөнхий шүүгчийн захирамж гаргахад 12 минут, шийтгэх, цагаатгах тогтоол гаргахад 91 минутыг тус тус зарцуулдаг гэсэн байна. Шүүхийн шийтгэврийн ажиглалтын мэдээлэл судалгааны багт ирээгүй хоосон байсан.



Зураг 1.3.14 Дүүргүүдийн хялбаршуулсан журмаар шийдвэр боловсруулах үеийн ажиллагаанд зарцуулах хугацаа

Зураг 1.3.13-д харуулсан үр дүнг шүүхээр задалж харуулбал шүүх хуралдааны тэмдэглэл хянаж, гарын үсэг зурахад 28, 30 минут буюу ойролцоо хугацаа, шүүгчийн захирамж гаргахад Баянзүрх дүүрэг Налайх дүүргээс 2 дахин их хугацаа, ерөнхий шүүгчийн захирамж гаргахад 11, 14 минут буюу ойролцоо хугацаа шийтгэх, цагаатгах тогтоол гаргахад Налайх дүүрэг Баянзүрх дүүргээс 2.6 дахин их хугацаа зарцуулдаг байна.



Зураг 1.3.15 Ажиглалтын өгөгдлөөр хялбаршуулсан журмаар шийдвэр боловсруулах үеийн ажиллагаанд зарцуулах хугацаа, хэргийн төрлөөр

Зураг 1.3.13-д харуулсан Эрүүгийн хэргийн шүүгчийн шийдвэр боловсруулах үе шатанд зарцуулах нийт хугацааг хэргийн төрөл тус бүрээр дараах зурагт задалж харуулав. Хэрэг хянан шийдвэрлэх 3-р үе шатны бүх ажиллагаанд зарцуулах хугацаа гэмт хэргийн бүх төрлийн хувьд ойролцоо дүнтэй байна. Хэрэг хянан шийдвэрлэх 3-р үе шатны ажиллагааны ерөнхий шүүгчийн захирамж, шүүгчийн захирамж, шийтгэх, цагаатгах тогтоолын ажиглалтын мэдээлэл задаргаатай орж ирсэн тул үзүүлэлт тус бүрээр тооцсон үр дүнг дурдъя.




Зураг 1.3.16 Шийдвэр боловсруулах үеийн зарим ажиллагааны задаргаа



Зураг 1.3.13-д дурдсан ерөнхий шүүгчийн захирамжийн ажиглалтын үр дүнг задалж үзэхэд ерөнхий шүүгчийн захирамжийг хянахад 8 минут, боловсруулахад 9 минут тус тус зарцуулдаг болох нь тооцоогоор гарав. Бусад ажиллагааны үзүүлэлтийг мөн адил ойлгоно.

• **Хэрэг хянан шийдвэрлэсний дараах үе шат**




Зураг 1.3.17 Хэрэг хянан шийдвэрлэсний дараах үеийн ажиллагааны задаргаа

Зураг 1.3.17-д Эрүүгийн хэргийн шүүгчийн хэрэг хянан шийдвэрлэсний дараах үе шатанд зарцуулах нийт хугацааг тус шатны ажиллагаа тус бүрээр задалж тооцсон үр дүнг харуулав. Энэ үе шатны гүйцэтгэх хуудас хянаж, гарын үсэг зурахад 8 минут, эрүүгийн хариуцлага хүлээлгэсэн тухай тэмдэглэл хянаж, гарын үсэг зурахад 8 минут, эмхэтгэсэн хэргийг хянаж баримтад гарын үсэг зурахад 12 минут, шүүгчийн залруулгын захирамж гаргахад 24 минут тус тус зарцуулдаг нь ажиглалтаар харагдав.



Зураг 1.3.18 Дүүргүүдийн хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэсний дараах үеийн ажиллагаанд зарцуулах хугацаа

Зураг 1.3.17-д харуулсан үр дүнг шүүхээр задалж харуулбал эрүүгийн хариуцлага хүлээлгэсэн тухай тэмдэглэл хянаж, гарын үсэг зурахад Баянзүрх дүүрэг Налайх дүүргээс 2.2 дахин их хугацаа, эмхэтгэсэн хэргийг хянаж баримтад гарын үсэг зурахад 12 минут буюу ижил хугацаа, шүүгчийн залруулгын захирамж гаргахад Баянзүрх дүүрэг Налайх дүүргээс 3.5 дахин их хугацаа, гүйцэтгэх хуудас хянаж, гарын үсэг зурахад 10, 13 минут буюу ойролцоо хугацаа зарцуулдаг байна.



Зураг 1.3.19 Ажиглалтын өгөгдлөөр хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэсний дараах үеийн ажиллагаанд зарцуулах хугацаа, хэргийн төрлөөр


Хэрэг хянан шийдвэрлэх 4-р үе шатны хувьд бүх хэргийн төрөл зүйл ангиар эрүүгийн хариуцлага хүлээлгэсэн тухай тэмдэглэл хянаж, гарын үсэг зурахад 7-9 минут, эмхэтгэсэн хэргийг хянаж баримтад гарын үсэг зурахад 10-14 минут, шүүгчийн залруулгын захирамж гаргахад 22-26 минут, гүйцэтгэх хуудас хянаж, гарын үсэг зурахад 11-13 минут буюу ойролцоо хугацаа зарцуулдаг байна.



1.3.2 Ердийн журмаар хянан шийдвэрлэсэн эрүүгийн хэргийн ажиглалтын өгөгдөлд хийх шинжилгээ


1.3.2.1 Ажиглалтын өгөгдлийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны ерөнхий дүн ба үе шатуудын хувьд хийх шинжилгээ

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэдэг шүүгчийн ажлын ажиллагааны ачааллыг бодитой тодорхойлохын тулд Баянзүрх, Налайх дүүргийн тус тус нэг шүүгчийн ердийн журмаар эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх үйл ажиллагаанд ажлын байрны зураг авалт хийж, өгөгдөл цуглуулан шинжилгээ хийсэн үр дүнг танилцуулж байна.



Зураг 1.3.20 Ердийн журмаар хэрэг хянан шийдвэрлэхэд зарцуулах хугацааны тухай ажиглалтын өгөгдлийн ерөнхий мэдээлэл

Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан зүйл, анги тус бүрийн ажиллагаанд зарцуулах хугацааны тухай Баянзүрх, Налайх дүүргийн Эрүүгийн хэргийн хоёр шүүгчийн ажлын байрны зураг авалтын үр дүнд цуглуулсан 40 өгөгдөлд хийсэн 3 хүчин зүйлийн дисперсийн шинжилгээний үр дүнг Зураг 1.3.20-д харуулав. Зургаас харвал Налайх дүүргийн Эрүүгийн хэргийн шүүгч 1 эрүүгийн хэргийг ердийн журмаар шийдэхэд 1693 минут, Баянзүрх, Налайх дүүргийн шүүгч 1363 минут зарцуулдаг байна. Харин шүүгч 1 эрүүгийн хэргийг ердийн журмаар шийдэхэд 1660 минут зарцуулдаг бол ерөнхий шүүгч 1396 минут зарцуулдаг байна. Хэрэг хянан шийдвэрлэх хугацааг Эрүүгийн хэргийн зүйл анги тус бүрээр нь задалж харуулсан зургаас харвал судалгаанд хамрагдсан хэргийн зүйл ангиудын хувьд 1043-1999 минут зарцуулдаг байна. Зураг авалтад хамрагдсан хоёр дүүргийн шүүхийн хувьд Налайх дүүргийн шүүгч судалгаанд хамрагдсан хэргийн зүйл ангиудын хувьд 1033-2603 минут зарцуулдаг байхад Баянзүрх дүүргийн шүүгч 1053-1884 минут зарцуулдаг төлөв ажиглагдсан байна.



Зураг 1.3.21 Ердийн журмаар хэрэг хянан шийдвэрлэхэд зарцуулах хугацааны тухай ажиглалтын өгөгдөл, хэргийн зүйл анги ба дүүргээр

Дисперсийн шинжилгээний программын үр дүнгээр детерминац, корреляц, вариацийн коэффициентийг тооцсон үр дүнг дараах хүснэгтээр харуулья.

№	Үзүүлэлт	Детерминацийн коэффициент	Корреляцийн коэффициент	Вариацийн коэффициент	Дундаж
1	Шүүх	0.17	0.41	68%	1528
2	Хэрэг	0.60	0.77	37%	
3	Шүүгч	0.40	0.64	45%	
4	Шүүх, Шүүгч	0.27	0.52	55%	
5	Шүүх, Хэрэг	0.41	0.64	44%	


Хүснэгт 1.3. 2 Ажиглалтын өгөгдлийн хэрэг хянан шийдвэрлэх хугацаанд нөлөөлөх хүчин зүйлүүд

Хүснэгтийн зөвхөн 4-р мөрний утгыг тайлбарлая. Хэргийг ердийн журмаар хянан шийдвэрлэхэд зарцуулах хугацааны өөрчлөлтийн 0.27 нь шүүхийн тогтолцоо (захын ба төвийн дүүрэг) ба шүүгчийн ангилал (ерөнхий шүүгч, шүүгч)-аас хамаарч байна.




Хэргийг ердийн журмаар хянан шийдвэрлэхэд зарцуулах хугацаа шүүхийн тогтолцоо ба шүүгчийн ангиллаас 0.64 буюу дунд зэрэг хамааралтай байна. Вариацийн коэффициент 45% тул тоон үзүүлэлтүүд нэгэн төрлийн бөгөөд дунджийг бусад тоон утгыг төлөөлөх чадвартай гэж үзнэ. Мөн шүүгчийн ангилал (ерөнхий шүүгч, шүүгч), шүүхийн тогтолцоо ба хэргийн төрөл, зүйл ангид зарцуулах хугацааны хувьд дундаж утгыг судалгаанд цааш нь ашиглах боломжтой.

Ердийн журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үе шат дараах үндсэн зургаан үе шатаас бүрдэх бөгөөд шинжилгээний үр дүнг харуулъя.




Зураг 1.3.22 Ердийн журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үндсэн үе шат

Зураг 1.3.22-оос харвал хэргийн материалтай танилцах үе шатанд дунджаар нэг хэргийг хянан шийдвэрлэхэд нийт хугацааны 30.9% буюу 492 минут, хэрэг хүлээн авснаас хойших ажиллагааны үе шатанд 9.8% буюу 156 минут, урьдчилсан хэлэлцүүлгийн хуралдаанаас шийдвэр гаргах үе шатанд 16.2% буюу 258 минут, хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхэд бэлтгэх үе шатанд 18.2% буюу 290 минут, шийдвэр боловсруулах, хянах, гарын үсэг зурах үе шатанд 21% буюу 334 минут, хэргийг эцэслэн шийдвэрлэсний дараах ажиллагааны үе шатанд 3.8% буюу 60 минут тус тус зарцуулдаг байна.



Зураг 1.3.23 Дүүргүүдийн ердийн журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд зарцуулах хугацаа, үе шатаар

Зураг 1.3.23-д харуулсан үр дүнг судалгаанд хамрагдсан шүүх тус бүрээр задалж харуулбал хэргийн 1-р үед шатанд Налайх дүүрэг Баянзүрх дүүргээс 1.7 дахин их хугацаа, хэргийн 3-р үед шатанд 1.8 дахин их хугацаа, хэргийн 4-р үед шатанд 1.1 дахин их хугацаа зарцуулдаг байна. Хэргийн 2-р үед хоёр дүүрэг ойролцоо хугацаа зарцуулдаг байхад 5, 6-р үед Баянзүрх дүүрэг Налайх дүүргээс 1.1, 1.5 дахин их хугацааг тус тус зарцуулдаг байна.



Зураг 1.3.24 Хэрэг хянан шийдвэрлэх үе шатанд хамаарах ажиллагааны хугацаа, хэргийн төрлөөр

Зураг 1.3.22-д харуулсан ерөнхий мэдээллийг Эрүүгийн хэргийн төрөл тус бүрээр Зураг 1.3.24-д дэлгэрэнгүй оруулав. Зургаас харвал хэрэг хянан шийдвэрлэх 1-р үе шатанд бүх хэргийн төрөл, зүйл ангийн ажиллагаанд зарцуулах хугацаа 323-714 минут байна. Хэрэг хянан




шийдвэрлэх 2-р үе шатанд судалгаанд авсан бүх зүйл ангийн ажиллагаанд зарцуулах хугацаа ойролцоо буюу 125-198 минут байна. Хэргийн 3-р үе шатанд бүх хэргийн зүйл ангийн ажиллагаанд зарцуулах хугацаа 190-306 минут орчим байна. Хэргийн 4-р үе шатанд бүх хэргийн зүйл ангийн ажиллагаанд зарцуулах хугацаа 141-437 минут байна. Хэргийн 5-р үе шатанд бүх хэргийн зүйл ангийн ажиллагаанд зарцуулах хугацаа 197-693 минут байна. Хэргийн 6-р үе шатанд бүх хэргийн зүйл ангийн ажиллагаанд зарцуулах хугацаа 45-70 минут байна.

1.3.2.2 Ердийн журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны 1-6-р үе шатанд зарцуулах хугацааны өгөгдөлд хийх шинжилгээ


• Хэргийн материалтай танилцах үе шат

Зураг 1.3.22-д харуулсан хэрэг хянан шийдвэрлэх үе шатыг ямар төрлийн ажиллагаанаас хамаарч харилцан адилгүй хугацаа зарцуулж байгааг 1-р үеийн хэргийн ажиллагаа тус бүрээр задалж харуулсан үр дүнг танилцуулъя.




Зураг 1.3.25 Ердийн журмаар хэрэг хянан шийдвэрлэх үеийн хэргийн материалтай танилцах үеийн ажиллагааны задаргаа

Зураг 1.3.25-аас харвал Эрүүгийн хэргийн шүүгч хэргийн материалтай танилцах үе шатанд зарцуулах нийт хугацааны 65.6% буюу 328 минутыг хэргийн материалтай уншиж танилцах, шаардлагатай хууль тогтоомжийг судлахад 9.8% буюу 49 минут, түүвэр гаргахад 12.6% буюу 63 минут, шүүхийн практик судлахад 6.6% буюу 33 минут, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг төлөвлөхөд 5.4% буюу 27 минут зарцуулдаг байна.



Зураг 1.3.26 Дүүргүүдийн ердийн журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хэргийн материалтай танилцах үеийн ажиллагаанд зарцуулах хугацаа

Зураг 1.3.25-д харуулсан үр дүнг судалгаанд хамрагдсан шүүх тус бүрээр задалж харуулбал хэргийн материалыг уншиж судлах ажиллагааны хувьд Налайх дүүрэг Баянзүрх дүүргээс 2.1 дахин их хугацаа зарцуулдаг байна. Харин шаардлагатай хууль тогтоомжийг судлах, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг төлөвлөх ажиллагааны хувьд хоёр дүүрэг ойролцоо хугацаа зарцуулдаг байна. Түүвэр гаргах ажиллагааны хувьд Баянзүрх дүүрэг Налайх дүүргээс 1.7 дахин их хугацаа зарцуулдаг байна. Шүүхийн практик судлах ажиллагааны хувьд Налайх дүүрэг Баянзүрх дүүргээс 1.8 дахин их хугацаа зарцуулдаг байна.




Зураг 1.3.27 Ажиглалтын өгөгдлийн ердийн журмаар хэргийн материалтай танилцах үеийн ажиллагаанд зарцуулах хугацаа, хэргийн төрлөөр



Зураг 1.3.25-д харуулсан Эрүүгийн хэргийн шүүгч хэргийн материалтай танилцах үе шатанд зарцуулах нийт хугацааг хэргийн төрөл тус бүрээр Зураг 1.3.27-д задалж харуулав. Хэрэг хянан шийдвэрлэх 1-р үе шат болох хэргийн материалтай танилцах үе шатны хэргийн материалыг уншиж судлах ажиллагаанд эрүүгийн хэргийн бүх төрөл, зүйл ангийн хувьд 198-538 минут зарцуулсан байна. 11.1, 17.1-2 хэргийг уншиж судлах хугацаа харьцангуй их байгаа нь ажиглалтын өгөгдөл хэт өндөр орж ирсэнтэй холбоотой. Энэ ажиллагааны ажиглалтын анхны өгөгдлийн утгыг нягталж хянасны үндсэн дээр судалгааны багт өгч шинжилгээнд оруулсан эсэх нь эргэлзээтэй байна. Шаардлагатай хууль тогтоомжийг судлах ажиллагаанд зарцуулах хугацаа бүх гэмт хэргийн төрлийн хувьд ойролцоо буюу 40-59 минут байна. Түүвэр гаргах ажиллагаанд 43-97 минут зарцуулсан байна. Шүүхийн практик судлах ажиллагаанд зарцуулах хугацаа бүх гэмт хэргийн төрлийн хувьд мөн ойролцоо буюу 23-39 минут байна. ХХША-г төлөвлөх ажиллагаанд зарцуулах хугацаа мөн бүх гэмт хэргийн төрлийн хувьд мөн ойролцоо буюу 21-36 минут байна.

• *Хэрэг хүлээн авснаас хойших ажиллагааны үе шат*




Зураг 1.3.28 Ердийн журмаар хэрэг хянан шийдвэрлэх үеийн хэрэг хүлээн авснаас хойших ажиллагааны задаргаа

Зураг 1.3.28-аас харвал Эрүүгийн хэргийн шүүгч хэрэг хүлээн авснаас хойших ажиллагааны үе шатанд зарцуулах нийт хугацааны 25.5% буюу 41 минутыг ТСАХ-тай холбоотой хүсэлтийг шийдвэрлэхэд, 28.6% буюу 46 минутыг хэргийг харьяалах шүүхэд шилжүүлэх эсэхийг шийдвэрлэх шүүгчийн захирамж гаргахад, 25.5% буюу 41 минутыг хэргийг түдгэлзүүлэх үндэслэл бий болсон эсэхийг шийдвэрлэсэн шүүгчийн захирамж гаргахад, 20.5% буюу 33 минутыг урьдчилсан хэлэлцүүлэг хийлгэх хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэхэд тус тус зарцуулдаг байна.




Зураг 1.3.29 Дүүргүүдийн ердийн журмаар хэрэг хянан шийдвэрлэх үеийн хэрэг хүлээн авснаас хойших ажиллагаанд зарцуулах хугацаа

Зураг 1.3.28-д харуулсан үр дүнг судалгаанд хамрагдсан шүүх тус бүрээр задалж харуулбал ТСАХ-тай холбоотой хүсэлтийг шийдвэрлэх, хэргийг түдгэлзүүлэх үндэслэл бий болсон эсэхийг шийдвэрлэсэн шүүгчийн захирамж гаргах, урьдчилсан хэлэлцүүлэг хийлгэх хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэх ажиллагаанд зарцуулах хугацаа хоёр дүүргийн хувьд ойролцоо байна. Харин хэргийг харьяалах шүүхэд шилжүүлэх эсэхийг шийдвэрлэх шүүгчийн захирамж гаргах ажиллагааны хувьд Налайх дүүрэг Баянзүрх дүүргээс 1.7 дахин бага хугацаа зарцуулдаг байна.



Зураг 1.3.30 Ажиглалтын өгөгдлийн ердийн журмаар хэрэг хянан шийдвэрлэх үеийн хэрэг хүлээн авснаас хойших ажиллагаанд зарцуулах хугацаа, хэргийн төрлөөр


Зураг 1.3.28-д харуулсан хэрэг хүлээн авснаас хойших үеийн ажиллагаанд зарцуулах нийт хугацааг хэргийн төрөл тус бүрээр Зураг 1.3.30-д задалж харуулав. Хэрэг хүлээн авснаас хойших үе шат буюу 2-р үе шатны ТСАХ-тай холбоотой хүсэлтийг шийдвэрлэх ажиллагаанд эрүүгийн хэргийн бүх төрөл, зүйл ангийн хувьд 34-55 минут зарцуулдаг байна. 27.10-2-оос бусад хэргийн хувьд 33-46 минут зарцуулдаг байна. 27.10-2 хэргийн ТСАХ-тай холбоотой хүсэлтийг шийдвэрлэх ажиллагаанд 130 минут буюу харьцангуй их байгаа нь ажиглалтын өгөгдөл хэт өндөр орж ирсэнтэй холбоотой. Энэ ажиллагааны ажиглалтын анхны өгөгдлийн утгыг нягталж хянасны үндсэн дээр судалгааны багт өгч шинжилгээнд оруулсан эсэх нь эргэлзээтэй байна. Хэргийг харьяалах шүүхэд шилжүүлэх эсэхийг шийдвэрлэх шүүгчийн захирамж гаргах ажиллагаанд 30-48 минут зарцуулдаг байна. Урьдчилсан хэлэлцүүлэг хийлгэх хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэх ажиллагаанд 27-40 минут зарцуулдаг байна. Хэрэг хянан шийдвэрлэх 2-р үе шатны ажиллагаа дотроо дараах 2 хэсгээс бүрдсэн байхаар задалж ажиглалт явуулсан байсан тул үзүүлэлт бүрийн хувьд тооцсон үр дүнг дурдъя.



Зураг 1.3.31 Ердийн журмаар хэрэг хянан шийдвэрлэх үеийн хэрэг хүлээн авснаас хойших ажиллагааны задаргаа

Зураг 1.3.31-д дурдсан ТСАХ-тай холбоотой хүсэлтийг шийдвэрлэх ажиллагааны ажиглалтын үр дүнг задалж үзэхэд ТСАХ-тай холбоотой хүсэлтийн шийдвэрийг хянахад 10 минут, боловсруулахад 39 минут тус тус зарцуулдаг болох нь тооцоогоор гарав. Бусад ажиллагааны үзүүлэлтийг мөн адил ойлгоно.

• **Урьдчилсан хэлэлцүүлгийн хуралдаанаас шийдвэр гаргах үе шат**



Зураг 1.3.32 Ердийн журмаар хэрэг хянан шийдвэрлэх үеийн урьдчилсан хэлэлцүүлгийн хуралдаанаас шийдвэр гаргах ажиллагааны задаргаа

Зураг 1.3.32-оос харвал Эрүүгийн хэргийн шүүгч урьдчилсан хэлэлцүүлгийн хуралдаанаас шийдвэр гаргах ажиллагааны үе шатанд зарцуулах нийт хугацааны 14.5% буюу 39 минутыг эрэн сурвалжлах, албадан ирүүлэх шүүгчийн захирамж гаргахад,




60.2% буюу 162 минутыг хэргийн прокурорт буцаах шүүгчийн захирамж гаргахад, 12.3% буюу 33 минутыг хэргийн оролцогчийг шүүх хуралдаанд оролцуулах эсэх хүсэлтийг шийдвэрлэхэд, 13% буюу 35 минутыг яллагдагчийг шүүхэд шилжүүлэх шүүгчийн захирамж гаргахад тус тус зарцуулдаг байна.



Зураг 1.3.33 Дүүргүүдийн ердийн журмаар хэрэг хянан шийдвэрлэх үеийн урьдчилсан хэлэлцүүлгийн хуралдаанаас шийдвэр гаргах ажиллагаанд зарцуулах хугацаа

Зураг 1.3.33-д харуулсан үр дүнг судалгаанд хамрагдсан шүүх тус бүрээр задалж харуулбал эрэн сурвалжлах, албадан ирүүлэх шүүгчийн захирамж гаргах, хэргийн оролцогчийг шүүх хуралдаанд оролцуулах эсэх хүсэлтийг шийдвэрлэх, яллагдагчийг шүүхэд шилжүүлэх шүүгчийн захирамж гаргах ажиллагаанд зарцуулах хугацаа хоёр дүүргийн хувьд ойролцоо байна. Харин хэргийн прокурорт буцаах шүүгчийн захирамж гаргахад Налайх дүүрэг Баянзүрх дүүргээс 3 дахин их хугацаа зарцуулдаг байна.



Зураг 1.3.34 Урьдчилсан хэлэлцүүлгийн хуралдаанаас шийдвэр гаргах ажиллагаанд зарцуулах хугацаа, хэргийн төрлөөр

Зургаас харвал хэрэг хянан шийдвэрлэх 3-р үе шатны хэргийг прокурорт буцаах шүүгчийн захирамж гаргах ажиллагаанд зарцуулах хугацаа бусад ажиллагааг бодвол харьцангуй их хугацаа зарцуулдаг байна. Энэ үе шатны дээрх ажиллагааг ажиглалтын өгөгдлөөр задалсан шинжилгээний үр дүнг дараах зурагт харуулав.



Зураг 1.3.35 Ердийн журмаар хэрэг хянан шийдвэрлэх үеийн урьдчилсан хэлэлцүүлгийн хуралдаанаас шийдвэр гаргах ажиллагааны задаргаа

Зураг 1.3.34-д дурдсан хэргийг прокурорт буцаах шүүгчийн захирамж гаргах ажиллагааны ажиглалтын үр дүнг задалж үзэхэд хэргийг прокурорт буцаах шүүгчийн захирамжийг хянахад 23 минут, боловсруулахад 186 минут тус тус зарцуулдаг болох нь тооцоогоор гарав. Хэргийг прокурорт буцаах шүүгчийн захирамжийг боловсруулах ажиллагаанд хянах ажиллагаанаас 8 дахин их хугацаа зарцуулдаг байна. Бусад ажиллагааны үзүүлэлтийг мөн адил ойлгоно.

• **Ердийн журмаар хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхэд бэлтгэх үе**




Зураг 1.3.36 Ердийн журмаар хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхэд бэлтгэх үеийн зарцуулах хугацаа

Зураг 1.3.36-аас харвал хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхэд бэлтгэх үе шатанд зарцуулах нийт хугацааны 3.3% буюу 10 минутыг хэргийн оролцогчдод шүүх хуралдааны тов мэдэгдэх хуудсанд гарын үсэг зурах, шүүхийн иргэдийн төлөөлөгчид мэдээлэл өгсөн баримтад гарын үсэг зурахад, 2.3% буюу 7 минутыг нөлөөллийн мэдүүлэг хөтөлдөг талаар мэдээлэл өгсөн баримтыг хянаж, гарын үсэг зурах ажиллагаанд зарцуулдаг байна. Харин энэ үе шатны 91% буюу 273 минутыг шүүх хуралдаанд зарцуулдаг байна.



Зураг 1.3.37 Дүүргүүдийн ердийн журмаар хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхэд бэлтгэх үеийн ажиллагаанд зарцуулах хугацаа

Зураг 1.3.36-д харуулсан үр дүнг судалгаанд хамрагдсан шүүх тус бүрээр задалж харуулбал шүүх хуралдааны тов мэдэгдэх хуудсанд гарын үсэг зурах ба шүүхийн иргэдийн төлөөлөгчид мэдээлэл өгсөн баримтад гарын үсэг зурахад Баянзүрх дүүрэг Налайх дүүргээс 3 дахин их хугацаа, нөлөөллийн мэдүүлэг хөтөлдөг талаар мэдээлэл өгсөн баримтыг хянаж, гарын үсэг зурах болон шүүх хуралдаанд хоёр дүүрэг ойролцоо хугацаа зарцуулдаг байна.




Зураг 1.3.38 Ажиглалтын өгөгдлийн хялбаршуулсан журмаар хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхэд бэлтгэх үеийн ажиллагаанд зарцуулах хугацаа, хэргийн төрлөөр

Зураг 1.3.36-д харуулсан Эрүүгийн хэргийн шүүгчийн хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхэд бэлтгэх ажиллагааны үе шатанд зарцуулах нийт хугацааг хэргийн төрөл тус бүрээр Зураг 1.3.38-д задалж харуулав. Хэрэг хянан шийдвэрлэх 4-р үе шатны шүүх хуралдааны тов мэдэгдэх хуудсанд гарын үсэг зурахад бүх гэмт хэргийн төрлийн хувьд 7-12 минут зарцуулдаг байна. Нөлөөллийн мэдүүлэг хөтөлдөг талаар мэдээлэл өгсөн баримтыг хянаж, гарын үсэг зурахад 6-8 минут зарцуулдаг байна. Шүүх хуралдаанд бүх гэмт хэргийн төрлийн хувьд 127-420 минут зарцуулдаг байна. Шүүхийн иргэдийн төлөөлөгчид мэдээлэл өгсөн баримтад гарын үсэг зурах ажиллагааны ажиглалтын утга зөвхөн 22.4 хэргийн үзүүлэлтээр ирсэн бөгөөд бусад хэргийн өгөгдөл ажиглалтын утгаар




задарч ирээгүй байна. Шүүх хуралдаан дотроо дараах 3 хэсгээс бүрдсэн байхаар ажиглалт явуулсан байсан тул үзүүлэлт бүрийн хувьд тооцсон үр дүнг дурдъя.



Зураг 1.3.39 Шүүх хуралдааны ажиллагааны задаргаа


Зураг 1.3.36-д шүүх хуралдаанд 273 минут зарцуулдаг гэж үзсэн ерөнхий дүнг ажиллагаа тус бүрээр задалж үзэхэд дангаар явуулах хуралдаанд 154 минут, бүрэлдэхүүн даргалах хуралдаанд 175 минут, зөвлөлдөхөд 37 минут, завсарлуулахад 15 минут, шүүхээс гарсан шийдвэрийн тогтоох хэсгийг танилцуулах, үндэслэлийг тайлбарлахад 25 минут зарцуулдаг байна.

• **Хэргийн шийдвэр боловсруулах, хянах, гарын үсэг зурах үе шат**




Зураг 1.3.40 Ердийн журмаар шийдвэр гаргах үеийн ажиллагааны задаргаа

Зураг 1.3.40-өөс харвал шийдвэр гаргах үеийн ажиллагаанд зарцуулах нийт хугацааны 12.5% буюу 43 минутыг шүүгчийн захирамж гаргахад, 13.3% буюу 46 минутыг шүүх хуралдааны тэмдэглэл хянаж, гарын үсэг зурахад, 11% буюу 38 минутыг шүүхийн тогтоол гаргахад, 15% буюу 52 минутыг шүүхийн шийтгэвэр гаргахад, 48.3% буюу 167 минутыг шийтгэх, цагаатгах тогтоол гаргахад тус тус зарцуулдаг байна.



Зураг 1.3.41 Дүүргүүдийн ердийн журмаар шийдвэр гаргах үеийн ажиллагаанд зарцуулах хугацаа

Зураг 1.3.40-д харуулсан үр дүнг шүүхээр задалж харуулбал шүүх хуралдааны тэмдэглэл хянаж, гарын үсэг зурах, шийтгэх цагаатгах тогтоол гаргахад ойролцоо хугацаа, шүүгчийн захирамж гаргах, шүүхийн тогтоол гаргахад Баянзүрх дүүрэг Налайх дүүргээс 1.5 ба 2 дахин их хугацаа тус тус зарцуулдаг байна. Шүүхийн шийтгэврийн ажиглалтын өгөгдөл Баянзүрх дүүргийн хувьд задарч ирээгүй болно.




Зураг 1.3.42 Ажиглалтын өгөгдлийн ердийн журмаар шийдвэр гаргах үеийн ажиллагаанд зарцуулах хугацаа, хэргийн төрлөөр

Зураг 1.3.40-д харуулсан шийдвэр гаргах, гарын үсэг зурах ажиллагааны үе шатанд зарцуулах нийт хугацааг хэргийн төрөл тус бүрээр Зураг 1.3.42-д задалж



харуулав. Хэрэг хянан шийдвэрлэх 5-р үе шатны бүх ажиллагаанд зарцуулах хугацааны хувьд шүүх хуралдааны тэмдэглэл хянаж, гарын үсэг зурахад 25-75 минут, шүүхийн тогтоол гаргахад 33-52 минут, шүүхийн шийтгэвэр гаргахад 40-53 минутыг тус тус зарцуулдаг байна. Харин шүүгчийн захирамж гаргах ажиллагааны 27.10-2 хэргийн ажиллагаанд зарцуулах хугацаа 460 минут буюу бусад хэргийн ажиллагаанд зарцуулах хугацаанаас 9-12 дахин их байгаа нь ажиглалтын өгөгдөл хэт өндөр орж ирсэнтэй холбоотой. Энэ ажиллагааны ажиглалтын анхны өгөгдлийн утгыг нягталж хянасны үндсэн дээр судалгааны багт өгч шинжилгээнд оруулаагүй байна гэсэн үг юм. Шийтгэх, цагаатгах тогтоолын 22.4 хэргийн хувьд мөн адил юм. Хэрэг хянан шийдвэрлэх 5-р үе шатны ажиллагааны шүүгчийн захирамж, шүүхийн тогтоол, шүүхийн шийтгэвэр, шийтгэх, цагаатгах тогтоолын ажиглалтын мэдээлэл задаргаатай орж ирсэн тул үзүүлэлт тус бүрээр тооцсон үр дүнг дурдъя.



Зураг 1.3.43 Шийдвэр боловсруулах үеийн зарим ажиллагааны задаргаа

Зураг 1.3.40-д дурдсан шүүгчийн захирамжийн ажиглалтын үр дүнг задалж үзэхэд шүүгчийн захирамжийг хянахад 9 минут, боловсруулахад 33 минут тус тус зарцуулдаг болох нь тооцоогоор гарав. Шүүгчийн захирамжийг боловсруулах ажиллагаанд хянах ажиллагаанаас 3.6 дахин их хугацаа зарцуулдаг байна. Бусад ажиллагааны үзүүлэлтийг мөн адил ойлгоно.



Зураг 1.3.44 Хэрэг хянан шийдвэрлэсний дараах үеийн ажиллагааны задаргаа


Зураг 1.3.44-д хэрэг хянан шийдвэрлэсний дараах үе шатанд зарцуулах нийт хугацааг тус шатны ажиллагаа тус бүрээр задалж тооцсон үр дүнг харуулав. Энэ үе шатны нийт ажиллагаанд зарцуулах хугацааны 40% буюу 28 минутыг шүүгчийн залруулгын захирамж гаргахад, 22.9% буюу 16 минутыг гүйцэтгэх хуудас хянаж гарын үсэг зурахад, 17.1% буюу 12 минутыг эмхэтгэсэн хэргийг хянаж баримтад гарын үсэг зурахад, 20% буюу 14 минутыг эрүүгийн хариуцлага хүлээлгэсэн тухай тэмдэглэл хянаж, гарын үсэг зурахад тус тус зарцуулдаг нь ажиглалтаар харагдав.



Зураг 1.3.45 Дүүргүүдийн ердийн журмаар хэрэг хянан шийдвэрлэсний дараах үеийн ажиллагаанд зарцуулах хугацаа



Зураг 1.3.44-д харуулсан үр дүнг шүүхээр задалж харуулбал эмхэтгэсэн хэргийг хянаж баримтад гарын үсэг зурахад ойролцоо хугацаа зарцуулдаг байна. Баянзүрх дүүрэг Налайх дүүргээс шүүгчийн залруулгын захирамж гаргахад 2.8, гүйцэтгэх хуудас хянаж, гарын үсэг зурахад 2.4, эрүүгийн хариуцлага хүлээлгэсэн тухай тэмдэглэл хянаж, гарын үсэг зурахад 1.8 дахин их хугацаа тус тус зарцуулдаг байна.



Зураг 1.3.46 Ажиглалтын өгөгдлийн ердийн журмаар хэрэг хянан шийдвэрлэсний дараах үеийн ажиллагаанд зарцуулах хугацаа, хэргийн төрлөөр

Хэрэг хянан шийдвэрлэх 6-р үе шатны хувьд бүх хэргийн төрөл зүйл ангиар шүүгчийн залруулгын захирамж гаргахад 19-34 минут, гүйцэтгэх хуудас хянаж, гарын үсэг зурахад 12-19 минут, эмхэтгэсэн хэргийг хянаж баримтад гарын үсэг зурахад 10-13 минут буюу ойролцоо хугацаа, эрүүгийн хариуцлага хүлээлгэсэн тухай тэмдэглэл хянаж, гарын үсэг зурахад 11-18 минут тус тус зарцуулдаг байна.

1.3.3 Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн хянан шийдвэрлэсэн хэргийн ажиглалтын өгөгдөлд хийх шинжилгээ

1.3.3.1 ДЗШШ-ийн ажиглалтын өгөгдлийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны ерөнхий дүн ба үе шатуудын хувьд хийх шинжилгээ

Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгчийн ажлын ажиллагааны ачааллыг бодитой тодорхойлохын тулд Дархан, Нийслэлийн эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн тус тус нэг шүүгчийн эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх үйл ажиллагаанд ажлын байрны зураг авалт хийж, өгөгдөл цуглуулан шинжилгээ хийсэн үр дүнг танилцуулъя.




Зураг 1.3.47 Давж заалдах шатны шүүхийн хэрэг хянан шийдвэрлэхэд зарцуулах хугацааны тухай ажиглалтын өгөгдлийн ерөнхий мэдээлэл

Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан зүйл, анги тус бүрийн ажиллагаанд зарцуулах хугацааны тухай Дархан, Нийслэлийн эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн хоёр шүүгчийн ажлын байрны зураг авалтын үр дүнд цуглуулсан 54 өгөгдөлд хийсэн 3 хүчин зүйлийн дисперсийн шинжилгээний үр дүнг Зураг 1.3.47-д харуулав. Зургаас харвал Дарханы эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгч 1 эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэхэд 1369 минут, Нийслэлийн шүүгч 858 минут зарцуулдаг байна. Харин эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн ерөнхий шүүгч ба шүүгчийн хэргийг хянан шийдвэрлэхэд зарцуулах хугацаа 1121-1126 минут буюу ойролцоо байна. Давж заалдах шатны шүүхийн хэрэг хянан шийдвэрлэх хугацааг Эрүүгийн хэргийн зүйл анги тус бүрээр нь задалж харуулсан зургаас харвал судалгаанд хамрагдсан хэргийн зүйл ангиудын хувьд 818-1760 минут зарцуулдаг байна. Зураг авалтад хамрагдсан хоёр шүүхийн хувьд Дарханы давж заалдах шатны шүүхийн шүүгч судалгаанд хамрагдсан хэргийн зүйл ангиудын хувьд 1035-1869 минут зарцуулдаг



байхад Нийслэлийн шүүгч 523-1650 минут зарцуулдаг төлөв ажиглагдсан байна. Нийслэлийн давж заалдах шатны шүүхийн 17.12-1-ийн хянан шийдвэрлэх ажиллагааны ажиглалтын утга судалгааны багт ирээгүй байна.



Зураг 1.3.48 Давж заалдах шатны шүүхийн хэрэг хянан шийдвэрлэхэд зарцуулах хугацааны тухай ажиглалтын өгөгдөл, хэргийн зүйл анги ба дүүргээр

Дисперсийн шинжилгээний программын үр дүнгээр детерминац, корреляц, вариацийн коэффициентийг тооцсон үр дүнг дараах хүснэгтээр харуулъя.

№	Үзүүлэлт	Детерминацийн коэффициент	Корреляцийн коэффициент	Вариацийн коэффициент	Дундаж
1	Шүүх	0.03	0.18	166%	1123
2	Хэрэг	0.06	0.24	124%	
3	Шүүх, Шүүгч	0.52	0.72	42%	

Хүснэгт 1.3.3 Ажиглалтын өгөгдлийн хэрэг хянан шийдвэрлэх хугацаанд нөлөөлөх хүчин зүйлүүд


Хүснэгтийн зөвхөн 3-р мөрний утгыг тайлбарлая. Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн хэрэг хянан шийдвэрлэхэд зарцуулах хугацааны өөрчлөлтийн 0.52 нь шүүхийн тогтолцоо (захын ба төвийн дүүрэг) ба шүүгчийн ангилал (ерөнхий шүүгч, шүүгч)-аас хамаарч байна. Хэрэг хянан шийдвэрлэхэд зарцуулах хугацаа шүүхийн тогтолцоо ба шүүгчийн ангиллаас 0.72 буюу хүчтэй хамааралтай байна. Вариацийн коэффициент 42% тул тоон үзүүлэлтүүд нэгэн төрлийн бөгөөд дунджийг бусад тоон утгыг төлөөлөх чадвартай гэж үзнэ.

Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үе шат дараах үндсэн таван үе шатаас бүрдэх бөгөөд шинжилгээний үр дүнг харуулъя.



Зураг 1.3.49 Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үндсэн үе шат


Зураг 1.3.49-өөс харвал хэргийн материалтай танилцах үе шатанд дунджаар нэг хэргийг хянан шийдвэрлэхэд нийт хугацааны 44.7% буюу 504 минут, хэрэг хүлээн авснаас хойших ажиллагааны үе шатанд 8.9% буюу 100 минут, хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхэд бэлтгэх үе шатанд 11.4% буюу 129 минут, шийдвэр боловсруулах, хянах, гарын үсэг зурах үе шатанд 30.4% буюу 343 минут, хэргийг хянан шийдвэрлэсний дараах ажиллагааны үе шатанд 4.6% буюу 52 минут зарцуулдаг байна.



Зураг 1.3.50 ЭХДЗШШ-ийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд зарцуулах хугацаа, үе шатаар



Зураг 1.3.49-д харуулсан үр дүнг судалгаанд хамрагдсан шүүх тус бүрээр задалж харуулбал хэргийн бүх үед шатанд хоёр шүүхийн шүүгч ойролцоо хугацаа зарцуулдаг байна.




Зураг 1.3.51 Хэрэг хянан шийдвэрлэх үе шатанд хамаарах ажиллагааны хугацаа, хэргийн төрлөөр

Зураг 1.3.49-д харуулсан ерөнхий мэдээллийг Эрүүгийн хэргийн төрөл тус бүрээр Зураг 1.3.51-д дэлгэрэнгүй оруулав. Зургаас харвал хэрэг хянан шийдвэрлэх 1-р үе шатанд бүх хэргийн төрөл, зүйл ангийн ажиллагаанд зарцуулах хугацаа 323-714 минут байна. Хэрэг хянан шийдвэрлэх 2-р үе шатанд судалгаанд авсан бүх зүйл ангийн ажиллагаанд зарцуулах хугацаа ойролцоо буюу 125-198 минут байна. Хэргийн 3-р үе шатанд бүх хэргийн зүйл ангийн ажиллагаанд зарцуулах хугацаа 190-306 минут орчим байна. Хэргийн 4-р үе шатанд бүх хэргийн зүйл ангийн ажиллагаанд зарцуулах хугацаа 141-437 минут байна. Хэргийн 5-р үе шатанд бүх хэргийн зүйл ангийн ажиллагаанд зарцуулах хугацаа 197-693 минут байна. Хэргийн 6-р үе шатанд бүх хэргийн зүйл ангийн ажиллагаанд зарцуулах хугацаа 45-70 минут байна.

1.3.3.2 Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны 1-5-р үе шатанд зарцуулах хугацааны өгөгдөлд хийх шинжилгээ


• Хэргийн материалтай танилцах үе шат

Зураг 1.3.49-д харуулсан хэрэг хянан шийдвэрлэх үе шатыг ямар төрлийн ажиллагаанаас хамаарч харилцан адилгүй хугацаа зарцуулж байгааг 1-р үеийн хэргийн ажиллагаа тус бүрээр задалж харуулсан үр дүнг танилцуулъя.




Зураг 1.3.52 ЭХДЗШШ-ийн хэргийн материалтай танилцах үеийн ажиллагааны задаргаа

Зураг 1.3.52-оос харвал хэргийн материалтай танилцах үе шатанд зарцуулах нийт хугацааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг төлөвлөхөд 10.7% буюу 54 минут, хэргийн материалтай уншиж танилцахад 36.6% буюу 184 минут, шаардлагатай хууль тогтоомжийг судлахад 14.3% буюу 72 минут, түүвэр гаргахад 24.2% буюу 122 минут, шүүхийн практик судлахад 14.1% буюу 71 минутыг тус тус зарцуулдаг байна.



Зураг 1.3.53 ЭХДЗШШ-үүдийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хэргийн материалтай танилцах үеийн ажиллагаанд зарцуулах хугацаа

Зураг 1.3.53-д харуулсан үр дүнг судалгаанд хамрагдсан шүүх тус бүрээр задалж харуулбал хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг төлөвлөх, шаардлагатай хууль тогтоомжийг судлах, шүүхийн практик судлах ажиллагааны хувьд хоёр шүүх ойролцоо хугацаа зарцуулдаг байна. Харин Дарханы шүүх Нийслэлийн дүүргээс хэргийн материалыг уншиж судлах ажиллагааны хувьд 1.3 дахин бага хугацаа, түүвэр гаргах ажиллагааны хувьд 1.4 дахин бага хугацаа зарцуулдаг байна.




Зураг 1.3.54 Ажиглалтын өгөгдлийн хэргийн материалтай танилцах үеийн ажиллагаанд зарцуулах хугацаа, хэргийн төрлөөр

Зураг 1.3.52-д харуулсан хэргийн материалтай танилцах үе шатанд зарцуулах нийт хугацааг хэргийн төрөл тус бүрээр Зураг 1.3.54-д задалж харуулав. Хэрэг хянан шийдвэрлэх 1-р үе шат болох хэргийн материалтай танилцах үе шатны ХХША-г төлөвлөх ажиллагаанд зарцуулах хугацаа бүх хэргийн төрлийн хувьд 23-81 минут байна. Зөвхөн 17.1-1-д 10 минут буюу харьцангуй бага хугацаа зарцуулдаг байна. Хэргийн материалыг уншиж судлах ажиллагаанд эрүүгийн хэргийн 22.4-өөс бусад төрөл, зүйл ангийн хувьд 75-227 минут зарцуулдаг байна. Эрүүгийн 22.4-ийн хэргийг уншиж судлах хугацаа харьцангуй их байгаа нь ажиглалтын өгөгдөл хэт өндөр орж ирсэнтэй холбоотой. Энэ ажиллагааны ажиглалтын анхны өгөгдлийн утгыг нягталж хянасны үндсэн дээр судалгааны багт өгч шинжилгээнд оруулсан эсэх нь эргэлзээтэй байна. Шаардлагатай хууль тогтоомжийг судлах ажиллагаанд зарцуулах хугацаа ихэнх гэмт хэргийн төрлийн хувьд 35-102 минут байна. 11.6-1, 17.5-1, 20.7-1 хэргийн шаардлагатай хууль тогтоомжийг судлах ажиллагаанд 10-25 минут буюу харьцангуй бага хугацаа зарцуулдаг байна. Түүвэр гаргах ажиллагаанд ихэнх гэмт хэргийн төрлийн хувьд 74-197 минут зарцуулдаг байна. 11.4-1, 17.3-1, 27.10-2 хэргийн шаардлагатай хууль тогтоомжийг судлах ажиллагаанд 30-36 минут буюу харьцангуй бага хугацаа зарцуулдаг байна. Шүүхийн практик судлах ажиллагаанд зарцуулах хугацаа бүх гэмт хэргийн төрлийн хувьд 33-90 минут байна.



• **Хэрэг хүлээн авснаас хойших ажиллагааны үе шат**




Зураг 1.3.55 Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн хэрэг хянан шийдвэрлэх үеийн хэрэг хүлээн авснаас хойших ажиллагааны задаргаа

Зураг 1.3.55-аас харвал хэрэг хүлээн авснаас хойших ажиллагааны үе шатанд зарцуулах нийт хугацааны 30.7% буюу 31 минутыг ТСАХ-тай холбоотой хүсэлтийг шийдвэрлэхэд, 36.6% буюу 37 минутыг хэргийг хэлэлцүүлэхгүй тухай шүүгчийн захирамж гаргахад, 32.7% буюу 33 минутыг хэргийг түдгэлзүүлэх үндэслэл бий болсон эсэхийг шийдвэрлэсэн шүүгчийн захирамж гаргахад тус тус зарцуулдаг байна.




Зураг 1.3.56 Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхүүдийн хэрэг хянан шийдвэрлэх үеийн хэрэг хүлээн авснаас хойших ажиллагаанд зарцуулах хугацаа

Зураг 1.3.56-д харуулсан үр дүнг судалгаанд хамрагдсан шүүх тус бүрээр задалж харуулбал ТСАХ-тай холбоотой хүсэлтийг шийдвэрлэх, хэргийг түдгэлзүүлэх үндэслэл бий болсон эсэхийг шийдвэрлэсэн шүүгчийн захирамж гаргах ажиллагаанд зарцуулах хугацаа хоёр дүүргийн хувьд ойролцоо байна. Хэргийг хэлэлцүүлэхгүй тухай шүүгчийн захирамж гаргах ажиллагааны хувьд Дарханы шүүх Нийслэлийн дүүргээс 1.7 дахин бага хугацаа зарцуулдаг байна.



Зураг 1.3.57 Ажиглалтын өгөгдлийн ердийн журмаар хэрэг хянан шийдвэрлэх үеийн хэрэг хүлээн авснаас хойших ажиллагаанд зарцуулах хугацаа, хэргийн төрлөөр

Зураг 1.3.55-д харуулсан хэрэг хүлээн авснаас хойших үеийн ажиллагаанд зарцуулах нийт хугацааг хэргийн төрөл тус бүрээр Зураг 1.3.57-д задалж харуулав. Хэрэг хүлээн авснаас хойших үе шат буюу 2-р үе шатны ТСАХ-тай холбоотой хүсэлтийг шийдвэрлэх ажиллагаанд эрүүгийн хэргийн ихэнх төрөл, зүйл ангийн хувьд 25-46 минут зарцуулдаг байна. 11.1-1 хэргийн ТСАХ-тай холбоотой хүсэлтийг шийдвэрлэх ажиллагаанд 9 минут буюу харьцангуй бага байна. Хэргийг хэлэлцүүлэхгүй тухай шүүгчийн захирамж гаргах ажиллагааны хувьд харьцуулагдахуйц биш ялгаатай үр дүнг харуулсан байна. 11.4-1, 17.1-1, 17.5-1, 20.7-1, 27.10-1 хэргийн ажиллагаанд зарцуулах хугацаа 59-78 минут байна. Бусад хэргийн хувьд 5-40 минут байна. Хэргийг түдгэлзүүлэх үндэслэл бий болсон эсэхийг шийдвэрлэсэн шүүгчийн захирамж гаргахад мөн адил харьцуулагдахуйц биш ялгаатай хугацаа ажиглагдаж байна. Хэрэг хүлээн авснаас хойших үеийн ажиллагаанууд дотроо дараах 2 хэсгээс бүрдсэн байхаар задалж ажиглалт явуулсан байсан тул үзүүлэлт бүрийн хувьд тооцсон үр дүнг дурдъя.



Зураг 1.3.58 Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхүүдийн хэрэг хүлээн авснаас хойших үеийн ажиллагааны задаргаа


Зураг 1.3.55-д дурдсан ТСАХ-тай холбоотой хүсэлтийг шийдвэрлэх ажиллагааны ажиглалтын үр дүнг задалж үзэхэд ТСАХ-тай холбоотой хүсэлтийн шийдвэрийг хянахад 9 минут, боловсруулахад 28 минут тус тус зарцуулдаг болох нь тооцоогоор гарав. Бусад ажиллагааны үзүүлэлтийг мөн адил ойлгоно.

• *Хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхэд бэлтгэх үе*




Зураг 1.3.59 ЭХДЗШШ-ийн хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхэд бэлтгэх үеийн хугацаа

Зураг 1.3.59-өөс харвал хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхэд бэлтгэх үе шатанд зарцуулах нийт хугацааны 13.3% буюу 19 минутыг хэргийн оролцогчдод шүүх хуралдааны тов мэдэгдэх хуудсанд гарын үсэг зурахад, 86.7% буюу 124 минутыг шүүх хуралдаанд зарцуулдаг байна.



Зураг 1.3.60 ЭХДЗШШ-ийн хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхэд бэлтгэх үеийн ажиллагаанд зарцуулах хугацаа

Зураг 1.3.59-д харуулсан үр дүнг судалгаанд хамрагдсан шүүх тус бүрээр задалж харуулбал Дарханы шүүх Нийслэлийн шүүхээс шүүх хуралдааны тов мэдэгдэх хуудсанд гарын үсэг зурахад 6.8 дахин бага хугацаа, шүүх хуралдаанд 6 дахин бага хугацаа зарцуулдаг байна. Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхүүдийн ажиглалтын өгөгдөл бодитой эсэх, сайн нягталсан эсэхэд эргэлзээ төрүүлэхээр байна.




Зураг 1.3.61 Ажиглалтын өгөгдлийн хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхэд бэлтгэх үеийн ажиллагаанд зарцуулах хугацаа, хэргийн төрлөөр

Зураг 1.3.59-д харуулсан хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхэд бэлтгэх ажиллагааны үе шатанд зарцуулах нийт хугацааг хэргийн төрөл тус бүрээр Зураг 1.3.65-д задалж харуулав. Хэрэг хянан шийдвэрлэх 3-р үе шатны шүүх хуралдааны тов мэдэгдэх хуудсанд гарын үсэг зурахад бүх гэмт хэргийн төрлийн хувьд 15-20 минут зарцуулдаг байна. Зарим хэргийн өгөгдөл ажиглалтын утгаар задарч ирээгүй байна.




Шүүх хуралдаанд бүх гэмт хэргийн төрлийн хувьд 78-215 минут зарцуулдаг байна. Шүүх хуралдаан дотроо дараах 4 хэсгээс бүрдсэн байхаар ажиглалт явуулсан байсан тул үзүүлэлт бүрийн хувьд тооцсон үр дүнг дурдъя.



Зураг 1.3.62 Шүүх хуралдааны ажиллагааны задаргаа

Зураг 1.3.59-д шүүх хуралдаанд 124 минут зарцуулдаг гэж үзсэн ерөнхий дүнг ажиллагаа тус бүрээр задалж үзэхэд хуралдаанд илтгэхэд 56 минут, зөвлөлдөхөд 35 минут, завсарлуулахад 21 минут, шүүхээс гарсан магадлалын тогтоох хэсгийг танилцуулах, үндэслэлийг тайлбарлахад 17 минут зарцуулдаг байна.

• Хэргийн шийдвэр боловсруулах, хянах, гарын үсэг зурах үе шат




Зураг 1.3.63 ЭХДЗШШ-үүдийн шийдвэр гаргах үеийн ажиллагааны задаргаа

Зураг 1.3.63-аас харвал шийдвэр гаргах үеийн ажиллагаанд зарцуулах нийт хугацааны 43.4% буюу 149 минутыг магадлалд, 10.5% буюу 36 минутыг шүүхийн тогтоол гаргахад, 29.1% буюу 100 минутыг шүүх хуралдааны тэмдэглэл хянаж, гарын үсэг зурахад, 9.6% буюу 33 минутыг шүүгчийн захирамж гаргахад, 7.3% буюу 25 минутыг ерөнхий шүүгчийн захирамж гаргахад тус тус зарцуулдаг байна.



Зураг 1.3.64 ЭХДЗШШ-ийн шийдвэр гаргах үеийн ажиллагаанд зарцуулах хугацаа


Зураг 1.3.63-д харуулсан үр дүнг шүүхээр задалж харуулбал энэ үе шатны бүх ажиллагаанд зарцуулах хугацаа ойролцоо байна.



Зураг 1.3.65 Ажиглалтын өгөгдлийн шийдвэр гаргах үеийн ажиллагаанд зарцуулах хугацаа, хэргийн төрлөөр



Зураг 1.3.67-д харуулсан шийдвэр гаргах, гарын үсэг зурах ажиллагааны үе шатанд зарцуулах нийт хугацааг хэргийн төрөл тус бүрээр Зураг 1.3.69-д задалж харуулав. Хэрэг хянан шийдвэрлэх 4-р үе шатны ажиллагаануудад зарцуулах хугацааны хувьд магадлалд 88-219 минут, шүүх хуралдааны тэмдэглэл хянаж, гарын үсэг зурахад 60-130 минут, ерөнхий шүүгчийн захирамж гаргахад 15-47 минут тус тус зарцуулдаг байна. Шүүхийн тогтоол гаргах, шүүгчийн захирамж гаргах ажиллагаанд зарцуулах хугацаа 18-64 минут байна. Хэрэг хянан шийдвэрлэх 4-р үе шатны ажиллагааны ерөнхий шүүгчийн захирамж, шүүгчийн захирамж, шүүхийн тогтоолын ажиглалтын мэдээлэл задаргаатай орж ирсэн тул үзүүлэлт тус бүрээр задалж тооцсон үр дүнг дурдъя.



Зураг 1.3.66 Шийдвэр боловсруулах үеийн зарим ажиллагааны задаргаа

Зураг 1.3.67-д дурдсан шүүгчийн захирамжийн ажиглалтын үр дүнг задалж үзэхэд шүүгчийн захирамжийг хянахад 5 минут, боловсруулахад 9 минут тус тус зарцуулдаг болох нь тооцоогоор гарав. Шүүгчийн захирамжийг боловсруулах ажиллагаанд хянах ажиллагаанаас 1.8 дахин их хугацаа зарцуулдаг байна. Бусад ажиллагааны үзүүлэлтийг мөн адил ойлгоно.

• **Хэрэг хянан шийдвэрлэсний дараах үе шат**




Зураг 1.3.67 Хэрэг хянан шийдвэрлэсний дараах үеийн ажиллагааны задаргаа

Зураг 1.3.67-оос харвал энэ үе шатны нийт ажиллагаанд зарцуулах хугацааны 42.3% буюу 22 минутыг мэдэгдэх хуудас хянаж, гарын үсэг зурахад, 57.7% буюу 30 минутыг шүүгчийн залруулгын захирамж, шүүхийн тогтоол гаргахад тус тус зарцуулдаг нь ажиглалтын өгөгдлийн шинжилгээгээр тогтоогдов.



Зураг 1.3.68 Хэрэг хянан шийдвэрлэсний дараах үеийн ажиллагаанд зарцуулах хугацаа

Зураг 1.3.71-д харуулсан үр дүнг шүүхээр задалж харуулбал энэ үе шатны ажиллагаа тус бүрийн хувьд шүүхүүд ойролцоо хугацаа зарцуулдаг байна.



Зураг 1.3.69 Ажиглалтын өгөгдлийн хэрэг хянан шийдвэрлэсний дараах үеийн ажиллагаанд зарцуулах хугацаа, хэргийн төрөл



Хэрэг хянан шийдвэрлэх 5-р үе шатны хувьд бүх хэргийн төрөл зүйл ангийн хувьд мэдэгдэх хуудас хянаж, гарын үсэг зурахад 16-35 минут зарцуулдаг байна. Харин шүүгчийн залруулгын захирамж, шүүхийн тогтоол гаргахад хэргийн төрөл зүйл ангийн хувьд хэт ялгаатай хугацаа зарцуулдаг гэсэн мэдээллийг өгч байна. Ажиглалтын өгөгдлийг нягтлах шаардлагатай байсан байна.



2.1 Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгч нараас авсан зөрчлийн хэргийн асуумжид хийх шинжилгээ

Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн хянан шийдвэрлэсэн зөрчлийн хэргийн ажиллагааны ачааллыг бодитой тодорхойлохын тулд ШЕЗ-ийн судалгаа шинжилгээний баг Зөрчлийн тухай хуульд заасан 10 төрлийн гэмт хэргийг хүснэгт дэх ажиллагааны үзүүлэлтийн дагуу шүүгч нараас асуумж авч тоон мэдээлэл цуглуулан шинжилгээ хийсэн үр дүнг энэ бүлэг танилцуулна. Судалгаанд дараах гэмт хэргийн төрөлд хамаарах асуумжийг авсан. Үүнд:

5.1 - Олон нийтийн газарт зүй бусаар биеэ авч явах

5.2 - Танхайрах

5.3 - Хүний биед халдах

5.4 - Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих

6.26 - Бэлгийн дарамт учруулах

8.6 - Хулгайлах

14.7-3 - Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчих

14.7-5 - Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчих

14.7-55- Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчих

15.3-Шүүх хуралдаанд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр шүүхийн иргэдийн төлөөлөгчөөр оролцохоос зайлсхийх, шүүхийн үйл ажиллагаанд саад учруулах

2.1.1 Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээр хянан шийдвэрлэсэн зөрчлийн хэргийн асуумжийн өгөгдөлд хийх шинжилгээ

Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн зөрчлийн хэргийн ажиллагааны ачааллын асуумжид шинжилгээ хийхэд ашигласан өгөгдлийн танилцуулгыг дараах хүснэгтээр харуулъя.

№	Шүүхийн нэр	5.1	5.2	5.3	5.4	6.26	8.6	14.7-3	14.7-5	14.7-55	15.3	Дүн
1	Сонгинохайрхан	1	1	1	1	1	1	0	0	1	0	7
2	Баянгол	1	1	1	1	1	1	1	1	1	1	10
3	Хан-Уул	1	1	1	1	1	1	1	1	1	1	10
4	Налайх	1	1	1	1	1	1	1	1	1	1	10
5	Архангай	1	1	1	1	1	1	1	1	1	1	10
6	Булган	1	1	1	1	1	1	1	1	1	1	10
7	Баянхонгор	1	1	1	1	1	1	1	1	1	1	10
8	Говь-Алтай	1	1	1	1	1	1	1	1	1	1	10
9	Завхан	1	1	1	1	1	1	1	1	1	1	10
10	Дархан-Уул	1	0	1	1	1	1	1	1	1	1	9
11	Дорноговь	1	0	1	1	1	1	1	1	1	1	9
12	Дундговь	1	1	1	1	1	1	1	1	1	1	10
13	Орхон	1	1	1	1	1	1	1	1	1	1	10
14	Өмнөговь	1	1	1	1	1	1	1	1	1	1	10
15	Сэлэнгэ	1	1	1	1	1	1	1	1	1	1	10
16	Төв	1	0	1	1	1	1	1	1	1	1	9
17	Увс	1	1	1	1	1	1	1	1	1	1	10
18	Ховд	1	0	1	1	1	1	1	1	1	1	9
19	Хөвсгөл	1	1	1	1	1	1	1	1	1	1	10
20	Тосонцэнгэл	1	1	1	1	1	1	1	0	1	1	9
21	Хархорин	1	1	1	1	1	1	1	0	1	1	9
22	Сайхан	0	0	1	1	1	1	1	0	0	1	6
23	Ховд Булган	1	1	1	1	1	1	1	0	1	1	9
24	Бор-Өндөр	1	1	1	1	1	1	1	0	1	1	9
25	Хархорин	0	1	1	1	1	1	1	0	1	1	8
Нийт		23	20	25	25	25	25	24	18	24	24	233

Хүснэгт 2.1.1 Анхан шатны шүүхийн зөрчлийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд зарцуулах хугацааны асуумжийн судалгаанд оролцсон шүүгчийн мэдээлэл

Монгол улсад Эрүүгийн хэргийн анхан шатны 38 шүүхээс Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүх, Баян-Өлгий, Говьсүмбэр, Дорнод, Өвөрхангай, Сүхбаатар, Хэнтий аймгууд дахь сум дундын шүүх болон сум дахь сум дундын 8



шүүхээс Өмнөговь аймгийн Ханбогд сум, Сэлэнгэ аймгийн Мандал сум дахь сум дундын шүүхүүдээс тус тус асуумж ирүүлээгүй байна. Баянзүрх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн хувьд ажлын байрны ажиглалтад хамрагдсаныг дурдах нь зүйтэй байна.

№	Шүүхийн нэр	5.1	5.2	5.3	5.4	6.26	8.6	14.7-3	14.7-5	14.7-55	15.3	Дүн
1	Сонгинохайрхан	1	1	1	1	1	1	0	0	1	0	7
2	Баянгол	1	1	1	1	1	1	1	1	1	1	10
3	Хан-Уул	1	1	1	1	1	1	1	1	1	1	10
4	Налайх	1	1	1	1	1	1	1	1	1	1	10
5	Архангай	1	1	1	1	1	1	1	1	1	1	1
6	Булган	1	1	1	1	1	1	1	1	1	1	1
7	Баянхонгор	1	1	1	1	1	1	1	1	1	1	1
8	Говь-Алтай	1	1	1	1	1	1	1	1	1	1	1
9	Завхан	1	1	1	1	1	1	1	1	1	1	1
10	Дундговь	1	1	1	1	1	1	1	1	1	1	1
11	Орхон	1	1	1	1	1	1	1	1	1	1	1
12	Өмнөговь	1	1	1	1	1	1	1	1	1	1	1
13	Сэлэнгэ	1	1	1	1	1	1	1	1	1	1	1
14	Увс	1	1	1	0	1	1	1	1	1	1	1
15	Хөвсгөл	1	1	1	1	1	1	1	1	1	1	1
16	Тосонцэнгэл	1	1	1	1	1	1	1	0	1	1	9
17	Хархорин	1	0	0	0	0	0	0	0	1	0	2
18	Ховд Булган	1	1	1	1	1	1	1	0	1	1	9
19	Бор-Өндөр	1	1	0	1	1	1	1	0	1	1	8
20	Хархорин	0	1	1	1	1	1	1	0	1	1	8
Нийт		19	19	18	18	19	19	18	14	20	18	182

Хүснэгт 2.1.2 Судалгаанд ашигласан өгөгдлийн мэдээ


Дархан-Уул, Дорноговь, Төв, Ховд аймгийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээс ирүүлсэн асуумжийн үр дүнг ашиглаагүй болно. Мөн улаан өнгөөр тодруулсан шүүхүүдийн мэдээлэл шинжилгээнд ашиглаагүй болно.

Судалгаанд оролцсон 26 шүүхийн 26 шүүгч Зөрчлийн тухай хуулийн 10 төрлийн зүйл ангийн хувьд 233 асуумж өгснөөс 22 шүүхийн 16 шүүгчийн 167 өгөгдлийг судалгаанд ашиглав.

2.1.1.1 Зөрчлийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үе шатуудад хийх шинжилгээ


Зөрчлийн тухай хуульд заасан зүйл, анги тус бүрийн ажиллагаанд зарцуулах хугацааны тухай нийслэл, аймаг, сум дундын шүүхийн Эрүүгийн хэргийн шүүгчдийн өгсөн 167 асуумжийн өгөгдөлд хийсэн 2 хүчин зүйлийн дисперсийн шинжилгээний үр дүнг Зураг 2.1.1-д харуулав. Зургаас харвал сум дахь сум дундын шүүхийн шүүгч нар 1 зөрчлийн хэргийг шийдэхэд 1638 минут, аймаг дахь шүүхийн шүүгчид 1120 минут, дүүрэг дэх эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгчид 256 минут, захын дүүргүүд 197 минут зарцуулдаг гэсэн байна.

1 зөрчлийн хэргийг шийдэхэд зарцуулах хугацааг Зөрчлийн тухай хуулийн зүйл анги тус бүрээр нь задалж харуулсан зургаас харвал 5.3-д 2498 минут, 5.4-д 2099 минут, 6.26-д хамгийн их буюу 2541 минут тус тус зарцуулдаг гэсэн асуулга өгсөн байна. Бусад хэргүүдийн хувьд 296-325 минут зарцуулдаг гэсэн байна.




Зураг 2.1.1 Зөрчлийн хэргийг хянан шийдвэрлэхэд зарцуулах хугацааны тухай асуумжийн ерөнхий мэдээлэл

Дисперсийн шинжилгээний хамтын нөлөөллийн үр дүнгээр Зураг 2.1.2-д харуулав. Зургаас харвал нийслэлийн сум дахь шүүхийн шүүгч зөрчлийн хэргийг хянан шийдвэрлэхдээ Зөрчлийн тухай хуулийн тухай хуулийн 6.26 дугаар зүйлээр 3441 минут зарцуулдаг гэж үзсэн байна.




Зураг 2.1.2 Зөрчлийн хэргийн шийдвэрлэх хугацаа, зүйл ангиар

Шүүгчийн ажлын туршлага, хэрэг хянан шийдвэрлэх хугацааны тухай бодит практик баримжаа, санал бодлыг энэхүү судалгаанд аль болох тусгаж оруулахыг судалгааны баг зорьсон ч зөрчлийн хэргийг хянан шийдвэрлэх хугацааны тухай захын дүүрэг, аймаг, сум дундын шүүхээс ирүүлсэн асуумжийн өгөгдлийн судалгааг цааш үргэлжлүүлэх шаардлагагүй болсон тул шинжилгээг зогсоов. Учир нь 5-р бүлгийн шүүгчийн ажлын ачаалал тооцох, хэргийн коэффициент тодорхойлох судалгаанд нэр дурдсан шүүхээс ирүүлсэн зөрчлийн хэрэг хянан шийдвэрлэх асуумжийн үр дүн шаардлага хангахгүй өгөгдөлд шилжиж байгаа тул бүтцийн болон дисперсийн шинжилгээг үргэлжлүүлэн хийх шаардлагагүй болов. Зөвхөн зөрчлийн хэрэг хянан шийдвэрлэх хугацааны тухай төвийн дүүргээс ирүүлсэн асуумжийн өгөгдлийг дараагийн судалгаанд ашиглана.



Зураг 2.1.3 Төвийн дүүргийн шүүхийн зөрчлийн хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааны үе шат

Зураг 2.1.3-аас харвал төвийн дүүргийн ЭХАШШШ-ийн зөрчлийн хэргийн материалтай танилцах үе шатанд дунджаар 15.1% буюу 38.6 минут, хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхэд бэлтгэх үе шатанд 18.9% буюу 48.3 минут, шийдвэр боловсруулах, хянах, гарын үсэг зурах үе шатанд 40.5% буюу 103.3 минут, хэргийг эцэслэн шийдвэрлэсний дараах ажиллагааны үе шатанд 25.4% буюу 64.9 минут зарцуулдаг байна.



Зураг 2.1.4 Төвийн дүүргийн шүүхийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд зарцуулах хугацаа, зөрчлийн хэргийн төрлөөр

Зураг 2.1.4-өөс харвал хэрэг хянан шийдвэрлэх 1, 2, 4-р үе шатанд Зөрчлийн тухай хуулийн 5.1 дүгээр зүйл ангийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд зарцуулах хугацаа хамгийн их буюу тус тус 63, 61, 76 минут байна. Нэгдүгээр үе шатанд 30-45 /5.1 дүгээр зүйл анги оруулахгүй дүн/ минутын хугацаа зарцуулж байна. Хэрэг хянан шийдвэрлэх 2-р үе шатанд судалгаанд 5.1 дүгээр зүйл ангиас бусад зүйл ангийн ажиллагаанд зарцуулах хугацаа ойролцоо буюу 46-49 минут байна. Хэргийн 3-р үе шатанд бүх хэргийн зүйл ангийн ажиллагаанд зарцуулах хугацаа 95-107 минут орчим гэж дүгнэгдсэн байна. Хэргийн 4-р үе шатанд бүх хэргийн зүйл ангийн ажиллагаанд зарцуулах хугацаа 63-76 минут орчим гэж дүгнэгдсэн байна. Зөрчлийн хэрэг хянан шийдвэрлэх 2, 3, 4-р үеийн шатны үйл ажиллагаанд зарцуулах хугацаа нь 5.1 дүгээр зүйл ангиас бусад хэргийн зүйл, ангийн хувьд ерөнхий дүгнэлттэй адил ойролцоо дүнтэй харагдаж байна.



2.1.2 Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгч нараас авсан зөрчлийн хэргийн асуумжид хийх шинжилгээ

Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгчийн хянан шийдвэрлэсэн зөрчлийн хэргийн ажиллагааны ачааллыг бодитой тодорхойлохын тулд ШЕЗ-ийн судалгаа шинжилгээний баг Зөрчлийн тухай хуульд заасан 10 төрлийн гэмт хэргийг хүснэгт дэх ажиллагааны үзүүлэлтийн дагуу шүүгч нараас асуумж авч тоон мэдээлэл цуглуулан шинжилгээ хийсэн үр дүнг энэ бүлэг танилцуулна. Судалгаанд дараах гэмт хэргийн төрөлд хамаарах асуумжийг авсан. Үүнд:

5.1 - Олон нийтийн газарт зүй бусаар биеэ авч явах

5.2 - Танхайрах

5.3 - Хүний биед халдах

5.4 - Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих

6.26 - Бэлгийн дарамт учруулах

8.6 - Хулгайлах

14.7-3 - Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчих

14.7-5 - Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчих

15.3-Шүүх хуралдаанд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр шүүхийн иргэдийн төлөөлөгчөөр оролцохоос зайлсхийх, шүүхийн үйл ажиллагаанд саад учруулах

2.1.1.2 Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхээр хянан шийдвэрлэсэн зөрчлийн хэргийн асуумжийн өгөгдөлд хийх шинжилгээ

Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн зөрчлийн хэргийн ажиллагааны ачааллын асуумжид шинжилгээ хийхэд ашигласан өгөгдлийн танилцуулгыг дараах хүснэгтээр харуулъя.

№	Шүүх	15.29	14.7-55	14.7-5	14.7-3	8.6	6.26	5.4	5.3	5.2	Дүн
1	Баянхонгор	1	1	1	1	1	1	1	1	1	9
2	Говь-Алтай	2	2	2	2	2	2	2	2	2	18
3	Орхон	1	1	1	1	1	1	1	1	1	9
4	Нэр байхгүй	2	2	2	2	2	2	2	2	2	18
5	Сүхбаатар	1	1	1	1	1	1	1	1	1	9
6	Увс	2	2	2	2	2	2	2	2	2	18
7	Хөвсгөл	1	1	1	1	1	1	1	1	1	9
	Нийт	10	10	10	10	10	10	10	10	10	90

Хүснэгт 2.1.3 ДЗШШ-ийн зөрчлийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд зарцуулах хугацааны асуумжийн судалгаанд оролцсон шүүгчийн мэдээлэл

Монгол улсад Эрүүгийн хэргийн давж заалдах шатны 22 шүүхээс Баянхонгор, Говь-Алтай, Орхон, Нэр байхгүй 2 шүүхээс, Сүхбаатар, Увс, Хөвсгөл аймгийн шүүхүүдээс зөрчлийн хэрэг шийдвэрлэх ажиллагаанд зарцуулж буй хугацаа тодорхойлох асуумжийн судалгааг бөглөн ирүүлсэн байна. Нийслэлийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүх болон Дархан-Уул аймаг дахь давж заалдах шатны шүүхүүдээс ажлын байрны ажиглалтын судалгааг авсан.

№	Шүүх	15.29	14.7-55	14.7-5	14.7-3	8.6	6.26	5.4	5.3	5.2	Дүн
1	Говь-Алтай	2	2	2	2	2	2	2	2	2	18
2	Орхон	1	1	1	1	1	1	1	1	1	9
	Нийт	3	3	3	3	3	3	3	3	3	27

Хүснэгт 2.1.4 Судалгаанд ашигласан өгөгдлийн мэдээ


Говь-Алтай аймаг болон Орхон аймгийн давж заалдах шатны шүүхийн шүүгчийн ирүүлсэн мэдээллийг ашигласан. Бусад аймгийн давж заалдах шатны шүүхийн ирүүлсэн хугацааны мэдээлэл хэт хөөсөрч өндөр өгсөн болон хэт доогуур өгсөн бусад аймгийн мэдээллийг судалгаанд ашиглах боломжгүй гэж үзсэн тул ашиглаагүй болно.

Судалгаанд оролцсон 8 шүүхийн 10 шүүгч Зөрчлийн тухай хуулийн 10 төрлийн зүйл ангийн хувьд 90 асуумж өгснөөс 2 шүүхийн 3 шүүгчийн 27 өгөгдлийг судалгаанд ашиглав.




2.1.1.3 Давж заалдах шатны шүүхээр зөрчлийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үе шатанд хийх шинжилгээ

Зөрчлийн тухай хуульд заасан зүйл, анги тус бүрийн ажиллагаанд зарцуулах хугацааны тухай давж заалдах шатны шүүхийн шүүгчдийн өгсөн 27 асуумжийн өгөгдөлд өгөгдөлд хийсэн шинжилгээний үр дүнгээс харвал давж заалдах шатны шүүхийн шүүгч 1 зөрчлийн хэргийг шийдэхэд 1505 минут зарцуулдаг гэсэн байна.




Зураг 2.1.5 Зөрчлийн хэрэг хянан шийдвэрлэх хугацааны тухай асуумжийн ерөнхий мэдээлэл

Зөрчлийн нэг хэргийг шийдэхэд зарцуулах хугацааг Зөрчлийн тухай хуулийн зүйл анги тус бүрээр нь задалж харуулсан зургаас харвал Зөрчлийн тухай хуулийн 14.7-3 дахь заалтад заасан зөрчлийн хэрэгт 1600 минут зарцуулдаг гэсэн асуулга өгсөн байна. Бусад зөрчлийн хэргүүдийн хувьд 1437-1560 минут зарцуулдаг гэсэн байна.



Зураг 2.1.6 Зөрчлийн хэргийг хянан шийдвэрлэх хэргийн ажиллагааны үе шат

Хэргийн материалтай танилцах үе шатанд дунджаар нэг хэргийг хянан шийдвэрлэхэд нийт хугацааны 29.1% буюу 438 минут, хэрэг хүлээн авснаас хойших ажиллагааны шатанд 16.6% буюу 250 минут, хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхэд бэлтгэх, хэлэлцэх үе шатанд 17.3% буюу 261 минут, шийдвэр боловсруулах, хянах, гарын үсэг зурах үе шатанд 30.8% буюу 463 минут, хэргийг эцэслэн шийдвэрлэсний дараах ажиллагааны үе шатанд 6.1% буюу 93 минут зарцуулдаг байна.




Зураг 2.1.9 Зөрчлийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд зарцуулах хугацаа, хэргийн төрлөөр

Ерөнхий мэдээллийг зөрчлийн хэргийн төрөл тус бүрээр дэлгэрэнгүй оруулав. Зургаас харвал хэрэг хянан шийдвэрлэх 1-р үе шатанд 6.26 болон 8.6 дугаар зүйлд заасан зөрчлийн хэргийн хэргийн ажиллагаанд зарцуулах хугацаа хамгийн их буюу тус тус 470 минут байна. Зөрчлийн хэрэг хянан шийдвэрлэх 1-р үе шатанд 396-470 минут, 2-р үе шатад 250 минут, 3-р үе шатад 243-313 минут, 4-р үе шатад 453-473 минут, 5-р үе шатанд 90-93 минут байна. Үе дотор зарцуулж буй минут зүйл анги тус бүр дээр ойролцоо байна. 1 болон 3-р үе шатуудад хамгийн их хугацаа зарцуулдаг гэж дүгнэж байна.



2.1.1.4 Зөрчлийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд зарцуулах хугацааны өгөгдөлд хийх шинжилгээ


Өмнөх бүлэгт харуулсан хэрэг хянан шийдвэрлэх үе шатыг ямар төрлийн ажиллагаанаас хамаарч харилцан адилгүй хугацаа зарцуулж байгааг хэргийн ажиллагаа тус бүрээр задалж харуулсан үр дүнг танилцуулъя.



Зураг 2.1.10 Зөрчлийн хэргийн материалтай танилцах үеийн ажиллагааны задаргаа


Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгч зөрчлийн хэргийн материалтай танилцах үе шатанд зарцуулах нийт хугацааны 36.4% буюу 160 минутыг хэргийн материалыг уншиж судлахад, 6% буюу 30 минутыг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг төлөвлөхөд, 17.7% буюу 78 минутыг түүвэр гаргахад, 24.6% буюу 108 минутыг шаардлагатай хууль тогтоомж судлахад, 14.3% буюу 63 минутыг шүүхийн практик судлахад зарцуулж байна.

Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгч зөрчлийн хэргийн материалтай танилцах үе шатанд зарцуулах нийт хугацааг хэргийн төрөл тус бүрээр задалж дараах зурагт харуулав.



Зураг 2.1.11 Зөрчлийн хэргийн материалтай танилцах үеийн ажиллагаанд зарцуулах хугацаа, хэргийн төрлөөр

Хэрэг хянан шийдвэрлэх 1-р үе шат болох хэргийн материалтай танилцах үе шатны хэргийн материалыг уншиж судлах ажиллагаанд Зөрчлийн тухай хуулийн асуумжид ирүүлсэн 10 зүйл ангид бүгд ижил буюу 160 минут зарцуулж байна гэсэн байна. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг төлөвлөх ажиллагааны хувьд асуумжаар авсан Зөрчлийн тухай хуулийн 10 зүйл мөн адил бүгд 30 минут, түүвэр гаргах ажиллагаанд 80 минут гэж тус тус бөглөсөн байна. Шаардлагатай хууль тогтоомжийг судлах ажиллагаанд 80-140 минут зарцуулдаг гэж үзсэн байна. Шүүхийн практик судлах ажиллагаанд 47-80 минут зарцуулдаг гэж үзсэн байна.




Зураг 2.1.12 Зөрчлийн хэргийг хүлээн авснаас хойших үеийн ажиллагааны задаргаа

Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгч зөрчлийн хэргийг хүлээн авснаас хойших ажиллагааны үе шатанд зарцуулах нийт хугацааны 36% буюу 90 минутыг хэргийг хэлэлцүүлэхгүй тухай шүүгчийн захирамжид, 36% буюу 90 минутыг таслан сэргийлэх




арга хэмжээтэй холбоотой хүсэлтийг шийдвэрлэхэд, 28% буюу 70 минутыг хэргийг түдгэлзүүлэх үндэслэл бий болсон эсэхийг шийдвэрлэсэн шүүгчийн захирамжид тус тус зарцуулдаг гэсэн байна.




Зураг 2.1.13 Зөрчлийн хэргийг хүлээн авснаас хойших үеийн ажиллагаанд зарцуулах хугацаа, хэргийн төрлөөр

Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгч зөрчлийн хэргийг хүлээн авснаас хойших ажиллагаанд зарцуулах нийт хугацааг төрөл тус бүрээр задалж харуулав. Хэрэг хянан шийдвэрлэх 1-р үе шатанд 70 минут, 2-р үе шатанд 90 минут, 3-р үе шатанд 90 минут тус тус зарцуулдаг гэсэн байна. Шүүх хуралдаан дотроо дараах 3 хэсгээс бүрдсэн байхаар асуумжийг задалж авсан тул үзүүлэлт бүрийн хувьд тооцсон үр дүнг дурдъя.




Зураг 2.1.14 Шийдвэр боловсруулах үеийн зарим ажиллагааны задаргаа

Хэргийг хэлэлцүүлэхгүй тухай шүүгчийн захирамжид 70 минут зарцуулдаг гэсэн асуумжийн үр дүнг задалж үзэхэд шүүгчийн захирамжийг хянахад 30 минут, боловсруулахад 40 минут зарцуулдаг болох нь тооцоогоор гарав. Таслан сэргийлэх арга хэмжээтэй холбоотой хүсэлтийг шийдвэрлэх болон хэргийг түдгэлзүүлэх үндэслэл бий болсон эсэхийг шийдвэрлэсэн ажиллагаануудад хянахад 30 минут, боловсруулахад 60 минут тус тус зарцуулдаг гэсэн байна.




Зураг 2.1.15 Зөрчлийн хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхэд бэлтгэх, хэлэлцэх үе шатны үеийн ажиллагааны задаргаа

Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгчийн зөрчлийн хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхэд бэлтгэх, хэлэлцэх үе шатанд зарцуулах нийт хугацааг тус шатны ажиллагаа тус бүрээр задалж тооцсон үр дүнг харуулав. Энэ үе шатны хэргийн оролцогчдод шүүх хуралдааны тов мэдэгдэхэд 6.4% буюу 17 минутыг, шүүх хуралдааны ажиллагаанд 93.6% буюу 248 минутыг тус тус зарцуулдаг гэсэн байна.




Зураг 2.1.16 Зөрчлийн хэргийн шийдвэр боловсруулах үеийн ажиллагаанд зарцуулах хугацаа, хэргийн төрлөөр

Хэрэг хянан шийдвэрлэх 3-р үе шатны эхний тов мэдэгдэх ажиллагаанд бүгд ижил буюу 17 минут зарцуулдаг гэсэн байна. Харин шүүх хуралдааны ажиллагаанд 227-297 минут зарцуулдаг гэсэн үр дүнг өгсөн байна.




Зураг 2.1.17 Зөрчлийн хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхэд бэлтгэх, хэлэлцэх үе шатны ажиллагааны задаргаа

Шүүх хуралдааны ажиллагааны 227-297 минут зарцуулдаг гэсэн асуумжийн үр дүнг задалж үзэхэд илтгэхэд 36 минут, даргалахад 85 минут, зөвлөлдөхөд 65 минут, засварлуулахад 32 минут, Шүүхээс гарсан магадлалын тогтоох хэсгийг танилцуулах, үндэслэлийг тайлбарлахад 30 минутыг тус тус зарцуулдаг гэсэн байна.




Зураг 2.1.18 Шийдвэр боловсруулах, хянах, гарын үсэг зурах үеийн ажиллагааны задаргаа

Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгчийн зөрчлийн хэргийн шийдвэр боловсруулах, хянах, гарын үсэг зурах үе шатанд зарцуулах нийт хугацааг тус шатны ажиллагаа тус бүрээр задалж тооцсон үр дүнг харуулав. Энэ үе шатны шүүх хуралдааны тэмдэглэл хянаж, гарын үсэг зурах ажиллагаанд 17.9% буюу 83 минутыг, шүүгчийн захирамжид 19.4% буюу 90 минутыг, шүүхийн тогтоолд 49.6% буюу 230 минутыг, магадлалд 12.9 % буюу 60 минутыг тус тус зарцуулдаг гэсэн байна.




Зураг 2.1.19 Зөрчлийн хэргийн шийдвэр боловсруулах ажиллагаанд зарцуулах хугацаа, хэргийн төрлөөр

Хэрэг хянан шийдвэрлэх 4-р үе шатны бүх ажиллагаанд зарцуулах хугацаа гэмт хэргийн бүх төрлийн хувьд ойролцоо дүнтэй байна.




Зураг 2.1.20 Шийдвэр боловсруулах ажиллагааны задаргаа

Шүүгчийн захирамжийг хянах, боловсруулахад 83 минут зарцуулдаг гэсэн асуумжийн үр дүнг задалж харвал шүүгчийн захирамжийг хянахад 23 минут, боловсруулахад 60 минут зарцуулдаг болох нь тооцоогоор гарав. Шүүхийн тогтоолыг хянах болон боловсруулахад 90 минут зарцуулдаг гэсэн асуумжийн үр дүнг задалж харвал шүүхийн тогтоолыг хянахад 30 минут, боловсруулахад 60 минут зарцуулж байна. Магадлалыг хянах боловсруулахад 220-240 минут зарцуулж байна гэсэн асуумжийн үр дүнг задалж харвал магадлалыг хянахад 60 минут, боловсруулахад 170 минут зарцуулж байна гэсэн үр дүн гарсан байна.




Зураг 2.1.21 Хэрэг хянан шийдвэрлэсний дараах ажиллагааны задаргаа

Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгчийн зөрчлийн хэрэг шийдвэрлэсний дараах ажиллагаанд зарцуулж буй нийт хугацааг тус шатны ажиллагаа тус бүрээр задалж тооцсон үр дүнг харуулав. Энэ үе шатны мэдэгдэх хуудас хянаж, гарын үсэг зурах ажиллагаанд 32.2% буюу 30 минутыг, шүүхийн залруулгын тогтоолд 67.7% буюу 63 минутыг тус тус зарцуулдаг гэсэн байна.



Зураг 2.1.22 Зөрчлийн хэрэг шийдвэрлэсний дараах ажиллагаанд зарцуулах хугацаа, хэргийн төрлөөр

Хэрэг шийдвэрлэсний дараах үе шатны мэдэгдэх хуудас хянаж, гарын үсэг зурах ажиллагаанд 30 минут, шүүхийн залруулгын тогтоол гаргах ажиллагаанд 60-63.3 минут зарцуулж байна гэсэн байна.



Зураг 2.1.23 Шүүхийн залруулгын тогтоол гаргах ажиллагааны задаргаа

Шүүхийн залруулгын тогтоолыг гаргах ажиллагааг хянахад 16 минут, боловсруулахад 47 минутыг тус тус зарцуулдаг болох нь тооцоогоор гарав.

2.1.1.5 Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгч нараас авсан зөрчлийн хэргийн асуумжийн дүгнэлт

Дүүргийн шүүхүүдийн хувьд хэргийн материалтай танилцах үе шатанд 30-63 минут зарцуулдаг гэсэн бол бусад 3 үе шатанд хэргийн төрөл бүрт ойролцоо хугацаа зарцуулдаг гэсэн дүн гарсан байна.



Давж заалдах шатны шүүхүүдийнх хувьд Зөрчлийн тухай хуулийн төрөл тус бүрд ойролцоо буюу 1437-1600 минутыг зарцуулж байна.

Давж заалдах шатны шүүхийн зөрчлийн хэрэг хянан шийдвэрлэх 5 үе шатанд хэргийн төрөл тус бүр зөрчүүлж буй хугацаа харьцангуй жигд өгөгдсөн байна. Хэргийн 1-р үед 396-470 минут, 2-р үе шатанд 250 минут, 3-р үе шатанд 243-313 минут, 4-р үе шатанд 453-473 минут, 5-р үе шатанд 90-93 минутыг тус тус зарцуулж байна.

2.2 Зөрчлийн хэргийн ажлын байрны ажиглалтын хүрээнд ирүүлсэн

МЭДЭЭЛЭЛД ХИЙХ ШИНЖИЛГЭЭ

Ажлын байрны ажиглалтыг Баянзүрх дүүрэг дэх эрүүгийн хэргийн анхан шатны шүүх, Налайх дүүрэг дэх эрүүгийн хэргийн анхан шатны шүүхүүдэд тус тус хийсэн бөгөөд Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн хянан шийдвэрлэсэн зөрчлийн хэргийн ажиллагааны ачааллыг бодитой тодорхойлохын тулд ШЕЗ-ийн судалгаа шинжилгээний баг Зөрчлийн тухай хуульд заасан 10 төрлийн гэмт хэргийг хүснэгт дэх ажиллагааны үзүүлэлтийн дагуу ажиглалт хийж тоон мэдээлэл цуглуулан шинжилгээ хийсэн үр дүнг энэ бүлэг танилцуулна. Судалгаанд дараах гэмт хэргийн төрөлд хамаарах асуумжийг авсан. Үүнд:

5.1 - Олон нийтийн газарт зүй бусаар биеэ авч явах

5.2 - Танхайрах

5.3 - Хүний биед халдах

5.4 - Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих

6.26 - Бэлгийн дарамт учруулах

8.6 - Хулгайлах

14.7-3 - Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчих


14.7-5 - Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчих

14.7-55 - Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчих

15.3-Шүүх хуралдаанд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр шүүхийн иргэдийн төлөөлөгчөөр оролцохоос зайлсхийх, шүүхийн үйл ажиллагаанд саад учруулах

2.2.1 Зөрчлийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үе шатуудад хийх шинжилгээ


Зөрчлийн тухай хуульд заасан зүйл, анги тус бүрийн ажиллагаанд зарцуулах хугацааны тухай Баянзүрх, Налайх дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн өгсөн 20 өгөгдөлд хийсэн 2 хүчин зүйлийн дисперсийн шинжилгээний үр дүнг Зураг 2.2.1-д харуулав. Зургаас харвал дүүрэг дэх эрүүгийн хэргийн анхан шатны шүүх 1 зөрчлийн хэргийг шийдэхэд 196 минут зарцуулдаг гэсэн байна.



Зураг 2.2.1 Зөрчлийн хэрэг хянан шийдвэрлэхэд зарцуулах хугацааны тухай асуумжийн ерөнхий мэдээлэл


Зөрчлийн нэг хэргийг шийдэхэд зарцуулах хугацааг шүүхээр болон шүүгчээр, Ерөнхий шүүгчээр тус бүрээр задлан харуулсан бөгөөд шүүхээр үзвэл Налайх дүүргийн шүүх 196 минутыг, Баянзүрх дүүргийн шүүх 194 минутыг тус тус зарцуулж байна. Шүүгчээр болон ерөнхий шүүгчээр задлан харвал Баянзүрх дүүргийн шүүхийн шүүгч 202 минут зарцуулж байхад Налайх дүүргийн шүүхийн шүүгч 191 минут зарцуулж байна. Дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгч 196 минут, Ерөнхий шүүгч 193 минут зарцуулж байна.

Зөрчлийн тухай хуулийн зүйл анги тус бүрээр нь задалж харуулбал Зөрчлийн тухай хуулийн 14.7-5 дугаар зүйлд заасан зөрчлийг 213 минутад шийдвэрлэж байгаа нь хамгийн их хугацаа зарцуулж байгаа бол 5.1 дүгээр зүйлд заасан зөрчлийг 178 минутад шийдвэрлэж байгаа нь хамгийн бага хугацаа зарцуулж байна гэсэн үр дүн гарсан байна.




Зураг 2.2.2 Дүүргийн шүүхийн шүүгчийн зөрчлийн хэрэг хянан шийдвэрлэх хэргийн ажиллагааны төрөл, шүүхээр

Налайх болон Баянзүрх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх Зөрчлийн тухай хуулийн 10 төрөл зүйл заалтад заасан зөрчлийн хэргийг хянан шийдвэрлэхдээ ойролцоо буюу Налайх дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүх 182-211 минут, Баянзүрх дүүргийн шүүх 170-216 минут тус зарцуулдаг гэсэн үр дүн гарсан байна.




Зураг 2.2.3 Зөрчлийн хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааны үе шат

Зураг 2.2.3-аас харвал Дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүх зөрчлийн хэргийн материалтай танилцах үе шатанд зарцуулах нийт хугацааны 33.8% буюу 66 минутыг хэргийн материалтай танилцахад, 14.4% буюу 28 минутыг хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхэд бэлтгэхэд, 35.9 % буюу 70 минутыг шийдвэр боловсруулах, хянах, гарын үсэг зурахад, 15.9% буюу 31 минутыг хэрэг хянан шийдвэрлэсний дараах ажиллагаанд зарцуулж байна.



Зураг 2.2.4 Зөрчлийн хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааны үе шат, шүүхээр

Зураг 2.2.4-өөс харвал хэргийн материалтай танилцах үе 1-р үе шатанд 2 шүүх 65 минутыг, 2-р үе шатанд 27-28 минутыг, 3-р үе шатанд адил 70 минутыг, 4-р үе шатанд мөн 31 минутыг тус тус зарцуулдаг гэсэн дүн гарсан байна.



Зураг 2.2.5 Хэрэг хянан шийдвэрлэх үе шатанд хамаарах ажиллагааны тоо, хэргийн төрлөөр

Зураг 2.2.4-д харуулсан ерөнхий мэдээллийг Зөрчлийн хэргийн төрөл тус бүрээр Зураг 2.2.5-д дэлгэрэнгүй оруулав. Зургаас харвал хэрэг хянан шийдвэрлэх 1-р үе шатанд дунджаар 58-78 минутыг зарцуулж байгаа бөгөөд Зөрчлийн тухай хуулийн 5.4 дүгээр зүйлд заасан “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих” зөрчилд 78 минутыг, мөн хуулийн 8.6




дугаар зүйлд заасан “Хулгайлах” зөрчилд 77 минутыг тус тус зарцуулж байгаа нь хамгийн их байна.

Хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхэд бэлтгэх үе шатанд дунджаар 24-31 минутыг зарцуулж байна гэсэн байна. Шийдвэр боловсруулах, хянах, гарын үсэг зурах үе шатанд 64-76 минутыг дунджаар зарцуулж байгаа бөгөөд Зөрчлийн тухай хуулийн 14.7 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан зөрчилд 75 минут, мөн хуулийн 14.7 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт заасан зөрчилд 76 минут зарцуулж байгаа нь хамгийн их хугацаа байна. Хэрэг хянан шийдвэрлэсний дараах ажиллагааны үе шатанд 27-32 минутыг зарцуулж байгаа нь бүх зүйлд ангид ойролцоо хугацаа зарцуулж байгаа нь харагдаж байна. Үе доторх зарцуулж буй минут зүйл анги тус бүр дээр ойролцоо байна. Хамгийн их хугацааг 1 болон 3-р үе шат буюу шийдвэр боловсруулах, хянах гарын үсэг зурах үе шатад зарцуулж байна гэж үзэж байна.


2.2.2 Зөрчлийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд зарцуулах хугацааны өгөгдөлд хийх шинжилгээ

Хэрэг хянан шийдвэрлэх үе шатыг ямар төрлийн ажиллагаанаас хамаарч харилцан адилгүй хугацаа зарцуулж байгааг хэргийн ажиллагаа тус бүрээр задалж харуулсан үр дүнг танилцуулъя.




Зураг 2.2.6 Хэргийн материалтай танилцах ажиллагааны үе шат

Хэргийн материалтай танилцах шатанд хэргийн материалыг уншиж судлахад 59.7% буюу 40 минутыг, шаардлагатай хууль тогтоомжийг судлахад 26.7% буюу 18 минутыг, шүүхийн практикийг судлахад 13.4% буюу 9 минутыг тус тус зарцуулдаг гэсэн байна.



Зураг 2.2.7 Хэргийн материалтай танилцах шатанд зарцуулах хугацаа, шүүхээр

Хэргийн материалыг уншиж судлахдаа 2 шүүх 40 минут, шаардлагатай хууль тогтоомжийг судлахад мөн адил 18 минут зарцуулдаг бол шүүхийн практикийг судлахад Налайх дүүргийн шүүх 10 минут, Баянзүрх дүүргийн шүүх 8 минут зарцуулж байна гэсэн дүн гарсан байна.



Зураг 2.2.8 Зөрчлийн хэргийн материалтай танилцах үеийн ажиллагаанд зарцуулах хугацаа, хэргийн төрлөөр

Зураг 2.2.7-д харуулсан Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгч зөрчлийн хэргийн материалтай танилцах үе шатанд зарцуулах нийт хугацааг хэргийн төрөл тус бүрээр Зураг 2.2.8-д задалж харуулав. Хэрэг хянан шийдвэрлэх 1-р үе шатанд унших ажиллагаанд Зөрчлийн тухай хуулийн 8.6 дугаар зүйлд заасан зөрчилд 34 минут зарцуулж байгаа нь хамгийн байгаа бол мөн хуулийн 14.7 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт заасан зөрчилд 51 минут зарцуулж байгаа нь хамгийн их хугацаа байна. Шаардлагатай хууль тогтоомжийг судлах ажиллагаанд Зөрчлийн тухай хуулийн 5.4 дүгээр зүйлд заасан “Тэр бүлийн хүчирхийлэлтэй



тэмцэх тухай” зөрчилд 28 минут буюу хамгийн их хугацаа зарцуулж байна. Харин Зөрчлийн тухай хуулийн 5.1 дүгээр зүйлд заасан “Олон нийтийн газарт зүй бусаар биеэ авч явах” зөрчилд хамгийн буюу 11 минутад шаардлагатай хууль тогтоомжийг судлах ажиллагаа хийдэг байна. Шүүхийн практик судлахад бүх зүйл анги дээр ойролцоо буюу 7-10 минутыг тус тус зарцуулдаг гэсэн үр дүн гарсан байна.




Зураг 2.2.9 Зөрчлийн хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхэд бэлтгэх үеийн ажиллагааны задаргаа

Зураг 2.2.9-өөс харвал Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгч зөрчлийн хэргийг хуралдаанаар хэлэлцэхэд бэлтгэх, хэлэлцэх үе шатанд зарцуулах нийт хугацааны 14.8% буюу 4 минутыг шүүх хуралдааны оролцогчдод тов мэдэгдэх хуудсанд гарын үсэг зурахад, 14.8% буюу 4 минутыг Нөлөөллийн мэдүүлэг хөтөлдөг талаар мэдээлэл өгсөн баримтыг хянаж гарын үсэг зурахад, 70.4% буюу 19 минутыг шүүх хуралдаанд тус тус зарцуулдаг гэсэн байна.




Зураг 2.2.10 Зөрчлийн хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхэд бэлтгэх үеийн ажиллагаа, шүүхээр

Хэргийн оролцогчдод шүүх хуралдааны тов мэдэгдэх хуудсанд гарын үсэг зурах ажиллагаанд Баянзүрх, Налайх дүүргүүд 4-5 минут зарцуулж, Нөлөөллийн мэдүүлэг хөтөлбөрийн талаар мэдээлэл өгсөн баримтыг хянаж, гарын үсэг зурах ажиллагаанд 2 дүүрэг адилхан 4 минутыг зарцуулж байна. Зөрчлийн хэргийн шүүх хуралдааны ажиллагаанд 19-20 минутыг тус 2 дүүрэг зарцуулж байна.



Зураг 2.2.11 Зөрчлийн хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхэд бэлтгэх үеийн ажиллагаанд зарцуулах хугацаа, хэргийн төрлөөр


Зураг 2.2.10-д харуулсан Дүүргийн эрүүгийн хэргийн шүүгч зөрчлийн хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхэд бэлтгэх үе шатанд зарцуулах нийт хугацааг хэргийн төрөл тус бүрээр Зураг 2.2.11-д задалж харуулав. Хэрэг хянан шийдвэрлэх 2-р үе шат болох хэргийг хуралдаанаар хэлэлцэхэд бэлтгэх, хэлэлцэх үе шатанд хэргийн оролцогчдод тов мэдэгдэх ажиллагаанд 3-5 минут зарцуулж байгаа бол нөлөөллийн мэдүүлэг хөтөлдөг талаарх өгсөн баримтыг хянаж, гарын үсэг зурахад 4-5 минут, шүүх хуралдааны ажиллагаанд 16-22 минут тус тус зарцуулдаг гэсэн байна. Шүүх хуралдаан дотроо дараах 3 хэсгээс бүрдсэн байхаар ажиглалтыг задалж авсан тул үзүүлэлт бүрийн хувьд тооцсон үр дүнг дурдъя.



Зураг 2.2.12 Шүүх хуралдааны ажиллагааны задаргаа


Зураг 2.2.11-д шүүх хуралдаанд 19-20 минут зарцуулдаг гэж үзсэн ерөнхий дүнг дэд ажиллагаа тус бүрээр задалж үзэхэд зөвлөлдөхөд 9 минут, завсарлуулахад 0, минут, шүүхээс гарсан шийдвэрийг тогтоох хэсгийг танилцуулах, үндэслэлийг тайлбарлахад 10 минут зарцуулдаг гэж үр дүн гарсан байна.

Зураг 2.2.13-д Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн зөрчлийн хэргийн шийдвэр боловсруулах, хянах, гарын үсэг зурах үе шатанд зарцуулах нийт хугацааг тус шатны ажиллагаа тус бүрээр задалж тооцсон үр дүнг харуулав. Энэ үе шатны шүүх хуралдааны тэмдэглэл хянаж, гарын үсэг зурахад 33.3% буюу 23 минутыг, ерөнхий шүүгчийн захирамжид 20.3% буюу 14 минутыг, шүүгчийн захирамжид 31 минут, шүүхийн шийтгэвэрт 46.7% буюу 32 минутыг тус тус зарцуулдаг гэсэн байна.




Зураг 2.2.13 Зөрчлийн хэргийн шийдвэр боловсруулах үеийн ажиллагааны задаргаа

Зураг 2.2.13-д харуулсан Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн зөрчлийн хэргийн шийдвэр боловсруулах үе шатанд зарцуулах нийт хугацааг хэргийн шүүх тус бүрээр Зураг 2.2.14-д задалж харуулав.



Зураг 2.2.14 Зөрчлийн хэргийн шийдвэр боловсруулах үеийн ажиллагааны задаргаа, шүүхээр

Зураг 2.2.13-д харуулсан Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн зөрчлийн хэргийн шийдвэр боловсруулах үе шатанд зарцуулах нийт хугацааг хэргийн шүүх тус бүрээр Зураг 2.2.14-д задалж харуулав. Шүүх хуралдааны тэмдэглэл хянаж, гарын үсэг зурах ажиллагаанд Баянзүрх болон Налайх дүүрэг 23-26 минут, ерөнхий шүүгчийн захирамжид 2 минут, шүүгчийн захирамжид 13-14 минут, шүүхийн шийтгэвэрт Налайх дүүрэг 31 минут, Баянзүрх дүүрэг 29 минут зарцуулж байна.




Зураг 2.2.15 Зөрчлийн хэргийн шийдвэр боловсруулах үеийн ажиллагаанд зарцуулах хугацаа, хэргийн төрлөөр




Шүүх хуралдааны тэмдэглэл хянахад 22-26 минут, Ерөнхий шүүгчийн 1.5-2.5 минут, шүүгчийн захирамжид 12-15 минут, шүүхийн шийтгэвэрт 25-36 минутыг тус тус зарцуулж байна гэсэн байна. Шийдвэр боловсруулах, хянах, гарын үсэг зурах ажиллагааны хянан шийдвэрлэх бүх ажиллагаа зөрчлийн хэргийн зүйлчлэлийн хувьд ойролцоо дүнтэй байна.

Хэрэг хянан шийдвэрлэх 3-р үе шат буюу шүүхийн ихэнх ажиллагааны асуумжийг задалж авсан тул задаргаатай орж ирсэн үзүүлэлт бүрийн хувьд тооцсон үр дүнг дурдъя.



Зураг 2.2.16 Шийдвэр боловсруулах үеийн зарим ажиллагааны задаргаа

Зураг 2.2.14-д дурдсан шүүгчийн захирамжид 13-14 минут зарцуулдаг гэсэн асуумжийн үр дүнг задалж үзэхэд шүүгчийн захирамжийг боловсруулахад 9 минут, хянахад 5 минут тус тус зарцуулдаг болох нь тооцоогоор гарав. Шүүхийн шийтгэврийг боловсруулахад 25 минут, хянахад 5 минут зарцуулдаг гэсэн байна.




Зураг 2.2.17 Хэрэг хянан шийдвэрлэсний дараах үеийн ажиллагааны задаргаа

Зураг 2.2.17-д Эрүүгийн хэргийн шүүгчийн хэрэг хянан шийдвэрлэсний дараах үе шатанд зарцуулах нийт хугацааг тус шатны ажиллагаа тус бүрээр задалж тооцсон үр дүнг харуулав. Энэ үе шатны гүйцэтгэх хуудас хянаж, гарын үсэг зурахад 21.9% буюу 7 минут, хэрэг эмхэтгэснийг хянаж баримтад гарын үсэг зурахад 34.4% буюу 11 минут, шүүгчийн залруулгын захирамжид 43.7% буюу 14 минут тус тус зарцуулдаг байна.



Зураг 2.2.18 Хэрэг хянан шийдвэрлэсний дараах үеийн ажиллагааны задаргаа, шүүхээр


Гүйцэтгэх хуудас хянаж, гарын үсэг зурах ажиллагаанд Налайх дүүргийн шүүх 6 минут зарцуулж байгаа бол Баянзүрх дүүргийн шүүх 7 минут зарцуулж байна. Хэрэг эмхэтгэснийг хянаж, баримтад гарын үсэг зурахад 2 дүүрэг адил 11 минут зарцуулж байгаа бол шүүгчийн залруулгын захирамжид Налайх дүүрэг 14 минут, Баянзүрх дүүрэг 13 минутыг тус тус зарцуулж байна.



Зураг 2.2.19 Зөрчлийн хэрэг хянан шийдвэрлэсний дараах үеийн ажиллагаанд зарцуулах хугацаа, хэргийн төрлөөр



Хэрэг хянан шийдвэрлэсний дараах ажиллагааны үе шатны гүйцэтгэх хуудас хянаж, гарын үсэг зурах ажиллагаанд 5-8 минут, хэрэг эмхэтгэснийг хянаж баримтад гарын үсэг зурах ажиллагаанд 8-12 минут, шүүгчийн залруулгын захирамж бичих ажиллагаанд 12-26 минутыг тус тус зарцуулдаг гэсэн дүнтэй гарсан байна.




Зураг 2.2.20 Шүүгчийн залруулгын захирамж ажиллагааны задаргаа

Зураг 2.2.20-д дурдсан шүүгчийн залруулгын захирамжийг хянахад 13 минут зарцуулдаг бөгөөд хянахад хугацаа зарцуулдаггүй гэсэн дүн гарсан байна.


2.2.3 Давж заалдах шатны шүүхийн зөрчлийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үе шатанд хийх шинжилгээ

Ажлын байрны ажиглалтыг Нийслэлийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүх, Дархан-Уул аймаг дахь эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүхүүдэд хийсэн Зөрчлийн тухай хуульд заасан зүйл, анги тус бүрийн ажиллагаанд зарцуулах хугацааны тухай Нийслэлийн эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүх, Дархан-Уул аймаг дахь эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхүүдийн шүүгчийн өгсөн 20 өгөгдөлд хийсэн 2 хүчин зүйлийн дисперсийн шинжилгээний үр дүнг Зураг 2.2.21-д харуулав. Зургаас харвал Дархан-Уул аймаг дахь давж заалдах шатны шүүхийн шүүгч 1 зөрчлийн хэргийг шийдэхэд 1276 минут, Нийслэлийн эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүх 192 минут зарцуулдаг гэсэн байна.



Зураг 2.2. 21 Зөрчлийн хэргийг хянан шийдвэрлэхэд зарцуулах хугацааны тухай асуумжийн ерөнхий мэдээлэл

Зөрчлийн нэг хэргийг шийдэхэд зарцуулах хугацааг шүүхээр болон шүүгчээр, Ерөнхий шүүгчээр тус бүрээр задлан харуулсан бөгөөд шүүхээр үзвэл Нийслэлийн эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгч 290 минут зарцуулж байгаа бол Дархан-Уул аймаг дахь эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгч 2501 минутыг тус тус зарцуулж байна гэж ажиглалтын шинжилгээний үр дүнгээр гарсан байна. Нийслэлийн эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгчээс 8.6 дахин их хугацааг зарцуулж байна гэсэн үр дүн гарсан байна. Давж заалдах шатны шүүхийн шүүгч 1119 минутад шийдэж байгаа бол ерөнхий шүүгч 517 минутад шийдвэрлэж байна гэж гарсан байна.




Зураг 2.2. 22 Дүүргийн шүүхийн шүүгчийн зөрчлийн хэрэг хянан шийдвэрлэх хэргийн ажиллагааны төрөл, шүүхээр

Зөрчлийн тухай хуулийн зүйл анги тус бүрээр нь задалж харуулбал Зөрчлийн тухай хуулийн 6.26 дугаар зүйлд заасан зөрчлийг 1358 минутад шийдвэрлэж байгаа нь хамгийн их хугацаа зарцуулж байгаа бол 14.7 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан зөрчлийг 407 минутад шийдвэрлэж байгаа нь хамгийн бага хугацаа зарцуулж байна гэсэн үр дүн гарсан байна.

Дархан-Уул аймгийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүх Зөрчлийн тухай хуулийн 6.26 дугаар зүйлд заасан “Бэлгийн дарамт учруулах” зөрчилд хамгийн их буюу 2278




минут зарцуулдаг бол Нийслэлийн эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүх 438 минут зарцуулдаг гэсэн байна. Дархан-Уул аймгийн эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүх хамгийн бага хугацаа зарцуулж буй зөрчлийн хэрэг нь Зөрчлийн тухай хуулийн 15.29 дугаар зүйлд заасан зөрчил байна. Нийслэлийн эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүх зөрчлийн хэргийг хянан шийдвэрлэх нийт хугацаа нь 346-438 минутыг зарцуулж байна.




Зураг 2.2.23 Зөрчлийн хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааны үе шат

Зураг 2.2.23-аас харвал Давж заалдах шатны шүүх зөрчлийн хэргийн материалтай танилцах үе шатанд зарцуулах нийт хугацааны 34.6% буюу 272 минутыг хэргийн материалтай танилцахад, 14.6% буюу 115 минутыг хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхэд бэлтгэхэд, 8.2 % буюу 64 минутыг шийдвэр боловсруулах, хянах, гарын үсэг зурахад, 37.2% буюу 292 минутыг шийдвэр боловсруулах, хянах, гарын үсэг зурахад, 5.4% буюу 42 минутыг хэрэг хянан шийдвэрлэсний дараах ажиллагаанд зарцуулж байна.



Зураг 2.2.24 Зөрчлийн хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааны үе шат, шүүхээр

Зураг 2.2.24-өөс харвал хэргийн материалтай танилцах үе шатанд Дархан-Уул аймаг дахь давж заалдах шатны шүүх 467 минут зарцуулсан бол Нийслэлийн эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүх 115 минутыг тус тус зарцуулж байна. Хэргийг хүлээн авснаас хойших ажиллагаанд Дархан-Уул аймгийн давж заалдах шатны шүүх 203 минут зарцуулж байгаа бол Нийслэлийн эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүх 44 минутыг буюу 4.6 дахин бага хугацааг зарцуулж байна. Хэргийн 3-р үе болох Хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхэд бэлтгэх шатанд 2 шүүх ойролцоо буюу 62-67 минутыг зарцуулж байна. Хэргийн 4-р үе шат болох Шийдвэр боловсруулах, хянах гарын үсэг зурах шатанд Дархан-Уул аймгийн эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүх 476 минут, Нийслэлийн эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүх 145 минут буюу 3.2 дахин бага хугацааг зарцуулдаг гэсэн байна. Хэргийн 5-р шат болох Хэрэг хянан шийдвэрлэсний дараах ажиллагаанд 2 шүүх харьцангуй дөхүү хугацаа буюу 25-63 минутыг тус тус зарцуулсан байна.



Зураг 2.2.25 Хэрэг хянан шийдвэрлэх үе шатанд хамаарах ажиллагааны тоо, хэргийн төрлөөр

Зураг 2.2.25-аас харвал хэргийн материалтай танилцах ажиллагааны үе шатанд 129-386 минутын хооронд ажиллагааг хийж байна. Зөрчлийн тухай хуулийн 5.5, 5.4, 6.26 дугаар зүйлд заасан зөрчлийн хэргүүдэд 371-386 минутыг зарцуулж байгаа нь хамгийн их хугацаа байна.


Хэрэг хүлээн авснаас хойших ажиллагааны үе шатанд Зөрчлийн тухай хуулийн 6.26 дугаар зүйлд 438 минут зарцуулж байгаа нь бусад хэрэгт зарцуулж буй хугацаанаас харьцангуй их байна.



Хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхэд бэлтгэх үе шатанд харьцангуй ойролцоо буюу 55-73 минутын хугацаа зарцуулж байна гэж гарсан байна. Шийдвэр боловсруулах, хянах шатны үсэг зурах ажиллагааны үе шатанд Зөрчлийн тухай хуулийн 6.26 дугаар зүйлд заасан зөрчилд 421 минут зарцуулж байгаа нь хамгийн өндөр байгаа бол 14.7 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан зөрчилд 144 минут зарцуулсан нь хамгийн бага хугацаа зарцуулсан байна. Хэрэг хянан шийдвэрлэсний дараах ажиллагааны үе шатанд бүх зүйл заалтууд ойролцоо буюу 28-58 минутын хугацаа зарцуулж байна.


2.2.4 Зөрчлийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд зарцуулах хугацааны өгөгдөлд хийх шинжилгээ

Хэрэг хянан шийдвэрлэх үе шатыг ямар төрлийн ажиллагаанаас хамаарч харилцан адилгүй хугацаа зарцуулж байгааг хэргийн ажиллагаа тус бүрээр задалж харуулсан үр дүнг танилцуулъя.




Зураг 2.2 26 Хэргийн материалтай танилцах ажиллагааны үе шат

Хэргийн материалтай танилцах шатанд хэргийн материалыг уншиж судлахад 62.7% буюу 170 минутыг, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг төлөвлөхөд 10.3% буюу 28 минутыг, түүвэр гаргахад 8.8% буюу 24 минутыг, шаардлагатай хууль тогтоомжийг судлахад 9.9% буюу 27 минутыг, шүүхийн практик судлахад 8.1% буюу 22 минутыг тус тус зарцуулдаг гэсэн байна.



Зураг 2.2.27 Хэргийн материалтай танилцах шатанд зарцуулах хугацаа, шүүхээр

Хэргийн материалыг уншиж судлахдаа Дархан-Уул аймгийн эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүх 339 минут зарцуулдаг бол Нийслэлийн эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүх 35 минут зарцуулдаг гэсэн байна. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг төлөвлөх болон түүвэр гаргах ажиллагаанд ойролцоо буюу 17-26, 20-29 минут тус тус зарцуулдаг гэсэн байна. Шаардлагатай хууль тогтоомжийг судлах болон шүүхийн практикийг судлахад Дархан-Уул аймгийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүх тус тус 41 минут зарцуулдаг бол Нийслэлийн эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүх 16-18 минут зарцуулдаг гэсэн дүн гарсан байна.




Зураг 2.2 28 Зөрчлийн хэргийн материалтай танилцах үеийн ажиллагаанд зарцуулах хугацаа, хэргийн төрлөөр




Давж заалдах шатны шүүхийн шүүгч зөрчлийн хэргийн материалтай танилцах үе шатанд зарцуулах нийт хугацааг хэргийн төрөл тус бүрээр Зураг 2.2.27-д задалж харуулав. Хэргийг уншиж судлах ажиллагаанд хамгийн их хугацааг Зөрчлийн тухай хуулийн 5.3, 5.4, 6.26, 8.6 дугаар зүйлд заасан зөрчлүүдэд зарцуулж байна.

Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг төлөвлөх, түүвэр гаргах, шаардлагатай хууль тогтоомж судлах, шүүхийн практик судлах ажиллагаануудад бүх зүйл анги ойролцоо хугацаа буюу 17-48 минутыг зарцуулж байна.



Зураг 2.2.29 Хэргийн харьяалал тогтоосон захирамж

Ерөнхий шүүгчийн хийх нэмэлт ажиллагаа болох зөрчлийн хэргийн харьяалал тогтоох захирамжийг боловсруулахад 10 минутыг, хянахад 5 минутыг тус тус зарцуулж байна.



Зураг 2.2.30 Зөрчлийн хэргийг шүүх хүлээн авснаас хойших үеийн ажиллагааны задаргаа



Зураг 2.2.31 Зөрчлийн хэргийг шүүх хүлээн авснаас хойших үеийн ажиллагааны задаргаа, шүүхээр


Зураг 2.2.30-аас харвал Давж заалдах шатны шүүхийн шүүгч зөрчлийн хэргийг хүлээн авснаас хойших ажиллагаанд зарцуулах нийт хугацааны 22.6% буюу 23 минутыг таслан сэргийлэх арга хэмжээтэй холбоотой хүсэлтийг шийдвэрлэх ажиллагаанд, 58.8% буюу 63 минутыг хэргийг хэлэлцүүлэхгүй тухай захирамж гаргах ажиллагаанд, 19.6% буюу 21 минутыг хэргийг түдгэлзүүлэх үндэслэл бий болсон эсэхийг шийдвэрлэсэн шүүгчийн захирамж гаргах ажиллагаанд тус тус зарцуулж байна.

Таслан сэргийлэх арга хэмжээтэй холбоотой хүсэлтийг шийдвэрлэх ажиллагаанд Дархан-Уул аймгийн эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүх 43 минут зарцуулж байгаа бол Нийслэлийн эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүх 6 минут зарцуулж байна гэсэн үр дүн гарсан байна. Хэргийг хэлэлцүүлэхгүй тухай шүүгчийн захирамж гаргах ажиллагаанд Дархан-Уул аймгийн эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүх 95 минут зарцуулж байгаа бол Нийслэлийн эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүх 37 минут зарцуулж байна. Хэргийг түдгэлзүүлэх үндэслэл бий болсон эсэхийг шийдвэрлэсэн шүүгчийн захирамжид Дархан-Уул аймгийн эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүх 46 минут зарцуулж байгаа Нийслэлийн эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүх 1 минут зарцуулдаг гэсэн үр дүн гарсан байна.




Зураг 2.2.32 Зөрчлийн хэргийг хүлээн авснаас хойших ажиллагаанд зарцуулах хугацаа, хэргийн төрлөөр

Зураг 2.2.31-д харуулсан Давж заалдах шатны шүүхүүд зөрчлийн хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхэд бэлтгэх үе шатанд зарцуулах нийт хугацааг хэргийн төрөл тус бүрээр Зураг 2.2.32-д задалж харуулав. Хэргийг хүлээн авснаас хойших ажиллагааны таслан сэргийлэх арга хэмжээтэй холбоотой хүсэлтийг шийдвэрлэх ажиллагаанд Зөрчлийн тухай хуулийн 5.4 дүгээр зүйлд заасан зөрчилд 126 минут зарцуулж байгаа нь хэт дөвийлгөсөн хугацаа гэж үзэхээр байна. Бусад зүйл заалт дээр энэ ажиллагаанд ойролцоо буюу 3-14 минутыг зарцуулж байна. Хэргийг хэлэлцүүлэхгүй тухай шүүгчийн захирамжид Зөрчлийн тухай хуулийн 5.4 дүгээр зүйлд заасан зөрчлийн хэрэгт 266 минут, бусад зүйл заалт дээр 32-43 минутыг зарцуулж байна. Хэргийг түдгэлзүүлэх үндэслэл бий болсон эсэхийг шийдвэрлэсэн шүүгчийн захирамжид 7-42 минутыг зарцуулж байгаа бөгөөд Зөрчлийн тухай хуулийн 8.6 дугаар зүйлд заасан зөрчилд 42 минут зарцуулж байгаа нь хамгийн их хугацаа байна. Шүүх хэргийг хүлээн авснаас хойших ажиллагааны үе дотроо дараах 3 хэсгээс бүрдсэн байхаар ажиглалтыг задалж авсан тул үзүүлэлт бүрийн хувьд тооцсон үр дүнг дурдъя.



Зураг 2.2.33 Шүүх хэргийг хүлээн авснаас хойших ажиллагааны задаргаа


Зураг 2.2.33-д хэргийг хэлэлцүүлэхгүй тухай шүүгчийн захирамжид 63 минут зарцуулдаг гэж үзсэн ерөнхий дүнг дэд ажиллагаа тус бүрээр задалж үзэхэд боловсруулахад 11 минут, хянахад 52 минут, таслан сэргийлэх арга хэмжээтэй холбоотой хүсэлтийг шийдвэрлэх ажиллагаа боловсруулахад 5 минут, хянахад 18 минут, хэргийг түдгэлзүүлэх үндэслэл бий болсон эсэхийг шийдвэрлэсэн шүүгчийн захирамжийг боловсруулахад 5 минут, хянахад 16 минутыг тус тус зарцуулдаг байна. Зураг 2.2.34-д Зөрчлийн хэргийн шийдвэр боловсруулах, хянах, гарын үсэг зурах үе шатанд зарцуулж буй нийт хугацааг тус шатны ажиллагаа тус бүрээр задалж тооцсон үр дүнг харуулав.



Зураг 2.2.34 Зөрчлийн хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхэд бэлтгэх, хэлэлцэх үе шат




Энэ үе шатны Хэргийн оролцогчдод шүүх хуралдааны тов мэдэгдэх хуудсанд гарын үсэг зурахад 3.1% буюу 2 минутыг, шүүх хуралдаанд 96.8% буюу 62 минутыг тус тус зарцуулж байна гэсэн байна.



Зураг 2.2.35 Зөрчлийн хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхэд бэлтгэх, хэлэлцэх үеийн ажиллагаа, шүүхээр

Хэргийн оролцогчдод шүүх хуралдааны тов мэдэгдэх хуудсанд гарын үсэг зурахад аймаг дахь давж заалдах шатны шүүх 5 минут зарцуулсан бол нийслэл дэх давж заалдах шатны шүүх минут зарцуулдаггүй гэсэн байна. Шүүх хуралдаанд бэлтгэх ажиллагаанд аймаг дахь болон нийслэл дэх давж заалдах шатны шүүхүүд 62-63 минут зарцуулдаг гэсэн дүн гарсан байна.



Зураг 2.2.36 Зөрчлийн хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхэд бэлтгэх, хэлэлцэх үеийн ажиллагаа, хэргийн төрлөөр


Зураг 2.2.36-д харуулсан давж заалдах шатны шүүхийн шүүгчийн зөрчлийн хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхэд бэлтгэх, хэлэлцэх үе шатанд шүүх хуралдааны ажиллагаанд 58-73 минутыг зарцуулж байна.



Зураг 2.2.37 Зөрчлийн хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхэд бэлтгэх, хэлэлцэх үе шатны задаргаа

Зураг 2.2.35-д харуулсан Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн зөрчлийн хэргийн шийдвэр боловсруулах үе шатанд зарцуулах нийт хугацааг хэргийн шүүх тус бүрээр Зураг 2.2.37-д задалж харуулав. Шүүх хуралдаанд 62 минут зарцуулдаг гэж үзсэн ерөнхий дүнг дэд ажиллагаа тус бүрээр задалж үзэхэд илтгэхэд 23 минут, зөвлөлдөхөд 21 минут, завсарлуулахад 6 минут, Шүүхээс гарсан магадлалын тогтоох хэсгийг танилцуулах, үндэслэлийг тайлбарлахад 13 минутыг тус тус зарцуулжээ.


Зураг 2.2.38-д Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн зөрчлийн хэргийн шийдвэр боловсруулах, хянах, гарын үсэг зурах үе шатанд зарцуулах нийт хугацааг тус шатны ажиллагаа тус бүрээр задалж тооцсон үр дүнг харуулав. Энэ үе шатны шүүх хуралдааны тэмдэглэл хянаж, гарын үсэг зурахад 7.5% буюу 22 минутыг, шүүгчийн захирамжид 15.9% буюу 47 минут, Ерөнхий шүүгчийн захирамжид 7.5% буюу 22 минут, магадлалд 62.2% буюу 183 минутыг шүүхийн тогтоолд 6.8% буюу 20 минутыг тус тус зарцуулж байна.



Зураг 2.2.38 Зөрчлийн хэргийн шийдвэр боловсруулах үеийн ажиллагааны задаргаа




Зураг 2.2.38-д харуулсан Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн зөрчлийн хэргийн шийдвэр боловсруулах үе шатанд зарцуулах нийт хугацааг хэргийн шүүх тус бүрээр Зураг 2.2.39-д задалж харуулав.



Зураг 2.2.39 Зөрчлийн хэргийн шийдвэр боловсруулах үеийн ажиллагааны задаргаа, шүүхээр


Давж заалдах шатны шүүхийн магадлалд аймгийн шүүх 351 минут зарцуулж байгаа бол нийслэлийн давж заалдах шатны шүүх 48 минут буюу 7.3 дахин бага хугацаа зарцуулж байна. Шүүхийн тогтоолд нийслэлийн давж заалдах шатны шүүх 0 минут зарцуулж байгаа нь анхаарал татаж байна. Ажиглалтын өгөгдөлд тоо минутыг буруу бичсэн гэж үзэхээр байна. Шүүгчийн захирамж болон ерөнхий шүүгчийн захирамжид зарцуулах хугацаа аймаг болон нийслэлийн давж заалдах шатны шүүхүүдийн зарцуулж буй хугацаа ойролцоо байна.



Зураг 2.2.40 Шийдвэр боловсруулах үеийн ажиллагаанд зарцуулах хугацаа, хэргийн төрлөөр

Давж заалдах шатны шүүхийн магадлалд зарцуулж буй хугацаа Зөрчлийн тухай хуулийн 5.3, 5.4, 6.26, 8.6 дугаар зүйлүүдэд заасан зөрчилд хамгийн их буюу 280-285 минутыг зарцуулж байна. Шүүхийн тогтоол, шүүх хуралдааны тэмдэглэл, шүүгчийн захирамж, ерөнхий шүүгчийн захирамжид зарцуулж буй хугацаа зөрчлийн хэргийн төрөл бүр ойролцоо байна.

Хэрэг хянан шийдвэрлэх 4-р үе шат буюу шийдвэр боловсруулах, хянах, гарын үсэг зурах ажиллагааны ажиглалтыг задалж авсан тул задаргаатай орж ирсэн үзүүлэлт бүрийн хувьд тооцсон үр дүнг дурдъя.



Зураг 2.2.41 Шийдвэр боловсруулах үеийн зарим ажиллагааны задаргаа

Зураг 2.2.41-д дурдсан шүүгчийн захирамжид 47 минут зарцуулдаг гэсэн асуумжийн үр дүнг задалж үзэхэд шүүгчийн захирамжийг боловсруулахад 35 минут, хянахад 12 минут, Ерөнхий шүүгчийн захирамжийг боловсруулахад 14 минут, хянахад 8 минут, шүүхийн тогтоолыг боловсруулахад 16 минут, хянахад 4 минут, магадлалыг боловсруулахад 171 минут, хянахад 12 минут тус тус зарцуулдаг болох нь тооцоогоор гарав.



Зураг 2.2.42 Хэрэг шийдвэрлэсний дараах үеийн ажиллагааны задаргаа



Зураг 2.2.42-д Эрүүгийн хэргийн шүүгчийн хэрэг хянан шийдвэрлэсний дараах үе шатанд зарцуулах нийт хугацааг тус шатны ажиллагаа тус бүрээр задалж тооцсон үр дүнг харуулав. Энэ үе шатны мэдэгдэх хуудас хянаж, гарын үсэг зурахад 33.3% буюу 14 минутыг, шүүгчийн залруулгын захирамж, тогтоолд 66.6% буюу 28 минутыг тус тус зарцуулдаг гэсэн байна.



Зураг 2.2. 43 Хэрэг шийдвэрлэсний дараах үеийн ажиллагааны задаргаа, шүүхээр

Мэдэгдэх хуудас хянаж, гарын үсэг зурах ажиллагаанд Дархан-Уул аймгийн эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүх болон Нийслэлийн эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхүүд ойролцоо минут зарцуулж байна. Залруулгын шүүгчийн захирамж, тогтоолд Дархан-Уул аймгийн эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүх 49 минут зарцуулж байгаа бол Нийслэлийн эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүх 4 дахин бага буюу 12 минут зарцуулж байна.



Зураг 2.2.44 Зөрчлийн хэрэг хянан шийдвэрлэсний дараах үеийн ажиллагаанд зарцуулах хугацаа, хэргийн төрлөөр

Хэрэг шийдвэрлэсний дараах ажиллагааны үе шатны мэдэгдэх хуудас хянаж, гарын үсэг зурах ажиллагаанд 12-15 минут, залруулгын шүүгчийн захирамж, шүүхийн тогтоолд 17-45 минут зарцуулдаг гэсэн дүнтэй гарсан байна. Залруулгын шүүгчийн захирамж, шүүхийн тогтоолд хамгийн их хугацааг Зөрчлийн тухай хуулийн 14.7 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан зөрчилд зарцуулж байна.



Зураг 2.2.45 Шүүгчийн залруулгын захирамж, шүүхийн тогтоол ажиллагааны задаргаа

Шүүгчийн залруулгын захирамж, шүүхийн тогтоолыг боловсруулахад 21 минут, хянахад 8 минутыг тус тус зарцуулдаг гэсэн дүнтэй гарсан байна.



2.2.5 Зөрчлийн хэргийн ажлын байрны ажиглалтын хүрээнд ирүүлсэн мэдээллийн дүгнэлт

Анхан шат: Налайх болон Баянзүрх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх Зөрчлийн тухай хуулийн 10 төрөл зүйл заалтад заасан зөрчлийн хэргийг хянан шийдвэрлэхдээ ойролцоо буюу Налайх дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүх 182-211 минут, Баянзүрх дүүргийн шүүх 170-216 минут тус зарцуулдаг гэсэн үр дүн гарсан байна.

Анхан шатны шүүхээр зөрчлийн хэргийг хянан шийдвэрлэхэд хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхэд бэлтгэх, хэрэг хянан шийдвэрлэсний дараах ажиллагааны үе шатуудад зарцуулах хугацаа бага байна. Шийдвэр боловсруулах, хянах, гарын үсэг зурах үе шат хамгийн их хугацаа зарцуулж байна.

Анхан шатны дүүргийн шүүхээр хянан шийдвэрлэж буй зөрчлийн хэрэгт хамгийн их хугацааг Зөрчлийн тухай хуулийн 5.4 дүгээр зүйлд заасан “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих” зөрчлийн хэрэгт зарцуулж байна.

Харьцангуй дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны 2 шүүхийн хувьд ойролцоо дүнтэй ажиглалтын дүн гарсан байна.

Давж заалдах шат: Дархан-Уул аймаг дахь эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн зөрчлийн хэрэг хянан шийдвэрлэхэд зарцуулж буй хугацаа Нийслэлийн эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн зарцуулж буй хугацаанаас 6.6 дахин их хугацаа зарцуулдаг гэсэн дүн гарсан нь анхаарал татаж байна.

Ижил буюу давж заалдах шатны 2 шүүх зөрчлийн нэг төрлийн хэргийг хянан шийдвэрлэхэд зарцуулах хугацаа харилцан адилгүй байгаа нь ажиглалтын үр дүн зарцуулах хугацааг бодитоор тогтоогоогүй гэж үзэхээр байна.

Хэргийн 2-р үед Зөрчлийн тухай хуулийн 6.26 дугаар зүйлд заасан “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих” зөрчлийн хэрэгт хамгийн их хугацаа зарцуулж байна.

Дархан-Уул аймгийн эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүх хэргийг хүлээн авснаас хойших ажиллагааны үе шатанд зарцуулж буй хугацаа Нийслэлийн эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхээс 2.3-7.2 дахин их хугацаа зарцуулдаг гэсэн үр дүн гарсан байна.

Давж заалдах шатны шүүхийн шүүгч зөрчлийн хэргийг хянан шийдвэрлэхдээ хэргийн 4-р үет болох шийдвэр боловсруулах хянах, гарын үсэг үеийн ажиллагаанд хамгийн их хугацаа зарцуулж байна.

Хамгийн бага хугацааг буюу 407 минутыг Зөрчлийн тухай хуулийн 14.7 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан “Согтуугаар замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчих” зөрчлийн хэрэгт зарцуулж байна.


Хэрэг хүлээн авснаас хойших ажиллагааны үе шатанд Зөрчлийн тухай хуулийн 5.4 дүгээр зүйлд заасан зөрчилд хамгийн их хугацаа зарцуулж байна.

Шийдвэр боловсруулах, хянах, гарын үсэг зурах ажиллагааны үе шатны Магадлалд зарцуулж буй хугацаа гэмт хэргийн төрлөөр задалж үзэхэд 3 хэсэг тусдаа савлагаа ихтэй орж ирсэн нь өгөгдлийн мэдээллийг нэг арга зүйгээр зөв оновчтойгоор хийсэн эсэх нь эргэлзээтэй байна.



3.1 Иргэний хавтаст хэргийн материалд хийсэн шинжилгээ

Иргэний хэргийн шүүгчийн хянан шийдвэрлэсэн хэргийн ажиллагааны ачааллыг бодитой зөв тодорхойлохын тулд ШЕЗ-ийн судалгаа шинжилгээний баг ердийн журмаар шийдвэрлэсэн 31 хэрэг, бага үнийн дүнтэй 6 хэрэг, хялбаршуулсан журмаар шийдсэн 16 хэрэг буюу нийтдээ 53 хавтаст хэргийн 77 хавтаст материалтай уншиж танилцан, тоон мэдээлэл цуглуулж шинжилгээ хийсэн үр дүнг энэ бүлэг танилцуулна. Үр дүнгийн танилцуулгыг дараах зурагт ерөнхий байдлаар харуулав.



Зураг 3.1.1 Үр дүнгийн танилцуулгын схем

3.1.1 Ердийн журмаар шийдвэрлэсэн иргэний хавтаст хэргийн танилцуулга

Судалгааны түүврээр шүүхийн практикт түгээмэл шийдвэрлэгддэг иргэн, хөдөлмөр, гэр бүл, шүүхийн шийдвэр гүйцэтгэл, цагаатгалын нөхөн олговортой холбоотой маргааны төрлүүдийг сонгосон бөгөөд нийт 31 хэргийн 61 хувь нь иргэний хуулиар шийдвэрлэгдсэн хэрэг байна.



Зураг. 3.1.2 Маргааны төрөл


3.1.1.1 Ердийн журмаар шийдвэрлэсэн иргэний хавтаст хэргийн анхан шатны шүүхийн ажиллагаа дахь шинжилгээ

Нэг хуулийн ангилалд багтах хэргийг ажиллагааны тоогоор дараах зурагт харуулав. Зураг 3.1.3-аас харвал нийт 31 хэргээс иргэний хууль дахь 19 хавтаст хэргээс 14-р хэрэг бусад хуулиар шийдвэрлэгдсэн хэргүүдээс хамгийн олон ажиллагаатай буюу 349 ажиллагаа хийгдсэн бол цагаатгалын нөхөн олговрын хуулиар шийдвэрлэгдсэн хэрэгт 19 ажиллагаа хийгдсэн нь хамгийн бага ажиллагаатай байна. Эдгээр хавтаст хэргийн ажиллагааг дунджаар харахдаа тус бүр хамгийн өндөр үзүүлэлтийг хасаж тооцсон бөгөөд иргэний хуулиар шийдсэн хэрэгт 77, гэр бүлийн хуулиар шийдсэн хэрэгт 54, хөдөлмөрийн хуулиар шийдсэн хэрэгт 41 нь ажиллагаа харин шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулиар шийдвэрлэсэн хэрэгт 45 нь




ажиллагаа

байна.




Зураг 3.1.3 Хавтаст хэргийн ажиллагааны тоо /Анхан/



Зураг 3.1.4. Хавтаст хэргийн хуудасны тоо/Анхан/

3.1.3-аар зурагт ажиллагааны тоог харуулсантай ижил хэлбэрээр хэрэг тус бүр дэх хуудасны тоог харуулав. Зургаас хамгийн олон хуудастай хэргийг харахад иргэний хуулийн 14-р хэрэг 431 хуудастай, хөдөлмөрийн 3-р хэрэг 400 хуудастай байна. Харин хамгийн цөөн хуудастай хэрэгт иргэний хэргийн 28 хуудастай 11-р хэрэг, 21 хуудастай 13-р хэрэг тус тус багтаж байна.



Зураг 3.1.5. Хавтаст хэргийн ажиллагаанд зарцуулсан хугацаа, хоногоор/Анхан/


Өмнөх 2 зургаар ажиллагааны тоо болон хуудсыг харуулсан бол дээрх зурагт хэрэг тус бүрд зарцуулж байгаа хугацааг хоногоор харуулав. Тус зургаас харахад гэр бүлийн хуулийн 3-аар хэрэг хамгийн олон хоног зарцуулсан бол хамгийн цөөн буюу 43.2 хоногийг иргэний хэргийн 13-аар хэрэг байна. Эдгээр хавтаст хэргээс 7 хэрэг 300-аас дээш хоног зарцуулж шийдвэрлэгдсэн хэрэг байна.

3.1.1.1.1 Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үе шатад хийх шинжилгээ

Энэ хэсэгт иргэний хавтаст хэргийн танилцуулга бүлэгт дурдсан 31 хавтаст хэргийн мэдээллийг иргэний маргааныг шийдвэрлэсэн хуулиар тус бүр харуулахдаа ажиллагааны тоо, хуудасны тоо, хоногийг тус бүрээр дундажлаж илэрхийлсэн мэдээллийг Зураг 3.1.6-д харуулав. Доорх зургийн анхаарал татсан хэргийн хувьд тайлбар өгвөл иргэний хуулиар шийдвэрлэсэн 19 хэрэг дунджаар 91.7 ажиллагаатай, 126.4 хуудастай бөгөөд 207 хоног зарцуулжээ. Мөн гэр бүлийн хуулиар шийдвэрлэсэн 3 хэргийн ажиллагааны дундаж 84, хуудас 185 байхад 433.6 хоног зарцуулсан байгаа нь бусдаасаа хамгийн өндөр байна. Үүнд нөлөөлсөн үзүүлэлтийг хэргийн оролцогч талаас гарч байгаа нотлох баримт, материалууд их байх тохиолдолд хугацаа илүү их зарцуулагддаг гэсэн таамаглал дэвшүүлж болох юм. Энэхүү таамаглалыг дүгнэлт хэсэгт нарийвчлан шинжлэх болно. Хөдөлмөрийн хуулийн 6 хэргийн дундаж ажиллагаа 46.3, цагаатгалын хуулийн хувьд ажиллагаа 45 буюу ойролцоо үзүүлэлтэй байна. Мөн тус 2 ажиллагааны хуудас ойролцоо буюу 185, 213 байсан. Харин хоногийн хувьд




хөдөлмөрийн хуулиар шийдсэн хэрэгт дунджаар 142.6 хоног байсан бол цагаатгалын хуулиар шийдсэн хэрэгт 81.8 хоног зарцуулсан байна.




Зураг 3.1.6. Хавтаст хэргийн ерөнхий мэдээлэл

Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үе шатад хийсэн нэг ба 2 хүчин зүйлийн дисперсийн шинжилгээний үр дүнг дараах зургаар харуулав. Зураг 3.1.7-ын А-гаас харвал хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхэд бэлтгэх, хэлэлцэх үе шатанд дунджаар нэг хэргийн нийт ажиллагааны 54.5% буюу 42 ажиллагаа, шүүх хуралдаанаар хэлэлцэх, шийдвэр гаргах үе шатанд нэг хэргийн нийт ажиллагааны 30.4% буюу 23.4 ажиллагаа хийгдэж байгаа нь ихэнх хувийг эзэлж байна. Зураг 3.1.7-ын Б хэсгийн хуудасны хувьд ихэнх хувийг мөн адил хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхэд бэлтгэх, хэлэлцэх үе шат болон шүүх хуралдаанаар хэлэлцэх, шийдвэр гаргах үе шат эзэлж байна. Харин хоногийн хувьд хэрэг үүсгэх эсэхийг шийдвэрлэх үе шатанд дунджаар нэг хэрэгт зарцуулах хоногийн 0.4% буюу 8.5 хоногийг, хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхэд бэлтгэх, хэлэлцэх үе шатанд 54.8% буюу 116.4 хоног, шүүх хуралдаанаар хэлэлцэх, шийдвэр гаргах үе шатад 22.9% буюу 48.7 хоног зарцуулдаг бол хэргийг эцэслэн шийдвэрлэсний дараах үе шатанд нэг хэрэгт 18.3% буюу 38.8 хоног зарцуулсан байна.




Зураг 3.1.7. Хэргийн ажиллагааны үе шат




Зураг 3.1.8. Хэрэг хянан шийдвэрлэх үе шатанд хамаарах ажиллагааны тоо, хуулийн ангиллаар

Зураг 3.1.7-ын А-д харуулсан ерөнхий мэдээллийг хуулийн ангилал тус бүрээр Зураг 3.1.8-д дэлгэрэнгүй оруулав. Зураг 3.1.8-аас харвал хэрэг хянан шийдвэрлэх 1-р үе шатанд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль /цаашид ШШГТХ гэнэ/ -ийн ажиллагаа хамгийн их буюу 3.5 бөгөөд бусад гэмт хэргийн ажиллагааны тоо 2.5-аас 3 буюу ойролцоо ажиллагаа явуулсан байна. 2-р үе шатанд гэр бүлийн хуулиар, иргэний хуулиар шийдвэрлэгдсэн хэргийн ажиллагаа хамгийн их буюу 50-аас 51 байна. Энэ үе шатанд бусад хэргийн ажиллагааны тоо харилцан адилгүй буюу хөдөлмөрийн хууль 25.8, ШШГТХ 16, цагаатгалын хуулиар шийдсэн хэрэгт 10 ажиллагаа хийгдсэн байна. 3-р үе шатанд хэргийг шийдвэрлэсэн хууль буюу маргааны төрлөөс хамаарч иргэний хууль, гэр бүлийн хуулиас бусад хуулиар шийдвэрлэсэн хэргийн ажиллагаа харилцан адилгүй явагдсан байна.



Зураг 3.1.9. Хэрэг хянан шийдвэрлэх үе шатанд хамаарах хавтаст хэргийн материал, хуудасны тоогоор

Зураг 3.1.7-ын Б-д харуулсан ерөнхий мэдээллийг хуулийн ангилал тус бүрээр Зураг 3.1.9-д дэлгэрэнгүй оруулав. Зураг 3.1.9-өөс харвал хэрэг хянан шийдвэрлэх 1-р үе шатанд цагаатгалын хуулиар шийдвэрлэгдсэн хэргийн материалын хуудасны тоо хамгийн их буюу 24 байна. Харин хамгийн бага нь 4.4 хуудастай буюу иргэний хууль байна. Бусад хэргийн материалын хуудасны тоо 5-9 хуудас байна. 2-р үе шатанд хөдөлмөрийн хуулиар шийдвэрлэсэн хэрэг хамгийн өндөр буюу 146.7 хуудастай бол цагаатгалын хууль хамгийн бага буюу 14 хуудастай байна. Энэ үе шатанд бусад хэргийн материалын хуудасны тоо харилцан адилгүй өөр өөр утгатай байна. 3-р үе шатанд цагаатгалын хуулиар шийдвэрлэгдсэн хэргээс бусад хэрэг төрлөөсөө үл хамаарч материалын хуудасны тоо ойролцоо байгаа бол 4-р үе шатанд мөн адил цагаатгалын хуулиар шийдвэрлэгдсэн хэргээс бусад хэргийн хуудасны тоо ойролцоо буюу 5.8-15.4 байна.




Зураг 3.1.10. Хэрэг хянан шийдвэрлэх үе шатанд хамаарах хавтаст хэрэгт зарцуулсан хугацаа, тоогоор


Зураг 3.1.7-ын В-д харуулсан ерөнхий мэдээллийг хэргийн төрөл тус бүрээр зарцуулсан хугацаа буюу хоногийн мэдээллийг Зураг 3.1.10-д дэлгэрэнгүй оруулав. Зураг 3.1.10-аас харвал хэрэг хянан шийдвэрлэх анхан шатны 1-р үе шатанд ШШГТХ-ын ажиллагаанд зарцуулсан хугацаа хамгийн их буюу 38.1 хоног байна. Бусад хэргийн хувьд 4.4-7.3-ийн хороонд буюу ойролцоо байна. 2-р үе шатанд гэр бүлийн хууль 244.4 буюу хамгийн их хоног зарцуулсан бол 47.3 хоногтой ШШГТХ-аар шийдсэн хэрэгт хамгийн бага хоногтой байна. Бусад хэргийн хувьд ойролцоо. 3-р үе шатанд судалгаанд хамрагдсан хэргийн төрлийн хувьд ажиллагаанд зарцуулсан хугацаа гэр бүлийн хуулиар шийдсэн хэрэг бусдаасаа 123.4 хоногоор хамгийн олон хоног зарцуулсан байна. Үүний дотор 2-р шатанд цагаатгалын хууль 62.3 хоногтой байсан бол 1.4 хоног болж буурсан байгаа нь хамгийн бага хугацаа зарцуулсан харагдаж байна. 4-р үеийн хувьд гэр бүлийн хуулиар шийдвэрлэсэн хэргийн хоног өмнөх 2, 3-аар үе шатын адил бусдаасаа их хоног зарцуулжээ.

3.1.1.1.2 Ердийн журмаар шийдвэрлэсэн иргэний хэрэг хянан шийдвэрлэх анхан шатны ажиллагааны төрөлд хийх шинжилгээ

Өмнөх бүлгийн Зураг 3.1.8-3.1.10-д харуулсан хэрэг хянан шийдвэрлэх үе шатны анхан шатад ямар төрлийн ажиллагаанаас хамаарч харилцан адилгүй үзүүлэлттэй байгааг хэргийн ажиллагаа тус бүрийн ажиллагааны тоо, хуудасны тоо болон хоногоор дэлгэрэнгүй тайлбарлан харуулъя.


Зураг 3.1.11. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны тоо, хэргийн үе шатаар²

Зураг 3.1.8-аар харуулсан үр дүнг Зураг 3.1.11-ээр ажиллагааны төрөл тус бүрээр задлан харуулав. /Ажиллагааны ангиллыг хавсралтаас харна уу/ Зураг 3.1.11-ээс харвал хэрэг шийдвэрлэх үйл ажиллагааны тооны хувьд 2, 3-р үеийн баримт, 2-р үеийн хүсэлт хамгийн их ажиллагаа шаарддаг болох нь харагдаж байна. Эдгээр үеүдэд хамгийн их ажиллагаа орсон баримт, нотлох баримт, хүсэлт ямар хуулиар шийдвэрлэгдсэн хэрэгт ачаалал үзүүлж байгааг тодорхойлохын тулд Зураг 3.1.12-д (программын үр дүн) харуулав.



Зураг 3.1.12 Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд нөлөөлөх үзүүлэлт, хуулийн ангиллаар

Зураг 3.1.12-аас харвал иргэний хуулиар шийдвэрлэгдсэн хэргийн судалгаанд авч үзсэн бүх хэргээс дунджаар хамгийн өндөр баримтын ажиллагаа нь 11.6 бол хамгийн бага нь 2.3 нь ажиллагаа явагдсан байна. Харин нотлох баримтын хувьд иргэний хууль мөн адил хамгийн их буюу 8.3 ажиллагаа явагдсан. Хүсэлт³ гэсэн ажиллагааны гэр бүлийн хуулиар шийдвэрлэгдсэн хэрэгт хамгийн их буюу 6.8 ажиллагаа явагдсан байна.



Зураг 3.1.13 Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны материалын хуудас, хэргийн үе шатаар


Зураг 3.1.9-ийн үр дүнг Зураг 3.1.13-д ажиллагаанд үйлдэгдсэн материалын хуудасны тоогоор задлан харуулав. Зураг 3.1.13-аас харвал хэрэг шийдвэрлэх үйл ажиллагаанд үйлдэгдсэн материалын хуудасны тооны хувьд 1, 2-р үеийн нотлох баримт, 1, 2-р үеийн баримт, 3-р үеийн шүүх хуралдааны тэмдэглэл хамгийн их хуудастай болох нь харагдаж байна. Эдгээр үеүдэд хамгийн ажиллагаа орсон баримт, нотлох баримт, шүүх хуралдааны тэмдэглэл ямар хуулиар шийдвэрлэгдсэн хэрэгт хамгийн их байгааг тодорхойлохын тулд Зураг 3.1.14-д

² Шүүхийн ажиллагааны ангиллын задаргаа буюу товч утгыг хавсралтаас харна уу.

³ Хүсэлт гэсэн ажиллагаанд үзлэг хийлгэх, гомдол гаргах хугацаа сэргээлгэх, залруулга хийлгэх, итгэмжлэгдсэн төлөөлөгчийг оролцуулах зэрэг 50 төрлийн ажиллагаа нь шүүхийн нөгөө талаас гарч байгаа ажиллагаа боловч энэ нь өөрөө шүүхэд ажиллагаа болдог тул тус ажиллагааг шүүхийн ажиллагаанд тооцсон.




(программын үр дүн) харуулав. Зураг 3.1.14-өөс харвал ердийн журмаар шийдвэрлэсэн анхан шатны хэргийн судалгаанд авч үзсэн хавтаст хэргийн материалын баримтын хуудасны тоо ойролцоо байна. Нотлох баримтын хувьд хөдөлмөрийн хамгийн их буюу 93.6 хуудас материал байна. Харин шүүх хуралдааны тэмдэглэлийн хувьд цагаатгалын хуулиар шийдвэрлэгдсэн хэргээс бусад хэрэг ойролцоо буюу 15.5-аас 30 хуудас материал байна.




Зураг 3.1.14. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны материалын хуудасны тоонд нөлөөлөх үзүүлэлт, хуулийн ангиллаар

Зураг 3.1.10-ын үр дүнг Зураг 3.1.15-д хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны төрлийг зарцуулсан хоногоор задлан харуулав. Зураг 3.1.15-аас харвал хэрэг шийдвэрлэх үйл ажиллагааны төрлийг зарцуулсан хоногийн хувьд 2-р үеийн баримт, ерөнхий шүүгчийн захирамж, 3-р үеийн тэмдэглэл хамгийн их хугацаа зарцуулсан болох нь харагдаж байна. Эдгээр үеүдэд хамгийн их ажиллагаа орсон баримт, ерөнхий шүүгчийн захирамж, тэмдэглэлийг ямар хуулиар шийдвэрлэсэн хэрэгт хамгийн их байгааг тодорхойлохын тулд Зураг 3.1.15-д (программын үр дүн) харуулав.



Зураг 3.1.15. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд зарцуулсан хоног, хэргийн үе шатаар⁴



Зураг 3.1.16. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд зарцуулсан хоногийн тоонд нөлөөлөх үзүүлэлт, хуулийн ангиллаар

Зураг 3.1.16-аас харвал баримтад зарцуулсан хугацааны хувьд гэр бүлийн хуулиар шийдвэрлэсэн хэрэгт 81.2 хоног зарцуулсан нь хамгийн өндөр байгаа бол бусад хуулийн хувьд ойролцоо байна. Ерөнхий шүүгчийн захирамжийн хувьд иргэний хууль, хөдөлмөрийн хуулиар шийдвэрлэсэн хэргийн хугацаа 9.5-9.6 байна. Харин гэр бүлийн хуулиар шийдвэрлэсэн хэрэгт дунджаар 0.1 буюу нэг хоног дотор шийдвэрлэсэн гэсэн үр дүн гарсан байна. Тэмдэглэл буюу шүүх хуралдааны тэмдэглэлээс бусад тэмдэглэлийн хувьд иргэн 41.6, хөдөлмөр 39.4 байсан нь хамгийн их хоног зарцуулсан гэж харагдаж байна.

⁴ Анхаарах асуудал: Шүүхийн ажиллагааны хоногийн мэдээллийг тооцоход “шийдвэр” гэсэн шүүхийн ажиллагааны хоногийг 0.1-ээр тооцсон болохыг анхаарна уу. Учир нь шүүх хуралдаан болсон өдрийн он, сар, өдрөөр тухай ажиллагааны он, сар, өдөр бичигддэг. Иймд “шийдвэр”-ийн хоногийн тоо “шийдвэр” боловсруулахад зарцуулж байгаа хугацааг илэрхийлэхгүй болохыг анхаарна уу.



Ердийн журмаар шийдвэрлэсэн иргэний хэрэг хянан шийдвэрлэх анхан шатны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үе шатуудад хийсэн 2 ба 3 хүчин зүйлийн дисперсийн шинжилгээг программын үр дүн дээр тулгуурлан дараах коэффициентуудыг тооцов. Үүнд:

№	Үзүүлэлт	Детерминацийн коэффициент	Корреляцийн коэффициент	Вариацийн коэффициент	Дундаж
1	Иргэний хэрэг /Хуулийн ангилал/	0.4	0.63	230%	76.8
2	Хэргийн үе	0.06	0.25	576%	
3	Ажиллагаа	0.12	0.35	407%	

Хүснэгт 3.1.1. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны материалын ажиллагааны тоонд нөлөөлөх хүчин зүйлүүд

Хүснэгт 3.1.1-ийн эхний мөрийн утгыг тайлбарлая. Иргэний хавтаст хэргийн анхан шатны ажиллагааны тооны нэгж өөрчлөлтийн 0.4 нь иргэний хэргийн хуулийн ангиллаас хамаарч байна. Өөрөөр хэлбэл иргэний хэргээс сонгогдсон хавтаст хэргийн ажиллагааны тооны өөрчлөлтийн 40% нь иргэний хэргийн хуулийн ангиллаас хамаардаг байна. Үлдсэн 60% нь бусад хүчин зүйлийн хамаарал байна. Иргэний хавтаст хэргийн ажиллагааны тооны нэгж өөрчлөлт нь иргэний хэргийн төрлөөс 0.63 буюу хүчтэй хамааралтай байна. Вариацийн коэффициент 230% байгаа нь тоон үзүүлэлтүүд нэгэн төрлийн бөгөөд дунджийн төлөөлөх чадвар өндөр буюу нэг төрлийн хуулийн ангиллаар шийдвэрлэгдсэн хэрэгт дунджаар 76.8 ажиллагаа байна. Ердийн журмаар шийдвэрлэгдсэн хэргийн төрлийн хувьд ажиллагааны дундаж тоон утгыг судалгаанд цааш нь ашиглах боломжтой.

Харин хэргийн үе болон ажиллагааны детерминацийн коэффициент 0.06-0.12 байгаа нь шугаман хамаарал маш сул буюу ажиллагааны тоон өөрчлөлтөд төдийлөн нөлөөлөлгүй байгаа бол тус бүрийн дунджийн төлөөлөх чадвар өндөр байна.

№	Үзүүлэлт	Детерминацийн коэффициент	Корреляцийн коэффициент	Вариацийн коэффициент	Дундаж
1	Иргэний хэрэг /Хуулийн ангилал/	0.12	0.35	412.7%	144.8
2	Хэргийн үе	0.06	0.26	966.6%	
3	Ажиллагаа	0.07	0.27	541.2%	

Хүснэгт 3.1.2. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны материалын хуудасны тоонд нөлөөлөх хүчин зүйлүүд

Хүснэгт 3.1.2-ын эхний мөрийн утгыг тайлбарлая. Ердийн журмаар шийдвэрлэгдсэн иргэний хавтаст хэргийн ажиллагааны ачааллын нэгж тооны өөрчлөлтөд иргэний хавтаст хэргийн анхан шатны ажиллагааны материалын хуудасны тоо 0.12 нэгж тооны нөлөөллийг үзүүлж байна. Өөрөөр хэлбэл иргэний хэргээс сонгогдсон хавтаст хэргийн ажиллагааны тооны өөрчлөлтийн 12%-ийг иргэний хэргийн хуудасны тоон дүн эзэлж байна. Иргэний хавтаст хэргийн хуудасны тоо иргэний хэргийн хуулийн ангилал, хэргийн үе болон ажиллагааны тооноос бага хамааралтай байна. Вариацийн коэффициент 412.7%-966.6% байгаа нь тоон үзүүлэлтүүд нэгэн төрлийн бөгөөд дунджийн төлөөлөх чадвар өндөр буюу нэг төрлийн хуулийн ангиллаар шийдвэрлэгдсэн хэрэг дунджаар 144.8 хуудастай байна. Иргэний хэргийн төрлийн хувьд хуудасны тооны дундаж утгыг судалгаанд цааш нь ашиглах боломжтой.

Хэргийн үе болон ажиллагааны детерминацийн коэффициент 0.06-0.12 байгаа нь шугаман хамаарал маш сул буюу ажиллагааны тооны өөрчлөлтөд төдийлөн нөлөөлөлгүй байгаа боловч тус бүрийн дунджийн төлөөлөх чадвар өндөр байна.

№	Үзүүлэлт	Детерминацийн коэффициент	Корреляцийн коэффициент	Вариацийн коэффициент	Дундаж
1	Иргэний хэрэг /Хуулийн ангилал/	0.39	0.63	332.4%	211.2
2	Хэргийн үе	0.06	0.25	588.4%	
3	Ажиллагаа	0.13	0.36	481.2%	


Хүснэгт 3.1.3. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд зарцуулах хугацаанд нөлөөлөх хүчин зүйлүүд



Хүснэгт 3.1.3-ын эхний мөрийн утгыг тайлбарлая. Ердийн журмаар шийдвэрлэгдэн иргэний хавтаст хэргийн ажиллагааны ачааллын нэгж тооны өөрчлөлтөд ердийн журмаар шийдвэрлэгдсэн иргэний хавтаст хэргийн анхан шатны ажиллагаанд зарцуулагдах хугацаанд 0.39-ийн нөлөөллийг үзүүлж байна. Өөрөөр хэлбэл иргэний хэргээс сонгогдсон хавтаст хэргийн ажиллагааны тооны өөрчлөлтийн 39% нь иргэний хэргийн ажиллагааны хугацааны өөрчлөлтөөс хамаардаг байна. Иргэний хавтаст хэргийн хугацаа хэрэг шийдвэрлэсэн хуулийн ангиллын хувьд 0.63 буюу хүчтэй хамааралтай байна. Өөрөөр хэлбэл ажиллагаа нэмэгдэхэд хоног мөн адил нэмэгдэг байна. Вариацийн коэффициент 332.4%-588.4% байгаа нь тоон үзүүлэлтүүд нэгэн төрлийн бөгөөд дунжийн төлөөлөх чадвар өндөр буюу нэг төрлийн хуулийн ангиллаар шийдвэрлэгдсэн хэргийн анхан шатанд дунджаар 211.2 хоног зарцуулдаг байна. Ердийн журмаар шийдвэрлэгдсэн иргэний хэргийн төрлийн хувьд хугацааны дундаж утгыг судалгаанд цааш нь ашиглах боломжтой.


3.1.1.2 Ердийн журмаар шийдвэрлэсэн иргэний хавтаст хэргийн давж заалдах шатны шүүхийн ажиллагаа дахь шинжилгээ

Өмнөх бүлэгт ердийн журмаар шийдвэрлэсэн иргэний хавтаст хэргийн анхан шатны шүүхийн ажиллагаанд шинжилгээ хийсэн бол энэхүү бүлэгт давж заалдах шатны шинжилгээний үр дүнг харуулна. Энэхүү шатанд цагаатгалын хуулиар шийдвэрлэсэн хэрэг болон бусад хуулиар шийдвэрлэгдсэн хэргүүдээс хасагдаж 31 хэргээс 17 хэргийн хүрээнд шинжилгээ хийв. Учир нь тус хасагдсан хэргүүд анхан шатанд шийдвэрлэгдэж, ажиллагаа дууссан болно.




Зураг 3.1.17 Хавтаст хэргийн ажиллагааны тоо /Давах/

Зураг 3.1.17-аас харвал давж заалдах шатны иргэний хууль дахь 17 хавтаст хэргээс 15-р хэрэг бусад хуулиар шийдвэрлэгдсэн хэргүүдээс хамгийн олон ажиллагаатай буюу 21 ажиллагаа хийгдсэн бол гэр бүлийн хуулиар шийдвэрлэгдсэн 2 хэргийн хувьд ойролцоо харин хөдөлмөрийн хуулиар шийдвэрлэгдсэн хэргүүдээс 5-р хэрэг 35 ажиллагаа хийгдсэн нь бүлэг дотроо болон давж заалдах шатны хэргүүдийн хувьд хамгийн олон ажиллагаатай байна. ИШШГТХ-ын 2 хэргийн хувьд 2-р хэрэгт дунджаар 15 ажиллагаа хийгдсэн байна. Ерөнхийд нь давж заалдах шатны ажиллагааны тооноос хамгийн их утгуудыг хасаж харвал дунджаар 6-аас 17 ажиллагаа хийгдсэн байна.



Зураг 3.1.18 Хавтаст хэргийн хуудасны тоо/Давах/

Ажиллагааны тоог харуулсантай ижил хэлбэрээр хэрэг тус бүр дэх хуудасны тоог харуулав. Зургаас хамгийн олон хуудастай хэргийг харахад иргэний хуулийн 15-р хэрэг 39 хуудастай, тус хуулийн 12-р хэрэг 33 хуудастай, хөдөлмөрийн хуулиар шийдвэрлэсэн 5-р хэрэг 50 хуудастай байна. Харин хамгийн цөөн хуудастай хэрэгт гэр бүлийн хуулиар шийдвэрлэгдсэн 1-р хэрэг 6 хуудастай байна. Дунджаар давж заалдах шатны шүүхээр шийдвэрлэсэн иргэний хэргийн хувьд 9-23 хуудастай байна.




Зураг 3.1.19 Хавтаст хэргийн ажиллагаанд зарцуулсан хугацаа, хоногоор/Давах/

Дээрх зурагт анхан шатны шүүхээс давж заалдах шат руу шилжиж, давж заалдах шатанд хийгдсэн ажиллагаанд зарцуулж буюу хугацааг хэрэг тус бүрээр харуулав. Тус зургаас харахад гэр бүлийн хуулиар шийдвэрлэгдсэн хэргээс 15-аар хэрэг 134.5 хоног зарцуулсан нь хамгийн өндөр байгаа бол хамгийн цөөн буюу 15.2 хоногт иргэний хэргийн 5-аар хэрэг шийдвэрлэгдсэн байна. Эдгээр 4 хуулийн ангилал бүхий нийт 26 хэргээс давж заалдах шатанд хамгийн олон хоног зарцуулсан хэргээр хөдөлмөрийн хуулиар шийдвэрлэсэн 5-р хэрэг 187.5 хоног зарцуулжээ.

3.1.1.2.1 Давж заалдах шатны ердийн журмаар шийдвэрлэсэн иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үе шатад хийх шинжилгээ

Өмнөх бүлэгт давж заалдах шат дахь хэрэг тус бүрээр харьцуулан ерөнхий байдлыг харсан бол одоо харин хуулийн ангиллаар нэгтгэж, ажиллагааны тоо, хуудасны тоо болон хоногийн шинжилгээний үр дүнг танилцуулна. Зураг 3.1.20-оос харвал хөдөлмөрийн хуулиар шийдвэрлэсэн хэргийн дунджаар 16.4 ажиллагаа 25.8 хуудастай байсан бөгөөд үүнд 124.9 хоног зарцуулсан хэрэг байна.




Зураг 3.1.20. Давж заалдах шатны хавтаст хэргийн материалын танилцуулга

Давж заалдах шатны ердийн журмаар шийдвэрлэгдсэн иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үе шатад дисперсийн шинжилгээний үр дүнг дараах зургаар харуулав. Зураг 3.1.21-ийн А-гаас харвал хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхэд бэлтгэх, хэлэлцэх үе шатанд дунджаар нэг хэргийн нийт ажиллагааны 24.2% буюу 3.1 ажиллагаа, шүүх хуралдаанаар хэлэлцэх, шийдвэр гаргах үе шатанд нэг хэргийн нийт ажиллагааны 52.3% буюу 6.7 ажиллагаа, хэргийг эцэслэн шийдвэрлэсний дараах үе шатанд нэг хэргийн нийт ажиллагааны 23.5% буюу 3 ажиллагааг явуулсан байна.

А.Ажиллагааны тоо/хувь

Б.Хуудасны тоо/хувь

В.Хоногийн тоо/хувь




Зураг 3.1.21. Давж заалдах шатны хэргийн ажиллагааны үе шатыг ажиллагаа, хуудас, хугацаагаар


Зураг 3.1.21-ийн Б-гийн хувьд хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхэд бэлтгэх, хэлэлцэх үе шатанд дунджаар нэг хэргийн нийт материалын 15.9% буюу 3.8 хуудас, хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэх, шийдвэр гаргах үе шатанд нэг хэргийн нийт материалын 64.4% буюу 15.4 хуудас, хэргийг эцэслэн шийдвэрлэсний дараах үе шатанд нэг хэргийн нийт материалын 19.7% буюу 4.7 хуудас материалаас бүрдсэн байна. Зураг 3.1.21-ийн В-гийн хувьд хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхэд бэлтгэх, хэлэлцэх үе шатанд дунджаар нэг хэрэгт зарцуулсан нийт хугацааны 25.4% буюу 17.3 хоног, хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэх,



шийдвэр гаргах үе шатанд 36.3% буюу 24-25 хоног, хэргийг эцэслэн шийдвэрлэсний дараах үе шатанд 38.3% буюу 26.1 хоног тус тус зарцуулсан байна. Зураг 3.1.17-д харуулсан ерөнхий мэдээллийг хуулийн ангилал тус бүрээр Зураг 3.1.22-д дэлгэрэнгүй оруулав. Зураг 3.1.22-оос харвал давж заалдах шатны хэрэг хянан шийдвэрлэх 3-р үе шатанд хамгийн олон ажиллагаа явуулсан байна. Ажиллагаа тус бүрээс хамгийн өндөр үзүүлэлтийг харвал 2-р үе шатанд ШШГТХ-аар шийдвэрлэсэн хэрэгт дунджаар 7, 3-р үе шатанд хөдөлмөрийн хуулиар шийдвэрлэсэн хэрэгт 9.4 бол 4-р үе шатанд гэр бүлийн хуулиар шийдвэрлэсэн хэргүүд байна. Тэгвэл хамгийн бага ажиллагаа хийгдсэн хуулийн ангиллыг үе тус бүрээр харвал 1-р үе шатанд иргэний хууль 1.6, 2-р үе шатанд ШШГТХ-аар шийдсэн хэрэг 4.5 байгаа бол 4-р үе шатанд хөдөлмөр, иргэн, ШШГТ-аар шийдвэрлэсэн хэргүүд ойролцоо буюу 2.4-2.8-ийн хооронд ажиллагаа явагддаг хэргүүд байна.




Зураг 3.1.22. ДЗШ-ны хэрэг хянан шийдвэрлэх үе шатанд хамаарах ажиллагааны тоо, хуулийн ангиллаар



Зураг 3.1.23 ДЗШ-ны хэрэг хянан шийдвэрлэх үе шатанд хамаарах хуудасны тоо, хуулийн ангиллаар

Зураг 3.1.18-д харуулсан хуудасны ерөнхий мэдээллийг хуулийн ангилал тус бүрээр Зураг 3.1.23-д дэлгэрэнгүй оруулав. Зураг 3.1.22-аас харвал давж заалдах шатны хэрэг хянан шийдвэрлэх 3-р үе шатанд хамгийн олон ажиллагаатай байсан бол хуудасны тоо мөн адил энэ үе шатанд хамгийн их байна. Ажиллагаа тус бүрээс хамгийн өндөр үзүүлэлтийг харвал 2-р үе ШШГТХ-аар шийдвэрлэсэн хэрэг дунджаар 8, 3 болон 4-р үе шат дахь гэр бүлийн хуулиар шийдвэрлэсэн хэрэг тус бүр 21 хуудастай байна. Харин дунджаар хамгийн бага хуудастай хуулийн ангиллаар 1-р үе шатанд иргэний хууль 2.2, 2-р үе шатанд ШШГТХ-аар шийдсэн хэрэг 8.5 байгаа бол 4-р үе шатанд хөдөлмөр, иргэн, ШШГТ-аар шийдвэрлэсэн хэргүүд ойролцоо буюу 2.5-3 хуудастай хэргүүд байна.




Зураг 3.1.24. ДЗШ-ны хэрэг хянан шийдвэрлэх үе шатанд хамаарах хоног дунджаар, хуулийн ангиллаар

Зураг 3.1.24-өөс давж заалдах шатны хянан шийдвэрлэх ажиллагааны хэддүгээр үед ямар хуулийн ангилал хамгийн их хугацаа зарцуулж байгааг харвал 3-р үе шатны гэр бүлийн хуулиар шийдвэрлэгдсэн нэг хэрэг дунджаар 67.9 хоног зарцуулсан байна. Тэгвэл хэргийн үе шат тус бүрээр хамгийн олон хоног зарцуулсан хуулийн ангийг харахад 2-р үе шатанд 34.2 хоногтой хөдөлмөрийн хууль, 3-р үе шатанд гэр бүлийн хууль, 4-р үе шатанд мөн адил гэр бүлийн хууль олон хоног буюу 37.6 хоног зарцуулагдсан байна.




3.1.1.2.2 Ердийн журмаар шийдвэрлэсэн иргэний хэрэг хянан шийдвэрлэх давж заалдах шатны ажиллагааны төрөлд хийх шинжилгээ

Зураг 3.1.22-д харуулсан давж заалдах шатны хэрэг хянан шийдвэрлэх үе шатыг хэргийн ажиллагаа тус бүрээр Зураг 3.1.25-д ажиллагааны төрөл тус бүрээр задлан харуулъя.




Зураг 3.1.258. ДЗШ-ны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны тоо, түүнд нөлөөлөх үзүүлэлт




Зураг 3.1.26 Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд нөлөөлөх үзүүлэлт, хуулийн ангиллаар

Зураг 3.1.26-аас харвал давж заалдах шатны хэрэг шийдвэрлэх үйл ажиллагаанд нөлөө өндөр ажиллагааны хувьд 3-р үеийн захирамж болон хүсэлт, 2-р үеийн баримт хамгийн их ажиллагаа болох нь харагдаж байна. Тус 3 нь нөлөөлөх өндөр ажиллагааг Зураг 3.1.26-аар ямар хуулийн ангилалд хамгийн их байгааг харвал захирамжийн хувьд ойролцоо буюу 1.2-2 ажиллагаатай байна. Баримтын хувьд хөдөлмөрийн хуулиар шийдвэрлэгдсэн хэрэг хамгийн их буюу 2.3 ажиллагаа орсон бол хүсэлтийн хувьд ШШГТХ хамгийн их буюу 2 ажиллагаатай байна.



Зураг 3.1.27. ДЗШ-ны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хуудасны тоо, түүнд нөлөөлөх үзүүлэлт


Зураг 3.1.27-оос харвал давж заалдах шатны хэрэг шийдвэрлэх үйл ажиллагааны хуудасны тооны хувьд хамгийн олон хуудастай ажиллагааг харвал 3 ба 4-р үеийн магадлал 7.9-8, 3-р үеийн шүүх хуралдааны тэмдэглэл 3.6, 4-р үеийн хяналтын болон давахын гомдол тус тус 3 хуудастай болох нь харагдаж байна.



Зураг 3.1.28 Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны материалын хуудасны хувьд нөлөөлөх үзүүлэлт, хуулийн ангиллаар




Энэхүү нөлөөлөх үзүүлэлтүүдээс хуулийн ангиллаар хамгийн олон хуудастай хуулийн ангиллыг нэрлэвэл Зураг 3.1.28-д иргэний хуулиар хянан шийдвэрлэсэн хэргийн магадлал дунджаар 10.5 хуудастай байна. Шүүх хуралдааны тэмдэглэлийн хувьд гэр бүлийн хуулиар шийдвэрлэгдсэн хэрэг 5 хуудастай, хяналтын гомдлын хувьд иргэний хуулиар шийдвэрлэсэн хэрэг 4 хуудастай бол давахын гомдол дахь хөдөлмөрийн хуулиар шийдсэн хэрэг 3 хуудастай байна.



Зураг 3.1.29 ДЗШ-ны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд зарцуулсан хугацаа, түүнд нөлөөлөх үзүүлэлт

Зураг 3.1.29 зургаас харвал давж заалдах шатны хэрэг шийдвэрлэх үйл ажиллагаанд зарцуулсан хугацаа 2-р үеийн ерөнхий шүүгчийн захирамж, 2 болон 3-р үеийн баримт, албан бичигт хамгийн их хугацаа зарцуулжээ. Тус нөлөө бүхий 3 ажиллагааг хуулийн ангиллаар харьцуулан Зураг 3.1.30-д харуулав. Зургаас хамгийн олон хоног зарцуулсан байдлыг харахад ерөнхий шүүгчийн захирамжийн хувьд ШШГТХ-д 10.1 хоног, баримт болон албан бичгийн хувьд гэр бүлийн хуулиар шийдвэрлэгдсэн хэрэгт 15-28.2 хоног зарцуулсан байна. Нэр дурдсан хэргийн материалуудын хуудасны тоог хоногтой харьцуулан харахад хуудас олон байхад хоногийн тоо их байх нөхцөлийг үүсгэхгүй байна.




Зураг 3.1.30 Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд зарцуулсан хугацааны хувьд нөлөөлөх үзүүлэлт, хуулийн ангиллаар

Эхний зургаас харвал давж заалдах шатны хэрэг шийдвэрлэх үйл ажиллагаанд зарцуулсан хугацааны хувьд 2 ба 3-р үеийн ерөнхий шүүгчийн захирамж, 3-р үеийн баримт, албан бичигт хамгийн их хугацаа зарцуулсан байна. Зураг 20-ийн дараагийн зургаас харвал 17.1-1-ийн баримт бүрдүүлэхэд 12 хоног, ерөнхий шүүгчийн захирамж бүрдүүлэхэд 15 хоног зарцуулсан байна. 11.6-2-д албан бичиг бүрдүүлэхэд хамгийн их буюу 53 хоног зарцуулсан байна. Нэр дурдсан хэргийн материалууд хэрэг хянан шийдвэрлэх үйл ажиллагаанд зарцуулсан хугацааг харьцангуй өндөр харагдуулах нөхцөлийг үүсгэсэн байна.

3.1.1.3 Хяналтын шатны ердийн журмаар шийдвэрлэсэн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үе шатад хийх шинжилгээ


Ердийн журмаар шийдвэрлэгдсэн иргэний хэргийн анхан, давж заалдах шатны шүүхээр шийдвэрлэгдсэн хэрэгт хийсэн шинжилгээ үр дүнг өмнөх бүлгүүдэд танилцуулсан бол энэхүү бүлэгт хяналтын шат руу орсон иргэний хуулийн 16 хэрэг, хөдөлмөрийн хуулийн 5 хэрэг, ШШГТ-ийн 2 хэргийн хүрээнд хийсэн шинжилгээний үр дүнг ерөнхий байдлаар ажиллагааны тоо, хуудасны тоо болон ажиллагаанд зарцуулж байгаа хоногийг танилцуулъя.



Зураг 3.1.31. Хавтаст хэргийн ажиллагааны тоо /Хяналт/




Зураг 3.1.31-ээс харвал давж заалдах шатны иргэний хууль дахь 16 хавтаст хэргээс 11-р хэрэг бусад хуулиар шийдвэрлэгдсэн хэргүүдээс хамгийн олон ажиллагаатай буюу 21 ажиллагаа хийгдсэн бол хөдөлмөрийн хуулиар шийдвэрлэгдсэн 5 хэргээс 1-р хэрэг хамгийн олон буюу 18 ажиллагаатай байсан бол ШШГТХ-аар шийдвэрлэгдсэн 2 хэрэг ойролцоо буюу 6-7 ажиллагаатай байна. Ерөнхийд нь хяналтын шатны ажиллагааны тооноос дээр дурдсан хамгийн их утгуудыг хасаж харвал дунджаар 6-аас 16 ажиллагаа хийгдсэн байна.




Зураг 3.1.32. Хавтаст хэргийн хуудасны тоо/Хяналт/

Хавтаст хэргийн хуудасны тоог Зураг 3.1.32-оос харвал давж заалдах шатны иргэний хууль дахь 16 хавтаст хэргээс 11-р хэрэг бусад хуулиар шийдвэрлэгдсэн хэргүүдээс хамгийн олон хуудастай буюу 38 нь хуудастай, удаах 2-р хэрэг 32 хуудастай байгаа бол хөдөлмөрийн хуулиар шийдвэрлэгдсэн 5 хэргээс 1-р хэрэг 30 хуудастай байсан бол бусад хэргийн хувьд ойролцоо ажиллагаатай байна. Ажиллагааны тоо болон хуудасны тоог харьцуулж харахад ажиллагаа болон хуудасны тоо шууд хамааралтай гэсэн таамаглалыг дэвшүүлэх боломжтой юм.




Зураг 3.1.33. Хавтаст хэргийн ажиллагаанд зарцуулсан хугацаа, хоногоор/Хяналт/

Зураг 3.1.33-г ажиллагаанд зарцуулсан хоногийг харуулсан бөгөөд үүнээс харахад ажиллагааны тоо болон хуудасны тооноос үл хамаарч дунджаар ажиллагаанд зарцуулах хугацаа харьцангуй их байна. Үүнийг тодорхойлохын тулд 3 төрлийн коэффициентоор шалгаж болох юм.




Зураг 3.1.34. Хяналтын шатны хавтаст хэргийн материалын танилцуулга

Хяналтын шатны хавтаст хэргийн материалын танилцуулгыг Зураг 3.1.34-өөс харахад иргэний хуулиар шийдвэрлэгдсэн хэргийн хувьд ажиллагааны тоо 9.9, хуудасны тоо 20.4 байсан бол үүнд зарцуулж байгаа хоног 138.6 байна. Харин ШШГТХ-аар шийдвэрлэгдсэн хэрэг дунджаар нэг хэрэгт 6.5 ажиллагаа байгаа бол тус нэг хэрэг 12 хуудастай үүнд зарцуулж байгаа хоног 187.2 байна.



Зураг 3.1.35. Давж заалдах шатны хэргийн ажиллагааны үе шат, ажиллагаа, хуудас, хугацаагаар

Хэргийн үе шатаар ажиллагааны тоо, хуудасны тоо болон ажиллагаанд зарцуулсан хугацааг Зураг 3.1.35-аас харахад шүүх хуралдаанаар хэлэлцэх, шийдвэр гаргах үе шат аль аль хэсэгт 49%-71.4%-ийг эзэлж байна.




Зураг 3.1.36. Хэрэг хянан шийдвэрлэх үе шат

Зураг 3.1.36-ийн харвал хяналтын шатны хэрэг хянан шийдвэрлэх үе шатыг хуулийн ангиллаар харьцуулан харвал 2-р үе шатны хөдөлмөрийн хуулиар шийдсэн хэрэгт дунджаар 6 ажиллагаа нь 6 хуудастай үүнд зарцуулж байгаа хоног 145.4 байна. Ерөнхий байдлаар хэргийн үе шат дахь хуулийг харьцуулж харахад ажиллагааны тоо, хуудасны тоо болон хоногийн тоо бүгд шууд хамааралтай байна.


3.1.1.3.1 Ердийн журмаар шийдвэрлэсэн иргэний хэрэг хянан шийдвэрлэх хяналтын шатны ажиллагааны төрөлд хийх шинжилгээ

Зураг 3.1.36-д харуулсан А хэсгийн хяналтын шатанд шийдвэрлэсэн хэргийг үе шатыг ажиллагаа тус бүрээр Зураг 3.1.37-д ажиллагааны төрөл тус бүрээр задлан харуулъя.



Зураг 3.1.37. ДЗШ-ны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны тоо, түүнд нөлөөлөх үзүүлэлт

Зураг 3.1.37-ын эхний зургаас харвал хяналтын шатны хэрэг шийдвэрлэх үйл ажиллагааны тооны хувьд 2, 3, 4-р үеийн ажиллагааны тоо ойролцоо байна. Үүнээс хамгийн олон ажиллагаа нь хэргийн 4-р үеийн тогтоол, 2-р үеийн захирамж, 3-р үеийн тогтоол хамгийн их ажиллагаа шаарддаг болох нь харагдаж байна. Тус бүрийг задлан дараагийн зургаас харвал хуулийн ангиллын хувьд ойролцоо байна.




Зураг 3.1.38. ДЗШ-ны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хуудасны тоо, түүнд нөлөөлөх үзүүлэлт

Зураг 3.1.38-ын эхний зургаас харвал хяналтын шатны хэрэг шийдвэрлэх үйл ажиллагааны тооны хувьд 2, 3, 4-р үеийн ажиллагааны тоо харилцан адилгүй байна. Үүнээс



хамгийн олон ажиллагаа нь шүүх хуралдааны тэмдэглэл, захирамж болон хүсэлт байна. Тус бүрийг задлан дараагийн зургаас харвал хуулийн ангиллын хувьд ойролцоо буюу 1-4.5-ийн хооронд байна.



Зураг 3.1.39. ДЗШ-ны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд зарцуулсан хугацаа, түүнд нөлөөлөх үзүүлэлт

Зураг 3.1.39-ын эхний зургаас харвал хяналтын шатны хэргийн ажиллагаанд зарцуулсан хугацаа нь 3-р үе шатанд их байна. Тус ажиллагаануудаас хамгийн олон ажиллагаа нь баримт, албан бичиг болон хариу тайлбар байна. Тус бүрийг шийдвэрлэсэн хуулиар задлан дараагийн зургаас харвал баримтын хувьд хөдөлмөрийн хуулиар шийдсэн 1 хэрэгт дунджаар 53.7 хоног, албан бичгийн хувьд хоног ойролцоо боловч хамгийн их зарцуулагдсан хуулийн ангилал бол иргэний хууль байна. Харин хариу тайлбарын хувьд харьцуулагдах боломжгүй дангаараа 7.3 хоног байна.

3.1.1.4 Ердийн журмаар шийдвэрлэсэн иргэний хавтаст хэргийн материалд хийсэн шинжилгээ бүлгийн дүгнэлт

Доорх хүснэгтээс хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үе шатуудын харьцуулалтыг анхан, давах, хяналаар харуулав. Тодруулбал:

- Анхан шатны хувьд хэргийн 2 болон 3-р үе нийт ажиллагаа, хуудасны 84.9-86.4% -ийг харин хоногийн 77.7%-ийг эзэлдэг байна.
- Давж заалдах шатны хувьд ШХ-аар хэлэлцэх, шийдвэр гаргах үе шатанд буюу 3-р үе шатанд ажиллагаанаас 52.3%-ийг, хуудаснаас 64.4%-ийг, хоногоос 36.3%-ийг эзэлж байна.
- Хяналтын шатны хувьд ШХ-аар хэлэлцэх, шийдвэр гаргах үе шатанд буюу 3-р үе шатанд ажиллагаанаас 50.5%-ийг, хуудаснаас 71.4%-ийг, хоногоос 49%-ийг эзэлж байна.

№	Хэргийн үе	Ажиллагаа			Хуудас			Хоног		
		Анхан	Давх	Хяналт	Анхан	Давх	Хяналт	Анхан	Давх	Хяналт
1	Хэрэг үүсгэх эсэхийг шийдвэрлэх үе	3.5%	-	-	5.2%	-	-	0.4%	-	-
2	Хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхэд бэлтгэх, хэлэлцэх	54.5%	24.2%	23.3%	51.8%	15.9%	12.9%	54.8%	25.4%	24.5%
3	ШХ-аар хэлэлцэх, шийдвэр гаргах үе	30.4%	52.3%	50.5%	34.6%	64.4%	71.4%	22.9%	36.3%	49%
4	Хэргийг эцэслэн шийдвэрлэсний дараах үе	11.6%	23.5%	26.2%	8.4%	19.7%	15.7%	18.3%	38.3%	26.5%

Хүснэгт 3.1.4. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үе шатуудын харьцуулалт

Өмнөх дэд бүлгүүдэд тайлбарласан шинжилгээний үр дүнгүүд дээр үндэслэн хамгийн олон ажиллагаа, хуудас, хоног зарцуулсан ажиллагааг түүвэрлэж хүснэгтээр ямар төрлийн хэргийн хэддүгээр үе дээр хэргийн ямар ажиллагааны тоо, хавтаст хэргийн хуудас, хэрэг хянан шийдвэрлэсэн хугацаа зэрэг нь өндөр утгатай байгааг дараах хүснэгтээс харна уу.

№	Хэргийн ажиллагаа	Хэргийн үе	Хэрэг	Ажиллагаа		Хуудас		Хоног	
				Анхан	Давх	Анхан	Давх	Анхан	Давх
1	Баримт	2	Иргэн	19.9	1	21.2		58.5	
			Гэр бүл	22	1	26.7		179.6	
			Хөдөлмөр	11.2	3.3	11.7	3.3	36.9	21.9
		3	Иргэн	8.4	1.5	8.5		15.7	



	Гэр бүл	7.7	1.5	7.7		35.9	52.1
	Хөдөлмөр	4.3	2.6	4.3	2.6	13.9	
4	Иргэн	6.1	1.3	6.1		35	
	ШШГТХ	4	1.5	4		20.7	25
	Хөдөлмөр	2.5	1.2	2.5		18.9	
	Гэр бүл	2	2	2	2	35.1	

Хүснэгт 3.1.5. Хэргийн ажиллагааны тодорхойлолт, баримтаар⁵

№	Хэргийн ажиллагаа	Хэргийн үе	Хэрэг	Ажиллагаа		Хуудас		Хоног	
				Анхан	Давах	Анхан	Давах	Анхан	Давах
2	Нотлох баримт	2	Иргэн	8.3	1	3.2	1	3.9	0.7
			Гэр бүл	6		49	1	3.1	
			Хөдөлмөр	6.4	1	141.2		4	
			ШШГТХ	3		54		6.2	
3	Хүсэлт		Иргэн	8.6		10.2	2		
		2	Гэр бүл	8.7		8.7			
			Хөдөлмөр	3.3		4	2		
			ШШГТХ		2		2		4
		3	Иргэн	1.7	2	1.7			
		4	Иргэн	1.4	1	1.4			
4	Шүүх хуралдааны тэмдэглэл	3	Иргэн	6.8		20.9		4.9	
			Гэр бүл	7.3		30	5	11.5	
			ШШГТХ	6.5		15.5		29.2	
			Хөдөлмөр	3.8	2.2	23.5		4.5	3.5
5	Ерөнхий шүүгчийн захирамж	2	Иргэн	6.3		4	1	34	
			ШШГТХ						17.1
		3	Иргэн	2.2		2.2	1.5	6.3	7.7
			Хөдөлмөр		1.5	1		9.5	
6	Тэмдэглэл	2	Иргэн	6.3		11		15.6	
			Гэр бүл	2		3.5		3	
			Хөдөлмөр			2.3		39.4	
		3	Гэр бүл	1.5		1.5		70.5	
		4	Гэр бүл					61	
			Иргэн	2					


Хүснэгт 3.1.6 Хэргийн ажиллагааны тодорхойлолт, нотлох баримт, хүсэлт, шүүх хуралдааны тэмдэглэл, ерөнхий шүүгчийн захирамж, тэмдэглэл

Хавтаст хэргийн ажиллагаа, хуудас, хоногийн дундаж тоон утгуудыг харьцуулан 3 үзүүлэлт дээр адил хамгийн их утга авсан ажиллагааг ямар хэрэгт өндөр байгааг нэрлэвэл гэр бүлийн хуулиар шийдвэрлэгдсэн 2-р үе шатны баримт, иргэний хуулиар шийдвэрлэгдсэн 2-р үе шатны ерөнхий шүүгчийн захирамж байна.

3.1.2 Бага үнийн дүнтэй иргэний хавтаст хэргийн материалд хийсэн шинжилгээ

Энэ бүлэгт бага үнийн дүнтэй иргэний хавтаст хэргийн анхан болон давж заалдах шатны шүүхийн ажиллагааны хүрээнд хийсэн шинжилгээний үр дүнг танилцуулна. Хяналтын шатны хувьд 6 хэргээс 3 хэрэг 5-6 ажиллагаанд шинжилгээ хийх боломжгүй байсан тул шинжилгээний үр дүнгээс хасав. Үр дүнг танилцуулахаас өмнө хавтаст хэргийн судалгаанд сонгогдсон 6 хэргийг хэрхэн сонгосон болохыг тайлбарлая. 2004.06.01-ээс 2022.04.26-ны хооронд хяналтын шатны шүүхийн шийдвэрлэсэн 71 төрлийн нийт 7706 хэргээс 10 сая хүртэлх нэхэмжлэлийн үнийн дүнтэй хэргийг бага үнийн дүнтэй хэрэг гэж үзэж, 6 хэргийг судалгааны түүврээр сонгож, дүн шинжилгээ хийлээ. Нийт 7706 хэргийн 65-аас дээш хувь нь 100-аас 500 хүртэлх хоногт шийдвэрлэгдсэн бол 30 орчим хувь нь 500-аас 1000 хүртэлх хоногт шийдвэрлэгдсэн байна. Харин 1000-аас дээш хоногт шийдвэрлэгдсэн хэрэг тун бага хувийг эзэлж байгаа нь доорх зураг 3.1.40-өөс харагдаж байна.

⁵ Жич: Ногоон өнгөөр хэргийн анхан шатны ажиллагааны задаргаа нь дахь хэргийн үе дотор хамгийн олон ажиллагаа, хуудас, хоногийг илэрхийлсэн тоог тэмдэглэв.




3.1.40. Хэрэг хянан шийдвэрлэсэн хугацаа /Эх сурвалж: Хэргийн бүртгэлийн нэгдсэн мэдээллийн сан/

3.1.2.1 Бага үнийн дүнтэй иргэний хавтаст хэргийн анхан шатанд хийгдсэн шинжилгээний танилцуулга


Судалгаанд сонгогдсон 6 хэргийг шийдвэрлэсэн гэрээний төрлөөр нь авч үзвэл худалдах худалдан авах гэрээ, хөдөлмөрийн гэрээ тус тус 1 харин түрээсийн гэрээ, зээлийн гэрээ тус тус 2 хэрэг байв.

Зураг 3.1.41-ээс харвал анхан шатны бага үнийн дүнтэй 6 хэргийг хэрэг тус бүрээр харьцуулан ажиллагааны тоо, хуудасны тоо болон хугацааны мэдээллийг харвал худалдах худалдан авах гэрээ болон зээлийн гэрээний ажиллагааны тоо тус бүр 44 байгаа нь хамгийн их ажиллагаатай болохыг харуулж байна. Харин зураг Б-ээс харахад 6 хэргийн хуудасны тоо харилцан адилгүй байна. Үүнээс хамгийн олон хуудастай хэргийг харвал хөдөлмөрийн гэрээний хуудасны тоо 134 байна. Хэргийн ажиллагаанд зарцуулж байгаа хоногийн хувьд 6 хэрэг бүгд ойролцоо буюу 85.9-127.6 байна. Зураг А, Б, В харьцуулан харахад ажиллагааны тоо, хуудасны тооноос хэрэгт зарцуулж байгаа хоногийн тоо үл хамаарч байна.


Зураг А. Ажиллагааны тоо.



Зураг Б. Хуудасны тоо



Зураг В. Зарцуулсан хоног




3.1.41. Хавтаст хэргийн ажиллагааны тоо, хуудасны тоо, ажиллагаанд зарцуулсан хоногийг хэргийг шийдвэрлэсэн гэрээний төрөл тус бүрээр харуулав /Анхан/

3.1.2.2 Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үе шатад хийх шинжилгээ


Энэ хэсэгт бага үнийн дүнгээр шийдвэрлэсэн иргэний хавтаст хэргийн анхан шатанд хийгдсэн шинжилгээний танилцуулга бүлэгт дурдсан 6 хавтаст хэргийн мэдээллийг шийдвэрлэсэн гэрээний төрөл тус бүрээр харуулахдаа ажиллагааны тоо, хуудасны тоо болон хоногийн тоог дундаж утгаар илэрхийлсэн мэдээллийг Зураг 3.1.42-д харуулав. Доорх зургийн анхаарал татсан хэргийн хувьд тайлбар өгвөл шийдвэрлэсэн 6 хэрэг дунджаар 34 ажиллагаатай, 78 хуудастай байсан бөгөөд тус хэрэгт 118 хоног зарцуулдаг байна. Харин тус 3 үзүүлэлтээс хамгийн их утгатай гэрээний төрлийг харвал худалдах худалдан авах гэрээгээр шийдвэрлэгдсэн хэргийн хувьд 44 ажиллагаа, 134 хуудсанд 127.6 хоног дунджаар зарцуулсан байна. Ажиллагааны тоо, хуудасны мэдээллийг харахад ажиллагаа их байхад хуудасны тоо их



байна. Харин ажиллагаанд зарцуулж байгаа хоногийн тоо ажиллагаа болон хуудасны тооноос үл хамаарч байна.




Зураг 3.1.42. Хавтаст хэргийн ерөнхий мэдээлэл




Зураг 3.1.43. Хэргийн ажиллагааны үе шат

Дээрх 3.1.43-ийн зургаар бага үнийн дүнтэй хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үе шатад хийсэн нэг ба 2 хүчин зүйлийн дисперсийн шинжилгээний үр дүнг дараах зургаар харуулав. Зураг 3.1.43-ын А-гаас харвал хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхэд бэлтгэх, хэлэлцэх үе шатанд дунджаар нэг хэргийн нийт ажиллагааны 44.4% буюу 14.2 ажиллагаа, шүүх хуралдаанаар хэлэлцэх, шийдвэр гаргах үе шатанд нэг хэргийн нийт ажиллагааны 27.5% буюу 8.8 ажиллагаа хийгдэж байгаа нь ажиллагааны дийлэнх хувь болох нь харагдаж байна. Зураг 3.1.43-ын Б хэсгийн хуудасны мэдээллийн хувьд мөн адил ихэнх хувийг хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхэд бэлтгэх, хэлэлцэх үе шат болон шүүх хуралдаанаар хэлэлцэх, шийдвэр гаргах үе шат нийт хуудасны 70.3%-ийг эзэлж байна. Харин хоногийн хувьд хэрэг үүсгэх эсэхийг шийдвэрлэх үе шатанд дунджаар нэг хэрэгт зарцуулах хоногийн 0.8% буюу 9.3 хоногийг, хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхэд бэлтгэх, хэлэлцэх үе шатанд 42.9% буюу 49.9 хоног, шүүх хуралдаанаар хэлэлцэх, шийдвэр гаргах үе шатад 13.9% буюу 16.2 хоног зарцуулдаг бол хэргийг эцэслэн шийдвэрлэсний дараах үе шатанд нэг хэрэгт 35.1% буюу 40.8 хоног зарцуулсан байна.




Зураг 3.1.44. Хэрэг хянан шийдвэрлэх үе шатанд хамаарах ажиллагааны тоо, гэрээний төрлөөр

Зураг 3.1.43-ын А-д харуулсан ажиллагааны ерөнхий мэдээллийг гэрээний төрөл тус бүрээр задлан Зураг 3.1.44-д дэлгэрэнгүй оруулав. Зураг 3.1.44-өөс харвал хэрэг хянан шийдвэрлэх 1-р үе шат дахь 4 төрлийн гэрээний ажиллагаа ойролцоо буюу 2-3.5-ын хооронд байна. 2-р үе шатанд хөдөлмөрийн гэрээгээр шийдвэрлэгдсэн хэргийн ажиллагаа хамгийн их буюу 23 байгаа бол үлдсэн 3 төрлийн гэрээний ажиллагаа ойролцоо буюу 20-15-ын хооронд байна бол 3-р үе шатны хувьд хамгийн бага 5 ажиллагаатай түрээсийн гэрээнээс бусад 3 гэрээнд хийгдсэн ажиллагаа ойролцоо буюу 10-12-ын хооронд байна. Харин 4-р үе шат болох хэргийг эцэслэн шийдвэрлэсний дараах ажиллагаанд ойролцоо буюу 4-8 ажиллагаа явагдсан байна.



Зураг 3.1.45. Хэрэг хянан шийдвэрлэх үе шатанд хамаарах хавтаст хэргийн материалын хуудасны тоо, гэрээний төрлөөр

Зураг 3.1.43-ын Б-д харуулсан хуудасны ерөнхий мэдээллийг гэрээний төрөл тус бүрээр задлан Зураг 3.1.45-д дэлгэрэнгүй оруулав. Зураг 3.1.45-аас харвал хэрэг хянан шийдвэрлэх 1-р үе шат дахь 4 төрлийн гэрээний ажиллагаанаас зээл, хөдөлмөрийн гэрээний ажиллагаа ойролцоо буюу 7-9-ын хооронд байна. Харин түрээс, худалдах худалдан авах гэрээний хувьд 19-20 хуудастай байна. 2-р үе шатанд хөдөлмөрийн гэрээгээр шийдвэрлэгдсэн хэргийн ажиллагааны хуудасны тоо хамгийн их буюу 98 байгаа бол үлдсэн 3 төрлийн гэрээний ажиллагааны хуудасны тоо ойролцоо буюу 17-24.5-ын хооронд байна. 3-р үе шатны хувьд хуудасны тоо ойролцоо буюу 12-21-ийн хооронд байна. Харин 4-р үе шат болох хэргийг эцэслэн шийдвэрлэсний дараах ажиллагааны хуудасны тоо мөн адил ойролцоо буюу 4-9.5 хуудастай байна.




Зураг 3.1.46. Хэрэг хянан шийдвэрлэх үе шатанд хамаарах хавтаст хэргийн ажиллагаанд зарцуулсан хоног, гэрээний төрлөөр

Зураг 3.1.43-ын В-д харуулсан ажиллагаанд зарцуулж байгаа хоногийн ерөнхий мэдээллийг гэрээний төрөл тус бүрээр задлан Зураг 3.1.46-д дэлгэрэнгүй оруулав. Зураг 3.1.46-аас харвал хэрэг хянан шийдвэрлэх 1-р үе шат дахь 4 төрлийн гэрээний ажиллагаанаас зээлийн гэрээний ажиллагаанд зарцуулж байгаа хоног бусдаас олон хоног буюу 14.5 хоног байна. Бусад 3 гэрээний хувьд ойролцоо хоногтой байв. 2-р үе шатанд хөдөлмөрийн гэрээгээр шийдвэрлэгдсэн хэргийн ажиллагаанд хамгийн олон хоног буюу 72.2 хоног зарцуулсан бол үлдсэн 3 төрлийн гэрээний ажиллагаанд зарцуулсан хоног ойролцоо буюу 38.4-54.9-ийн хооронд байна. 3-р үе шатны хувьд хамгийн олон хоног зарцуулсан гэрээний төрлөөр 30.8 хоногтой худалдах худалдан авах гэрээ байна. Харин 4-р үе шатанд ажиллагаанд зарцуулсан хоногийн тоо бүгд ойролцоо буюу 38.2-43.7 хоногтой байна.

3.1.2.3 Бага үнийн дүнтэй иргэний хэрэг хянан шийдвэрлэх анхан шатны ажиллагааны төрөлд хийсэн шинжилгээ


Өмнөх бүлгийн Зураг 3.1.44-3.1.46-д харуулсан хэрэг хянан шийдвэрлэх үе шатны анхан шатад ямар гэрээний төрлөөр шийдвэрлэгдэх хэргээс хамаарч ажиллагааны тоо, хуудасны тоо, ажиллагаанд зарцуулж байгаа хоногийн тоо харилцан адилгүй үзүүлэлттэй байгааг хэргийн ажиллагаа тус бүрээр дэлгэрэнгүй тайлбарлан харуулъя.



Зураг 3.1.47. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны тоо, хэргийн үе шатаар




Зураг 3.1.44-д харуулсан үр дүнг Зураг 3.1.47-оор ажиллагааны төрөл тус бүрээр задлан харуулав. Зураг 3.1.47-оос харвал хэрэг шийдвэрлэх үйл ажиллагааны тооны хувьд 2, 3-р үеийн баримт, 2-р үеийн нотлох баримт /оролцогч тал/-аас ирсэн баримт ажиллагаа их үүсгэж байна. Мөн 2-р үе дэх гомдол дунджаар 7 ажиллагаа үүсгэсэн байна. Эдгээр үеүдэд хамгийн их ажиллагаа орсон баримт, нотлох баримт болон давах гомдлыг ямар гэрээний төрлүүдэд ачаалал үүсгэж байгааг Зураг 3.1.48-д (программын үр дүн) харуулав.




Зураг 3.1.48. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд нөлөөлөх үзүүлэлт, гэрээний төрлөөр

Зураг 3.1.48-аас харвал баримт, нотлох баримт нь гэрээний төрлөөс үл хамаарч бүгд ойролцоо ажиллагаатай байна. Харин давахын гомдлын хувьд хөдөлмөрийн гэрээгээр шийдвэрлэгдсэн хэрэгт дунджаар 10 удаа буюу бусдаасаа хамгийн олон хийгдсэн байна.



Зураг 3.1.49. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны материалын хуудас, хэргийн үе шатаар


Зураг 3.1.45-д харуулсан үр дүнг Зураг 3.1.49-д ажиллагааны төрөл тус бүрээр задлан харуулав. Зураг 3.1.49-өөс харвал хэрэг шийдвэрлэх үйл ажиллагаанд зарцуулж байгаа хуудасны тооны хувьд 2, 3-р үеийн нотлох баримт, 1, 3-р үеийн захирамж болон 3-р үеийн шүүх хуралдааны тэмдэглэл олон хуудастай байна. Тус үеүдэд хамгийн их хуудас орсон нотлох баримт, захирамж, шүүх хуралдааны тэмдэглэл нь ямар гэрээний төрлүүдэд ачаалал үүсгэж байгааг Зураг 3.1.48-д (программын үр дүн) харуулав.




Зураг 3.1.50. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны материалын хуудасны хувьд нөлөөлөх үзүүлэлт, гэрээний төрлөөр

Зураг 3.1.50-аас харвал нотлох баримтын хувьд хөдөлмөрийн гэрээгээр шийдвэрлэгдсэн хэрэгт 42 хуудас ачаалал үүсгэсэн байна. Харин захирамжийн хуудасны хувьд ойролцоо буюу 1.2-2.7 хооронд байна. Харин шүүх хуралдааны тэмдэглэлийн хувьд зээлийн гэрээ, хөдөлмөрийн гэрээ тус тус 10 хуудастай байсан бол худалдах худалдан авах гэрээ болон түрээсийн гэрээ 3-6.5 хуудастай байна.

Зураг А. Ажиллагаа тус бүрээр



Зураг Б. Гэрээний төрөл тус бүрээр




Зураг 51. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд зарцуулсан хоног



Зураг 3.1.46-д харуулсан үр дүнг Зураг 3.1.51-д ажиллагааны төрөл тус бүрээр задлан харуулав. Зураг 3.1.51-ээс харвал хэрэг шийдвэрлэх үйл ажиллагаанд зарцуулж байгаа хоногийн хувьд 4-р үеийн баримт, 2, 4-р үеийн нотлох баримт болон 2-р үеийн захирамж тус шатны хугацааг сунгаж байна. Тус үеүдэд хамгийн олон хоног зарцуулж байгаа баримт, нотлох баримт, захирамжийг ямар гэрээний төрлүүдэд ачаалал үүсгэж байгааг (программын үр дүн) харахад баримтын хувьд түрээсийн гэрээнд 21, нотлох баримтын хувьд хөдөлмөрийн гэрээнд 13 нь хоног байгаа бол захирамжийн хувьд зээлийн гэрээнд 8.3 хоног зарцуулагдсан байна.

3.1.2.4 Бага үнийн дүнтэй иргэний хавтаст хэргийн давж заалдах шатны шүүхийн ажиллагаа дахь шинжилгээ

Энэ бүлгийн өмнөх бүлэгт бага үнийн үнэтэй иргэний хавтаст хэргийн анхан шатны шүүхийн ажиллагаанд шинжилгээ хийсэн бол одоо давж заалдах шатны шинжилгээний үр дүнг харуулна. Энэ шатанд худалдах худалдан авах гэрээгээр шийдвэрлэгдсэн хэрэг, түрээсийн гэрээний 1 хэрэг хасагдаж 6 хэргээс 4 хэрэг үлдэж, тус хүрээнд шинжилгээ хийв. Тус хасагдсан хэргүүд анхан шатанд шийдвэрлэгдэж, ажиллагаа дууссан болно.



Зураг А. Ажиллагаа

Зураг Б. Хуудас

Зураг В. Хоног

3.1.52. Хавтаст хэргийн ажиллагааны тоо, хуудасны тоо, ажиллагаанд зарцуулсан хоног, гэрээний төрлөөр

Зураг 3.1.52-оос харвал хөдөлмөрийн гэрээ, түрээсийн гэрээ болон зээлийн гэрээний шүүхийн ажиллагаа болон ажиллагааны хуудасны тоо жигд байна. Харин ажиллагаанд зарцуулж байгаа хоногийн хувьд хөдөлмөрийн гэрээгээр шийдвэрлэгдсэн хэрэгт 63.2 хоног зарцуулагдсан нь хамгийн өндөр үзүүлэлт байна. Бусад хэргийн хувьд ойролцоо буюу 45.1-50.1 хоног зарцуулсан байна.

3.1.2.4.1 Давж заалдах шатны бага үнийн дүнтэй иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үе шатад хийх шинжилгээ

Өмнөх бүлэгт давж заалдах шатны ажиллагааны мэдээллийг ерөнхий байдлаар харсан бол одоо харин хуулийн ангиллаар нэгтгэж, ажиллагааны тоо, хуудасны тоо болон хоногийн шинжилгээний үр дүнг танилцуулна. Зураг 3.1.53-аас харвал ажиллагааны хувьд бүгд ойролцоо буюу дунджаар 6.5 ажиллагаа, 9.7 хуудастай байсан бөгөөд үүнд 53.5 хоног зарцуулсан байна. Хоногийн хувьд хөдөлмөрийн гэрээгээр шийдвэрлэгдсэн хэрэгт дунджаар 63.2 хоног зарцуулсан нь бусдаасаа хамгийн олон хоног зарцуулсан гэсэн үр дүнг харуулж байна.




Зураг 3.1.53. Давж заалдах шатны хавтаст хэргийн материалын танилцуулга

Давж заалдах шатны бага үнийн дүнтэй иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үе шатад дисперсийн шинжилгээний үр дүнг дараах зургаар харуулав. Зураг 3.1.54-ийн А-гаас харвал хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхэд бэлтгэх, хэлэлцэх үе шатанд дунджаар нэг хэргийн нийт ажиллагааны хамгийн бага буюу 0.1% буюу 1 ажиллагаа, шүүх хуралдаанаар хэлэлцэх, шийдвэр гаргах үе шатанд нэг хэргийн нийт ажиллагааны дийлэнх буюу 61.4% буюу




3-4 ажиллагаа, хэргийг эцэслэн шийдвэрлэсний дараах үе шатанд нэг хэргийн нийт ажиллагааны 28.6% буюу 2 ажиллагаа хийгдсэн байна.



Зураг 3.1.54. ДЗШ-ны хэргийн ажиллагааны үе шатыг ажиллагаа, хуудас, хугацаагаар

Зураг 3.1.54-ийн Б-гийн хувьд хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхэд бэлтгэх, хэлэлцэх үе шатанд дунджаар нэг хэргийн нийт материалын 0.9% буюу 1 хуудас, хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэх, шийдвэр гаргах үе шатанд нэг хэргийн нийт материалын 72.2% буюу 7-8 хуудас, хэргийг эцэслэн шийдвэрлэсний дараах үе шатанд нэг хэргийн нийт материалын 18.5% буюу 2 хуудас материалаас бүрдсэн байна. Зураг 3.1.54-ийн В-гийн хувьд хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхэд бэлтгэх, хэлэлцэх үе шатанд дунджаар нэг хэрэгт зарцуулсан нийт хугацааны 32.2% буюу 22 хоног, хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэх, шийдвэр гаргах үе шатанд 37.4% буюу 25-26 хоног, хэргийг эцэслэн шийдвэрлэсний дараах үе шатанд 30.4% буюу 20.8 хоног тус тус зарцуулсан байна. Зураг 3.1.54-д харуулсан ажиллагааны үе шатны ерөнхий мэдээллийг хуулийн ангилал тус бүрээр Зураг 3.1.22-д дэлгэрэнгүй оруулав. Зураг 3.1.22-оос харвал давж заалдах шатны хэрэг хянан шийдвэрлэх 3-р үе шатанд хамгийн олон ажиллагаа явуулсан байна. Ажиллагаа тус бүрээс хамгийн өндөр үзүүлэлтийг харвал 2-р үе шатанд ШШГТХ-аар шийдвэрлэсэн хэрэгт дунджаар 7, 3-р үе шатанд хөдөлмөрийн хуулиар шийдвэрлэсэн хэрэгт 9.4 бол 4-р үе шатанд гэр бүлийн хуулиар шийдвэрлэсэн хэргүүд байна. Тэгвэл хамгийн бага ажиллагаа хийгдсэн хуулийн ангиллыг үе тус бүрээр харвал 1-р үе шатанд иргэний хууль 1.6, 2-р үе шатанд ШШГТХ-аар шийдсэн хэрэг 4.5 байгаа бол 4-р үе шатанд хөдөлмөр, иргэн, ШШГТ-аар шийдвэрлэсэн хэргүүд ойролцоо буюу 2.4-2.8-ийн хооронд ажиллагаа явагддаг хэргүүд байна.



3.1.55. ДЗШ-ны хэрэг хянан шийдвэрлэх үе шатанд хамаарах ажиллагаанд нөлөөлөх хүчин зүйлс, гэрээний төрлөөр

Зураг 3.1.54-г харуулсан хэрэг хянан шийдвэрлэх үе шатанд хамаарах ажиллагааг харуулсан бол Зураг 3.1.55-аар үе шат тус бүрд хийгдсэн ажиллагааг тухайн хэргийг шийдвэрлэсэн гэрээний төрлөөр харуулав. 3.1.55-ын А зурагт ажиллагааны тоо 3 шатанд ойролцоо харагдаж байна. Мөн Б зураг дахь хуудасны тоо бүгд ойролцоо байна. Харин хэрэг хянан шийдвэрлэхэд зарцуулж байгаа хоногийн хувьд 2-р үе шатанд бүгд ойролцоо бол 3-р үе шатанд түрээсийн гэрээ 35.1 хоног зарцуулж байгаа нь бусад 2 гэрээний төрлөөс олон хоног зарцуулж байна. 4-р үе шатанд хамгийн олон буюу 39 хоног зарцуулсан гэрээгээр хөдөлмөрийн гэрээ харагдаж байна.


3.1.2.4.2 Бага үнийн дүнтэй иргэний хэрэг хянан шийдвэрлэх давж заалдах шатны ажиллагааны төрөлд хийсэн шинжилгээ

Өмнөх бүлгийн Зураг 3.1.55-д харуулсан хэрэг хянан шийдвэрлэх үе шатны давж заалдах шатад ямар төрлийн ажиллагаанаас хамаарч харилцан адилгүй үзүүлэлттэй байгааг




хэргийн ажиллагаа тус бүрээр харахдаа ажиллагааны тоо, хуудасны тоо болон хоногоор дэлгэрэнгүй тайлбарлан харуулъя.


А.Ажиллагааны тоо



Б.Хуудасны тоо



В.Хоногийн тоо



Зураг 3.1.56. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны тоо, хэргийн үе шатаар

Зураг 3.1.56-аар үе шатанд хийгдсэн ажиллагааг задлан харахад ажиллагааны хувьд цөөн ажиллагааны хүрээнд шинжилгээ хийгдсэн тул бүгд ойролцоо буюу ажиллагаа тус бүр нэг удаа хийгдсэн байна. Харин хуудасны тооны хувьд 3-р үе шат дахь магадлал дунджаар 4-5 удаа хийгджээ. В буюу хоногийн тооны хувьд 2-р үе шат дахь баримтын ажиллагаанд 22 хоног зарцуулсан болохыг (программын үр дүн) харуулав.

3.1.2.4.3 Бага үнийн дүнтэй иргэний хэрэг хянан шийдвэрлэх анхан шатны ажиллагааны төрөлд хийсэн онол

3.1.2.3 дэд бүлэгт шинжилгээ хийсэн программын үр дүн дээр тулгуурлан дараах коэффициентуудыг тооцов. Үүнд:

№	Үзүүлэлт	Детерминацийн коэффициент	Корреляцийн коэффициент	Вариацийн коэффициент	Дундаж
1	Иргэний хэрэг /гэрээний төрөл/	0.21	0.46	79.8	31.8
2	Хэргийн үе	0.05	0.22	164	
3	Ажиллагаа	0.06	0.25	149	

Хүснэгт 3.1.7 Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны материалын ажиллагааны тоонд нөлөөлөх хүчин зүйлүүд

Хүснэгт 3.1.7-ийн эхний мөрийн утгыг тайлбарлая. Бага үнийн дүнтэй хавтаст хэргийн ажиллагааны нэгж тооны өөрчлөлтийн 0.21 нь хэргийн гэрээний төрлөөс хамаарч байна. Бага үнийн дүнтэй хавтаст хэргийн ажиллагааны тоо нь хэргийн гэрээний төрлөөс 0.46 буюу дундаж хамааралтай байна. Вариацийн коэффициент 79.8% байгаа нь тоон үзүүлэлтүүд нэгэн төрлийн бөгөөд дунджийн төлөөлөх чадвар өндөр байна. Бага үнийн дүнтэй иргэний хэргийн гэрээний төрлийн хувьд ажиллагааны тооны дундаж утгыг судалгаанд цааш нь ашиглах боломжтой.

№	Үзүүлэлт	Детерминацийн коэффициент	Корреляцийн коэффициент	Вариацийн коэффициент	Дундаж
1	Иргэний хэрэг /гэрээний төрөл/	0.36	0.60	154	69.7
2	Хэргийн үе	0.27	0.52	176	
3	Ажиллагаа	0.09	0.30	303	

Хүснэгт 3.1.8. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны материалын хуудасны тоонд нөлөөлөх хүчин зүйлүүд

№	Үзүүлэлт	Детерминацийн коэффициент	Корреляцийн коэффициент	Вариацийн коэффициент	Дундаж
1	Иргэний хэрэг /гэрээний төрөл/	1.2	1.1	88	116.2
2	Хэргийн үе	0.1	0.3	299	
3	Ажиллагаа	0.3	0.5	185	

Хүснэгт 3.1.9. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд зарцуулах хугацаанд нөлөөлөх хүчин зүйлүүд

№	Хэргийн үе	Ажиллагаа		Хуудас		Хоног	
		Анхан	Давах	Анхан	Давах	Анхан	Давах
1	Хэрэг үүсгэх эсхийг шийдвэрлэх үе	0.9%	-	19.7%	-	0.8%	-




2	Хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхэд бэлтгэх, хэлэлцэх үе	44.4%	0.1%	48.3%	0.9%	42.9%	32.2%
3	ШХ-аар хэлэлцэх, шийдвэр гаргах үе	27.5%	61.4%	22%	72.2%	13.9%	37.4%
4	Хэргийг эцэслэн шийдвэрлэсний дараах үе	19.4%	28.6%	10%	18.5%	35.1%	30.4%

Хүснэгт 3.1.10. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үе шатуудын харьцуулалт


3.1.3 Хялбаршуулсан журмаар шийдвэрлэсэн иргэний хавтаст хэргийн анхан шатны шүүхийн ажиллагааны хавтаст хэргийн материалд хийсэн шинжилгээ

Нэг хуулийн ангилалд багтах хэргийг ажиллагааны тоогоор дараах зурагт харуулав. Зураг 3.1.57-аас харвал нийт 16 хэрийн 12 нь иргэний хууль дахь хавтаст хэрэг, хөдөлмөрийн хуулиар шийдвэрлэгдсэн 2 хэрэг үлдсэн 2 хэрэг нь гэр бүлийн хуулиар шийдвэрлэгдсэн хэргийн материалд шинжилгээ хийв. Иргэний хуулиар шийдвэрлэгдсэн хэргийн 1-р хэрэг 69 ажиллагаатай байсан нь бусад хуулиар шийдвэрлэгдсэн хэргүүдээс хамгийн олон ажиллагаатай байсан бол үлдсэн 11 хэргийн хувьд ойролцоо буюу 15-25 ажиллагаатай байна. Хөдөлмөрийн хуулиар шийдвэрлэгдсэн 2 хэргийн хувьд 1-р хэрэг 39 ажиллагаатай байсан нь 2 дахь хэргээс ажиллагааны тоо 17-оор илүү их байна. Гэр бүлийн хуулиар шийдвэрлэгдсэн хэргийн хувьд мөн адил 1-р хэргийн ажиллагаа 10-аар илүү олон байна. Зураг 3.1.57-ийн 2-р зургаас хуудасны мэдээллийг харвал ажиллагааны мэдээлэлтэй ижил үр дүнг үзүүлсэн байна.



3.1.57. Хавтаст хэргийн ажиллагааны тоо болон хуудасны тоо

Зураг 3.1.58-аас хамгийн олон хоног зарцуулсан хэргийг харвал иргэний хуулийн 7-р хэрэг 257.9 хоног, 1-р хэрэг 218.2 хоног зарцуулжээ. Харин хөдөлмөрийн хууль, гэр бүлийн хуулиар шийдвэрлэгдсэн 4 хэргийн хувьд бүгд ойролцоо буюу 46.8-94.4 хоногийг ажиллагаандаа зарцуулсан байна.




Зураг 3.1.58. Хавтаст хэргийн ажиллагаанд зарцуулсан хугацаа, хоногоор/Анхан/

3.1.3.1 Хялбаршуулсан журмаар шийдвэрлэсэн анхан шатны иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үе шатад хийсэн шинжилгээ

Өмнөх бүлэгт хэргийн ерөнхий байдлыг танилцуулсан бол одоо харин хуулийн ангиллаар ажиллагааны тоо, хуудасны тоо болон хоногийн шинжилгээний үр дүнг танилцуулна. Зураг 3.1.59-өөс хамгийн өндөр үзүүлэлтүүдийг харвал хөдөлмөрийн хуулиар шийдвэрлэсэн хэргийн ажиллагаа дунджаар 28.5, хуудас 30.5 байсан бол үүнд зарцуулж байгаа хоног 90.7 хоног зарцуулсан байна.



ИРГЭНИЙ ХЭРГИЙН СУДАЛГАА




Зураг 3.1.59. Давж заалдах шатны хавтаст хэргийн материалын танилцуулга

Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үе шатад хийсэн нэг ба 2 хүчин зүйлийн дисперсийн шинжилгээний үр дүнг дараах зургаар харуулав. Зураг 3.1.60-ын А-гаас харвал хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхэд бэлтгэх, хэлэлцэх үе шатанд дунджаар нэг хэргийн нийт ажиллагааны 43.5% буюу 10 ажиллагаа, шүүх хуралдаанаар хэлэлцэх, шийдвэр гаргах үе шатанд нэг хэргийн нийт ажиллагааны 29.6% буюу 6.8 ажиллагаа хийгдсэн байгаа нь ихэнх хувийг эзэлж байна. Зураг 3.1.60-ын Б хэсгийн хуудасны хувьд ихэнх хувийг мөн адил хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхэд бэлтгэх, хэлэлцэх үе шат болон шүүх хуралдаанаар хэлэлцэх, шийдвэр гаргах үе шат эзэлж байна. Харин хоногийн хувьд хэрэг үүсгэх эсэхийг шийдвэрлэх үе шатанд дунджаар нэг хэрэгт зарцуулах хоногийн 0.5% буюу 3.7 хоногийг, хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхэд бэлтгэх, хэлэлцэх үе шатанд 50.3% буюу 34.2 хоног, шүүх хуралдаанаар хэлэлцэх, шийдвэр гаргах үе шатад 26.5% буюу 18 хоног зарцуулдаг бол хэргийг эцэслэн шийдвэрлэсний дараах үе шатанд нэг хэрэгт 17.6% буюу хоног зарцуулсан байна.

А.Ажиллагааны тоо/хувь

Б.Хуудасны тоо/хувь

В.Хоногийн тоо/хувь




Зураг 3.1.60. Хэргийн ажиллагааны үе шат

Зураг 3.1.60-ын А-д харуулсан ерөнхий мэдээллийг хуулийн ангилал тус бүрээр Зураг 3.1.61-д дэлгэрэнгүй оруулав. Зураг 3.1.61-ээс харвал хэрэг хянан шийдвэрлэх 2-р үе шатны хөдөлмөрийн хуулиар шийдвэрлэгдсэн хэрэгт 14.5 ажиллагаа хийгдсэн бөгөөд тус ажиллагаа 13.5 хуудастай байсан байна.



Зураг 3.1.61. Хэрэг хянан шийдвэрлэх үе шатанд хамаарах ажиллагааны тоо, хуудасны тоог хуулийн ангиллаар




Зураг 3.1.62. Хэрэг хянан шийдвэрлэх үе шатанд хамаарах хавтаст хэрэгт зарцуулсан хугацаа, тоогоор



Зураг 3.1.62-оос харвал хэрэг хянан шийдвэрлэх анхан шатны 2-р, 3-р үе шатанд хамгийн их ажиллагаа хийгдсэн байна. Үүнээс хамгийн олон хоног зарцуулсан хуулийн ангиллыг харвал 4-р үе шатны иргэний хуулийн хэрэгт 57.9 хоног зарцуулсан байна.


3.1.3.2 Хялбаршуулсан журмаар шийдвэрлэсэн иргэний хэрэг хянан шийдвэрлэх анхан шатны ажиллагааны төрөлд хийсэн шинжилгээ

Өмнөх бүлгийн Зураг 3.1.61 болон 3.1.62-д харуулсан хэрэг хянан шийдвэрлэх үе шатны анхан шатад ямар төрлийн ажиллагаанаас хамаарч харилцан адилгүй үзүүлэлттэй байгааг хэргийн ажиллагаа тус бүрийн ажиллагааны тоо, хуудасны тоо болон хоногоор дэлгэрэнгүй тайлбарлан харуулъя.




Зураг 3.1.63. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны тоо, хэргийн үе шатаар

Зураг 3.1.63-с харвал хэрэг шийдвэрлэх үйл ажиллагааны тооны хувьд 2, 3-р үеийн баримт, 3-р үеийн шүүх хуралдааны тэмдэглэл, 3-р үеийн захирамж хамгийн их ажиллагаа үүсгэж байна. Эдгээр үеүдэд хамгийн их ажиллагаа үүсгэсэн тус 3 ажиллагааг хуулийн ангиллаар аль хууль дээр илүү ачаалал үүсгэж байгааг Зураг 3.1.64-д (программын үр дүн) харуулав.




Зураг 3.1.64. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд нөлөөлөх үзүүлэлт, хуулийн ангиллаар

Зураг 3.1.64-өөс харвал баримт, шүүх хуралдааны тэмдэглэлийн хувьд ойролцоо ажиллагаатай буюу 1.3-3.5-ийн хооронд байна. Харин захирамжийн хувьд иргэний хуулиар шийдвэрлэгдсэн хэрэгт 4.5 тус ажиллагаа байна.




Зураг 3.1.65. ДЗШ-ны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хуудасны тоо, түүнд нөлөөлөх үзүүлэлт




Зураг 3.1.66 Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны материалын хуудасны хувьд нөлөөлөх үзүүлэлт, хуулийн ангиллаар

Энэхүү нөлөөлөх үзүүлэлтүүдээс хамгийн олон хуудастай хуулийн ангиллыг нэрлэвэл Зураг 3.1.66-д иргэний хуулиар хянан шийдвэрлэсэн хэргийн баримт дунджаар 4.5 хуудастай, шүүх хуралдааны тэмдэглэлийн хувьд тус хууль дээр 4.6 хуудастай байсан нь хамгийн өндөр утга байна.



Зураг 3.1.67. Давж заалдах шатны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд зарцуулсан хугацаа, түүнд нөлөөлөх үзүүлэлт

Зураг 3.1.67-ын эхний зургаас харвал анхан шатны хэрэг шийдвэрлэх үйл ажиллагаанд зарцуулсан хугацааны хувьд 2-р, 3-р, 4-р үеийн баримт дунджаар хамгийн олон буюу 7.7-19.4 хоног, 2-р үеийн захирамжид 6.2 хоног, 2-р үе шатны албан бичигт 7.4 хоног зарцуулсан байна.



Зураг 3.1.68. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд зарцуулсан хугацааны хувьд нөлөөлөх үзүүлэлт, хуулийн ангиллаар

Зураг 3.1.68-д хамгийн олон хоног зарцуулсан ажиллагааг хуулийн ангилал тус бүрээр харуулав. Тодруулбал баримтын хувьд гэр бүлийн хуулиар шийдвэрлэгдсэн хэрэгт 17 хоног зарцуулсан. Захирамжийн хувьд бүгд ойролцоо буюу 5.1-6.8 хоног зарцуулсан бол албан бичгийн хувьд тус 2 хуулийн аль алинд нь 1-2 хоног зарцуулсан байна.

Хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэх ажиллагааны үе шатуудад хийсэн 2 ба 3 хүчин зүйлийн дисперсийн шинжилгээг программын үр дүн дээр тулгуурлан дараах коэффициентуудыг тооцов.

№	Үзүүлэлт	Детерминацийн коэффициент	Корреляцийн коэффициент	Вариацийн коэффициент	Дундаж
1	Иргэний хэрэг /хуулийн төрөл/	0.88	0.94	64.9	20.2
2	Хэргийн үе	0.11	0.33	184.6	
3	Ажиллагаа	0.14	0.37	163	

Хүснэгт 3.1.11. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны материалын ажиллагааны тоонд нөлөөлөх хүчин зүйлүүд

Хүснэгт 3.1.11-ийн эхний мөрийн утгыг тайлбарлая. Хялбаршуулсан журмаар шийдвэрлэсэн иргэний хавтаст хэргийн ажиллагааны тооны өөрчлөлтийн 0.88 нь хэргийн төрөл буюу хэргийг шийдвэрлэж байгаа хуулийн төрлөөс хамаарч байна. Иргэний хавтаст хэргийн ажиллагааны тоо хэргийн төрлөөс 0.94 буюу хүчтэй хамааралтай байна. Вариацийн коэффициент 64.9% байгаа нь тоон үзүүлэлтүүд нэгэн төрлийн бөгөөд дунджийн төлөөлөх чадвар өндөр байна. Хялбаршуулсан журмаар шийдвэрлэсэн иргэний хэргийн төрлийн хувьд ажиллагааны дундаж тоон утгыг судалгаанд цааш нь ашиглах боломжтой.

№	Үзүүлэлт	Детерминацийн коэффициент	Корреляцийн коэффициент	Вариацийн коэффициент	Дундаж
1	Иргэний хэрэг /хуулийн төрөл/	1.65	1.28	53	
2	Хэргийн үе	0.15	0.39	173.9	21.8
3	Ажиллагаа	0.23	0.48	142	

Хүснэгт 3.1.12. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны материалын хуудасны тоонд нөлөөлөх хүчин зүйлүүд

№	Үзүүлэлт	Детерминацийн коэффициент	Корреляцийн коэффициент	Вариацийн коэффициент	Дундаж
1	Иргэний хэрэг /хуулийн төрөл/	1.89	1.4	142.2	
2	Хэргийн үе	0.10	0.3	607	96.1
3	Ажиллагаа	0.75	0.9	226.9	

Хүснэгт 3.1.13. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд зарцуулах хугацаанд нөлөөлөх хүчин зүйлүүд

№	Хэргийн үе	Ажиллагаа	Хуудас	Хоног
---	------------	-----------	--------	-------



			Анхан	
1	Хэрэг үүсгэх эсэхийг шийдвэрлэх үе шат	12%	19.7%	0.5%
2	Хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхэд бэлтгэх, хэлэлцэх үе шат	43.5%	48.3%	50.3%
3	ШХ-аар хэлэлцэх, шийдвэр гаргах үе шат	29.6%	22%	26.5%
4	Хэргийг эцэслэн шийдвэрлэсний дараах үе	14.9%	10%	17.6%

Хүснэгт 3.1.14. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үе шатуудын харьцуулалт

3.1.4 Иргэний хавтаст хэргийн материалд хийсэн шинжилгээний дүгнэлт

Иргэний хэргийн шүүгчийн хянан шийдвэрлэсэн хэргийн ажиллагааны ачааллыг бодитой зөв тодорхойлохын тулд ШЕЗ-ийн судалгаа шинжилгээний баг ердийн журмаар шийдвэрлэсэн 31 хэрэг, бага үнийн дүнтэй 6 хэрэг, хялбаршуулсан журмаар шийдсэн 16 хэрэг буюу нийтдээ 53 хавтаст хэргийн 77 хавтаст материалтай уншиж танилцан, тоон мэдээлэл цуглуулж шинжилгээ хийсэн үр дүнгийн дүгнэлтийг танилцуулъя. Ердийн журмаар шийдвэрлэсэн 31 иргэний хэргийг ерөнхийд нь дүгнэвэл. Үүнд:

- Нийт 31 хэргийн 55 хавтаст хэрэгт хийгдсэн 2,893 ажиллагааг шүүн таслах ажиллагааны 4 үе шатаар ангилан авч үзвэл хэрэг үүсгэснээс хойш хэргийг шүүх хуралдаанд бэлтгэх болон хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцүүлж, шүүхийн шийдвэр гаргах гэсэн 2, 3-р үе шатны ажиллагаа нь нийт ажиллагааны ойролцоогоор 80-84 хувийг эзэлж байв. Тус 2 үе шатанд шүүгч болон шүүхийн захиргааны ажилчид хамгийн их ачаалалтай ажилладаг болохыг харуулж байна.
- Харин хавтаст хэргийн материалын хувьд 31 хэргийн нийт 9,967 хуудас хэргийн материалын 3,659 хуудас буюу 36.7 хувь нь шүүхээс боловсруулсан баримт /эрхийн акт болон бүх төрлийн баримт хамаарна/, 5225 хуудас буюу 52.4 хувь хэргийн оролцогчдоос гаргасан баримт /үүний 4454 хуудас буюу 44.7 хувь нь нотлох баримт/, үлдсэн 1083 хуудас буюу 10.9 хувь нь бусад баримт /иргэдийн төлөөлөгчийн дүгнэлт гэх мэт эдгээр ангиллын альд нь ч хамаарахгүй баримт/ эзэлж байв.

Ердийн журмаар шийдвэрлэгдсэн иргэний хэрэг: Ердийн журмаар шийдвэрлэгдсэн иргэний хэрэг хянан шийдвэрлэх **анхан шатны** ажиллагааны төрөлд хийсэн онолын дүгнэлтийг ажиллагаа, хуудасны тоо, хоногийн хувьд харуулав. Үүнд:

Ажиллагаа-Ердийн журмаар шийдвэрлэгдсэн нэг хэрэгт дунджаар 76.8 ажиллагаа хийгддэг байна. Тус журмаар шийдвэрлэсэн иргэний хэргийн анхан шатны ажиллагааны тооны нэгж өөрчлөлт 0.4 гарсан. Тодруулбал сонгогдсон хавтаст хэргийн ажиллагааны тооны нэгж өөрчлөлтийн 40% нь иргэний хэргийн хуулийн ангиллаас хамаардаг болохыг илэрхийлж байна. Харин хэргийн үе болон ажиллагааны төрөл нь шүүгчийн ажлын ачаалалд маш бага нөлөө үзүүлдэг байна.

Мөн иргэний хавтаст хэргийн ажиллагааны тооны нэгж өөрчлөлт нь иргэний хэргийн төрлөөс 0.63 буюу хүчтэй хамааралтай байна. Өөрөөр хэлбэл ямар төрлийн хэрэг байхаас үл хамаарч ажиллагааны тоо их байх тусам ачаалал нэмэгдэж байна.

Хуудасны тоо-Ердийн журмаар шийдвэрлэгдсэн иргэний хавтаст хэргийн ажиллагааны ачааллын нэгж тооны өөрчлөлтөд иргэний хавтаст хэргийн анхан шатны ажиллагааны материалын хуудасны тоо 12%-ийг эзэлж байна. Хэргийн үе, ажиллагаа тус бүрийн хувьд шүүгчийн ажлын ачаалалд нөлөөлөл бага үзүүлдэг. Вариацийн коэффициент үр дүнгээр нэг хэрэг дунджаар 144.8 хуудастай байна.

Хоногийн тоо-Ердийн журмаар шийдвэрлэгдсэн иргэний хэргийн ажиллагааны ачааллын хугацааны нэг хэргийн хувьд нэгж тоон өөрчлөлтийн 39% нь иргэний хэргийн ажиллагааны хугацааны өөрчлөлтөөс хамаарч байна.

Иргэний хавтаст хэргийн хугацаа хэрэг шийдвэрлэсэн хуулийн ангиллын хувьд 0.63 буюу хүчтэй хамааралтай байна. Өөрөөр хэлбэл ямар хуулиар шийдвэрлэгдсэн бэ гэдгээс хамаарч хоног ихсэх тусам ажиллагаа нэмэгддэг байна.

Анхан шатны хувьд хэргийн 2 болон 3-р үе нийт ажиллагаа, хуудасны 84.9-86.4% -ийг харин хоногийн 77.7%-ийг эзэлдэг байна.



Давж заалдах шатны хувьд ШХ-аар хэлэлцэх, шийдвэр гаргах үе шатанд буюу 3-р үе шатанд ажиллагаанаас 52.3%-ийг, хуудаснаас 64.4%-ийг, хоногоос 36.3%-ийг эзэлж байна.

Хяналтын шатны хувьд ШХ-аар хэлэлцэх, шийдвэр гаргах үе шатанд буюу 3-р үе шатанд ажиллагаанаас 50.5%-ийг, хуудаснаас 71.4%-ийг, хоногоос 49%-ийг эзэлж байна.

Бага үнийн дүнтэй иргэний хэрэг:

Бага үнийн дүнтэй хавтаст хэргийн ажиллагааны нэгж тооны өөрчлөлтийн 0.21 нь хэргийн гэрээний төрлөөс хамаарч байна. Бага үнийн дүнтэй хавтаст хэргийн ажиллагааны тоо нь хэргийн гэрээний төрлөөс 0.46 буюу дундаж хамааралтай байна. Вариацийн коэффициент 79.8% байгаа нь тоон үзүүлэлтүүд нэгэн төрлийн бөгөөд дунджийн төлөөлөх чадвар өндөр байна. Бага үнийн дүнтэй иргэний хэргийн гэрээний төрлийн хувьд ажиллагааны тоон дундаж утга 31.8 гарсан. Өөрөөр хэлбэл нэгэн төрлийн гэрээгээр шийдвэрлэгдсэн нэг хэрэгт дунджаар 31.8 ажиллагаа хийгдэж, нийт хуудас дунджаар 69.7 хуудастай байдаг ба хугацааны хувьд гэрээний төрлөөс хамаарч хугацааны дундаж өөр өөр байна.

Хэргийн үе шатны хувьд 2-р үе шатанд хамгийн их ажиллагаа хийгдэж, хуудас болон хоног зарцуулдаг байна.

Хялбаршуулсан журмаар шийдвэрлэсэн иргэний хэрэг: Хялбаршуулсан журмаар шийдвэрлэсэн иргэний хавтаст хэргийн ажиллагааны тооны өөрчлөлтийн 0.88 нь хэргийн төрөл буюу хэргийг шийдвэрлэж байгаа хуулийн төрлөөс хамаарч байна. Иргэний хавтаст хэргийн ажиллагааны тоо хэргийн төрлөөс 0.94 буюу хүчтэй хамааралтай байна. Вариацийн коэффициент 64.9% байгаа нь тоон үзүүлэлтүүд нэгэн төрлийн бөгөөд дунджийн төлөөлөх чадвар өндөр байна. Хялбаршуулсан журмаар шийдвэрлэсэн иргэний хэргийн төрлийн хувьд ажиллагааны дундаж тоон утгыг судалгаанд цааш нь ашиглах боломжтой.

Санал: Дээрх дүгнэлтэд үндэслэж дараах саналыг гаргаж болохоор байна. Үүнд:

1. Бага үнийн дүнтэй иргэний хэргийг хянан шийдвэрлэх тусгайлсан шуурхай процедуртай болох,
2. Шүүх хуралдааны бэлтгэлийг сайтар хангахад шүүх болон хэргийн оролцогчдын анхаарал, идэвхийг сайжруулах. Үүний тулд процессын хуульд өөрчлөлт оруулах. Тухайлбал иргэний хэргийн шүүхэд урьдчилсан хэлэлцүүлгийг нэвтрүүлэх. Шүүх хуралдааныг товлон зарлахдаа хэргийн оролцогчдын саналыг авч товлон, нотлох баримтыг заасан хугацаанд ирүүлээгүй байгууллагад хуульд заасан хариуцлагыг хүлээлгэж, хуралдааныг хойшлуулах болон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоотойгоор хэргийн оролцогчдын зүгээс гаргах хүсэлтийг эдийн засгийн хөшүүрэг бүхий санкцитай зохицуулалтаар хязгаарлаж, тэдний процессын хариуцлагыг нэмэгдүүлэх зохицуулалтыг тусгах,
3. Нотлох баримт цуглуулах болон хэргийн оролцогчдоос шалтгаалж шүүх хуралдаан хойшлогдох тохиолдол их гарч байгаа тохиолдол их байсан тул шүүх хуралдааныг товлон зарлахдаа хэргийн оролцогчдын саналыг авах, нотлох баримтыг шүүхээс заасан хугацаанд ирүүлээгүй байгууллагад хуульд заасан хариуцлага хүлээлгэж, хариуцлага хүлээлгэдэг болгох,
4. Нийслэлийн иргэний хэргийн анхан шатны шүүх дэх шүүгчийн туслахын орон тоог нэмэгдүүлэх. Одоо ажиллаж байгаа шүүх хуралдааны нарийн бичгийн даргын ажлыг технологиор орлуулж, тэднийг шүүгчийн туслах болгох арга хэмжээг авах ажлыг судалж, хэрэгжүүлэх,
5. Хавтаст хэргийг уншиж байх явцад огноо байхгүй баримтууд нэлээн их байснаас гадна шүүхийн хийж буй ажиллагааны дараалал цаг хугацааны хувьд урд, хойноо орсон /жишээ нь хэрэг үүсгэх захирамж гараагүй байхад хариуцагчийг шүүхэд дуудан ирүүлэх, хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцүүлэх, шүүх хуралдааныг товлон зарлах шүүгчийн захирамж гарахаас өмнө хэргийн оролцогчид шүүх хуралдааны товыг мэдэгдэх зэрэг ажиллагаанууд хийгдсэн байсан./, нотлох баримтыг аль тал гарган өгсөн



нь тодорхойгүй буюу тэмдэглэгээ хийгээгүй байгаа нь хавтаст хэргийн судалгааг хийхэд хүндрэлтэй байлаа. Иймд шүүхээс хийгдэж буй ажиллагааг зөв дарааллаар хийж, хавтаст хэргийг хөтөлж, эмхэтгэх, шүүхээс үйлдэж буй бүх баримтад огноо тавих, нотлох баримт гарган өгсөн хэргийн оролцогч, огноог нотлох баримтын ард тэмдэглэх.

3.2 Иргэний хэргийн шүүхийн шүүгч нараас авсан асуумжид хийх шинжилгээ

Иргэний хэргийн шүүгчийн хянан шийдвэрлэсэн хэргийн ажиллагааны ачааллыг бодитой тодорхойлохын тулд ШЕЗ-ийн судалгаа шинжилгээний баг 6 төрлийн хуулиар багцлан дагуу шүүгч нараас асуумж авч тоон мэдээлэл цуглуулан шинжилгээ хийсэн үр дүнг энэ бүлэг танилцуулна. Судалгаанд дараах хуулиудад хамаарах асуумжийг авсан. Үүнд:

- ✓ *Иргэний хуулиар*
- ✓ *Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулиар*
- ✓ *Гэр бүлийн тухай хуулиар*
- ✓ *Хөдөлмөрийн тухай хуулиар*
- ✓ *Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулиар*
- ✓ *Бусад*

3.2.1 Бага үнийн дүнтэй хэргийг хянан шийдвэрлэсэн иргэний хэргийн асуумжийн өгөгдөлд хийх шинжилгээ

3.2.1.1 Бага үнийн дүнтэй хэргийг хянан шийдвэрлэсэн иргэний хэргийн асуумжийн тухай

Иргэний хэргийн ажиллагааны ачааллын асуумжид шинжилгээ хийхэд ашигласан өгөгдлийн танилцуулгыг дараах хүснэгтээр харуулъя.

№	Шүүх	Иргэний хуулиар	ИХШХШТХ	Гэр бүл	Хөдөлмөр	ШШГТХ	Бусад	Дүн
1	Баянзүрх	1	1	1	1	1	1	6
2	Сүхбаатар	1	1	1	1	1	1	6
3	Чингэлтэй	1	1	1	1	1	1	6
4	Сонгинохайрхан	2	2	3	2	3	2	14
5	Багахангай	1	1	1	1	1	1	6
6	Налайх	2	2	2	2	2	2	12
7	Баян-Өлгий	1	1	1	1	1	1	6
8	Баянхонгор	3	3	3	3	3	3	18
9	Говь-Алтай	3	3	3	3	3	3	18
10	Дархан-Уул	2	2	2	2	2	2	12
11	Дорноговь	1	1	1	1	1	1	6
12	Дорнод	3	3	3	3	3	3	18
13	Дундговь	2	2	2	2	2	2	12
14	Өвөрхангай	2	2	2	2	2	2	12
15	Сүхбаатар	1	1	1	1	1	1	6
16	Сэлэнгэ	1	1	1	1	1	1	6
17	Ховд	2	2	2	2	2	2	12
18	Хөвсгөл	1	1	1	1	1	1	6
19	Хэнтий	3	3	3	3	3	3	18
20	Замын үүд	3	2	2	2	2	2	13
21	Тосонцэнгэл	3	3	3	3	3	3	18
22	Сайхан	4	4	4	4	4	4	24
23	Дүн	43	42	43	42	43	42	255

Хүснэгт 3.2. 1 Бага үнийн дүнтэй иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд зарцуулах хугацааны асуумжийн судалгаанд оролцсон шүүгчийн мэдээлэл

Монгол улсад Иргэний хэрэг хянан шийдвэрлэх үйл ажиллагаа явуулдаг анхан шатны 38 шүүхээс 22 шүүх асуумж бөглөн ирүүлсэн бөгөөд үлдсэн 16 шүүх ирүүлээгүй байна. Ирүүлсэн 17 шүүхээс судалгаанд дараах шүүхүүдийн өгөгдлийн мэдээллийг ашигласан болно.

№	Шүүх	Иргэний хуулиар	ИХШХШТХ	Гэр бүл	Хөдөлмөр	ШШГТХ	Бусад	Дүн
1	Баянзүрх	1	1	1	1	1	1	6
2	Сонгинохайрхан	2	2	3	2	2	2	13




3	Багахангай	1	1	1	1	1	1	6
4	Налайх	1	1	1	1	1	1	6
5	Баян-Өлгий	1	1	0	0	0	0	2
6	Баянхонгор	1	1	2	2	0	1	7
7	Говь-Алтай	3	3	3	1	3	2	15
8	Дархан-Уул	1	1	2	1	2	1	8
9	Дорноговь	1	1	1	1	1	1	6
10	Дорнод	1	2	1	1	1	1	7
11	Дундговь	1	0	2	2	2	0	7
12	Өвөрхангай	2	2	2	2	1	2	11
13	Сэлэнгэ	0	0	1	1	1	0	3
14	Хэнтий	3	3	3	3	3	3	18
15	Замын үүд	0	1	2	0	2	2	7
16	Тосонцэнгэл	0	1	0	1	0	0	2
17	Сайхан	3	3	3	3	3	3	18
18	Дүн	22	24	28	23	24	21	142

Хүснэгт 3.2. 2 Судалгаанд ашигласан өгөгдлийн мэдээ

Судалгаанд оролцсон нийт 22 шүүхийн 43 шүүгч иргэний хэрэг маргааныг хянан шийдвэрлэхэд ашигладаг 6 хуулийн хувьд 255 асуумж өгснөөс 17 шүүхийн 23 шүүгчийн 142 өгөгдлийг судалгаанд ашиглав. Үүнээс Сүхбаатар дүүрэг, Чингэлтэй дүүрэг, Сүхбаатар аймаг, Ховд аймаг, Хөвсгөл аймгийн шүүхийн асуумжийн өгөгдлийг судалгаанаас хасав. Асуумжийг хассан шалтгааныг Хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэсэн эрүүгийн хэргийн асуумжид хийсэн шинжилгээнд дэлгэрэнгүй тайлбарласан болно.


3.2.1.1 Бага үнийн дүнтэй иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үе шатуудад хийх шинжилгээ

Иргэний хэрэг бүрийн ажиллагаанд зарцуулах хугацааны тухай нийслэл, аймаг, сум дундын шүүхийн Иргэний хэргийн шүүгчдийн өгсөн 142 асуумжийн өгөгдөлд хийсэн 2 хүчин зүйлийн дисперсийн шинжилгээний үр дүнг Зураг 3.2.1-д харуулав. Зургаас харвал Дүүргийн төвийн 6 дүүргийн Иргэний хэргийн шүүгч нар 1 бага үнийн дүнтэй иргэний хэргийг шийдэхэд 1082 минут, захын дүүргийн шүүгч нар 1050 минут, аймгийн шүүгчид 1440, Сум дундын шүүхийн шүүгчид 1248 минут зарцуулдаг гэсэн байна. Бага үнийн дүнтэй 1 иргэний хэргийг шийдэхэд зарцуулах хугацааг хууль тус бүрээр нь задалж харуулсан зургаас харвал Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулиар шийдвэрлэхэд хамгийн их буюу 1399 минут зарцуулдаг гэсэн асуулга өгсөн байна. Бусад хуулиудын хувьд 1199-1392 минут зарцуулдаг гэсэн байна.



Зураг 3.2. 1 Бага үнийн дүнтэй иргэний хэрэг хянан шийдвэрлэхэд зарцуулах хугацааны тухай асуумжийн ерөнхий мэдээлэл

Дисперсийн шинжилгээний хамтын нөлөөллийн үр дүнгээр Зураг 3.2.2-д харуулав. Зургаас харвал Иргэний хэргийн шүүгчид Иргэний хуулиар бага үнийн дүнтэй хэрэг маргаан эцэслэн шийдэхэд 1346 минут, ИХШХШТХ-иар бага үнийн дүнтэй хэрэг маргаан эцэслэн шийдэхэд 1199 минут, Гэр бүлийн тухай хуулиар бага үнийн дүнтэй хэрэг маргаан эцэслэн шийдэхэд 1392 минут, Хөдөлмөрийн тухай хуулиар бага үнийн дүнтэй хэрэг маргаан эцэслэн шийдэхэд 1247 минут, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулиар бага үнийн дүнтэй хэрэг маргаан эцэслэн шийдэхэд 1399 минут, бусад хуулиар бага үнийн дүнтэй хэрэг маргаан эцэслэн шийдэхэд 1334 минут тус тус зарцуулдаг гэж үзсэн байна.



Зураг 3.2. 2 Бага үнийн дүнтэй иргэний хэрэг хянан шийдвэрлэхэд зарцуулах хугацаа, хуулиар

Шүүгчийн ажлын туршлага, хэрэг хянан шийдвэрлэх хугацааны тухай бодит практик баримжаа, санал бодлыг энэхүү судалгаанд аль болох тусгаж оруулахыг судалгааны баг зорьсон ч бага үнийн дүнтэй хэрэг хянан шийдвэрлэх асуумжийн өгөгдлийн судалгааг цааш үргэлжлүүлэх шаардлагагүй болсон тул шинжилгээг зогсоов. Учир нь 5-р бүлгийн шүүгчийн ажлын ачаалал тооцох, хэргийн коэффициент тодорхойлох судалгаанд бага үнийн дүнтэй хэрэг хянан шийдвэрлэх асуумжийн үр дүн шаардлага хангахгүй өгөгдөлд шилжиж байгаа тул бүтцийн болон дисперсийн шинжилгээг үргэлжлүүлэн хийх шаардлагагүй болов.

3.2.2 Хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэсэн иргэний хэргийн асуумжийн өгөгдөлд хийх шинжилгээ

3.2.2.1 Хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэсэн иргэний хэргийн асуумжийн тухай

Иргэний хэргийн ажиллагааны ачааллын асуумжид шинжилгээ хийхэд ашигласан өгөгдлийн танилцуулгыг дараах хүснэгтээр харуулъя.

№	Иргэний хуулиар	ИХШХШтХ	Гэр бүл	Хөдөлмөр	ШШГТХ	Бусад	Дүн
1	Сонгинохайрхан	2	2	1	1	1	8
2	Чингэлтэй	1	1	1	1	1	6
3	Сүхбаатар	1	2	1	1	1	7
4	Баян-Өлгий	1	1	2	3	3	13
5	Баянхонгор	2	2	2	2	2	12
6	Дархан-Уул	2	2	2	2	2	12
7	Дорнод	3	3	3	3	3	18
8	Дундговь	1	1	1	1	1	6
9	Завхан	2	2	2	2	2	12
10	Өвөрхангай	4	4	4	4	4	24
11	Сэлэнгэ	0	3	3	3	3	15
12	Увс	2	2	2	2	2	12
13	Хөвсгөл	1	1	1	1	1	6
14	Хэнтий	3	3	3	3	3	18
15	Замын үүд	3	3	3	3	3	18
16	Сайхан	4	4	4	4	4	24
17	Бор-Өндөр	2	2	2	2	2	12
18	Дүн	36	38	37	38	38	223

Хүснэгт 3.2. 3 Хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд зарцуулах хугацааны асуумжийн судалгаанд оролцсон шүүгчийн мэдээлэл

Монгол улсад Иргэний хэрэг хянан шийдвэрлэх үйл ажиллагаа явуулдаг анхан шатны 38 шүүхээс 17 шүүх асуумж бөглөн ирүүлсэн бөгөөд үлдсэн 21 шүүх ирүүлээгүй байна. Ирүүлсэн 17 шүүхээс судалгаанд дараах шүүхүүдийн өгөгдлийн мэдээллийг ашигласан болно.

№	Шүүх	Иргэний хуулиар	ИХШХШтХ	Гэр бүл	Хөдөлмөр	ШШГТХ	Бусад	Дүн
1	Сонгинохайрхан	1	1	1	1	1	1	6
2	Баян-Өлгий		1			1		1
3	Баянхонгор	2	2	2	2	2	2	12
4	Дорнод					1	4	5
5	Дархан-Уул		1	4				5
6	Дорнод		2					2
7	Өвөрхангай	4	1		4	4		13
8	Хэнтий	1		2	1	1	1	6
9	Сайхан	4	4	4	4	4	4	24
10	Дүн	12	12	13	12	14	12	75




Хүснэгт 3.2. 4 Судалгаанд ашигласан өгөгдлийн мэдээ

Судалгаанд оролцсон нийт 17 шүүхийн 38 шүүгч иргэний хэрэг маргааныг хянан шийдвэрлэхэд ашигладаг 6 хуулийн хувьд 223 асуумж өгснөөс 9 шүүхийн 14 шүүгчийн 75 өгөгдлийг судалгаанд ашиглав. Үүнээс Сүхбаатар дүүрэг, Чингэлтэй дүүрэг, Дундговь, Завхан, Увс, Хөвсгөл, Замын-Үүд, Бор-Өндөр шүүхийн асуумжийн өгөгдлийг судалгаанаас хасав. Асуумжийг хассан шалтгааныг Хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэсэн эрүүгийн хэргийн асуумжид хийсэн шинжилгээнд дэлгэрэнгүй тайлбарласан болно.


3.2.2.2 Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үе шатуудад хийх шинжилгээ

Иргэний хэрэг бүрийн ажиллагаанд зарцуулах хугацааны тухай нийслэл, аймаг, сум дундын шүүхийн Иргэний хэргийн шүүгчдийн өгсөн 75 асуумжийн өгөгдөлд хийсэн 2 хүчин зүйлийн дисперсийн шинжилгээний үр дүнг Зураг 3.2.3-д харуулав. Зургаас харвал Дүүргийн төвийн 6 дүүргийн Иргэний хэргийн шүүгч нар хялбаршуулсан журмаар иргэний хэргийг шийдэхэд 455 минут, аймгийн шүүгчид 745, Сум дундын шүүхийн шүүгчид 573 минут зарцуулдаг байна. Хялбаршуулсан журмаар 1 иргэний хэргийг шийдэхэд зарцуулах хугацааг хууль тус бүрээр нь задалж харуулсан зургаас харвал Иргэний хуулиар шийдвэрлэхэд хамгийн их буюу 716 минут, ИХШХШТХ-иар хамгийн бага буюу 551 минут тус тус зарцуулдаг гэсэн асуулга өгсөн байна. Бусад хуулиудын хувьд 673-709 минут зарцуулдаг байна.



Зураг 3.2.3 Хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэхэд зарцуулах хугацааны тухай асуумжийн ерөнхий мэдээлэл

Дисперсийн шинжилгээний хамтын нөлөөллийн үр дүнг Зураг 3.2.3-д харуулав. Зургаас харвал Иргэний хэргийн шүүгчид хялбаршуулсан журмаар Иргэний хуулиар хэрэг маргаан эцэслэн шийдэхэд 716 минут, ИХШХШТХ-иар хэрэг маргаан эцэслэн шийдэхэд 661 минут, Гэр бүлийн тухай хуулиар хэрэг маргаан эцэслэн шийдэхэд 709 минут, Хөдөлмөрийн тухай хуулиар бага үнийн дүнтэй хэрэг маргаан эцэслэн шийдэхэд 681 минут, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулиар хэрэг маргаан эцэслэн шийдэхэд 669 минут, бусад хуулиар хэрэг маргаан эцэслэн шийдэхэд 673 минут тус тус зарцуулдаг гэж үзсэн байна.



Зураг 3.2. 4 Хялбаршуулсан журмаар иргэний хэрэг хянан шийдвэрлэхэд зарцуулах хугацаа, хуулиар

Шүүгчийн ажлын туршлага, хэрэг хянан шийдвэрлэх хугацааны тухай бодит практик баримжаа, санал бодлыг энэхүү судалгаанд аль болох тусгаж оруулахыг судалгааны баг зорьсон ч хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх асуумжийн өгөгдлийн судалгааг цааш үргэлжлүүлэх шаардлагагүй болсон тул шинжилгээг зогсоов. Учир нь 5-р бүлгийн шүүгчийн ажлын ачаалал тооцох, хэргийн коэффициент тодорхойлох судалгаанд хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх асуумжийн үр дүн шаардлага хангахгүй өгөгдөлд шилжиж байгаа тул бүтцийн болон дисперсийн шинжилгээг үргэлжлүүлэн хийх шаардлагагүй болов.



3.2.3 Ердийн журмаар хянан шийдвэрлэсэн иргэний хэргийн асуумжийн өгөгдөлд хийх шинжилгээ

3.2.3.1 Ердийн журмаар хянан шийдвэрлэсэн иргэний хэргийн асуумжийн тухай

Иргэний хэргийн ажиллагааны ачааллын асуумжид шинжилгээ хийхэд ашигласан өгөгдлийн танилцуулгыг дараах хүснэгтээр харуулъя.

№	Шүүх	Иргэний хуулиар	ИХШХШтХ	Гэр бүл	Хөдөлмөр	ШШГТХ	Бусад	Дүн
1	Баянзүрх	1	1	1	1	1	1	6
2	Сүхбаатар	1	1	1	1	1	1	6
3	Чингэлтэй	1	1	1	1	1	1	6
4	Сонгинохайрхан	2	2	2	2	2	2	10
5	Багахангай	1	1	1	1	1	1	6
6	Налайх	2	3	3	3	3	3	17
7	Баян-Өлгий	1	1	1	1	1	1	6
8	Баянхонгор	3	3	3	3	3	3	18
9	Говь-Алтай	2	2	2	2	2	2	12
10	Дархан-Уул	2	2	2	2	2	2	12
11	Дорноговь	1	1	1	1	1	1	6
12	Дорнод	3	3	3	3	3	3	18
13	Дундговь	1	1	1	1	1	1	6
14	Завхан	5	3	3	3	3	3	20
15	Өвөрхангай	2	2	2	2	2	2	12
16	Сүхбаатар	1	1	1	1	1	1	6
17	Увс	1	1	1	1	1	1	6
18	Хөвсгөл	1	1	1	1	1	1	6
19	Хэнтий	2	2	2	2	2	2	12
20	Замын үүд	1	1	1	1	1	1	6
21	Тосонцэнгэл	3	3	3	3	3	3	18
22	Хархорин	1	1	1	1	1	1	6
23	Сайхан	1	1	1	1	1	1	6
24	Ховдын Булган	1	1					2
25	Дүн	40	39	38	36	38	38	229

Хүснэгт 3.2. 5 Ердийн журмаар иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд зарцуулах хугацааны асуумжийн судалгаанд оролцсон шүүгчийн мэдээлэл

Монгол улсад Иргэний хэрэг хянан шийдвэрлэх үйл ажиллагаа явуулдаг анхан шатны 38 шүүхээс 24 шүүх асуумж бөглөн ирүүлсэн бөгөөд үлдсэн 14 шүүх ирүүлээгүй байна. Ирүүлсэн 24 шүүхээс судалгаанд дараах шүүхүүдийн өгөгдлийн мэдээллийг ашигласан болно.

№	Шүүх	Иргэний хуулиар	ИХШХШтХ	Гэр бүл	Хөдөлмөр	ШШГТХ	Бусад	Дүн
1	Баянзүрх		1			1	1	3
2	Сүхбаатар	1	1	1	1	1	1	6
3	Сонгинохайрхан	2	1	2	2	2	2	11
4	Багахангай	1	1	1	1	1		5
5	Налайх		1	1				2
6	Баян-Өлгий		1					1
7	Баянхонгор	2	3	2	2	2	2	13
8	Говь-Алтай	1	1	1	1	1	1	6
9	Дархан-Уул	1	1	1	1	1	1	6
10	Дорноговь	1	1	1	1	1	1	6
11	Дорнод			1				1
12	Дундговь	1	1	1	1	1	1	6
13	Завхан	3	1	3	3	3	3	16
14	Өвөрхангай	2	2	2	2	2	2	12
15	Сүхбаатар	1		1	1	1		4
16	Хөвсгөл			1	1	1	1	4
17	Хэнтий	2	2	2	2	2	2	12
18	Замын үүд	1	1	1	1	1	1	6
19	Тосонцэнгэл		1				1	2
20	Хархорин	1	1	1	1	1	1	6
21	Ховдын Булган	1						1
22	Дүн	21	21	23	21	22	21	129



Хүснэгт 3.2. 6 Судалгаанд ашигласан өгөгдлийн мэдээ

Судалгаанд оролцсон нийт 24 шүүхийн 40 шүүгч иргэний хэрэг маргааныг хянан шийдвэрлэхэд ашигладаг 6 хуулийн хувьд 229 асуумж өгснөөс 21 шүүхийн 23 шүүгчийн 129 өгөгдлийг судалгаанд ашиглав. Үүнээс Чингэлтэй дүүрэг, Увс, Замын-Үүд шүүхийн асуумжийн өгөгдлийг судалгаанаас хасав. Асуумжийг хассан шалтгааныг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэсэн эрүүгийн хэргийн асуумжид хийсэн шинжилгээнд дэлгэрэнгүй тайлбарласан болно.


3.2.3.2 Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үе шатанд хийх шинжилгээ

Иргэний хэрэг бүрийн ажиллагаанд зарцуулах хугацааны тухай нийслэл, аймаг, сум дундын шүүхийн Иргэний хэргийн шүүгчдийн өгсөн 129 асуумжийн өгөгдөлд хийсэн 2 хүчин зүйлийн дисперсийн шинжилгээний үр дүнг Зураг 3.2.5-д харуулав. Зургаас харвал Дүүргийн төвийн 6 дүүргийн Иргэний хэргийн шүүгч нар ердийн журмаар иргэний хэргийг шийдэхэд 1071 минут, захын дүүргийн шүүгч нар 1280 минут, аймгийн шүүгчид 1229, Сум дундын шүүхийн шүүгчид 798 минут зарцуулдаг гэсэн байна. Ердийн журмаар 1 иргэний хэргийг шийдэхэд зарцуулах хугацааг хууль тус бүрээр нь задалж харуулсан зургаас харвал Иргэний хуулиар шийдвэрлэхэд хамгийн их буюу 1222 минут зарцуулдаг гэсэн асуулга өгсөн байна. Бусад хуулиудын хувьд 1124-1164 минут зарцуулдаг гэсэн байна.



Зураг 3.2.5 Ердийн журмаар иргэний хэрэг хянан шийдвэрлэхэд зарцуулах хугацааны тухай асуумжийн ерөнхий мэдээлэл

Дисперсийн шинжилгээний хамтын нөлөөллийн үр дүнг Зураг 3.2.6-д харуулав. Зургаас харвал Иргэний хэргийн шүүгчид Иргэний хуулиар ердийн журмаар хэрэг маргаан эцэслэн шийдэхэд 1346 минут, ИХШХШТХ-иар ердийн журмаар хэрэг маргаан эцэслэн шийдэхэд 1222 минут, Гэр бүлийн тухай хуулиар ердийн журмаар хэрэг, маргаан эцэслэн шийдэхэд 1133 минут, Хөдөлмөрийн тухай хуулиар ердийн журмаар хэрэг маргаан эцэслэн шийдэхэд 1164 минут, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулиар ердийн журмаар хэрэг маргаан эцэслэн шийдэхэд 1153 минут, бусад хуулиар ердийн журмаар хэрэг маргаан эцэслэн шийдэхэд 1164 минут тус тус зарцуулдаг гэж үзсэн байна.



Зураг 3.2.6 Ердийн журмаар иргэний хэрэг хянан шийдвэрлэхэд зарцуулах хугацаа, хуулиар

Шүүгчийн ажлын туршлага, хэрэг хянан шийдвэрлэх хугацааны тухай бодит практик баримжаа, санал бодлыг энэхүү судалгаанд аль болох тусгаж оруулахыг судалгааны баг зорьсон ч ердийн журмаар хэрэг хянан шийдвэрлэх асуумжийн өгөгдлийн захын дүүрэг, аймгийн шүүхээс ирүүлсэн судалгааг цааш үргэлжлүүлэх шаардлагагүй болсон тул шинжилгээг зогсоов. Учир нь 5-р бүлгийн шүүгчийн ажлын ачаалал тооцох, хэргийн коэффициент тодорхойлох судалгаанд ердийн журмаар хэрэг хянан шийдвэрлэх тухай захын дүүрэг, аймгийн шүүхээс ирүүлсэн асуумжийн өгөгдөл судалгааны шаардлага хангахгүй өгөгдөлд шилжиж байгаа тул бүтцийн болон дисперсийн шинжилгээг үргэлжлүүлэн хийхгүйгээр төвийн дүүрэг болон сум дундын шүүхээс ирүүлсэн асуумжийн өгөгдлийг ашиглав.



3.2.4 Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхээс ирүүлсэн асуумжийн өгөгдөлд хийх шинжилгээ

3.2.4.1 Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхээс ирүүлсэн асуумжийн тухай

Иргэний хэргийн ажиллагааны ачааллын асуумжид шинжилгээ хийхэд ашигласан өгөгдлийн танилцуулгыг дараах хүснэгтээр харуулъя.

№	Шүүх	Иргэний хуулиар	ИХШХШТХ	Гэр бүл	Хөдөлмөр	ШШГТХ	Бусад	Дүн
1	Нийслэл	2	2	2	2	2	2	12
2	Архангай	1	1	1	1	1	1	6
3	Баянхонгор	2	2	2	2	2	1	11
4	Говь-Алтай	2	2	3	2	2	2	13
5	Говьсүмбэр	1	1	1	1	1	1	6
6	Дархан-Уул	2	2	2	2	2	1	11
7	Дорноговь	1	1	1	1	1	1	6
8	Завхан	2	2	2	2	2	1	11
9	Увс	2	2	2	2	2	2	12
10	Ховд	2	2	2	2	2	1	11
11	Хөвсгөл	2	2	2	2	2	1	11
Дүн		19	19	20	19	19	14	110


Хүснэгт 3.2.7 ДЗШШ-ийн иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд зарцуулах хугацааны асуумжийн судалгаанд оролцсон шүүгчийн мэдээлэл

Монгол улсад Иргэний хэрэг хянан шийдвэрлэх үйл ажиллагаа явуулдаг давж заалдах шатны 22 шүүхээс 11 шүүх асуумж бөглөн ирүүлсэн бөгөөд үлдсэн 11 шүүх ирүүлээгүй байна. Ирүүлсэн 11 шүүхээс судалгаанд дараах шүүхүүдийн өгөгдлийн мэдээллийг ашигласан болно.

№	Шүүх	Иргэний хуулиар	ИХШХШТХ	Гэр бүл	Хөдөлмөр	ШШГТХ	Бусад	Дүн
1	Нийслэл	1	1	1	-	1	1	5
2	Архангай	-	-	-	-	1		1
3	Баянхонгор	2		2	2	-	1	7
4	Говь-Алтай	2	2	1	2	2	2	11
5	Дархан-Уул	2	2	-	-	2	-	6
6	Увс	-	-	-	-	2	2	4
7	Ховд	2	-	2	2	-	1	7
8	Хөвсгөл	1	-	-	-	2	1	4
Дүн		10	5	6	6	10	8	45

Хүснэгт 3.2.8 Судалгаанд ашигласан өгөгдлийн мэдээ

Судалгаанд оролцсон нийт 11 шүүхийн 20 шүүгч иргэний хэрэг маргааныг хянан шийдвэрлэхэд ашигладаг 6 хуулийн хувьд 110 асуумж өгснөөс 8 шүүхийн 10 шүүгчийн 45 өгөгдлийг судалгаанд ашиглав. Үүнээс Говьсүмбэр, Дорноговь, Завхан шүүхийн асуумжийн өгөгдлийг судалгаанаас хасав. Асуумжийг хассан шалтгааныг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэсэн эрүүгийн хэргийн асуумжид хийсэн шинжилгээнд дэлгэрэнгүй тайлбарласан болно.




Зураг 3.2.7 ИХДЗШШ-ийн хэргийн ажиллагаанд зарцуулах хугацааны тухай асуумжийн ерөнхий мэдээлэл

Иргэний хэрэг бүрийн ажиллагаанд зарцуулах хугацааны тухай нийслэл, аймгийн Иргэний хэргийн давж заалдах шүүгчдийн өгсөн 45 асуумжийн өгөгдөлд хийсэн 2 хүчин зүйлийн дисперсийн шинжилгээний үр дүнг Зураг 3.2.7-д харуулав. Зургаас харвал аймгийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх 1 хэрэг хянан шийдвэрлэхэд 1336 минут, Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх 1 хэрэг хянан шийдвэрлэхэд 750 минут тус тус зарцуулдаг байна. Давж заалдах шатны шүүх 1 иргэний хэргийг шийдэхэд зарцуулах хугацааг хууль тус бүрээр нь задалж харуулсан зургаас харвал Шүүхийн шийдвэр



гүйцэтгэх тухай хуулиар хамгийн их буюу 1658 минут зарцуулдаг гэсэн асуулга өгсөн байна. Бусад хуулиудын хувьд 926-1331 минут зарцуулдаг гэсэн байна.



Зураг 3.2.8 ИХДЗШШ-ийн хэргийн ажиллагаанд зарцуулах хугацаа, хэргийн зүйл ангиар

Зураг 3.2.8-аас харвал нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх нь бүх хэргийн төрөл, зүйл ангийн хувьд аймгийн шүүхээс 2 дахин бага хугацааг хэргийн ажиллагаанд зарцуулдаг байна.


3.2.4.2 Давж заалдах шатны шүүхийн иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үе шатанд хийх шинжилгээ

Асуумжийн өгөгдөл дээр хэрэг хянан шийдвэрлэх үе шатуудын хувьд шинжилгээ хийсэн үр дүнг дараах зургаар харуулав.



Зураг 3.2.9 Ердийн журмаар иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үе шат

Зураг 3.2.9-өөс харвал хэргийг шүүгч хүлээн авах үе шатанд дунджаар нэг хэрэг, маргааныг хянан шийдвэрлэхэд нийт хугацааны 19% буюу 240 минут, хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхэд бэлтгэх, хэлэлцэх үе шатанд 80% буюу 995 минут, хэргийг шийдвэрлэсний дараах үе шатанд 1% буюу 14 минут зарцуулдаг байна.



Зураг 3.2.10 ИХДЗШШ-ийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үе шатанд зарцуулах хугацаа, хэргийн төрлөөр


Зураг 3.2.9-д харуулсан ерөнхий мэдээллийг хууль тус бүрээр Зураг 3.2.10-д дэлгэрэнгүй оруулав. Зургаас харвал хэрэг хянан шийдвэрлэх 1-р үе шатны ажиллагаанд зарцуулах хугацаанаас хамгийн их хугацааг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулиар 414 минут, Иргэний хуулиар 303 минут байна. Харин үлдсэн 4 хуулийн хувьд 142-178 минут байна. Хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхэд бэлтгэх, хэлэлцэх үе шатанд судалгаанд авсан 6 хуулийн ажиллагаанд зарцуулах хугацаанаас Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулиар шийдвэрлэх ажиллагаанд зарцуулах хугацаа хамгийн их буюу 1236 минут, Иргэний хуулиар 1100 минут тус тус зарцуулсан байна. Бусад 4 хуулиар шийдвэрлэх ажиллагаанд зарцуулах хугацаа 612-1034 минут байна. Хэргийг шийдвэрлэсний дараах үе шатанд бүх хуулийн ажиллагаанд зарцуулах хугацаа ойролцоо буюу 9-26 минут орчим гэж дүгнэгдсэн байна.



3.2.4.3 Давж заалдах шатны шүүхийн иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үе шатны өгөгдөлд хийх шинжилгээ

Зураг 3.2.10-д харуулсан хэрэг хянан шийдвэрлэх үе шатыг ямар төрлийн ажиллагаанаас хамаарч харилцан адилгүй хугацаа зарцуулж байгааг хэрэг, маргааны ажиллагаа тус бүрээр задалж харуулсан үр дүнг танилцуулъя.

• 1-р үе шат: Хэргийг шүүгч хүлээн авах үе шат




Зураг 3.2. 11 Хэргийг шүүгч хүлээн авах үе шатны ажиллагааны задаргаа, эзлэх хувиар

Зураг 3.2.11-ээс харвал иргэний хэргийн давж заалдах шатны шүүгч хэргийг хүлээн авах үе шатанд зарцуулах нийт хугацааны 79% буюу 151 минутыг хэрэг түүнд хавсаргасан баримтыг уншиж танилцахад, 11% буюу 22 минутыг гомдлыг хүлээн авахаас татгалзах /давж заалдах гомдол гараагүйд тооцох/ тухай захирамжийн төслийг боловсруулах, хянах, гарын үсэг зурахад, 10% буюу 19 минутыг татгалзах үндэслэл байгаа эсэхийг шалгасан туслахыг ажиллагааг хянахад тус тус зарцуулдаг байна.



Зураг 3.2. 12 ИХДЗШШШ-ийн хэргийг хүлээн авах үеийн ажиллагаанд зарцуулах хугацаа, хуулиар


Зураг 3.2.12-д харуулсан иргэний хэргийн давж заалдах шатны шүүгч хэргийг хүлээн авах үе шатанд зарцуулах нийт хугацааг хууль бүрээр Зураг 3.2.13-д задалж харуулав. Энэ үе шатны гомдлыг хүлээн авахаас татгалзах /давж заалдах гомдол гараагүйд тооцох/ тухай захирамжийн төслийг боловсруулах, хянах, гарын үсэг зурахад бүх хуулийн хувьд 10-35 минут зарцуулдаг байна. Хамгийн их хугацааг Иргэний хуулиар 35 минут, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулиар 31 минут тус тус зарцуулдаг гэсэн байна. Татгалзах үндэслэл байгаа эсэхийг шалгасан туслахыг ажиллагааг хянахад бүх хуулийн хувьд 10-33 минутыг зарцуулдаг байна. Хамгийн их хугацааг Хөдөлмөрийн тухай хуулиар 33 минут, Иргэний хуулиар 24 минут зарцуулдаг байна. Хэрэг түүнд хавсаргасан баримтыг уншиж танилцах ажиллагааны хувьд бүх хуулиудын хувьд 64-244 минут зарцуулдаг гэсэн байна. Хамгийн их хугацааг Иргэний хуулиар 244 минут, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулиар 191 минут тус тус зарцуулдаг байна.



Зураг 3.2.13 Хэрэг түүнд хавсаргасан баримтыг уншиж танилцах ажиллагаа, дундаж минутаар

Зураг 3.2.13-аас харвал 1-4 хавтастай хэргийг уншиж танилцахад 56 минут, 5-10 хавтастай хэргийг уншиж танилцахад 152 минут, 11-аас дээш хавтастай хэргийг уншиж танилцахад 244 минут зарцуулдаг гэж үзсэн байна. Хэрэг түүнд хавсаргасан баримтыг уншиж танилцах ажиллагаанд дунджаар 151 минут зарцуулдаг байна.

• 2-р үе шат: Хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхэд бэлтгэх, хэлэлцэх үе шат



Зураг 3.2. 14 ИХДЗШШШ-ийн хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхэд бэлтгэх, хэлэлцэх үе шатны ажиллагаа


Зураг 3.2.14-өөс харвал Иргэний хэргийн шүүгч хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхэд бэлтгэх, хэлэлцэх үеийн ажиллагаанд зарцуулах нийт хугацааны 46% буюу 524 минутыг шийдвэр боловсруулах, хянах, гарын үсэг зурахад, 28% буюу 316 минутыг хэргийн материалтай танилцахад, 20% буюу 231 минутыг шүүх хуралдаанд, 3% буюу 34 минутыг шүүх хуралдааны тэмдэглэл хянахад, 1% буюу 15 минутыг шүүх хуралдааныг хэзээ товлүүл болонжтойг тодруулах, шүүх хуралдааныг товлон талаар шүүгчийн туслахад чиглэл өгөхөд, 1% буюу 11 минутыг шүүх хуралдаан даргалагч, шүүх бүрэлдэхүүн томилсныг албажуулах тухай Ерөнхий шүүгчийн захирамжийн төслийг хянахад, 0.6% буюу 7 минутыг хэргийн оролцогчдод шүүх хуралдааны тов мэдэгдэх хуудсыг хянаж, гарын үсэг зурахад тус тус зарцуулдаг гэсэн байна.



Зураг 3.2. 15 Хэргийн материалтай танилцах, түүвэр гаргах ажиллагааны задаргаа

Зураг 3.2.15-д хэргийн материалтай танилцахад 467 минут зарцуулдаг гэж үзсэн ерөнхий дүнг дэд ажиллагаа тус бүрээр задалж үзэхэд шаардлагатай хууль тогтоомжийг судлахад 113 минут, түүвэр гаргахад 75 минут, ХХША-г төлөвлөхөд 22 минут, шүүхийн практик судлахад 106 минут тус тус зарцуулдаг гэж үзсэн байна.

Түүвэр гаргах ажиллагаагаа дотроо 3 задарч байгаа бөгөөд 1-4 хавтастай хэргийн түүвэр гарахад 45 минут, 5-10 хавтастай түүвэр гаргахад 72 минут, 11-ээс дээш хавтастай хэргийн түүвэр гаргахад 108 минут тус тус зарцуулдаг бөгөөд дунджаар түүвэр гаргах ажиллагаа 75 минут зарцуулж байна.



Зураг 3.2. 16 Шүүх хуралдаан, шийдвэр боловсруулах хянах гарын үсэг зурах ажиллагааны задаргаа

Зураг 3.2.16-д шүүх хуралдаанд 231 минут зарцуулдаг гэж үзсэн ерөнхий дүнг дэд ажиллагаа тус бүрээр задалж үзэхэд илтгэхэд 87 минут, зөвлөлдөхөд 36 минут, шүүхээс гарсан шийдвэрийн тогтоох хэсгийг танилцуулах, үндэслэлийг тайлбарлахад 21 минут, бүрэлдэхүүн даргалахад 88 минут тус тус зарцуулдаг гэж үзсэн байна.

Шийдвэр боловсруулах, хянах, гарын үсэг зурахад мөн 3 задарч байгаа магадлал боловсруулж хянахад 428 минут, шүүхийн тогтоол боловсруулж хянахад 61 минут, шүүгчийн захирамж боловсруулж хянахад 56 минут тус тус зарцуулдаг байна.

• 3-р үе шат: Хэргийг шийдвэрлэсний дараах үе шат

Хэрэг хянан шийдвэрлэх 3-р үе шатны бүх ажиллагаанд зарцуулах хугацаа хууль тус бүрээр ойролцоо дүнтэй буюу албан бичиг хянахад дунджаар 14 минут зарцуулдаг байна.



3.2.5 Иргэний хэргийн анхан болон давж заалдах шатны шүүхээс ирүүлсэн асуумжийн дүгнэлт

1. Бага үнийн дүнтэй хэргийг хянан шийдвэрлэсэн иргэний хэргийн асуумжийн өгөгдөлд хийх шинжилгээ:

Бага үнийн дүнтэй иргэний хэргийн асуумжийн судалгаанд нийт 22 шүүхийн 43 шүүгч иргэний хэрэг маргааныг хянан шийдвэрлэхэд ашигладаг 6 хуулийн хувьд 255 асуумж өгснөөс 17 шүүхийн 23 шүүгчийн 142 өгөгдлийг судалгаанд ашиглав. Үүнээс Сүхбаатар дүүрэг, Чингэлтэй дүүрэг, Сүхбаатар аймаг, Ховд аймаг, Хөвсгөл аймгийн шүүхийн асуумжийн өгөгдлийг судалгаанаас хасав. Шинжилгээгээр дүүргийн Иргэний хэргийн шүүгчид нэг бага үнийн дүнтэй иргэний хэргийг шийдэхэд 1082 минут, захын дүүргийн шүүгчид 1050 минут, аймгийн шүүгчид 1440, Сум дундын шүүхийн шүүгчид 1248 минут тус тус зарцуулдаг байна.

Иргэний хэргийн шүүгчид Иргэний хуулиар бага үнийн дүнтэй хэрэг маргаан эцэслэн шийдэхэд 1346 минут, ИХШХШТХ-иар бага үнийн дүнтэй хэрэг маргаан эцэслэн шийдэхэд 1199 минут, Гэр бүлийн тухай хуулиар бага үнийн дүнтэй хэрэг маргаан эцэслэн шийдэхэд 1392 минут, Хөдөлмөрийн тухай хуулиар бага үнийн дүнтэй хэрэг маргаан эцэслэн шийдэхэд 1247 минут, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулиар бага үнийн дүнтэй хэрэг маргаан эцэслэн шийдэхэд 1399 минут, бусад хуулиар бага үнийн дүнтэй хэрэг маргаан эцэслэн шийдэхэд 1334 минут тус тус зарцуулдаг байна. Иргэний хэрэг үүсгэх эсэхийг шийдвэрлэх үе шатанд дунджаар нэг хэрэг, маргааныг хянан шийдвэрлэхэд нийт хугацааны 4% буюу 57 минут, хэрэг үүсгэснээс хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцүүлэх шийдвэр гаргах хүртэлх хугацааны ажиллагааны үе шатанд 46% буюу 604 минут, хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхэд бэлтгэх үе шатанд 46% буюу 611 минут, хэргийг эцэслэн шийдвэрлэсний дараах ажиллагааны үе шатанд 4% буюу 48 минут зарцуулдаг байна.

2. Хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэсэн иргэний хэргийн асуумжийн өгөгдөлд хийх шинжилгээ

Хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэсэн иргэний хэргийн асуумжийн судалгаанд нийт 17 шүүхийн 38 шүүгч иргэний хэрэг маргааныг хянан шийдвэрлэхэд ашигладаг 6 хуулийн хувьд 223 асуумж өгснөөс 9 шүүхийн 14 шүүгчийн 75 өгөгдлийг судалгаанд ашиглав. Үүнээс Сүхбаатар дүүрэг, Чингэлтэй дүүрэг, Дундговь, Завхан, Увс, Хөвсгөл, Замын-Үүд, Бор-Өндөр шүүхийн асуумжийн өгөгдлийг судалгаанаас хасав. Дүүргийн төвийн 6 дүүргийн Иргэний хэргийн шүүгч нар хялбаршуулсан журмаар иргэний хэргийг шийдэхэд 455 минут, аймгийн шүүгчид 745, Сум дундын шүүхийн шүүгчид 573 минут зарцуулдаг гэсэн байна.

Иргэний хэргийн шүүгчид хялбаршуулсан журмаар Иргэний хуулиар хэрэг маргаан эцэслэн шийдэхэд 716 минут, ИХШХШТХ-иар хэрэг маргаан эцэслэн шийдэхэд 661 минут, Гэр бүлийн тухай хуулиар хэрэг маргаан эцэслэн шийдэхэд 709 минут, Хөдөлмөрийн тухай хуулиар бага үнийн дүнтэй хэрэг маргаан эцэслэн шийдэхэд 681 минут, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулиар хэрэг маргаан эцэслэн шийдэхэд 669 минут, бусад хуулиар хэрэг маргаан эцэслэн шийдэхэд 673 минут тус тус зарцуулдаг байна. Иргэний хэрэг үүсгэх эсэхийг шийдвэрлэх шатанд дунджаар нэг хэрэг, маргааныг хянан шийдвэрлэхэд нийт хугацааны 10% буюу 66 минут, хэрэг үүсгэснээс хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцүүлэх шийдвэр гаргах хүртэлх хугацааны ажиллагаа үе шатанд 82% буюу 544 минут, хэрэг хянан шийдвэрлэсний дараах үе шатанд 9% буюу 57 минут зарцуулдаг байна.

3. Ердийн журмаар хянан шийдвэрлэсэн иргэний хэргийн асуумжийн өгөгдөлд хийх шинжилгээ

Ердийн журмаар хянан шийдвэрлэсэн иргэний хэргийн асуумжийн судалгаанд нийт 24 шүүхийн 40 шүүгч иргэний хэрэг маргааныг хянан шийдвэрлэхэд ашигладаг 6 хуулийн хувьд 229 асуумж өгснөөс 21 шүүхийн 23 шүүгчийн 129 өгөгдлийг судалгаанд ашиглав. Үүнээс Чингэлтэй дүүрэг, Увс, Замын-Үүд шүүхийн асуумжийн өгөгдлийг судалгаанаас хасав. Дүүргийн төвийн 6 дүүргийн Иргэний хэргийн шүүгч нар ердийн журмаар иргэний хэргийг



шийдэхэд 1071 минут, захын дүүргийн шүүгч нар 1280 минут, аймгийн шүүгчид 1229, Сум дундын шүүхийн шүүгчид 798 минут зарцуулдаг гэсэн байна.

Иргэний хэргийн шүүгчид Иргэний хуулиар ердийн журмаар хэрэг маргаан эцэслэн шийдэхэд 1346 минут, ИХШХШТХ-иар ердийн журмаар хэрэг маргаан эцэслэн шийдэхэд 1222 минут, Гэр бүлийн тухай хуулиар ердийн журмаар хэрэг, маргаан эцэслэн шийдэхэд 1133 минут, Хөдөлмөрийн тухай хуулиар ердийн журмаар хэрэг маргаан эцэслэн шийдэхэд 1164 минут, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулиар ердийн журмаар хэрэг маргаан эцэслэн шийдэхэд 1153 минут, бусад хуулиар ердийн журмаар хэрэг маргаан эцэслэн шийдэхэд 1164 минут тус тус зарцуулдаг байна. Иргэний хэрэг үүсгэх эсэхийг шийдвэрлэх үе шатанд дунджаар нэг хэрэг, маргааныг хянан шийдвэрлэхэд нийт хугацааны 4% буюу 51 минут, хэрэг үүсгэснээс хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцүүлэх шийдвэр гаргах хүртэлх хугацааны ажиллагааны үе шатанд 41% буюу 480 минут, хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхэд бэлтгэх үе шатанд 50% буюу 575 минут, хэргийг эцэслэн шийдвэрлэсний дараах ажиллагааны үе шатанд 5% буюу 54 минут зарцуулдаг байна.

4. Давж заалдах шатны шүүхийн асуумжийн өгөгдөлд хийх шинжилгээ

Давж заалдах шатны шүүхийн судалгаанд нийт 11 шүүхийн 20 шүүгч иргэний хэрэг маргааныг хянан шийдвэрлэхэд ашигладаг 6 хуулийн хувьд 110 асуумж өгснөөс 8 шүүхийн 10 шүүгчийн 45 өгөгдлийг судалгаанд ашиглав. Үүнээс Говьсүмбэр, Дорноговь, Завхан шүүхийн асуумжийн өгөгдлийг судалгаанаас хасав. Аймгийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгч 1 хэрэг хянан шийдвэрлэхэд 1336 минут, Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгч 1 хэрэг хянан шийдвэрлэхэд 750 минут тус тус зарцуулдаг байна. Давж заалдах шатны шүүхийн 1 шүүгч иргэний хэргийг шийдэхэд зарцуулах хугацааг хууль тус бүрээр нь задалж харуулсан зургаас харвал Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулиар хамгийн их буюу 1658 минут зарцуулдаг гэсэн асуулга өгсөн байна. Бусад хуулиудын хувьд 926-1331 минут зарцуулдаг гэсэн байна. Хэргийг шүүгч хүлээн авах үе шатанд дунджаар нэг хэрэг, маргааныг хянан шийдвэрлэхэд нийт хугацааны 19% буюу 240 минут, хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхэд бэлтгэх, хэлэлцэх үе шатанд 80% буюу 995 минут, хэргийг шийдвэрлэсний дараах үе шатанд 1% буюу 14 минут зарцуулдаг байна.



3.3 Иргэний хэрэг хянан шийдвэрлэх үйл ажиллагааны ажиглалтын өгөгдөлд хийх шинжилгээ


Иргэний хэргийн шүүгчийн хянан шийдвэрлэсэн хэргийн ажиллагааны ачааллыг бодитой тодорхойлохын тулд ШЕЗ-ийн судалгаа шинжилгээний баг Иргэний хуульд заасан дараах маргааны төрлийн үзүүлэлтийн дагуу шүүгчийн ажлын байрны зураг авалт хийж, цуглуулсан өгөгдөлд хийсэн шинжилгээний үр дүнг энэ бүлэгт танилцуулна. Судалгаанд дараах маргааны төрөлд хамаарах ажлын байрны зураг авалтыг хийсэн байна. Үүнд:

1. Иргэний хуулиар
2. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулиар
3. Гэр бүлийн тухай хуулиар
4. Хөдөлмөрийн тухай хуулиар
5. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулиар
6. Бусад хуулиар

3.3.1 Хялбаршуулсан журмаар иргэний хэрэг хянан шийдвэрлэх үйл ажиллагааны ажиглалтын өгөгдөлд хийх шинжилгээ


3.3.1.1 Ажиглалтын өгөгдлийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны ерөнхий дүн ба үе шатуудын хувьд хийх шинжилгээ

Иргэний хэрэг хянан шийдвэрлэдэг шүүгчийн ажлын ажиллагааны ачааллыг бодитой тодорхойлохын тулд Хан-Уул, Багануур дүүргийн тус тус нэг шүүгчийн хялбаршуулсан журмаар иргэний хэрэг хянан шийдвэрлэх үйл ажиллагаанд ажлын байрны зураг авалт хийж, өгөгдөл цуглуулан шинжилгээ хийсэн үр дүнг танилцуулж байна.



Зураг 3.3.1 Хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэхэд зарцуулах хугацааны тухай ажиглалтын өгөгдлийн ерөнхий мэдээлэл

Иргэний хуулийн тусгай ангид заасан маргааны төрөл тус бүрийн ажиллагаанд зарцуулах хугацааны тухай Хан-Уул, Багануур дүүргийн Иргэний хэргийн хоёр шүүгчийн ажлын байрны зураг авалтын үр дүнд цуглуулсан 24 өгөгдөлд хийсэн 3 хүчин зүйлийн дисперсийн шинжилгээний үр дүнг Зураг 3.3.1-д харуулав. Зургаас харвал Хан-Уул дүүргийн Иргэний хэргийн шүүгч 1 иргэний хэргийг хялбаршуулсан журмаар шийдэхэд 447 минут, Багануур дүүргийн шүүгч 388 минут зарцуулдаг байна. Харин шүүгч 1 иргэний хэргийг хялбаршуулсан журмаар шийдэхэд 389 минут зарцуулдаг бол ерөнхий шүүгч 446 минут зарцуулдаг байна.



Зураг 3.3.2 Хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэхэд зарцуулах хугацааны тухай ажиглалтын өгөгдөл, маргааны төрөл ба дүүргээр



Хэрэг хянан шийдвэрлэх хугацааг Иргэний хэргийн маргааны төрөл тус бүрээр нь задалж харуулсан зургаас харвал судалгаанд хамрагдсан маргааны төрлүүдийн хувьд 376-448 минут зарцуулдаг байна. Харин Иргэний хэргийн хуулиар шийдвэрлэх маргаанд хамгийн их буюу 519 минут зарцуулдаг байна. Зураг авалтад хамрагдсан хоёр дүүргийн шүүхийн хувьд Багануур дүүргийн шүүгч судалгаанд хамрагдсан маргааны төрлүүдийн хувьд 348-472 минут зарцуулдаг байхад Хан-Уул дүүргийн шүүгч 376-566 минут зарцуулдаг төлөв ажиглагдсан байна. Дисперсийн шинжилгээний программын үр дүнгээр детерминац, корреляц, вариацийн коэффициентийг тооцсон үр дүнг дараах хүснэгтээр харуулъя.

№	Үзүүлэлт	Детерминацийн коэффициент	Корреляцийн коэффициент	Вариацийн коэффициент	Дундаж
1	Хэрэг	0.02	0.14	33%	417
2	Шүүгч	0.01	0.11	27%	
3	Шүүх, Хэрэг	0.17	0.41	9%	

Хүснэгт 3.3.1 Ажиглалтын өгөгдлийн хэрэг хянан шийдвэрлэх хугацаанд нөлөөлөх хүчин зүйлүүд


Хүснэгтийн гуравдугаар мөрийн утгыг тайлбарлая. Хэргийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэхэд зарцуулах хугацааны өөрчлөлтийн 0.17 нь хэргийн маргааны төрөл ба шүүхийн тогтолцооноос хамаарч байна. Хэргийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэхэд зарцуулах хугацаа иргэний хэргийн маргааны төрлөөс 0.41 буюу дунд зэрэг хамааралтай байна. Вариацийн коэффициент 9% байгаа нь дунджийг бусад тоон утгыг төлөөлөх чадвартай гэж үзнэ. Мөн шүүгчийн ангилал (ерөнхий шүүгч, шүүгч), шүүхийн тогтолцоо ба маргааны төрлийн зарцуулах хугацааны хувьд дундаж утгыг судалгаанд цааш нь ашиглах боломжтой.

Хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үе шат дараах үндсэн гурван үе шатаас бүрдэх бөгөөд шинжилгээний үр дүнг харуулъя.




Зураг 3.3.3 Хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үндсэн үе шат

Хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцүүлэх, шийдвэр гаргах үе шатанд 85.9% буюу 359 минут, хэрэг хянан шийдвэрлэсний дараах үе шатанд 3.4% Зураг 3.3.3-аас харвал иргэний хэрэг үүсгэх эсэхийг шийдвэрлэх үе шатанд дунджаар нэг хэргийг хянан шийдвэрлэхэд нийт хугацааны 10.8% буюу 45 минут, хэргийг шүүх хуралдаанаар буюу 14 минут тус тус зарцуулдаг байна.



Зураг 3.3.4 Дүүргүүдийн хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд зарцуулах хугацаа, хэргийн үе шатаар

Зураг 3.3.3-д харуулсан үр дүнг судалгаанд хамрагдсан шүүх тус бүрээр задалж харуулбал хэргийн 1 ба 3-р үед шатанд Багануур, Хан-Уул дүүргүүд ижил шахам хугацаа хугацаа зарцуулдаг байна. Хэргийн 2-р үед Хан-Уул дүүрэг Багануур дүүргээс 58 минутаар илүү хугацаа зарцуулдаг байна.




Зураг 3.3.5 Хэрэг хянан шийдвэрлэх үе шатанд хамаарах ажиллагааны хугацаа, маргааны төрлөөр

Зураг 3.3.3-д харуулсан ерөнхий мэдээллийг Иргэний хэргийн маргааны төрөл тус бүрээр Зураг 3.3.5-д задалж оруулав. Зургаас харвал хэрэг хянан шийдвэрлэх 1-р үе шатанд бүх маргааны төрлийн ажиллагаанд зарцуулах хугацаа 40-56 минут байна. Хэрэг хянан шийдвэрлэх 2-р үе шатанд судалгаанд авсан бүх маргааны төрлийн ажиллагаанд зарцуулах хугацаа 320-446 минут байна. Хэргийн 3-р үе шатанд бүх маргааны төрлийн ажиллагаанд зарцуулах хугацаа 12-17 минут орчим байна. Хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх 1, 3-р үеийн шатны үйл ажиллагаанд зарцуулах хугацаа нь бүх маргааны төрлийн хувьд ойролцоо дүнтэй харагдаж байна.

3.3.1.2 Хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны 1-3-р үе шатанд зарцуулах хугацааны өгөгдөлд хийх шинжилгээ


• Иргэний хэрэг үүсгэх эсэхийг шийдвэрлэх үе шат

Өмнөх бүлгийн Зураг 3.3.3-д харуулсан хэрэг хянан шийдвэрлэх үе шатыг ямар төрлийн ажиллагаанаас хамаарч харилцан адилгүй хугацаа зарцуулж байгааг 1-р үеийн хэргийн ажиллагаа тус бүрээр задалж харуулсан үр дүнг танилцуулъя.




Зураг 3.3.6 Хялбаршуулсан журмаар иргэний хэрэг үүсгэх эсэхийг шийдвэрлэх үеийн ажиллагаа

Зураг 3.3.6-аас харвал шүүгч иргэний хэрэг үүсгэх эсэхийг шийдвэрлэх үе шатанд зарцуулах нийт хугацааны 17.8% буюу 8 минутыг нэхэмжлэлд хавсаргасан баримттай танилцахад, 24.4% буюу 11 минутыг ИХШХШТХ-д заасан татгалзах үндэслэл байгаа эсэхийг шалгасан туслахын ажиллагааг хянахад, 57.8% буюу 26 минутыг иргэний хэрэг үүсгэх, үл үүсгэх тухай захирамжийн төслийн ажиллагаанд тус тус зарцуулдаг байна.



Зураг 3.3.7 Дүүргүүдийн иргэний хэрэг үүсгэх эсэхийг шийдвэрлэх үеийн ажиллагаанд зарцуулах хугацаа


Зураг 3.3.6-д харуулсан үр дүнг судалгаанд хамрагдсан шүүх тус бүрээр задалж харуулбал иргэний хэрэг үүсгэх эсэхийг шийдвэрлэх үе шатны нэхэмжлэлд хавсаргасан баримттай танилцах, ИХШХШТХ-д заасан татгалзах үндэслэл байгаа эсэхийг шалгасан туслахын ажиллагааг хянах, иргэний хэрэг үүсгэх, үл үүсгэх тухай захирамжийн төслийн ажиллагаанд зарцуулах хугацаа ойролцоо байна.



Зураг 3.3.8 Ажиглалтын өгөгдлийн хялбаршуулсан журмаар иргэний хэрэг үүсгэх эсэхийг шийдвэрлэх үеийн ажиллагаанд зарцуулах хугацаа, маргааны төрлөөр


Зураг 3.3.6-д харуулсан шүүгч иргэний хэрэг үүсгэх эсэхийг шийдвэрлэх үе шатанд зарцуулах нийт хугацааг маргааны төрлөөр Зураг 3.3.8-д задалж харуулав. Хэрэг хянан шийдвэрлэх 1-р үе шат буюу иргэний хэрэг үүсгэх эсэхийг шийдвэрлэх үе шатны нэхэмжлэлд хавсаргасан баримттай танилцах ажиллагаанд бүх маргааны төрлийн хувьд 6-12 минут зарцуулдаг байна. ИХШХШТХ-д заасан татгалзах үндэслэл байгаа эсэхийг шалгасан туслахын ажиллагааг хянах ажиллагаанд зарцуулах хугацаа бүх маргааны төрлийн хувьд 10-15 минут байна. Иргэний хэрэг үүсгэх, үл үүсгэх тухай захирамжийн төслийн ажиллагаанд 24-29 минут зарцуулдаг байна.

• **Хялбаршуулсан журмаар хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхэд бэлтгэх үе**



Зураг 3.3.9 Хялбаршуулсан журмаар хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцүүлэх, шийдвэр гаргах үеийн ажиллагааны задаргаа


Зураг 3.3.9-өөс харвал Иргэний хэргийн шүүгч хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцүүлэх, шийдвэр гаргах үе шатанд зарцуулах нийт хугацааны 8.7% буюу 31 минутыг хариуцагчид хүргүүлэх мэдэгдэх хуудас, хариуцагчид нэхэмжлэлийн хувь гардуулсан баримт, хариуцагчид эрх, үүрэг тайлбарласан баримт, нөлөөллийн мэдүүлгийн мэдээлэл өгсөн баримт зэрэг ажиллагаанд, 5% буюу 18 минутыг хариу тайлбартай танилцах ажиллагаанд, 44.4% буюу 159 минутыг хэргийн оролцогчийн ХХША-тай холбоотой хүсэлтийн шийдвэр гаргах ажиллагаанд, 32.1% буюу 115 минутыг хэргийн материалтай танилцах ажиллагаанд, 9.8% буюу 35 минутыг шүүгчийн захирамж гаргах ажиллагаанд тус тус зарцуулдаг байна.



Зураг 3.3.10 Дүүргүүдийн хялбаршуулсан журмаар хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцүүлэх, шийдвэр гаргах үеийн ажиллагаанд зарцуулах хугацаа




Зураг 3.3.9-д харуулсан үр дүнг судалгаанд хамрагдсан шүүх тус бүрээр задалж харуулбал шүүгчийн захирамж гаргах ажиллагааны хувьд Хан-Уул дүүрэг Багануур дүүргээс 4.5 дахин их хугацаа зарцуулдаг байна. Энэ үе шатны бусад ажиллагааны хувьд судалгаанд хамрагдсан дүүргүүдийн зарцуулах хугацаа ойролцоо байна.




Зураг 3.3.11 Ажиглалтын өгөгдлийн хялбаршуулсан журмаар хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцүүлэх, шийдвэр гаргах үеийн ажиллагаанд зарцуулах хугацаа, маргааны төрлөөр

Зураг 3.3.9-д харуулсан Иргэний хэргийн шүүгч хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцүүлэх, шийдвэр гаргах үе шатанд зарцуулах нийт хугацааг маргааны төрөл тус бүрээр Зураг 3.3.11-д задалж харуулав. Хэрэг хянан шийдвэрлэх 2-р үе шатны хэргийн оролцогчийн ХХША-тай холбоотой хүсэлтийн шийдвэр гаргах ажиллагаанд 138-192 минут, хэргийн материалтай танилцах ажиллагаанд бүх маргааны төрлийн хувьд 91-148 минут зарцуулдаг байна. Энэ үе шатны бусад ажиллагаа тус бүр бүх маргааны төрлийн хувьд ойролцоо хугацаа зарцуулдаг байна. Хэргийн оролцогчийн ХХША-тай холбоотой хүсэлтийн шийдвэр дотроо дараах 5 хэсгээс бүрдсэн байхаар ажиглалт явуулсан байсан тул үзүүлэлт бүрийн хувьд тооцсон үр дүнг дурдъя.



Зураг 3.3.12 Хэргийн оролцогчийн ХХША-тай холбоотой хүсэлтийн шийдвэрийн задаргаа


Зураг 3.3.9-д хэргийн оролцогчийн ХХША-тай холбоотой хүсэлтийн шийдвэр гаргахад 159 минут зарцуулдаг гэж үзсэн ерөнхий дүнг ажиллагаа тус бүрээр задалж үзэхэд шүүхийн шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах арга хэмжээ авахад 34 минут, ХХША-тай холбоотой ажиллагаанд 38 минут зарцуулдаг байна. Нотлох баримттай холбоотой ажиллагаанд 24 минут, гуравдагч этгээд оролцуулах ажиллагаанд 34 минут, бусад ажиллагаанд 29 минут тус тус зарцуулдаг байна.



Зураг 3.3.13 Хэргийн материалтай танилцах ажиллагааны задаргаа

Зураг 3.3.9-д хэргийн материалтай танилцахад 115 минут зарцуулдаг гэж үзсэн ерөнхий дүнг ажиллагаа тус бүрээр задалж үзэхэд хэргийн материалыг уншиж судлахад 28 минут, ХХША-г төлөвлөхөд 15 минут зарцуулдаг байна. Түүвэр гаргах ажиллагаанд


23 минут, шаардлагатай хууль тогтоомжийг судлахад 26 минут, шүүхийн практик судлахад 24 минут тус тус зарцуулдаг байна.



Зураг 3.3.14 Шүүгчийн захирамж гаргах ажиллагааны задаргаа

Зураг 3.3.9-д шүүгчийн захирамж гаргахад 35 минут зарцуулдаг гэж үзсэн ерөнхий дүнг ажиллагаа тус бүрээр задалж үзэхэд шүүгчийн захирамж боловсруулахад 13 минут, хянахад 23 минут тус тус зарцуулдаг байна.

• **Хэрэг хянан шийдвэрлэсний дараах үе шат**




Зураг 3.3.15 Хэрэг хянан шийдвэрлэсний дараах үе шатны ажиллагаа

Зураг 3.3.15-д Иргэний хэргийн шүүгчийн хэрэг хянан шийдвэрлэсний дараах үе шатанд зарцуулах нийт хугацааг тус шатны ажиллагаа тус бүрээр задалж тооцсон үр дүнг харуулав. Гүйцэтгэх хуудас хянаж, гарын үсэг зурахад энэ үе шатанд зарцуулах нийт хугацааны 28.5% буюу 3-4 минут, эмхэтгэсэн хэргийг хянаж баримтад гарын үсэг зурахад 71.5% буюу 9 минут тус тус зарцуулдаг нь ажиглалтаар харагдав.



Зураг 3.3.16 Дүүргүүдийн хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэсний дараах үеийн ажиллагаанд зарцуулах хугацаа

Зураг 3.3.15-д харуулсан үр дүнг шүүхээр задалж харуулбал гүйцэтгэх хуудас хянаж, гарын үсэг зурахад 3-4 минут буюу ойролцоо хугацаа зарцуулдаг байна. Эмхэтгэсэн хэргийг хянаж баримтад гарын үсэг зурахад 8 ба 10 минут буюу мөн ойролцоо хугацаа зарцуулдаг байна.



Зураг 3.3.17 Ажиглалтын өгөгдлийн хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэсний дараах үеийн ажиллагаанд зарцуулах хугацаа, маргааны төрлөөр


Хэрэг хянан шийдвэрлэх 3-р үе шатны хувьд бүх маргааны төрлөөр гүйцэтгэх хуудас хянаж, гарын үсэг зурахад 3-4 минут буюу ойролцоо хугацаа, эмхэтгэсэн хэргийг хянаж баримтад гарын үсэг зурахад 7-10 минут зарцуулдаг байна. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулиар эмхэтгэсэн хэргийг хянаж баримтад гарын үсэг зурахад хамгийн бага буюу 5 минут зарцуулдаг байна. Иргэний хуулиар эмхэтгэсэн хэргийг хянаж баримтад гарын үсэг зурахад хамгийн их буюу 13 минут зарцуулдаг байна.



3.3.2 Ердийн журмаар хянан шийдвэрлэсэн иргэний хэргийн ажиглалтын өгөгдөлд хийх шинжилгээ


3.3.2.1 Ажиглалтын өгөгдлийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны ерөнхий дүн ба үе шатуудын хувьд хийх шинжилгээ

Иргэний хэрэг хянан шийдвэрлэдэг шүүгчийн ажлын ажиллагааны ачааллыг бодитой тодорхойлохын тулд Хан-Уул, Багануур дүүргийн тус тус нэг шүүгчийн ердийн журмаар иргэний хэрэг хянан шийдвэрлэх үйл ажиллагаанд ажлын байрны зураг авалт хийж, өгөгдөл цуглуулан шинжилгээ хийсэн үр дүнг танилцуулж байна.



Зураг 3.3.18 Ердийн журмаар хэрэг хянан шийдвэрлэхэд зарцуулах хугацааны тухай ажиглалтын өгөгдлийн ерөнхий мэдээлэл

Иргэний хуулийн маргааны төрлийн ажиллагаанд зарцуулах хугацааны тухай Хан-Уул, Багануур дүүргийн Иргэний хэргийн хоёр шүүгчийн ажлын байрны зураг авалтын үр дүнд цуглуулсан 24 өгөгдөлд хийсэн 3 хүчин зүйлийн дисперсийн шинжилгээний үр дүнг Зураг 3.3.18-д харуулав. Зургаас харвал Хан-Уул дүүргийн Иргэний хэргийн шүүгч 1 иргэний хэргийг ердийн журмаар хянан шийдвэрлэхэд 1177 минут, Багануур дүүргийн шүүгч 964 минут зарцуулдаг байна. Шүүгч 1 иргэний хэргийг ердийн журмаар хянан шийдвэрлэхэд 1060 минут зарцуулдаг бол ерөнхий шүүгч 1082 минут зарцуулдаг байна.



Зураг 3.3.19 Ердийн журмаар хэрэг хянан шийдвэрлэхэд зарцуулах хугацааны тухай ажиглалтын өгөгдөл, маргааны төрөл ба дүүргээр

Хэрэг хянан шийдвэрлэх хугацааг Иргэний хэргийг маргааны төрлөөр нь задалж харуулсан зургаас харвал судалгаанд хамрагдсан маргааны төрлүүдийн хувьд 811-1380 минут зарцуулдаг байна. Зураг авалтад хамрагдсан хоёр дүүргийн шүүхийн хувьд Багануур дүүргийн шүүгч судалгаанд хамрагдсан хэргийн зүйл ангиудын хувьд 772-1237 минут зарцуулдаг байхад Хан-Уул дүүргийн шүүгч 881-1522 минут зарцуулдаг төлөв ажиглагдсан байна.

Дисперсийн шинжилгээний программын үр дүнгээр детерминац, корреляц, вариацийн коэффициентийг тооцсон үр дүнг дараах хүснэгтээр харуулья.

№	Үзүүлэлт	Детерминацийн коэффициент	Корреляцийн коэффициент	Вариацийн коэффициент	Дундаж
1	Шүүгч	0.29	0.53	5%	1071
2	Шүүх, Шүүгч	0.19	0.44	6%	
3	Шүүх, Хэрэг	0.07	0.27	11%	

Хүснэгт 3.3.2 Ажиглалтын өгөгдлийн хэрэг хянан шийдвэрлэх хугацаанд нөлөөлөх хүчин зүйлүүд

Хүснэгтийн зөвхөн 1-р мөрний утгыг тайлбарлая. Хэргийг ердийн журмаар хянан шийдвэрлэхэд зарцуулах хугацааны өөрчлөлтийн 0.29 нь шүүгчийн ангилал (ерөнхий шүүгч, шүүгч)-аас хамаарч байна. Хэргийг ердийн журмаар хянан шийдвэрлэхэд зарцуулах хугацаа шүүгчийн ангиллаас 0.53 буюу дунд зэрэг хамааралтай байна.




Вариацийн коэффициент 5% тул тоон үзүүлэлтүүд нэгэн төрлийн бөгөөд дунджийг бусад тоон утгыг төлөөлөх чадвартай гэж үзнэ. Мөн шүүгчийн ангилал (ерөнхий шүүгч, шүүгч), шүүхийн тогтолцоо ба хэргийн төрөл, зүйл ангид зарцуулах хугацааны хувьд дундаж утгыг судалгаанд цааш нь ашиглах боломжтой.

Ердийн журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үе шат дараах үндсэн дөрвөн үе шатаас бүрдэх бөгөөд шинжилгээний үр дүнг харуулъя.




Зураг 3.3.20 Ердийн журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үндсэн үе шат

Зураг 3.3.20-оос харвал иргэний хэрэг үүсгэх эсэхийг шийдвэрлэх үе шатанд дунджаар нэг хэргийг хянан шийдвэрлэхэд нийт хугацааны 5.5% буюу 59 минут, хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцүүлэх тухай шийдвэр гаргах үе шатанд 43.2% буюу 461 минут, хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхэд бэлтгэх, хэлэлцэх үе шатанд 47% буюу 501 минут, хэрэг хянан шийдвэрлэсний дараах үе шатанд 4.2% буюу 45 минут тус тус зарцуулдаг байна.



Зураг 3.3.21 Дүүргүүдийн ердийн журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд зарцуулах хугацаа, хэргийн үе шатаар

Зураг 3.3.20-д харуулсан үр дүнг судалгаанд хамрагдсан шүүх тус бүрээр задалж харуулбал хэргийн 1-р үед шатанд Багануур, Хан-Уул дүүргүүд ойролцоо хугацаа, хэргийн 2-р үед шатанд Хан-Уул дүүрэг Багануур дүүргээс 1.3 дахин их хугацаа, хэргийн 3-р үед шатанд 1.1 дахин их хугацаа, хэргийн 4-р үед Хан-Уул дүүрэг Багануур дүүргээс 1.7 дахин их хугацааг тус тус зарцуулдаг байна.



Зураг 3.3.22 Хэрэг хянан шийдвэрлэх үе шатанд хамаарах ажиллагааны хугацаа, маргааны төрлөөр

Зураг 3.3.20-д харуулсан ерөнхий мэдээллийг Иргэний хэргийн маргааны төрөл тус бүрээр Зураг 3.3.22-д дэлгэрэнгүй оруулав. Зургаас харвал хэрэг хянан шийдвэрлэх 1-р үе шатанд бүх маргааны төрлийн ажиллагаанд зарцуулах хугацаа 41-81 минут байна. Хэрэг хянан шийдвэрлэх 2-р үе шатанд судалгаанд авсан бүх маргааны төрлийн ажиллагаанд зарцуулах хугацаа 419-525 минут байна. Хэргийн 3-р үе шатанд маргааны төрлүүдийн ажиллагаанд зарцуулах хугацаа харилцан адилгүй байна. Жишээ нь иргэний хэргийн хуулиар маргааныг шийдвэрлэхэд 740 минут бол гэр бүлийн хууль, ИХШХШТХ-ийн хуулиар маргааныг шийдвэрлэхэд 313 минут зарцуулдаг байна. Хэргийн 4-р үе шатанд бүх маргааны төрлийн ажиллагаанд зарцуулах хугацаа 42-58 минут байна.



3.3.2.2 Ердийн журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны 1-4-р үе шатанд зарцуулах хугацааны өгөгдөлд хийх шинжилгээ

• Иргэний хэрэг үүсгэх эсэхийг шийдвэрлэх үе шат

Зураг 3.3.20-д харуулсан хэрэг хянан шийдвэрлэх үе шатыг ямар төрлийн ажиллагаанаас хамаарч харилцан адилгүй хугацаа зарцуулж байгааг 1-р үеийн хэргийн ажиллагаа тус бүрээр задалж харуулсан үр дүнг танилцуулъя.




Зураг 3.3.23 Ердийн журмаар хэрэг хянан шийдвэрлэх үеийн иргэний хэрэг үүсгэх эсэхийн шийдвэрлэх үеийн ажиллагаа

Зураг 3.3.23-аас харвал Иргэний хэргийн шүүгч иргэний хэрэг үүсгэх эсэхийн шийдвэрлэх үе шатанд зарцуулах нийт хугацааны 26.5% буюу 16 минутыг нэхэмжлэлд хавсаргасан баримттай танилцахад, 34.6% буюу 20 минутыг ХШХШТХ-д заасан татгалзах үндэслэлийг шалгасан туслахын ажиллагааг хянахад, 38.9% буюу 23 минутыг иргэний хэрэг үүсгэх, үл үүсгэх тухай захирамжийн төсөл гаргах ажиллагаанд тус тус зарцуулдаг байна.



Зураг 3.3.24 Дүүргүүдийн ердийн журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны иргэний хэрэг үүсгэх эсэхийн шийдвэрлэх үеийн ажиллагаанд зарцуулах хугацаа

Зураг 3.3.24-д харуулсан үр дүнг судалгаанд хамрагдсан шүүх тус бүрээр задалж харуулбал нэхэмжлэлд хавсаргасан баримттай танилцахад 12, 19 минут, ХШХШТХ-д заасан татгалзах үндэслэлийг шалгасан туслахын ажиллагааг хянахад 17, 24 минут, иргэний хэрэг үүсгэх, үл үүсгэх тухай захирамжийн төсөл гаргах ажиллагаанд дүүргүүд ижил хугацаа зарцуулдаг байна.



Зураг 3.3.25 Ажиглалтын өгөгдлөөр ердийн журмаар иргэний хэрэг үүсгэх эсэхийн шийдвэрлэх үеийн ажиллагаанд зарцуулах хугацаа, маргааны төрлөөр

Зураг 3.3.23-д харуулсан Иргэний хэргийн шүүгч иргэний хэрэг үүсгэх эсэхийн шийдвэрлэх үе шатанд зарцуулах нийт хугацааг хэргийн төрөл тус бүрээр Зураг 3.3.25-д задалж харуулав. Хэрэг хянан шийдвэрлэх 1-р үе шат болох иргэний хэрэг үүсгэх эсэхийн шийдвэрлэх үе шатны нэхэмжлэлд хавсаргасан баримттай танилцах ажиллагаанд иргэний хэргийн бүх маргааны төрлийн хувьд 13-21 минут зарцуулдаг байна. Бусад хуулиар нэхэмжлэлд хавсаргасан баримттай танилцах хугацаа харьцангуй их байна. ХШХШТХ-д заасан татгалзах үндэслэлийг шалгасан туслахын ажиллагааг




хянах ажиллагаанд зарцуулах хугацаа бүх маргааны төрлийн хувьд 15-25 минут байна. Иргэний хэрэг үүсгэх, үл үүсгэх тухай захирамжийн төсөл гаргах ажиллагаанд зарцуулах хугацаа ихэнх маргааны төрлийн хувьд 22-35 минут байна. ИХШХШТХ-ийн хуулиар маргааныг хянан шийдвэрлэхэд зарцуулах хугацаа 14 минут буюу хамгийн бага хугацаа зарцуулдаг байна.

• *Хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцүүлэх тухай шийдвэр гаргах үе шат*




Зураг 3.3.26 Ердийн журмаар хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцүүлэх тухай шийдвэр гаргах үеийн ажиллагаа

Зураг 3.3.26-аас харвал Иргэний хэргийн шүүгч хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцүүлэх тухай шийдвэр гаргах ажиллагааны үе шатанд зарцуулах нийт хугацааны 8.3% буюу 38-39 минутыг хариуцагчид хүргүүлэх мэдэгдэх хуудас, хариуцагчид нэхэмжлэлийн хувь гардуулсан баримт, хариуцагчид эрх, үүрэг тайлбарласан баримт, нөлөөллийн мэдүүлгийн мэдээлэл өгсөн баримт, шүүгчийн захирамж зэрэг ажиллагаанд, 4.6% буюу 21 минутыг хариу тайлбартай танилцах ажиллагаанд, 34.9% буюу 161 минутыг хэргийн оролцогчийн ХХША-тай холбоотой хүсэлтийн шийдвэр гаргахад, 42.5% буюу 196 минутыг хэргийн материалтай танилцахад, 9.8% буюу 45 минутыг шүүх хуралдааны тов тодруулах, товын тухай шүүгчийн туслахад чиглэл өгөх зэрэг ажиллагаанд тус тус зарцуулдаг байна.




Зураг 3.3.27 Дүүргүүдийн ердийн журмаар хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцүүлэх тухай шийдвэр гаргах үеийн ажиллагаанд зарцуулах хугацаа

Зураг 3.3.26-д харуулсан үр дүнг судалгаанд хамрагдсан шүүх тус бүрээр задалж харуулбал хариу тайлбартай танилцах, хэргийн оролцогчийн ХХША-ны хүсэлтийн шийдвэр гаргах ажиллагаанд зарцуулах хугацаа хоёр дүүргийн хувьд ойролцоо байна. Харин хэргийн материалтай танилцахад Багануур дүүрэг Хан-Уул дүүргээс 1.8 дахин бага хугацаа зарцуулдаг байхад шүүх хуралдааны тов тодруулах ажиллагааны хувьд Багануур дүүрэг Хан-Уул дүүргээс 2 дахин их хугацаа зарцуулдаг байна.




Зураг 3.3.28 Ажиглалтын өгөгдлийн ердийн журмаар хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцүүлэх тухай шийдвэр гаргах үеийн ажиллагаанд зарцуулах хугацаа, маргааны төрлөөр

Зураг 3.3.26-д харуулсан хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцүүлэх тухай шийдвэр гаргах ажиллагаанд зарцуулах нийт хугацааг маргааны төрөл тус бүрээр Зураг 3.3.28-д задалж харуулав. Хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцүүлэх тухай шийдвэр гаргах үе буюу 2-р үе шатанд хийгддэг ажиллагаанууд дотроос хариуцагчид хүргүүлэх мэдэгдэх хуудас, хариуцагчид нэхэмжлэлийн хувь гардуулсан баримт, шүүгчийн захирамж, шүүх хуралдааны тов тодруулах, товын тухай шүүгчийн туслахад чиглэл өгөх зэрэг ажиллагаанд зарцуулах хугацаанууд маргааны төрөл тус бүрийн хувьд ижил байна. Харин хариуцагчид эрх, үүрэг тайлбарласан баримт, нөлөөллийн мэдүүлгийн мэдээлэл өгсөн баримт, хариу тайлбартай танилцах зэрэг ажиллагаанд зарцуулах хугацаа 3-10 минутын хэлбэлзэлтэйгээр ялгаатай байна. Хэргийн оролцогчийн ХХША-тай холбоотой хүсэлтийн шийдвэр гаргах, хэргийн материалтай танилцах ажиллагаа нь маргааны төрөл тус бүрээр харилцан адилгүй хугацаа зарцуулдаг үр дүн харагдаж байна. Хэрэг хянан шийдвэрлэх 2-р үе шатны хэргийн оролцогчийн ХХША-тай холбоотой хүсэлтийн шийдвэр гаргах ажиллагаа дотроо дараах 5 хэсгээс бүрдсэн байхаар задалж ажиглалт явуулсан байсан тул үзүүлэлт бүрийн хувьд тооцсон үр дүнг дурдъя.



Зураг 3.3.29 Ердийн журмаар хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцүүлэх тухай шийдвэр гаргах үеийн хэргийн оролцогчийн ХХША-тай холбоотой хүсэлтийн шийдвэр гаргах ажиллагааны задаргаа

Зураг 3.3.26-д дурдсан хэрэг хянан шийдвэрлэх 2-р үе шатны нийт ажиллагааны 34.9% буюу 161 минутыг эзлэх хэргийн оролцогчийн ХХША-тай холбоотой хүсэлтийн шийдвэр гаргах ажиллагааны ажиглалтын үр дүнг задалж үзэхэд шүүхийн шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах арга хэмжээнд 35 минут, ХХША - тай холбоотой ажиллагаанд 31 минут, нотлох баримттай холбоотой ажиллагаанд 31 минут, гуравдагч этгээд оролцуулах тухай ажиллагаанд 28 минут, бусад ажиллагаанд 36 минут тус тус зарцуулдаг болох нь тооцоогоор гарав.



Зураг 3.3.30 Ердийн журмаар хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцүүлэх тухай шийдвэр гаргах үеийн хэргийн материалтай танилцах ажиллагааны задаргаа




Зураг 3.3.26-д дурдсан хэрэг хянан шийдвэрлэх 2-р үе шатны нийт ажиллагааны 42.5% буюу 196 минутыг эзлэх хэргийн материалтай танилцах ажиллагааны ажиглалтын үр дүнг задалж харуулахад хэргийн материалыг уншиж судлахад 26 минут, ХХША-г төлөвлөхөд 15 минут, түүвэр гаргахад 32 минут, шаардлагатай хууль тогтоомжийг судлахад хамгийн их буюу 68 минут, шүүхийн практик судлахад 55 минут тус тус зарцуулдаг болох нь тооцоогоор гарав.



Зураг 3.3.31 Ердийн журмаар хэрэг хянан шийдвэрлэх үеийн шүүгчийн захирамж ажиллагааны задаргаа


Зураг 3.3.26-д дурдсан шүүгчийн захирамж гаргах ажиллагааны ажиглалтын үр дүнг задалж үзэхэд хянах, гарын үсэг зурахад 4 минут зарцуулдаг байна. Шүүгчийн захирамж боловсруулах ажиллагааны ажиглалтын өгөгдөл задарч орж ирээгүй тул 0-ээр тэмдэглэв.

• **Ердийн журмаар хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхэд бэлтгэх, хэлэлцэх үе**




Зураг 3.3.32 Ердийн журмаар хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхэд бэлтгэх, хэлэлцэх үед зарцуулах хугацаа

Зураг 3.3.32-оос харвал хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхэд бэлтгэх, хэлэлцэх үе шатанд зарцуулах нийт хугацааны 1.7% буюу 9 минутыг шүүх хуралдааны тов мэдэгдэх хуудсыг хянах, гарын үсэг зурах, шүүхийн иргэдийн төлөөлөгчид мэдээлэл өгсөн баримтыг хянах, гарын үсэг зурах ажиллагаанд, 22.1% буюу 110 минутыг шүүх хуралдаан явуулах ажиллагаанд, 9.6% буюу 48 минутыг шүүх хуралдааны тэмдэглэл хянах, гарын үсэг зурах ажиллагаанд, 66.5% буюу 331 минутыг шийдвэр боловсруулах, хянах, гарын үсэг зурах ажиллагаанд тус тус зарцуулдаг байна.




Зураг 3.3.33 Дүүргүүдийн ердийн журмаар хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхэд бэлтгэх, хэлэлцэх үеийн ажиллагаанд зарцуулах хугацаа

Зураг 3.3.32-д харуулсан үр дүнг судалгаанд хамрагдсан шүүх тус бүрээр задалж харуулбал хэрэг хянан шийдвэрлэх 3-р үе шатны зурагт харуулсан дээрх ажиллагаануудад хоёр дүүрэг ойролцоо хугацаа зарцуулдаг байна.




Зураг 3.3.34 Ажиглалтын өгөгдлийн хялбаршуулсан журмаар хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхэд бэлтгэх, хэлэлцэх үеийн ажиллагаанд зарцуулах хугацаа, маргааны төрлөөр

Зураг 3.3.32-д харуулсан Иргэний хэргийн шүүгчийн хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхэд бэлтгэх, хэлэлцэх ажиллагааны үе шатанд зарцуулах нийт хугацааг маргааны төрөл тус бүрээр Зураг 3.3.34-д задалж харуулав. Хэрэг хянан шийдвэрлэх 3-р үе шатны шүүх хуралдааны тов мэдэгдэх хуудсанд гарын үсэг зурахад бүх маргааны төрлийн хувьд 4-7 минут зарцуулдаг байна. Шүүхийн иргэдийн төлөөлөгчид мэдээлэл өгсөн баримтад гарын үсэг зурах ажиллагааны хувьд зурахад бүх маргааны төрлөөр 3-5 минут зарцуулдаг байна. Шүүх хуралдааны ажиллагаанд бүх маргааны төрлийн хувьд 65-165 минут зарцуулдаг бөгөөд маргааны төрөл тус бүрийн хувьд харилцан адилгүй хугацаа зарцуулдаг байна. Шүүх хуралдааны тэмдэглэл хянах, гарын үсэг зурахад ШШГТХ-аас бусад маргааны хувьд 40-91 минут зарцуулдаг байна. ШШГТХ-иар хэрэг хянан шийдвэрлэхэд 20 минут буюу хамгийн бага хугацаа зарцуулдаг байна. Шийдвэр боловсруулах, хянах ажиллагааны хувьд гэр бүл, ИХШХШТХ-иас бусад маргааны хувьд 349-473 минут зарцуулдаг байна. Зураг 3.3.32-д дурдсан хэрэг хянан шийдвэрлэх 3-р үе шатны нийт ажиллагааны 22.1% буюу 110 минутыг эзлэх шүүх хуралдаан явуулах ажиллагааны ажиглалтын үр дүнг судалгаанд ирсэн ажиглалтын өгөгдлөөр задалж харуулав.




Зураг 3.3.35 Шүүх хуралдааны задаргаа

Зургаас харвал шүүх хуралдаан хийхэд хамгийн их буюу 58 минут, зөвлөлдөхөд 38 минут, шийдвэрийн тогтоох хэсгийг танилцуулахад 15 минут тус тус зарцуулдаг болох нь тооцоогоор гарав. Шүүх хуралдааны хэлбэр ажиглалтын өгөгдлөөр задаргаатай ирсэн тул үзүүлэлт бүрийн хувьд тооцсон үр дүнг дурдъя.



Зураг 3.3.36 Шүүх хуралдаан явуулах хэлбэрийн хувьд зарцуулах хугацаа

Зургаас харвал шүүх хуралдааныг дангаар явуулах үед 66 минут, бүрэлдэхүүн даргалах үед 45 минут зарцуулна гэж үзсэн байна.



Зураг 3.3.37 Шүүхийн шийдвэр гаргах ажиллагааны задаргаа

Зураг 3.3.32-д хэрэг хянан шийдвэрлэх 3-р үе шатны 66.5% буюу 331 минутыг эзлэх шийдвэр боловсруулах ажиллагааны ерөнхий дүнг ажиллагаа тус бүрээр задалж үзэхэд шүүгчийн захирамж гаргахад 46 минут, шүүхийн шийтгэвэр гаргах ажиллагаанд



38 минут, шүүхийн тогтоолд 32 минут, шүүхийн шийдвэр гаргахад 214 минут зарцуулдаг байна.

• **Хэрэг хянан шийдвэрлэсний дараах үе шат**



Зураг 3.3.38 Хэрэг хянан шийдвэрлэсний дараах үеийн ажиллагааны задаргаа

Зураг 3.3.38-д хэрэг хянан шийдвэрлэсний дараах үе шатанд зарцуулах нийт хугацааг тус шатны ажиллагаа тус бүрээр задалж тооцсон үр дүнг харуулав. Энэ үе шатны нийт ажиллагаанд зарцуулах хугацааны 26% буюу 11 минутыг албадан гүйцэтгэх захирамж хянах, гарын үсэг зурахад, 18.7% буюу 8 минутыг гүйцэтгэх хуудас хянах, гарын үсэг зурахад, 55.3% буюу 24 минутыг эмхэтгэсэн хэргийг хянах, гарын үсэг зурах ажиллагаанд тус тус зарцуулдаг нь ажиглалтаар харагдав.



Зураг 3.3.39 Дүүргүүдийн ердийн журмаар хэрэг хянан шийдвэрлэсний дараах үеийн ажиллагаанд зарцуулах хугацаа

Зураг 3.3.38-д харуулсан үр дүнг шүүхээр задалж харуулбал албадан гүйцэтгэх захирамж ба гүйцэтгэх хуудас хянах, гарын үсэг зурахад Хан-Уул дүүрэг Багануур дүүргээс 5 минут илүү хугацаа зарцуулдаг байна. Эмхэтгэсэн хэргийг хянаж баримтад гарын үсэг зурахад мөн Хан-Уул дүүрэг Багануур дүүргээс 12 минут илүү хугацаа зарцуулдаг байна.



Зураг 3.3.40 Ажиглалтын өгөгдлийн ердийн журмаар хэрэг хянан шийдвэрлэсний дараах үеийн ажиллагаанд зарцуулах хугацаа, маргааны төрлөөр


Хэрэг хянан шийдвэрлэх 4-р үе шатны ажиллагаанд бүх маргааны төрлөөр хэрэг хянан шийдвэрлэхэд зарцуулах хугацааг харуулав. Албадан гүйцэтгэх захирамж хянах, гарын үсэг зурахад бүх маргааны төрлийн хувьд 9-16 минут зарцуулдаг байна. Гүйцэтгэх хуудас хянах, гарын үсэг зурахад бүх маргааны төрлийн хувьд 5-13 минут зарцуулдаг байна. Эмхэтгэсэн хэргийг хянаж баримтад гарын үсэг зурахад энэ үе шатны бусад ажиллагааг бодвол бага зэрэг их хугацаа зарцуулах бөгөөд бүх маргааны төрлийн хувьд 23-25 минут зарцуулдаг байна.



3.3.3 Бага үнийн дүнтэй иргэний хэргийн ажиглалтын өгөгдөлд хийх шинжилгээ


3.3.3.1 Ажиглалтын өгөгдлийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны ерөнхий дүн ба үе шатуудын хувьд хийх шинжилгээ

Иргэний хэрэг хянан шийдвэрлэдэг шүүгчийн ажлын ажиллагааны ачааллыг бодитой тодорхойлохын тулд Хан-Уул, Багануур дүүргийн тус тус нэг шүүгчийн бага үнийн дүнтэй иргэний хэрэг хянан шийдвэрлэх үйл ажиллагаанд ажлын байрны зураг авалт хийж, өгөгдөл цуглуулан шинжилгээ хийсэн үр дүнг танилцуулж байна.



Зураг 3.3.41 Бага үнийн дүнтэй хэрэг хянан шийдвэрлэхэд зарцуулах хугацааны тухай ажиглалтын өгөгдлийн ерөнхий мэдээлэл

Иргэний хуулийн бага үнийн дүнтэй хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаанд зарцуулах хугацааны тухай Хан-Уул, Багануур дүүргийн Иргэний хэргийн хоёр шүүгчийн ажлын байрны зураг авалтын үр дүнд цуглуулсан 24 өгөгдөлд хийсэн 3 хүчин зүйлийн дисперсийн шинжилгээний үр дүнг Зураг 3.3.41-д харуулав. Зургаас харвал Хан-Уул дүүргийн Иргэний хэргийн шүүгч нэг бага үнийн дүнтэй хэрэг хянан шийдвэрлэхэд 556 минут, Багануур дүүргийн шүүгч 635 минут зарцуулдаг байна. Харин шүүгч нэг бага үнийн дүнтэй хэрэг хянан шийдвэрлэхэд 589 минут зарцуулдаг бол ерөнхий шүүгч 602 минут зарцуулдаг байна.



Зураг 3.3.42 Бага үнийн дүнтэй хэрэг хянан шийдвэрлэхэд зарцуулах хугацааны тухай ажиглалтын өгөгдөл, маргааны төрөл ба дүүргээр

Хэрэг хянан шийдвэрлэх хугацааг иргэний хэргийг маргааны төрлөөр нь задалж харуулсан зургаас харвал судалгаанд хамрагдсан маргааны төрлүүдийн хувьд 568-670 минут зарцуулдаг байна. Зураг авалтад хамрагдсан шүүхийн хувьд Хан-Уул дүүргийн шүүгч бага үнийн дүнтэй бүх маргааны хувьд 499-651 минут зарцуулдаг байхад Багануур дүүргийн шүүгч 585-690 минут зарцуулдаг төлөв ажиглагдсан байна.

Дисперсийн шинжилгээний программын үр дүнгээр детерминац, корреляц, вариацийн коэффициентийг тооцсон үр дүнг дараах хүснэгтээр харуулъя.


№	Үзүүлэлт	Детерминацийн коэффициент	Корреляцийн коэффициент	Вариацийн коэффициент	Дундаж
1	Шүүгч	0.04	0.19	50%	596
2	Шүүх, Шүүгч	0.50	0.71	13.2%	

Хүснэгт 3.3.3 Ажиглалтын өгөгдлийн хэрэг хянан шийдвэрлэх хугацаанд нөлөөлөх хүчин зүйлүүд

Хүснэгтийн зөвхөн 1-р мөрний утгыг тайлбарлая. Бага үнийн дүнтэй хэргийг хянан шийдвэрлэхэд зарцуулах хугацааны өөрчлөлтийн 0.04 нь шүүгчийн ангилал (ерөнхий шүүгч, шүүгч)-аас хамаарч байна. Бага үнийн дүнтэй хэргийг хянан шийдвэрлэхэд зарцуулах хугацаа шүүгчийн ангиллаас 0.19 буюу сул хамааралтай байна. Вариацийн коэффициент 50% тул тоон үзүүлэлтүүд нэгэн төрлийн бөгөөд дунджийг бусад тоон утгыг төлөөлөх чадвартай гэж үзнэ.




Бага үнийн дүнтэй хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үе шат дараах үндсэн дөрвөн үе шатаас бүрдэх бөгөөд шинжилгээний үр дүнг харуулъя.




Зураг 3.3.43 Бага үнийн дүнтэй хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үндсэн үе шат

Зураг 3.3.43-аас харвал иргэний хэрэг үүсгэх эсэхийг шийдвэрлэх үе шатанд дунджаар нэг хэргийг хянан шийдвэрлэхэд нийт хугацааны 4.2% буюу 25 минут, хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцүүлэх тухай шийдвэр гаргах үе шатанд 4.2% буюу 25 минут, хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхэд бэлтгэх, хэлэлцэх үе шатанд 52.9% буюу 315 минут, хэрэг хянан шийдвэрлэсний дараах үе шатанд 38.8% буюу 231 минут тус тус зарцуулдаг байна.



Зураг 3.3.44 Дүүргүүдийн бага үнийн дүнтэй хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд зарцуулах хугацаа, хэргийн үе шатаар

Зураг 3.3.43-д харуулсан үр дүнг судалгаанд хамрагдсан шүүх тус бүрээр задалж харуулбал хэргийн 1, 4-р үед шатанд Багануур, Хан-Уул дүүргүүд ойролцоо хугацаа, хэргийн 2-р үед шатанд Хан-Уул дүүрэг Багануур дүүргээс 34 минутаар бага хугацаа, хэргийн 3-р үед шатанд 44 минутаар бага хугацаа тус тус зарцуулдаг байна.



Зураг 3.3.45 Хэрэг хянан шийдвэрлэх үе шатанд хамаарах ажиллагааны хугацаа, маргааны төрлөөр

Зураг 3.3.43-д харуулсан ерөнхий мэдээллийг Иргэний хэргийн маргааны төрөл тус бүрээр Зураг 3.3.45-д дэлгэрэнгүй оруулав. Зургаас харвал хэрэг хянан шийдвэрлэх 1-р үе шатанд бүх маргааны төрлийн ажиллагаанд зарцуулах хугацаа бүгд ижил буюу 25 минут байна. Хэрэг хянан шийдвэрлэх 2-р үе шатанд судалгаанд авсан бүх маргааны төрлийн ажиллагаанд зарцуулах хугацаа 293-344 минут байна. Хэргийн 3-р үе шатанд маргааны төрлүүдийн ажиллагаанд зарцуулах хугацаа харилцан адилгүй байна. Жишээ нь иргэний хэргийн хуулиар маргааныг шийдвэрлэхэд 274 минут бол ШШГТХ-иар маргааныг шийдвэрлэхэд 205 минут зарцуулдаг байна. Хэргийн 4-р үе шатанд бүх маргааны төрлийн ажиллагаанд зарцуулах хугацаа 22-28 минут байна.

3.3.3.2 Бага үнийн дүнтэй хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны 1-4-р үе шатанд зарцуулах хугацааны өгөгдөлд хийх шинжилгээ

• Иргэний хэрэг үүсгэх эсэхийг шийдвэрлэх үе шат

Зураг 3.3.43-д харуулсан хэрэг хянан шийдвэрлэх үе шатыг ямар төрлийн ажиллагаанаас хамаарч харилцан адилгүй хугацаа зарцуулж байгааг 1-р үеийн хэргийн ажиллагаа тус бүрээр задалж харуулсан үр дүнг танилцуулъя.




Зураг 3.3.46 Бага үнийн дүнтэй хэрэг хянан шийдвэрлэх үеийн иргэний хэрэг үүсгэх эсэхийн шийдвэрлэх үеийн ажиллагаа

Зураг 3.3.46-аас харвал Иргэний хэргийн шүүгч бага үнийн дүнтэй хэрэг үүсгэх эсэхийн шийдвэрлэх үе шатанд зарцуулах нийт хугацааны 40% буюу 10 минутыг нэхэмжлэлд хавсаргасан баримттай танилцахад, 20% буюу 5 минутыг ИХШХШТХ-д заасан татгалзах үндэслэлийг шалгасан туслахын ажиллагааг хянахад, 40% буюу 10 минутыг иргэний бага үнийн дүнтэй хэрэг үүсгэх, үл үүсгэх тухай захирамжийн төсөл гаргах ажиллагаанд тус тус зарцуулдаг байна.



Зураг 3.3.47 Дүүргүүдийн бага үнийн дүнтэй хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны иргэний хэрэг үүсгэх эсэхийн шийдвэрлэх үеийн ажиллагаанд зарцуулах хугацаа

Зураг 3.3.47-д харуулсан үр дүнг судалгаанд хамрагдсан шүүх тус бүрээр задалж харуулбал нэхэмжлэлд хавсаргасан баримттай танилцахад 10 минут, ИХШХШТХ-д заасан татгалзах үндэслэлийг шалгасан туслахын ажиллагааг хянахад 5 минут, иргэний хэрэг үүсгэх, үл үүсгэх тухай захирамжийн төсөл гаргах ажиллагаанд дүүргүүд 10 минут ижил хугацаа зарцуулдаг байна.



Зураг 3.3.48 Ажиглалтын өгөгдлийн бага үнийн дүнтэй хэрэг үүсгэх эсэхийн шийдвэрлэх үеийн ажиллагаанд зарцуулах хугацаа, маргааны төрлөөр


Зураг 3.3.46-д харуулсан Иргэний хэргийн шүүгч бага үнийн дүнтэй хэрэг үүсгэх эсэхийн шийдвэрлэх үе шатанд зарцуулах нийт хугацааг хэргийн төрөл тус бүрээр Зураг 3.3.48-д задалж харуулав. Хэрэг хянан шийдвэрлэх 1-р үе шат болох иргэний хэрэг үүсгэх эсэхийн шийдвэрлэх үе шатны нэхэмжлэлд хавсаргасан баримттай танилцах ажиллагаанд иргэний хэргийн бүх маргааны төрлийн хувьд 10 минут зарцуулдаг байна. ИХШХШТХ-д заасан татгалзах үндэслэлийг шалгасан туслахын ажиллагааг хянах ажиллагаанд зарцуулах хугацаа бүх маргааны төрлийн хувьд 5 минут байна. Иргэний хэрэг үүсгэх, үл үүсгэх тухай захирамжийн төсөл гаргах ажиллагаанд зарцуулах хугацаа бүх маргааны төрлийн хувьд 10 минут байна. Иргэний хэргийн маргааны төрөл хамаарахгүйгээр ажиллагаа тус бүрд ижил хугацаа зарцуулна гэсэн ажиглалтын дүн гарсан байна.

• *Хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцүүлэх тухай шийдвэр гаргах үе шат*




Зураг 3.3.49 Бага үнийн дүнтэй хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцүүлэх тухай шийдвэр гаргах үеийн ажиллагаа


Зураг 3.3.49-өөс харвал Иргэний хэргийн шүүгч бага үнийн дүнтэй хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцүүлэх тухай шийдвэр гаргах ажиллагааны үе шатанд зарцуулах нийт хугацааны 4.6% буюу 15 минутыг хариуцагчид хүргүүлэх мэдэгдэх хуудас, хариуцагчид нэхэмжлэлийн хувь гардуулсан баримт, хариуцагчид эрх, үүрэг тайлбарласан баримт, нөлөөллийн мэдүүлгийн мэдээлэл өгсөн баримт, шүүгчийн захирамж зэрэг ажиллагаанд, 5.1% буюу 16 минутыг хариу тайлбартай танилцах ажиллагаанд, 46% буюу 145 минутыг хэргийн оролцогчийн ХХША-тай холбоотой хүсэлтийн шийдвэр гаргахад, 41.2% буюу 130 минутыг хэргийн материалтай танилцахад, 3.2% буюу 10 минутыг шүүх хуралдааны тов тодруулах, товын тухай шүүгчийн туслахад чиглэл өгөх зэрэг ажиллагаанд тус тус зарцуулдаг байна.



Зураг 3.3.50 Дүүргүүдийн бага үнийн дүнтэй хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцүүлэх тухай шийдвэр гаргах үеийн ажиллагаанд зарцуулах хугацаа


Зураг 3.3.49-д харуулсан үр дүнг судалгаанд хамрагдсан шүүх тус бүрээр задалж харуулбал хариуцагчид хүргүүлэх мэдэгдэх хуудас, хариуцагчид нэхэмжлэлийн хувь гардуулсан баримт, хариуцагчид эрх, үүрэг тайлбарласан баримт, нөлөөллийн мэдүүлгийн мэдээлэл өгсөн баримт, шүүгчийн захирамж хянах, шүүх хуралдааны тов тодруулах зэрэг ажиллагаанд зарцуулах хугацаа хоёр дүүргийн хувьд ойролцоо байна. Хэргийн оролцогчийн ХХША-ны хүсэлтийн шийдвэр гаргах, хариу тайлбартай танилцах, хэргийн материалтай танилцах зэрэг ажиллагаанд зарцуулах хугацаа хоёр дүүргийн хувьд ялгаатай байна.






Зураг 3.3.51 Ажиглалтын өгөгдлийн бага үнийн дүнтэй хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцүүлэх тухай шийдвэр гаргах үеийн ажиллагаанд зарцуулах хугацаа, маргааны төрлөөр

Зураг 3.3.49-д харуулсан хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцүүлэх тухай шийдвэр гаргах ажиллагаанд зарцуулах нийт хугацааг маргааны төрөл тус бүрээр Зураг 3.3.51-д задалж харуулав. Хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцүүлэх тухай шийдвэр гаргах үе буюу 2-р үе шатанд хийгддэг ажиллагаанууд дотроос хариуцагчид хүргүүлэх мэдэгдэх хуудас, хариуцагчид нэхэмжлэлийн хувь гардуулсан баримт, хариуцагчид эрх, үүрэг тайлбарласан баримт, нөлөөллийн мэдүүлгийн мэдээлэл өгсөн баримт, шүүгчийн захирамж хянах, шүүх хуралдааны тов тодруулах, товын тухай шүүгчийн туслахад чиглэл өгөх, хэргийн материалтай танилцах зэрэг ажиллагаанд зарцуулах хугацаанууд маргааны төрөл тус бүрийн хувьд ижил байна. Хариу тайлбартай танилцах ажиллагаанд зарцуулах хугацаа 13-20 минутын хэлбэлзэлтэйгээр ялгаатай байна. Хэргийн оролцогчийн ХХША-тай холбоотой хүсэлтийн шийдвэр гаргах ажиллагаа нь маргааны төрөл тус бүрээр харилцан адилгүй хугацаа зарцуулдаг үр дүн харагдаж байна. Хэрэг хянан шийдвэрлэх 2-р үе шатны хэргийн оролцогчийн ХХША-тай холбоотой хүсэлтийн шийдвэр гаргах ажиллагаа дотроо дараах 5 хэсгээс бүрдсэн байхаар задалж ажиглалт явуулсан байсан тул үзүүлэлт бүрийн хувьд тооцсон үр дүнг дурдъя.



Зураг 3.3.52 Бага үнийн дүнтэй хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцүүлэх тухай шийдвэр гаргах үеийн хэргийн оролцогчийн ХХША-тай холбоотой хүсэлтийн шийдвэр гаргах ажиллагааны задаргаа


Зураг 3.3.49-д дурдсан хэрэг хянан шийдвэрлэх 2-р үе шатны нийт ажиллагааны 46% буюу 145 минутыг эзлэх хэргийн оролцогчийн ХХША-тай холбоотой хүсэлтийн шийдвэр гаргах ажиллагааны ажиглалтын үр дүнг задалж үзэхэд шүүхийн шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах арга хэмжээнд 22 минут, ХХША-тай холбоотой ажиллагаанд 35 минут, нотлох баримттай холбоотой ажиллагаанд 25 минут, гуравдагч этгээд оролцуулах тухай ажиллагаанд 33 минут, бусад ажиллагаанд 30 минут тус тус зарцуулдаг болох нь тооцоогоор гарав.



Зураг 3.3.53 Бага үнийн дүнтэй хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцүүлэх тухай шийдвэр гаргах үеийн хэргийн материалтай танилцах ажиллагааны задаргаа


Зураг 3.3.49-д дурдсан хэрэг хянан шийдвэрлэх 2-р үе шатны нийт ажиллагааны 41.2% буюу 130 минутыг эзлэх хэргийн материалтай танилцах ажиллагааны ажиглалтын үр дүнг задалж харуулахад хэргийн материалыг уншиж судлахад 28 минут, ХХША-г төлөвлөхөд 8 минут, түүвэр гаргахад 25 минут, шаардлагатай хууль тогтоомжийг судлахад хамгийн их буюу 50 минут, шүүхийн практик судлахад 20 минут тус тус зарцуулдаг болох нь тооцоогоор гарав.

- Бага үнийн дүнтэй хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхэд бэлтгэх, хэлэлцэх үе




Зураг 3.3.54 Бага үнийн дүнтэй хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхэд бэлтгэх, хэлэлцэх үед зарцуулах хугацаа

Зураг 3.3.55-аас харвал хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхэд бэлтгэх, хэлэлцэх үе шатанд зарцуулах нийт хугацааны 1.6% буюу 5 минутыг шүүх хуралдааны тов мэдэгдэх хуудсыг хянах, гарын үсэг зурах, шүүхийн иргэдийн төлөөлөгчид мэдээлэл өгсөн баримтыг хянах, гарын үсэг зурах ажиллагаанд, 41.7% буюу 130 минутыг шүүх хуралдаан явуулах ажиллагаанд, 8.3% буюу 26 минутыг шүүх хуралдааны тэмдэглэл хянах, гарын үсэг зурах ажиллагаанд, 48.4% буюу 151 минутыг шийдвэр боловсруулах, хянах, гарын үсэг зурах ажиллагаанд тус тус зарцуулдаг байна.



Зураг 3.3.55 Дүүргүүдийн бага үнийн дүнтэй хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхэд бэлтгэх, хэлэлцэх үеийн ажиллагаанд зарцуулах хугацаа

Зураг 3.3.55-д харуулсан үр дүнг судалгаанд хамрагдсан шүүх тус бүрээр задалж харуулбал хэрэг хянан шийдвэрлэх 3-р үе шатны зурагт харуулсан ажиллагаануудаас шүүх хуралдааны тов мэдэгдэх хуудас, шүүхийн иргэдийн төлөөлөгчид мэдээлэл өгсөн баримт, шүүх хуралдааны тэмдэглэл ажиллагаанд хоёр дүүрэг ойролцоо хугацаа зарцуулдаг байна. Шүүх хуралдаан хийх ажиллагаанд Багануур дүүрэг Хан-Уул дүүргээс 1.6 дахин их хугацаа зарцуулдаг байна. Шийдвэр боловсруулах, хянах ажиллагаанд Багануур дүүрэг Хан-Уул дүүргээс 1.9 дахин бага хугацаа зарцуулдаг байна.




Зураг 3.3.56 Ажиглалтын өгөгдлийн хялбаршуулсан журмаар хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхэд бэлтгэх, хэлэлцэх үеийн ажиллагаанд зарцуулах хугацаа, маргааны төрлөөр

Зураг 3.3.55-д харуулсан Иргэний хэргийн шүүгчийн бага үнийн дүнтэй хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхэд бэлтгэх, хэлэлцэх ажиллагааны үе шатанд зарцуулах нийт хугацааг маргааны төрөл тус бүрээр Зураг 3.3.57-д задалж харуулав. Хэрэг хянан шийдвэрлэх 3-р үе шатны шүүх хуралдааны тов мэдэгдэх хуудсанд гарын үсэг зурахад бүх маргааны төрлийн хувьд 3 минут зарцуулдаг байна. Шүүхийн иргэдийн төлөөлөгчид мэдээлэл өгсөн баримтад гарын үсэг зурах ажиллагааны хувьд зурахад бүх маргааны төрлөөр 2-3 минут зарцуулдаг байна. Шүүх хуралдааны ажиллагаанд бүх маргааны




төрлийн хувьд 120-148 минут зарцуулдаг бөгөөд маргааны төрөл тус бүрийн хувьд харилцан адилгүй хугацаа зарцуулдаг байна. Шүүх хуралдааны тэмдэглэл хянах, гарын үсэг зурахад ШШГТХ-аас бусад маргааны хувьд 20-44 минут зарцуулдаг байна. ШШГТХ-иар хэрэг хянан шийдвэрлэхэд 10 минут буюу хамгийн бага хугацаа зарцуулдаг байна. Шийдвэр боловсруулах, хянах ажиллагааны бүх маргааны хувьд 143-167 минут зарцуулдаг байна. Зураг 3.3.55-д дурдсан хэрэг хянан шийдвэрлэх 3-р үе шатны нийт ажиллагааны 41.7% буюу 130 минутыг эзлэх шүүх хуралдаан явуулах ажиллагааны ажиглалтын үр дүнг судалгаанд ирсэн ажиглалтын өгөгдлөөр задалж харуулав.




Зураг 3.3.57 Шүүх хуралдааны задаргаа

Зургаас харвал шүүх хуралдаан хийхэд хамгийн их буюу 80 минут, зөвлөлдөхөд 28 минут, шийдвэрийн тогтоох хэсгийг танилцуулахад 2 минут тус тус зарцуулдаг болох нь тооцоогоор гарав. Шүүх хуралдааны хэлбэр ажиглалтын өгөгдлөөр задаргаатай ирсэн тул үзүүлэлт бүрийн хувьд тооцсон үр дүнг дурдъя.



Зураг 3.3.58 Шүүх хуралдаан явуулах хэлбэрийн хувьд зарцуулах хугацаа

Зургаас харвал шүүх хуралдааныг дангаар явуулах үед 90 минут, бүрэлдэхүүн даргалах үед 70 минут зарцуулна гэж үзсэн байна.



Зураг 3.3.59 Шүүхийн шийдвэр гаргах ажиллагааны задаргаа

Зураг 3.3.55-д хэрэг хянан шийдвэрлэх 3-р үе шатны 48.4% буюу 151 минутыг эзлэх шийдвэр боловсруулах ажиллагааны ерөнхий дүнг ажиллагаа тус бүрээр задалж үзэхэд шүүгчийн захирамж гаргахад 26 минут, шүүхийн шийтгэвэр гаргахад 20 минут, шүүхийн тогтоолд 13 минут, шүүхийн шийдвэр гаргахад 92 минут зарцуулдаг байна.

• Хэрэг хянан шийдвэрлэсний дараах үе шат




Зураг 3.3.60 Хэрэг хянан шийдвэрлэсний дараах үеийн ажиллагааны задаргаа

Зураг 3.3.61-д хэрэг хянан шийдвэрлэсний дараах үе шатанд зарцуулах нийт хугацааг тус шатны ажиллагаа тус бүрээр задалж тооцсон үр дүнг харуулав. Энэ үе




шатны нийт ажиллагаанд зарцуулах хугацааны 19.7% буюу 5 минутыг албадан гүйцэтгэх захирамж хянах, гарын үсэг зурахад, 12% буюу 3 минутыг гүйцэтгэх хуудас хянах, гарын үсэг зурахад, 68.3% буюу 17 минутыг эмхэтгэсэн хэргийг хянах, гарын үсэг зурах ажиллагаанд тус тус зарцуулдаг нь ажиглалтаар харагдав.



Зураг 3.3.61 Дүүргүүдийн бага үнийн дүнтэй хэрэг хянан шийдвэрлэсний дараах үеийн ажиллагаанд зарцуулах хугацаа

Зураг 3.3.61-д харуулсан үр дүнг шүүхээр задалж харуулбал албадан гүйцэтгэх захирамж ба гүйцэтгэх хуудас хянах, гарын үсэг зурахад хоёр дүүрэг ижил хугацаа зарцуулдаг байна. Эмхэтгэсэн хэргийг хянаж баримтад гарын үсэг зурахад мөн адил ойролцоо хугацаа зарцуулдаг байна.



Зураг 3.3.62 Ажиглалтын өгөгдлөөр бага үнийн дүнтэй хэрэг хянан шийдвэрлэсний дараах үеийн ажиллагаанд зарцуулах хугацаа, маргааны төрлөөр

Хэрэг хянан шийдвэрлэх 4-р үе шатны ажиллагаанд бүх маргааны төрлөөр хэрэг хянан шийдвэрлэхэд зарцуулах хугацааг харуулав. Албадан гүйцэтгэх захирамж хянах, гарын үсэг зурахад бүх маргааны төрлийн хувьд 3-8 минут зарцуулдаг байна. Гүйцэтгэх хуудас хянах, гарын үсэг зурахад бүх маргааны төрлийн хувьд 3 минут зарцуулдаг байна. Эмхэтгэсэн хэргийг хянаж баримтад гарын үсэг зурахад энэ үе шатны бусад ажиллагааг бодвол бага зэрэг их хугацаа зарцуулах бөгөөд бүх маргааны төрлийн хувьд 15-19 минут зарцуулдаг байна.

3.3.4 Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн хянан шийдвэрлэсэн хэргийн ажиглалтын өгөгдөлд хийх шинжилгээ

3.3.4.1 Давж заалдах шатны шүүхийн ажиглалтын өгөгдлийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны ерөнхий дүн ба үе шатуудын хувьд хийх шинжилгээ


Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгчийн ажлын ажиллагааны ачааллыг бодитой тодорхойлохын тулд Дархан, Нийслэлийн иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн тус тус нэг шүүгчийн иргэний хэрэг хянан шийдвэрлэх үйл ажиллагаанд ажлын байрны зураг авалт хийж, өгөгдөл цуглуулан шинжилгээ хийсэн үр дүнг танилцуулж байна.



Зураг 3.3.63 Давж заалдах шатны шүүхийн хэрэг хянан шийдвэрлэхэд зарцуулах хугацааны тухай ажиглалтын өгөгдлийн ерөнхий мэдээлэл



Иргэний хэргийн хуульд заасан маргааны төрлүүдийн ажиллагаанд зарцуулах хугацааны тухай Дархан, Нийслэлийн иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн хоёр шүүгчийн ажлын байрны зураг авалтын үр дүнд цуглуулсан 24 өгөгдөлд хийсэн 3 хүчин зүйлийн дисперсийн шинжилгээний үр дүнг Зураг 3.3.64-д харуулав. Зургаас харвал Дарханы иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгч нэг иргэний хэргийг хянан шийдвэрлэхэд 354 минут, Нийслэлийн шүүгч 499 минут зарцуулдаг байна. Харин иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн ерөнхий шүүгч ба шүүгчийн хэргийг хянан шийдвэрлэхэд зарцуулах хугацаа 422 ба 431 минут буюу ойролцоо байна.



Зураг 3.3.64 Давж заалдах шатны шүүхийн хэрэг хянан шийдвэрлэхэд зарцуулах хугацааны тухай ажиглалтын өгөгдөл, маргааны төрөл ба дүүргээр

Давж заалдах шатны шүүхийн хэрэг хянан шийдвэрлэх хугацааг Иргэний хэргийн маргааны төрөл тус бүрээр нь задалж харуулсан зургаас харвал судалгаанд хамрагдсан хэргийн маргааны төрлүүдийн хувьд 413-443 минут зарцуулдаг байна. Зураг авалтад хамрагдсан хоёр шүүхийн хувьд Дарханы давж заалдах шатны шүүхийн шүүгч судалгаанд хамрагдсан маргааны төрлүүдийн хувьд 343-378 минут зарцуулдаг байхад Нийслэлийн шүүгч 483-522 минут зарцуулдаг төлөв ажиглагдсан байна.


Дисперсийн шинжилгээний программын үр дүнгээр детерминац, корреляц, вариацийн коэффициентийг тооцсон үр дүнг дараах хүснэгтээр харуулъя.

№	Үзүүлэлт	Детерминацийн коэффициент	Корреляцийн коэффициент	Вариацийн коэффициент	Дундаж
1	Хэрэг	0.02	0.13	48%	427
2	Шүүгч	0.02	0.12	52%	
3	Шүүх, Шүүгч	0.02	0.14	43%	
4	Шүүх, Хэрэг	0.02	0.14	46%	

Хүснэгт 3.3.4 Ажиглалтын өгөгдлийн хэрэг хянан шийдвэрлэх хугацаанд нөлөөлөх хүчин зүйлүүд

Хүснэгтийн зөвхөн 3-р мөрний утгыг тайлбарлая. Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн хэрэг хянан шийдвэрлэхэд зарцуулах хугацааны өөрчлөлтийн 0.02 нь шүүхийн тогтолцоо (захын ба төвийн дүүрэг) ба шүүгчийн ангилал (ерөнхий шүүгч, шүүгч)-аас хамаарч байна. Хэрэг хянан шийдвэрлэхэд зарцуулах хугацаа шүүхийн тогтолцоо ба шүүгчийн ангиллаас 0.14 буюу сул хамааралтай байна. Вариацийн коэффициент 43% тул тоон үзүүлэлтүүд нэгэн төрлийн бөгөөд дунджийг бусад тоон утгыг төлөөлөх чадвартай гэж үзнэ.


Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үе шат дараах үндсэн гурван үе шатаас бүрдэх бөгөөд шинжилгээний үр дүнг харуулъя.



Зураг 3.3.65 Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үндсэн үе шат




Зураг 3.3.65-аас харвал хэргийг хүлээн авах үе шатанд дунджаар нэг хэргийг хянан шийдвэрлэхэд нийт хугацааны 10.1% буюу 43 минут, хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхэд бэлтгэх, хэлэлцэх үе шатанд 86.6% буюу 369 минут, хэргийг хянан шийдвэрлэсний дараах ажиллагааны үе шатанд 3.3% буюу 14 минут зарцуулдаг байна.



Зураг 3.3.66 Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд зарцуулах хугацаа, үе шатаар

Зураг 3.3.65-д харуулсан үр дүнг судалгаанд хамрагдсан шүүх тус бүрээр задалж харуулбал хэрэг хянан шийдвэрлэх 1-р үед шатанд Нийслэлийн давж заалдах шатны шүүх Дархан-Уул аймгийн давж заалдах шатны шүүхээс 1.5 дахин их хугацаа зарцуулдаг байна. Хэрэг хянан шийдвэрлэх 2-р үед шатанд Нийслэлийн давж заалдах шатны шүүх Дархан-Уул аймгийн давж заалдах шатны шүүхээс мөн 1.4 дахин их хугацаа зарцуулдаг байна. Хэрэг хянан шийдвэрлэх 3-р үед шатанд хоёр шүүхийн шүүгч ойролцоо хугацаа зарцуулдаг байна.




Зураг 3.3.67 Хэрэг хянан шийдвэрлэх үе шатанд хамаарах ажиллагааны хугацаа, маргааны төрлөөр

Зураг 3.3.65-д харуулсан ерөнхий мэдээллийг Иргэний хэргийн маргааны төрөл тус бүрээр Зураг 3.3.65-д задалж оруулав. Зургаас харвал хэрэг хянан шийдвэрлэх 1-р үе шатанд бүх маргааны төрлийн ажиллагаанд зарцуулах хугацаа 42-44 минут байна. Хэрэг хянан шийдвэрлэх 2-р үе шатанд судалгаанд авсан бүх маргааны төрлийн ажиллагаанд зарцуулах хугацаа ойролцоо буюу 356-384 минут байна. Хэргийн 3-р үе шатанд бүх хэргийн зүйл ангийн ажиллагаанд зарцуулах хугацаа 11-15 минут байна.

3.3.4.2 Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны 1-3-р үе шатанд зарцуулах хугацааны өгөгдөлд хийх шинжилгээ

• Хэргийг шүүгч хүлээн авах үе шат


Зураг 3.3.65-д харуулсан хэрэг хянан шийдвэрлэх үе шатыг ямар төрлийн ажиллагаанаас хамаарч харилцан адилгүй хугацаа зарцуулж байгааг хэрэг хянан шийдвэрлэх 1-р үеийн хэргийн ажиллагаа тус бүрээр задалж харуулсан үр дүнг танилцуулъя.



Зураг 3.3.68 Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн хэргийг хүлээн авах үеийн ажиллагааны задаргаа




Зураг 3.3.68-аас харвал хэргийг хүлээн авах үе шатанд зарцуулах нийт хугацааны хэрэгт хавсаргасан баримттай уншиж танилцахад 60.5% буюу 26 минут, татгалзах үндэслэл байгаа эсэхийг шалгасан туслахын ажиллагааг хянахад 23.2% буюу 10 минут, гомдлыг хүлээн авахаас татгалзах тухай захирамжийн төсөл боловсруулах, хянах, гарын үсэг зурахад 16.3% буюу 7 минут тус тус зарцуулдаг байна.



Зураг 3.3.69 Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхүүдийн хэргийг хүлээн авах үеийн ажиллагаанд зарцуулах хугацаа


Зураг 3.3.68-д харуулсан үр дүнг судалгаанд хамрагдсан шүүх тус бүрээр задалж харуулбал татгалзах үндэслэл байгаа эсэхийг шалгасан туслахын ажиллагааг хянахад хоёр шүүх адил хугацаа зарцуулдаг байна. Харин Дархан-Уул аймгийн шүүх Нийслэлийн шүүхээс хэрэгт хавсаргасан баримттай уншиж танилцахад ажиллагааны хувьд 1.6 дахин бага хугацаа, гомдлыг хүлээн авахаас татгалзах тухай захирамжийн төсөл боловсруулах, хянах, гарын үсэг зурах ажиллагааны хувьд 2.4 дахин бага хугацаа тус тус зарцуулдаг байна.



Зураг 3.3.70 Ажиглалтын өгөгдлийн хэргийг хүлээн авах үеийн ажиллагаанд зарцуулах хугацаа, маргааны төрлөөр

Зураг 3.3.68-д харуулсан хэргийг хүлээн авах үе шатанд зарцуулах нийт хугацааг маргааны төрөл тус бүрээр Зураг 3.3.70-д задалж харуулав. Хэрэг хянан шийдвэрлэх 1-р үе шат болох хэргийг хүлээн авах үе шатны бүх ажиллагаа тус бүрийн хувьд зарцуулах хугацаа бүх маргааны төрлийн хувьд ижил байна. Хэрэг хянан шийдвэрлэх 1-р үе буюу хэргийг хүлээн авах үеийн ажиллагаанд зарцуулах хугацаа маргааны төрлөөс хамаарахгүй энэ үеийн 1-р ажиллагаанд 25-27 минут, 2-р ажиллагаанд 10 минут, 3-р ажиллагаанд 7 минут тус тус зарцуулдаг байна.


• Хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхэд бэлтгэх, хэлэлцэх үе



Зураг 3.3.71 Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхэд бэлтгэх, хэлэлцэх үеийн ажиллагаанд зарцуулах хугацаа




Зураг 3.3.71-ээс харвал хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхэд бэлтгэх үе шатанд зарцуулах нийт хугацааны 6.5% буюу 24 минутыг хэргийн оролцогчдод шүүх хуралдааны тов мэдэгдэх хуудас, хэргийн оролцогчийн ХХША-тай холбоотой хүсэлтийн шийдвэр, шүүх хуралдааны тов тодруулах, шүүгчийн туслахад чиглэл өгөх, шүүх хуралдааны бүрэлдэхүүн томилсныг албажуулах зэрэг ажиллагаанд, 34.4% буюу 127 минутыг хэргийн материалтай танилцахад, 21.7% буюу 80 минутыг шүүх хуралдаанд, 3.8% буюу 14 минутыг шүүх хуралдааны тэмдэглэл хөтлөхөд, 33.6% буюу 124 минутыг шүүхийн шийдвэр гаргахад тус тус зарцуулдаг байна.



Зураг 3.3.72 Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхүүдийн хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхэд бэлтгэх, хэлэлцэх үеийн ажиллагаанд зарцуулах хугацаа

Зураг 3.3.72-д харуулсан үр дүнг судалгаанд хамрагдсан шүүх тус бүрээр задалж харуулбал Дархан-Уул аймгийн шүүх Нийслэлийн шүүхээс хэргийн материалтай танилцах ажиллагаанд 3.4 дахин бага хугацаа, шүүх хуралдаанд 1.3 дахин бага хугацаа зарцуулдаг байна. Харин шүүхийн шийдвэр гаргах ажиллагаанд Дархан-Уул аймгийн шүүх Нийслэлийн шүүхээс 1.3 дахин их хугацаа зарцуулдаг байна. Энэ үе шатанд хийгддэг бусад ажиллагаанд ойролцоо хугацаа зарцуулдаг байна. Нийслэлийн шүүхийн хэргийн оролцогчийн ХХША-тай холбоотой хүсэлтийн шийдвэрийн ажиглалтын өгөгдөл судалгааны багт ирээгүй тул 0-ээр тэмдэглэв.




Зураг 3.3.73 Ажиглалтын өгөгдлийн хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхэд бэлтгэх, хэлэлцэх үеийн ажиллагаанд зарцуулах хугацаа, маргааны төрлөөр

Зураг 3.3.71-д харуулсан хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхэд бэлтгэх ажиллагааны үе шатанд зарцуулах нийт хугацааг хэргийн төрөл тус бүрээр Зураг 3.3.73-д задалж харуулав. Хэрэг хянан шийдвэрлэх 2-р үе шатанд хийгддэг бүх ажиллагаанд




зарцуулах хугацаа маргааны төрөл тус бүрийн хувьд ойролцоо, ижил шахам хугацаа зарцуулдаг байна.



Зураг 3.3.74 Хэргийн материалтай танилцах ажиллагааны задаргаа


Зураг 3.3.71-д дурдсан хэрэг хянан шийдвэрлэх 2-р үе шатны нийт ажиллагааны 34.4% буюу 127 минутыг эзлэх хэргийн материалтай танилцах ажиллагааны ажиглалтын үр дүнг задалж харуулахад хэргийн материалыг уншиж судлахад 37 минут, ХХША-г төлөвлөхөд 15 минут, түүвэр гаргахад 38 минут, шаардлагатай хууль тогтоомжийг судлахад хамгийн их буюу 18 минут, шүүхийн практик судлахад 21 минут тус тус зарцуулдаг болох нь тооцоогоор гарав.



Зураг 3.3. 75 Шүүх хуралдааны задаргаа


Зураг 3.3.71-д дурдсан хэрэг хянан шийдвэрлэх 2-р үе шатны нийт ажиллагааны 21.7% буюу 80 минутыг эзлэх шүүх хуралдаан явуулах ажиллагааны ажиглалтын үр дүнг судалгаанд ирсэн ажиглалтын өгөгдлөөр задалж харуулав. Зургаас харвал шүүх хуралдааны бүрэлдэхүүн даргалахад 23 минут, илтгэхэд хамгийн их буюу 31 минут, зөвлөлдөхөд 17 минут, шийдвэрийн тогтоох хэсгийг танилцуулахад 10 минут тус тус зарцуулдаг болох нь тооцоогоор гарав.

Зураг 3.3.71-д дурдсан хэрэг хянан шийдвэрлэх 2-р үе шатны нийт ажиллагааны 41.7% буюу 130 минутыг эзлэх шүүх хуралдаан явуулах ажиллагааны ажиглалтын үр дүнг судалгаанд ирсэн ажиглалтын өгөгдлөөр задалж харуулав.



Зураг 3.3.76 Шүүхийн шийдвэр гаргах ажиллагааны задаргаа

Зураг 3.3.71-д хэрэг хянан шийдвэрлэх 2-р үе шатны 33.6% буюу 124 минутыг эзлэх шийдвэр боловсруулах ажиллагааны ерөнхий дүнг ажиллагаа тус бүрээр задалж үзэхэд шүүгчийн захирамж гаргахад 19 минут, магадлал гаргахад 84 минут, шүүхийн тогтоолд 21 минут зарцуулдаг байна. Шүүхийн шийдвэр гаргах үйл ажиллагааны шүүгчийн захирамж, магадлал, шүүхийн тогтоолууд нь дотроо задаргаатай ажиглалтын өгөгдөлтэй байсан тул тооцооны үр дүнг задаргаагаар харуулъя.



Зураг 3.3.77 Шүүхийн шийдвэр боловсруулсан, хянасан задаргаа

Зургаас харвал шүүгчийн захирамж ба шүүхийн тогтоолыг хянах ажиллагаанд боловсруулсан ажиллагаанаас илүү хугацаа зарцуулдаг байна. Харин магадлалд хянах ажиллагаанд боловсруулсан ажиллагаанаас бага хугацаа зарцуулдаг байна.



• **Хэрэг хянан шийдвэрлэсний дараах үе шат**



Зураг 3.3.78 Хэрэг хянан шийдвэрлэсний дараах үеийн ажиллагаа

Зураг 3.3.78-д хэрэг хянан шийдвэрлэсний дараах үе шатанд зарцуулах нийт хугацааг тус шатны ажиллагаагаар тооцсон үр дүнг харуулав. Энэ үе шатны ажиллагаа нь албан бичиг хянаж гарын үсэг зурах гэсэн нэг ажиллагаанаас тогтсон онцлогтой байна. Энэ шатны ажиллагаанд зарцуулах хугацаа шүүхийн тогтолцоо, маргааны төрлөөс хамаарахгүй жигд 15 минут зарцуулдаг нь ажиглалтын өгөгдлийн шинжилгээгээр тогтоогдов.




4.1 Захиргааны хавтаст хэргийн материалд хийсэн шинжилгээ

Захиргааны хэргийн шүүгчийн хянан шийдвэрлэсэн хэргийн ажиллагааны ачааллыг бодитой зөв тодорхойлохын тулд ШЕЗ-ийн судалгаа шинжилгээний баг хялбаршуулсан болон ердийн журмаар шийдвэрлэсэн захиргааны 16 төрлийн маргаанд хамаарах нийт 48 хавтаст хэргийг материалтай уншиж танилцан, тоон мэдээлэл цуглуулж шинжилгээ хийсэн үр дүнг энэ бүлэг танилцуулна.

4.1.1 Хялбаршуулсан журмаар шийдвэрлэсэн захиргааны хавтаст хэргийн материалд хийх шинжилгээ

4.1.1.1 Хялбаршуулсан журмаар шийдвэрлэсэн захиргааны хавтаст хэргийн танилцуулга

Маргааны төрлөөр хавтаст хэргийн ажиллагааны тоог дараах зургаар харуулав. Зураг 4.1.1-ээс харвал газрын маргааны 2 хэргээс 2-р хэрэг хамгийн олон ажиллагаатай буюу 105 ажиллагаа хийгдэж, 170 хуудастай, 352 хоног зарцуулсан байна. Эдгээр 7 хэргээс хамгийн бага үзүүлэлт нь газрын маргаанд 7 ажиллагаа хийгдэж, 10 хуудастай, 66 хоног зарцуулсан байхад төрийн албаны маргаанд 9 ажиллагаа хийгдэж, 14 хуудастай, газрын маргаанаас 2 дахин бага хоног зарцуулсан байна.




Зураг 4.1. 1 Хялбаршуулсан журмаар шийдвэрлэсэн захиргааны хэргийн ажиллагааны тоо, хуудас, хоног, хэрэг тус бүрээр



Зураг 4.1. 2 Хялбаршуулсан журмаар шийдвэрлэсэн захиргааны хэргийн ажиллагаа, маргааны төрлөөр

Захиргааны хавтаст хэргийн танилцуулга бүлэгт дурдсан 7 хавтаст хэргийг маргааны төрөл тус бүрээр дундажлаж илэрхийлсэн мэдээллийг Зураг 4.1.2-д харуулав. газрын маргаан 56 ажиллагаатай, 90 хуудастай, 209 хоног зарцуулсан хэрэг судалгаанд сонгогдсон нь хамгийн их дүнтэй байгаа бол төрийн албаны маргаан 25-26 ажиллагаатай, 36 хуудастай, 59 хоног зарцуулсан нь хамгийн бага дүнтэй хэргүүд захиргааны хавтаст хэргийн ачааллыг тодорхойлох зорилгоор сонгогдсон байна.




Зураг 4.1. 3 Хялбаршуулсан журмаар шийдвэрлэсэн захиргааны хэргийн ажиллагаа, хуудас, хоног, ХХША-ны үе шатаар

Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үе шатад хийсэн нэг ба 2 хүчин зүйлийн дисперсийн шинжилгээний үр дүнг дараах зургаар харуулав. Зураг 4.1.3-ын 1 дэх зургаас харвал хэрэг үүсгэх эсэхийг шийдвэрлэх үе шатанд дунджаар нэг хэргийн




нийт ажиллагааны 17.1% буюу 6 ажиллагаа, хэргийг шийдвэрлэх үе шатанд нэг хэргийн нийт ажиллагааны 77.8% буюу 28 ажиллагаа, хэргийг шийдвэрлэсний дараах үе шатанд нэг хэргийн нийт ажиллагааны 5% буюу 1-2 ажиллагаа хийгдсэн байна. 2 дахь зургийн хувьд хэрэг үүсгэх эсэхийг шийдвэрлэх үе шатанд дунджаар нэг хэргийн нийт материалын 18.5% буюу 27-28 хуудас, хэргийг шийдвэрлэх үе шатанд нэг хэргийн нийт материалын 77.8% буюу 42 хуудас, хэргийг шийдвэрлэсний дараах үе шатанд нэг хэргийн нийт материалын 3.7% буюу 2 хуудас материал тус тус бүрдсэн байна. 3 дахь зургийн хувьд хэрэг үүсгэх эсэхийг шийдвэрлэх үе шатанд дунджаар нэг хэрэгт зарцуулсан нийт хугацааны 20% буюу 22-23 хоног, хэргийг шийдвэрлэх үе шатанд 73% буюу 82 хоног, хэргийг шийдвэрлэсний дараах үе шатанд 6.7% буюу 7-8 хоног тус тус зарцуулсан байна.



Зураг 4.1. 4 Хялбаршуулсан журмаар шийдвэрлэсэн захиргааны хэргийн ажиллагааны тоо, хуудас, хоног, маргааны төрлөөр

Зураг 4.1.4-өөс харвал хэрэг хянан шийдвэрлэх 1-р үе шатанд татварын маргаад хийгдсэн ажиллагааны тоо 7-8, хуудасны тоо 12, зарцуулсан хугацаа 28 хоног байсан нь хамгийн их байна. 2-р үе шатанд газрын маргаанд 49 ажиллагаа хийгдэж, 80-81 хуудас материал бүрдэж, 171 хоног зарцуулсан нь хамгийн их дүнтэй байна. 3-р үе шатанд мөн л газрын маргаанд хийгдсэн ажиллагаа 2-3, хуудасны тоо 3, зарцуулсан хугацаа 17 хоног байна. Хялбаршуулсан журмаар ХХША-г хуваасан дээрх 3 үе шатны мэдээлэлд ажиллагаа, хуудас, хоног гэсэн 3 төрлийн өгөгдөл нь маргааны төрлөөс үл хамааран 2-р үе шат буюу “хэргийг шийдвэрлэх үе шат”-нд хамгийн өндөр дүнтэй болох нь харагдаж байна. Энэ нь ХХША-ны хуульчлагдсан хугацаа болон тухайн үе шатанд процессын олон ажиллагаа хамаарч байгаатай холбоотой юм. Нийт 3-н үе шатны дүнгээр газрын маргаанд хийгдсэн ажиллагаа, хуудасны тоо, зарцуулсан хугацаа өндөр дүнтэй, харин төрийн албаны маргаанд эдгээр үзүүлэлт бага дүнтэй байна.



Зураг 4.1. 5 Хялбаршуулсан журмаар шийдвэрлэсэн захиргааны хэргийн ажиллагааны тоо, хуудас, хоног, ажиллагааны төрлөөр

Зураг 4.1.5-аас харвал ажиллагааны тоо, хуудасны тоо, зарцуулсан хугацааны хувьд өндөр дүнтэй бусдаас эрс ялгаатай байгаа зарим ажиллагааг тайлбарлая.

Ажиллагааны тоо: Нэг хавтаст хэрэгт ихэнх төрлийн ажиллагаа хэд хэд хийгдсэн дүнтэй байгаа тул энэхүү давтамжийг ажиллагааны тоо гэсэн нэршлээр зурагт




харуулж, дүгнэв. Зураг 4.1.5-ын эхний зургаас харахад төрлийн хувьд 1-р үе шатанд 8 ажиллагаа байгаагаас баримт 14 удаа, албан бичиг 2-3 удаа хийгдсэн бол 2-р үе шатанд шүүгчийн захирамж, албан бичиг 4-5 удаа хийгдсэн нь өндөр байна. 3-р үе шатанд баримт, албан бичиг зэрэг ажиллагаа тус бүр 2 удаа хийгдсэн байна.

Хуудасны тоо: 1-3-р үе шатанд шүүгчийн захирамж 6, 2-р үе шатанд баримт 10, шүүх хуралдааны тэмдэглэл 14 хуудас байгаа нь хамгийн өндөр дүнтэй байна. Ажиллагааны тоо болон хуудасны тоонд өндөр дүнтэй гарсан ажиллагааны төрлийг харьцуулан үзвэл шүүгчийн захирамж, шүүх хуралдааны тэмдэглэл гэсэн ажиллагаанд давтамжийн тооноос хуудасны тоо их, 1 удаа хийгдсэн ажиллагаанд хэд хэдэн хуудас материал боловсруулагдаж байна.

Зарцуулсан хугацаа: 1-р үе шатанд хийгдсэн ажиллагаанаас шүүгчийн захирамж 16 хоног, 2-р үе шатанд баримт 31, шүүгчийн захирамж 19, албан бичиг 19, шүүгчдийн зөвлөгөөний тогтоол 22 хоног зарцуулсан мэдээлэлтэй байна. Зураг 3.1.5-аар харуулсан ажиллагааны тоо, хугацааны мэдээллийг өндөр дүнтэй гарсан зарим төрлийн ажиллагаанд холбон дэлгэрүүлэн тайлбарлая. Тухайлбал, 2-р үе шатанд гарсан 14-н баримтад 31 хоног, 5, 5-н шүүгчийн захирамж, албан бичигт тус бүр 19 хоног зарцуулсан бол 3-н шүүгчдийн зөвлөгөөний тогтоолд 22 хоног зарцуулсан дүнтэй байна.


4.1.1.2 Хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэсэн захиргааны хэргийн ажиллагааны төрөлд хийх шинжилгээ


Өмнөх бүлгийн Зураг 4.1.3, 4.1.4-т харуулсан ХХША-ны үе шат нь ямар төрлийн маргаанаас хамаарч харилцан адилгүй үзүүлэлттэй байгааг онцлох зарим ажиллагаанд холбогдуулан дэлгэрэнгүй тайлбарлая.



Зураг 4.1. 6 ХХША-ны 1-р үе шатанд ажиллагааны тоо, хуудас, хоног, маргааны төрлөөр


ХХША-ны 1-р үе шат. Судлагдсан 3 төрлийн маргаанаас газрын маргаанд “нэхэмжлэл”, “захирамж” гэх ажиллагаа хамгийн өндөр дүнтэй буюу тус бүр 3 удаа байна. Энэ нь тус маргааны хувьд шүүхэд анх гаргасан нэхэмжлэлээс гадна бүрдүүлбэр хангуулах, нэхэмжлэгч нэхэмжлэлийн шаардлагаа өөрчлөх зэрэг шалтгаанаар нэхэмжлэл, түүнтэй дүйх хэмжээний ажиллагаа нийт 3 удаа байгааг илэрхийлж байна. Газрын маргаанд шүүхээс дээрх материалыг уншиж, танилцаад энэ төрлийн 3 ажиллагаанд 7 хуудас захирамж боловсруулсан бөгөөд 21 хоног зарцуулсан байна. Энэ мэтчилэн аль ч үе шатанд хамаарах ажиллагааны тайлбарыг ойлгох зарчим нь энэ хэсэгт дурдсантай ижил болно.





Зураг 4.1.7 ЗХХША-ны 2-р үе шатанд ажиллагааны тоо, хуудас, хоног, маргааны төрлөөр

ХХША-ны 2-р үе шат. Судлагдсан 3 төрлийн маргаанаас өндөр дүнтэй бусдаас эрс ялгаатай байгаа зарим ажиллагааг тайлбарлая. Төрийн албаны маргаанд 2 хэрэг судлагдсанаас “шүүх хуралдааны тэмдэглэл” гэх ажиллагааг 9 удаа хийж, 38 хуудас материал боловсруулж, 17-18 хоног зарцуулсан байна. Газрын маргаанд 2 хэрэг судлагдсанаас “баримт” гэх ажиллагааг 18-19 удаа хийж, 19 хуудас материал боловсруулж, 43 хоног зарцуулсан байна. Газрын болон төрийн албаны маргааны эдгээр дүнгээс харвал “баримт” гэх ажиллагаа илүү ихээр хийгдэж, олон хоног зарцуулсан харагдаж байгаа хэдий ч хавтаст хэргийн материалыг судлах явцад огноо тодорхойгүй, өмнөх ажиллагаа болон баримт гэсэн ажиллагаа хоорондох хоногийг гаргахад тодорхойгүй нөхцөл байдлууд тулгарч байсныг дурдах нь зүйтэй байна. Мөн “баримт”, “шүүх хуралдааны тэмдэглэл” гэх 2 ажиллагааг харьцуулж үзвэл баримтыг боловсруулахдаа мэдээлэл бүртгэж, тайлбарлаж, гарын үсэг зуруулах гэх мэтээр хийгдэх ажил нь шүүх хуралдааны тэмдэглэлийг бичих, гарын үсэг зуруулахаас илүү хөнгөн, ажиллагаа багатай, гол төлөв техникийн шинжтэй ажил байдаг. Иймд баримт гэх ажиллагаа нь илүү техник шинжтэй, олон удаагийн давтамжтай, 1 бүрд зарцуулах хугацаа бага тул эсрэгээрээ ажиллагааны тоо, хуудас багатай ч хугацаа их зарцуулж хийгддэг бусад ажиллагаатай харьцуулахад шүүгчид үзүүлэх ачаалал бага, гол төлөв шүүгчийн туслах хариуцан хийдэг ажил юм.




Зураг 4.1.8 ЗХХША-ны 3-р үе шатанд ажиллагааны тоо, хуудас, хоног, маргааны төрлөөр

ХХША-ны 3-р үе шат. Өндөр дүнтэй болон онцлогтой байгаа зарим үзүүлэлтийг тайлбарлая. Зураг 4.1.8-аас харвал ажиллагааны тоо, хуудасны тоо, зарцуулсан хугацаа гэсэн 3 төрлийн үзүүлэлтээр татварын маргаан өндөр дүнтэй байна. Тухайлбал, татварын маргааны 3 хэрэг судлагдсанаас “албан бичиг” гэх ажиллагааг 1-2 удаа хийж, 2 хуудас боловсруулж, 2 өдөр зарцуулсан байна. ЗХХША-нд албан бичиг боловсруулах ажиллагааг нотлох баримт шаардсан албан бичиг, бусад гэх байдлаар үндсэнд нь 2 төрөлд хувааж болохоор юм. Нотлох баримт шаардсан албан бичгийн хувьд боловсруулах, хянуулах, хүргүүлэх ажлыг гүйцэтгэхэд хугацаа нэлээд шаардагддаг бол бусад албан бичиг нь техникийн шинжтэй шүүх хооронд эсвэл хэргийн оролцогч зэрэгт хэрэг, эрхийн акт, материалыг хүргүүлэх тохиолдолд үйлдэгддэг. 3-р үе шат буюу хэргийг шийдвэрлэсний дараах үе шатанд “шүүгчийн захирамж” гэх ажиллагааг 1 удаа хийж, хуралдаанаар тухайн хэрэг хэлэлцэгдэж, хялбаршуулсан журмаар шийдвэрлэгдсэн болохыг харуулж байгаа бол зураг 4.1.6-д харуулсан энэ төрлийн ажиллагаанд 2-12 захирамж гарсан байгаа нь бусад хэрэг бүгд хуралдаанаас өмнө хялбаршуулсан журмаар шийдвэрлэгдсэнийг харуулж байна. ХХША-нд хялбаршуулсан журмаар шийдвэрлэсэн хэрэгт шийдвэрийн дугаар олгодог хэдий ч захирамжийг бланк




ашиглан боловсруулж, албажуулж, хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгчид эрх зүйн үр дагаврыг танилцуулдаг онцлогтой. Иймд судалгаанд энэ тохиолдлыг “захирамж” гэх ажиллагаанд хамруулж судалсан.

Зураг 4.1.9-4.1.10-т ХХША-ны үе шат нь ямар төрлийн ажиллагаанаас хамаарч харилцан адилгүй үзүүлэлттэй байгааг онцлох зарим ажиллагаанд холбогдуулан дэлгэрэнгүй тайлбарлая.




Зураг 4.1. 9 ЗХХША-ны 1-р үе шатанд ажиллагааны тоо, хуудас, хоног, ажиллагааны төрлөөр

ХХША-ны 1-р үе шат. Судалгаанд хамрагдсан нийт 7 хэрэгт “баримт”, “нэхэмжлэл”, “шүүгчийн захирамж”, “албан бичиг” гэсэн 4 төрлийн ажиллагаа хийгдсэн байна. Энд “нэхэмжлэл” гэх ажиллагааны цаана шүүгч, шүүгчийн туслах нэхэмжлэлийг уншиж, судлах ажиллагаа хамаарч байгаа гэж ойлгоно. Ажиллагааны тоо, хуудасны тоо, зарцуулсан хоног гэсэн 3 төрлийн үзүүлэлтийн нэгдлээр “шүүгчийн захирамж” гэх ажиллагаа бусад ажиллагаанаас илүү болох нь харагдаж байна. Эндээс 1-р үе шатанд энэ ажиллагааг 2 удаа хийж, 6 хуудас боловсруулж, 16 хоног зарцуулжээ.



Зураг 4.1. 10 ЗХХША-ны 2-р үе шатанд ажиллагааны тоо, хуудас, хоног, ажиллагааны төрлөөр

ХХША-ны 2-р үе шат. Зураг 4.1.9-өөс харвал энэ үе шатанд 8 төрлийн ажиллагаа буюу өмнөх шатнаас 2 дахин их төрлийн ажиллагаа хийгдсэн байна. Үүнээс ажиллагааны тоо, хуудасны тоо, зарцуулсан хугацаа гэсэн 3 төрлийн үзүүлэлтийн нэгдлээр “шүүгчийн захирамж”, “албан бичиг”, “шүүх хуралдааны тэмдэглэл” гэх ажиллагаа өндөр дүнтэй байна. “Шүүх хуралдааны тэмдэглэл” гэх ажиллагаа нь 3-4 удаа хийгдэж, 14 хуудас бичигдэж, 6 хоног зарцуулсан байна. Тэгвэл “урьдчилсан хэлэлцүүлгийн тэмдэглэл” гэх ажиллагааг 1 удаа хийж, 3 хуудас бичиж, 6 хоног зарцуулсан байна.



Зураг 4.1.11 ЗХХША-ны 3-р үе шатанд ажиллагааны тоо, хуудас, хоног, ажиллагааны төрлөөр

ХХША-ны 3-р үе шат. Өндөр дүнтэй болон онцлогтой байгаа зарим үзүүлэлтийг тайлбарлая. Зураг 4.1.10-аас харвал “баримт”, “шүүгчийн захирамж” гэсэн үзүүлэлт өндөр дүнтэй байна. 2 хуудас бүхий 1 захирамж боловсруулахад 0.1 хоног буюу 1 өдрийн дотор багтах хугацааг зарцуулсан байна. Хавтаст хэргийн материалд хийх шинжилгээнд өгсөн хоногийн өгөгдөлд 0.1 гэх дүн нь 1 хоногт хүрэхгүй, ажлын 1 хоногоос бага хугацааг зарцуулж хийгдсэн болохыг илэрхийлж байна. Иймд огноо нь тодорхойгүй ажиллагааг ямар ч хугацаа зарцуулаагүй гэж үзэхээс сэргийлж, зурагт 0.1 гэсэн тоогоор, харин тайланд энэ мэтчилэн тохиолдолд энд дурдсан агуулгатай ижил зарчмаар бичиж, дүгнэв.




4.1.2 Ердийн журмаар шийдвэрлэсэн захиргааны хавтаст хэргийн материалд хийх шинжилгээ

4.1.2.1 Ердийн журмаар шийдвэрлэсэн захиргааны хавтаст хэргийн танилцуулга


Нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны шүүхэд ердийн журмаар хянан шийдвэрлэсэн дараах 16 төрлийн маргааны нийт 41 хэрэг судалгаанд хамрагдсан. Үүнд:

ГА-газар-4, ТӨ-төрийн алба-4, ТА-татвар-5, ТЕ-тендер-4, ТЗ-тусгай зөвшөөрөл-2, ӨР-өрсөлдөөн-2, ГЛ-гааль-2, ОО-оюуны өмч-2, СЗХ-санхүүгийн зохицуулах хороо-3, АМ-ашигт малтмал-4, ТХШ-төрийн хяналт шалгалт-2, БО-боловсрол-2, НД-нийгмийн даатгал-2, УБ-улсын бүртгэл-1, БН-байгаль орчин-1, ЗТ-зам тээвэр-1 хэрэг тус тус байна.

Захиргааны хавтаст хэргийн ажиллагааны тоог дараах зургаар харуулав. Зураг 4.1.12-оос харвал газрын маргааны 1-р хэрэгт 350 ажиллагаа хийсэн нь хамгийн их, санхүүгийн зохицуулах хорооны 2-р хэрэгт 20 ажиллагаа хийсэн нь хамгийн бага дүнтэй байна.




Зураг 4.1. 12 Захиргааны хавтаст хэргийн ажиллагааны тоо, анхан шатны шүүхээр



Зураг 4.1. 13 Захиргааны хавтаст хэргийн хуудасны тоо, анхан шатны шүүхээр


Захиргааны хавтаст хэргийн хуудасны тоог дээрх зургаар харуулав. Зураг 4.1.13-аас харвал газрын маргааны 1-р хэрэг хамгийн олон буюу 1370 хуудастай байжээ. Эдгээр 41 хэргээс хамгийн цөөн буюу 53 хуудастай нь тендерийн маргаан байх бөгөөд 150-аас доош хуудастай хэрэг бүх төрлийн маргаанд байгаа бол 200-гаас дээш хуудастай хэрэг газар, тарийн алба, татвар, ашигт малтмалын маргаанд хамаарч байна. Эдгээр маргаан нь шүүхийн статистикийн тайлан мэдээллээр өндөр дүнтэй шийдвэрлэгддэг маргааны төрөлд багтдаг. Иймд шүүгчийн хянан шийдвэрлэх захиргааны маргааны төрөлд элбэг тохиолдох эдгээр маргаан буюу 200-550 хуудас материалаас бүрдсэн хэрэг зонхилох шинжтэй болохыг харуулж байна.



Зураг 4.1. 14 Захиргааны хавтаст хэргийн ажиллагаанд зарцуулсан хугацаа, анхан шатны шүүхээр





Захиргааны хавтаст хэргийн ажиллагаанд зарцуулсан хугацааны өгөгдлийг хоногоор илэрхийлж дээрх зургаар харуулав. Зураг 4.1.14-өөс харвал ажиллагааны тоо болон хуудасны өгөгдөл өндөр дүнтэй байсан маргааны төрлүүдэд зарцуулсан хугацааны өгөгдөл мөн өндөр дүнтэй байгаа шууд хамаарал ажиглагдаж байна. Тэгвэл гаалийн маргааны 2 хэрэг судалгаанаас 2-р хэрэг нь 1-р хэргээсээ ажиллагааны тоогоор 30 хувиар их, хуудасны тоогоор 2 дахин их, зарцуулсан хугацаагаар 2.8 дахин их, татварын маргааны 5 хэрэг судалгаанаас 2-р хэрэг нь 1-р хэргээс ажиллагааны тоогоор 8 хувиар их, хуудасны тоогоор 1.6 дахин их, зарцуулсан хугацаагаар 3.3 дахин их байгаа онцлог тус тус ажиглагдлаа. Иймд ажиллагааны тоо, хуудасны тоо, хугацаа гэсэн 3 төрлийн өгөгдлийн хавтаст хэргийн ерөнхий мэдээллийн хувьд өндөр дүнтэй байгаа маргааны төрөл нь хоорондоо шууд хамааралтай байгаа нийтлэг шинж ажиглагдаж байгаа хэдий ч нэг маргааны төрөл доторх хэрэг тус бүр нь эдгээр 3 төрлийн мэдээллийн хувьд өөр өөр шинжтэй тохиолдлууд ч байна.



Зураг 4.1. 15 Захиргааны хавтаст хэргийн ерөнхий мэдээлэл, дунджаар


Захиргааны 41 хэргийг маргааны төрөл тус бүрээр дундажлаж илэрхийлсэн мэдээллийг Зураг 4.1.15-д харуулав. Дээрх зургаас анхаарал татсан маргааны хувьд тайлбар өгвөл газрын маргаан 158 ажиллагаатай, 274 хуудастай, 624 хоног зарцуулсан, мөн улсын бүртгэлийн маргаан 93 ажиллагаатай, 187 хуудастай, 522 хоног зарцуулсан хэрэг судалгаанд сонгогдсон нь хамгийн өндөр дүнтэй байна. Тэгвэл байгаль орчны маргаанд хамаарах 1 хэрэг судалгаанд хамрагдсан байгаагаас энэ хэрэг нь 93 ажиллагаатай, 187 хуудастай, 93 хоног зарцуулсан байна. Маргааны төрлүүдэд хамаарах нийт хэргүүдийн дундаж мэдээллээс хугацаа бага зарцуулсан хэр нь ажиллагааны тоо болон хуудасны тоо өндөртэй, өөрөөр хэлбэл хугацаа их шаарддаггүй ч давтагдсан шинжтэй, техник ажиллагаа өндөртэй, бусдаасаа ялгарах үйл ажиллагаа ажиглагдахгүй байна.





Зураг 4.1. 16 Захиргааны хавтаст хэргийн ерөнхий мэдээлэл, ХХША-ны үе шатаар


Зураг 4.1.16-аас харвал хэргийг хэлэлцэхэд бэлтгэх болон хэлэлцэх, хэргийг шийдвэрлэх шатанд дийлэнх ажиллагаа хийгдэж, олон тооны хуудас материал хавтаст хэрэгт бүрдэж, эдгээр үе шатанд хамгийн их хугацааг зарцуулж байна. Үүнээс хэргийг шийдвэрлэх буюу 3-р үе шатанд хамаарах мэдээллийг дэлгэрүүлэн тайлбарлавал, судалгаанд хамрагдсан 41 хэргийн хувьд зөвхөн энэ үе шатанд 31 ажиллагаа буюу нийт ажиллагааны 41 хувь нь хийгдэж, 79 хуудас буюу нийт хуудасны 55.3 хувь бүрдэж, 103 өдөр буюу нийт зарцуулсан хугацааны 33 хувь нь хамаарч байна.



Зураг 4.1. 17 ЗХХША-ны үе шат, ажиллагааны тоогоор


Маргааны төрөл тус бүрээр ажиллагааны тоог зураг 4.1.17-д харуулав. Зарим төрлийн маргаанд хамаарах онцлох үр дүнг дэлгэрүүлэн тайлбарлая. Газар, төрийн алба, тусгай зөвшөөрлийн маргаан нь хэргийн 3-н үе шатанд бусдаасаа өндөр дүнтэй байна. Тухайлбал, төрийн албаны маргаан 1-р үе шатанд 61, 2-р үе шатанд 43, 4-р үе шатанд 18 ажиллагаа хийгдсэн дүнтэй байна. Судалгаанд төрийн албаны маргаанаас 4 хэрэг судлагдсан бөгөөд тухайн хэргүүдийн дунджийг бусад маргаантай харьцуулахад 3-н үе шатанд өндөр дүнтэй гарсан маргааны төрөлд багтсан гэж ойлгоно. Энэ нь газар, төрийн алба, тусгай зөвшөөрлийн маргааны төрөл дэх ачаалал нь ажиллагааны тоогоор бусад маргаанаас илүү болохыг харуулж байна.

Тэгвэл хуудас болон хугацааны мэдээллийн хувьд эдгээр маргааны төрлүүд өндөр дүнтэй байх эсэхийг үргэлжлүүлэн шинжилж, үр дүнг дараах зургуудаар харуулбал:



Зураг 4.1. 18 ЗХХША-ны үе шат, хуудсаар

Зураг 4.1.18-аас харахад хавтаст хэргийн хуудасны мэдээллээр мөн л 2 болон 3-р үе шат өндөр дүнтэй буюу 14-154 хуудас, харин 1 болон 4-р үе шат 2-24 хуудастай байна. маргааны төрлийн хувьд 2 болон 3-р үед газар, байгаль орчин, төрийн алба, тусгай зөвшөөрлийн маргаанд бүрдсэн хуудасны тоо илүү байгаа бол 1-р үед гааль, газар, зам тээвэр, төрийн албаны маргаан, 2-р үед газар, төрийн алба, тусгай зөвшөөрөл гэсэн маргааны төрөлд хамаарах хуудасны тоо өндөр дүнтэй байна.




Зураг 4.1. 19 ЗХХША-ны үе шат, хоногоор

Зураг 4.1.19-өөр 2-р үед хамгийн ихдээ газрын маргаан 278 хоног, төрийн албаны маргаан 193 хоног, 3-р үед боловсролын маргаан 316, газрын маргаан 213 хоног, 4-р үед байгаль орчны маргаан 154 хоног, газрын маргаан 115 хоног, төрийн албаны маргаан 109 хоног зарцуулсан бол хамгийн бага хугацаа зарцуулсан маргааны төрөлд 3-р үед зам тээврийн маргаан 10 хоног, тендерийн маргаан 4 хоног, 4-р үед нийгмийн даатгалын маргаан 14 хоног тус тус зарцуулсан дүнтэй байна.




4.1.2.2 Ердийн журмаар шийдвэрлэсэн захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хийх шинжилгээ

Маргааны төрөл тус бүрд хамраах ажиллагааны тооны мэдээллийг зураг 4.1.20-4.1.23-аар, хуудасны тооны мэдээллийг 4.1.24-4.1.27-оор, хугацааны мэдээллийг 4.1.28-4.1.31-ээр тус тус харуулав.



Зураг 4.1.20 XXIIIA-ны 1-р үе шатанд хийгдсэн ажиллагаа, маргааны төрлөөр


1-р үе шатанд 5 төрлийн ажиллагаа байгаагаас ихэнх ажиллагааны төрөл нь 1-2 удаагийн давтамжтай байна. Хамгийн ихдээ газрын маргаанд 3-4 ажиллагаа хийджээ. Хавтаст хэргийн материалыг судлах явцад XXIIIA-ны 1-р үе буюу хэрэг үүсгэх эсэхийг шийдвэрлэх шатанд гол төлөв нэхэмжлэл унших, судлах, бүрдүүлбэр хангуулах, хэрэг үүсгэх эсвэл татгалзах захирамж гаргах, тэдгээртэй холбоотой баримтыг үйлдэх ажлыг хийсэн байна. Тэгвэл эдгээрээс гадна хүсэлт нь газар болон оюуны өмчийн маргаанд, шүүгчдийн зөвлөгөөний тогтоол нь төрийн албаны маргаанд хамаарч хийгдсэн ажиллагаа байна. Иймд газар болон оюуны өмчийн маргаанд нэхэмжлэл дээр нэмээд хүсэлтийг шүүгч уншиж, судлах ажиллагаа мөн хийгдсэн гэж ойлгоно.



Зураг 4.1. 21 XXIIIA-ны 2-р үе шатанд хийгдсэн ажиллагаа, маргааны төрлөөр




Зураг 4.1.21-ээс харвал судалгаанд хамрагдсан 16 төрлийн маргаанд хамаарах нийт 41 хэрэгт ХХША-ны 2-р үе шатанд 11 төрлийн ажиллагаа хийгдсэн байна. Үүнээс баримт, шүүгчийн захирамж, албан бичиг, нотлох баримт шаардсан албан бичиг, шүүгчдийн зөвлөгөөний тогтоол зэрэг ажиллагаа өндөр дүнтэй байна. Харин гомдол нь 3 төрлийн маргаанд 1-2 давтамжтай, хүсэлт нь 7 төрлийн маргаанд 1-3 удаагийн давтамжтай байна. Ажиллагааг төрлийн хувьд авч үзвэл баримт, шүүгчийн захирамж, албан бичиг нь бараг бүх төрлийн маргаанд бусад ажиллагаанаас олон удаагийн давтамжтайгаар хийгдсэн байна.



Зураг 4.1. 22 ХХША-ны 3-р үе шатанд хийгдсэн ажиллагаа, маргааны төрлөөр


Зураг 4.1.22-оос харвал 3-р үе шатанд баримт, шүүхийн тогтоол, шүүгчийн зөвлөгөөний тогтоол, шүүгчийн захирамж, шүүх хуралдааны тэмдэглэл гэсэн ажиллагаа бусдаасаа илүү давтамжтайгаар хийгдсэн байна. Энэ үе шатанд бусад үе шаттай харьцуулахад хүсэлт хамгийн өндөр дүнтэй гарч байгаа тул шүүгчээс хүсэлттэй танилцах, хангах эсэхийг шийдвэрлэх ажиллагааны давтамж буюу шүүгчийн захирамж, тогтоол боловсруулах, хянах ажиллагаа нэмэгдэж байна.




Зураг 4.1. 23 ХХША-ны 4-р үе шатанд хийгдсэн ажиллагаа, маргааны төрлөөр



Зураг 4.1.23-аас харвал энэ үе шатанд маргааны төрлөөс хамаарч 1-5 удаагийн давтамжтай хийгдсэн гомдол гэх ажиллагааны өгөгдлийг цуглуулахдаа анхан шатны шүүхэд тухайн гомдлыг хүлээн авч, давж заалдах шатанд хүргүүлэх ажлыг гүйцэтгэдэг практиктай холбогдуулан анхан шатны ажиллагаанд дүнд багтааж тоолж гаргасан байна. Гомдлыг хавтаст хэргийн хамт давж заалдах шатны шүүхийн шүүгч уншиж, судалсан ажил нь давж заалдах шатны шүүхийн шүүгчийн ажиллагаа юм.




Зураг 4.1.24-өөс харвал ХХША-ны 1-р үе шатанд шүүхэд хүлээн авсан нэхэмжлэлийн хуудасны тоогоор зам тээврийн маргаан 10, байгаль орчны маргаан 8 байгаа нь бусад маргааны төрлийн нэхэмжлэлийн хуудаснаас илүү дүнтэй байгаа бол шүүгчийн захирамжийн хувьд гаалийн маргаан 8, байгаль орчны маргаан 7, зам тээврийн маргааны 10 хуудастай байгаа нь өндөр дүнтэй байна. Харин улсын бүртгэл, боловсролын маргааны ажиллагааны хуудасны тоо бусад маргаанаас бага дүнтэй байна.



Энэ үе шатанд 11 төрлийн ажиллагаа хийгдсэн байгаагаас зураг 4.1.25-д өндөр дүнтэй болон олон төрлийн маргааны хувьд хийгдсэн 9 ажиллагааг сонгон харуулав. Шинжилгээнд шүүгч урьдчилсан хэлэлцүүлэг болон шүүх хуралдааны тэмдэглэлээс бусад тэмдэглэлтэй танилцах, хянах ажиллагааг бусад тэмдэглэл гэх ажиллагаанд хамааруулж судлав. Байгаль орчны маргааны бусад тэмдэглэл 23 хуудас, тусгай зөвшөөрлийн маргааны урьдчилсан хэлэлцүүлгийн тэмдэглэл 20 хуудас, газар болон




байгаль орчны маргааны нотлох баримт шаардсан албан бичиг боловсруулах, хянах ажиллагаа 23 болон 19 хуудастай байгаа нь хамгийн өндөр дүнтэй байна. Харин энэ үе шатанд шүүхэд гаргасан гомдол нь захирамж тогтоолд гаргасан гомдол тул анхан шатны шүүхийн шүүгч уг гомдлыг хүлээн авах, унших, хянах ажиллагаа хийгдэхгүй, давж заалдах шатны шүүхийн шүүгчийн ажиллагаанд хамааруулж ойлгоно. Бусад тогтоол гэх нэршлээр шүүхийн тогтоолыг судаллаа. Иймд 4.1.25 болон 4.1.27-д харуулсан гомдлын хуудасны тоо, зарцуулсан хугацаа нь давж заалдах шатны шүүхийн шүүгчийн ажиллагаанд тооцогдоно.



Зураг 4.1. 26 ХХША-ны 3-р үе шатанд хийсэн ажиллагааны хуудасны тоо, маргааны төрлөөр


Зураг 4.1.26-аас харвал ХХША-ны 3-р үе шатанд газрын болон төрийн албаны маргааны үзүүлэлтүүд бусад маргааны үзүүлэлтээс өндөр дүнтэй байна. Баримт, шийдвэр, шүүгчийн захирамж, шүүх хуралдааны тэмдэглэл гэсэн ажиллагаа нь маргааны бүх төрөлд 1-56 удаагийн давтамжтай хийгдэж байна. Тэгвэл зарим ажиллагааны хувьд судалгаанд хамрагдсан 16 төрлийн маргааны 4-5 маргааны төрөлд л хамаарч байгаа тохиолдлууд гарч байна. Тухайлбал, хүсэлт, бусад тэмдэглэл зэрэг нь нийтлэг шинжтэй ажиллагаа биш болох нь харагдаж байна.



Зураг 4.1. 27 ХХША-ны 4-р үе шатанд хийсэн ажиллагааны хуудасны тоо, маргааны төрлөөр




Зураг 4.1.27-оос харвал баримт, гомдол, албан бичигт хамаарах ажиллагааны дүн өндөр байна. Эдгээр нь мөн л газар, төрийн алба, тусгай зөвшөөрлийн маргаанд хамаарч байна.




Зураг 4.1. 28 ХХША-ны 1-р үе шатанд хийсэн ажиллагаанд зарцуулсан хоног, маргааны төрлөөр

Зураг 4.1.28-аар ХХША-ны 1-р үе шатанд хийсэн ажиллагаанд зарцуулсан хугацааны мэдээллийг хоногоор харуулав. Хавтаст хэргийн судалгаанд ажиллагааны тоо буюу давтамж, хуудасны тооны мэдээлэл нь тухайн үе шатанд хэргийн оролцогч болон тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгчөөс мөн шүүхээс гаргасан материал бүгд тоолж, бүртгэгдсэн бол зарцуулсан хугацааг хоногоор илэрхийлсэн мэдээлэл нь зөвхөн шүүхээс хийгдсэн ажиллагаанд хамаарч байхаас гадна дараалсан ажиллагаа хоорондын хугацаагаар илэрхийлэгджээ.


ХХША-ны 1-р үе шатанд зураг 4.1.28-д харуулсан 3 төрлийн ажиллагаанд хамаарах зарцуулсан хугацааны мэдээллийг хавтаст хэргийн судалгаанаас гаргах боломжтой байсан. Үүнээс энэ үе шатанд шүүгчийн захирамж гэсэн ажиллагаа нь нийт судлагдсан 16 төрлийн маргаанд хийгдэж, бусад ажиллагааны төрлөөс илүү хоног зарцуулсан байна. Хамгийн ихдээ оюуны өмчийн маргааны захирамжид дунджаар 20 хоног зарцуулсан бол хамгийн багадаа тендерийн маргааны захирамжид 4 хоног зарцуулсан дүнтэй байна. Шүүгчдийн зөвлөгөөний тогтоол гэх ажиллагаа нь зөвхөн төрийн албаны маргаанд хийгдсэн бөгөөд түүнийг 1 хоногийн дотор хийсэн ажиллагаанд хамааруулж мэдээллийг бүртгэсэн байна. Учир нь энэ ажиллагаа нь өмнөх ажиллагаатай огнооны хувьд 1 ижил байгаа учраас өгөгдлийг тоолж гаргахад ийм тохиолдлыг 1 хоног дотор багтаж хийгдсэн ажиллагаанд хамааруулан судалсан. Баримт гэх ажиллагаанд зарцуулсан хоногийн мэдээллийг хавтаст хэргийн материалаас тоолж гаргахад хүндрэлтэй байдлууд үүсэж байсан нь тодорхой байна. Энэ нь зарим баримтын хувьд огноогүй, зарим баримтад гарын үсэг зурсан огноогоор ажиллагааны хугацааг тооцохоор, хэргийн өөр өөр оролцогч баримт дээр гарын үсэг зурсан огноо харилцан адилгүй байх тохиолдол олон гарсан байна. Иймд өмнөх ажиллагаатай нэг өдөр хийгдэх боломжтой буюу 1 хоног дотор багтаж хийгдсэн ажиллагаа гэж үзээд дээр дурдсанчлан эдгээрийг 0.1 хоног гэж өгөгдлийг цуглуулсан байна. Гэтэл зарим баримтын хувьд огноо нь байгаа тул өмнөх ажиллагаа хоорондын хоногийн зөрүүг тооцоход 1-р үе шатанд хамгийн ихдээ 14 хоног зарцуулсан баримт хүртэл гарсан байна. Энэ нь боловсролын маргаанд 1 удаа гарсан 1 хуудастай баримт юм. Эндээс дүгнэхэд хугацааг тодорхойлох хоногийн мэдээлэл нь баримт бүрийн хувьд үнэн бодитой гарч чадаагүйг харуулж байна. Харин хавтаст хэрэг уншсан материалын судалгаанд баримтын огноо бичигдсэн тохиолдлыг өмнөх ажиллагааны огноо хоорондын хоногийн зөрүүгээр тооцож гаргахад өөр байдлаар гаргах боломжгүй байсан нь харагдаж байна.






Зураг 4.1. 29 ХХША-ны 2-р үе шатанд хийсэн ажиллагаанд зарцуулсан хоног, маргааны төрлөөр

Зураг 4.1.29-өөс харвал ХХША-ны 2-р үе шатанд 9 төрлийн ажиллагаанд зарцуулсан хугацааны өгөгдөл шинжлэгдсэн байна. Үүнээс зам тээврийн болон санхүүгийн зохицуулах хорооны маргаанаас бусад маргааны хувьд шүүгчийн захирамжийг гаргахад хамгийн багадаа 1 хоног хүрэхгүй, хамгийн ихдээ 58 хоног зарцуулсан байна. Тэгвэл газрын маргааны албан бичигт 70 хоног зарцуулсан мэдээлэл гарсан байна. Судалгаанд газрын маргааны 4 хэрэг судлагдсан бөгөөд эдгээр хэргийн дунджаар энэхүү мэдээлэл гарсан гэж ойлгоно. ЗХХША-ны практикаас харахад нотлох баримт шаардсан албан бичгийг шүүхээс гаргаад дараагийн ажиллагаа хоорондын хугацаа их гарахаар байна. Гэтэл шинжилгээнд ирүүлсэн өгөгдлөөс харахад нотлох баримт шаардаагүй албан бичиг нь нотлох баримт шаардсан агуулгатай албан бичгээсээ зарим маргааны төрлийн хувьд их хугацааг зарцуулсан байгаа нь албан бичиг, нотлох баримт шаардсан албан бичиг зэрэг ажиллагаанд зарцуулсан хугацааны мэдээлэл үнэн зөв эсэхэд эргэлзээг төрүүлж байна.



Зураг 4.1. 30 ХХША-ны 3-р үе шатанд хийсэн ажиллагаанд зарцуулсан хоног, маргааны төрлөөр

Зураг 4.1.30-д ХХША-ны 3-р үе шатанд хамаарах 4 төрлийн ажиллагаанд зарцуулсан хугацааны мэдээллийг хоногоор харуулсан байна.



Зураг 4.1. 31 ХХША-ны 4-р үе шатанд хийсэн ажиллагаанд зарцуулсан хоног, маргааны төрлөөр


Зураг 4.1.31-д ХХША-ны 4-р үе шатанд хийгдсэн ажиллагаанд зарцуулсан хугацааны мэдээллийг харуулав. Зургаас харахад газрын маргааны баримт, байгаль орчны маргааны албан бичигт зарцуулсан хугацаа өндөр дүнтэй гарсан байна. Энэ нь өмнө дурдсанчлан хавтаст хэргийн материалаас ажиллагаанд зарцуулсан хугацааны мэдээллийг гаргахад хүндрэлтэй байсан нөхцөл байдалтай холбоотой юм.



4.1.3 Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн хавтаст хэргийн материалд хийх шинжилгээ


4.1.3.1 Давж заалдах шатны шүүхээс шийдвэрлэсэн захиргааны хавтаст хэргийн танилцуулга

Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхэд ердийн журмаар хянан шийдвэрлэсэн дараах хэргүүд судалгаанд хамрагдсан.




Зураг 4.1. 32 Захиргааны хавтаст хэргийн ажиллагааны тоо, хэрэг тус бүрээр

Зураг 4.1.32-ээс харвал татварын маргааны 5 хэргээс 5 хэрэг давж заалдах шатны шүүхээр шийдвэрлэгдсэн бол санхүүгийн зохицуулах хорооны 3 хэргээс давж заалдах шатны шүүхэд гомдол гарч шийдвэрлэгдсэн хэрэг гараагүй байна. Ажиллагааны тоогоор анхан шатны шүүхийн ажиллагаанд өндөр дүнтэй байсан газрын болон төрийн албаны маргаан мөн өндөр дүнтэй байгаа нийтлэг шинж ажиглагдаж байна.




Зураг 4.1. 33 Захиргааны хавтаст хэргийн ажиллагааны хуудасны тоо, хэрэг тус бүрээр

Зураг 4.1.33-д давж заалдах шатны шүүхээс хянан шийдвэрлэсэн хэрэг дэх тухайн шатанд хамаарч байгаа ажиллагааны хуудасны тоог харуулав. Хамгийн ихдээ газрын маргааны 1-р хэрэгт 198 хуудас, төрийн албаны маргааны 2-р хэрэгт 106 хуудас материал бүрдсэн бол хамгийн багадаа тендерийн маргааны 1-р хэрэг 16 хуудастай, 2-р хэрэг 17 хуудастай байжээ. Давж заалдах шатны шүүхэд хийгдсэн ажиллагааны тоо, бүрдсэн хуудасны тоо зэрэг нь нэг талаас зураг 4.1.33 болон 4.1.34-т харуулсан тухайн шатны шүүхийн ажиллагааны дүнгээр илэрхийлэгдэх бол нөгөө талаас уншиж судалж буй материал, түүний хуудасны тооны хувьд анхан шатанд бүрдсэн бүх материал бүхэлдээ багтах агуулгатай юм. Иймд давж заалдах шатны шүүхийн уншиж, судлах материал, түүний хуудасны тоо нь анхан шатны шүүхийнхээс илүү болох нь тодорхой байгаа учраас ажиллагааны тооноос гадна унших, судлах, хянах материал, хуудасны тооны хувьд давж заалдах шатны шүүгч өндөр ачаалалтай байна. 2 өөр шатны шүүхийн ажиллагааны тоо, хуудасны тоо, зарцуулсан хугацаа буюу хоног гэсэн хэмжээсийг хооронд нь харьцуулах боломжгүй юм. Учир нь шат шатны шүүх нь өөр өөр эрх хэмжээ, хууль, журмыг үйл ажиллагаандаа мөрдөж байгаа бол ижил шатны шүүхийн үйл ажиллагаанд ижил хууль, журам, эрх хэмжээ мөрдөгдөж байгаа учраас тэдгээрийн ачааллыг хооронд нь харьцуулан судлах, дүгнэх нь илүү ач холбогдолтой юм. Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн хувьд Улсын хэмжээнд нэг байдаг онцлогтой тул зэрэгцүүлэх, харьцуулах ижил шатны шүүх байхгүй, энэ төрлийн мэдээлэл шинжилгээнд ирээгүй болно.




Зураг 4.1. 34 Захиргааны хавтаст хэргийн ажиллагаанд зарцуулсан хугацаа, хэрэг тус бүрээр

Зураг 4.1.34-өөс харвал газрын, төрийн албаны, ашигт малтмалын маргаанд хугацаа илүү зарцуулдаг болох нь харагдаж байна. Эдгээр маргааны төрөл нь шүүхийн статистик тайлан, мэдээллээр шийдвэрлэсэн хэргийн дүнд өндөр дүн эзэлдэг байна.



Зураг 4.1. 35 ДЭШШ-д шийдвэрлэсэн захиргааны хавтаст хэргийн ерөнхий мэдээлэл, дунджаар


Захиргааны 36 хэргийн мэдээллийг маргааны төрөл тус бүрээр дундажлаж илэрхийлсэн дүнг Зураг 4.1.35-д харуулав. Дээрх зургаас анхаарал татсан маргааны хувьд тайлбар өгвөл газрын маргаан 52 ажиллагаатай, 114 хуудастай, 225 хоног зарцуулсан, мөн төрийн албаны маргаан 34 ажиллагаатай, 66 хуудастай, 143 хоног зарцуулсан хэрэг судалгаанд сонгогдсон нь хамгийн өндөр дүнтэй байна. Тэгвэл санхүүгийн зохицуулах хороонд холбогдох 3 хэрэг АШШ-д хянагдсан ч эдгээр хэрэг давж заалдах шатны шүүхэд гомдол гарч хянагдсан тохиолдол гараагүй байна. Зам тээврийн маргаанд хамаарах 1 хэрэг судалгаанд хамрагдсан байгаагаас энэ хэрэг нь 9 ажиллагаатай, 19 хуудастай, 64 хоног зарцуулсан нь хамгийн бага дүнтэй байна.



Зураг 4.1. 36 ДЭШШ-д шийдвэрлэсэн захиргааны хавтаст хэргийн ерөнхий мэдээлэл, ХХША-ны үе шатаар




Зураг 4.1.36-аас харвал хэргийг хэлэлцэхэд бэлтгэх болон хэлэлцэх, хэргийг шийдвэрлэх шатанд дийлэнх ажиллагаа хийгдэж, олон тооны хуудас материал хавтаст хэрэгт бүрдэж, эдгээр үе шатанд хамгийн их хугацааг зарцуулж байна. Үүнээс хэргийг шийдвэрлэх буюу 2-р үе шатанд хамаарах мэдээллийг дэлгэрүүлэн тайлбарлавал, судалгаанд хамрагдсан 36 хэргийн хувьд зөвхөн энэ үе шатанд 12 ажиллагаа буюу нийт ажиллагааны 53.4 хувь нь хийгдэж, 35 хуудас буюу нийт хуудасны 74 хувь бүрдэж, 42 өдөр буюу нийт зарцуулсан хугацааны 39 хувь нь хамаарч байна.



Зураг 4.1. 37 ЗХДЗШШ-ийн ХХША-ны үе шатанд хийгдсэн ажиллагааны тоо, маргааны төрлөөр

Маргааны төрөл тус бүрээр ажиллагааны тоог зураг 4.1.37-д харуулав. Зарим төрлийн маргаанд хамаарах оцлох үр дүнг дэлгэрүүлэн тайлбарлая. Газар, төрийн алба, ашигт малтмалын маргаан нь хэргийг 3-н үе шатанд бусдаасаа өндөр дүнтэй байна. Тухайлбал, газрын маргаан 2-р үе шатанд 5, 3-р үе шатанд 30, 4-р үе шатанд 17 ажиллагаа хийгдсэн дүнтэй байна. Судалгаанд газрын маргаанаас 4 хэрэг судлагдсан бөгөөд тухайн хэргүүдийн дунджийг бусад маргаантай харьцуулахад дээрх 3-н үе шатанд өндөр дүнтэй гарсан маргааны төрөлд багтсан гэж ойлгоно. Энэ нь газар, төрийн алба, ашигт малтмалын маргааны төрөл дэх ачаалал ажиллагааны тоогоор бусад маргаанаас илүү болохыг харуулж байна.




Зураг 4.1. 38 ЗХДЗШШ-ийн ХХША-ны үе шатанд бүрдсэн хуудасны тоо, маргааны төрлөөр

Зураг 4.1.38-аас харвал 3-р үед хамгийн ихдээ газрын маргаан 90 хоног, төрийн албаны маргаан 53 хоног, 4-р үед газрын маргаан 17 хуудас, төрийн албаны маргаан 12 хуудас бүрдсэн бол хамгийн бага нь 3-р үед зам тээврийн маргаан 14 хуудас бүрдсэн дүнтэй байна. Давж заалдах шатны шүүхийн ажиллагаанд 3-р үе ачаалал ихтэй байна. 1-р үед хамаарах өгөгдөл шинжилгээнд ирээгүй тул зургаар харуулах боломжгүй байсан. Хуульд заасан журмын хувьд захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн онцлогийг илэрхийлэх ажиллагаа нь захирамж, тогтоолыг хянадаг ажиллагаа байдаг. Энэ тухай Суурь судалгаанд ч мөн дурдсан байна. Давж заалдах шатны шүүхийн шүүгчийн ажиллагааны ачааллыг судлах ажилд захирамж, тогтоол хянах ажиллагаа заавал хамаарна. Иймд АШШ-ийн ХХША-ны 1-р үе шатанд гомдол гарсан тохиолдолд ДЗШШ-ийн ХХША-ны 1-р үе шатанд холбогдох ажиллагааг тоолж, нөхөх шаардлагатай байжээ. Энэ тохиолдолд ДЗШШ-ийн ХХША-ны 1-р үе шатанд ажиллагааны төрлийн хувьд үндсэн ажиллагаа нь шүүхийн тогтоол, харин баримт зэрэг бусад дагалдах ажиллагаа байхаар ойлгох юм. Шинжилгээнд өгсөн өгөгдлөөс харахад ДЗШШ-ийн ХХША-ны 1-р үе шатанд тоолж, нөхөх байсан энэхүү ажиллагаа нь бусад үе шатанд



ангилагдаж тоологдсон байх тул шинжилгээнд орхигдоогүй, өгөгдлөөсөө шалтгаалан ХХША-ны бусад үе шатанд хамт судлагдсан гэж ойлгоно.




Зураг 4.1. 39 ХХДЗШШ-ийн ХХША-ны үе шатанд зарцуулсан хугацаа, маргааны төрлөөр

Зураг 4.1.39-өөс харвал ХХША-ны 3 болон 4-р үе шатанд зарцуулсан хугацаа өндөр дүнтэй байна. 4-р үе шат нь хэргийг шийдвэрлэсний дараа үе шат бөгөөд энэ шатанд зарцуулсан хугацаа өндөр гарсан нь нэг талаас зарим төрлийн ажиллагаа хуульд заасан хугацаанд хийгдээгүй, ингэж удаашрах дотоод болон гадаад тодорхой хүчин зүйлүүд байсантай холбогдож болох боловч нөгөөд талаас өгөгдөл цуглуулах, бүрдүүлэх ажиллагаа үнэн зөв хийгдсэн эсэхэд мөн эргэлзээ төрүүлж байна.


4.1.3.2 Давж заалдах шатны шүүхийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хийх шинжилгээ

Давж заалдах шатны шүүхээр хянагдсан маргааны төрөл тус бүрд хамраах ажиллагааны тооны мэдээллийг зураг 4.1.40-4.1.42-оор, хуудасны тооны мэдээллийг 4.1.43-4.1.45-аар, хугацааны мэдээллийг 4.1.46-4.1.48-аар тус тус харуулав.




Зураг 4.1. 40 ХХДЗШШ-ээс ХХША-ны 2-р үе шатанд хийсэн ажиллагааны тоо, маргааны төрлөөр

Зураг 4.1.40-д харуудсан 8 төрлийн ажиллагаа нь 2-р үе шатанд хийгдсэн байна. Энэ үед хийгдсэн ажиллагаа нь хэлбэлзэл бага, хамгийн ихдээ ажиллагааны нэг төрөл нь 3 хүртэл давтамжтай байна. 15 төрлийн маргааны хавтаст хэргийг давж заалдах шатны шүүхээс хянаснаас бүх маргаанд дээрх 8 төрлийн ажиллагаа хийгдсэн нийтлэг тохиолдол гараагүй байна. Тухайлбал, бусад тэмдэглэл зөвхөн газар, татвар, тендерийн маргаанд, албан бичиг нь газар, байгаль орчин, татвар, тендер, боловсрол, төрийн хяналт шалгалт, төрийн албаны маргаанд тус тус хийгджээ.



Зураг 4.1. 41 ЗХДЗШШ-ээс ХХША-ны 3-р үе шатанд хийсэн ажиллагааны тоо, маргааны төрлөөр

Зураг 4.1.41-ээс харвал ХХША-ны 3-р үе шатанд 10 төрлийн ажиллагаа хийгджээ. Эдгээрээс баримт, шүүгчийн захирамж, бусад тогтоол гэсэн ажиллагаа өндөр дүнтэй байна. Маргааны төрлийн хувьд мөн л газар, төрийн алба, ашигт малтмалын маргаанд хийгдсэн эдгээр ажиллагаа өндөр дүнтэй байна. 15 төрлийн маргаан дотор албан бичиг, бусад тэмдэглэл гэсэн ажиллагаанууд зөвхөн 5-6 төрлийн маргаанд хийгдсэн байна. Энэ үе шатанд хамаарах өгөгдлөөс тогтоол, бусад тогтоол гэсэн 2 өгөгдөл байгаа нь бусад тогтоолд ХХША-ны явцад ДЗШШ-ээс гарч байгаа тогтоолууд хамаарч байгаа бол “тогтоол” гэх ажиллагаанд ямар агуулга хамаарч байгаа нь тодорхойгүй байна. Хяналтын шатны шүүхийн өгөгдөл⁶ дэх тогтоол ажиллагаа нь хяналтын шатны шүүхийн шийдвэр буюу хяналтын тогтоол гэсэн агуулгын хүрээнд тоолж бүртгэгдсэн бол давж заалдах шатанд “тогтоол” гэх ажиллагаагаар юуг төлөөлүүлсэн нь ойлгомжгүй байна. Магадгүй тогтоол+бусад тогтоол буюу нэг агуулгыг өөр өөр ажиллагааны нэршлээр тоолж бүртгэсэн тохиолдол байхыг үгүйсгэхгүй юм. Иймд өгөгдлийг цуглуулах, тоолж, нөхөх ажиллагаа нь ойлгомжтой, давхцалгүй, тодорхой ангилагдсан, үнэн зөв, эргэлзээгүй байх, цаашид ийм шаардлага хангасан өгөгдлөөр мэдээллийн баазаа бүрдүүлэх шаардлагатайг энд онцлон дурдахаар байна.




Зураг 4.1. 42 ЗХДЗШШ-ээс ХХША-ны 4-р үе шатанд хийсэн ажиллагааны тоо, маргааны төрлөөр

ХХША-ны 4-р үе шатанд төрлийн хувьд 6 ажиллагаа хийгдсэн байна. Зураг 4.1.42-т эдгээрээс 14-15 төрлийн маргаанд хийгдсэн 3 төрлийн ажиллагааг сонгон харуулав. Харин гомдол, тогтоол, шүүгчийн захирамж гэсэн ажиллагаа нь зөвхөн 1-2 маргааны төрөлд хийгджээ. Маргааны төрлийн хувьд 4-р үе шатанд газар, төрийн хяналт

⁶ Хяналтын шатны өгөгдөл шинжилгээнд ирсэн ч шинжилгээ хийх хугацаанд захирагдан өгөгдлийг программаар шинжилж, тайлан хэлбэрээр боловсруулаагүй болно. Харин ШЕЗ-ын ажлын албанаас бие даан хийсэн “Хавтаст хэргийн баримт бичгийн судалгаа”-нд хяналтын шатны шүүхийн өгөгдөл судлагдсан байна.




шалгалт, төрийн алба, тусгай зөвшөөрлийн маргаанд хийгдсэн ажиллагааны давтамж өндөр дүнтэй байна.




Зураг 4.1. 43 ЗХДЗШШ-ээс ХХША-ны 2-р үе шатанд хийсэн ажиллагааны хуудасны тоо, маргааны төрлөөр

Зураг 4.1.43-аас харвал оюуны өмчийн маргааныг гомдол нь 9 хуудас материал байсан нь хамгийн өндөр дүнтэй байна. Бусад ажиллагааны хувьд 1 хуудастай байгаа нийтлэг шинж харагдаж байгаа нь энэ үе шатанд ажиллагааны тоо буюу давтамж мөн цөөхөн, маш бага дүнтэй байсантай холбоотой.




Зураг 4.1. 44 ЗХДЗШШ-ээс ХХША-ны 3-р үе шатанд хийсэн ажиллагааны хуудасны тоо, маргааны төрлөөр

Зураг 4.1.44-өөс харвал магадлал хамгийн ихдээ 20 хуудас хамгийн багадаа 5 хуудастай үйлдэгдсэн байна. Харин газрын маргааны баримт хамгийн ихдээ 10 хуудас байсан нь газрын маргааны 3 хэрэгт дунджаар 10 хуудас баримт энэ үе шатанд үйлдэгдсэн гэж ойлгоно. Магадлал болон шүүх хуралдааны тэмдэглэл гэсэн 2 ажиллагааны үзүүлэлтийн уялдааг тайлбарлав, газрын маргаанд олон хуудас магадлал мөн тэмдэглэл гардаг, энэ зүй тогтол нь өндөр дүнтэй байгаа ашигт малтмал, төлийн алба, тусгай зөвшөөрлийн маргаанд мөн хадгалагдаж байна.




Зураг 4.1. 45 ЗХДЗШШ-ээс ХХША-ны 4-р үе шатанд хийсэн ажиллагааны хуудасны тоо, маргааны төрлөөр

ХХША-ны 4-р үе шатанд 6 төрлийн ажиллагаа хийгдсэн байгаагаас зураг 4.1.45-д нийтлэг шинжтэйгээр маргааны төрлүүдэд хийгдсэн 3 төрлийн ажиллагааг сонгож харуулав. Өмнөх 3-р шатанд өндөр дүтэй байсан маргааны төрлүүд болох газар, төрийн алба, тусгай зөвшөөрлийн маргаанд хийгдсэн ажиллагааны хуудасны тоо өндөр дүнтэй байна.



Зураг 4.1. 46 ЗХДЗШШ-ээс ХХША-ны 2-р үе шатанд хийсэн ажиллагаанд зарцуулсан хугацаа, маргааны төрлөөр

Зураг 4.1.46-аас харвал газрын маргааны баримтад 32 хоног, шүүгчийн захирамжид 12 хоног албан бичигт 25 хоног, ерөнхий шүүгчийн захирамжид 4 хоног тус тус зарцуулсан байна. Газрын болон төрийн хяналт шалгалтын маргаануудын бусад тогтоолыг 1 хоног дотор ажлын цагт багтааж, газрын маргааны ШЗ тогтоолыг 5 хоногт, тусгай зөвшөөрлийн маргааны ШЗ тогтоолыг 12 хоногт, газрын маргааны бусад тэмдэглэлийг 1 хоног дотор ажлын цагт багтааж, татварын маргааны мөн ажиллагаанд 8 хоног, тендерийн маргааныхад 9 хоног тус тус зарцуулсан байна.




Зураг 4.1. 47 ЗХДЗШШ-ээс ХХША-ны 3-р үе шатанд хийсэн ажиллагаанд зарцуулсан хугацаа, маргааны төрлөөр



Зураг 4.1.47-д давж заалдах шатны шүүхээс хянасан хэргийн ХХША-ны 3-р үе шатанд зарцуулсан хугацааг ажиллагаа болон маргааны төрөл тус бүрээр задлан харуулав. Эндээс магадлалд хамаарах өндөр үзүүлэлтийг тайлбарлая. Бусад ажиллагааны дүнг тайлбарлах зарчим нь ижил болно.

Оюуны өмчийн маргааны магадлалд 6-7 хоног зарцуулсан үр дүн гарсан байна. Судалгаанд энэ төрлийн маргааны 2 хэрэг судлагдсанаас 1-р хэргийн магадлал 0.1 хоног буюу 1 хоног дотор ажлын цагт багтаж хийгдсэн ажлаар тоологдсон бол 2-р хэрэг нь 13 хоног зарцуулсан өгөгдөл шинжилгээнд тус тус өгсөн байна. Иймд 2 хэргийн дунджаар энэ төрлийн маргаанд давж заалдах шатны шүүхийн шүүгч магадлал гаргахад 6-7 өдөр зарцуулсан тооцоо гарчээ.



Зураг 4.1. 48 ЗХДЗШШ-ээс ХХША-ны 4-р үе шатанд хийсэн ажиллагаанд зарцуулсан хугацаа, маргааны төрлөөр

ХША-ны 4-р үе шатанд 5 төрлийн ажиллагаанд зарцуулсан хугацааны өгөгдөл шинжилгээнд ирүүлсэн байна. Үүнээс зураг 4.1.48-аар 3 төрлийн ажиллагааны үр дүнг харуулав. Хамгийн ихдээ төрийн албаны маргааны баримтад 43 хоног, газрын маргааны албан бичигт 46 хоног, төрийн хяналт шалгалтын маргааны бусад тэмдэглэлд 11 хоног зарцуулсан дүнтэй байна. Хугацааны мэдээлэл тухайн хэргийг шийдвэрлэж байгаа шүүгч энэ хэрэгт ажиллагаа хийх үед нэгэн зэрэг хэдэн хэрэг, хэдэн ажиллагааг хамт хийж байсан мэдээлэл байхгүй юм. Судалгаанд 1 шүүгчийн тодорхой хугацааны турш нэгэн зэрэг хийж байсан ажиллагаа хамрагдаагүй тул шинжилгээнд өгсөн хугацааны өгөгдөл нь хэтэрхий ерөнхий, тухайн ажиллагааг хийхэд зарцуулсан хугацааны бодит мэдээллийг өгч чадахааргүй байна.

4.1.4 Захиргааны хавтаст хэргийн материалд хийсэн шинжилгээний дүгнэлт

Хавтаст хэргийг судлах болсон зорилго, шүүхийн статистикийн мэдээ, тайлангийн дүнд тулгуурлан ХХША-ны 1-3, 1-4-н үе шатанд хамаарах ажиллагаа, хуудас, хоног гэсэн 3 төрлийн үзүүлэлтэд 1, 2, 3-н хүчин зүйлийн дисперсийн шинжилгээг хийж дараах дүгнэлтийг гаргаж байна. Дүгнэлтийг өгөхдөө ямар журмаар шийдвэрлэсэн хэрэг болох, аль шатны шүүхийн шүүгчийн ажиллагаа болох, маргааны төрлийн хувьд ажиллагаа тус бүрээр харуулсан дэд хэсгүүдэд ангилж дараах хэлбэрийг сонгов.

- **Хялбаршуулсан журмаар шийдвэрлэсэн захиргааны хэргийн ажиллагааны ачаалал**

Маргааны төрөл. Хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэсэн хэргийн ажиллагаа болон хуудасны тоо, зарцуулсан хугацаанд маргааны төрөл нөлөө багатай буюу ямар төрлийн маргаан байхаас үл хамаарч өөр өөр хэв шинж ажиглагдахгүй байна.

ЗХХША-ны үе шат. Хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэсэн хэргийн ажиллагаа болон хуудасны тоо, зарцуулсан хугацаанд ЗХХША-ны үе шат харилцан адилгүй, шинжтэй байна. Жишээ нь 2-р үе шат буюу “хэргийг шийдвэрлэх үе шат”-нд хамгийн их хугацаа зарцуулагдсан байна. 3-р үе шат буюу “хэргийг шийдвэрлэсний дараах үе шат”-нд хамгийн бага хугацаа зарцуулсан байна.



Ажиллагааны төрөл. ХХША-ны аль ч үе шатанд “баримт” болон “захирамж” гэсэн ажиллагаа өндөр дүнтэй байгаа бол 1-р үе шатанд “нэхэмжлэл”, 2 дугаар үе шатанд “шүүх хуралдааны тэмдэглэл”, 1 болон 2 дугаар үе шатанд “албан бичиг” гэх ажиллагаа өндөр дүнтэй гарсан нь хялбаршуулсан журмаар шийдвэрлэгдсэн дээрх 7 хэргийн ихэнх нь 2-р үе шатанд эвлэрлийг баталж, хэргийг хэрэгсэхгүй болгосон захирамж /шийдвэр/ гарсантай холбоотой байна. Иймд хялбаршуулсан журмаар шийдвэрлэсэн эдгээр хэргийн хувьд ажиллагааны ачаалалд өндөр дүн үзүүлж байгаа ажиллагаа нь “шүүгчийн захирамж”, “шүүх хуралдааны тэмдэглэл”, “албан бичиг”, “баримт” байгаагаас баримтын ажиллагааны тоо их байгаа хэдий ч хуудасны тоо, зарцуулсан хугацаагаар бага, харин албан бичиг нь нотлох баримт шаардсан эсэхээс хамаарч зарцуулсан хугацаагаар харилцан адилгүй байна. Шүүгчийн захирамж нь ажиллагааны тоо, хуудас, хугацааны мэдээлэл жигд өндөр, шүүх хуралдааны тэмдэглэл нь ажиллагааны тоо бага хэдий ч түүнтэйгээ харьцуулахад хуудасны тоо, хугацааны мэдээлэл өндөр гарах зүй тогтол ажиглагдлаа. Эндээс судалгаанд ажиллагааны төрөл болж шинжлэгдсэн 8 төрлийн ажиллагаанаас ачааллыг тодорхойлох хугацааны мэдээлэлд “шүүгчийн захирамж”, “шүүх хуралдааны тэмдэглэл” нь хамгийн их нөлөөлж, “албан бичиг” нь нотлох баримт шаардсан эсэхээс хамаарч тодорхой хэмжээнд нөлөөлж, харин бусад ажиллагаа ачаалалд нөлөө багатай байна.

- ***Ердийн журмаар шийдвэрлэсэн захиргааны хэргийн ажиллагааны ачаалал***

Ердийн журмаар шийдвэрлэсэн захиргааны хавтаст хэргийн судалгаанд Шүүхийн статистикийн мэдээ, тайлангийн дүнд тулгуурлан, хялбаршуулсан журмаар шийдвэрлэсэн 16 маргааны төрөл, ХХША-ны 4-н үе шатанд хамаарах ажиллагаа, хуудас, хоног гэсэн 3 төрлийн үзүүлэлтэд 1, 2, 3-н хүчин зүйлийн дисперсийн шинжилгээг хийж, үр дүнг зургаар харуулсан. Үүнээс дараах дүгнэлтийг гаргаж байна.

Анхан шатны шүүхийн шүүгчийн ажиллагааны ачаалал.

Маргааны төрөл. Газрын болон төрийн албаны маргааны ажиллагааны тоо бусад маргааны төрлөөс илүү өндөр байна. Яг энэ зүй тогтол хуудасны тоо болон хугацааны мэдээлэлд хадгалагдаж байна. Ажиллагааны тоо болон хуудасны тоо, хугацааны мэдээлэл хооронд шууд хамаарал байх бөгөөд газрын маргааны 4 хэрэг судалгаанд хамрагдсанаас 1-р хэрэг бусад 3 хэргээсээ огцом өндөр дүнтэй байгаа бол өрсөлдөөний маргааны 2 хэрэг судлагдсан нь ажиллагааны тоогоор нэг нь нөгөөгөөсөө их эсвэл бага гэсэн хэлбэлзэл ажиглагдахгүй, ижил дүнтэй байна. Эндээс дүгнэхэд аливаа төрлийн маргааны бүх хэрэг өндөр дүнтэй тохиолдол ажиглагдахгүй, харилцан адилгүй өөр өөр шинжтэй болох нь тодорхой байна. Мөн шүүхийн статистик мэдээллээр шийдвэрлэсэн хэргийн дотор өндөр дүн эзэлж байгаа маргааны төрлүүд болох газар, төрийн алба, ашигт малтмалын маргаанууд нь судалгаанд хамрагдсан бусад төрлийн маргаанаас ажиллагааны тоо, хуудасны тоо, зарцуулсан хугацааны мэдээллээр өндөр дүнтэй байна. Энэ нь шүүгчийн шийдвэрлэсэн нийт хэргийн дотор эдгээр маргааны төрлийн эзлэх хувь хэмжээг харгалзан ачааллыг тооцох шаардлагатай болохыг харуулж байна.

3 хүчин зүйлийн дисперсийн шинжилгээгээр ХХША-ны 2 болон 4-р үе шатанд маргааны төрөл хоорондоо өөр өөр хэв шинжтэй гэсэн программын үр дүн гарсан. Энэ нь эдгээр үе шатанд хийгдсэн ажиллагааны тоо, хуудасны тоо, хугацаа нь ямар төрлийн маргаан байхаас шалтгаалан өөр өөр дүнтэй байгааг илэрхийлж байна.

ЗХХША-ны үе шат. Ачааллыг хэмжих ажиллагааны тоо, хуудасны тоо, хугацаа гэсэн 3 төрлийн үзүүлэлтийн хувьд ХХША-ны үе шат өөр өөр хэв шинжтэй байна. Тухайлбал,



“Хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхэд бэлтгэх” буюу 2-р үе шат болон “Хэргийг шийдвэрлэх” буюу 3-р үе шат нь хамгийн их ачаалал өгдөг үеүүд байна. Энэ нь эдгээр үе шатыг бусад үе шаттай харьцуулахад ХХША-ны хугацаа урт, тогтоох, шийдэх шаардлагатай ажиллагааны тоо олон байдагтай холбоотой юм. Аль ч маргааны төрөлд ХХША-ны 2 болон 3-р үе шат өндөр дүнтэй байгаа тул маргааны төрөл ямар байхаас үл хамааран эдгээр үе шат нь бусад үе шатаас өндөр дүнтэй нийтлэг шинжтэй байна.

Ажиллагааны төрөл. 2 болон 3-р үе шатанд хамгийн олон төрлийн ажиллагаа хийгдсэн бөгөөд ХХША-ны 1-4-р үе шатанд бүхэлдээ ажиллагааны төрөл нь өөр өөр хэв шинжтэй гэсэн үр дүн гарсан байна. Энэ нь ажиллагааны төрөл хоорондоо өөр өөр дүнтэй болохыг харуулах байна. Тухайлбал, судалгаанд хамрагдсан нийт хэргийн хувьд шүүгчийн захирамж, албан бичиг, шүүх хуралдааны тэмдэглэл зэрэг ажиллагааны төрлүүд нь хоорондоо эрс тэс өөр өөр дүнтэй, ажиллагааны төрөл бүр хоорондоо ойролцоо, ижил дүн байхгүй гэж ойлгоно. Эдгээрийг нэг ижил гэж авч үзэж болохгүй гэсэн мэдээллийг шинжилгээний үр дүн харуулж байна.

ХХША-ны аль ч үе шатанд шүүгчийн захирамж, баримт гэсэн ажиллагаа өндөр дүнтэй байгаа бол ачаалал ихээр үзүүлж байгаа 2 болон 3-р үе шатанд шүүгчийн захирамж, албан бичиг, шүүх хуралдааны тэмдэглэл, баримт зэрэг ажиллагаа зонхилж байна.

- *Давж заалдах шатны шүүхийн ажиллагааны ачаалал*

Ажиллагааны тоо болон хуудасны тооны хувьд ДЗШШ-ийн ХХША нь өндөр дүнтэй биш байгаа ч хавтаст хэргийн материал уншиж, судлахад АШШ-д бүрдсэн нийт хуудасны тоон дээр ДЗШ-нд хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгч талаас бүрдсэн материал мөн хамаарч байгаа тул энэ агуулгаараа АШШ-ээс ачааллын хувьд бага нөхцөл байдал шууд ажиглагдахгүй байна.

Маргааны төрөл. АШШ-ийн маргааны төрөлд өндөр дүнтэй маргааны төрлүүд ДЗШШ-д мөн адил байна. Судалгаанд хамрагдсан, АШШ-д ердийн журмаар шийдвэрлэсэн 16 төрлийн маргааны 41 хэргээс давж заалдах шатны шүүхэд 15 төрлийн маргааны 36 хэрэг хянагджээ. Эндээс газар, төрийн алба, ашигт малтмал, тусгай зөвшөөрлийн маргааны ажиллагааны тоо, хуудасны тоо, зарцуулсан хугацааны мэдээлэл бусад төрлийн маргаанаас өндөр дүнтэй байна.

ЗХХША-ны үе шат. 1-р үе шатанд хамаарах өгөгдөл шинжилгээнд ирээгүй, энэ үе шатанд хамаарах зарим мэдээлэл дараагийн үе шатанд тоолж, бүртгэгдсэн байх талтай эсвэл судалгаанд хамрагдсан нийт хэргийн хувьд АШШ-д хэрэг үүсгэх эсэхийг шийдвэрлэх үе шатанд захирамж, тогтоолд гомдол гараагүй байж болох юм. 3 болон 4-р үе шатанд ажиллагаа хамгийн их хийгдэж, хуудас ихээр бүрдэж, хугацаа их хэмжээгээр зарцуулсан байна.

Ажиллагааны төрөл. Давтамжийн хувьд баримт, шүүгчийн захирамж, албан бичиг, ерөнхий шүүгчийн захирамж, бусад тэмдэглэл нь олон удаа хийгдсэн бол 15 төрлийн маргаан бүрд нийтлэг шинжтэй хийгдэж байгаа ажиллагаа нь магадлал, шүүгчийн захирамж, албан бичиг, баримт байна. Ерөнхий дүнгээрээ хамгийн ихдээ 10 төрлийн ажиллагаа хийгдсэн бол эдгээр ажиллагаа нь дунджаар 4 удаагийн давтамжтай хийгдсэн дүнтэй байна.

Дараах хүснэгтээр хялбаршуулсан болон ердийн журмаар шийдвэрлэсэн хэрэг, мөн давж заалдах шатны шүүхээс шийдвэрлэсэн 1 хэрэгт хамаарах ажиллагааны тоо, хуудасны тооны мэдээллийг судалгаанд өгөгдлөөр ирүүлсэн үзүүлэлт тус бүрд дундаж хэмжээгээр тооцож, дүгнэв. Маргааны төрлөөс анхан болон давж заалдах шатны шүүхэд



бусад маргаанаас өндөр үзүүлэлттэй байгаа маргааныг сонгож мөн дунджийг гаргахад 15-16 төрлийн маргааны дунджаас газрын маргаан, төрийн албаны маргаан хамаагүй өндөр дүнтэй болох нь тодорхой байна.

№	Төрөл	Шийдвэр, магадлал	Шүүгчийн захирамж	Шүүхийн тогтоол	Нэхэмжлэл	Хүсэлт	Гомдол	НБ албан бичиг	Гүйцэтгэх хуудас	УХ тэмдэглэл	ШХ тэмдэглэл	Бусад тэмдэглэл	ШЗ тогтоол	ЕШ захирамж	Албан бичиг	Баримт
1	ХЖ	-	3.6	-	1.7	-	-	-	-	1	3.7	1	2.5	1.5	4	6.1
2	ЕЖ	1.3	3.8	3.2	1.2	2.7	1.5	7	1.3	1.7	4.7	1.6	3	2	3.8	8.1
	ГА маргаан	1.8	7.4	13	1.3	1	2.5	21	-	1	10.8	3.3	8.8	3.5	7.5	15.1
	ТӨ маргаан	1.8	5.5	3	1.3	1.3	1	-	7.5	2.5	9.3	2.7	2.6	4	7	12.9
	АМ маргаан	1.3	3.8	-	1	7	-	6.7	1	1.3	4	1	2.3	2.3	1.4	8.4
	ТЗ маргаан	1.5	3.1	1	1.5	1.5	1.8	4	2	4	3	2	5.5	1	3	7.9
3	ДЗШШ	1.3	1.8	2.6	-	1.6	1.4	-	-	-	2.3	1.4	2.7	1.9	1.9	2.7
	ГА маргаан	2.0	4.2	2.7	-	-	-	-	-	-	5.7	1.4	3.5	3.3	4.5	6.2
	АМ маргаан	1.8	2.6	4.0	-	-	1.0	-	-	-	3.8	1.5	1.5	4.5	2.5	3.7
	ТӨ маргаан	1.3	1.7	5.0	-	1.0	2.0	-	-	-	2.3	1.0	-	1.7	3.2	2.5
	ТЗ маргаан	1.5	3.0	1.5	-	-	-	-	-	-	3.0	2.0	5.0	2.0	4.0	2.7

Хүснэгт 4.1. 15 Шат шатны шүүхэд хянан шийдвэрлэсэн захиргааны 1 хэрэгт хийгдсэн ажиллагааны тоо, дунджаар

Хүснэгт 4.1.1-ийн утгыг хялбаршуулсан болон ердийн журмаар шийдвэрлэсэн хэрэгт хийгдсэн ажиллагааны тоо буюу давтамжийн хүрээнд тайлбарлая. Хялбаршуулсан журмаар шийдвэрлэсэн хэрэгт 9 төрлийн ажиллагаа, ердийн журмаар шийдвэрлэгдсэн хэрэгт 15 төрлийн ажиллагаа хийгдсэн байна. Үүнээс шүүгчийн захирамж дунджаар тус бүр 4 удаа, шүүх хуралдааны тэмдэглэл хялбаршуулсан журмаар шийдвэрлэсэн хэрэгт 4, ердийн журмаар шийдвэрлэсэн хэрэгт 5 удаа гарсан байна. Энэ мэтчилэн хүснэгтээр харуулсан ажиллагааны дундаж утгыг ойлгох зарчим нь ижил болно.

№	Төрөл	Шийдвэр, магадлал	Шүүгчийн захирамж	Шүүхийн тогтоол	Нэхэмжлэл	Хүсэлт	Гомдол	НБ албан бичиг	Гүйцэтгэх хуудас	УХ тэмдэглэл	ШХ тэмдэглэл	Бусад тэмдэглэл	ШЗ тогтоол	ЕШ захирамж	Албан бичиг	Баримт
1	ХЖ	-	15.7	-	2.2	-	-	-	-	3.3	14	2.7	5.5	2	7	18.7
2	ЕЖ	16	7.2	6.7	2.6	5.1	2.8	7.1	2.3	5.7	27.8	3.8	6.8	2.3	4	8.5
	ГА маргаан	24.3	11.8	27.5	1.8	2.3	6.8	23	-	3	56.3	5.3	15.5	3.7	7.7	15.5
	ТӨ маргаан	25.5	11.4	4.5	2.3	1.7	1.5	-	-	7.5	51.3	4.7	6.9	4.3	7	13.9
	АМ маргаан	14.3	6.6	-	2.5	22.5	2.5	7	2	5	20.3	1.3	4.5	2.7	1.4	8.6
	ТЗ маргаан	19.0	5.6	1	1.5	-	2	4	3	20	21	5	9	1	3.3	9.3
3	ДЗШШ	9.6	2.1	8.7	-	4.1	2.9	-	-	-	11.9	1.4	3.4	2	2	2.9
	ГА маргаан	20	5.3	12.3	-	-	-	-	-	-	31.3	1.4	6.5	3.3	4.5	6.9
	АМ маргаан	13.3	3.6	12.5	-	-	1	-	-	-	16.5	1.5	4.5	4.5	2.6	4
	ТӨ маргаан	9	1.7	6	-	3	3	-	-	-	12	1	-	1.7	3.2	2.5
	ТЗ маргаан	14.5	3	6.5	-	-	-	-	-	-	18	2.5	-	2	4	2.7

Хүснэгт 4.1. 16 Шат шатны шүүхэд шийдвэрлэсэн захиргааны 1 хэрэгт хийгдсэн ажиллагааны хуудасны тоо, дунджаар

Хүснэгт 4.1.2-ын утгыг газрын маргаанд хийгдсэн ажиллагааны дунджид холбогдуулан тайлбарлая. Энэ маргаанд шийдвэр 24, шүүхийн тогтоол 28, нотлох баримт шаардсан албан бичиг 23, шүүх хуралдааны тэмдэглэл 56, шүүгчдийн зөвлөгөөний тогтоол 16 хуудас үйлдэгдсэн бөгөөд ердийн журмаар шийдвэрлэсэн хэргийн ажиллагаа, мөн бусад маргааны төрлийн ажиллагаанаас хамгийн өндөр дүнтэй маргааны төрөл болох нь харагдаж байна.



Захиргааны хавтаст хэргийн материалд хийсэн шинжилгээний хүрээн дэх санал

Хавтаст хэргийн материалыг уншиж, судлах ажлын дүнд ажиллагааны тоо болон хуудасны тооны бодит мэдээллийг гарган авах замаар бүрдүүлсэн өгөгдлийг цаашид хэргийн хөдөлгөөний удирдлага болон холбогдох бусад үйл ажиллагаанд зориулан баяжуулж, судалгааны эргэлтэд оруулах,

1. Зарцуулсан хугацааны мэдээлэл нь ажиллагааны төрөл бүрд хавтаст хэрэгт уншилт хийж тодорхойлох боломжгүй, зарим ажиллагааны мэдээлэл эргэлзээтэй, бодит байдлаас хол зөрүүтэй дүнгүүд ажиглагдаж байгаа тул дараа дараагийн судалгаанд эх сурвалж болгон ашиглахгүй байх,
2. Хялбаршуулсан журмаар шийдвэрлэсэн захиргааны хэргийн хувьд маргааны төрөл тус бүр өөр өөр хэв шинжтэй биш ажиллагаа, хуудас, хугацааны мэдээлэл нийтлэг шинжтэй байгаа тул ачааллыг тооцохдоо маргааны төрлийг харгалзахгүйгээр тодорхойлох,
3. Шүүхийн статистик мэдээллээр шийдвэрлэсэн хэрэгт зонхилох байр суурь эзэлж байгаа маргааны төрөл, мөн нийт судалгаанд хамрагдсан маргааны төрлөөс зонхилох хэмжээнд хийгдэж байгаа ажиллагааны төрлийн мэдээллээр цаашид хэргийн болон ажиллагааны ачаалал тодорхойлох өгөгдлийн бааз бүрдүүлэх, зонхилох хэмжээ, харьцааг баримтлан ажиллагааг хэргийн ачаалалд шилжүүлэх, ачааллыг тодорхойлох арга зүйг хэвшүүлэх,
4. Дүгнэлтэд хүснэгт хэлбэрээр харуулсан ажиллагааны төрлүүдийг ажиллагааны ачаалал тооцох шалгуур үзүүлэлт батлах зэрэг ажилд харгалзан үзэх, ашиглах
5. Өндөр дүнтэй шийдвэрлэгддэг зарим төрлийн маргааны ажиллагааны ачаалал мөн бусад маргаанаас өндөр дүнтэй байгааг ачаалал тооцох, ажлыг хуваарилах, зохион байгуулах асуудлаар бодлого тодорхойлох, шийдвэр гаргахдаа харгалзан үзэх.

Захиргааны хавтаст хэргийн материалд хийсэн шинжилгээний хүрээн дэх зөвлөмж

1. Хэргийг шийдвэрлэх хуульд заасан хугацааны зохицуулалт нь шүүхийн практикт мөрдөгдөж хэрэгжих тохиолдол хялбаршуулсан журмаар шийдвэрлэгдэж байгаа зарим хэрэг төдийгөөр хязгаарлагдаж байна. Ачаалалд тохирох хүний нөөцийн бодлогыг хэрэгжүүлэх эсвэл хэрэг хянан шийдвэрлэх хуульд заасан хугацааны хэм хэмжээ нь нийцтэй байгаа эсэхийг практик болон хэргийн онцлог нөхцөл байдлыг харгалзан эргэн харах шаардлага үүссэн байна.
2. Хавтаст хэргийн судалгаагаар ажиллагаанд зарцуулсан хугацааг ажиллагаа хоорондын огнооны зөрүүгээр гаргасан хугацааны өгөгдлийг судлан үзэхэд зарим хэрэгт хугацаа их зарцуулсан ажиллагаа нь шүүхээс шалтгаалаагүй, хэргийн түдгэлзүүлэх болон сэргээх ажиллагаа хоорондох хугацаа, хэргийг шийдвэрлэсний дараа ШИНБ-ыг хянуулах хүсэлт гаргасан тохиолдол, нотлох баримт шаардсан албан бичгийг шүүхээс хүргүүлэхэд хариуцагч болон нотлох баримтыг гаргаж өгөх талаас хариу ирүүлээгүй байх, хэд хэдэн эрхийн акт, ажиллагаа нэг огноотой байгааг тухайн ажлыг нэг ижил хугацаанд нэгэн зэрэг хийсэн гэж үзэх үү? эсвэл 1 хоног зарцуулж бүгдийг хийсэн үзэх үү гэсэн онцлог нөхцөл байдлууд тулгарч байна. Иймд ажиллагааны хугацааг хавтаст хэргийн материалыг судлах замаар тодорхойлох нь бүх ажиллагааны хувьд боломжгүй, ихэнх ажиллагааны хугацаа өндөр дүнтэй, бодит бус гарах нөхцөл байдал ажиглагдаж байгааг анхаарч ажиллагааны хугацааг гаргахад хавтаст хэргийг эх сурвалж болгон ашиглахгүй байх нь зүйтэй байна.



3. Хуульд зааснаар тухайн хэргийг шүүхээс шийдвэрлэх ажил нь хянан шийдвэрлэж байгаа процессын хуульд заасан журам, хугацааны хүрээнд хийгддэг ажил байна. Хуульд заасан хугацааг хэтэрч шийдвэрлэгдэж байгаа хэргүүдийн хувьд ачаалал болон хууль тогтоомжийн өөрчлөлт, ажиллах хүчний арга барил, туршлага зэрэг янз бүрийн хүчин зүйлээс шалтгаалсан байх талтай юм.
4. Ажиллагаанд зарцуулсан хугацааны мэдээллийг ямар эх сурвалж ашиглаж, бодитой тодорхойлох талаар цаашид эрэлхийлж, оновчтой арга, хэлбэрийг тогтоох ажлыг шүүхийн захиргааны байгууллагаас давтамжтайгаар зохион байгуулах, бодит өгөгдлийг бүрдүүлэх нь чухал байна.
5. Ажиллагааны ачааллыг судлах явцад ШЕЗ-ын 58 дугаар тогтоолын хүрээнд цуглуулсан өгөгдөлд хийсэн Суурь судалгаанд дурдсан хянан шийдвэрлэсэн хэргийн дундаж ачааллын тооцоогоор өндөр дүнтэй гарсан нийслэлийн төвийн 6 дүүргийн шүүхийн шүүгчдийн шийдвэрлэсэн хэрэгт мөн ажиллагаа, хугацаа хамгийн их зарцуулсан давхцал ажиглагдаж байна. Иймд ачаалал ихтэй шүүхүүд нь хэрэг, маргааныг хуульд заасан хугацаанд шийдвэрлэх, мөн төрийн үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай үзүүлэх зарчмыг хэрэгжүүлэн ажиллах боломж хязгаарлагдаж байгааг анхаарах нь зүйтэй байна.
6. Анхан шатны шүүхээс хийгдсэн ажиллагааны тоо, хуудасны тоо, хугацааны мэдээлэл нь давж заалдах шатны шүүхийн мөн энэ төрлийн мэдээлэлтэй харьцуулагдахгүй бөгөөд ижил шатны шүүх хооронд мэдээллийн харьцуулалт хийгдэх нь харьцуулан судлах арга зүйд нийцэхээр байна.
7. Шинжилгээнд өгсөн зарим ажиллагааны төрөл нь шүүгчийн хийж гүйцэтгэдэг ажил үүрэг мөн эсэхэд эргэлзээг төрүүлж байна. Тухайлбал, баримт гэх ажиллагаа хэргийн ихэнх үе шатанд өндөр дүнтэй үйлдэгдэж, хуудасны тоо мөн зарцуулсан хугацааны мэдээлэл зарим тохиолдолд урьдчилсан хэлэлцүүлгийн тэмдэглэл, албан бичиг зэрэг ажиллагаанаас өндөр дүнтэй гарсан байна. Энэ нь бодит практикт мөн шүүгчийн ажиллагааны ачаалал тодорхойлох зорилготой хэрхэн нийцтэй байгааг нягтлах шаардлагатай байна.
8. Ажиллагаанд зарцуулсан хугацааг тодорхойлохоор цуглуулж, бүрдүүлсэн мэдээлэл нь судалгааны шаардлага төдийлөн хангахгүй өгөгдөл байгаа тул цаашид 1 шүүгчид 1 жилд ногдох ачааллыг тодорхойлохын тулд ХХША-нд зарцуулах хуульд заасан хугацааг хэргийн төрөлд холбогдуулан нарийвчлан гаргах ажил дутуу байна.
9. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үе шатыг процесс ажиллагааны онцлох үечлэлийн дагуу хувааж өгөгдлийг цуглуулсан байна. Процесс ажиллагаа нь хуульд зааснаар мөн хуралдаанаар хэлэлцэхээс өмнө бүрдүүлэх, цуглуулах, шалгах, тогтоох, тодорхойлох зэрэг олон төрлийн ажиллагаа хийгдэх энэхүү шаардлагын дагуу 2 болон 3-р үе шатанд дийлэнх ажиллагаа төвлөрч хийгдсэн, нийтлэг шинж ажиглагдаж байна. Иймд аль үе шатанд аль ажиллагааны төрөл их эсвэл бага байгаа тухай мэдээлэл төдийлөн ач холбогдол үзүүлэхээргүй байна.
10. Хавтаст хэргийн материалыг уншиж, судлах ажлын дүнд цуглуулсан ажиллагааны тоо болон хуудасны тоо, мөн энэхүү судалгааны тайланд дурдсан зарим мэдээлэлд тулгуурлан хэргийн хөдөлгөөний удирдлагын чиглэлд төлөвлөх, анхаарч хэрэгжүүлэх ажлуудыг тодорхойлох боломж байна.
11. Ердийн журмаар шийдвэрлэсэн хэрэгт ХХША-ны 2 болон 3 дугаар үе шат, давж заалдах шатны шүүхээс шийдвэрлэсэн хэрэгт 3 болон 4-р үе шат ажиллагааны ачаалал үзүүлж байгаа тул хэрэг, нэхэмжлэл хуваарилах үед, мөн шүүгч өөрийн хэргийн хөдөлгөөний менежментээ төлөвлөхдөө нэгэн зэрэг хийх ажилд анхан шатанд 2 болон 3 дугаар, давах шатанд 3 болон 4-р үе шатанд хамаарах хэд хэчнээн хэрэг байгааг тус тус анхаарч ажиллах нь ачаалал өндөр байгаа



ажиллагааны давхардал үүсэх, хугацаа алдах зэргээс сэргийлэх боломжийг бүрдүүлэхээр байна.

12. Маргааны төрлийн хувьд анхан болон давж заалдах шатны шүүхэд газар, төрийн алба, ашигт малтмал, тусгай зөвшөөрлийн маргаанд хийгдэх ажиллагаа, уншиж, судлах, улмаар боловсруулах материал, зарцуулах хугацаа аль аль нь өндөр дүнтэй бусад маргаанаас илүү ачаалал үзүүлж байгаа учраас хэрэг, нэхэмжлэлийг хуваарилах, ХХША-тай холбоотой болон холбоогүй ажлын оногдуулахдаа ачаалал өндөр үзүүлэх маргааны төрлийн тооны харьцааг харгалзах байдлаар ажлын хувиараа оновчтой тогтоох арга хэлбэрийг туршиж үзэх нь зохистой юм.

4.2 Захиргааны хэргийн шүүхийн шүүгч нараас авсан асуумжид хийх шинжилгээ

Захиргааны хэргийн шүүгчийн хянан шийдвэрлэсэн хэргийн ажиллагааны ачааллыг бодитой тодорхойлохын тулд Шүүхийн ерөнхий зөвлөлийн судалгаа шинжилгээний баг тодорхой төрлийн маргааны төрлүүдээр шүүгч нараас асуумж авч тоон мэдээлэл цуглуулан шинжилгээ хийсэн үр дүнг энэ бүлэг танилцуулна.

Судалгаанд дараах маргааны төрөлд хамаарах асуумжийг авсан. Үүнд:

- ✓ *Ашигт малтмалын маргаан*
- ✓ *Нийгмийн даатгалтай холбоотой маргаан*
- ✓ *Улсын бүртгэлтэй холбоотой маргаан*
- ✓ *Нийтийн эрүүл мэндтэй холбоотой маргаан*
- ✓ *Санхүүгийн зохицуулах хороотой холбоотой маргаан*
- ✓ *Нийтийн өмчийг хамгаалахтай холбоотой маргаан*
- ✓ *Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авахтай холбоотой маргаан*
- ✓ *Гаальтай холбоотой маргаан*
- ✓ *Газрын маргаан*
- ✓ *Оюуны өмчтэй холбоотой маргаан*
- ✓ *Татварын маргаан*
- ✓ *Зам тээвэртэй холбоотой маргаан*
- ✓ *Хүүхдийн эрхтэй холбоотой маргаан*
- ✓ *Байгаль орчныг хамгаалахтай холбоотой маргаан*
- ✓ *Барилгын эрх зүйн маргаан*
- ✓ *Зохиогчийн эрх, барааны тэмдэгтэй холбоотой маргаан*
- ✓ *Улсын байцаагчийн акттай холбоотой маргаан*
- ✓ *Боловсролтой холбоотой маргаан*
- ✓ *Тусгай зөвшөөрөлтэй холбоотой маргаан*
- ✓ *Шударга бус өрсөлдөөнийг хянан зохицуулах, хэрэглэгчийн эрх ашигтай холбоотой маргаан*
- ✓ *Төрийн албаны маргаан*
- ✓ *Төрийн хяналт, шалгалттай холбоотой маргаан*

4.2.1 Хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэсэн захиргааны хэргийн асуумжийн өгөгдөлд хийх шинжилгээ

4.2.1.1 Хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэсэн захиргааны хэргийн асуумжийн тухай

Захиргааны хэргийн ажиллагааны ачааллын асуумжид шинжилгээ хийхэд ашигласан өгөгдлийн танилцуулгыг дараах хүснэгтээр харуулъя.



№	Маргааны төрөл	Архангай	Баян-Өлгий	Булган	Дорноговь	Дорнод	Дундговь	Завхан	Өвөрхангай	Сэлэнгэ	Төв	Увс	Ховд	Хөвсгөл	Хэнтий	Нийслэл	Дүн
1	Ашигт малтмал	1	1	1	0	1	1	2	0	1	1	1	1	1	1	9	22
2	Нийгмийн даатгал	1	1	1	0	1	1	2	1	1	1	1	1	1	1	9	23
3	Улсын бүртгэл	1	1	1	1	1	1	2	1	1	1	1	1	1	1	9	24
4	Нийтийн эрүүл мэнд	1	1	1	0	1	1	2	0	0	0	0	0	1	1	9	18
5	СЗХ	1	1	0	0	1	1	2	0	0	0	0	0	1	1	9	17
6	Нийтийн өмч	1	1	1	0	1	1	2	0	1	0	0	0	1	1	9	19
7	ТБОН	1	1	1	0	1	1	2	0	1	1	1	1	1	1	9	22
8	Гааль	1	1	0	0	1	1	2	0	1	1	0	0	1	1	9	19
9	Газар	1	1	1	1	1	1	2	1	1	1	1	1	1	1	9	24
10	Оюуны өмч	1	1	0	0	1	1	2	0	0	0	0	0	1	1	9	17
11	Татвар	1	1	1	0	1	1	2	0	1	1	1	1	1	1	9	22
12	Тээвэр	1	1	1	0	1	1	2	0	0	1	0	0	1	1	9	19
13	Хүүхэд	1	1	1	0	1	1	2	0	0	0	0	0	1	1	9	18
14	Байгаль орчин	1	1	1	0	1	1	2	0	1	0	1	0	1	1	9	20
15	Барилга	1	1	1	0	1	1	2	0	1	0	0	0	1	1	9	19
16	Зохиогчийн эрх	1	1	0	0	1	1	2	0	0	0	0	0	1	1	9	17
17	Улсын байцаагч	1	1	1	1	1	1	2	1	1	1	1	1	1	1	9	24
18	Боловсрол	1	1	1	0	1	1	2	0	1	1	1	0	1	1	9	21
19	Тусгай зөвшөөрөл	1	1	1	0	1	1	2	0	1	1	1	1	1	1	9	22
20	Өрсөлдөөн	1	1	0	0	1	1	2	0	0	0	0	0	1	1	9	17
21	Төрийн алба	1	1	1	1	1	1	2	1	1	1	1	1	1	1	9	24
22	Төрийн хяналт	1	1	1	1	1	1	2	0	1	1	1	1	1	1	9	23
	Дүн	22	22	17	5	22	22	44	5	15	13	12	10	22	22	198	451

Хүснэгт 4.2.1 Хялбаршуулсан журмаар эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд зарцуулах хугацааны асуумжийн судалгаанд оролцсон шүүгчийн мэдээлэл

Монгол улсад Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх үйл ажиллагаа явуулдаг 23 шүүхээс Баянхонгор, Говь-Алтай, Говьсүмбэр, Дархан-Уул, Орхон, Өмнөговь, Сүхбаатар аймгийн шүүхүүд асуумжийн судалгааг явуулаагүй байна.

№	Маргааны төрөл	Баян-Өлгий	Дорноговь	Дорнод	Завхан	Өвөрхангай	Сэлэнгэ	Төв	Хөвсгөл	Нийслэл	Дүн
1	Ашигт малтмал	1	0	1	2	0	1	1	1	9	16
2	Нийгмийн даатгал	1	0	1	2	1	1	1	1	9	17
3	Улсын бүртгэл	1	1	1	2	1	1	1	1	9	18
4	Нийтийн эрүүл мэнд	1	0	1	2	0	0	0	1	9	14
5	СЗХ	1	0	1	2	0	0	0	1	9	14
6	Нийтийн өмч	1	0	1	2	0	1	0	1	9	15
7	ТБОН	1	0	1	2	0	1	1	1	9	16
8	Гааль	1	0	1	2	0	1	1	1	9	16
9	Газар	1	1	1	2	1	1	1	1	9	18
10	Оюуны өмч	1	0	1	2	0	0	0	1	9	14
11	Татвар	1	0	1	2	0	1	1	1	9	16
12	Тээвэр	1	0	1	2	0	0	1	1	9	15
13	Хүүхэд	1	0	1	2	0	0	0	1	9	14
14	Байгаль орчин	1	0	1	2	0	1	0	1	9	15
15	Барилга	1	0	1	2	0	1	0	1	9	15
16	Зохиогчийн эрх	1	0	1	2	0	0	0	1	9	14
17	Улсын байцаагч	1	1	1	2	1	1	1	1	9	18
18	Боловсрол	1	0	1	2	0	1	1	1	9	16
19	Тусгай зөвшөөрөл	1	0	1	2	0	1	1	1	9	16
20	Өрсөлдөөн	1	0	1	2	0	0	0	1	9	14
21	Төрийн алба	1	1	1	2	1	1	1	1	9	18
22	Төрийн хяналт	1	1	1	2	0	1	1	1	9	17
	Дүн	22	5	22	44	5	15	13	22	198	346

Хүснэгт 4.2.2 Судалгаанд ашигласан өгөгдлийн мэдээ


Судалгаанд оролцсон 15 шүүхийн 24 шүүгч Захиргааны хэргийн 22 маргааны хувьд 451 асуумж өгснөөс 9 шүүхийн 18 шүүгчийн 346 өгөгдлийг судалгаанд ашиглав.



Үүнээс Архангай, Булган, Дундговь, Увс, Ховд, Хэнтий аймгийн шүүхийн асуумжийн өгөгдлийг судалгаанаас хасав. Асуумжийг хассан шалтгааныг Эрүүгийн хэрэг бүлгийн программын үр дүнгээс харна уу. Өгөгдлийн шинжилгээнээс хассан тайлбар адил тул энд давтан оруулахгүй дараагийн судалгаанд шилжье.

4.2.1.2 Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үе шатуудад хийх шинжилгээ

Захиргааны хэргийн 22 маргааны тус бүрийн ажиллагаанд зарцуулах хугацааны тухай аймаг, нийслэлийн шүүхийн Захиргааны хэргийн шүүгчдийн өгсөн 346 асуумжийн өгөгдөлд хийсэн 2 хүчин зүйлийн дисперсийн шинжилгээний үр дүнг Зураг 4.2.1-д харуулав.



Зураг 4.2.1 Хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэсэн хэрэгт зарцуулах хугацааны тухай асуумжийн ерөнхий мэдээлэл


Зургаас харвал нийслэлийн захиргааны хэргийн шүүхийн шүүгч нар 1 хэргийг хялбаршуулсан журмаар шийдэхэд 2032 минут, аймгийн шүүхийн шүүгчид 6431 минут зарцуулдаг гэсэн байна. 1 захиргааны хэргийг хялбаршуулсан журмаар шийдэхэд зарцуулах хугацааг Захиргааны 22 маргаан тус бүрээр нь задалж харуулсан зургаас харвал Улсын бүртгэлийн маргаан хамгийн их буюу 4841 минут зарцуулдаг гэсэн асуулга өгсөн байна. Бусад маргааны хувьд 2809-4283 минут зарцуулдаг гэсэн байна.

Шүүгчийн ажлын туршлага, хэрэг хянан шийдвэрлэх хугацааны тухай бодит практик баримжаа, санал бодлыг энэхүү судалгаанд аль болох тусгаж оруулахыг судалгааны баг зорьсон ч хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх тухай орон нутгаас ирүүлсэн асуумжийн өгөгдлийн судалгааг цааш үргэлжлүүлэх шаардлагагүй болсон тул шинжилгээг зогсоов. Учир нь 5-р бүлгийн шүүгчийн ажлын ачаалал тооцох, хэргийн коэффициент тодорхойлох судалгаанд хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх асуумжийн үр дүн шаардлага хангахгүй өгөгдөлд шилжиж байгаа тул бүтцийн болон дисперсийн шинжилгээг үргэлжлүүлэн хийх шаардлагагүй болов. Харин зөвхөн НЗХДЗШШ-ээс ирүүлсэн асуумжийн өгөгдлийн судалгаанд ашиглахаар сонгож үлдээв.

4.2.2 Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн хянан шийдвэрлэсэн хэргийн ажиглалтын өгөгдөлд хийх шинжилгээ

4.2.2.1 Давж заалдах шатны шүүхийн ажиглалтын өгөгдлийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны ерөнхий дүн ба үе шатуудын хувьд хийх шинжилгээ


Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгчийн ажлын ажиллагааны ачааллыг бодитой тодорхойлохын тулд Нийслэлийн захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн захиргааны хэрэг хянан шийдвэрлэх үйл ажиллагаанд ажлын байрны зураг авалт хийж, өгөгдөл цуглуулан шинжилгээ хийсэн үр дүнг танилцуулж байна.





Зураг 4.2.2 ЗХДЗШШ-ийн гомдол шийдвэрлэхэд зарцуулах хугацааны тухай ажиглалтын өгөгдлийн мэдээлэл

Захиргааны хэргийн хуульд заасан гомдлуудын ажиллагаанд зарцуулах хугацааны тухай ЗХДЗШШ-ийн шүүгчийн ажлын байрны зураг авалтын үр дүнд цуглуулсан 24 өгөгдөлд хийсэн 3 хүчин зүйлийн дисперсийн шинжилгээний үр дүнг Зураг 4.2.17-д харуулав. Зургаас харвал ЗХДЗШШ-ийн шүүхийн шүүгч нэг захиргааны хэргийн гомдлыг шийдвэрлэхэд 5015 минут, ерөнхий шүүгч 5434 минут зарцуулдаг гэж асуумж өгсөн байна.



Зураг 4.2.3 ЗХДЗШШ-ийн гомдол шийдвэрлэхэд зарцуулах хугацааны тухай ажиглалтын өгөгдөл, маргааны төрлөөр


Давж заалдах шатны шүүхийн гомдол хянан шийдвэрлэх хугацааг Захиргааны хэргийн маргааны төрөл тус бүрээр нь задалж харуулсан зургаас харвал судалгаанд хамрагдсан хэргийн маргааны төрлүүдийн хувьд 3760-6800 минут зарцуулдаг байна.

Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн гомдол хянан шийдвэрлэх ажиллагааны үе шат дараах үндсэн гурван үе шатаас бүрдэх бөгөөд шинжилгээний үр дүнг харуулъя.



Зураг 4.2.4 ЗХДЗШШ-ийн гомдол хянан шийдвэрлэх ажиллагааны үндсэн үе шат

Зураг 4.2.19-аас харвал хэргийг хүлээн авах үе шатанд дунджаар нэг хэргийг хянан шийдвэрлэхэд нийт хугацааны 10.1% буюу 453 минут, хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхэд бэлтгэх, хэлэлцэх үе шатанд 41.5% буюу 1861 минут, хэргийг хянан шийдвэрлэсний дараах ажиллагааны үе шатанд 48.8% буюу 2170 минут тус тус зарцуулдаг байна.



Зураг 4.2.5 Гомдол шийдвэрлэх үе шатанд хамаарах ажиллагааны хугацаа, маргааны төрлөөр

Зураг 4.2.19-д харуулсан ерөнхий мэдээллийг Захиргааны хэргийн маргааны төрөл тус бүрээр Зураг 4.2.20-д задалж оруулав. Зургаас харвал хэрэг хянан шийдвэрлэх 1-р үе шатанд бүх маргааны төрлийн ажиллагаанд зарцуулах хугацаа 155-585 минут байна. Хэрэг хянан шийдвэрлэх 2-р үе шатанд судалгаанд авсан бүх маргааны төрлийн ажиллагаанд зарцуулах хугацаа 1285-2215 минут байна. Хэргийн 3-р үе шатанд бүх маргааны төрлийн ажиллагаанд зарцуулах хугацаа 1700-2695 минут байна. Хэргийн бүх үе шатанд Газар, Төрийн алба, Төрийн хяналт, шалгалт, Ашигт малтмал, Төрийн болон



орон нутгийн хөрөнгөөр бараа худалдан авах, Татвар, Улсын бүртгэл, Нийгмийн даатгал, Тусгай зөвшөөрөл, Барилгын эрх зүйн маргаан, Улсын байцаагчийн акт, Байгаль орчныг хамгаалах, Боловсрол, Санхүүгийн зохицуулах хороо гэх мэт маргааны гомдлыг хянан шийдвэрлэх хугацаа хамгийн их хугацаа шаарддаг дүр зураг ажиглагдаж байна.

4.2.2.2 ЗХДЗШШ-ийн гомдол хянан шийдвэрлэх ажиллагааны 1-3-р үе шатанд зарцуулах хугацааны өгөгдөлд хийх шинжилгээ


• Хэргийг шүүгч хүлээн авах үе шат

Зураг 4.2.19-д харуулсан гомдол хянан шийдвэрлэх үе шатыг ямар төрлийн ажиллагаанаас хамаарч харилцан адилгүй хугацаа зарцуулж байгааг гомдол хянан шийдвэрлэх 1-р үеийн хэргийн ажиллагаа тус бүрээр задалж харуулсан үр дүнг танилцуулъя.



Зураг 4.2. 6 ЗХДЗШШ-ийн хэргийг хүлээн авах үеийн ажиллагааны задаргаа


Зураг 4.2.21-ээс харвал хэргийг хүлээн авах үе шатанд зарцуулах нийт хугацааны 2.4% буюу 11 минутыг улсын тэмдэгтийн хураамж төлсөн эсэхийг шалгах ажиллагаанд, 85.4% буюу 387 минутыг гомдолд хавсаргасан баримттай уншиж танилцах ажиллагаанд, 12.1% буюу 55 минутыг гомдлыг хүлээн авахаас татгалзах үндэслэлийг шалгасан туслахын ажиллагааг хянахад тус тус зарцуулдаг байна.



Зураг 4.2.7 Ажиглалтын өгөгдлийн хэргийг хүлээн авах үеийн ажиллагаанд зарцуулах хугацаа, маргааны төрлөөр


Зураг 4.3.21-д харуулсан хэргийг хүлээн авах үе шатанд зарцуулах нийт хугацааг маргааны төрөл тус бүрээр Зураг 4.2.22-д задалж харуулав. Хэрэг хянан шийдвэрлэх 1-р үе шат болох хэргийг хүлээн авах үе шатны бүх ажиллагаа тус бүрийн хувьд зарцуулах хугацаа бүх маргааны төрлийн хувьд ялгаатай байна. Хэрэг хянан шийдвэрлэх 1-р үе буюу хэргийг хүлээн авах үеийн ажиллагаанд зарцуулах хугацаа маргааны төрлөөс хамаарч байгаа бөгөөд 1-р ажиллагаанд 5-15 минут, 2-р ажиллагаанд 120-480 минут, 3-р ажиллагаанд 30 ба 90 минут тус тус зарцуулдаг байна.

• Хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхэд бэлтгэх, хэлэлцэх үе




Зураг 4.2.8 ЗХДЗШШ-ийн хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхэд бэлтгэх, хэлэлцэх үеийн ажиллагаанд зарцуулах хугацаа

Зураг 4.2.23-аас харвал хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхэд бэлтгэх үе шатанд зарцуулах нийт хугацааны 12.2% буюу 228 минутыг нөлөөллийн мэдүүлэг хөтөлдөг талаар мэдээлэл өгсөн баримтыг хянах, гомдол гаргаагүйд тооцох, хэргийн оролцогчийн ХХША-тай холбоотой хүсэлтийн шийдвэр, шүүх хуралдааныг хэзээ товлон болгохтойг тодруулах, шүүх хуралдааныг товлон талаар шүүгчийн туслахад чиглэл өгөх, хэргийн оролцогчдод шүүх хуралдааны тов мэдэгдэх хуудсыг хянаж, гарын үсэг зурах, хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцүүлэх тухай захирамжийг хянах, гарын үсэг зурах зэрэг ажиллагаануудад, 8.7% буюу 162 минутыг хариу тайлбартай танилцахад, 70.8% буюу 1319 минутыг хэргийн материалтай танилцахад, 8.2% буюу 153 минутыг шүүх хуралдаан хийхэд тус тус зарцуулдаг байна.



Зураг 4.2.9 Ажиглалтын өгөгдлийн хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхэд бэлтгэх, хэлэлцэх үеийн ажиллагаанд зарцуулах хугацаа, маргааны төрлөөр

Зураг 4.2.23-д харуулсан хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхэд бэлтгэх ажиллагааны үе шатанд зарцуулах нийт хугацааг хэргийн төрөл тус бүрээр Зураг 4.2.24-д задалж харуулав. Хэрэг хянан шийдвэрлэх 2-р үе шатанд хийгддэг бүх ажиллагаануудын хувьд хэргийн материалтай танилцах ажиллагаанд маргааны төрөл тус бүрийн хувьд хамгийн их хугацаа зарцуулдаг байна.




Зураг 4.2.10 Хэргийн материалтай танилцах ажиллагааны задаргаа

Зураг 4.2.23-д дурдсан хэрэг хянан шийдвэрлэх 2-р үе шатны нийт ажиллагааны 70.8% буюу 1319 минутыг эзлэх хэргийн материалтай танилцах ажиллагааны ажиглалтын үр дүнг задалж харуулахад хэргийн материалыг уншиж судлахад 633 минут,




АШШ-ны журам зөрчсөн эсэхийг хянахад 349 минут, түүвэр гаргахад 91 минут, шаардлагатай хууль тогтоомжийг судлахад хамгийн их буюу 136 минут, шүүхийн практик судлахад 109 минут тус тус зарцуулдаг болох нь тооцоогоор гарав.



Зураг 4.2. 11 Шүүх хуралдааны задаргаа


Зураг 4.2.26-д дурдсан хэрэг хянан шийдвэрлэх 2-р үе шатны нийт ажиллагааны, 8.2% буюу 153 минутыг эзлэх шүүх хуралдаан явуулах ажиллагааны ажиглалтын үр дүнг судалгаанд ирсэн ажиглалтын өгөгдлөөр задалж харуулав. Зургаас харвал шүүх хуралдаан явуулахад 94 минут, зөвлөлдөхөд 30 минут, илтгэхэд 29 минут тус тус зарцуулдаг болох нь тооцоогоор гарав.

• Хэрэг хянан шийдвэрлэсний дараах үе шат




Зураг 4.2.12 Хэрэг хянан шийдвэрлэсний дараах үеийн ажиллагаа

Зураг 4.2.27-оос харвал хэрэг хянан шийдвэрлэсний дараах үе шатанд зарцуулах нийт хугацааны 3% буюу 49 минутыг шүүх хуралдааны тэмдэглэл хянаж, гарын үсэг зурахад, 64.6% буюу 1060 минутыг шийдвэр боловсруулах, хянах, гарын үсэг зурахад, 32.4% буюу 531 минутыг бүрэлдэхүүний ажиллагаанд тус тус зарцуулдаг байна.



Зураг 4.2.13 Хэрэг хянан шийдвэрлэсний дараах үеийн ажиллагаа, маргааны төрлөөр

Зураг 4.2.27-д харуулсан хэрэг хянан шийдвэрлэсний дараах ажиллагааны үе шатанд зарцуулах нийт хугацааг маргааны төрөл тус бүрээр Зураг 4.2.28-д задалж харуулав. Хэрэг хянан шийдвэрлэх 3-р үе шатанд хийгддэг ажиллагаануудын хувьд шийдвэр боловсруулах, хянах, гарын үсэг зурах ажиллагаанд Газар, Төрийн алба, Төрийн хяналт, шалгалт, Ашигт малтмал, Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа худалдан авах, Татвар, Улсын бүртгэл, Нийгмийн даатгал, Тусгай зөвшөөрөл, Барилгын эрх зүйн маргаан, Улсын байцаагчийн акт, Байгаль орчныг хамгаалах, Боловсрол, Санхүүгийн зохицуулах хороо гэх мэт маргааны гомдолд хамгийн их хугацаа зарцуулдаг байна. Зураг 4.2.28-ын бүрэлдэхүүний ажиллагаа дараах үзүүлэлтээр задарч ирсэн тул шинжилгээ хийсэн үр дүнг харуулья.






Зураг 4.2.14 Бүрэлдэхүүний ажиллагаа задаргаагаар

Бүрэлдэхүүний ажиллагааг асуумжийн өгөгдөл тус бүрээр задалж үзэхэд хурлын бүрэлдэхүүн даргалагч 505 минут, хурлын бүрэлдэхүүн 91 минут, хурлын илтгэгч 997 минут тус тус зарцуулдаг байна.



Зураг 4.2.15 Хурлын бүрэлдэхүүний хийх ажлын зааварчилгаа

Зураг 4.2.29-ийн мэдээллийг хурлын бүрэлдэхүүний хийх ажлын ажиллагаагаар Зураг 4.2.30-д задалж харуулав. Жишээ нь бүрэлдэхүүн даргалагч шүүхийн магадлал гаргахад 199 минут, шүүхийн тогтоол гаргахад 196 минут, хурлын тэмдэглэл хийхэд 109 минут тус тус зарцуулдаг байна. Хурлын бүрэлдэхүүн магадлалын төсөлд санал өгөхөд 42 минут, тогтоолын төсөлд санал өгөхөд 49 минут тус тус зарцуулдаг байна. Илтгэгчийн ажиллагаа нь төсөл бичихэд 634 минут, даргалагч, бүрэлдэхүүнээс ирүүлсэн саналуудыг төсөлд тусгах эсэхэд 112 минут, саналыг тусган боловсруулахад 232 минут, гарын үсэг зурахад 20 минут байдаг байна.



Зураг 4.2.16 Шийдвэр боловсруулах ажиллагааны задаргаа

Зураг 4.2.27-д хэрэг хянан шийдвэрлэсний дараах үе шатанд зарцуулах нийт хугацааны 64.6% буюу 1060 минутыг эзлэх шийдвэр боловсруулах, хянах, гарын үсэг зурах ажиллагааг задалж үзэхэд шүүгчийн захирамж гаргахад 113 минут, шүүхийн шийтгэвэр гаргахад 100 минут, шүүхийн тогтоол гаргахад 138 минут, шүүхийн магадлал гаргахад 709 минут тус тус зарцуулдаг байна.

4.2.3 Ердийн журмаар хянан шийдвэрлэсэн захиргааны хэргийн асуумжийн өгөгдөлд хийх шинжилгээ

4.2.3.1 Ердийн журмаар хянан шийдвэрлэсэн захиргааны хэргийн асуумжийн тухай

Захиргааны хэргийн ердийн журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны ачааллын асуумжид шинжилгээ хийхэд ашигласан өгөгдлийн танилцуулгыг дараах хүснэгтээр харуулъя.

№	Маргааны төрөл	Архангай	Баян-Өлгий	Баянхонгор	Булган	Дархан-Уул	Дорноговь	Дорнод	Дундговь	Завхан	Өвөрхангай	Сэлэнгэ	Төв	Увс	Ховд	Хөвсгөл	Хэнтий	Нийслэл	Дүн
1	Ашигт малтмал	1	1	1	1	1	0	1	1	2	1	1	1	1	1	1	1	9	25
2	Нийгмийн даатгал	1	1	1	1	1	0	1	1	2	0	1	1	1	1	1	1	9	24
3	Улсын бүртгэл	1	1	1	1	1	1	1	1	2	1	1	1	1	1	1	1	9	26
4	Нийтийн эрүүл мэнд	1	1	0	1	0	0	1	1	2	0	0	0	0	0	1	1	9	18
5	СЗХ	1	1	0	0	0	0	1	1	2	0	0	0	0	0	1	1	9	17
6	Нийтийн өмч	1	1	1	1	0	0	1	1	2	0	1	0	0	1	1	1	9	21
7	ТБОН	1	1	1	1	1	0	1	1	2	1	1	1	1	1	1	1	9	25
8	Гааль	1	1	0	0	1	1	1	1	2	0	1	1	0	0	1	1	9	21
9	Газар	1	1	1	1	1	1	1	1	2	1	1	1	1	1	1	1	9	26
10	Оюуны өмч	1	1	0	0	0	0	1	1	2	0	0	0	0	0	1	1	9	17
11	Татвар	1	1	0	1	1	1	1	1	2	0	1	1	1	1	1	1	9	24



12	Тээвэр	1	1	1	1	0	0	1	1	2	0	0	1	0	0	1	1	9	20
13	Хүүхэд	1	1	0	1	0	0	1	1	2	0	0	0	0	0	1	1	9	18
14	Байгаль орчин	1	1	1	1	0	1	1	1	2	0	1	0	1	0	1	1	9	22
15	Барилга	1	1	0	1	1	0	1	1	2	0	1	0	0	0	1	1	9	20
16	Зохиогчийн эрх	1	1	0	0	0	0	1	1	2	0	0	0	0	0	1	1	9	17
17	Улсын байцаагч	1	1	1	1	1	1	1	1	2	1	1	1	1	1	1	1	9	26
18	Боловсрол	1	1	1	1	1	0	1	1	2	0	1	1	1	0	1	1	9	23
19	Тусгай зөвшөөрөл	1	1	0	1	1	0	1	1	2	0	1	1	1	1	1	1	9	23
20	Өрсөлдөөн	1	1	0	0	0	0	1	1	2	0	0	0	0	0	1	1	9	17
21	Төрийн алба	1	1	1	1	1	1	1	1	2	1	1	1	1	1	1	1	9	26
22	Төрийн хяналт	1	1	1	1	1	1	1	1	2	1	1	1	1	1	1	1	9	26
Дүн		22	22	12	17	13	8	22	22	44	7	15	13	12	11	22	22	198	482

Хүснэгт 4.2.3 Ердийн журмаар захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд зарцуулах хугацааны асуумжийн судалгаанд оролцсон шүүхийн мэдээлэл

Монгол улсад Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх үйл ажиллагаа явуулдаг 23 шүүхээс Говь-Алтай, Говьсүмбэр, Орхон, Өмнөговь, Сүхбаатар аймгийн шүүхүүд асуумжийн судалгааг явуулаагүй байна.


№	Маргааны төрөл	Ашигт малтмал	Нийгмийн даатгал	Улсын бүртгэл	Нийтийн эрүүл	СЗХ	Нийтийн өмч	ТБОН	Гааль	Газар	Оюуны өмч	Татвар	Тээвэр	Хүүхэд	Байгаль орчин	Барилга	Зохиогчийн эрх	Улсын байцаагч	Боловсрол	Тусгай зөвшөөрөл	Өрсөлдөөн	Төрийн алба	Төрийн хяналт	Дүн
1	Нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны шүүх	9	9	9	9	9	9	9	9	9	9	9	9	9	9	9	9	9	9	9	9	9	9	198

Хүснэгт 4.2.4 Судалгаанд ашигласан өгөгдлийн мэдээ

Судалгаанд оролцсон 17 шүүхийн 26 шүүгч Захиргааны хэргийн 22 маргааны хувьд 482 асуумж өгснөөс 1 шүүхийн 9 шүүгчийн 198 өгөгдлийг судалгаанд ашиглав.

4.2.3.2 Ердийн журмаар захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үе шатанд хийх шинжилгээ

Захиргааны хэргийн маргааны тус бүрийн ажиллагаанд зарцуулах хугацааны тухай нийслэл, аймгийн шүүхийн Захиргааны хэргийн шүүгчдийн өгсөн 355 асуумжийн өгөгдөлд хийсэн 2 хүчин зүйлийн дисперсийн шинжилгээний үр дүнг Зураг 4.2.32-д харуулав. Зургаас харвал аймгийн Захиргааны хэргийн шүүгч нар 1 захиргааны хэргийг ердийн журмаар шийдэхэд 10680 минут буюу 178 цаг, нийслэлийн шүүхийн шүүгчид 3779 минут буюу 62.9 цаг зарцуулдаг гэсэн байна. Аймгийн Захиргааны хэргийн шүүхээс ирүүлсэн асуумжийн өгөгдөл НЗХАШШ-ээс ирүүлсэн асуумжийн өгөгдлөөс 2.8 дахин их байгаа тул судалгаанд зөвхөн НЗХАШШ-ийн асуумжийн өгөгдлийг ашиглана.




Зураг 4.2.17 Ердийн журмаар хянан шийдвэрлэсэн хэрэгт зарцуулах хугацааны тухай асуумжийн харьцуулсан мэдээлэл


1 захиргааны хэрэг, маргааныг ердийн журмаар хянан шийдвэрлэхэд зарцуулах хугацааг Захиргааны хэргийн маргаан тус бүрээр нь задалж харуулсан зургаас харвал Татвартай холбоотой маргаан хамгийн их буюу 4133 минут зарцуулдаг гэсэн асуулга өгсөн байна. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ



худалдан авахтай холбоотой маргааны /ТБОН/ хувьд хамгийн бага буюу 3396 минут зарцуулдаг бөгөөд бусад хэргүүдийн хувьд 3624-4084 минут зарцуулдаг гэж үзсэн байна.




Зураг 4.2.183 Ердийн журмаар хянан шийдвэрлэсэн хэрэгт зарцуулах хугацааны тухай асуумжийн ерөнхий мэдээлэл



Ердийн журмаар хянан шийдвэрлэх хэргийн ажиллагааны үе шат

Зураг 4.2.33-аас харвал хэрэг үүсгэснээс хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцүүлэх шийдвэр гаргах хүртэлх хугацааны ажиллагааны үе шатанд дунджаар нэг хэргийг хянан шийдвэрлэхэд нийт хугацааны 46.8% буюу 1770 минут, захиргааны хэрэг үүсгэх эсэхийг шийдвэрлэх шатанд 3.2% буюу 123 минут, хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхэд бэлтгэх, хэлэлцэх үе шат 47.3% буюу 1800 минут, хэргийг эцэслэн шийдвэрлэсний дараах ажиллагааны үе шат 2.3% буюу 86 минутыг зарцуулдаг байна.




Зураг 4.2.34. Ердийн журмаар хэрэг хянан шийдвэрлэх үе шатанд хамаарах ажиллагааны тоо, хэргийн төрлөөр

Зураг 4.2.34-т дэлгэрэнгүй оруулав. Зургаас харвал хэрэг хянан шийдвэрлэх 3-р үе шатанд бусад үеүдийг бодвол их хугацаа зарцуулдаг байна. Энэ үе шатанд бүх маргааны төрөл, ажиллагаанд зарцуулах хугацаа 1285-1961 минут байна. Хэрэг хянан шийдвэрлэх 1-р үе шатанд судалгаанд авсан бүх маргааны ажиллагаанд зарцуулах хугацаа 109-141 минут байна. Хэргийн 2-р үе шатанд бүх маргааны ажиллагаанд зарцуулах хугацаа 1636-2096 минут орчим гэж дүгнэгдсэн байна. Хэргийн 4-р үе шатанд маргааны ажиллагаанд зарцуулах хугацааны бусад үеүдийг бодвол бага бөгөөд 81-87 минут зарцуулна гэсэн байна.


4.2.3.3 Ердийн журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд зарцуулах хугацааны өгөгдөлд хийх шинжилгээ

Өмнөх бүлгийн Зураг 4.2.34-д харуулсан хэрэг хянан шийдвэрлэх үе шатыг ямар төрлийн ажиллагаанаас хамаарч харилцан адилгүй хугацаа зарцуулж байгааг хэргийн ажиллагаа тус бүрээр задалж харуулсан үр дүнг танилцуулъя.



Зураг 4.2.35. Ердийн журмаар хэргийн материалтай танилцах үеийн ажиллагааны задаргаа


Зураг 4.2.35-аас харвал Захиргааны хэргийн шүүгч хэрэг үүсгэх эсэхийг шийдвэрлэх үе шатанд зарцуулах нийт хугацааны 2% буюу 2 минутыг улсын тэмдэгтийн хураамж төлсөн эсэхийг шалгах, 42.8% буюу 51 минутыг нэхэмжлэл, түүнд хавсаргасан баримттай уншиж танилцах, 22.7% буюу 27 минутыг нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах үндэслэл байгаа эсэхийг шалгасан туслахын ажиллагааг хянахад, 32.8% буюу 39 минутыг нэхэмжлэлийн бүрдүүлбэр хангуулах хугацаа тогтоох, хэрэг үүсгэх, буцаах, татгалзах тухай захирамж гаргахад тус тус зарцуулдаг байна.




Зураг 4.2.36. Ердийн журмаар хэрэг үүсгэх эсэхийг шийдвэрлэх шатанд үеийн ажиллагаанд зарцуулах хугацаа, хэргийн төрлөөр

Зураг 4.2.35-д харуулсан Захиргааны хэргийн шүүгч хэрэг үүсгэх эсэхийг шийдвэрлэх үе шатанд зарцуулах нийт хугацааг хэргийн төрөл тус бүрээр Зураг 4.2.36-д задалж харуулав. Хэрэг хянан шийдвэрлэх хэрэг үүсгэх эсэхийг шийдвэрлэх үе шатны нэхэмжлэл, түүнд хавсаргасан баримттай уншиж танилцах ажиллагаа бусад ажиллагааг бодоход их хугацаа зарцуулна гэсэн байна. Улсын тэмдэгтийн хураамж төлсөн эсэхийг шалгах бусад ажиллагааг бодоход бага хугацаа зарцуулна гэсэн байна.

Хэрэг үүсгэснээс хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцүүлэх шийдвэр гаргах хүртэлх ажиллагааны үе шатанд зарцуулах нийт хугацааг хэргийн төрөл тус бүрээр Зураг 4.2.37-д задалж харуулав. Ердийн журмаар хэрэг хянан шийдвэрлэх 2-р үе шатны дээрх ажиллагааг асуумжийн өгөгдлөөр задалсан шинжилгээний үр дүнг дараах зурагт харуулав.




Зураг 4.2.287. Хэрэг үүсгэснээс хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцүүлэх шийдвэр гаргах хүртэлх хугацааны ажиллагаа



Зураг 4.2.298. Хэргийн оролцогчоос ХХША–тай холбоотой хүсэлт гаргасан тохиолдолд шийдвэрлэх үеийн ажиллагааны задаргаа

Энэ ажиллагааны ХХША–тай холбоотой ажиллагаанд 125 минут, гуравдагч этгээд оролцуулах тухай ажиллагаанд 31 минут, нотлох баримттай холбоотой ажиллагаанд 51 минут, захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлэх ажиллагаанд 44 минут, шүүхээс гарах шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах арга хэмжээ авах ажиллагаанд 31 минут, бусад ажиллагаанд 125 минут тус тус зарцуулдаг байна. Хэргийн материалыг уншиж судлах ажиллагааг мөн асуумжийн өгөгдлөөр задалж тооцсон үр дүнг дараах зурагт харуулав.



Зураг 4.2.39. Хэргийн материал уншиж судлах үеийн ажиллагааны задаргаа


Дээрх графикаас харвал хэргийн түүвэр гаргах хугацаа хамгийн их буюу 243 минутыг зарцуулдаг гэж үзсэн байна.

Хэрэг хянан шийдвэрлэх 3-р үе шатны шийдвэр боловсруулах, хянах, гарын үсэг зурах ажиллагаанд зарцуулах хугацаа бусад ажиллагааг бодвол харьцангуй их хугацаа зарцуулдаг гэж үзсэн байна. Энэ үе шатны дээрх ажиллагааг асуумжийн өгөгдлөөр задалсан шинжилгээний үр дүнг дараах зурагт харуулав.




Зураг 4.2.40. Хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхэд бэлтгэх, хэлэлцэх үеийн ажиллагаанд зарцуулах хугацааны задаргаа

Шүүх хуралдаанд зарцуулах хугацааны асуумж дотроо дараах 4-н хувилбартайгаар өгөгдсөн тул шинжилгээний үр дүнг хувилбар тус бүрээр задалж дараах зурагт харуулав. Доорх зургаас харвал бүрэлдэхүүн даргалсан үе хамгийн их буюу 202 минут, үндэслэлийг тайлбарлах үе хамгийн бага буюу 16 минут тус тус зарцуулдаг болох нь тооцоогоор гарав.




Зураг 4.2.41. Шүүх хуралдаан үеийн ажиллагаанд зарцуулах асуумжийн задаргаа



Зураг 4.2.42. Шийдвэр боловсруулах, хянах, гарын үсэг зурах ажиллагаанд зарцуулах хугацаа

Шийдвэр боловсруулах, хянах, гарын үсэг зурах ажиллагааны үе шатанд шүүхийн шийдвэр боловсруулах, хянах үйл ажиллагаанд зарцуулах хугацаа бусад ажиллагааг бодоход харьцангуй их хугацаа буюу 1927 минут, шүүхийн шийтгэвэрт хамгийн бага хугацаа буюу 61 минутыг тус тус зарцуулдаг байна.



Зураг 4.2.43. Хэрэг хянан шийдвэрлэсний дараах ажиллагаа

Зураг 4.2.43-аас харвал Захиргааны хэргийн шүүгч хэрэг хянан шийдвэрлэсний дараах ажиллагааны үе шатанд зарцуулах нийт хугацааны 39% буюу 49 минутыг албадан гүйцэтгэх захирамж хянаж, гарын үсэг зурахад, 30% буюу 37 минутыг гүйцэтгэх хуудас хянаж, гарын үсэг зурахад, хэргийг эмхэтгэснийг хянаж, баримтад гарын үсэг зурахад 31% буюу 39 минутыг тус тус зарцуулдаг байна.

4.2.4 Захиргааны хэргийн анхан болон давж заалдах шатны шүүхээс ирүүлсэн асуумжийн дүгнэлт

1. Хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэсэн захиргааны хэргийн асуумжийн өгөгдөлд хийх шинжилгээ

Хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэсэн захиргааны хэргийн асуумжийн судалгаанд нийт 15 шүүхийн 24 шүүгч захиргааны хэрэг маргааныг хянан шийдвэрлэхэд ашигладаг 22 төрлийн маргааны хувьд 451 асуумж өгснөөс 9 шүүхийн 18 шүүгчийн 346 өгөгдлийг судалгаанд ашиглав. Үүнээс Архангай, Булган, Дундговь, Увс, Ховд, Хэнтий аймгийн шүүхийн асуумжийн өгөгдлийг судалгаанаас хасав.

Нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгч нар хялбаршуулсан журмаар захиргааны 1 хэргийг шийдэхэд дунджаар 2032 минут, аймгийн шүүгчид 6431 минут тус тус зарцуулдаг гэсэн байна.

Асуумжид өгөгдсөн захиргааны хэргийн шүүхийн 22 маргаанаас Улсын бүртгэлийн маргаан хамгийн их буюу 4841 минут зарцуулдаг харин оюуны өмчтэй холбоотой маргаан хамгийн бага буюу 2809 минутыг зарцуулдаг гэж өгсөн байна

Захиргааны хэрэг үүсгэх эсэхийг шийдвэрлэх үе шатанд дунджаар нэг хэрэг маргааныг хянан шийдвэрлэхэд нийт хугацааны 5% буюу 198 минут, хэрэг үүсгэснээс хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцүүлэх шийдвэр гаргах хүртэлх хугацааны үе шатанд 68% буюу 2625 минут, хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхэд бэлтгэх, хэлэлцэх үе шатанд 24% буюу 947 минут, хэргийг эцэслэн шийдвэрлэсний дараах ажиллагааны үе шатанд 3% буюу 114 минутыг тус тус зарцуулдаг байна.



2. *Ердийн журмаар хянан шийдвэрлэсэн захиргааны хэргийн асуумжийн өгөгдөлд хийх шинжилгээ*

Ердийн журмаар хянан шийдвэрлэсэн захиргааны хэргийн асуумжийн судалгаанд нийт 17 шүүхийн 26 шүүгч захиргааны хэрэг маргааныг хянан шийдвэрлэхэд ашигладаг 22 төрлийн маргааны хувьд 482 асуумж өгснөөс 1 шүүхийн 9 шүүгчийн 198 өгөгдлийг судалгаанд ашиглав.

Нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгч нар ердийн журмаар захиргааны 1 хэрэг маргааныг шийдэхэд дунджаар 3779 минут буюу 62.9 цаг, аймгийн шүүгчид 10680 минут буюу 178 цагийг тус тус зарцуулдаг гэсэн байна. Аймгийн Захиргааны хэргийн анхан шатны шүүхээс ирүүлсэн асуумжийн өгөгдөл НЗХАШШ-ээс ирүүлсэн асуумжийн өгөгдлөөс 2.8 дахин их байгаа тул аймгийн захиргааны хэргийн анхан шатны шүүхүүдээс ирүүлсэн судалгаанаас хассан.

Асуумжид өгөгдсөн захиргааны хэргийн шүүхийн 22 маргаанаас Татвартай холбоотой маргаан хамгийн их буюу 4133 минут, харин Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авахтай холбоотой маргааны /ТБОН/ хувьд хамгийн бага буюу 3396 минутыг тус тус зарцуулдаг.

Захиргааны хэрэг үүсгэснээс хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцүүлэх шийдвэр гаргах хүртэлх хугацааны ажиллагааны үе шатанд дунджаар нэг хэргийг хянан шийдвэрлэхэд нийт хугацааны 46.8% буюу 1770 минут, захиргааны хэрэг үүсгэх эсэхийг шийдвэрлэх шатанд 3.2% буюу 123 минут, хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхэд бэлтгэх, хэлэлцэх үе шат 47.3% буюу 1800 минут, хэргийг эцэслэн шийдвэрлэсний дараах ажиллагааны үе шат 2.3% буюу 86 минутыг зарцуулдаг байна.

3. *Давж заалдах шатны шүүхийн асуумжийн өгөгдөлд хийх шинжилгээ*

Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгчийн ажлын ажиллагааны ачааллыг бодитой тодорхойлохын тулд Нийслэлийн захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн захиргааны хэрэг хянан шийдвэрлэх үйл ажиллагаанд ажлын байрны зураг авалт хийсэн өгөгдлийг судалгаанд ашиглав.

Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгч нэг захиргааны хэрэг маргааныг хянан шийдвэрлэхэд 5015 минут, ерөнхий шүүгч 5434 минут зарцуулдаг гэж асуумж өгсөн байна.

Асуумжид өгөгдсөн захиргааны хэргийн шүүхийн 22 маргааныг шийдвэрлэхэд дунджаар 3760-6800 минут зарцуулдаг байна.

Хэргийг хүлээн авах үе шатанд дунджаар нэг хэргийг хянан шийдвэрлэхэд нийт хугацааны 10.1% буюу 453 минут, хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхэд бэлтгэх, хэлэлцэх үе шатанд 41.5% буюу 1861 минут, хэргийг хянан шийдвэрлэсний дараах ажиллагааны үе шатанд 48.8% буюу 2170 минут зарцуулдаг байна.

4.3 Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх үйл ажиллагааны ажиглалтын өгөгдөлд хийх шинжилгээ


Захиргааны хэргийн шүүгчийн хянан шийдвэрлэсэн хэргийн ажиллагааны ачааллыг бодитой тодорхойлохын тулд ШЕЗ-ийн судалгаа шинжилгээний баг Захиргааны хэргийн хуульд заасан дараах маргааны төрлийн үзүүлэлтийн дагуу шүүгчийн ажлын байрны зураг авалт хийж, цуглуулсан өгөгдөлд хийсэн шинжилгээний үр дүнг энэ бүлэгт танилцуулна. Судалгаанд 22 маргааны төрөлд хамаарах ажлын байрны зураг авалт хийсэн өгөгдлийг ашиглав.



4.3.1 ЗХАШШ-ийн хэрэг хянан шийдвэрлэх үйл ажиллагааны ажиглалтын өгөгдөлд хийх шинжилгээ


4.3.1.1 Ажиглалтын өгөгдлийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны ерөнхий дүн ба үе шатуудын хувьд хийх шинжилгээ

Захиргааны хэрэг хянан шийдвэрлэдэг шүүгчийн ажлын ажиллагааны ачааллыг бодитой тодорхойлохын тулд Дархан-Уул, Нийслэлийн шүүхийн тус тус нэг шүүгчийн захиргааны хэрэг хянан шийдвэрлэх үйл ажиллагаанд ажлын байрны зураг авалт хийж, өгөгдөл цуглуулан шинжилгээ хийсэн үр дүнг танилцуулж байна.




Зураг 4.3.1 Захиргааны хэрэг хянан шийдвэрлэхэд зарцуулах хугацааны тухай ажиглалтын өгөгдлийн ерөнхий мэдээлэл

Захиргааны хэргийн хуульд заасан маргааны төрөл тус бүрийн ажиллагаанд зарцуулах хугацааны тухай Дархан-Уул, Нийслэлийн Захиргааны хэргийн хоёр шүүгчийн ажлын байрны зураг авалтын үр дүнд цуглуулсан 70 өгөгдөлд хийсэн 3 хүчин зүйлийн дисперсийн шинжилгээний үр дүнг Зураг 4.3.1-д харуулав. Зургаас харвал Дархан-Уул аймгийн захиргааны хэргийн шүүгч нэг хэрэг шийдэхэд 3415 минут, Нийслэлийн шүүгч 3108 минут зарцуулдаг байна. Харин шүүгч нэг захиргааны хэрэг шийдэхэд 2998 минут зарцуулдаг бол ерөнхий шүүгч 3446 минут зарцуулдаг байна.



Зураг 4.3.2 Захиргааны хэрэг хянан шийдвэрлэхэд зарцуулах хугацааны тухай ажиглалтын өгөгдөл, маргааны төрлөөр

Хэрэг хянан шийдвэрлэх хугацааг захиргааны хэргийн маргааны төрөл тус бүрээр нь задалж харуулсан зургаас харвал судалгаанд хамрагдсан маргааны төрлүүдийн хувьд 2861-3592 минут зарцуулдаг байна.



Зураг 4.3.3 Захиргааны хэрэг хянан шийдвэрлэхэд зарцуулах хугацааны тухай ажиглалтын өгөгдөл, маргааны төрөл ба шүүхээр



Ажлын байрны зураг авалтад хамрагдсан хоёр шүүхийн хувьд Дархан-Уул аймгийн ЗХШ-ийн шүүгч судалгаанд хамрагдсан маргааны төрлүүдийн хувьд 3102-3632 минут зарцуулдаг байхад нийслэлийн ЗХШ-ийн шүүгч 2852-3592 минут зарцуулдаг төлөв ажиглагдсан байна. Дисперсийн шинжилгээний программын үр дүнгээр детерминац, корреляц, вариацийн коэффициентийг тооцсон үр дүнг дараах хүснэгтээр харуулъя.

№	Үзүүлэлт	Детерминацийн коэффициент	Корреляцийн коэффициент	Вариацийн коэффициент	Дундаж
1	Шүүх	0.09	0.30	38%	3222
2	Хэрэг	0.67	0.82	14%	
3	Шүүгч	0.04	0.20	58%	

Хүснэгт 4.3.1 Ажиглалтын өгөгдлийн хэрэг хянан шийдвэрлэх хугацаанд нөлөөлөх хүчин зүйлүүд


Хүснэгтийн хоёрдугаар мөрийн утгыг тайлбарлая. Захиргааны хэргийг хянан шийдвэрлэхэд зарцуулах хугацааны өөрчлөлтийн 0.67 нь хэргийн маргааны төрлөөс хамаарч байна. Захиргааны хэргийг хянан шийдвэрлэхэд зарцуулах хугацаа хэргийн маргааны төрлөөс 0.82 буюу хүчтэй хамааралтай байна. Вариацийн коэффициент 14% байгаа нь дунджийг бусад тоон утгыг төлөөлөх чадвартай гэж үзнэ. Мөн шүүгчийн ангилал (ерөнхий шүүгч, шүүгч), шүүхийн тогтолцоо ба маргааны төрлийн зарцуулах хугацааны хувьд дундаж утгыг судалгаанд цааш нь ашиглах боломжтой.

Захиргааны хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааны үе шат дараах үндсэн дөрвөн үе шатаас бүрдэх бөгөөд шинжилгээний үр дүнг харуулъя.




Зураг 4.3.4 Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үндсэн үе шат

Зураг 4.3.4-оос харвал захиргааны хэрэг үүсгэх эсэхийг шийдвэрлэх үе шатанд дунджаар нэг хэргийг хянан шийдвэрлэхэд нийт хугацааны 5.1% буюу 165 минут, хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцүүлэх тухай шийдвэр гаргах үе шатанд 62.2% буюу 2005 минут, хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхэд бэлтгэх, хэлэлцэх үе шатанд 26.5% буюу 854 минут, хэрэг хянан шийдвэрлэсний дараах үе шатанд 6.1% буюу 198 минут тус тус зарцуулдаг байна.



Зураг 4.3.5 Шүүхүүдийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд зарцуулах хугацаа, хэргийн үе шатаар

Зураг 4.3.4-д харуулсан үр дүнг судалгаанд хамрагдсан шүүх тус бүрээр задалж харуулбал хэргийн 1-р үед шатанд Дархан-Уул АЗХШ, НЗХШ-ээс 57 минутаар илүү хугацаа, хэргийн 2-р үед шатанд 307 минутаар илүү хугацаа, хэргийн 3-р үед шатанд 102 минутаар илүү хугацаа, хэргийн 4-р үе шатанд 158 минутаар бага хугацаа тус тус зарцуулдаг байна.



Зураг 4.3.6 Хэрэг хянан шийдвэрлэх үе шатанд хамаарах ажиллагааны хугацаа, маргааны төрлөөр

Зураг 4.3.4-д харуулсан ерөнхий мэдээллийг захиргааны хэргийн маргааны төрөл тус бүрээр Зураг 4.3.6-д дэлгэрэнгүй оруулав. Зургаас харвал хэрэг хянан шийдвэрлэх 1-р үе шатанд бүх маргааны төрлийн ажиллагаанд зарцуулах хугацаа 130-18 минут байна. Хэрэг хянан шийдвэрлэх 2-р үе шатанд судалгаанд авсан бүх маргааны төрлийн ажиллагаанд зарцуулах хугацаа 1673-2373 минут байна. Хэргийн 3-р үе шатанд судалгаанд авсан бүх маргааны төрлийн ажиллагаанд зарцуулах хугацаа 791-915 минут байна. Хэргийн 4-р үе шатанд бүх маргааны төрлийн ажиллагаанд зарцуулах хугацаа 170-342 минут байна.

4.3.1.2 Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны 1-4-р үе шатанд зарцуулах хугацааны өгөгдөлд хийх шинжилгээ

Захиргааны хэрэг үүсгэх эсэхийг шийдвэрлэх үе шат

Зураг 4.3.4-д харуулсан хэрэг хянан шийдвэрлэх үе шатыг ямар төрлийн ажиллагаанаас хамаарч харилцан адилгүй хугацаа зарцуулж байгааг 1-р үеийн хэргийн ажиллагаа тус бүрээр задалж харуулсан үр дүнг танилцуулъя.




Зураг 4.3.7 Захиргааны хэрэг үүсгэх эсэхийн шийдвэрлэх үе шатанд хийгдэх ажиллагаа

Зураг 4.3.7-оос харвал захиргааны хэргийн шүүгч хэргийг үүсгэх эсэхийг шийдвэрлэх үе шатанд зарцуулах нийт хугацааны 1.2% буюу 2 минутыг улсын тэмдэгтийн хураамж төлсөн эсэхийг шалгахад, нэхэмжлэлд хавсаргасан баримттай




уншиж танилцахад 34.3% буюу 57 минут, нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах үндэслэлийг шалгасан туслахын ажиллагааг хянахад 22.9% буюу 38 минут, нэхэмжлэлийн бүрдүүлбэр хангуулах хугацаа тогтоох, хэрэг үүсгэх, буцаах, татгалзах тухай захирамж гаргахад 41.6% буюу 69 минут тус тус зарцуулдаг байна.



Зураг 4.3.8 Шүүхүүдийн захиргааны хэрэг үүсгэх эсэхийн шийдвэрлэх үеийн ажиллагаанд зарцуулах хугацаа

Зураг 4.3.8-д харуулсан үр дүнг судалгаанд хамрагдсан шүүх тус бүрээр задалж харуулбал улсын тэмдэгтийн хураамж төлсөн эсэхийг шалгахад 2 ба 3 минут, нэхэмжлэлд хавсаргасан баримттай уншиж танилцахад 106, 27 минут, нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах үндэслэлийг шалгасан туслахын ажиллагааг хянахад 26, 45 минут, нэхэмжлэлийн бүрдүүлбэр хангуулах хугацаа тогтоох, хэрэг үүсгэх, буцаах, татгалзах тухай захирамж гаргахад 66, 70 минут хугацаа зарцуулдаг байна. Нэхэмжлэлд хавсаргасан баримттай уншиж танилцахад Дархан-Уул аймгийн ЗХШ харьцангуй их хугацаа буюу 106 зарцуулсан байна.




Зураг 4.3.9 Ажиглалтын өгөгдлийн захиргааны хэрэг үүсгэх эсэхийн шийдвэрлэх үеийн ажиллагаанд зарцуулах хугацаа, маргааны төрлөөр

Зураг 4.3.7-д харуулсан захиргааны хэрэг үүсгэх эсэхийн шийдвэрлэх үе шатанд зарцуулах нийт хугацааг хэргийн төрөл тус бүрээр Зураг 4.3.7-д задалж харуулав. Хэрэг хянан шийдвэрлэх 1-р үе шат болох захиргааны хэрэг үүсгэх эсэхийн шийдвэрлэх үе шатны улсын тэмдэгтийн хураамж төлсөн эсэхийг шалгах ажиллагаанд захиргааны хэргийн бүх маргааны төрлийн хувьд 1-4 минут зарцуулдаг байна. Нэхэмжлэлд




хавсаргасан баримттай уншиж танилцахад захиргааны хэргийн бүх маргааны төрлийн хувьд 20-74 минут зарцуулдаг байна. Нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах үндэслэлийг шалгасан туслахын ажиллагааг хянахад захиргааны хэргийн бүх маргааны төрлийн хувьд 30-60 минут зарцуулдаг байна. Нэхэмжлэлийн бүрдүүлбэр хангуулах хугацаа тогтоох, хэрэг үүсгэх, буцаах, татгалзах тухай захирамж гаргахад 58-77 минут зарцуулдаг байна.

• **Хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцүүлэх тухай шийдвэр гаргах үе шат**



Зураг 4.3.10 Захиргааны хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцүүлэх тухай шийдвэр гаргах үеийн ажиллагаа

Зураг 4.3.10-аас харвал Захиргааны хэргийн шүүгч хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцүүлэх тухай шийдвэр гаргах ажиллагааны үе шатанд зарцуулах нийт хугацааны 4.4% буюу 90 минутыг хариуцагчид хүргүүлэх мэдэгдэх хуудас, хариуцагчид нэхэмжлэлийн хувь гардуулсан баримт, хариуцагчид эрх, үүрэг тайлбарласан баримт, нөлөөллийн мэдүүлгийн мэдээлэл өгсөн баримт зэрэг ажиллагаанд, 8.2% буюу 164 минутыг үзлэг хийхэд, 13.7% буюу 274 минутыг хэргийн оролцогчийн ХХША-тай холбоотой хүсэлтийн шийдвэр гаргахад, 5.8% буюу 117 минутыг хариу тайлбартай танилцах, хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцүүлэх тухай захирамжийг хянах, гарын үсэг зурах ажиллагаанд, 11.4% буюу 229 минутыг хэргийн оролцогчтой уулзалт хийх, эрх үүрэг тайлбарлах, урьдчилсан хэлэлцүүлэг ажиллагаанд, 41.6% буюу 925 минутыг хэргийн материалтай танилцахад, 10.3% буюу 207 минутыг нотлох баримт цуглуулах зэрэг ажиллагаанд тус тус зарцуулдаг байна.




Зураг 4.3.11 Шүүхүүдийн захиргааны хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцүүлэх тухай шийдвэр гаргах үеийн ажиллагаанд зарцуулах хугацаа

Зураг 4.3.11-д харуулсан үр дүнг судалгаанд хамрагдсан шүүх тус бүрээр задалж харуулбал хариу тайлбартай танилцах, хэргийн оролцогчийн ХХША-ны хүсэлтийн шийдвэр гаргах, үзлэг хийх, хариу тайлбартай танилцах, хэргийн шүүх хуралдаанаар




хэлэлцүүлэх тухай захирамж зэрэг ажиллагаанд зарцуулах хугацаа хоёр шүүхийн хувьд эрс ялгаатай байна.

Хэрэг хянан шийдвэрлэх 2-р үе шатны хэргийн оролцогчийн ХХША-тай холбоотой хүсэлтийн шийдвэр гаргах ажиллагаа дотроо дараах 6 хэсгээс бүрдсэн байхаар задалж ажиглалт явуулсан байсан тул үзүүлэлт бүрийн хувьд тооцсон үр дүнг дурдъя.




Зураг 4.3.12 Захиргааны хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцүүлэх тухай шийдвэр гаргах үеийн хэргийн оролцогчийн ХХША-тай холбоотой хүсэлтийн шийдвэр гаргах ажиллагааны задаргаа

Зураг 4.3.10-д дурдсан хэрэг хянан шийдвэрлэх 2-р үе шатны нийт ажиллагааны 13.7% буюу 274 минутыг эзлэх хэргийн оролцогчийн ХХША-тай холбоотой хүсэлтийн шийдвэр гаргах ажиллагааны ажиглалтын үр дүнг задалж үзэхэд шүүхийн шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах арга хэмжээнд 61 минут, ХХША - тай холбоотой ажиллагаанд 29 минут, нотлох баримттай холбоотой ажиллагаанд 57 минут, захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлэх ажиллагаанд 68 минут, гуравдагч этгээд оролцуулах тухай ажиллагаанд 56 минут, бусад ажиллагаанд 3 минут тус тус зарцуулдаг болох нь тооцоогоор гарав.



Зураг 4.3.13 Захиргааны хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцүүлэх тухай шийдвэр гаргах үеийн хэргийн материалтай танилцах ажиллагааны задаргаа


Зураг 4.3.10-д дурдсан хэрэг хянан шийдвэрлэх 2-р үе шатны нийт ажиллагааны 41.6% буюу 925 минутыг эзлэх хэргийн материалтай танилцах ажиллагааны ажиглалтын үр дүнг задалж харуулахад ХХША-г төлөвлөхөд 49 минут, хэргийн материалыг уншиж судлахад 177 минут, шаардлагатай хууль тогтоомжийг судлахад хамгийн их буюу 202 минут, түүвэр гаргахад 239 минут, шүүхийн практик судлахад 258 минут тус тус зарцуулдаг болох нь тооцоогоор гарав.



Зураг 4.3.14 Хэргийн оролцогчтой уулзалт хийх, эрх үүрэг тайлбарлах ажиллагааны задаргаа


Зураг 4.3.10-д дурдсан хэрэг хянан шийдвэрлэх 2-р үе шатны нийт ажиллагааны 11.4% буюу 117 минутыг эзлэх хэргийн оролцогчтой уулзалт хийх, эрх үүрэг тайлбарлах ажиллагааны ажиглалтын үр дүнг задалж харуулахад гуравдагч этгээдтэй уулзахад 26 минут, хэргийн хариуцагч, хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгч, нэхэмжлэгчтэй уулзах зэрэг ажиллагаанд тус тус 32 минут зарцуулдаг болох нь тооцоогоор гарав.

- **Хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхэд бэлтгэх, хэлэлцэх үе шат**




Зураг 4.3.15 Захиргааны хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхэд бэлтгэх, хэлэлцэх үед зарцуулах хугацаа

Зураг 4.3.15-аас харвал хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхэд бэлтгэх, хэлэлцэх үе шатанд зарцуулах нийт хугацааны 56.7% буюу 485 минутыг шийдвэр боловсруулах, хянах, гарын үсэг зурах ажиллагаанд, 11.1% буюу 95 минутыг шүүх хуралдааны тэмдэглэл хянах, гарын үсэг зурах ажиллагаанд, 1.8% буюу 15 минутыг шүүх хуралдааны тов мэдэгдэх хуудсыг хянах, гарын үсэг зурах, шүүхийн иргэдийн төлөөлөгчид мэдээлэл өгсөн баримтыг хянах, гарын үсэг зурах ажиллагаанд, 30.4% буюу 260 минутыг шүүх хуралдаан явуулах ажиллагаанд тус тус зарцуулдаг байна.



Зураг 4.3.16 Шүүхүүдийн ердийн журмаар хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхэд бэлтгэх, хэлэлцэх үеийн ажиллагаанд зарцуулах хугацаа

Зураг 4.3.15-д харуулсан үр дүнг судалгаанд хамрагдсан шүүх тус бүрээр задалж харуулбал хэрэг хянан шийдвэрлэх 3-р үе шатны зурагт харуулсан дээрх ажиллагаануудын шүүхийн шийдвэр боловсруулах, хянах ажиллагааны хувьд Дархан-Уул аймгийн ЗХШ 578 минут зарцуулдаг байхад НЗХШ 429 минут зарцуулдаг байна. Бусад ажиллагаануудын хувьд 2 шүүх ойролцоо хугацаа зарцуулдаг байна.



Зураг 4.3.17 Ажиглалтын өгөгдлийн хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхэд бэлтгэх, хэлэлцэх үеийн ажиллагаанд зарцуулах хугацаа, маргааны төрлөөр



Зураг 4.3.15-д харуулсан Захиргааны хэргийн шүүгчийн хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхэд бэлтгэх, хэлэлцэх ажиллагааны үе шатанд зарцуулах нийт хугацааг маргааны төрөл тус бүрээр Зураг 4.3.17-д задалж харуулав. Хэрэг хянан шийдвэрлэх 3-р үе шатны шүүх хуралдааны тов мэдэгдэх хуудсанд гарын үсэг зурахад бүх маргааны төрлийн хувьд 5-10 минут зарцуулдаг байна. Шүүхийн иргэдийн төлөөлөгчид мэдээлэл өгсөн баримтад гарын үсэг зурах ажиллагааны хувьд зурахад бүх маргааны төрлөөр 8-15 минут зарцуулдаг байна. Шүүх хуралдааны ажиллагаанд бүх маргааны төрлийн хувьд 237-303 минут зарцуулдаг бөгөөд маргааны төрөл тус бүрийн хувьд харилцан адилгүй хугацаа зарцуулдаг байна. Шүүх хуралдааны тэмдэглэл хянах, гарын үсэг зурахад 70-115 минут зарцуулдаг байна. Шийдвэр боловсруулах, хянах ажиллагааны хувьд 420-531 минут зарцуулдаг байна.

Зураг 4.3.15-д дурдсан хэрэг хянан шийдвэрлэх 3-р үе шатны нийт ажиллагааны 30.4% буюу 260 минутыг эзлэх шүүх хуралдаан явуулах ажиллагааны ажиглалтын үр дүнг судалгаанд ирсэн ажиглалтын өгөгдлөөр задалж харуулав.




Зураг 4.3.18 Шүүх хуралдааны задаргаа

Зургаас харвал шүүх хуралдаан хийхэд хамгийн их буюу 143 минут, зөвлөлдөхөд 80 минут, шийдвэрийн тогтоох хэсгийг танилцуулахад 47 минут тус тус зарцуулдаг болох нь тооцоогоор гарав. Шүүх хуралдааны хэлбэр ажиглалтын өгөгдлөөр задаргаатай ирсэн тул үзүүлэлт бүрийн хувьд тооцсон үр дүнг дурдъя.



Зураг 4.3.19 Шүүх хуралдаан явуулах хэлбэрийн хувьд зарцуулах хугацаа


Зургаас харвал шүүх хуралдааныг дангаар явуулах үед 141 минут, бүрэлдэхүүн даргалах үед 144 минут зарцуулна гэж үзсэн байна.



Зураг 4.3.20 Шүүхийн шийдвэр гаргах ажиллагааны задаргаа

Зураг 4.3.15-д хэрэг хянан шийдвэрлэх 3-р үе шатны 56.7% буюу 485 минутыг эзлэх шийдвэр боловсруулах ажиллагааны ерөнхий дүнг ажиллагаа тус бүрээр задалж үзэхэд шүүгчийн захирамж гаргахад 67 минут, шүүхийн шийтгэвэр гаргах ажиллагаанд 70 минут, шүүхийн тогтоолд 85 минут, шүүхийн шийдвэр гаргахад 263 минут зарцуулдаг байна.


• Хэрэг хянан шийдвэрлэсний дараах үе шат



Зураг 4.3.21 Хэрэг хянан шийдвэрлэсний дараах үеийн ажиллагааны задаргаа




Зураг 4.3.21-д хэрэг хянан шийдвэрлэсний дараах үе шатанд зарцуулах нийт хугацааг тус шатны ажиллагаа тус бүрээр задалж тооцсон үр дүнг харуулав. Энэ үе шатны нийт ажиллагаанд зарцуулах хугацааны 32.7% буюу 65 минутыг албадан гүйцэтгэх захирамж хянах, гарын үсэг зурахад, 29.6% буюу 59 минутыг гүйцэтгэх хуудас хянах, гарын үсэг зурахад, 37.7% буюу 75 минутыг эмхэтгэсэн хэргийг хянах, гарын үсэг зурах ажиллагаанд тус тус зарцуулдаг нь ажиглалтаар харагдав.



Зураг 4.3.22 Шүүхүүдийн хэрэг хянан шийдвэрлэсний дараах үеийн ажиллагаанд зарцуулах хугацаа

Зураг 4.3.22-д харуулсан үр дүнг шүүхээр задалж харуулбал албадан гүйцэтгэх захирамж ба гүйцэтгэх хуудас хянах, гарын үсэг зурахад Дархан-Уулын шүүх Нийслэлийн шүүхээс 50 ба 54 минутаар бага хугацаа зарцуулдаг байна. Эмхэтгэсэн хэргийг хянаж баримтад гарын үсэг зурахад мөн Дархан-Уулын шүүх Нийслэлийн шүүхээс 55 минут илүү хугацаа зарцуулдаг байна.



Зураг 4.3.23 Ажиглалтын өгөгдлийн хэрэг хянан шийдвэрлэсний дараах үеийн ажиллагаанд зарцуулах хугацаа, маргааны төрлөөр

Хэрэг хянан шийдвэрлэх 4-р үе шатны ажиллагаанд бүх маргааны төрлөөр хэрэг хянан шийдвэрлэхэд зарцуулах хугацааг харуулав. Албадан гүйцэтгэх захирамж хянах, гарын үсэг зурахад бүх маргааны төрлийн хувьд 56-112 минут зарцуулдаг байна. Гүйцэтгэх хуудас хянах, гарын үсэг зурахад бүх маргааны төрлийн хувьд 50-107 минут зарцуулдаг байна. Эмхэтгэсэн хэргийг хянаж баримтад гарын үсэг зурахад энэ үе шатны бусад ажиллагаатай адил хугацаа зарцуулах бөгөөд бүх маргааны төрлийн хувьд 63-123 минут зарцуулдаг байна.

4.3.2 Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн хянан шийдвэрлэсэн хэргийн ажиглалтын өгөгдөлд хийх шинжилгээ

Судалгаанд дараах маргааны төрөлд хамаарах ажлын байрны зураг авалтыг хийсэн бөгөөд хуулийн зарим нэр томъёоны тайлбарыг товч оруулъя. Үүнд:

Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль /ЗХШХШТХ/-ийн 122 дугаар зүйлийн 122.1-д заасан гомдол гэдэгт шүүгчийн захирамж, шүүхийн тогтоолд гомдол гаргах тухай юм.



14.6. Энэ хуулийн 14.1-14.4-т заасан хугацаа зайлигүй хүндэтгэн үзэх шалтгааны улмаас хэтэрсэн бол хүн, хуулийн этгээд, нийтийн ашиг сонирхлыг төлөөлөх эрх бүхий этгээд хугацаа сэргээлгэх хүсэлтээ холбогдох нотлох баримтын хамт тухайн захиргааны хэргийн шүүхэд гаргаж болох бөгөөд шүүгч уг хугацааг хэтэрснээс хойш гурван жилийн дотор нөхөн сэргээж болно.

32.6. Захиргааны хэргийн шүүх хэрэгт хамааралгүй, нотолгооны ач холбогдолгүй, хуулиар зөвшөөрөгдөөгүй баримтыг хэргийн нотлох баримтаас хасах бөгөөд уг баримтыг шаардан гаргуулж болохгүй.

54.2. Нэхэмжлэлийг энэ хуулийн 54.1-д заасан үндэслэлээр хүлээн авахаас татгалзахдаа шүүгч захирамж гарган татгалзсан шалтгааныг зааж, уг нэхэмжлэлийг дахин гаргах, эсхүл хүлээн авахад саад болж байгаа зөрчлийг хэрхэн засахыг зааж, нэхэмжлэлийг буцаана.

61.1. Энэ хуулийн 62 дугаар зүйл, эсхүл хуульд тусгайлан зааснаас бусад тохиолдолд шүүгч хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгчийн хүсэлтээр захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлнэ.


65.1. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг дараах тохиолдолд шүүгч захирамж, шүүх тогтоол гарган түдгэлзүүлнэ:

111.3. Энэ хуулийн 111.1-д заасны дагуу гаргасан шүүгчийн захирамж, шүүхийн тогтоол илт үндэслэлгүй бол уг захирамж, тогтоолыг гаргасан шүүгч, шүүх бүрэлдэхүүн хүчингүй болгох, эсхүл өөрчилж болно.

119.6. Энэ хуулийн 119.5-д заасан хугацааг хүндэтгэн үзэх шалтгаанаар хэтрүүлсэн бол хугацаа сэргээлгэх хүсэлтийг анхан шатны шүүхэд гаргах бөгөөд хүсэлтийг хангах эсэхийг шүүгч захирамж гарган шийдвэрлэнэ.


123.7. Хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгч энэ хуулийн 119.5-д заасан хугацааг хүндэтгэн үзэх шалтгаанаар хэтрүүлсэн бол хугацаа сэргээлгэх хүсэлтээ холбогдох нотлох баримтын хамт анхан шатны шүүхэд гаргах бөгөөд хүсэлтийг хангах эсэхийг шүүгч тухайн хүсэлтэд хавсаргасан баримтын хүрээнд захирамж гарган шийдвэрлэнэ.

Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгчийн ажлын ажиллагааны ачааллыг бодитой тодорхойлохын тулд НЗХДЗШШШ-ийн Захиргааны хэргийн гомдол шийдвэрлэх үйл ажиллагаанд ажлын байрны зураг авалт хийж, өгөгдөл цуглуулан шинжилгээ хийсэн үр дүнг танилцуулж байна.



Зураг 4.3.24 ЗХДЗШШШ-ийн гомдол шийдвэрлэхэд зарцуулах хугацааны ажиглалтын өгөгдлийн мэдээлэл

Захиргааны хэргийн хуульд заасан маргааны төрлүүдийн ажиллагаанд зарцуулах хугацааны тухай Нийслэлийн Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгчийн ажлын байрны зураг авалтын үр дүнд цуглуулсан 18 өгөгдөлд хийсэн 2 хүчин зүйлийн дисперсийн шинжилгээний үр дүнг Зураг 4.3.24-д харуулав. Зургаас харвал Нийслэлийн шүүгч зураг дээр байгаа 9 төрлийн гомдлыг 1020-2130 минутын хугацаанд хянан шийдвэрлэдэг байна. ЗХДЗШШ-ийн гомдол шийдвэрлэх дундаж хугацаа 1558 минут байна.




Зураг 4.3.25 Давж заалдах шатны шүүхийн гомдол шийдвэрлэхэд зарцуулах хугацааны тухай ажиглалтын өгөгдөл, маргааны төрөл ба шүүгчээр




Давж заалдах шатны шүүхийн гомдол шийдвэрлэх хугацааг Захиргааны хэргийн маргааны төрөл тус бүрээр нь задалж харуулсан зургаас харвал судалгаанд хамрагдсан гомдлын төрлүүдийн хувьд шүүгч болон ерөнхий шүүгчийн ажиллагаанд зарцуулах хугацаа ижил байна. 61.1, 65.1, 111.3, 54.2 гэх мэт гомдолд бусад төрлийн гомдлыг бодвол илүү хугацаа зарцуулдаг төлөв ажиглагдсан байна.

Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь дараах хэлбэрийн ажиллагаанаас бүрдсэн бүтэцтэй судалгааны багт ирсэн.




Зураг 4.3.26 Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн гомдол шийдвэрлэх ажиллагаа

Зураг 4.3.26-аас харвал ЗХДЗШШ-ийн гомдол шийдвэрлэх ажиллагаанд зарцуулах нийт хугацааны 27% буюу 420 минутыг гомдолд хавсаргасан баримтыг уншиж танилцахад, 11% буюу 170 минутыг гомдлыг буцаах үндэслэл байгаа эсэхийг шалгасан туслахын ажиллагааг хянахад, 14.1% буюу 220 минутыг гомдлыг буцаах захирамж боловсруулах, хянах, гарын үсэг зурахад, 11% буюу 171 минутыг гомдлыг шүүх хуралдаанаар хэлэлцүүлэх тухай захирамж боловсруулах, хянах, гарын үсэг зурахад, 3.2% буюу 50 минутыг хэргийн оролцогчдод шүүх хуралдааны тов мэдэгдэх хуудсыг хянаж, гарын үсэг зурахад, 8.1% буюу 127 минутыг шүүх хуралдааны тэмдэглэл хянах, гарын үсэг зурахад, 25.7% буюу 400 минутыг тогтоол боловсруулах, хянах, гарын үсэг зурах ажиллагаанд тус тус зарцуулдаг байна.



Зураг 4.3.27 Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн гомдол шийдвэрлэх ажиллагаанд зарцуулах хугацаа, гомдлын төрлөөр


Зураг 4.3.26-д харуулсан үр дүнг ажиллагаа тус бүрээр задалж харуулбал гомдолд хавсаргасан баримтыг уншиж танилцахад 180-600 минут зарцуулдаг байна. 119.6, 123.7, гуравдагч этгээдийг оролцуулахаас татгалзсан тухай шүүгчийн захирамж, шүүхийн тогтоол зэрэг ажиллагаанд зарцуулах хугацаа хамгийн бага буюу 180 минут байна. Гомдлыг буцаах үндэслэл байгаа эсэхийг шалгасан туслахын ажиллагааг хянахад 30 ба 240 минут зарцуулдаг байна. 119.6, 123.7, гуравдагч этгээдийг оролцуулахаас татгалзсан тухай шүүгчийн захирамж, шүүхийн тогтоол зэрэг ажиллагаанд зарцуулах хугацаа хамгийн бага буюу 30 минут байна. Гомдлыг буцаах захирамж боловсруулах, хянах, гарын үсэг зурахад 200-240 минут зарцуулдаг байна.



Зураг 4.3.28 Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн гомдол шийдвэрлэх ажиллагаанд зарцуулах хугацаа, гомдлын төрлөөр



Зураг 4.3.26-д харуулсан үр дүнг ажиллагаа тус бүрээр задалж харуулбал гомдлыг шүүх хуралдаанаар хэлэлцүүлэх тухай захирамж боловсруулах, хянах, гарын үсэг зурахад 80-240 минут зарцуулдаг байна. 14.6, 32.6 зэрэг ажиллагаанд зарцуулах хугацаа хамгийн бага буюу 80 минут байна. Хэргийн оролцогчдод шүүх хуралдааны тов мэдэгдэх хуудсыг хянаж, гарын үсэг зурахад 30 ба 60 минут зарцуулдаг байна.



Зураг 4.3.29 Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн гомдол шийдвэрлэх ажиллагаанд зарцуулах хугацаа, гомдлын төрлөөр

Зураг 4.3.26-д харуулсан үр дүнг ажиллагаа тус бүрээр задалж харуулбал шүүх хуралдааны тэмдэглэл хянах, гарын үсэг зурахад 60-180 минут зарцуулдаг байна. 14.6, 32.6 зэрэг ажиллагаанд зарцуулах хугацаа хамгийн бага буюу 60 минут байна. Хэргийн тогтоол боловсруулах, хянах, гарын үсэг зурахад 240-600 минут зарцуулдаг байна.



5. Шүүгчийн ажлын ачаалал болон хэргийн коэффициент тодорхойлох шинжилгээ

Шүүхийн ерөнхий зөвлөлийн хэргийн хөдөлгөөний удирдлагын хэлтсээс гаргаж өгсөн сүүлийн 5 жилийн динамикийн өгөгдлийг ашиглан шүүгчийн хянан шийдвэрлэсэн хэргийн ачааллыг хэргийн төрөл, шүүхийн тогтолцоо зэргийг харгалзан үзэж тооцсон шинжилгээний үр дүнг энэ бүлэгт ашиглана. Энэ бүлэгт шүүгчийн ажлын байрны зураг авалт буюу ажиглалтын өгөгдөл, асуумжийн өгөгдөлд хийсэн шинжилгээний үр дүнг ашиглан шүүгчийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны ачааллыг бодитой тодорхойлохыг зорьсон болно. Ингэхдээ АЭХАШШ, нийслэлийн болон захын дүүргийн ЭХАШШ-ийн шүүгч эрүү, зөрчлийн хэрэг дээр, СДШ-ийн шүүгч эрүү, зөрчил, иргэний хэрэг дээр, АДЗШШ-ийн шүүгч эрүү, зөрчил, иргэний хэрэг дээр ажилладаг онцлогийг харгалзан үзсэний үндсэн дээр хэргийн коэффициентийг баталгаажуулах тооцоо хийв. Эрүү, зөрчил, иргэн, захиргааны хэргийн улсын дундаж коэффициентийг шүүгчийн ажлын ачааллын онцлогтой уялдуулан уян хатан үзүүлэлт болж чадах эсэхийг дүгнэж, зохистой коэффициентийг тодорхойлох саналыг энэ бүлэгт дэвшүүлнэ.

Мөн “ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛИЙН 2022 ОНЫ 58 ДУГААР ТОГТООЛООР БАТЛАГДСАН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТЭД ХАМААРАХ ӨГӨГДӨЛД ХИЙСЭН СУУРЬ СУДАЛГАА” сэдэвт судалгааны ажлын шинжилгээний бас нэг үр дүн болох 1 эрүүгийн хэрэг=10.2 зөрчлийн хэрэг, 1 эрүүгийн хэрэг=2.4 иргэний хэрэг гэсэн тооцоо гарсан. Энэ тооцоог дээр дурдсан өгөгдлүүдийн шинжилгээний үр дүн буюу ажиллагааны ачаалалд зарцуулах хугацаагаар нь харьцуулан үзэж дүгнэх зорилгоор энэ бүлгийн шинжилгээнүүд хийгдэнэ. Энэ бүлэгт тооцоо хийхэд ашигласан зарим коэффициентийн тайлбарыг оруулъя.

Ажлын өдрийн тайлбар: Нэг жилийн 365 хоногийн 52 долоо хоногийн 104 өдөр амралтын өдөр, 15 өдөр баяр наадам, улс нийтээр амрах өдөр, ажлын 20 хоног нь дунджаар нэг шүүгчийн ээлжийн амралтын өдөр гэж үзвэл $365-104-15-20=226$ өдрийг нэг жилийн ажлын өдөр гэж үзнэ.

5.1 Эрүүгийн хэргийн шүүгчийн ажиллагаанд зарцуулах хугацаа тооцох коэффициентийн шинжилгээ

Шүүхийн ерөнхий зөвлөлийн хэргийн хөдөлгөөний удирдлагын хэлтэс 2017-2021 онд хянан шийдвэрлэсэн эрүүгийн хэргийн тоог шүүхийн тогтолцоогоор гаргаж судалгааны багт ирүүлсэн. Шүүгчийн ажлын ачаалал тооцох, хэргийн коэффициент тодорхойлох өмнөх судалгаа шүүхийн тогтолцоо тус бүрээр хийгдсэний дараа улсын дундаж тоог баримтлан шүүгчийн ажлын ачаалал тодорхойлж байсан. Өмнөх судалгааны ажлын зарчмыг энэ судалгааны ажилд мөн адил баримтлан шүүхийн тогтолцоо тус бүрээр тооцоо хийсэн.

№	Шүүх	Хялбаршуулсан					Ердийн				
		2017	2018	2019	2020	2021	2017	2018	2019	2020	2021
1	Төвийн	698	2181	2304	2149	1949	2795	4190	4828	4956	4095
2	Захын	73	202	94	110	79	159	168	186	253	228
3	Аймаг	1014	2306	1920	1849	1842	3335	2695	3225	3363	3168
4	Сум дунд	139	340	345	301	360	626	469	525	489	347

Хүснэгт 5.1.1 Эрүүгийн хянан шийдвэрлэсэн хэргийн тоо

Эх сурвалж: ШЕЗ-ийн хэргийн хөдөлгөөний удирдлагын хэлтэс

Хүснэгт 5.1.1-ийн өгөгдлийг хэрэг хянан шийдвэрлэх журмын хувьд эрүүгийн хэргийн тооны харьцааг тодорхойлоход ашигласан бөгөөд хялбаршуулсан ба ердийн журмаар хянан шийдвэрлэсэн хэргийн тооны харьцааг дараах зургаас харна уу.



ХЭРГИЙН КОЭФФИЦИЕНТ ТООЦОХ ШИНЖИЛГЭЭ



Зураг 5.1.1 Ердийн ба хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэсэн хэргийн тооны харьцаа

Зураг 5.1.1-ээс харвал 2017 онд төвийн дүүргийн эрүүгийн хэргийн шүүгч (4:1 харьцаатай) 4 ердийн журмын хэрэг тутамд 1 хялбаршуулсан журмын хэрэг хянан шийдвэрлэсэн гэсэн үг юм. 2017 онд шүүхийн тогтолцоо (төв ба захын дүүрэг, аймаг, сум дундын шүүх) бүрд хялбаршуулсан журам ба ердийн журмаар хянан шийдвэрлэсэн хэргийн харьцаа бусад оныг бодвол өндөр байсан байна. 2018 оноос 2021 он хүртэлх хэрэг хянан шийдвэрлэх журмын өгөгдлийн харьцаа харьцангуй тогтвортой болсон шинж ажиглагдаж байна. Энэ нь эрүүгийн хэргийн хууль, дүрэм журам өөрчлөгдөн, шинэчлэгдсэнтэй холбоотой байж магадгүй юм. Иймд дээрх зургийн 2-р зурагт шүүхийн тогтолцоо тус бүрийн дундаж утгыг 2018-2021 оны хэрэг хянан шийдвэрлэх журмын өгөгдлийн харьцаагаар илэрхийлэв. Зураг 5.1.1-ийн хоёрдугаар зургийн төвийн дүүрэг 2.1 гэсэн утгыг тайлбарлая. Төвийн дүүргийн эрүүгийн хэргийн шүүгчийн сүүлийн 5 жилийн дунджаар хянан шийдвэрлэсэн хэргийн тоог (2.1:1 харьцаа) 3.1-д хувааж тооцохдоо 2.1 ердийн журмын хэрэг тутамд 1 хялбаршуулсан журмын хэрэг хянан шийдвэрлэсэн гэж үзэж тооцоо хийнэ. Бусад шүүхийн тогтолцоо тус бүрийн хувьд энэ тайлбартай адил утгаар ойлгоно.

• Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн ажиллагаа

Энэ судалгааны ажлын 1-р бүлэгт тооцсон ЭХАШШШ-ийн шинжилгээний ерөнхий үр дүнг энэ бүлэгт нэгтгэж дурдъя. ШЕЗ-ийн судалгааны баг шүүгчийн ажлаа хийх явцад хийгддэг ажиллагааны ачааллыг бодитой тодорхойлохын тулд шүүгчээс асуумж авах, шүүгчийн ажлын байрны ажиглалт явуулах зэрэг үйл ажиллагааны хүрээнд цуглуулсан өгөгдөлд шинжилгээ хийж, ерөнхий үр дүнг дараах хүснэгтэд харуулав.

№	Шүүхийн тогтолцоо	Асуумж		Ажиглалт	
		Ердийн	Хялбаршуулсан	Ердийн	Хялбаршуулсан
1	Төвийн дүүрэг	7312	475	1363	259
2	Захын дүүрэг	2127	532	1693	514
3	Аймаг	5852	493	-	-
4	Сум дунд	6306	638	-	-
	Дүн	-	534	1528	387

Хүснэгт 5.1.2 ЭХАШШШ-ийн хэрэг хянан шийдвэрлэхэд шаардагдах хугацаа, минутаар

Тодорхойлолт 1: ЭХАШШШ-ийн хэргийг ердийн журмаар хянан шийдвэрлэхэд зарцуулах ажиллагааны хугацааг 1528 минут, хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэхэд зарцуулах ажиллагааны хугацааг $(534+387):2=460.5$ минут байхыг улсын дундаж стандарт гэж үзнэ.

Хүснэгт 5.1.2-д асуумж ба ажиглалтын утгын өгөгдлийн шинжилгээний үр дүнг харуулав. Эрүүгийн хэргийг ердийн ба хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэхэд шаардагдах хугацааг шүүгчид өөрсдийн ажлын туршлага, баримжааг үндэслэн үзэл бодол, саналаа чөлөөтэй илэрхийлэх боломжоор хангах үүднээс асуумж явуулсан. Харамсалтайн хэт өндөр савлагаа ихтэй дүн тавьж явуулсан шүүхүүдийн асуумжийн өгөгдлийн утгыг хасаж (программын үр дүнгээр), олонхын саналтай нийцэхүйц судалгааны өгөгдлийг шинжилгээнд ашигласан ч ажиглалтын өгөгдлөөс хэд дахин өндөр хугацаа орж ирсэн тул ердийн журмын бүх асуумжийн өгөгдөл судалгаанаас хасагдав. Зургаас харвал хялбаршуулсан журмын хувьд ажиглалтын утга, асуумжийн



утгаас 1.3 дахин бага байсан ч хол зөрүүтэй биш, үнэний хувьтай байх магадлалтай утга тул хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд зарцуулах хугацааг ажиглалт ба асуумжийн дундаж утгаар тооцож судалгаанд ашиглав.

Ердийн журмаар хянан шийдвэрлэх үйл ажиллагааны асуумжийн утгыг судалгаанаас хассан шалтгааныг жишээ авч тайлбарлая. Төвийн дүүргийн эрүүгийн хэргийн шүүгч нэг хэргийн хянан шийдвэрлэхэд ажиглалтын утгаар 1363 минут байхад асуумжийн утгаар 7312 минут зарцуулна гэсэн нь 5.4 дахин их хугацаа байхаар судалгаанд орж ирэв. Хэрэв 7312 минут зарцуулдаг гэж үзвэл $7312 \times 88 = 643456$ ердийн журмаар хянан шийдвэрлэхэд шаардагдах хугацаа, $367 \times 44 = 16148$ хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэхэд шаардагдах хугацаа, $643456 + 16148 = 659604$ минут нэг жилд, $659604 : 60 = 10993$ цаг, $10993 : 226 = 49$ цаг буюу хоногийн 24 цагийн 49 цагт ажилладаг гэсэн хэт зөрүүтэй дүгнэлтэд хүрэхээр байна.

Хүснэгт 5.1.3-д “ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛИЙН 2022 ОНЫ 58 ДУГААР ТОГТООЛООР БАТЛАГДСАН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТЭД ХАМААРАХ ӨГӨГДӨЛД ХИЙСЭН СУУРЬ СУДАЛГАА” сэдэвт судалгааны ажлын үр дүнгээс харуулав. Энэ үр дүнг Хүснэгт 5.1.4-д ашиглан шүүгчийн ажлын ачааллыг тооцов.

№	Шүүхийн тогтолцоо	Эрүү	Зөрчил	Иргэн
1	Төвийн дүүрэг	136	-	-
2	Захын дүүрэг	44	58	-
3	Аймаг	79	143	-
4	Сум дунд	28	71	105

Хүснэгт 5.1.3 Нэг шүүгчид нэг жилд ногдох хянан шийдвэрлэсэн хэргийн тоо

Эх сурвалж: ШЕЗ-ийн захиалгат судалгааны ажлын тайлан

Шүүхийн тогтолцоо	Хэргийн харьцаа	Хэрэг хянан шийдвэрлэх хугацаа /минут/			Шүүгчийн ажлын ачаалал /цаг/
		Хялбаршуулсан	Ердийн	Нийт ажиллагаа	
Төвийн дүүрэг	136:3.1=44	$460 \times 44 = 20240$	$1528 \times 92 = 140576$	$20240 + 140576 = 160816$	$160816 : 60 = 2680$
Захын дүүрэг	44:3=14.7	$460 \times 14.7 = 6762$	$1528 \times 29.3 = 44770$	$6762 + 44770 = 51532$	$51532 : 60 = 859$
Аймаг	79:2.6=30.4	$460 \times 30.4 = 13984$	$1528 \times 48.6 = 74261$	$13984 + 74261 = 88245$	$88245 : 60 = 1471$
Сум дунд	28:2.4=11.7	$460 \times 11.7 = 5382$	$1528 \times 16.3 = 24906$	$5382 + 24906 = 30288$	$30288 : 60 = 505$
				30289	$505 : 226 = 2.2$ /өдөрт/

Хүснэгт 5.1.4 ЭХАШШ-ийн Шүүгчийн ажлын ачаалал

Хэрэг хянан шийдвэрлэх журмын харьцаа гэдэгт шүүхийн тогтолцоо тус бүрээр ЭХАШШ-ийн шүүгчийн хянан шийдвэрлэсэн хэргийн тоо (Хүснэгт 5.1.3-ийн эрүү гэсэн баганын утга)-г Зураг 5.1.1-ийн 2-р зургийн коэффициент дээр 1-ийг нэмж хуваасан харьцааг ойлгоно.

Хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх хугацаа гэдэгт шүүхийн тогтолцоо тус бүрээр *Хэрэг хянан шийдвэрлэх журмын харьцааг* Тодорхойлолт 1-ийн 460 гэсэн коэффициентоор үржүүлсэн тоог ойлгоно.

Ердийн журмаар хэрэг хянан шийдвэрлэх хугацаа гэдэгт шүүхийн тогтолцоо тус бүрээр ЭХАШШ-ийн шүүгчийн хянан шийдвэрлэсэн хэргийн тоо (Хүснэгт 5.1.3-ийн эрүү гэсэн баганын утга)-ноос *Хэрэг хянан шийдвэрлэх журмын харьцааг* хассан ялгавраас Тодорхойлолт 1-ийн 1528 гэсэн коэффициентоор үржүүлсэн тоог ойлгоно.

Нийт ажиллагаанд шаардагдах хугацаа гэдэгт шүүхийн тогтолцоо тус бүрээр хэрэг хянан шийдвэрлэх журмын хугацаа тус бүрийн утгын нийлбэрийг ойлгоно.

Шүүгчийн ажлын ачаалал гэдэгт шүүхийн тогтолцоо тус бүрээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд шаардагдах хугацааг 60-д хувааж цагаар илэрхийлэх, 226-д хувааж өдөрт ажиллах хугацааг цагаар илэрхийлсэн утгыг ойлгоно.

Жишээ болгож төвийн дүүргийн шүүгчийн ажлын ачааллыг тооцсон мөрийн утгыг тайлбарлая. Хүснэгт 5.1.3-ийн төвийн дүүргийн шүүгчийн эрүүгийн хэрэг хянан



шийдвэрлэсэн 136 гэсэн утгыг $136:(2.1+1)=44$ гэж олсон нь 136 хэргийн 44 хэргийг хялбаршуулсан журмаар, үлдсэн хэргийг буюу $136-44=92$ хэргийг ердийн журмаар шийдвэрлэсэн гэсэн үг юм. Тодорхойлолтын утгыг $460 \times 44=20240$, $1528 \times 92=140576$ гэж хэргийн тоо тус бүрээр үржүүлж ажиллагаанд зарцуулах хугацаа тус бүрийн утгын олно. Ажиллагаа тус бүрийн нийлбэрийг 60-д хувааж $160376:60=2673$ цаг, ажлын 226 өдөрт хувааж $2673:226=11.8$ цаг гарна. Энэ нь төвийн дүүргийн ЭХАШШ-ийн шүүгч жилийн турш ажлын өдөр 11.8 цаг тасралтгүй хэргийн ажиллагааны ачаалалтай ажилладаг гэсэн үг юм. Хүснэгт 5.1.4-ийн үр дүнд гүйцэт дүгнэлт өгөх боломжгүй. Учир нь аймгийн ЭХАШШ, СДШ, захын ДШ-ийн шүүгчид зөрчил болон иргэний хэрэг дээр давхар ажилладаг онцлогтой тул зөрчил ба иргэний хэргийн шүүгчийн ажиллагааны ачаалал бүрэн тооцогдсоны дараа тодорхойлж харьцуулалт хийх боломжтой болно.

• **Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгчийн ажиллагаа**

Энэ судалгааны ажлын 1-р бүлэгт тооцсон ЭХДЗШШ-ийн шинжилгээний ерөнхий үр дүнг энэ бүлэгт ашиглая.

№	Шүүхийн тогтолцоо	Асуумж	Ажиглалт
1	Нийслэл	35648	858
2	Аймаг, Дархан-Уул	3292	1369

Хүснэгт 5.1.5 ЭХДЗШШ-ийн хэрэг хянан шийдвэрлэхэд шаардагдах хугацаа, минутаар

Тодорхойлолт 2: ЭХДЗШШ-ийн хэрэг хянан шийдвэрлэхэд зарцуулах ажиллагааны хугацааг $(3292+858+1369):3=1840$ минут байхыг улсын дундаж стандарт гэж үзнэ.

Хүснэгт 5.1.5-д ЭХДЗШШ-ийн шүүгчийн өгсөн асуумж ба ажиглалтын утгын өгөгдлийн шинжилгээний үр дүнг харуулав. Хэрэг хянан шийдвэрлэхэд шаардагдах хугацааг тодорхойлохдоо ЭХДЗШШ-ийн шүүгчид өөрсдийн ажлын туршлага, баримжааг үндэслэн үзэл бодол, саналаа чөлөөтэй илэрхийлэх боломжоор хангах үүднээс асуумж явуулсан. Харамсалтайн хэт өндөр савлагаа ихтэй дүн тавьж явуулсан тул НЭХДЗШШ-ийн асуумжийн өгөгдлийн утгыг хасав (программын үр дүнгээр). Жишээ авч дурдвал өмнөх бүлэгт тайлбарласантай адил хоногийн 24 цагийн 30 цагт ажилладаг хэмжээний дүн гарахаар байгаа тул тайлбарыг товчилъё. Аймаг ба нийслэлийн ЭХДЗШШ-ийн ажиглалтын утгыг хэрэг хянан шийдвэрлэх хугацааны утгаар тооцсон үр дүнг харуулъя.

№	Шүүхийн тогтолцоо	Эрүү	Зөрчил	Иргэн
1	Нийслэл	69	11	-
2	Орхон, Дархан-Уул	25	6	-

Хүснэгт 5.1.4 ЭХДЗШШ-ийн нэг шүүгчид ногдох хянан шийдвэрлэсэн хэргийн тоо

Эх сурвалж: ШЕЗ-ийн захиалгат судалгааны ажлын тайлан

Хүснэгт 5.1.5-ийн үр дүнг Хүснэгт 5.1.6-д ашиглан ЭХДЗШШ-ийн шүүгчийн ажлын ачааллыг тооцов.

№	Шүүхийн тогтолцоо	Хэрэг хянан шийдвэрлэх хугацаа, минутаар	Шүүгчийн ажлын ачаалал, цагаар жилд	Шүүгчийн ажлын ачаалал, цагаар өдөрт
1	Нийслэл	$1840 \times 69=126960$	$126960:60=2116$	$2116:226=9.4$
2	Аймаг, Дархан-Уул	$1840 \times 25=46000$	$46000:60=767$	$767:226=3.4$

Хүснэгт 5.1.5 ЭХДЗШШ-ийн Шүүгчийн ажлын ачаалал

Хүснэгт 5.1.7-оос харвал аймгийн ЭХДЗШШ-ийн шүүгч өдөрт ажлын ажиллагаанд 3.4 цаг зарцуулдаг байхад нийслэлийн ЭХДЗШШ-ийн шүүгч өдөрт ажлын ажиллагаанд 9.4 цаг зарцуулдаг байна. Нийслэлийн болон аймгийн ЭХДЗШШ-ийн Шүүгчийн ажлын ачаалал зөрчлийн хэргийн ажиллагаанд зарцуулах тооцогдсоны дараа тодорхой болно.



5.2 Зөрчлийн хэрэг хянан шийдвэрлэсэн шүүгчийн ажлын ачаалал тооцох коэффициентийн шинжилгээ

• Зөрчлийн хэрэг хянан шийдвэрлэсэн шүүгчийн ажиллагаа

Энэ судалгааны ажлын 2-р бүлэгт тооцсон ЭХАШШШ-ийн зөрчлийн хэргийн шинжилгээний ерөнхий үр дүнг энэ бүлэгт ашиглана. ШЕЗ-ийн судалгааны баг шүүгчийн ажлын явцад хийгддэг ажиллагааны ачааллыг бодитой тодорхойлохын тулд шүүгчээс асуумж авах, шүүгчийн ажлын байрны ажиглалт явуулах зэрэг үйл ажиллагааны хүрээнд цуглуулсан өгөгдөлд шинжилгээ хийсэн ерөнхий үр дүнг дараах хүснэгтэд харуулав.

	Шүүхийн тогтолцоо	Асуумж	Ажиглалт
1	Төвийн дүүрэг	197	194
2	Захын дүүрэг	256	196
3	Аймаг	1120	-
4	Сум дунд	1638	-
	Дүн	197	195

Хүснэгт 5.2.1 ЭХАШШШ-ийн зөрчлийн хэрэг хянан шийдвэрлэхэд шаардагдах хугацаа, минутаар

Тодорхойлолт 3: ЭХАШШШ-ийн зөрчлийн хэргийг хянан шийдвэрлэхэд шаардагдах хугацааг $(197+195):2=196$ минут байхыг улсын дундаж стандарт гэж үзнэ.

Хүснэгт 5.2.1-д ЭХАШШШ-ийн шүүгчийн өгсөн асуумж ба ажиглалтын утгын өгөгдлийн шинжилгээний үр дүнг харуулав. Зөрчлийн хэрэг хянан шийдвэрлэхэд шаардагдах хугацааг тодорхойлохдоо АШШ-ийн шүүгчид өөрсдийн ажлын туршлага, хийгдэх ажлын баримжааг үндэслэн үзэл бодол, саналаа чөлөөтэй илэрхийлэх боломжоор хангах үүднээс асуумж явуулсан. Гэвч хэт өндөр савлагаа ихтэй дүн тавьж явуулсан аймаг, сум дундын ШШ-ийн асуумжийн өгөгдлийн утгыг цаашид судалгаанд ашиглах боломжгүй тул шинжилгээнээс хасав (программын үр дүнгээр). Төвийн дүүргийн АШШ-ийн ажиглалтын утгыг ашиглан зөрчлийн хэрэг хянан шийдвэрлэх хугацааг тооцсон үр дүнг харуулъя.

№	Шүүхийн тогтолцоо	Эрүү	Зөрчил	Иргэн
1	Төвийн дүүрэг	136	-	-
2	Төвийн дүүрэг	-	1390	-
3	Захын дүүрэг	44	58	-
4	Аймаг	79	143	-
5	Сум дунд	28	71	105

Хүснэгт 5.2.2 Нэг шүүгчид ногдох хянан шийдвэрлэсэн хэргийн тоо

Эх сурвалж: ШЕЗ-ийн захиалгат судалгааны ажлын тайлан

Хүснэгт 5.2.2-ын үр дүнг ашиглан Хүснэгт 5.2.3-д шүүгчийн ажлын ачааллыг тооцож харуулав.

№	Шүүхийн тогтолцоо	Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд шаардагдах хугацаа, минутаар	Шүүгчийн ажлын ачаалал, цагаар жилд	Шүүгчийн ажлын ачаалал, цагаар өдөрт
1	Төвийн дүүрэг	$1390 \times 196 = 272440$	$272440:60 = 4541$	$4541:226 = 20$
2	Захын дүүрэг	$58 \times 196 = 11368$	$11368:60 = 189$	$189:226 = 0.8$
3	Аймаг	$143 \times 196 = 28028$	$28028:60 = 467$	$467:226 = 2.1$
4	Сум дунд	$71 \times 196 = 13916$	$13916:60 = 232$	$232:226 = 1$

Хүснэгт 5.2.3 Зөрчлийн хэргийг хянан шийдвэрлэсэн Шүүгчийн ажлын ачаалал

Хүснэгт 5.2.3-аас харвал ЭХАШШШ-ийн зөрчлийн хэрэг хянан шийдвэрлэх ажлын ачаалал төвийн дүүрэгт анхаарал татах өндөр хэмжээнд ирснийг харуулж байна. Төвийн дүүргийн зөрчлийн хэргийн шүүгч нэг жилийн ажлын 226 өдөрт ажиллахад хоногт 20 цаг ажилладаг гэсэн тооцоо гарч байна. Эндээс зөрчлийн хэргийн шүүгч амралтын өдөр болон бүх нийтээр тэмдэглэн өнгөрүүлдэг амралтын өдөр ч гэсэн



ажилладаг гэсэн таамаглал дэвшүүлэхээр байна. Өдөрт 15 цаг ажиллахад жилд 302 өдөр ажиллаж байж энэ ачааллыг давах дүр зураг ажиглагдаж байна. Захын дүүргийн шүүгч зөрчлийн хэрэг дээр өдөрт 0.8 цаг, аймгийн шүүхийн шүүгч 2.1 цаг, сум дундын шүүхийн шүүгч 1 цаг ажилладаг гэсэн тооцоо гарч байна.

- **Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн зөрчлийн хэрэг дээр ажиллах шүүгчийн ажиллагааны ачаалал**

Энэ судалгааны ажлын 2-р бүлэгт тооцсон ЭХДЗШШ-ийн зөрчлийн хэргийн шинжилгээний ерөнхий үр дүнг энэ бүлэгт нэгтгэж дурдъя.

№	Шүүхийн тогтолцоо	Асуумж	Ажиглалт	Дундаж
1	Нийслэл	-	192	192
2	Дархан-Уул	1505	1276	1390

Хүснэгт 5.2.4 ЭХДЗШШ-ийн зөрчлийн хэрэг хянан шийдвэрлэхэд шаардагдах хугацаа, минутаар

Тодорхойлолт 4: ЭХДЗШШ-ийн зөрчлийн хэргийг хянан шийдвэрлэхэд шаардагдах хугацааг $(192+1390):2=791$ минут байхыг улсын дундаж стандарт гэж үзнэ.

Хүснэгт 5.2.4-д ЭХДЗШШ-ийн шүүгчийн зөрчлийн хэрэг хянан шийдвэрлэхэд шаардагдах хугацааны тухай өгсөн асуумж ба ажиглалтын утгын өгөгдлийн шинжилгээний үр дүнг харуулав. Дархан-Уул аймгийн шүүхээс авсан асуумж ба ажиглалтын утга ойролцоо хугацааны тухай мэдээлэл өгч байгаа тул шинжилгээнд цааш нь ашиглав. Зөрчлийн хэрэг хянан шийдвэрлэхэд зарцуулах хугацааны Дархан-Уул аймгийн ЭХДЗШШ-ийн ажиглалтын утга нийслэлийн ЭХДЗШШ-ийн ажиглалтын утгаас 6.6 дахин их дүнтэй шинжилгээнд орсон байна. Энэ нь ажиглалт явуулсан хоёр шүүхийн өгөгдлийг сайн нягталж шалгасны дараа шинжилгээнд оруулсан эсэх нь эргэлзээтэй байна. Энэ өгөгдлийн тухай асуулт, тодруулга гарвал хариуцаж шинжилгээ хийсэн ШЕЗ-ийн ажилтанд хандана уу. Шинжилгээ хийхэд өгөгдөл эргэлзээтэй ч гэсэн судалгааг шинжилгээнд оруулсан утгаар нь оруулж тооцоог цааш үргэлжлүүлэв.

№	Шүүхийн тогтолцоо	Эрүү	Зөрчил	Иргэн
1	Нийслэл	69	11	-
2	Орхон, Дархан-Уул	25	6	-

Хүснэгт 5.2.5 ЭХДЗШШ-ийн нэг шүүгчид ногдох хянан шийдвэрлэсэн хэргийн тоо

Эх сурвалж: ШЕЗ-ийн захиалгат судалгааны ажлын тайлан

Хүснэгт 5.2.5-ын үр дүнг ашиглан Хүснэгт 5.2.6-д ЭХДЗШШ-ийн шүүгчийн ажлын ачааллыг тооцож харуулав.

№	Шүүхийн тогтолцоо	Хэрэг хянан шийдвэрлэх хугацаа, минутаар	Шүүгчийн ажлын ачаалал, цагаар	Шүүгчийн ажлын ачаалал, цагаар өдөрт	ЭХДЗШШ-ийн ачаалал
1	Нийслэл	$791 \times 11 = 8701$	$8701:60 = 145$	$145:226 = 0.6$	$9.4 + 0.6 = 10$
2	Дархан-Уул	$791 \times 6 = 4746$	$4746:60 = 79$	$79:226 = 0.4$	$3.4 + 0.4 = 3.8$

Хүснэгт 5.2.6 ЭХДЗШШ-ийн Шүүгчийн ажлын ачаалал

Хүснэгт 5.2.6-аас харвал Дархан-Уул аймгийн ЭХДЗШШ-ийн шүүгч өдөрт зөрчлийн хэргийн ажлын ажиллагаанд 0.4 цаг, эрүү ба зөрчлийн хэргийн нийлбэр ажиллагаанд 3.8 цаг зарцуулдаг байхад нийслэлийн ЭХДЗШШ-ийн шүүгч өдөрт зөрчлийн хэргийн ажлын ажиллагаанд 0.6 цаг, эрүү ба зөрчлийн хэргийн нийлбэр ажиллагаанд 10 цаг зарцуулдаг байна. Дархан-Уул аймгийн ЭХДЗШШ-ийн Шүүгчийн ажлын ачаалал ажлын 8 цагийн ачааллаас доогуур байхад НЭХДЗШШ-ийн шүүгчийн ажлын ачаалал өдөрт 2 цаг илүү байдаг байна.



5.3 Иргэний хэргийн шүүгчийн ажлын ачаалал тооцох коэффициентийн шинжилгээ

Шүүхийн ерөнхий зөвлөлийн хэргийн хөдөлгөөний удирдлагын хэлтсээс 2017-2021 онд хянан шийдвэрлэсэн иргэний хэргийн тоог шүүхийн тогтолцоогоор гаргаж судалгааны багт ирүүлсэн. Шүүгчийн ажлын ачаалал тооцох, хэргийн коэффициент тодорхойлох өмнөх судалгаа шүүхийн тогтолцоо тус бүрээр хийгдсэний дараа улсын дундаж тодорхойлсон байсан тул өмнөх судалгааны ажлын зарчимтай ижил аргаар явуулна.

№ Шүүх	Хялбаршуулсан					Ердийн					Хэрэгсэхгүй болгосон				
	2017	2018	2019	2020	2021	2017	2018	2019	2020	2021	2017	2018	2019	2020	2021
1 Төвийн	7331	7425	6300	8451	9326	12075	11818	12027	12230	10736	5233	5862	5007	5785	5611
2 Захын	545	398	589	786	624	385	400	468	448	355	40	56	41	100	94
3 Аймаг	4903	4070	4123	5330	4964	11853	14717	11710	15968	10127	635	811	896	1304	1317
4 Сум дунд	833	623	705	1171	905	1346	1912	1465	2005	1333	54	63	66	100	52
Дүн	13612	12516	11717	15738	15819	25659	28847	25670	30651	22551	5962	6792	6010	7289	7074

Хүснэгт 5.3.1 Иргэний хянан шийдвэрлэсэн хэргийн тоо

Эх сурвалж: ШЕЗ-ийн хэргийн хөдөлгөөний удирдлагын хэлтэс

ИХАШШШ-ийн нийт хянан шийдвэрлэсэн хэргийн тоог хэрэг хянан шийдвэрлэх журам, хэрэгсэхгүй болгосон хэргийн дүнгийн нийлбэрээр тооцогдсон тул дээрх хүснэгтэд задгайгаар харуулав. Дараагийн тооцоонд хэрэгсэхгүй болгосон хэргийн ажиллагаанд зарцуулсан хугацааг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэсэн хэргийн ажиллагаатай адил коэффициентээр тооцох тул Хүснэгт 5.3.1 нь иргэний хэргийн коэффициентийн харьцааг тодорхойлох үүрэг гүйцэтгэнэ.

№ Шүүх	2017	2018	2019	2020	2021	Дүн
1 Төвийн	12318	12439	10735	14031	14299	51%
2 Захын	672	488	685	888	751	65%
3 Аймаг	5439	4584	5244	6115	6219	30%
4 Сум дунд	762	678	769	1243	959	35%
Дүн	19191	18189	17433	22277	22228	42%

Хүснэгт 5.3.2 Бага үнийн дүнтэй хэргийн тоо

Эх сурвалж: ШЕЗ-ийн хэргийн хөдөлгөөний удирдлагын хэлтэс

ИХАШШШ-ийн ажлын ачаалал нь бусад хэргээс бага үнийн дүнтэй хэрэг гэж задардаг онцлогтой тул энэ үзүүлэлтийг нэмж оруулав. Иргэний хянан шийдвэрлэсэн хэргийн тоонд бага үнийн дүнтэй хэргийн эзлэх хувь томоохон байр суурийг эзэлж байгаа тул энэ үзүүлэлтийг зайлшгүй оруулж тооцоо хийх нь иргэний хэрэг хянан шийдвэрлэдэг шүүгчийн ачаалал зөв тооцогдох суурийг бүрдүүлнэ.

Хүснэгт 5.3.1, 5.3.2-ын утгыг ашиглан бүтцийн шинжилгээ хийж иргэний хянан шийдвэрлэсэн нийт хэргийн дүнд бага үнийн дүнтэй хэргийн хялбаршуулсан ба ердийн журмаар шийдвэрлэсэн хэрэг, хэрэгсэхгүй болгосон хэргийн эзлэх тоог шүүхийн тогтолцоо тус бүрээр тооцож Хүснэгт 5.3.3-д харуулав.


Шүүх	Хялбаршуулсан					Ердийн					Хэрэгсэхгүй болгосон				
	2017	2018	2019	2020	2021	2017	2018	2019	2020	2021	2017	2018	2019	2020	2021
Төвийн	3665	3679	2898	4480	5194	6037	5856	5533	6484	5980	2616	2904	2304	3067	3125
Захын	378	227	367	523	437	267	229	292	298	248	28	32	26	67	66
Аймаг	1533	952	1292	1442	1881	3707	3442	3671	4320	3838	199	190	281	353	499
Сум дунд	284	163	242	444	379	459	499	504	761	558	18	16	23	38	22
Дүн	5775	4728	4707	6531	7738	10886	10896	10312	12721	11030	2529	2565	2414	3025	3460

Хүснэгт 5.3.3 Хянан шийдвэрлэсэн бага үнийн дүнтэй хэрэг

Хүснэгт 5.3.1, 5.3.2, 5.3.3-ын утгыг ашиглан иргэний хянан шийдвэрлэсэн нийт хэргийн дүнд бага үнийн дүн, хялбаршуулсан ба ердийн журмаар шийдвэрлэсэн хэрэг,



хэрэгсэхгүй болгосон хэргийн эзлэх хувийг шүүхийн тогтолцоо тус бүрээр тооцож Зураг 5.3.1-д харуулав.



Зураг 5.3.1 Хянан шийдвэрлэсэн иргэний хэргийн тооны харьцаа, хувиар

Зураг 5.3.1-ээс харвал төвийн дүүргийн хянан шийдвэрлэсэн иргэний хэргийн тооны 40%-ийг, захын дүүргийн хянан шийдвэрлэсэн иргэний хэргийн тооны 61%-ийг, аймгийн ИХАШШ-д хянан шийдвэрлэсэн иргэний хэргийн тооны 29%-ийг, сум дундын шүүхийн хянан шийдвэрлэсэн иргэний хэргийн тооны 34%-ийг бага үнийн дүнтэй хэргийн тоо тус тус эзэлдэг онцлогтой байна. Зураг 5.3.1-ийн 2-р зургийн хувьд улсын дундаж дүнгээр ИХШ-д хянан шийдвэрлэсэн иргэний хэргийн тооны 36%-ийг бага үнийн дүнтэй хэрэг, 17%-ийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэсэн хэрэг, 33%-ийг ердийн журмаар хянан шийдвэрлэсэн хэрэг, 14%-ийг хянан шийдвэрлээд хэрэгсэхгүй болгосон хэрэг тус тус эзэлдэг байна.

• **Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн ажиллагаа**

Энэ судалгааны ажлын 3-р бүлэгт тооцсон ИХАШШ-ийн шинжилгээний ерөнхий үр дүнг энэ бүлэгт нэгтгэж дурдъя. ШЕЗ-ийн судалгааны баг шүүгчийн ажлын явцад хийгддэг ажиллагааны ачааллыг бодитой тодорхойлохын тулд шүүгчээс асуумж авах, шүүгчийн ажлын байрны ажиглалт явуулах зэрэг үйл ажиллагааны хүрээнд цуглуулсан өгөгдөлд шинжилгээ хийсэн ерөнхий үр дүнг дараах хүснэгтэд харуулав.

№	Шүүхийн тогтолцоо	Асуумж			Ажиглалт		
		Ердийн	Хялбаршуулсан	Бага үнэ	Ердийн	Хялбаршуулсан	Бага үнэ
1	Төвийн дүүрэг	1071	455	1082	1177	447	556
2	Захын дүүрэг	1280	-	1050	964	388	635
3	Аймаг	1229	745	1440	-	-	-
4	Сум дунд	798	573	1248	-	-	-
	Дүн	934	-	1205	964	388	595

Хүснэгт 5.3.4 ИХАШШ-ийн хэрэг хянан шийдвэрлэхэд шаардагдах хугацаа, минутар

Тодорхойлолт 5: ИХАШШ-ийн хэргийг ердийн журмаар хянан шийдвэрлэхэд шаардагдах хугацааг $(934+964):2=949$ минут, хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэхэд зарцуулах хугацааг 388 минут, бага үнийн дүнтэй хэрэг хянан шийдвэрлэхэд зарцуулах хугацааг $(556+635):2=596$ минут байхыг улсын дундаж стандарт гэж үзнэ.

Хүснэгт 5.3.4-д асуумж ба ажиглалтын утгын өгөгдлийн шинжилгээний үр дүнг харуулав. Иргэний хэргийг ердийн ба хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэхэд шаардагдах хугацааг шүүгчид өөрсдийн ажлын туршлага, ажиллагааны баримжааг үндэслэн санал бодлоо чөлөөтэй илэрхийлэх боломжоор хангах үүднээс асуумж явуулсан. Ердийн журмаар хэрэг хянан шийдвэрлэх хугацааны тухай төвийн дүүрэг ба захын дүүргийн шүүхээс ирүүлсэн өгөгдлийг судалгаанд ашиглахаар үлдээж бусад өгөгдлийг судалгаанаас хасав. Хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэхэд шаардлагатай хугацааны тухай бүх шүүхээс ирүүлсэн асуумжийн өгөгдлийг судалгааны шаардлага хангахгүй байгаа тул дараагийн тооцооноос хасав. Бага үнийн дүнтэй хэргийн асуумжийн өгөгдөл судалгааны ажлын шаардлага хангахгүй байгаа тул зөвхөн ажиглалтын өгөгдлийг цаашид тооцоонд ашиглахаар үлдээв. Судалгаанд оролцсон Хан-Уул дүүргийн хялбаршуулсан журмаар нэг иргэний хэрэг хянан шийдвэрлэх хугацаа 477



ХЭРГИЙН КОЭФФИЦИЕНТ ТООЦОХ ШИНЖИЛГЭЭ

минут байхад Багануур дүүргийнх 388 минут байгаа нь шүүгчийн ачаалал тодорхойлох шийдвэрлэх тооцоонд эргэлзээ төрүүлэхээс гадна дахин нягтлах шалгах, судалгааны баг хэлэлцүүлэг хийх асуудал үүсгэсэн. Ердийн журмын хувьд мөн адил асуудал үүсгэв. Өмнөх судалгаагаар Хан-Уул дүүргийн шүүх өндөр ачаалалтай шүүх бөгөөд Багануур дүүрэг шиг хэргийг аажуу тайван хугацаанд шийдвэрлэх боломж байхгүй гэсэн дүгнэлт гарсан байсан. Энэ 2 шүүхийн ажиглалтын өгөгдлийн дунджаар ИХАШШ-ийн шүүгчийн ачаалал тооцож үзэхэд ИХДЗШШ-ийн шүүгчийн ачаалалтай ижил үр дүн гарав. Иймд судалгааны баг Хан-Уул дүүргийн ажиглалтын өгөгдлийн утгыг судалгаанаас хасаж зөвхөн Багануур дүүргийн ажиглалтын утгыг судалгаанд хэрэглэх шийдвэрт хүрэв.

№	Шүүхийн тогтолцоо	Эрүү	Зөрчил	Иргэн
1	Төвийн дүүрэг	-	-	326
2	Захын дүүрэг	-	-	142
3	Аймаг	-	-	267
4	Сум дунд	28	71	105

Хүснэгт 5.3.5 Нэг шүүгчид ногдох хянан шийдвэрлэсэн хэргийн тоо

Эх сурвалж: ШЕЗ-ийн захиалгат судалгааны ажлын тайлан

Зураг 5.3.1-ийн үр дүнг Хүснэгт 5.3.6-д ашиглан шүүгчийн хянан шийдвэрлэсэн хэргийн тоог журам болон бага үнийн дүнгээр ялган тооцов.

№	Шүүхийн тогтолцоо	Хянан шийдвэрлэсэн хэргийн тоо	Бага үнийн дүнтэй хэрэг		Хянан шийдвэрлэсэн хэргийн тоо, журмаар				Хэрэгсэхгүй болгосон хэрэг	
			Эзлэх хувь	Хэргийн тоо	Хялбар-шуулсан	Ердийн	Хялбар-шуулсан	Ердийн	Эзлэх хувь	Хэргийн тоо
1	Төвийн дүүрэг	326	40%	130	15%	49	23%	75	22%	72
2	Захын дүүрэг	142	61%	87	19%	27	14%	20	6%	9
3	Аймаг	267	29%	77	18%	48	48%	128	5%	13
4	Сум дунд	105	34%	36	22%	23	42%	44	3%	3

Хүснэгт 5.3.6 ИХАШШ-ийн шүүгчийн хянан шийдвэрлэсэн хэргийн тооны задаргаа

Хүснэгт 5.3.6-гийн үр дүнг Хүснэгт 5.3.7-д ашиглан шүүгчийн ажлын ачааллыг тооцож харуулав.

№	Шүүхийн тогтолцоо	Хэрэг хянан шийдвэрлэх хугацаа /минутаар/				Нийт хугацаа /минут/	Шүүгчийн ажлын ачаалал /цагаар, өдөрт/
		Хялбаршуулсан	Ердийн	Бага үнийн дүнтэй	Хэрэгсэхгүй болгосон		
1	Төвийн дүүрэг	388×49=18973	949×75=71156	595×130=77588	388×72=27827	195545	195545:60=3259 32589226=14.4
2	Захын дүүрэг	388×27=10468	949×20=18866	595×87=51539	388×9=3306	84179	84179:60=1403 1403:226=6.2
3	Аймаг	388×48=18647	949×128=12624	595×77=46071	388×13=5180	191552	191552:60=3192 3192:226=14.1
4	Сум дунд	388×23=8963	949×44=41851	595×36=21420	388×3=1222	73277	73277:60=1221 1221:226=5.4

Хүснэгт 5.3.7 ИХАШШ-ийн Шүүгчийн ажлын ачаалал

Хүснэгт 5.3.7-д сум дундын шүүхээс бусад шүүхийн хувьд дүгнэлт өгье. Учир нь сум дундын шүүхийн шүүгч эрүү, зөрчил болон иргэний хэрэг дээр давхар ажилладаг онцлогтой. Хүснэгт 5.3.7-гоос харвал төвийн дүүрэг, аймгийн ИХАШШ-ийн шүүгч ажлын 226 өдрөөс гадна амралтын өдөр мөн ажиллаж байж ажлын ажиллагааны ачааллыг давж гардаг төлөв ажиглагдаж байна.

- **Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгчийн ажиллагаа**

Энэ судалгааны ажлын 3-р бүлэгт тооцсон ИХДЗШШ-ийн шинжилгээний ерөнхий үр дүнг энэ бүлэгт дахин дурдъя.



ХЭРГИЙН КОЭФФИЦИЕНТ ТООЦОХ ШИНЖИЛГЭЭ

№	Шүүхийн тогтолцоо	Асуумж	Ажиглалт	Дундаж
1	Нийслэл	750	499	625
2	Дархан-Уул, Аймаг	1336	354	845

Хүснэгт 5.3.8 ИХДЗШШШ-ийн хэрэг хянан шийдвэрлэхэд шаардагдах хугацаа, минутаар

Тодорхойлолт 6: ИХДЗШШ-ийн хэрэг хянан шийдвэрлэхэд шаардагдах хугацааг $(625+845):2=735$ минут байхыг улсын дундаж стандарт гэж үзнэ.

Хүснэгт 5.3.8-д ИХДЗШШ-ийн шүүгчийн өгсөн асуумж ба ажиглалтын утгын өгөгдлийн шинжилгээний үр дүнг харуулав. Хэрэг хянан шийдвэрлэхэд шаардагдах хугацааг тодорхойлохдоо ИХДЗШШ-ийн шүүгчид өөрсдийн ажлын туршлага, баримжааг үндэслэн үзэл бодол, саналаа чөлөөтэй илэрхийлэх боломжоор хангах үүднээс асуумж явуулсан. Дархан-Уул аймгийн ИХДЗШШШ-дийн явуулсан асуумжийн үр дүн, ажиглалтын өгөгдлийн үр дүнгээс 3.8 дахин их байна. Энэ нь шинжилгээнд аймгийн ИХДЗШШШ-ийн хэт өндөр тоог санамсаргүй байдлаар судалгааны ажлын шинжилгээнд оруулсан гэсэн юм. Энэ өгөгдлийн үр дүнг харьцангуй их болгосон шалтгааныг 3-р бүлгийн шинжилгээний үр дүнгээс харах, хариуцаж хийсэн ШЕЗ-ийн ажилтнаас тодруулга хийх зэргээр хандаж болно. Гэвч нэгэнт хийсэн шинжилгээний үр дүнг дахин хянаж завсарлахад маш их хугацаа орох тул энэ хэвээр нь хэт өндөр дүнтэй тоон утгаар дунджилж шинжилгээг цааш нь явуулъя.

№	Шүүхийн тогтолцоо	Эрүү	Зөрчил	Иргэн
1	Нийслэл	-	-	160
2	Орхон, Дархан-Уул	-	-	46

Хүснэгт 5.3.9 ИХДЗШШ-ийн нэг шүүгчид ногдох хянан шийдвэрлэсэн хэргийн тоо

Эх сурвалж: ШЕЗ-ийн захиалгат судалгааны ажлын тайлан

Хүснэгт 5.3.12-ын үр дүнг Хүснэгт 5.3.13-д ашиглан ИХДЗШШ-ийн шүүгчийн ажлын ачааллыг тооцож харуулав.

№	Шүүхийн тогтолцоо	Хэрэг хянан шийдвэрлэх хугацаа, минутаар	Шүүгчийн ажлын ачаалал, цагаар	Шүүгчийн ажлын ачаалал, цагаар өдөрт
1	Нийслэл	$160 \times 735 = 117600$	$117600:60=1960$	$1960:226=8.7$
2	Дархан-Уул	$46 \times 735 = 33810$	$33810:60=564$	$564:226=2.5$

Хүснэгт 5.3.10 ИХДЗШШ-ийн Шүүгчийн ажлын ачаалал

Хүснэгт 5.3.13-аас харвал аймгийн ИХДЗШШ-ийн шүүгч өдөрт ажлын ажиллагаанд 2.5 цаг зарцуулдаг байхад нийслэлийн ИХДЗШШ-ийн шүүгч өдөрт ажлын ажиллагаанд 8.7 цаг зарцуулдаг байна. НИХДЗШШ-ийн шүүгчийн ажлын ажиллагаа ажлын 8 цагаас илүү байхад, Дархан-Уул аймгийн ИХДЗШШ-ийн шүүгчийн ажлын ажиллагаа ажлын 8 цагт хүрэхгүй байна.

5.4 Захиргааны хэргийн шүүгчийн ажлын ачаалал тооцох коэффициентийн шинжилгээ

Шүүхийн ерөнхий зөвлөлийн хэргийн хөдөлгөөний удирдлагын хэлтсээс 2017-2021 онд хянан шийдвэрлэсэн захиргааны хэргийн тоог шүүхийн тогтолцоогоор гаргаж судалгааны багт ирүүлсэн. Шүүгчийн ажлын ачаалал тооцох, хэргийн коэффициент тодорхойлох өмнөх судалгаа шүүхийн тогтолцоо тус бүрээр хийгдсэний дараа улсын дундаж тодорхойлсон байсан тул өмнөх судалгааны ажлын зарчимтай ижил аргаар явуулна.

Шүүх	Хялбаршуулсан					Ердийн					Хэрэгсэхгүй болгосон				
	2017	2018	2019	2020	2021	2017	2018	2019	2020	2021	2017	2018	2019	2020	2021
Орон нутаг	236	219	221	228	281	591	437	422	340	445	21	18	30	35	38
Нийслэл	202	254	227	179	172	779	605	702	656	733	79	105	145	86	95
Дүн	438	473	448	407	453	1370	1042	1124	996	1178	100	123	175	121	133


Хүснэгт 5.4. 1 Захиргааны хянан шийдвэрлэсэн хэргийн тоо

Эх сурвалж: ШЕЗ-ийн хэргийн хөдөлгөөний удирдлагын хэлтэс



ХЭРГИЙН КОЭФФИЦИЕНТ ТООЦОХ ШИНЖИЛГЭЭ

Хүснэгт 5.4.1-ийн утгыг ашиглан захиргааны хянан шийдвэрлэсэн нийт хэргийн дүнд хялбаршуулсан ба ердийн журмаар шийдвэрлэсэн хэрэг, хэрэгсэхгүй болгосон хэргийн эзлэх хувийг шүүхийн тогтолцоо тус бүрээр тооцож Зураг 5.4.1-д харуулав.



Зураг 5.4.1 Хянан шийдвэрлэсэн захиргааны хэргийн тооны харьцаа, хувиар

Зураг 5.4.1-ээс харвал нийслэлийн хянан шийдвэрлэсэн захиргааны хэргийн тооны 33%-ийг, орон нутгийн ЗХАШШ-д хянан шийдвэрлэсэн захиргааны хэргийн тооны 21%-ийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэсэн хэргийн тоо тус тус эзэлдэг онцлогтой байна. Зураг 5.4.1-ийн 2-р зургийн хувьд улсын дундаж дүнгээр ЗХШ-д хянан шийдвэрлэсэн захиргааны хэргийн тооны 26%-ийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэсэн хэрэг, 67%-ийг ердийн журмаар хянан шийдвэрлэсэн хэрэг, 8%-ийг хянан шийдвэрлээд хэрэгсэхгүй болгосон хэрэг тус тус эзэлдэг байна.

Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн ажиллагаа

Энэ судалгааны ажлын 4-р бүлэгт тооцсон ЗХАШШ-ийн шинжилгээний ерөнхий үр дүнг энэ бүлэгт нэгтгэж дурдъя. ШЕЗ-ийн судалгааны баг шүүгчийн ажлын явцад хийгддэг ажиллагааны ачааллыг бодитой тодорхойлохын тулд шүүгчээс асуумж авах, шүүгчийн ажлын байрны ажиглалт явуулах зэрэг үйл ажиллагааны хүрээнд цуглуулсан өгөгдөлд шинжилгээ хийсэн ерөнхий үр дүнг дараах хүснэгтэд харуулав.

№	Шүүхийн тогтолцоо	Асуумж		Ажиглалт	
		Ердийн	Хялбаршуулсан	Ердийн	Хялбаршуулсан
1	Орон нутаг	10680	6431	3581	-
2	Нийслэл	3779	2032	3253	-
	Дүн	3779	2032	3417	

Хүснэгт 5.4.2 ЗХАШШ-ийн хэрэг хянан шийдвэрлэхэд шаардагдах хугацаа, минутаар

Тодорхойлолт 7: ЗХАШШ-ийн хэргийг ердийн журмаар хянан шийдвэрлэхэд зарцуулах хугацааг $(3779+3417):2=3598$ минут, хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэхэд зарцуулах хугацааг 2032 минут байхыг улсын дундаж стандарт гэж үзнэ.

Хүснэгт 5.4.2-д асуумж ба ажиглалтын утгын өгөгдлийн шинжилгээний үр дүнг харуулав. Захиргааны хэргийг ердийн ба хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэхэд шаардагдах хугацааг шүүгчид өөрсдийн ажлын туршлага, ажиллагааны баримжааг үндэслэн санал бодлоо чөлөөтэй илэрхийлэх боломжоор хангах үүднээс асуумж явуулсан. Орон нутгийн ЗХШ-ийн ердийн ба хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх асуумжийн хугацааг хүчингүйд тооцож судалгаанаас хасав. Харин нийслэлийн ЗХШ-ийн ердийн ба хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх асуумжийн үр дүнг цааш нь судалгаанд ашиглахаар үлдээв. Нийслэлийн ЗХШ-ийн ажиглалт ба асуумжийн өгөгдлийн утга ердийн журмаар хэрэг хянан шийдвэрлэх хугацаатай ойролцоо үр дүн харуулж байгаа тул энэ үзүүлэлтийн дундаж утгаар шүүгчийн ажлын ачааллыг тооцоход ашиглав. ЗХШ-ийн хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиглалтын өгөгдөл судалгааны багт ирээгүй тул зөвхөн ердийн журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд шаардагдах ажиглалтын хугацааг оруулав. Ердийн журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд шаардагдах хугацааг нийслэлийн ЗХШ-ээс ирүүлсэн ажиглалтын утгаар тооцоонд цааш нь ашиглав.

№	Шүүхийн тогтолцоо	Эрүү	Зөрчил	Иргэн	Захиргаа
1	Нийслэл	-	-	-	54
2	Орон нутаг	-	-	-	13

Хүснэгт 5.4.3 ЗХ-ийн нэг шүүгчид ногдох хянан шийдвэрлэсэн хэргийн тоо

Эх сурвалж: ШЕЗ-ийн захиалгат судалгааны ажлын тайлан



Зураг 5.4.1-ийн үр дүнг Хүснэгт 5.4.4-д ашиглан шүүгчийн хянан шийдвэрлэсэн хэргийн тоог журмаар болон хэрэгсэхгүй болгосон хэргийн тооны дүнгээр ялган тооцов.

№	Шүүхийн тогтолцоо	Хянан шийдвэрлэсэн хэргийн тоо	Хянан шийдвэрлэсэн хэргийн тоо, журмаар				Хэрэгсэхгүй болгосон хэрэг	
			Хялбаршуулсан		Ердийн		Эзлэх хувь	Хэргийн тоо
1	Нийслэл	54	21%	11	69%	37	10%	5
2	Орон нутаг	13	33%	4	63%	8	4%	1

Хүснэгт 5.4.4 ЗХШ-ийн шүүгчийн хянан шийдвэрлэсэн хэргийн тооны задаргаа

Хүснэгт 5.4.4-ийн үр дүнг Хүснэгт 5.4.5-д ашиглан шүүгчийн ажлын ачааллыг тооцож харуулав.

Шүүхийн тогтолцоо	Хэрэг хянан шийдвэрлэх хугацаа /минутаар/			Нийт хугацаа /минут/	Шүүгчийн ажлын ачаалал /цагаар, өдөрт/
	Хялбаршуулсан	Ердийн	Хэрэгсэхгүй болгосон		
Нийслэл	2032×11=23043	3598×37=134061	2032×5=10973	168077	168077:60=2801 2801:226=12.4
Орон нутаг	2032×4=8717	3598×8=29468	2032×9=1=2032	39242	39242:60=654 654:226=2.9

Хүснэгт 5.4.5 ЗХАШШШ-ийн ажлын ажиллагааны ачаалал

Хүснэгт 5.4.5-аас харвал НЗХАШШ-ийн шүүгч ажлын 226 өдрөөс гадна амралтын өдөр мөн ажиллаж байж ажлын ажиллагааны ачааллыг давж гардаг төлөв ажиглагдаж байна. АЗХШ-ийн шүүгч өдөрт 3 цаг ажиллагааны ачаалалтай ажилладаг бөгөөд ажлын 8 цагийн ачааллыг гүйцэт авдаггүй, бусад хэргийн шүүхийн шүүгчийг бодвол ачаалалгүй ажилладаг төлөв ажиглагдаж байна.

• **Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгчийн ажиллагаа**

Энэ судалгааны ажлын 4-р бүлэгт тооцсон ЗХДЗШШ-ийн шинжилгээний ерөнхий үр дүнг энэ бүлэгт дахин дурдъя.

№	Шүүхийн тогтолцоо	Асуумж	Ажиглалт	Дундаж
1	Нийслэл	5235	1558	3397

Хүснэгт 5.4.6 ЗХДЗШШШ-ийн хэрэг хянан шийдвэрлэхэд шаардагдах хугацаа, минутаар

Тодорхойлолт 8: *ЗХДЗШШ-ийн хэрэг хянан шийдвэрлэхэд шаардагдах хугацааг $(5235+1558):2=3397$ минут байхыг улсын дундаж стандарт гэж үзнэ.*

Хүснэгт 5.4.5-д ЗХДЗШШ-ийн шүүгчийн өгсөн асуумж ба ажиглалтын утгын өгөгдлийн шинжилгээний үр дүнг харуулав. Хэрэг хянан шийдвэрлэхэд шаардагдах хугацааг тодорхойлохдоо ЗХДЗШШ-ийн шүүгчид өөрсдийн ажлын туршлага, баримжааг үндэслэн саналаа бодлоо чөлөөтэй илэрхийлэх боломжоор хангах үүднээс асуумж явуулсан. ЗХДЗШШШ-дийн явуулсан асуумжийн үр дүн, ажиглалтын өгөгдлөөс 3.4 дахин их байна. Энэ нь ЗХДЗШШ-ийн хэт өндөр тоо судалгааны ажлын шинжилгээнд орсон гэсэн юм. Гэвч нэгэнт хийсэн шинжилгээний үр дүнг дахин хянаж завсарлахад их хугацаа орох тул энэ хэвээр нь хэт өндөр дүнтэй тоон утгаар дунджилж шинжилгээг цааш нь явуулъя.

№	Шүүхийн тогтолцоо	Эрүү	Зөрчил	Иргэн	Захиргаа
1	Нийслэл	-	-	-	62

Хүснэгт 5.4.7 ЗХДЗШШ-ийн нэг шүүгчид ногдох хянан шийдвэрлэсэн хэргийн тоо

Эх сурвалж: ШЕЗ-ийн захиалгат судалгааны ажлын тайлан

Хүснэгт 5.4.6-гийн үр дүнг Хүснэгт 5.4.7-д ашиглан ЗХДЗШШ-ийн шүүгчийн ажлын ачааллыг тооцож харуулав.

№	Шүүхийн тогтолцоо	Хэрэг хянан шийдвэрлэх хугацаа, минутаар	Шүүгчийн ажлын ачаалал, цагаар	Шүүгчийн ажлын ачаалал, цагаар өдөрт
1	Нийслэл	62×3397=210583	210583:60=3510	3510:226=16

Хүснэгт 5.4.8 ЗХДЗШШ-ийн Шүүгчийн ажлын ачаалал



Хүснэгт 5.4.7-оос харвал ЗХДЗШШ-ийн шүүгч жилд ажлын 226 өдөр байдаг гэж үзвэл өдөрт ажлын ажиллагаанд 16 цаг зарцуулдаг байна. ЗХДЗШШ-ийн шүүгч амралтын өдөр болон ажлын өдөр илүү цагаар ажиллаж байж энэхүү ачааллыг давж гардаг төлөв ажиглагдаж байна.

5.5 Шүүгчийн ажлын ачааллын дүгнэлт

5-р бүлгийн 1-4 дэд бүлэгт тооцсон үр дүнг шүүхийн тогтолцоо тус бүрээр нэгтгэж дүгнэх, шүүгчийн ажлын ачааллын зохистой коэффициентийг тодорхойлох, хэргийн коэффициентийн харьцааг тооцох зэрэг ажлыг энэ бүлэгт хийнэ.

• Шүүгчийн ажлын ачааллын дүгнэлт

Шүүхийн тогтолцоо тус бүрээр судалгааны үр дүнг дараах хүснэгтэд нэгтгэн бичив. Энэ нь хянан шийдвэрлэх хэргийн төрөл өөр өөр байдаг захын дүүргийн, аймгийн ААШ-ийн, СДШ-ийн шүүгчийн ачааллыг нэгтгэж илэрхийлэхэд хялбар байх юм.

№	Хэргийн төрөл	Нэг шүүгчид ногдох хянан шийдвэрлэсэн хэргийн тоо	Ангилал				Шүүгчийн ачаалал, цагаар өдөрт
			Ердийн	Хялбар-шуулсан	Хэрэг-сэхгүй	Бага үнийн дүн	
1	Эрүү	136	92	44	-	-	11.8
2	Зөрчил	1390	-	-	-	-	20
3	Иргэн	326	75	49	72	130	14.4
4	Захиргаа	54	37	11	5	-	12.4

Хүснэгт 5.5.1 Төвийн дүүргийн АШШ-ийн шүүгчийн ажлын ачаалал, ажлын өдөрт цагаар

Хүснэгт 5.5.1-ийн төвийн дүүргийн АШШ-ийн шүүгчийн ажлын ачааллаас харвал ЭХАШШ-ийн эрүүгийн хэргийн шүүгчийн ачаалал 50%, ЭХАШШ-ийн зөрчлийн хэргийн шүүгчийн ачаалал 150%, ИХАШШ-ийн шүүгчийн ачаалал 80%, ЗХАШШ-ийн шүүгчийн ачаалал 55%-иар тус тус хэтэрсэн харагдаж байна.

№	Хэргийн төрөл	Нэг шүүгчид ногдох хянан шийдвэрлэсэн хэргийн тоо	Ангилал				Шүүгчийн ачаалал, цагаар өдөрт
			Ердийн	Хялбар-шуулсан	Хэрэг-сэхгүй	Бага үнийн дүн	
1	Эрүү	44	29.3	14.7	-	-	3.8
2	Зөрчил	58	-	-	-	-	0.8
3	Иргэн	142	20	27	9	87	6.2

Хүснэгт 5.5.2 Захын дүүргийн шүүхийн шүүгчийн ажлын ачаалал, ажлын өдөрт цагаар

Хүснэгт 5.5.2-ийн захын дүүргийн шүүхийн шүүгчийн ажлын ачааллаас харвал ЭХШ-ийн шүүгчийн ачаалал 4.6 цаг буюу өдөрт авах ёстой ачааллын 58.8%-д хүрэх хэмжээний ачаалалтай ажилладаг харагдаж байна. Харин ИХШ-ийн шүүгчийн ачаалал 6.2 цаг буюу өдөрт авах ёстой ачааллын 77%-д хүрэх хэмжээний ачаалалтай ажилладаг харагдаж байна.

№	Хэргийн төрөл	Нэг шүүгчид ногдох хянан шийдвэрлэсэн хэргийн тоо	Ангилал				Шүүгчийн ачаалал, цагаар өдөрт
			Ердийн	Хялбар-шуулсан	Хэрэг-сэхгүй	Бага үнийн дүн	
1	Эрүү	79	48.6	30.4	-	-	6.5
2	Зөрчил	143	-	-	-	-	2.1
3	Иргэн	267	128	48	13	77	14.1
4	Захиргаа	13	8	4	1	-	2.9

Хүснэгт 5.5.3 ААШШ-ийн шүүгчийн ажлын ачаалал, ажлын өдөрт цагаар



Хүснэгт 5.5.3-ын АШШ-ийн шүүгчийн ажлын ачааллаас харвал ЭХШ-ийн шүүгчийн ачаалал 8.6 цаг буюу 10%-иар хэтэрсэн ачаалалтай ажилладаг харагдаж байна. ИХАШШ-ийн шүүгчийн ачаалал 81%-иар хэтэрсэн харагдаж байна. ЗХШ-ийн шүүгчийн ачаалал 3 цаг буюу өдөрт авах ёстой ачааллын 37.5%-д хүрэх хэмжээний ачаалал авч, 62.5%-ийн ачаалал дутуу ажилладаг харагдаж байна.

№	Хэргийн төрөл	Нэг шүүгчид ногдох хянан шийдвэрлэсэн хэргийн тоо	Ангилал				Шүүгчийн ачаалал, цагаар өдөрт
			Ердийн	Хялбаршуулсан	Хэрэгсэхгүй	Бага үнийн дүн	
1	Эрүү	28	16.3	11.7	-	-	2.2
2	Зөрчил	71	-	-	-	-	1.0
3	Иргэн	105	44	23	3	36	5.4

Хүснэгт 5.5.4 СДШ-ийн шүүгчийн ажлын ачаалал, ажлын өдөрт цагаар

Хүснэгт 5.5.4-ийн СДШ-ийн шүүгчийн ажлын ачааллаас харвал эрүүгийн хэргийн ачааллаас 2.2 цаг, зөрчлийн хэргийн ачааллаас 1 цаг, иргэний хэргийн ачааллаас 5.4 цаг, нийт 8.6 цагийн ачаалалтай ажиллаж өдөрт 10%-иар илүү ачаалалтай ажилладаг дүр зураг ажиглагдаж байна.

№	Хэргийн төрөл	Нэг шүүгчид ногдох хянан шийдвэрлэсэн хэргийн тоо	Журам		Шүүгчийн ачаалал, цагаар өдөрт
			Ердийн	Хялбаршуулсан	
1	Эрүү	69	-	-	9.4
2	Зөрчил	11	-	-	0.7
3	Иргэн	160	-	-	8.7
4	Захиргаа	62	-	-	16

Хүснэгт 5.5.5 Нийслэлийн ДЗШШ-ийн шүүгчийн ажлын ачаалал, ажлын өдөрт цагаар

Хүснэгт 5.5.5-ын НДЗШШ-ийн шүүгчийн ажлын ачааллаас харвал ЭХШ-ийн шүүгчийн ачаалал 10 цаг буюу өдөрт авах ёстой ачааллын хэмжээнээс 25%-иар илүү ачаалалтай ажилладаг дүр зураг ажиглагдаж байна. ИХДЗШШ-ийн шүүгчийн ачаалал 10%-иар, ЗХДЗШШ-ийн шүүгчийн ачаалал 99%-иар хэтэрсэн харагдаж байна.

№	Хэргийн төрөл	Нэг шүүгчид ногдох хянан шийдвэрлэсэн хэргийн тоо	Журам		Шүүгчийн ачаалал, цагаар өдөрт
			Ердийн	Хялбаршуулсан	
1	Эрүү	25	-	-	3.4
2	Зөрчил	6	-	-	0.4
3	Иргэн	46	-	-	2.5

Хүснэгт 5.5.6 Дархан-Уул аймгийн ДЗШШ-ийн шүүгчийн ажлын ачаалал, ажлын өдөрт цагаар

Хүснэгт 5.5.6-гийн Дархан-Уул аймгийн ДЗШШ-ийн шүүгчийн ажлын ачааллаас харвал ЭХШ ба ИХШ-ийн шүүгчийн ачаалал 3.8 ба 2.5 цаг буюу өдөрт авах ёстой ачааллын хэмжээнээс 52.5% ба 68.8% -иар дутуу ачаалалтай ажилладаг дүр зураг ажиглагдаж байна.

• **Шүүгчийн ажлын ачааллын зохистой коэффициентийн тооцоо**

Хүснэгт 5.5.1-5.5.6-гийн үр дүнг ашиглан шүүгчийн ажлын ачааллын зохистой коэффициентийг тодорхойлъё. АШШ-ийн эрүүгийн хэргийн нэг шүүгч жилд 136 (44, 79, 28) хэргийг ердийн ба хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэхийн тулд (жилийн 226 ажлын өдрийн) ажлын өдөр 11.8 (3.8, 6.5, 2.2) цаг ажилладаг гэсэн тооцоо гарсан. Тэгвэл ажлын 8 цагаар ажиллахад хэдэн хэрэг жилд хянан шийдвэрлэвэл зохистой байх вэ гэсэн асуултын хариуг тодорхойлохын тулд дараах бодолтыг хийв.

$$\frac{136 + 44 + 79 + 28}{11.8 + 3.8 + 6.5 + 2.2} \times 8 = 94$$

Энэ нь ЭХАШШ-ийн шүүгч жилд 94 хэргийг хянан шийдвэрлэхийн тулд өдөрт 8 цаг ажиллана гэсэн үг юм.



ЭХАШШ-ийн зөрчлийн хэргийн нэг шүүгч жилд 1390 (58, 143, 71) хэргийг хянан шийдвэрлэхийн тулд (жилийн 226 ажлын өдрийн) ажлын өдөр 20 (0.8, 2.1, 1.0) цаг ажилладаг гэсэн тооцоо гарсан. Тэгвэл ажлын 8 цагаар ажиллахад хэдэн хэрэг жилд хянан шийдвэрлэвэл зохистой байх вэ гэсэн асуултын хариуг тодорхойлохын тулд дараах бодолтыг хийв.

$$\frac{1390 + 58 + 143 + 71}{20.1 + 0.8 + 2.1 + 1} \times 8 = 554$$

ЭХАШШ-ийн зөрчлийн хэргийн шүүгч жилд 600 орчим хэргийг хянан шийдвэрлэхийн тулд өдөрт 8 цаг ажиллана гэсэн үг юм.

АШШ-ийн иргэний хэргийн нэг шүүгч жилд 326 (142, 267, 105) хэргийг ердийн ба хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэхийн тулд (жилийн 226 ажлын өдрийн) ажлын өдөр 14.4 (6.2, 14.1, 5.4) цаг ажилладаг гэсэн тооцоо гарсан. Тэгвэл ажлын 8 цагаар ажиллахад хэдэн хэрэг жилд хянан шийдвэрлэвэл зохистой байх вэ гэсэн асуултын хариуг тодорхойлохын тулд дараах бодолтыг хийв.

$$\frac{326 + 142 + 267 + 105}{14.4 + 6.2 + 14.1 + 5.4} \times 8 = 167$$

Эндээс ИХАШШ-ийн шүүгч жилд 170 орчим хэргийг хянан шийдвэрлэхийн тулд өдөрт 8 цаг ажиллана гэсэн үг юм.

ЗХАШШ-ийн нэг шүүгч жилд 54 (13) хэргийг ердийн ба хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэхийн тулд (жилийн 226 ажлын өдрийн) ажлын өдөр 12.4 (2.9) цаг ажилладаг гэсэн тооцоо гарсан. Тэгвэл ажлын 8 цагаар ажиллахад хэдэн хэрэг жилд хянан шийдвэрлэвэл зохистой байх вэ гэсэн асуултын хариуг тодорхойлохын тулд дараах бодолтыг хийв.

$$\frac{54 + 13}{12.4 + 2.9} \times 8 = 35$$

Эндээс ЗХАШШ-ийн шүүгч жилд 35 хэргийг хянан шийдвэрлэхийн тулд өдөрт 8 цаг ажиллана гэж үзнэ.

ЭХДЗШШ-ийн эрүүгийн хэргийн нэг шүүгч жилд 69, 11 (25, 6) хэргийг ердийн ба хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэхийн тулд (жилийн 226 ажлын өдрийн) ажлын өдөр 5.8, 0.7 (2.1, 0.4) цаг ажилладаг гэсэн тооцоо гарсан. Тэгвэл ажлын 8 цагаар ажиллахад хэдэн хэрэг жилд хянан шийдвэрлэвэл зохистой байх вэ гэсэн асуултын хариуг тодорхойлохын тулд дараах бодолтыг хийв.

$$\frac{69 + 25}{9.4 + 3.4} \times 8 = 59 \text{ эрүүгийн хэрэг, эсвэл } \frac{11 + 6}{0.6 + 0.4} \times 8 = 137 \text{ зөрчлийн хэрэг}$$

Бодолтоос харвал ЭХДЗШШ-ийн шүүгч жилд 59 эрүүгийн хэрэг эсвэл 137 зөрчлийн хэргийг хянан шийдвэрлэхийн тулд өдөрт 8 цаг ажилладаг байна.

ИХДЗШШ-ийн иргэний хэргийн нэг шүүгч жилд 160 (46) хэргийг ердийн ба хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэхийн тулд (жилийн 226 ажлын өдрийн) ажлын өдөр 8.7 (2.5) цаг ажилладаг гэсэн тооцоо гарсан. Тэгвэл ажлын 8 цагаар ажиллахад хэдэн хэрэг жилд хянан шийдвэрлэвэл зохистой байх вэ гэсэн асуултын хариуг тодорхойлохын тулд дараах бодолтыг хийв.

$$\frac{160 + 46}{8.7 + 2.5} \times 8 = 148$$

Бодолтоос харвал ИХДЗШШ-ийн шүүгч жилд 145 иргэний хэргийг хянан шийдвэрлэхийн тулд өдөрт 8 цаг ажиллана.

ЗХДЗШШ-ийн нэг шүүгч жилд 62 хэргийг ердийн ба хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэхийн тулд (жилийн 226 ажлын өдрийн) ажлын өдөр 16 цаг ажилладаг гэсэн тооцоо гарсан. Тэгвэл ажлын 8 цагаар ажиллахад хэдэн хэрэг жилд хянан шийдвэрлэвэл зохистой байх вэ гэсэн асуултын хариуг тодорхойлохын тулд дараах бодолтыг хийв.



$$\frac{62}{16} \times 8 = 31$$

Эндээс ЗХДЗШШ-ийн шүүгч жилд 31 хэргийг хянан шийдвэрлэхийн тулд өдөрт 8 цаг ажиллана гэж үзнэ.

- ***Хэргийн коэффициентийн харьцаа***

ЭХАШШШ-ийн нэг жилд хянан шийдвэрлэх хэргийн тоог 94 эрүүгийн хэрэг, 560 зөрчлийн хэрэг гэсэн тооцоо гарсан. $560:94=6$ гэдгээс 1 эрүүгийн хэрэг 6 зөрчлийн хэрэгтэй тэнцэнэ гэсэн тооцоо гарч байна.

ИХАШШШ-ийн нэг жилд хянан шийдвэрлэх хэргийн тоог 167 гэж тооцсон. $167:94=1.8$ гэдгээс 1 эрүүгийн хэрэг 1.8 иргэний хэрэгтэй тэнцэнэ гэсэн тооцоо гарч байна.

ЭХДЗШШШ-ийн нэг жилд хянан шийдвэрлэх хэргийн тоог 59 эрүүгийн хэрэг, 124 зөрчлийн хэрэг гэсэн тооцоо гарсан. $137:59=2.3$ гэдгээс 1 эрүүгийн хэрэг 2.3 зөрчлийн хэрэгтэй тэнцэнэ гэсэн тооцоо гарч байна.



ДҮГНЭЛТ

Шүүгчийн ажлын ачаалал тооцох, шүүгчийн нэг жилд хянан шийдвэрлэх хэргийн тоог тодорхойлох, хэргийн коэффициент тооцох зорилгын хүрээнд энэхүү судалгааны ажил хийгдсэн болно. Мөн Шүүхийн ерөнхий зөвлөлөөс судлаачдын багтай хамтран хийсэн “ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛИЙН 2022 ОНЫ 58 ДУГААР ТОГТООЛООР БАТЛАГДСАН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТЭД ХАМААРАХ ӨГӨГДӨЛД ХИЙСЭН СУУРЬ СУДАЛГАА”-ны ажлын үр дүнг үнэлэх, харьцуулах, батлах, өмнөх судалгааны ажлуудын үр дүнг холбох зорилго тавигдсан. Энэхүү судалгааны ажлыг их дээд сургуулийн судалгаанд мэргэшсэн хөндлөнгийн судалгааны баг болон ШЕЗ-өөс томилогдсон судалгааны баг хамтран амжилттай хийж гүйцэтгэв. Судалгаанд эрүү, иргэн, захиргааны хэргийн хавтаст хэрэгт уншилт хийж цуглуулсан өгөгдөл, ЭХАШШ, ИХАШШ, ЗХАШШ, ЭХДЗШШ, ИХДЗШШ, ЗХДЗШШ-ийн шүүгчдээс авсан хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд зарцуулах хугацааны тухай асуумжийн өгөгдөл, ажлын байрны зураг авалт хийж цуглуулсан ажиглалтын өгөгдлийг ашиглав. Судалгааны ажлын 1-р бүлэг Эрүүгийн хэргийн ажиллагаа, 2-р бүлэг Зөрчлийн хэргийн ажиллагаа, 3-р бүлэг Иргэний хэргийн ажиллагаа, 4-р бүлэг Захиргааны хэргийн ажиллагаа, 5-р бүлэг Шүүгчийн ажлын ачаалал болон хэргийн коэффициентийн тодорхойлолт гэсэн үндсэн бүлгүүдээс тогтсон. Судалгааны ажилд тавьсан зорилгыг биелүүлэхийн тулд статистикийн хүснэгт графикийн арга, дундаж, харьцангуй хэмжигдэхүүн, дисперс, вариацийн коэффициент тооцох зэрэг боловсруулалтын арга, олон хүчин зүйлийн дисперсийн шинжилгээ, корелляцийн шинжилгээ, бүтцийн шинжилгээ зэрэг шинжилгээний аргуудыг хэрэглэв. Excel, Mathematica программыг ашиглан судалгааны ажлын боловсруулалт ба шинжилгээний ажлыг гүйцэтгэв. Судалгааны ажлын сонирхсон бүлэг ба дэд бүлгийн дотоод бүтцийн шинжилгээг бүлэг тус бүрээс нарийвчлан харж танилцана уу.

1-р бүлгийн Эрүүгийн хэргийн ажиллагааны өгөгдөлд хийх шинжилгээ бүлгийн тухайд: Энэ бүлэг гурван дэд бүлгээс бүрдсэн бөгөөд эрүүгийн хэргийн 12 зүйл ангид хамаарах 30 хавтаст хэргийн уншилтад хийсэн шинжилгээгээр нэг эрүүгийн хэргийн хянан шийдвэрлэхэд 69 хоног зарцуулах бөгөөд, 36 хуудастай, 18 ажиллагаа хийгддэг гэсэн дүгнэлтэд хүрсэн. Энэ үр дүнг 5-р дэд бүлэгтэй холбоход төвийн дүүргийн эрүүгийн хэргийн шүүгч өдөрт $\frac{136 \times 18}{226} = 11$ ажил хийж, $\frac{136 \times 36}{226} = 22$ хуудас материал үйлддэг байна. Өдөрт ойролцоогоор $\frac{136 \times 69}{226} = 42$ хэрэг шүүгчийн гар дээр хүлээлттэй байдаг байна. Захын дүүргийн эрүүгийн хэргийн шүүгч өдөрт $\frac{44 \times 18}{226} = 4$ ажил хийж, $\frac{44 \times 36}{226} = 7$ хуудас материал үйлддэг байна. Өдөрт ойролцоогоор $\frac{44 \times 69}{226} = 13$ хэргийн материал шүүгчийн гар дээр хүлээлттэй байдаг байна. Аймгийн эрүүгийн хэргийн шүүгч өдөрт $\frac{79 \times 18}{226} = 6$ ажил хийж, $\frac{79 \times 36}{226} = 13$ хуудас материал үйлддэг байна. Өдөрт ойролцоогоор $\frac{79 \times 69}{226} = 24$ хэргийн материал шүүгчийн гар дээр хүлээлттэй байдаг байна. Сум дундын эрүүгийн хэргийн шүүгч өдөрт $\frac{28 \times 18}{226} = 2$ ажил хийж, $\frac{28 \times 36}{226} = 4$ хуудас материал үйлддэг байна. Өдөрт ойролцоогоор $\frac{28 \times 69}{226} = 9$ хэргийн материал шүүгчийн гар дээр хүлээлттэй байдаг байна.

Хавтаст хэргийн материалын 2-р үе болох хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхэд бэлтгэх үе шатанд нэг хэргийн нийт ажиллагааны 41% буюу 7-8 ажиллагаа, нэг хэргийн нийт хуудасны 63% буюу 23 хуудас материал хийгддэг онцлогтой байна. Хэргийг эцэслэн шийдвэрлэсний дараах үе шатанд нэг хэрэгт зарцуулах нийт хугацааны 72.6% буюу 50 хоног зарцуулдаг байна. ЭХДЗШШ-д эдгээр 30 хавтаст хэргээс 3 хавтаст хэрэг



шилжсэн байсан бөгөөд нэг эрүүгийн хэргийн хянан шийдвэрлэхэд 55 хоног зарцуулах бөгөөд, 20 хуудастай, 11 ажиллагаа хийгддэг гэсэн дүгнэлтэд хүрсэн. Энэ үр дүнг 5-р дэд бүлэгтэй холбоход НЭХДЗШШ-ийн шүүгч өдөрт $\frac{69 \times 11}{226} = 3$ ажил хийж, $\frac{69 \times 20}{226} = 6$ хуудас материал үйлддэг байна. Өдөрт ойролцоогоор $\frac{69 \times 55}{226} = 17$ хэрэг шүүгчийн гар дээр хүлээлттэй байдаг байна. Орхон, Дархан-Уул аймгийн ЭХДЗШШ-ийн шүүгч өдөрт $\frac{25 \times 11}{226} = 1$ ажил хийж, $\frac{25 \times 20}{226} = 2$ хуудас материал үйлддэг байна. Өдөрт ойролцоогоор $\frac{25 \times 55}{226} = 6$ хэргийн материал шүүгчийн гар дээр хүлээлттэй байдаг байна. ЭХДЗШШ-ийн ажиллагаа нь 2 үе шатаас бүрдэх бөгөөд хавтаст хэргийн материалын 1 ба 2-р үе шатанд бараг ижил ажиллагаа буюу буюу 5-6 ажиллагаа, хийгддэг онцлогтой байна. Нэг хавтаст хэргийн нийт хуудасны 70% буюу 14 хуудас материал нь хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхэд бэлтгэх үе болох 1-р үе шатанд хийгддэг онцлогтой байна. Харин хэргийг эцэслэн шийдвэрлэсний дараах үе шатанд нэг хэрэгт зарцуулах нийт хугацааны 74% буюу 41 хоног зарцуулдаг байна.

2-р бүлгийн Зөрчлийн хэргийн ажиллагааны өгөгдөлд хийх шинжилгээ бүлгийн тухайд: Энэ бүлэг хоёр дэд бүлгээс бүрдсэн бөгөөд зөрчлийн хэргийн 10 зүйл ангид хамаарах ажиглалтын болон асуумжийн өгөгдөлд шинжилгээ хийсэн. Зөрчлийн хавтаст хэргийн уншилт хийгдээгүй тул хавтаст хэргийн онцлогийн тухай энэ бүлэгт бичигдээгүй болно.

3-р бүлгийн Иргэний хэргийн ажиллагааны өгөгдөлд хийх шинжилгээ бүлгийн тухайд: Энэ бүлэг гурван дэд бүлгээс бүрдсэн бөгөөд ердийн журмаар хянан шийдвэрлэсэн 31 хавтаст хэрэг, хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэсэн 16 хавтаст хэрэг, бага үнийн дүнтэй 6 хавтаст хэрэг нийт 53 хавтаст хэрэгт уншилт хийсэн байна. Үүнээс иргэний хэргийн 5 маргааны төрөл (иргэн, гэр бүл, хөдөлмөр, цагаатгал, шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль)-д хамаарах ердийн журмаар хянан шийдвэрлэсэн 31 хавтаст хэргийн уншилтад хийсэн шинжилгээгээр ердийн журмаар нэг иргэний хэргийг хянан шийдвэрлэхэд 210 хоног зарцуулах бөгөөд 135 хуудастай, 57 ажиллагаа хийгддэг гэсэн дүгнэлтэд хүрсэн. Энэ үр дүнг 5-р дэд бүлэгтэй холбоход төвийн дүүргийн иргэний хэргийн шүүгч өдөрт ердийн журмаар хянан шийдвэрлэх $\frac{75 \times 57}{226} = 19$ ажил хийж, $\frac{75 \times 135}{226} = 45$ хуудас материал бүрдүүлдэг байна. Өдөрт ойролцоогоор ердийн журмаар хянан шийдвэрлэх $\frac{75 \times 210}{226} = 70$ хэрэг шүүгчийн гар дээр хүлээлттэй байдаг байна. Захын дүүргийн иргэний хэргийн шүүгч өдөрт ердийн журмаар хянан шийдвэрлэх $\frac{20 \times 57}{226} = 5$ ажил хийж, $\frac{20 \times 135}{226} = 12$ хуудас материал бүрдүүлдэг байна. Өдөрт ойролцоогоор ердийн журмаар хянан шийдвэрлэх $\frac{20 \times 210}{226} = 19$ хэргийн материал шүүгчийн гар дээр хүлээлттэй байдаг байна. Аймгийн иргэний хэргийн шүүгч өдөрт $\frac{128 \times 57}{226} = 32$ ажил хийж, $\frac{128 \times 135}{226} = 76$ хуудас материал бүрдүүлдэг байна. Өдөрт ойролцоогоор ердийн журмаар хянан шийдвэрлэх $\frac{128 \times 210}{226} = 119$ хэргийн материал шүүгчийн гар дээр хүлээлттэй байдаг байна. Сум дундын иргэний хэргийн шүүгч өдөрт $\frac{44 \times 57}{226} = 11$ ажил хийж, $\frac{44 \times 135}{226} = 31$ хуудас материал бүрдүүлдэг байна. Өдөрт ойролцоогоор ердийн журмаар хянан шийдвэрлэх $\frac{44 \times 135}{226} = 26$ хэргийн материал шүүгчийн гар дээр хүлээлттэй байдаг байна.

Ердийн журмаар хянан шийдвэрлэсэн иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа дөрвөн үе шатаас бүрдэх бөгөөд эдгээр үе шат дотроос 2-р үе болох хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхэд бэлтгэх үе шатанд нэг хэргийн нийт ажиллагааны 54.5% буюу 42 ажиллагаа, нэг хэргийн нийт хуудасны 51.8% буюу 75 хуудас материал



бүрдүүлдэг онцлогтой байна. Мөн энэ үе шатанд нэг хэрэгт зарцуулах нийт хугацааны 54.8% буюу 116 хоног зарцуулдаг байна. ИХДЗШШ-д эдгээр 31 хавтаст хэргээс 4 хавтаст хэрэг шилжсэн байсан бөгөөд нэг иргэний хэргийг хянан шийдвэрлэхэд 80 хоног зарцуулах бөгөөд, 17 хуудастай, 13 ажиллагаа хийгддэг гэсэн дүгнэлтэд хүрсэн. Энэ үр дүнг 5-р дэд бүлэгтэй холбоход НИХДЗШШ-ийн шүүгч өдөрт $\frac{160 \times 13}{226} = 9$ ажил хийж, $\frac{160 \times 17}{226} = 12$ хуудас материал бүрдүүлдэг байна. Өдөрт ойролцоогоор $\frac{160 \times 80}{226} = 57$ хэрэг шүүгчийн гар хүлээлттэй байдаг байна. Орхон, Дархан-Уул аймгийн ИХДЗШШ-ийн шүүгч өдөрт $\frac{46 \times 13}{226} = 3$ ажил хийж, $\frac{46 \times 17}{226} = 3$ хуудас материал бүрдүүлдэг байна. Өдөрт ойролцоогоор $\frac{46 \times 80}{226} = 16$ хэргийн материал шүүгчийн гар дээр хүлээлттэй байдаг байна. ИХДЗШШ-ийн хэрэг хянан шийдвэрлэх үйл ажиллагаа нь 3 үе шатаас бүрдэх бөгөөд хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэх, шийдвэр гаргах 2-р үе шатанд нэг хэргийн нийт ажиллагааны 52.3% буюу 6-7 ажиллагаа хийгддэг онцлогтой байна. Нэг хавтаст хэргийн нийт хуудасны 64.4% буюу 15 хуудас материал мөн энэ 2-р үе шатанд бүрдүүлдэг онцлогтой байна. Харин иргэний хэрэг хянан шийдвэрлэх хугацааны хувьд 2 ба 3-р үе шатанд ойролцоо буюу 26, 25 хоног зарцуулдаг байна. 1-р үе шатанд 25 хоног зарцуулдаг байна.

4-р бүлгийн Захиргааны хэргийн ажиллагааны өгөгдөлд хийх шинжилгээ бүлгийн тухайд: Энэ бүлэг гурван дэд бүлгээс бүрдсэн бөгөөд ердийн журмаар хянан шийдвэрлэсэн 41 хавтаст хэрэг, хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэсэн 7 хавтаст хэрэг нийт 48 хавтаст хэрэгт уншилт хийсэн байна. Үүнээс захиргааны хэргийн 3 маргааны төрөл (газар, татвар, төрийн алба)-д хамаарах хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэсэн 7 хавтаст хэргийн уншилтад хийсэн шинжилгээгээр нэг захиргааны хэргийг хянан шийдвэрлэхэд 117 хоног зарцуулах бөгөөд, 56 хуудастай, 37 ажиллагаа хийгддэг гэсэн дүгнэлтэд хүрсэн. Энэ үр дүнг 5-р дэд бүлэгтэй холбоход нийслэлийн захиргааны хэргийн шүүгч өдөрт хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэх $\frac{11 \times 37}{226} = 2$ ажил хийж, $\frac{11 \times 56}{226} = 3$ хуудас материал бүрдүүлдэг байна. Өдөрт ойролцоогоор хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэх $\frac{11 \times 117}{226} = 6$ хэрэг шүүгчийн гар дээр хүлээлттэй байдаг байна. Орон нутгийн захиргааны хэргийн шүүгч өдөрт хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэх $\frac{4 \times 37}{226} = 0.6$ ажил хийж, $\frac{4 \times 56}{226} = 1$ хуудас материал бүрдүүлдэг байна. Өдөрт ойролцоогоор хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэх $\frac{4 \times 117}{226} = 2$ хэргийн материал шүүгчийн гар дээр хүлээлттэй байдаг байна.

Хялбаршуулсан журмаар захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа гурван үе шатаас бүрдэх бөгөөд эдгээр үе шат дотроос 2-р үе болох хэргийг шийдвэрлэх үе шатанд нэг хэргийн нийт ажиллагааны 77.8% буюу 28 ажиллагаа хийж, нэг хэргийн нийт материалын 77.8% буюу 42 хуудас материал бүрдүүлж, нэг хэргийг хянан шийдвэрлэхэд зарцуулах хугацааны 73% буюу 82 хоногийг тус тус зарцуулдаг байна. Захиргааны хэргийн хэргийг хянан шийдвэрлэх гурван үе шатаас 2-р үе шатанд хамгийн их ажиллагаа явуулж, хамгийн их материал бүрдүүлж, хамгийн их хугацаа зарцуулдаг байна.

1-4-р бүлгийн дэд бүлгүүд болох АШШ-ээс ирүүлсэн асуумж ба ажиглалтын өгөгдөлд хийсэн шинжилгээний тухайд: 1, 3, 4-р бүлгийн хоёр ба гуравдугаар дэд бүлэг, 2-р бүлгийн нэг ба хоёрдугаар дэд бүлгийн ерөнхий дүгнэлтийг дараах хүснэгтээр танилцуулъя.

№	Хэргийн төрөл	Хялбаршуулсан	Ердийн	Бага үнийн дүнтэй	Хэрэгсэхгүй болгосон
1	Эрүү	460	1528	-	-
2	Зөрчил	196		-	-



3	Иргэн	388	949	595	388
4	Захиргаа	3598	2032	-	2032

Хүснэгт. А.1. АШШШ-ийн хэрэг хянан шийдвэрлэхэд шаардагдах хугацаа, минутаар

Шүүгчийн хэрэг хянан шийдвэрлэхэд шаардагдах хугацааг хэргийн төрлөөр Хүснэгт. А.1-д харуулав. Хүснэгтээс харвал захиргааны хэргийг ердийн болон хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэхэд хамгийн их хугацаа зарцуулдаг байна. Зөрчлийн хэргийг хянан шийдвэрлэхэд хамгийн бага буюу 196 минут зарцуулдаг байна.

Эрүүгийн хэргийн асуумжийн хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэхэд зарцуулах хугацаа, *ажиглалтын* утгын ердийн ба хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэхэд зарцуулах хугацаа нь шүүгчийн ажлын ачаалал тооцох шинжилгээнд ашиглагдах өгөгдлийн сонголтод орсон болно. Харин ердийн журмаар хянан шийдвэрлэхэд зарцуулах хугацааг сонгохдоо бодит практикт хамгийн ойр байх өгөгдлийг шүүж шинжилгээнд оруулсан боловч эцсийн тооцоонд шинжилгээнээс хасагдах өгөгдлийн сонголтод оров.

Зөрчлийн хэргийн асуумжийн төвийн дүүргийн хэрэг хянан шийдвэрлэхэд зарцуулах хугацаа, *ажиглалтын* утгын төвийн ба захын дүүргийн хэрэг хянан шийдвэрлэхэд зарцуулах хугацаа нь шүүгчийн ажлын ачаалал тооцох шинжилгээнд ашиглагдах өгөгдлийн сонголтод орсон болно. Харин захын дүүрэг, аймаг, сум дундын шүүхээс ирүүлсэн зөрчлийн хэрэг хянан шийдвэрлэхэд зарцуулах хугацааг сонгохдоо бодит практикт хамгийн ойр байх өгөгдлийг шүүж шинжилгээнд оруулсан боловч эцсийн тооцоонд шинжилгээнээс хасагдах өгөгдлийн сонголтод оров.

Иргэний хэргийн төвийн дүүрэг, сум дундын шүүхийн асуумжийн ердийн журмаар хэрэг хянан шийдвэрлэхэд зарцуулах хугацаа, *ажиглалтын* захын дүүргийн ердийн ба хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэхэд зарцуулах хугацаа нь шүүгчийн ажлын ачаалал тооцох шинжилгээнд ашиглагдах өгөгдлийн сонголтод орсон болно. Харин ердийн журмаар хэрэг хянан шийдвэрлэх тухай захын дүүрэг, аймгийн шүүхээс ирүүлсэн асуумжийн өгөгдөл, хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх бүх шүүхээс ирүүлсэн асуумжийн өгөгдөл шинжилгээнээс хасагдах өгөгдлийн сонголтод оров. Бага үнийн дүнтэй хэргийг хянан шийдвэрлэх тухай бүх шүүхээс ирүүлсэн асуумжийн өгөгдөл шинжилгээнээс хасагдаж зөвхөн ажиглалт явуулсан шүүхийн өгөгдлөөр судалгааны ажлын тооцоог хийв.

Захиргааны хэргийн асуумжийн хувьд орон нутгаас ирүүлсэн хялбаршуулсан ба ердийн журмаар хэрэг хянан шийдвэрлэхэд зарцуулах хугацаа шинжилгээнд хасагдах өгөгдлийн сонголтод оров. Харин НЗХАШШ-ээс ирүүлсэн хялбаршуулсан ба ердийн журмаар хэрэг хянан шийдвэрлэхэд зарцуулах хугацааны тухай асуумжийн өгөгдөл шүүгчийн ажлын ачаалал тооцох шинжилгээнд ашиглагдах өгөгдлийн сонголтод орсон болно. ЗХАШШ-ийн *ажиглалтын* утга зөвхөн ердийн журмаар хэрэг хянан шийдвэрлэхэд зарцуулах хугацааны тухай судалгааны багт ирсэн тул хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэхэд зарцуулах хугацааны утгыг НЗХАШШ-ээс ирүүлсэн асуумжийн утгаар тооцож шинжилгээ хийв.

1-4-р бүлгийн дэд бүлгүүд болох ДЗШШ-ээс ирүүлсэн асуумж ба ажиглалтын өгөгдөлд хийсэн шинжилгээний тухайд: ДЗШШ-ийн хэрэг хянан шийдвэрлэхэд зарцуулах хугацааны тухай ерөнхий дүгнэлтийг дараах хүснэгтээр танилцуулъя.

№	Хэргийн төрөл	Хэрэг хянан шийдвэрлэхэд зарцуулах хугацаа
1	Эрүү	1840
2	Зөрчил	791
3	Иргэн	735
4	Захиргаа	3397

Хүснэгт. А.2 ДЗШШШ-ийн хэрэг хянан шийдвэрлэхэд шаардагдах хугацаа, минутаар



ДЗШШШ-ийн хэрэг хянан шийдвэрлэхэд шаардагдах хугацааг хэргийн төрлөөр Хүснэгт.А.2-д харуулав. Хүснэгтээс харвал захиргааны хэргийг хянан шийдвэрлэхэд хамгийн их хугацаа зарцуулдаг байна. Иргэний хэргийг хянан шийдвэрлэхэд хамгийн бага буюу 735 минут зарцуулдаг байна.

Эрүүгийн хэргийн асуумжийн АДЗШШ-ээс ирүүлсэн хэрэг хянан шийдвэрлэхэд зарцуулах хугацаа, *ажиглалтын* хэрэг хянан шийдвэрлэхэд зарцуулах хугацаа нь ДЗШШ-ийн шүүгчийн ажлын ачаалал тооцох шинжилгээнд ашиглагдах өгөгдлийн сонголтод орсон болно. Харин НЭХДЗШШ-ээс ирүүлсэн хэрэг хянан шийдвэрлэх тухай асуумжийн өгөгдөл шинжилгээнээс хасагдав.

Зөрчлийн хэргийн асуумжийн тухайд АДЗШШ-ээс ирүүлсэн өгөгдлийг судалгаанд ашиглав. НЭХДЗШШ-ээс зөрчлийн хэрэг хянан шийдвэрлэх тухай асуумж ирүүлээгүй байна. НЭХДЗШШ, Дархан-Уул аймгийн ЭХДЗШШ-ээс авсан *ажиглалтын* утга нь зөрчлийн хэрэг хянан шийдвэрлэхэд зарцуулах хугацааны тухай шүүгчийн ажлын ачаалал тооцох шинжилгээнд ашиглагдах өгөгдлийн сонголтод орсон болно.

Иргэний хэргийг хянан шийдвэрлэх тухай НИХДЗШШ, АДЗШШ-ээс ирүүлсэн асуумжийн өгөгдлийг судалгаанд ашиглав. НИХДЗШШ, Дархан-Уул аймгийн ИХДЗШШ-ээс авсан *ажиглалтын* утга нь иргэний хэрэг хянан шийдвэрлэхэд зарцуулах хугацааны тухай шүүгчийн ажлын ачаалал тооцох шинжилгээнд ашиглагдах өгөгдлийн сонголтод орсон болно.

Захиргааны хэргийн асуумж ба ажиглалтын утгын хувьд ЗХДЗШШ-ээс авсан хэрэг хянан шийдвэрлэхэд зарцуулах хугацаа шүүгчийн ажлын ачаалал тооцох шинжилгээнд ашиглагдах өгөгдлийн сонголтод орсон болно.



САНАЛ

ШЕЗ, ХААИС, МУИС-ийн судлаач, ажилтан, албан хаагч нараас бүрдсэн баг хавтаст хэргийн материалын уншилт болон шат шатны шүүхээс ирүүлсэн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд зарцуулах хугацааны тухай асуумж, шүүгчийн ажлын байрны зураг авалт хийх зэрэг ажиллагааны хүрээнд цуглуулсан өгөгдөлд боловсруулалт ба шинжилгээ хийх явцад гарсан үр дүнгүүд дээр тулгуурлан дараах саналыг дэвшүүлж байна. Үүнд:

- Шүүгчийн нэг жилд хянан шийдвэрлэх хэргийн тоог тодорхойлохдоо “ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛИЙН 2022 ОНЫ 58 ДУГААР ТОГТООЛООР БАТЛАГДСАН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТЭД ХАМААРАХ ӨГӨГДӨЛД ХИЙСЭН СУУРЬ СУДАЛГАА”-ны ажлын үр дүнтэй холбож хоёр судалгааны ажлын дунджаар тооцох нь зохимжтой гэж үзэж байна. ЭХАШШ-ийн шүүгч жилд $(94+89):2=91$ эрүүгийн хэрэг, $(554+908):2=731$ зөрчлийн хэрэг, ИХАШШ-ийн шүүгч жилд $(167+250):2=209$ иргэний хэрэг, ЗХ-ийн шүүгч $(35+34):2=35$ захиргааны хэрэг хянан шийдвэрлэх нь нэг шүүгчийн нэг жилд авах зохист ачаалал гэж үзэх
- ДЗШШ-ийн хувьд ЭХДЗШШ-ийн шүүгч жилд $(59+39):2=49$ эрүүгийн хэрэг, эсвэл $(137+82):2=110$ зөрчлийн хэрэг, ИХДЗШШ-ийн шүүгч жилд $(148+103):2=126$ иргэний хэрэг, ЗХДЗШШ-ийн шүүгч жилд $(31+31):2=31$ захиргааны хэрэг хянан шийдвэрлэх нь ДЗШШ-ийн нэг шүүгчийн нэг жилд авах зохист ачаалал гэж үзэх.
- Хоёр судалгааны үр дүнгээр анхан шатны шүүхийн хувьд АЗХШ-ийн шүүгчийн ажлын ачаалал хамгийн бага гарч байгаа тул аймгийн захиргааны хэргийн шүүгчийг иргэний хэрэг дээр давхар ажилладаг байхаар сургаж чиглэл өгөх эсвэл захиргааны хэргийн анхан шатны зарим шүүхийг тойргийн шүүх болгох нь зүйтэй. ИХАШШ-ийн шүүгчийн ачааллаас аймгийн захиргааны хэргийн шүүгч хуваалцах нөхцөл бүрдвэл ИХШШ-ийн ачаалал багасна гэж үзэж байна. Сум дундын шүүхийн шүүгч эрүү, зөрчил, иргэний гэсэн 3-н төрлийн хэрэг дээр ажиллаж байгаа тул захиргааны хэргийн шүүгч иргэний хэрэг дээр ажиллах бүрэн боломжтой гэж үзэж байна.
- Судалгааны ажлын тооцооноос харвал шүүгч нэмж авах шаардлага зайлшгүй тулгарч байгаа ч эхлээд шүүгчийн ачаалал авах бүтцээ дотооддоо зөв зохион байгуулах хэрэгтэй байна. Хамгийн их ачаалал авч ажиллаж байгаа төвийн дүүргийн ЭХАШШ, ИХАШШ, нийслэлийн ЗХАШШ-ийн шүүгчийн ажлын ачааллыг бүтцийн өөрчлөлт хийж яаралтай бууруулах хэрэгтэй. Хөдөлмөрийн хуульд заасан хөдөлмөрийн шударга хуваарилалт төвийн 6 дүүрэг дээр аль хэдийн алдагдсан байна.
- Аймгийн ДЗШШ-ийн шүүгчид мөн зохистой ачаалал авахгүй хэмжээнд ажиллаж байна. Иймд Хавсралт-д задалж оруулсан шүүхүүдийн мэдээлэлтэй танилцаж аймгийн ДЗШШ-д шүүгч нэмж авахгүй байх шаардлагатай.
- Нийслэл эсвэл баруун, зүүн, хангай, төвийн гэх мэт бүсэд давж заалдах шатны шүүх байгуулах нь тохиромжтой байж магадгүй юм.
- АШШШ-ийн нэг хэрэг хянан шийдвэрлэхэд шаардагдах хугацааны нормыг баримтлахдаа дээр дэвшүүлсэн саналыг харгалзан үзвэл Хүснэгт А.1-ийн тооцоог дараах байдлаар өөрчлөх шаардлага тулгарч байгааг хүснэгтээр харуулъя.

№	Хэргийн төрөл	Хялбаршуулсан	Ердийн	Бага үнийн дүнтэй	Хэрэгсэхгүй болгосон
1	Эрүү	470	1550	-	-
2	Зөрчил	149		-	-
3	Иргэн	250	750	595	250



4	Захиргаа	3598	2032	-	2032
---	----------	------	------	---	------

Хүснэгт. А. 3 АШШШ-ийн хэрэг хянан шийдвэрлэхэд шаардагдах хугацааны санал, минутаар

- ДЗШШШ-ийн нэг хэрэг хянан шийдвэрлэхэд шаардагдах хугацааны нормыг баримтлахдаа дээр дэвшүүлсэн саналыг харгалзан үзвэл Хүснэгт А.2-ийн тооцоог дараах байдлаар өөрчлөх шаардлага тулгарч байгааг хүснэгтээр харуулъя.

№	Хэргийн төрөл	Хэрэг хянан шийдвэрлэхэд зарцуулах хугацаа
1	Эрүү	2215
2	Зөрчил	985
3	Иргэн	861
4	Захиргаа	3397

Хүснэгт. А.4 ДЗШШШ-ийн хэрэг хянан шийдвэрлэхэд шаардагдах хугацааны санал, минутаар

- АШШ-ийн Эрүү, зөрчил болон иргэний хэргийн хэрэг хянан шийдвэрлэх хугацааны тухай дэвшүүлсэн санал Хүснэгт А.3, А.4-ийг хэлэлцүүлэг хийж, нягталж үзэх шаардлагата



ЗӨВЛӨМЖ

ШЕЗ, ХААИС, МУИС-ийн судлаач, ажилтан, албан хаагч нараас бүрдсэн баг хавтаст хэргийн материалын уншилт болон шат шатны шүүхээс ирүүлсэн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд зарцуулах хугацааны тухай асуумж, шүүгчийн ажлын байрны зураг авалт хийх зэрэг ажиллагааны хүрээнд цуглуулсан өгөгдөлд боловсруулалт ба шинжилгээ хийх явцад гарч байсан ажиллагаа нь дээр тулгуурлан дараах зөвлөмжийг хүргүүлж байна. Үүнд:

- Хүний нөөцийн бодлого, хэрэг хянан шийдвэрлэх хуульд заасан хугацаа нь нийцтэй байгаа эсэхийг бодит байдалтай уялдуулж харах шаардлага үүссэн байна.
- Ажиллагааны хугацааг хавтаст хэргийн материалыг судлах замаар тодорхойлох нь бүх ажиллагааны хувьд боломжгүй, ихэнх ажиллагааны хугацаа өндөр дүнтэй, бодит бус гарах нөхцөл байдал ажиглагдаж байгааг анхаарч ажиллагааны хугацааг гаргахад хавтаст хэргийг эх сурвалж болгон ашиглахгүй байх нь зүйтэй байна.
- Хуульд зааснаар хэргийг шүүхээр шийдвэрлэх ажил нь эрүү, иргэн, захиргааны хэргийг хянан шийдвэрлэх процессын хуулиас хамаарч хуульд заасан журам, хугацааны хүрээнд харилцан адилгүй ялгаатай хийгддэг ажил байна. Хуульд заасан хугацааг хэтэрч шийдвэрлэгдэж байгаа хэргүүдийн хувьд ачаалал болон хууль тогтоомжийн өөрчлөлт, ажиллах хүчний арга барил, туршлага зэрэг янз бүрийн хүчин зүйлээс шалтгаалсан байх талтай юм.
- Ачаалал ихтэй шүүхүүд нь хэрэг, маргааныг хуульд заасан хугацаанд шийдвэрлэх, мөн төрийн үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай үзүүлэх зарчмыг хэрэгжүүлэн ажиллах боломж хязгаарлагдаж байгааг анхаарах нь зүйтэй байна.
- Шинжилгээнд өгсөн зарим ажиллагааны төрөл нь шүүгчийн хийж гүйцэтгэдэг ажил үүрэг мөн эсэхэд эргэлзээг төрүүлж байна. Тухайлбал, баримт гэх ажиллагаа хэргийн ихэнх үе шатанд өндөр дүнтэй үйлдэгдэж, хуудасны тоо мөн зарцуулсан хугацааны мэдээлэл зарим тохиолдолд урьдчилсан хэлэлцүүлгийн тэмдэглэл, албан бичиг зэрэг ажиллагаанаас өндөр дүнтэй гарсан байна. Энэ нь бодит практикт мөн шүүгчийн ажиллагааны ачаалал тодорхойлох зорилготой хэрхэн нийцтэй байгааг нягтлах шаардлагатай байна.
- Нэг шүүгчийн нэг жилд ногдох ачааллыг тодорхойлохдоо ХХША-нд зарцуулах хуульд заасан хугацааг хэргийн төрөлд холбогдуулан нарийвчлан гаргах ажлыг цаашид хийх боломжтой.
- Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үе шатыг процесс ажиллагааны онцлох үечлэлийн дагуу хувааж өгөгдлийг цуглуулсан байна. Процесс ажиллагаа нь хуульд зааснаар мөн хуралдаанаар хэлэлцэхээс өмнө бүрдүүлэх, цуглуулах, шалгах, тогтоох, тодорхойлох зэрэг олон төрлийн ажиллагаа хийгдэх энэхүү шаардлагын дагуу 2 болон 3-р үе шатанд дийлэнх ажиллагаа төвлөрч хийгдсэн шинж ажиглагдаж байна. Иймд аль үе шатанд аль ажиллагааны төрөл их эсвэл бага байгаа тухай мэдээлэл төдийлөн ач холбогдол үзүүлэхээргүй байна.
- Хавтаст хэргийн материалыг уншиж, судлах ажлын дүнд цуглуулсан ажиллагааны тоо болон хуудасны тоо, мөн энэхүү судалгааны тайланд дурдсан зарим мэдээлэлд тулгуурлан хэргийн хөдөлгөөний удирдлагын чиглэлд төлөвлөх, анхаарч хэрэгжүүлэх ажлуудыг тодорхойлох боломж байна.
- Асуумж авах судалгааны хүснэгтийн бичвэрийг ойлгомжтой цэгцтэй, зөв найруулгатай бичих шаардлагатай.
- Батлагдсан асуумжийн маягтыг туршлагатай 2-3 шүүгчээр бөглүүлж туршиж үзэх хэрэгтэй.



- Шүүхээс ирүүлсэн асуумжид анхан шатны дүгнэлт хийж анхаарал татсан шүүхээс тодруулга авдаг байх хэрэгтэй.
- Ажлын байрны зураг авалт хийх буюу ажиглалт хийж ирсэн ажилтны өгөгдлийг хянах, тодруулга авах хэрэгтэй.
- Засаж шалгасан өгөгдлийн тухай товч дүгнэлт бичсэний дараа архивлах, судалгаа шинжилгээний эргэлтэд оруулах шаардлагатай байна.

**ХАВСРАЛТ 1.**

Детерминацийн коэффициентийг $R = \frac{\delta_i^2}{\sigma_i^2}$ томъёогоор олдог. Детерминацийн коэффициент нь үр дүнгийн нийт өөрчлөлтөд шинж тэмдгийн өөрчлөлт хэрхэн нөлөөлж байгааг харуулдаг.

Корреляцийн коэффициентийг $r = \sqrt{\frac{\delta_i^2}{\sigma_i^2}}$ томъёогоор олдог. Корреляцийн коэффициент нь үзүүлэлтүүдийн хоорондох нөлөөллийг хэмждэг.

Вариацийн коэффициентийг $V = \frac{S}{\bar{x}} \times 100\%$ томъёогоор олдог. Үүнд: S - стандарт хэлбэлзэл, $\bar{x}$ - дундаж

Вариацийн коэффициент нь 33.3%-аас ихгүй байвал

- Нэг төрлийн байдал
- Дунджийн төлөөлөх чадвар
- Тухайн үзүүлэлтийн жигд байдлыг үнэлэх шалгуур болдог.

ХАВСРАЛТ 2.

Эрүүгийн хавтаст хэргийн материалд хийсэн шинжилгээний хүрээнд шүүхээс хийгддэг ажиллагааг дараах байдлаар ангилж шинжилгээ хийсэн.

Ажиллагааны төрөл	Ажиллагааны задаргаа
Ерөнхий шүүгчийн захирамж	Шүүх хуралдаан даргалагчийг томилсон шийдвэрийг албажуулах
Баримт	Давж заалдах болон хяналтын журмаар гаргасан гомдол, эсэргүүцэл танилцуулсан, хүргүүлсэн
	Магадлал, тогтоол гардуулсан, танилцуулсан
	Мэдэгдэх хуудас
	Нөлөөллийн мэдүүлэг
	Хувийн баталгаа гаргах
	Хууль сануулж, эрх үүрэг тайлбарласан
	Хэргийг эмхэтгэсэн
	Хэрэг танилцуулсан
	Шийдвэрийг цахим санд байршуулахыг мэдэгдсэн
	Шийтгэх /цагаатгах/ тогтоол гардуулсан, танилцуулсан
	Шүүгчийн захирамж /шүүхийн тогтоол/
	Шүүх хуралдааны тов мэдэгдсэн
	Шүүх хуралдааны тов мэдэгдэж, танилцуулсан
	Шүүхэд дуудан ирүүлэх
	Эрх, үүрэг тайлбарлаж, хууль сануулсан
	Эрх, үүрэг танилцуулсан
	Ялтныг цагдан хорих төв /цагдан хорих байр/
	Ялтныг шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад хүлээлгэн өгсөн
Захирамж	Шүүх хуралдаан товлон зарлах
	Шүүх хуралдааны тов тогтоох
	Урьдчилсан хэлэлцүүлгийн тов тогтоох
	Хэргийг прокурорт буцаах
	Хэргийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэх
	Хялбаржуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх
	Шүүгдэгчийг албадан ирүүлж, шүүх хуралдааныг хойшлуулах тухай
	Шүүх хуралдаан хойшлуулах
	Шүүхийн шийдвэрийг задруулах
	Яллагдагчийг шүүхэд шилжүүлж, шүүх хуралдааны тов тогтоох
	Яллагдагчийг шүүхэд шилжүүлэх
Шүүх хуралдааны тэмдэглэл	
Шийтгэх тогтоол	
Тэмдэглэл	Утсаар ярьсан



	Хохирогч гомдол санал нэхэмжлэх зүйлгүй
	Эд мөрийн баримт хүлээлгэн өгсөн
	Эрүүгийн хариуцлага хүлээсэн хүний
	Ял шийтгэл
Албан бичиг	
Бүртгэл	Гүйцэтгэх хуудас хүлээлгэн өгсөн
Хүсэлт	Нөхцөл байдлыг минь харгалзан үзэж шийдэж өгнө үү
	Зорчих эрхийг хязгаарлах ялаар сольж өгнө үү
	Нотлох баримт хуулбарлах
	Өмгөөлөгчгүй оролцох
	Хуралд оролцох
	Хүсэлтийг зохих журмын дагуу шийдвэрлэж өгнө үү
	Хэргийг хялбаршуулсан журмаар шийдүүлэх
	Хялбаржуулсан журмаар шийдвэрлэх
	Шийтгэх тогтоолд залруулга хийлгэх
	Шүүх хуралдаан хойшлуулах
Дүгнэлт	Ял хөнгөрүүлэх
	Гэм буруутайд тооцох
	Гэм буруутайд тооцуулах
	Улсын яллагч
Магадлал	
Давах гомдол	
Прокурорын санал-хялбаржуулсан журмаар шийдвэрлэх	
Прокурорын эсэргүүцэл-захирамж хүчингүй болгох	

Иргэний хавтаст хэргийн материалд хийсэн шинжилгээний хүрээнд шүүхээс хийгддэг ажиллагааг дараах байдлаар ангилж шинжилгээ хийсэн.

ХАВСРАЛТ 3.

Ажиллагааны төрөл	Ажиллагааны задаргаа
Нэхэмжлэл	
Баримт	Нэхэмжлэлийн хувийг гардуулсан
	Давж заалдах болон хяналтын журмаар гаргасан гомдлыг танилцуулсан
	Хэргийн материал танилцуулсан
	Хяналтын журмаар гаргасан гомдлыг танилцуулсан
	Шинээр илэрсэн нөхцөл хянуулах хүсэлт танилцуулсан
	Шүүхийн шийдвэрийг цахим санд байршуулахыг мэдэгдсэн
	Гэрч асуух тов мэдэгдсэн
	Магадлал гардуулсан
	Магадлалыг цахим санд байршуулахыг мэдэгдэх тухай
	Нөлөөллийн мэдүүлэг танилцуулсан
	Улсын дээд шүүхийн ерөнхий шүүгчид гаргасан гомдлыг танилцуулсан
	Улсын дээд шүүхийн ерөнхий шүүгчид гаргасан гомдлыг хүлээн авсан
	Урьдчилсан хэлэлцүүлгийн тов мэдэгдсэн
	Үзлэгийн тов мэдэгдсэн
	Хавтаст хэргээс баримт, материал хассан
	Хэргийн материал танилцуулсан
	Хэргийн оролцогчдод эрх, үүрэг тайлбарласан
	Хэрэг эмхэтгэсэн
	Шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шүүхийн шийдвэрийг дахин хянуулах хүсэлт танилцуулсан
	Шүүгчийн захирамж шүүхийн тогтоолд гаргасан гомдол танилцуулах/ мэдэгдэх
	Шүүх хуралдааны товыг мэдэгдсэн
	Шүүхийн тогтоол шүүгчийн захирамж танилцуулж, гардуулсан
	Шүүхэд дуудан ирүүлэх
Албан бичиг	
Шүүгчийн захирамж	Гуравдагч этгээдээр татах
	Гэрчийг албадан ирүүлэх
	Захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлэх
	Захиргааны хэрэг үүсгэх
	Нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзаж, нэмэгдүүлсэн шаардлагад бүрдүүлбэр хангуулах хугацаа тогтоосон



	Улсын тэмдэгтийн хураамжаас чөлөөлөх, буцаан олгох
	Хамтран хариуцагчийг ХХША-нд татан оролцуулах
	Хариуцагчийг солих
	Хүсэлт хэрэгсэхгүй болгох
	Хүсэлт шийдвэрлэж, шүүх хуралдааныг хойшлуулах
	Хүсэлтийн зарим хэсгийг хэрэгсэхгүй болгож, шүүх хуралдаан хойшлуулах
	ХХША-г сэргээж, шүүх хуралдааныг товлон
	Хэргийг хэрэгсэхгүй болгож, нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах
	Хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцүүлэх
	Хэрэг нэгтгэх
	Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлэх
	Шинжээч томилж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлэх
	Шинжээчийг өөрчлөн томилох
	Шүүх хуралдааныг товлон зарлах
	Улсын тэмдэгтийн хураамжаас чөлөөлөх, буцаан олгох
	Шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгэх
	Хяналтын журмаар гомдол гаргаагүйд тооцох
	Шүүх хуралдаан хойшлуулах
	Давж заалдах гомдол гаргах хугацаа сэргээх
	Хяналтын журмаар гаргасан гомдлыг хүлээн авахаас татгалзах
	Эрх залгамжлагч солих
Ерөнхий шүүгчийн захирамж	Шүүх бүрэлдэхүүн болон даргалагчийг томилсон шүүхийн шийдвэрийг албажуулах
	Шүүгчийг татгалзан гаргах хүсэлтийг хэрэгсэхгүй болгох
Гомдол	Давж заалдах
	Хяналт
	УДШ Ерөнхий шүүгч
Нотлох баримт шаардсан	
Танхимын тэргүүний захирамж	Шүүх бүрэлдэхүүн томилох
Тэмдэглэл	Үзлэг хийсэн
	Утсаар ярьсан
	Иргэдийн төлөөлөгчийг баталгаажуулсан
	Гэрч асуусан
	Шинжээчээс тайлбар авсан
	Иргэдийн төлөөлөгч сонгосон
	Шинжээчийн дүгнэлт
	Хэргийн түүвэр
Хариу тайлбар	
Хүсэлт	Нэхэмжлэлийг буцаах
	Нэхэмжлэлийн шаардлага нэмэгдүүлэх
	Нэхэмжлэлийн шаардлага тодруулах
	Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хариуцагчаар орохоос татгалзах
	Тайлбар гаргах
	Хуралдаан хойшлуулах
	Шинжээч томилох
	Нэхэмжлэгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийг шүүх хуралдаанд оролцуулах
	Дахин шинжээч томилох
	Өмгөөлөгч авах
Урьдчилсан хэлэлцүүлгийн тэмдэглэл	
Шүүх хуралдааны тэмдэглэл	
Шүүхийн шийдвэр	
Магадлал	
Тогтоол	
Шүүхийн тогтоол	Шүүх хуралдаан хойшлуулах
	Анхан шатны шүүгчийн захирамжийг хянасан
	Хүсэлт хэрэгсэхгүй болгосон шүүгчийн захирамжийг хянасан
	Нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзаж, хэргийг хэрэгсэхгүй болгох
	Нэхэмжлэлийн бүрдүүлбэр хангуулах хугацаа тогтоох
	Хэргийг хэрэгсэхгүй болгож, нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан шүүгчийн захирамж
	Захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлж, хүсэлт шийдвэрлэсэн шүүгчийн захирамж



Шүүгчдийн зөвлөгөөний тогтоол	Шүүх хуралдааныг товлон зарлах
	Захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлсэн шүүгчийн захирамжийг хянасан
	Хэрэг хуваарилах
	Хэрэг хянан шийдвэрлэх хугацаа сунгах
	Хэрэг буцаан шилжүүлэх
	Хэрэг шилжүүлэн хуваарилах
	Шүүгчийн татгалзан гаргах хүсэлтийг хэрэгсэхгүй болгох шүүх хуралдааны хойшлуулах
	Хэрэг, нэхэмжлэл, хүсэлт шилжүүлэх
	Хэрэг, нэхэмжлэл, өргөдөл шилжүүлсэн
	Хугацаа сунгах
Гүйцэтгэх хуудас	

ХАВСРАЛТ 4.

Захиргааны хавтаст хэргийн материалд хийсэн шинжилгээний хүрээнд шүүхээс хийгддэг ажиллагааг дараах байдлаар ангилж шинжилгээ хийсэн.



Ажиллагаа төрөл	Ажиллагааны задаргаа
Баримт	Шүүх хуралдааны тов мэдэгдсэн
	Гуравдагч этгээдийн нэхэмжлэлийн хувийг нэхэмжлэгчид гардуулсан
	Гэрч, шинжээч, орчуулагч, хэлмэрчид эрх үүрэг тайлбарласан
	Зохигч гуравдагч этгээд, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгчид эрх үүрэг тайлбарласан
	Иргэдийн төлөөлөгчид хэрэг танилцуулсан
	Иргэдийн төлөөлөгчид эрх, үүрэг тайлбарласан
	Магадлал, тогтоолыг хэргийн оролцогчдод гардуулсан буюу хүргүүлсэн
	Нөлөөллийн мэдүүлэг танилцуулсан
	Нэхэмжлэл гардуулсан
	Нэхэмжлэлийн хувийг гуравдагч этгээдэд гардуулсан
	Сөрөг нэхэмжлэлийн шаардлагыг гардуулсан
	Тогтоолыг хэргийн оролцогчдод гардуулсан буюу хүргүүлсэн
	Хэргийн оролцогчдод хэргийн материал танилцуулсан
	Хэрэг танилцуулсан
	Хэрэг хөтлөх, эмхлэх
	Шийдвэрийг цахим санд байршуулахыг мэдэгдсэн
	Шүүгчийн захирамж, шүүхийн тогтоолд гаргасан гомдлыг хэргийн оролцогчид танилцуулсан
	Шүүгчийн захирамж, шүүхийн тогтоолыг мэдэгдсэн буюу гардуулсан
	Шүүх хуралдаанд дуудан ирүүлэх
	Шүүхийн шийдвэр хэргийн оролцогчдод гардуулсан, хүргүүлсэн
	Давж заалдах болон хяналтын журмаар гаргасан гомдлыг танилцуулсан
	Сөрөг нэхэмжлэлийн нэмэгдүүлсэн хувийг нэхэмжлэгчид гардуулсан
	Хариуцагчид нэхэмжлэл гардуулсан
Тэмдэглэл	Ярианы бичлэг буулгасан
	Үйл явдлыг бичсэн
	Дуу дүрсний бичлэг
	Үзлэг хийсэн
	Эвлэрүүлэн зуучлах ажиллагаа дуусгавар болсон
	Гэрчээр асуусан
	Хэрэг хүлээлцсэн
	Утсаар ярьсан
	Нотлох баримт хүлээлгэж өгсөн
	Иргэдийн төлөөлөгчийг баталгаажуулсан
Захирамж	Ажиллагааг сэргээн явуулах
	Гэрлэгчдэд эвлэрүүлэх арга хэмжээ авч, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлэх
	Давж заалдах гомдол гаргах хугацаа сэргээх
	Нотлох баримт гаргуулах
	Нотлох баримт гаргуулж, шүүх хуралдаан хойшлуулах
	Нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах
	Улсын тэмдэгтийн хураамж буцаан олгох
	Улсын тэмдэгтийн хураамжаас чөлөөлөх
	Хариуцагчийг албадан ирүүлэх
	Хүсэлт хянан шийдвэрлэх
	Хүсэлт шийдвэрлэж, шүүх хуралдааныг хойшлуулах
	Хүсэлт шийдвэрлэж нотлох баримт гаргуулах
	Хүсэлт шийдвэрлэж, шүүхээс гарах шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах
	Хүсэлт шийдвэрлэн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлэх
	Хүсэлтийг хангахаас татгалзах
	Хэргийг хэрэгсэхгүй болгох
	Хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцүүлэх
	Хэрэг үүсгэх
	Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг сэргээх
	Шийдвэр гүйцэтгэх ажиллагааг түдгэлзүүлэх
	Шинжээч томилж хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлэх
	Шүүгчээс татгалзсан хүсэлтийг шийдвэрлүүлэхээр шүүх хуралдааныг хойшлуулах
	Шүүх хуралдааны тов өөрчлөх
	Шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгэх
	Шүүхээс гарах шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах



	Шүүхээс татгалзсан хүсэлт шийдвэрлүүлэхээр шүүх хуралдааныг хойшлуулах
	Даалгавар гүйцэтгүүлж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлэх
	Захирамжид өөрчлөлт оруулах
	Нэхэмжлэлийг буцаах
	Өөр шүүхэд шилжүүлэх
	Хүсэлт хангахаас татгалзах
	Хүсэлтийг хэсэгчлэн хангах тухай
	Хэргийн харьяалал тогтоолгох
	Шийдвэр гүйцэтгэх ажиллагааг түдгэлзүүлж, шүүх хуралдааны тов тогтоох
Ерөнхий шүүгч, танхимын тэргүүний захирамж	Ерөнхий шүүгчийг түр орлох шүүгч томилох
	Хэргийн харьяалал тогтоох
	Шүүх бүрэлдэхүүн даргалагч, шүүх бүрэлдэхүүнийг томилсон шийдвэрийг албажуулах
	Шүүх хуралдааны бүрэлдэхүүн томилсон шийдвэрийг албажуулах
Шүүгчдийн зөвлөгөөний тогтоол	Шүүгчийн татгалзан гарах хүсэлтийг шийдвэрлэх
	Хугацаа сунгах
Шүүхийн тогтоол – анхан шат	Хэрэг шилжүүлэх
	Гомдол хянан шийдвэрлэх
	Хүсэлт шийдвэрлэж, шүүх хуралдааныг хойшлуулах
	Шинжээч томилж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлэх
	Шүүх хуралдааныг товлох
	Шүүх хуралдааныг үргэлжлүүлэх
	Шүүх хуралдааныг хойшлуулах
	Шүүх хуралдааныг хойшлуулж, нотлох баримт гаргуулах
Шүүхийн тогтоол – давж заалдах шат	Шүүхийн бүх шүүгчдээс татгалзсан хүсэлт шийдвэрлэх
	Шүүх хуралдаан хойшлуулах
Хяналтын шат	Хүсэлт хэрэгсэхгүй болгох
	Тогтоол
Хүсэлт	Гомдол гаргах хугацаа сэргээлгэх
	Гуравдагч этгээдээр оролцуулах
	Гэрч асуух
	Гэрч дахин асуулгах
	Гэрч оролцуулах
	Гэрчээр асуухаас татгалзах
	Данс битүүмжлэх
	Залруулга хийлгэх
	Зарим хариуцагчаас татгалзах
	Итгэмжлэгдсэн төлөөлөгч оролцуулах
	Итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр дамжуулан шүүх хуралдаанд оролцох
	Итгэмжлэгдсэн төлөөлөгчөөс татгалзаж, өөрийн биеэр оролцох
	Итгэмжлэлээс татгалзах
	Нотлох баримт /эмнэлгийн карт/ буцаан авах
	Нотлох баримт гаргуулах
	Нотлох баримт гаргуулах, гэрчээр асуух
	Нотлох баримт гаргуулах, шинжээч томилуулах
	Нотлох баримтаар гаргасан өгсөн материалын эх хувийг авах
	Нотлох баримтын шаардлага хангасан хэлбэрээр гаргуулах
	Нэмэлт тодруулга хүсэх
	Нэхэмжлэгчээр оролцуулах
	Нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах
	Нэхэмжлэлийн шаардлага тодруулсан
	Нэхэмжлэлийн шаардлагын зарим хэсгээс татгалзах
	Өмгөөлөгч авах
	Өмгөөлөгч оролцуулах
	Өмгөөлөгчгүй оролцох
	Тус шүүхийн бүх шүүгчдээс татгалзах
	Улсын тэмдэгт төлөх хугацааг хойшлуулах
	Улсын тэмдэгтийн хураамжаас чөлөөлүүлэх
	Үзлэг хийлгэх
	Хамтран хариуцагч татах
	Хариуцагчийг албадан ирүүлэх
	Хариуцагчийн хүсэлтийг хангахгүй орхиж, хэргийг шуурхай хянан шийдвэрлүүлэх
	Харьяаллын шүүхэд хэрэг шилжүүлэх



	Хуралд оролцох боломжгүй, хуульд заасан журмын дагуу шийдэх
	Хуулийн этгээдийн лавлагаа гаргуулах
	Хүүхдийн санал асуулгах
	Хэрэгт оролцохоос татгалзах
	Шийдвэрийг албадан гүйцэтгүүлэх
	Шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах
	Шинжээч дахин томилуулах
	Шинжээч томилуулах, нотлох баримт гаргуулах
	Шүүгчээс татгалзах
	Шүүх ажиллагаанд оролцох боломжгүй болсон
	Шүүх хуралдаанд өмгөөлөгчтэй оролцох
	Шүүх хуралдааны товыг урагшлуулах
	Шүүхийн гүйцэтгэх хуудас бичүүлэх
	Шүүхээс татгалзсан хүсэлтээсээ татгалзах
	Эвлэрлийн гэрээ байгуулах боломж олгох
	Эд хөрөнгө битүүмжлэх
	Асрамж, хамгаалалтад байлгах урьдчилсан арга хэмжээ авах
	Аудитын дүгнэлт гаргуулах
	Үйл ажиллагаа явуулах эрхийг нээлгэх
	Үйл ажиллагаанд саад учруулж байгаа тул, хамгаалалтын ажилчдыг татан буулгаж өгөх
	Харьяалал тогтоолгох
	Хөрөнгийн дэлгэрэнгүй үнэлгээ хийлгүүлэх
	Хөрөнгө битүүмжлэх
	Хүсэлт хүлээн авч шийдвэрлэхдээ хасаж шийдвэрлэх
	Хүүхдүүдтэй уулзах бололцоогоор хангах
	Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түр хойшлуулах
	Эд хөрөнгөд халдахгүй байх, бүтцийг өөрчлөхгүй байх, зүй бусаар харьцахгүй байх
Тайлбар	Гомдолд гаргасан
	Нотлох баримттай холбоотой
	Нэхэмжлэгчийн гаргасан хүсэлттэй холбоотой
	Нэхэмжлэлийн шаардлагыг тодруулах
	Прокурор
	Хүсэлтийг тодруулах
Дүгнэлт	Гомдлын нэмэлт
	Шинжээч

**ХАВСРАЛТ 5.**

Шүүгчийн ажлын ачаалал тооцох судалгааны үр дүнгийн тооцооллоор АШШ-д нийт 130 шүүгч шаардлагатай, ДЗШШ-д нийт 12 шүүгч илүүдэлтэй байна.

Тайлбар: Ажлын цагаар тооцсон шаардлагатай шүүгчийн тоог олохдоо нэг шүүгчийн нэг ажлын өдрийн ачааллаас ажлын 8 цагийг хассан ялгаврыг ШЕЗ-ийн хэргийн хөдөлгөөний хэлтсээс гаргаж өгсөн 2022 онд ажиллаж буй шүүгчийн тоогоор үржүүлж ажлын 8 цагт хувааж олсон болно.

Шүүгчийн ажлын ачаалал тооцох нь, судалгааны дүнгээр

№	Шүүх	Хянан шийдвэрлэсэн хэргийн тоо, журмаар /2017-2021 оны дунджаар/		Хэргийн дүн	Шүүгчийн тоо /2017-2021 оны дунджаар/	Ажлын ачаалал, цагаар /2017-2021 оны дунджаар/		Нэг шүүгчийн нэг ажлын өдрийн ачаалал, цагаар	Ажлын цагаар тооцсон шаардлагатай шүүгчийн тоо
		Хялбар-шуулсан	Ердийн			Хялбар-шуулсан	Ердийн		
1	Баянзүрх	644.8	949.4	1594.2	9.6	2.3	11.2	13.5	8
2	Сүхбаатар	337.4	559.6	897	6.5	1.8	9.7	11.4	3
3	Чингэлтэй	242.2	594.6	836.8	6.2	1.3	10.8	12.1	4
4	Баянгол	227.2	678.6	905.8	7.6	1.0	10.0	11.0	4
5	Хан-Уул	153	502.6	655.6	6.0	0.9	9.5	10.4	2
6	Сонгинохайрхан	246.4	862.6	1109	8.2	1.0	11.9	12.9	6
Дундаж		-	-	-	-	1.4	10.5	11.9	-
Дүн		1851	4147	5998	44.0	-	-	-	27

Хүснэгт В.1 Төвийн дүүргийн ЭХАШШ-ийн нэг шүүгчийн ачаалал, судалгааны дүнгээр

№	Шүүх	Хэргийн дүн /2017-2021 оны дунджаар/	Шүүгчийн тоо /2017-2021 оны дунджаар/	Нэг шүүгчийн нэг ажлын өдрийн ачаалал, цагаар	Ажлын цагаар тооцсон шаардлагатай шүүгчийн тоо
1	Баянзүрх	2606.8	1	37.7	4
2	Сүхбаатар	1027.0	1	14.8	1
3	Чингэлтэй	866.5	1	12.5	1
4	Баянгол	1124.3	1	16.3	1
5	Хан-Уул	1242.3	1	18.0	1
6	Сонгинохайрхан	1471.8	1	21.3	2
Дундаж		-	-	20.1	-
Дүн		8339	6	-	10

Хүснэгт В.2 Төвийн дүүргийн ЭХАШ-ийн зөрчлийн хэргийн нэг шүүгчийн ачаалал, судалгааны дүнгээр

№	Шүүх	Хянан шийдвэрлэсэн хэргийн тоо, журам ба бусад /2017-2021 оны дунджаар/			Шүүгчийн тоо /2017-2021 оны дунджаар/	Ажлын ачаалал, цагаар /2017-2021 оны дунджаар/			Нэг шүүгчийн нэг ажлын өдрийн ачаалал, цагаар	Ажлын цагаар тооцсон шаардлагатай шүүгчийн тоо
		Хялбар-шуулсан	Ердийн	Зөрчил		Хялбар-шуулсан	Ердийн	Зөрчил		
1	Багануур	55.8	67.2	241	3.3	0.6	2.3	1.2	4.0	-2
2	Багахангай	7.4	28	23	1.0	0.3	3.2	0.3	3.8	-2
3	Налайх	60.5	131.25	155	2.7	0.8	5.4	0.7	6.9	-1
Дундаж		-	-	-	-	0.5	3.7	0.6	4.9	-
Дүн		124	226	419	7	-	-	-	-	-5

Хүснэгт В.3 Захын дүүргийн ЭХШ-ийн нэг шүүгчийн ачаалал, судалгааны дүнгээр

№	Шүүх	Хянан шийдвэрлэсэн хэргийн тоо, журам ба бусад /2017-2021 оны дунджаар/			Шүүгчийн тоо /2017-2021 оны дунджаар/	Ажлын ачаалал, цагаар /2017-2021 оны дунджаар/			Нэг шүүгчийн нэг ажлын өдрийн ачаалал, цагаар	Ажлын цагаар тооцсон шаардлагатай шүүгчийн тоо
		Хялбар-шуулсан	Ердийн	Зөрчил		Хялбар-шуулсан	Ердийн	Зөрчил		
1	Архангай	72	187	428	3.0	0.8	7.1	2.1	10.0	1
2	Баян-Өлгий	81	103	341	3.1	0.9	3.7	1.6	6.2	-1
3	Баянхонгор	100	223	570	3.2	1.1	8.0	2.6	11.6	1



4	Булган	93	129	417	2.7	1.2	5.3	2.2	8.6	0
5	Говь-Алтай	53	62	240	3.0	0.6	2.3	1.2	4.1	-1
6	Говьсүмбэр	48	51	167	2.7	0.6	2.1	0.9	3.6	-2
7	Дархан-Уул	134	295	373	4.5	1.0	7.3	1.2	9.5	1
8	Дорноговь	56	117	213	2.7	0.7	4.8	1.1	6.6	-1
9	Дорнод	135	212	421	2.7	1.7	8.7	2.2	12.6	2
10	Дундговь	44	74	156	2.7	0.5	3.1	0.8	4.4	-1
11	Завхан	67	50	209	2.9	0.8	1.9	1.0	3.8	-2
12	Орхон	118	261	1014	3.9	1.0	7.6	3.8	12.4	2
13	Өмнөговь	63	100	221	3.0	0.7	3.8	1.1	5.6	-1
14	Өвөрхангай	73	135	1013	2.8	0.9	5.4	5.2	11.6	1
15	Сүхбаатар	103	110	267	2.7	1.3	4.6	1.4	7.3	0
16	Сэлэнгэ	59	148	184	2.5	0.8	6.8	1.1	8.7	0
17	Төв	115	323	668	4.6	0.8	7.9	2.1	10.9	2
18	Увс	74	117	390	2.7	0.9	4.8	2.1	7.8	0
19	Ховд	100	86	362	2.6	1.3	3.7	2.0	7.0	0
20	Хөвсгөл	135	225	510	3.6	1.3	7.1	2.1	10.4	1
21	Хэнтий	62	175	515	2.4	0.9	8.1	3.0	12.0	1
Дундаж		-	-	-	-	0.9	5.4	1.9	8.3	-
Дүн		1786	3183	8676	64.1	-	-	-	-	2

Хүснэгт В.4 Аймгийн ЭХАШШ-ийн нэг шүүгчийн ачаалал, судалгааны дүнгээр

№	Шүүх	Хянан шийдвэрлэсэн эрүүгийн хэргийн тоо, журам ба бусад /2017-2021 оны дунджаар/			Хянан шийдвэрлэсэн иргэний хэргийн тоо, журам ба бусад /2017-2021 оны дунджаар/				Шүүгчийн тоо /2017-2021 оны дунджаар/
		Хялбар-шуулсан	Ердийн	Зөрчил	Хялбар-шуулсан	Ердийн	Бага үнийн дүн	Хэрэгсэхгүй болгосон	
1	Замын-Үүд	55	82	155	86	106	137	5	4
2	Тосонцэнгэл	37	19	177	46	232	68	12	2.8
3	Ханбогд	51	90	151	36	90	46	9	4
4	Хархорин	30	67	395	77	268	101	12	3
5	Мандал	44	110	239	109	112	227	14	4
6	Сайхан	23	53	101	45	44	116	10	3.7
7	Булган	26	45	184	51	195	60	0	2.7
8	Бор-Өндөр	32	28	118	54	52	103	4	3
Дүн		298	494	1520	504	1099	858	66	27.2

Хүснэгт В.5 Сум дундын шүүхэд хянан шийдвэрлэсэн хэргийн тоо

№	Шүүх	Хянан шийдвэрлэсэн эрүүгийн хэргийн тоо, журам ба бусад /2017-2021 оны дунджаар/				Хянан шийдвэрлэсэн иргэний хэргийн тоо, журам ба бусад /2017-2021 оны дунджаар/					Нэг шүүгчийн нэг ажлын өдрийн ачаалал, цагаар	Ажлын цагаар тооцсон шаардлагатай шүүгчийн тоо
		Хялбар-шуулсан	Ердийн	Зөрчил	Дүн	Хялбар-шуулсан	Ердийн	Бага үнийн дүн	Хэрэгсэхгүй болгосон	Дүн		
1	Замын-Үүд	0.5	2.3	0.6	3.3	0.6	1.9	1.5	0.0	4.0	7.3	0
2	Тосонцэнгэл	0.4	0.7	0.8	2.0	0.4	5.3	1.0	0.1	6.9	8.8	0
3	Ханбогд	0.5	2.9	0.6	4.1	0.3	1.8	0.6	0.1	2.8	6.9	-1
4	Хархорин	0.3	2.4	1.8	4.6	0.7	6.0	1.4	0.1	8.3	12.8	2
5	Мандал	0.4	3.5	1.0	4.9	0.9	2.2	2.8	0.1	6.0	10.9	1
6	Сайхан	0.2	1.7	0.4	2.3	0.4	0.9	1.4	0.1	2.7	5.0	-1
7	Булган	0.3	1.7	0.9	2.9	0.5	4.6	0.9	0.0	6.0	9.0	0
8	Бор-Өндөр	0.4	1.1	0.6	2.1	0.5	1.3	1.6	0.0	3.5	5.6	-1
Дундаж		0.4	2.1	0.8	3.3	0.5	3.0	1.4	0.1	5.0	8.3	-
Дүн		-	-	-	-	-	-	-	-	-	-	0

Хүснэгт В.6 Сум дундын шүүхийн нэг шүүгчийн ачаалал, судалгааны дүнгээр

№	Шүүх	Хянан шийдвэрлэсэн иргэний хэргийн тоо, журам ба бусад /2017-2021 оны дунджаар/				Шүүгчийн тоо /2017-2021 оны дунджаар/	Ажлын ачаалал, цагаар /2017-2021 оны дунджаар/				Нэг шүүгчийн нэг ажлын өдрийн ачаалал, цагаар	Ажлын цагаар тооцсон шаардлагатай шүүгчийн тоо
		Хялбар-шуулсан	Ердийн	Бага үнийн дүн	Хэрэгсэхгүй болгосон		Хялбар-шуулсан	Ердийн	Бага үнийн дүн	Хэрэгсэхгүй болгосон		
1	Баянзүрх	751	1053	2259	1546	16.4	1.3	4.5	6.0	2.7	14.5	14
2	Сүхбаатар	553	1213	1091	844	11.5	1.4	7.4	4.1	2.1	15.0	9
3	Чингэлтэй	498	1088	1077	707	11.8	1.2	6.5	4.0	1.7	13.4	8
4	Баянгол	698	966	1991	661	14.4	1.4	4.7	6.1	1.3	13.4	10
5	Хан-Уул	650	976	1379	938	11.0	1.7	6.2	5.5	2.4	15.8	11
6	Сонгино хайрхан	547	575	2180	803	12.0	1.3	3.4	8.0	1.9	14.5	11



Дундаж	-	-	-	-	-	1.4	5.4	5.6	2.0	14.4	-
Дүн	3697	5871	9976	5500	77.2	-	-	-	-	-	63

Хүснэгт В.7 Төвийн дүүргийн ИХАШШ-ийн нэг шүүгчийн ачаалал, судалгааны дүнгээр

№	Шүүх	Хянан шийдвэрлэсэн иргэний хэргийн тоо, журам ба бусад /2017-2021 оны дунджаар/				Шүүгчийн тоо /2017-2021 оны дунджаар/	Ажлын ачаалал, цагаар /2017-2021 оны дунджаар/				Нэг шүүгчийн нэг ажлын өдрийн ачаалал, цагаар	Ажлын цагаар тооцсон шаардлагатай шүүгчийн тоо
		Хялбаршуулсан	Ердийн	Бага үнийн дүн	Хэрэгсэхгүй болгосон		Хялбаршуулсан	Ердийн	Бага үнийн дүн	Хэрэгсэхгүй болгосон		
1	Багануур	94	65	364	17.6	3.4	0.8	1.3	4.7	0.1	7.0	0
2	Багахангай	11	6	19	4.5	1.0	0.3	0.4	0.8	0.1	1.7	-1
3	Налайх	103	74	272	45	3.1	0.9	1.7	3.9	0.4	6.9	0
Дундаж		-	-	-	-	-	0.7	1.1	3.1	0.2	5.2	-1
Дүн		208	145	655	67	7.5	-	-	-	-	-	-1

Хүснэгт В.8 Захын дүүргийн ИХШ-ийн нэг шүүгчийн ачаалал, судалгааны дүнгээр

№	Шүүх	Хянан шийдвэрлэсэн иргэний хэргийн тоо, журам ба бусад /2017-2021 оны дунджаар/				Шүүгчийн тоо /2017-2021 оны дунджаар/	Ажлын ачаалал, цагаар /2017-2021 оны дунджаар/				Нэг шүүгчийн нэг ажлын өдрийн ачаалал, цагаар	Ажлын цагаар тооцсон шаардлагатай шүүгчийн тоо
		Хялбаршуулсан	Ердийн	Бага үнийн дүн	Хэрэгсэхгүй болгосон		Хялбаршуулсан	Ердийн	Бага үнийн дүн	Хэрэгсэхгүй болгосон		
1	Архангай	103	613	155	63	2.8	1.1	15.3	2.4	0.6	19.5	4
2	Баян-Өлгий	191	478	281	24	4.0	1.4	8.4	3.1	0.2	13.0	2
3	Баянхонгор	158	678	175	16	2.9	1.6	16.3	2.6	0.2	20.6	5
4	Булган	135	446	174	25	2.6	1.5	11.8	2.9	0.3	16.5	3
5	Говь-Алтай	68	418	129	18	2.7	0.7	10.9	2.1	0.2	13.9	2
6	Говьсүмбэр	31	35	149	2	2.7	0.3	0.9	2.4	0.0	3.7	-2
7	Дархан-Уул	244	449	613	90	4.2	1.6	7.4	6.3	0.6	16.0	5
8	Дорноговь	92	198	138	29	2.9	0.9	4.7	2.1	0.3	8.0	0
9	Дорнод	228	195	627	84	3.8	1.7	3.6	7.2	0.6	13.1	3
10	Дундговь	72	449	129	21	2.8	0.7	11.1	2.0	0.2	14.0	2
11	Завхан	99	473	92	2	2.9	1.0	11.4	1.4	0.0	13.8	2
12	Орхон	224	494	671	212	5.0	1.3	7.0	5.9	1.2	15.4	5
13	Өмнөговь	104	267	100	30	2.7	1.1	7.0	1.7	0.3	10.1	1
14	Өвөрхангай	139	485	137	40	2.6	1.5	13.1	2.3	0.4	17.4	4
15	Сүхбаатар	111	355	126	8	2.9	1.1	8.7	1.9	0.1	11.8	1
16	Сэлэнгэ	115	178	333	34	3.7	0.9	3.4	3.9	0.3	8.4	0
17	Төв	230	865	252	86	4.4	1.5	13.7	2.5	0.6	18.3	6
18	Увс	159	403	193	48	2.8	1.6	10.2	3.1	0.5	15.4	2
19	Ховд	130	376	228	42	2.8	1.3	9.5	3.6	0.4	14.8	3
20	Хөвсгөл	267	1114	213	83	5.5	1.4	14.3	1.7	0.4	17.8	7
21	Хэнтий	159	339	265	35	2.6	1.8	9.1	4.5	0.4	15.7	3
Дундаж		-	-	-	-	-	1.2	9.4	3.1	0.4	14.2	-
Дүн		3059	9308	5180	992	69.3	-	-	-	-	-	58

Хүснэгт В.9 Аймгийн ИХАШШ-ийн нэг шүүгчийн ачаалал, судалгааны дүнгээр

№	Шүүх	Хянан шийдвэрлэсэн иргэний хэргийн тоо, журам ба бусад /2017-2021 оны дунджаар/				Шүүгчийн тоо /2017-2021 оны дунджаар/	Ажлын ачаалал, цагаар /2017-2021 оны дунджаар/			Нэг шүүгчийн нэг ажлын өдрийн ачаалал, цагаар	Ажлын цагаар тооцсон шаардлагатай шүүгчийн тоо
		Хялбаршуулсан	Ердийн	Хэрэгсэхгүй болгосон	Дүн		Хялбаршуулсан	Ердийн	Хэрэгсэхгүй болгосон		
1	Нийслэл	205	689	101	995	18.5	1.7	9.9	0.8	12.4	10

Хүснэгт В.10 НЗХАШШ-ийн нэг шүүгчийн ачаалал, судалгааны дүнгээр

№	Шүүх	Хянан шийдвэрлэсэн иргэний хэргийн тоо, журам ба бусад /2017-2021 оны дунджаар/				Шүүгчийн тоо /2017-2021 оны дунджаар/	Ажлын ачаалал, цагаар /2017-2021 оны дунджаар/			Нэг шүүгчийн нэг ажлын өдрийн ачаалал, цагаар	Ажлын цагаар тооцсон шаардлагатай шүүгчийн тоо
		Хялбаршуулсан	Ердийн	Хэрэгсэхгүй болгосон	Дүн		Хялбаршуулсан	Ердийн	Хэрэгсэхгүй болгосон		
1	Архангай	14	23	3	40	2.2	1.0	2.8	0.2	4.0	-1
2	Баян-Өлгий	25	52	1	78	2.9	1.3	4.7	0.1	6.1	-1
3	Баянхонгор	14	18	2	34	3.0	0.7	1.6	0.1	2.4	-2
4	Булган	15	9	1	26	2.0	1.1	1.2	0.1	2.4	-1



5	Говь-Алтай	9	21	2	32	1.7	0.8	3.2	0.2	4.2	-1
6	Говьсүмбэр	3	11	1	15	2.1	0.2	1.5	0.1	1.7	-2
7	Дархан-Уул	11	24	2	37	3.0	0.5	2.1	0.1	2.7	-2
8	Дорноговь	8	16	1	25	2.9	0.4	1.5	0.1	2.0	-2
9	Дорнод	13	14	2	29	2.1	1.0	1.7	0.1	2.8	-1
10	Дундговь	15	11	2	28	2.2	1.0	1.3	0.1	2.5	-1
11	Завхан	9	28	1	39	3.0	0.5	2.5	0.1	3.0	-2
12	Орхон	8	25	1	34	3.0	0.4	2.2	0.1	2.7	-2
13	Өмнөговь	9	17	1	27	2.6	0.5	1.7	0.1	2.3	-2
14	Өвөрхангай	5	14	1	20	2.8	0.3	1.3	0.0	1.7	-2
15	Сүхбаатар	11	22	1	35	3.0	0.6	2.0	0.1	2.6	-2
16	Сэлэнгэ	14	17	2	33	2.8	0.8	1.7	0.1	2.5	-2
17	Төв	15	29	2	46	3.0	0.7	2.5	0.1	3.4	-2
18	Увс	7	37	3	47	2.1	0.5	4.7	0.2	5.4	-1
19	Ховд	13	29	4	46	2.8	0.7	2.7	0.2	3.6	-2
20	Хөвсгөл	7	22	3	32	2.0	0.6	2.9	0.2	3.7	-1
21	Хэнтий	9	9	0	18	2.8	0.5	0.8	0.0	1.3	-2
Дундаж		-	-	-	-	-	0.7	2.2	0.1	3.0	-
Дүн		234	448	36	721	53.9	-	-	-	-	-34

Хүснэгт В.11 Аймгийн ЗХШ-ийн нэг шүүгчийн ачаалал, судалгааны дүнгээр

№	Шүүх	Хянан шийдвэрлэсэн хэргийн тоо /2017-2021 оны дунджаар/		Шүүгчийн тоо /2017-2021 оны дунджаар/	Ажлын ачаалал, цагаар /2017-2021 оны дунджаар/		Нэг шүүгчийн нэг ажлын өдрийн ачаалал, цагаар	Ажлын цагаар тооцсон шаардлагатай шүүгчийн тоо
		Эрүү	Зөрчил		Эрүү	Зөрчил		
1	Нийслэл	1053	160	13.4	10.7	0.7	11.4	7

Хүснэгт В.12 НЭХДЗШ-ийн нэг шүүгчийн ачаалал, судалгааны дүнгээр

№	Шүүх	Хянан шийдвэрлэсэн иргэний хэргийн тоо /2017-2021 оны дунджаар/	Шүүгчийн тоо /2017-2021 оны дунджаар/	Нэг шүүгчийн нэг ажлын өдрийн ачаалал, цагаар	Ажлын цагаар тооцсон шаардлагатай шүүгчийн тоо
1	Нийслэл	2312	14.7	8.5	1

Хүснэгт В.13 НИХДЗШ-ийн нэг шүүгчийн ачаалал, судалгааны дүнгээр

№	Шүүх	Хянан шийдвэрлэсэн иргэний хэргийн тоо /2017-2021 оны дунджаар/	Шүүгчийн тоо /2017-2021 оны дунджаар/	Нэг шүүгчийн нэг ажлын өдрийн ачаалал, цагаар	Ажлын цагаар тооцсон шаардлагатай шүүгчийн тоо
1	Нийслэл	742	11.7	15.8	14

Хүснэгт В.14 ЗХДЗШШ-ийн нэг шүүгчийн ачаалал, судалгааны дүнгээр

№	Шүүх	Хянан шийдвэрлэсэн хэргийн тоо /2017-2021 оны дунджаар/			Шүүгчийн тоо /2017-2021 оны дунджаар/	Ажлын ачаалал, цагаар /2017-2021 оны дунджаар/			Нэг шүүгчийн нэг ажлын өдрийн ачаалал, цагаар	Ажлын цагаар тооцсон шаардлагатай шүүгчийн тоо
		Эрүү	Зөрчил	Иргэн		Эрүү	Зөрчил	Иргэн		
1	Архангай	40	11	27	3.0	1.8	0.2	0.5	2.5	-2
2	Баян-Өлгий	30	12	103	2.7	1.5	0.3	2.1	3.9	-1
3	Баянхонгор	75	10	30	2.5	4.1	0.2	0.7	5.0	0
4	Булган	41	8	23	2.6	2.1	0.2	0.5	2.8	-1
5	Говь-Алтай	25	12	32	3.0	1.1	0.2	0.6	1.9	-2
6	Говьсүмбэр	22	3	20	3.0	1.0	0.0	0.4	1.4	-2
7	Дархан-Уул	72	14	-	3.0	3.3	0.6	-	3.9	-1
	Дархан-Уул	-	-	127	3.1	-	-	2.2	2.2	-1
8	Дорноговь	60	12	35	3.0	2.7	0.3	0.6	3.6	-2
9	Дорнод	38	8	34	2.9	1.7	0.1	0.6	2.5	-1
10	Дундговь	19	4	25	2.8	0.9	0.1	0.5	1.5	-2
11	Завхан	21	12	30	3.0	1.0	0.2	0.5	1.7	-2
12	Орхон	78	21	-	3.0	3.5	0.4	-	3.9	-2
	Орхон	-	-	151	3.0	-	-	2.8	2.8	-2
13	Өмнөговь	59	7	31	2.6	3.1	0.2	0.7	3.9	-1
14	Өвөрхангай	40	8	29	2.8	1.9	0.2	0.6	2.7	-1
15	Сүхбаатар	27	4	17	3.1	1.2	0.1	0.3	1.6	-2
16	Сэлэнгэ	69	28	57	2.9	3.2	0.6	1.1	4.8	-1
17	Төв	76	5	33	4.0	2.6	0.1	0.4	3.1	-2
18	Увс	33	9	26	2.6	1.7	0.2	0.6	2.5	-2
19	Ховд	39	17	53	2.7	2.0	0.4	1.0	3.3	-1



20	Хөвсгөл	40	17	32	2.9	1.9	0.3	0.6	2.8	-2
21	Хэнтий	39	15	25	2.3	2.3	0.4	0.6	3.3	-1
Дундаж		-	-	-	-	2.1	0.3	0.9	2.9	-
Дүн		943	237	940	66.5	-	-	-	-	-34

Хүснэгт В.15 Аймгийн ДЗШШ-ийн нэг шүүгчийн ачаалал, судалгааны дүнгээр

Хүснэгт С бүлгийн тооцоо судалгааны багийн санал болгох дүнгээр тооцсон тооцоолол бөгөөд санал болгох дүнгээр АШШ-д нийт 76 шүүгч нэмж, ДЗШШ-ээс 2 шүүгч хасч ажиллуулснаар шүүгчийн ачаалал хэвийн болохоор байна.

Шүүгчийн ажлын ачаалал тооцох нь, санал болгох дүнгээр

№	Шүүх	Хянан шийдвэрлэсэн хэргийн тоо, журмаар /2017-2021 оны дунджаар/		Хэргийн дүн	Шүүгчийн тоо /2017-2021 оны дунджаар/	Ажлын ачаалал, цагаар /2017-2021 оны дунджаар/		Нэг шүүгчийн нэг ажлын өдрийн ачаалал, цагаар	Ажлын цагаар тооцсон шаардлагатай шүүгчийн тоо
		Хялбар-шуулсан	Ердийн			Хялбар-шуулсан	Ердийн		
1	Баянзүрх	644.8	949.4	1594.2	9.6	2.3	11.4	13.7	9
2	Сүхбаатар	337.4	559.6	897	6.5	1.8	9.8	11.6	4
3	Чингэлтэй	242.2	594.6	836.8	6.2	1.4	11.0	12.3	4
4	Баянгол	227.2	678.6	905.8	7.6	1.0	10.2	11.2	4
5	Хан-Уул	153	502.6	655.6	6.0	0.9	9.7	10.5	2
6	Сонгинохайрхан	246.4	862.6	1109	8.2	1.0	12.1	13.1	6
Дундаж		-	-	-	-	1.4	10.7	12.1	-
Дүн		1851	4147	5998	44.0	-	-	-	29

Хүснэгт С.1 Төвийн дүүргийн ЭХАШШ-ийн нэг шүүгчийн ачаалал, санал болгох дүнгээр

№	Шүүх	Хэргийн дүн /2017-2021 оны дунджаар/	Шүүгчийн тоо /2017-2021 оны дунджаар/	Нэг шүүгчийн нэг ажлын өдрийн ачаалал, цагаар	Ажлын цагаар тооцсон шаардлагатай шүүгчийн тоо
1	Баянзүрх	2606.8	1	28.6	3
2	Сүхбаатар	1027.0	1	11.3	0
3	Чингэлтэй	866.5	1	9.5	0
4	Баянгол	1124.3	1	12.4	1
5	Хан-Уул	1242.3	1	13.7	1
6	Сонгинохайрхан	1471.8	1	16.2	1
Дундаж		-	-	15.3	-
Дүн		8339	6	-	6

Хүснэгт С.2 Төвийн дүүргийн ЭХАШ-ийн зөрчлийн хэргийн нэг шүүгчийн ачаалал, санал болгох дүнгээр

№	Шүүх	Хянан шийдвэрлэсэн хэргийн тоо, журам ба бусад /2017-2021 оны дунджаар/			Шүүгчийн тоо /2017-2021 оны дунджаар/	Ажлын ачаалал, цагаар /2017-2021 оны дунджаар/			Нэг шүүгчийн нэг ажлын өдрийн ачаалал, цагаар	Ажлын цагаар тооцсон шаардлагатай шүүгчийн тоо
		Хялбар-шуулсан	Ердийн	Зөрчил		Хялбар-шуулсан	Ердийн	Зөрчил		
1	Багануур	55.8	67.2	123	3.3	0.6	2.3	0.9	3.8	-2
2	Багахангай	7.4	28	35	1.0	0.3	3.2	0.3	3.8	-2
3	Налайх	60.5	131.25	192	2.7	0.8	5.5	0.6	6.9	-1
Дундаж		-	-	-	-	0.5	3.7	0.6	4.8	-
Дүн		124	226	350	7	-	-	-	-	-5

Хүснэгт С.3 Захын дүүргийн ЭХШ-ийн нэг шүүгчийн ачаалал, санал болгох дүнгээр

№	Шүүх	Хянан шийдвэрлэсэн хэргийн тоо, журам ба бусад /2017-2021 оны дунджаар/			Шүүгчийн тоо /2017-2021 оны дунджаар/	Ажлын ачаалал, цагаар /2017-2021 оны дунджаар/			Нэг шүүгчийн нэг ажлын өдрийн ачаалал, цагаар	Ажлын цагаар тооцсон шаардлагатай шүүгчийн тоо
		Хялбар-шуулсан	Ердийн	Зөрчил		Хялбар-шуулсан	Ердийн	Зөрчил		
1	Архангай	72	187	428	3.0	0.8	7.2	1.6	9.6	1
2	Баян-Өлгий	81	103	341	3.1	0.9	3.8	1.2	5.9	-1
3	Баянхонгор	100	223	570	3.2	1.1	8.1	2.0	11.1	1
4	Булган	93	129	417	2.7	1.2	5.4	1.7	8.2	0



5	Говь-Алтай	53	62	240	3.0	0.6	2.4	0.9	3.9	-2
6	Говьсүмбэр	48	51	167	2.7	0.6	2.2	0.7	3.4	-2
7	Дархан-Уул	134	295	373	4.5	1.0	7.4	0.9	9.4	1
8	Дорноговь	56	117	213	2.7	0.7	4.9	0.9	6.4	-1
9	Дорнод	135	212	421	2.7	1.7	8.9	1.7	12.3	2
10	Дундговь	44	74	156	2.7	0.6	3.1	0.6	4.3	-1
11	Завхан	67	50	209	2.9	0.8	2.0	0.8	3.6	-2
12	Орхон	118	261	1014	3.9	1.1	7.7	2.9	11.6	1
13	Өмнөговь	63	100	221	3.0	0.7	3.9	0.8	5.4	-1
14	Өвөрхангай	73	135	1013	2.8	0.9	5.5	4.0	10.4	1
15	Сүхбаатар	103	110	267	2.7	1.3	4.6	1.1	7.0	0
16	Сэлэнгэ	59	148	184	2.5	0.8	6.9	0.8	8.6	0
17	Төв	115	323	668	4.6	0.9	8.1	1.6	10.5	2
18	Увс	74	117	390	2.7	0.9	4.9	1.6	7.4	0
19	Ховд	100	86	362	2.6	1.3	3.8	1.5	6.6	-1
20	Хөвсгөл	135	225	510	3.6	1.3	7.2	1.6	10.1	1
21	Хэнтий	62	175	515	2.4	0.9	8.2	2.3	11.4	1
Дундаж		-	-	-	-	1.0	5.5	1.5	8.0	-
Дүн		1786	3183	8676	64.1	-	-	-	-	0

Хүснэгт С.4 Аймгийн ЭХАШШ-ийн нэг шүүгчийн ачаалал, санал болгох дүнгээр

№	Шүүх	Хянан шийдвэрлэсэн эрүүгийн хэргийн тоо, журам ба бусад /2017-2021 оны дунджаар/			Хянан шийдвэрлэсэн иргэний хэргийн тоо, журам ба бусад /2017-2021 оны дунджаар/				Шүүгчийн тоо /2017-2021 оны дунджаар/
		Хялбар-шуулсан	Ердийн	Зөрчил	Хялбар-шуулсан	Ердийн	Бага үнийн дүн	Хэрэгсэхгүй болгосон	
1	Замын-Үүд	55	82	155	86	106	137	5	4
2	Тосонцэнгэл	37	19	177	46	232	68	12	2.8
3	Ханбогд	51	90	151	36	90	46	9	4
4	Хархорин	30	67	395	77	268	101	12	3
5	Мандал	44	110	239	109	112	227	14	4
6	Сайхан	23	53	101	45	44	116	10	3.7
7	Булган	26	45	184	51	195	60	0	2.7
8	Бор-Өндөр	32	28	118	54	52	103	4	3
Дүн		298	494	1520	504	1099	858	66	27.2

Хүснэгт С.5 Сум дундын шүүхэд хянан шийдвэрлэсэн хэргийн тоо

№	Шүүх	Хянан шийдвэрлэсэн эрүүгийн хэргийн тоо, журам ба бусад /2017-2021 оны дунджаар/				Хянан шийдвэрлэсэн иргэний хэргийн тоо, журам ба бусад /2017-2021 оны дунджаар/					Нэг шүүгчийн нэг ажлын өдрийн ачаалал, цагаар	Ажлын цагаар тооцсон шаардлагатай шүүгчийн тоо
		Хялбар-шуулсан	Ердийн	Зөрчил	Дүн	Хялбар-шуулсан	Ердийн	Бага үнийн дүн	Хэрэгсэхгүй болгосон	Дүн		
1	Замын-Үүд	0.5	2.3	0.4	3.2	0.4	1.5	1.5	0.0	3.4	6.6	-1
2	Тосонцэнгэл	0.4	0.7	0.6	1.8	0.3	4.2	1.0	0.1	5.5	7.3	0
3	Ханбогд	0.5	3.0	0.5	4.0	0.2	1.5	0.6	0.1	2.3	6.2	-1
4	Хархорин	0.3	2.4	1.4	4.2	0.5	4.8	1.4	0.1	6.7	10.9	1
5	Мандал	0.4	3.5	0.7	4.7	0.6	1.7	2.8	0.1	5.2	9.9	1
6	Сайхан	0.2	1.7	0.3	2.2	0.2	0.7	1.4	0.1	2.4	4.6	-2
7	Булган	0.3	1.8	0.7	2.8	0.3	3.7	0.9	0.0	4.9	7.6	0
8	Бор-Өндөр	0.4	1.1	0.6	2.1	0.4	1.0	1.6	0.0	3.0	5.1	-1
Дундаж		0.4	2.1	0.7	3.1	0.3	2.4	1.4	0.0	4.2	7.3	-
Дүн		-	-	-	-	-	-	-	-	-	-	-3

Хүснэгт С.6 Сум дундын шүүхийн нэг шүүгчийн ачаалал, санал болгох дүнгээр

№	Шүүх	Хянан шийдвэрлэсэн иргэний хэргийн тоо, журам ба бусад /2017-2021 оны дунджаар/				Шүүгчийн тоо /2017-2021 оны дунджаар/	Ажлын ачаалал, цагаар /2017-2021 оны дунджаар/				Нэг шүүгчийн нэг ажлын өдрийн ачаалал, цагаар	Ажлын цагаар тооцсон шаардлагатай шүүгчийн тоо
		Хялбар-шуулсан	Ердийн	Бага үнийн дүн	Хэрэгсэхгүй болгосон		Хялбар-шуулсан	Ердийн	Бага үнийн дүн	Хэрэгсэхгүй болгосон		
1	Баянзүрх	751	1053	2259	1546	16.4	0.8	3.6	6.0	1.7	12.2	9
2	Сүхбаатар	553	1213	1091	844	11.5	0.9	5.8	4.1	1.3	12.2	5
3	Чингэлтэй	498	1088	1077	707	11.8	0.8	5.1	4.0	1.1	11.0	5
4	Баянгол	698	966	1991	661	14.4	0.9	3.7	6.1	0.8	11.5	7
5	Хан-Уул	650	976	1379	938	11.0	1.1	4.9	5.5	1.6	13.0	7
6	Сонгино хайрхан	547	575	2180	803	12.0	0.8	2.6	8.0	1.2	12.7	8
Дундаж		-	-	-	-	-	0.9	4.3	5.6	1.3	12.1	-



Дүн	3697	5871	9976	5500	77.2	-	-	-	-	-	41
-----	------	------	------	------	------	---	---	---	---	---	----

Хүснэгт С.7 Төвийн дүүргийн ИХАШШ-ийн нэг шүүгчийн ачаалал, санал болгох дүнгээр

№	Шүүх	Хянан шийдвэрлэсэн иргэний хэргийн тоо, журам ба бусад /2017-2021 оны дунджаар/				Шүүгчийн тоо /2017-2021 оны дунджаар/	Ажлын ачаалал, цагаар /2017-2021 оны дунджаар/				Нэг шүүгчийн нэг ажлын өдрийн ачаалал, цагаар	Ажлын цагаар тооцсон шаардлагатай шүүгчийн тоо
		Хялбар-шуулсан	Ерд-ийн	Бага үнийн дүн	Хэрэгсэхгүй болгосон		Хялбар-шуулсан	Ерд-ийн	Бага үнийн дүн	Хэрэгсэхгүй болгосон		
1	Багануур	94	65	364	17.6	3.4	0.5	1.1	4.7	0.1	6.4	-1
2	Багахангай	11	6	19	4.5	1.0	0.2	0.3	0.8	0.1	1.4	-1
3	Налайх	103	74	272	45	3.1	0.6	1.3	3.9	0.3	6.0	0
Дундаж		-	-	-	-	-	0.4	0.9	3.1	0.1	4.6	-
Дүн		207	145	655	67	7.5	-	-	-	-	-	-2

Хүснэгт С.8 Захын дүүргийн ИХШ-ийн нэг шүүгчийн ачаалал, санал болгох дүнгээр

№	Шүүх	Хянан шийдвэрлэсэн иргэний хэргийн тоо, журам ба бусад /2017-2021 оны дунджаар/				Шүүгчийн тоо /2017-2021 оны дунджаар/	Ажлын ачаалал, цагаар /2017-2021 оны дунджаар/				Нэг шүүгчийн нэг ажлын өдрийн ачаалал, цагаар	Ажлын цагаар тооцсон шаардлагатай шүүгчийн тоо
		Хялбар-шуулсан	Ерд-ийн	Бага үнийн дүн	Хэрэгсэхгүй болгосон		Хялбар-шуулсан	Ерд-ийн	Бага үнийн дүн	Хэрэгсэхгүй болгосон		
1	Архангай	103	613	155	63	2.8	0.7	12.1	2.4	0.4	15.6	3
2	Баян-Өлгий	191	478	281	24	4.0	0.9	6.6	3.1	0.1	10.7	1
3	Баянхонгор	158	678	175	16	2.9	1.0	12.8	2.6	0.1	16.6	3
4	Булган	135	446	174	25	2.6	0.9	9.4	2.9	0.2	13.4	2
5	Говь-Алтай	68	418	129	18	2.7	0.5	8.6	2.1	0.1	11.3	1
6	Говьсүмбэр	31	35	149	2	2.7	0.2	0.7	2.4	0.0	3.4	-2
7	Дархан-Уул	244	449	613	90	4.2	1.1	5.9	6.3	0.4	13.7	4
8	Дорноговь	92	198	138	29	2.9	0.6	3.7	2.1	0.2	6.6	-1
9	Дорнод	228	195	627	84	3.8	1.1	2.8	7.2	0.4	11.5	2
10	Дундговь	72	449	129	21	2.8	0.5	8.7	2.0	0.1	11.3	1
11	Завхан	99	473	92	2	2.9	0.6	9.0	1.4	0.0	11.1	1
12	Орхон	224	494	671	212	5.0	0.8	5.5	5.9	0.8	13.1	3
13	Өмнөговь	104	267	100	30	2.7	0.7	5.6	1.7	0.2	8.1	0
14	Өвөрхангай	139	485	137	40	2.6	1.0	10.3	2.3	0.3	13.9	2
15	Сүхбаатар	111	355	126	8	2.9	0.7	6.9	1.9	0.1	9.6	0
16	Сэлэнгэ	115	178	333	34	3.7	0.6	2.6	3.9	0.2	7.3	0
17	Төв	230	865	252	86	4.4	1.0	10.8	2.5	0.4	14.7	4
18	Увс	159	403	193	48	2.8	1.1	8.1	3.1	0.3	12.5	1
19	Ховд	130	376	228	42	2.8	0.9	7.5	3.6	0.3	12.2	2
20	Хөвсгөл	267	1114	213	83	5.5	0.9	11.3	1.7	0.3	14.2	5
21	Хэнтий	159	339	265	35	2.6	1.1	7.2	4.5	0.2	13.0	2
Дундаж		-	-	-	-	-	0.8	7.4	3.1	0.2	11.6	-
Дүн		3059	9308	5180	992	69.3	-	-	-	-	-	34

Хүснэгт С.9 Аймгийн ИХАШШ-ийн нэг шүүгчийн ачаалал, санал болгох дүнгээр

№	Шүүх	Хянан шийдвэрлэсэн иргэний хэргийн тоо, журам ба бусад /2017-2021 оны дунджаар/				Шүүгчийн тоо /2017-2021 оны дунджаар/	Ажлын ачаалал, цагаар /2017-2021 оны дунджаар/			Нэг шүүгчийн нэг ажлын өдрийн ачаалал, цагаар	Ажлын цагаар тооцсон шаардлагатай шүүгчийн тоо
		Хялбар-шуулсан	Ерд-ийн	Хэрэгсэхгүй болгосон	Дүн		Хялбар-шуулсан	Ерд-ийн	Хэрэгсэхгүй болгосон		
1	Нийслэл	205	689	101	995	18.5	1.7	9.9	0.8	12.4	10

Хүснэгт С.10 НЗХАШШ-ийн нэг шүүгчийн ачаалал, судалгааны дүнгээр

№	Шүүх	Хянан шийдвэрлэсэн иргэний хэргийн тоо, журам ба бусад /2017-2021 оны дунджаар/				Шүүгчийн тоо /2017-2021 оны дунджаар/	Ажлын ачаалал, цагаар /2017-2021 оны дунджаар/			Нэг шүүгчийн нэг ажлын өдрийн ачаалал, цагаар	Ажлын цагаар тооцсон шаардлагатай шүүгчийн тоо
		Хялбар-шуулсан	Ерд-ийн	Хэрэгсэхгүй болгосон	Дүн		Хялбар-шуулсан	Ерд-ийн	Хэрэгсэхгүй болгосон		
1	Архангай	14	23	3	40	2.2	2.2	0.3	0.6	3.0	-1
2	Баян-Өлгий	25	52	1	78	2.9	1.8	0.3	2.4	4.6	-1
3	Баянхонгор	14	18	2	34	3.0	4.9	0.3	0.8	6.0	-2
4	Булган	15	9	1	26	2.0	2.6	0.2	0.6	3.4	-1
5	Говь-Алтай	9	21	2	32	1.7	1.4	0.3	0.7	2.3	-1



6	Говьсүмбэр	3	11	1	15	2.1	1.2	0.1	0.4	1.7	-2
7	Дархан-Уул	11	24	2	37	3.0	3.9	0.3	-	4.3	-2
8	Дорноговь	8	16	1	25	2.9	-	-	2.6	2.6	-2
9	Дорнод	13	14	2	29	2.1	3.3	0.3	0.7	4.3	-1
10	Дундговь	15	11	2	28	2.2	2.1	0.2	0.7	3.1	-1
11	Завхан	9	28	1	39	3.0	1.1	0.1	0.6	1.8	-2
12	Орхон	8	25	1	34	3.0	1.1	0.3	0.6	2.1	-2
13	Өмнөговь	9	17	1	27	2.6	4.2	0.5	-	4.8	-2
14	Өвөрхангай	5	14	1	20	2.8	-	-	3.2	3.2	-2
15	Сүхбаатар	11	22	1	35	3.0	3.7	0.2	0.8	4.7	-2
16	Сэлэнгэ	14	17	2	33	2.8	2.3	0.2	0.7	3.2	-2
17	Төв	15	29	2	46	3.0	1.4	0.1	0.3	1.9	-2
18	Увс	7	37	3	47	2.1	3.9	0.7	1.2	5.8	-1
19	Ховд	13	29	4	46	2.8	3.1	0.1	0.5	3.7	-2
20	Хөвсгөл	7	22	3	32	2.0	2.1	0.3	0.6	3.0	-1
21	Хэнтий	9	9	0	18	2.8	2.4	0.5	1.2	4.1	-2
Дундаж		-	-	-	-	-	0.7	2.2	0.1	3.0	-
Дүн		234	448	36	721	53.9	-	-	-	-	-34

Хүснэгт С.11 Аймгийн ЗХШ-ийн нэг шүүгчийн ачаалал, судалгааны дүнгээр

№	Шүүх	Хянан шийдвэрлэсэн хэргийн тоо /2017-2021 оны дунджаар/		Шүүгчийн тоо /2017-2021 оны дунджаар/	Ажлын ачаалал, цагаар /2017-2021 оны дунджаар/		Нэг шүүгчийн нэг ажлын өдрийн ачаалал, цагаар	Ажлын цагаар тооцсон шаардлагатай шүүгчийн тоо
		Эрүү	Зөрчил		Эрүү	Зөрчил		
1	Нийслэл	1053	160	13.4	12.9	0.9	13.8	12

Хүснэгт С.12 НЭХДЗШ-ийн нэг шүүгчийн ачаалал, санал болгох дүнгээр

№	Шүүх	Хянан шийдвэрлэсэн иргэний хэргийн тоо /2017-2021 оны дунджаар/	Шүүгчийн тоо /2017-2021 оны дунджаар/	Нэг шүүгчийн нэг ажлын өдрийн ачаалал, цагаар	Ажлын цагаар тооцсон шаардлагатай шүүгчийн тоо
1	Нийслэл	2312	14.7	10.0	3

Хүснэгт С.13 НИХДЗШ-ийн нэг шүүгчийн ачаалал, санал болгох дүнгээр

№	Шүүх	Хянан шийдвэрлэсэн иргэний хэргийн тоо /2017-2021 оны дунджаар/	Шүүгчийн тоо /2017-2021 оны дунджаар/	Нэг шүүгчийн нэг ажлын өдрийн ачаалал, цагаар	Ажлын цагаар тооцсон шаардлагатай шүүгчийн тоо
1	Нийслэл	742	11.7	15.8	14

Хүснэгт С.14 ЗХДЗШШ-ийн нэг шүүгчийн ачаалал, судалгааны дүнгээр

№	Шүүх	Хянан шийдвэрлэсэн хэргийн тоо /2017-2021 оны дунджаар/			Шүүгчийн тоо /2017-2021 оны дунджаар/	Ажлын ачаалал, цагаар /2017-2021 оны дунджаар/			Нэг шүүгчийн нэг ажлын өдрийн ачаалал, цагаар	Ажлын цагаар тооцсон шаардлагатай шүүгчийн тоо
		Эрүү	Зөрчил	Иргэн		Эрүү	Зөрчил	Иргэн		
1	Архангай	40	11	27	3.0	2.2	0.3	0.6	3.0	-2
2	Баян-Өлгий	30	12	103	2.7	1.8	0.3	2.4	4.6	-1
3	Баянхонгор	75	10	30	2.5	4.9	0.3	0.8	6.0	0
4	Булган	41	8	23	2.6	2.6	0.2	0.6	3.4	-1
5	Говь-Алтай	25	12	32	3.0	1.4	0.3	0.7	2.3	-2
6	Говьсүмбэр	22	3	20	3.0	1.2	0.1	0.4	1.7	-2
7	Дархан-Уул	72	14	-	3.0	3.9	0.3	-	4.3	0
	Дархан-Уул	-	-	127	3.1	-	-	2.6	2.6	-1
8	Дорноговь	60	12	35	3.0	3.3	0.3	0.7	4.3	-1
9	Дорнод	38	8	34	2.9	2.1	0.2	0.7	3.1	-1
10	Дундговь	19	4	25	2.8	1.1	0.1	0.6	1.8	-2
11	Завхан	21	12	30	3.0	1.1	0.3	0.6	2.1	-2
12	Орхон	78	21	-	3.0	4.2	0.5	-	4.8	-1
	Орхон	-	-	151	3.0	-	-	3.2	3.2	-2
13	Өмнөговь	59	7	31	2.6	3.7	0.2	0.8	4.7	-1
14	Өвөрхангай	40	8	29	2.8	2.3	0.2	0.7	3.2	-1
15	Сүхбаатар	27	4	17	3.1	1.4	0.1	0.3	1.9	-2
16	Сэлэнгэ	69	28	57	2.9	3.9	0.7	1.2	5.8	-1
17	Төв	76	5	33	4.0	3.1	0.1	0.5	3.7	-2
18	Увс	33	9	26	2.6	2.1	0.3	0.6	3.0	-2
19	Ховд	39	17	53	2.7	2.4	0.5	1.2	4.1	-1
20	Хөвсгөл	40	17	32	2.9	2.3	0.4	0.7	3.4	-2



21	Хэнтий	39	15	25	2.3	2.8	0.5	0.7	3.9	-1
Дундаж		-	-	-	-	2.6	0.3	1.0	3.5	-
Дүн		943	237	940	66.5	-	-	-	-	-31

Хүснэгт С.15 Аймгийн ДЗШШ-ийн нэг шүүгчийн ачаалал, санал болгох дүнгээр

ХАВСРАЛТ 6.

Шүүгчийн тооны харьцуулалт

№	Шүүх	ШЕЗ-ийн 2022 оны 58-р тогтоолоор батлагдсан шалгуур үзүүлэлтэд хамаарах өгөгдөлд хийсэн суурь судалгаа		Шүүгчийн тоо /2022 он/	Ажлын цагаар тооцсон шаардлагатай шүүгчийн тоо	
		Хувилбар 1	Хувилбар 2		Судалгааны дүнгээр	Санал болгох дүнгээр
1	Баянзүрх	19	20	12	20	21
2	Сүхбаатар	10	11	8	11	12
3	Чингэлтэй	10	11	7	11	11
4	Баянгол	11	11	10	14	14
5	Хан-Уул	8	9	7	9	9
6	Сонгинохайрхан	13	14	10	16	16
Дүн		71	76	54	81	83

Хүснэгт D.16 Төвийн дүүргийн ЭХАШШ-д ажиллах шаардлагатай шүүгчийн тоо

№	Шүүх	ШЕЗ-ийн 2022 оны 58-р тогтоолоор батлагдсан шалгуур үзүүлэлтэд хамаарах өгөгдөлд хийсэн суурь судалгаа		Шүүгчийн тоо /2022 он/	Ажлын цагаар тооцсон шаардлагатай шүүгчийн тоо	
		Хувилбар 1	Хувилбар 2		Судалгааны дүнгээр	Санал болгох дүнгээр
1	Баянзүрх	3	3	1	5	4
2	Сүхбаатар	1	1	1	2	1
3	Чингэлтэй	1	1	1	2	1
4	Баянгол	1	1	1	2	2
5	Хан-Уул	1	2	1	2	2
6	Сонгинохайрхан	2	2	1	3	2
Дүн		9	10	6	16	12

Хүснэгт D.17 Төвийн дүүргийн ЭХАШ-ийн зөрчлийн хэрэг дээр ажиллах шаардлагатай шүүгчийн тоо

№	Шүүх	ШЕЗ-ийн 2022 оны 58-р тогтоолоор батлагдсан шалгуур үзүүлэлтэд хамаарах өгөгдөлд хийсэн суурь судалгаа		Шүүгчийн тоо /2022 он/	Ажлын цагаар тооцсон шаардлагатай шүүгчийн тоо	
		Хувилбар 1	Хувилбар 2		Судалгааны дүнгээр	Санал болгох дүнгээр
1	Багануур	2	2	4	2	2
2	Багахангай	0	0	3	1	1
3	Налайх	2	3	4	3	3
Дүн		5	5	11	6	6

Хүснэгт D.18 Захын дүүргийн ЭХШ-д ажиллах шаардлагатай шүүгчийн тоо

№	Шүүх	ШЕЗ-ийн 2022 оны 58-р тогтоолоор батлагдсан шалгуур үзүүлэлтэд хамаарах өгөгдөлд хийсэн суурь судалгаа		Шүүгчийн тоо /2022 он/	Ажлын цагаар тооцсон шаардлагатай шүүгчийн тоо	
		Хувилбар 1	Хувилбар 2		Судалгааны дүнгээр	Судалгааны дүнгээр
1	Архангай	4	4	3	4	4
2	Баян-Өлгий	3	3	3	2	3
3	Баянхонгор	4	4	3	4	4
4	Булган	3	3	3	3	3
5	Говь-Алтай	2	2	3	2	1
6	Говьсүмбэр	1	1	3	1	1
7	Дархан-Уул	5	6	5	6	6
8	Дорноговь	2	2	3	2	2
9	Дорнод	5	5	3	5	6
10	Дундговь	2	2	2	1	2
11	Завхан	2	2	3	1	1
12	Орхон	5	6	3	5	6
13	Өмнөговь	2	2	3	2	2
14	Өвөрхангай	2	4	3	4	4
15	Сүхбаатар	3	3	3	3	2
16	Сэлэнгэ	3	3	3	3	2
17	Төв	6	6	5	7	7
18	Увс	3	3	3	3	2



19	Ховд	3	3	3	3	2
20	Хөвсгөл	5	5	4	5	7
21	Хэнтий	3	4	2	3	4
Дүн		68	73	66	69	71

Хүснэгт D.19 Аймгийн ЭХАШШ-д ажиллах шаардлагатай шүүгчийн тоо

№	Шүүх	ШЕЗ-ийн 2022 оны 58-р тогтоолоор батлагдсан шалгуур үзүүлэлтэд хамаарах өгөгдөлд хийсэн суурь судалгаа		Шүүгчийн тоо /2022 он/	Ажлын цагаар тооцсон шаардлагатай шүүгчийн тоо	
		Хувилбар 1	Хувилбар 2		Судалгааны дүнгээр	Санал болгох дүнгээр
1	Замын-Үүд	3	4	4	4	3
2	Тосонцэнгэл	3	3	3	3	3
3	Ханбогд	3	3	4	3	3
4	Хархорин	4	4	3	5	4
5	Мандал	4	5	4	5	5
6	Сайхан	2	2	4	3	2
7	Булган	3	3	3	3	3
8	Бор-Өндөр	2	2	3	2	2
Дүн		24	26	28	28	25

Хүснэгт D.5 Сум дундын шүүхэд ажиллах шаардлагатай шүүгчийн тоо

№	Шүүх	ШЕЗ-ийн 2022 оны 58-р тогтоолоор батлагдсан шалгуур үзүүлэлтэд хамаарах өгөгдөлд хийсэн суурь судалгаа		Шүүгчийн тоо /2022 он/	Ажлын цагаар тооцсон шаардлагатай шүүгчийн тоо	
		Хувилбар 1	Хувилбар 2		Судалгааны дүнгээр	Санал болгох дүнгээр
1	Баянзүрх	25	26	17	31	26
2	Сүхбаатар	16	17	10	19	15
3	Чингэлтэй	15	17	12	20	17
4	Баянгол	19	20	15	25	22
5	Хан-Уул	18	19	11	22	18
6	Сонгинохайрхан	17	19	13	24	21
Дүн		110	118	78	141	119

Хүснэгт D.6 Төвийн дүүргийн ИХАШШ-д ажиллах шаардлагатай шүүгчийн тоо

№	Шүүх	ШЕЗ-ийн 2022 оны 58-р тогтоолоор батлагдсан шалгуур үзүүлэлтэд хамаарах өгөгдөлд хийсэн суурь судалгаа		Шүүгчийн тоо /2022 он/	Ажлын цагаар тооцсон шаардлагатай шүүгчийн тоо	
		Хувилбар 1	Хувилбар 2		Судалгааны дүнгээр	Санал болгох дүнгээр
1	Багануур	2	3	4	4	3
2	Багахангай	0	0	1	0	0
3	Налайх	3	3	2	2	2
Дүн		5	6	7	6	5

Хүснэгт D.7 Захын дүүргийн ИХШ-д ажиллах шаардлагатай шүүгчийн тоо

№	Шүүх	ШЕЗ-ийн 2022 оны 58-р тогтоолоор батлагдсан шалгуур үзүүлэлтэд хамаарах өгөгдөлд хийсэн суурь судалгаа		Шүүгчийн тоо /2022 он/	Ажлын цагаар тооцсон шаардлагатай шүүгчийн тоо	
		Хувилбар 1	Хувилбар 2		Судалгааны дүнгээр	Санал болгох дүнгээр
1	Архангай	4	5	3	7	6
2	Баян-Өлгий	4	5	4	6	5
3	Баянхонгор	5	5	3	8	6
4	Булган	3	4	3	6	5
5	Говь-Алтай	3	3	3	5	4
6	Говьсүмбэр	1	1	3	1	1
7	Дархан-Уул	6	7	5	10	9
8	Дорноговь	2	2	3	3	2
9	Дорнод	5	5	4	7	6
10	Дундговь	3	3	3	5	4
11	Завхан	3	3	3	5	4
12	Орхон	6	8	5	10	8
13	Өмнөговь	2	2	3	4	3
14	Өвөрхангай	4	4	3	7	5
15	Сүхбаатар	3	3	2	3	2
16	Сэлэнгэ	3	3	2	2	2
17	Төв	7	7	5	11	9
18	Увс	4	4	2	4	3
19	Ховд	4	4	3	6	5
20	Хөвсгөл	8	8	6	13	11



21	Хэнтий	4	4	3	6	5
Дүн		84	90	71	129	105

Хүснэгт D.8 Аймгийн ИХАШШ-д ажиллах шаардлагатай шүүгчийн тоо

№	Шүүх	ШЕЗ-ийн 2022 оны 58-р тогтоолоор батлагдсан шалгуур үзүүлэлтэд хамаарах өгөгдөлд хийсэн суурь судалгаа		Шүүгчийн тоо /2022 он/	Ажлын цагаар тооцсон шаардлагатай шүүгчийн тоо	
		Хувилбар 1	Хувилбар 2		Судалгааны дүнгээр	Санал болгох дүнгээр
1	Нийслэл	28	28	17	27	27

Хүснэгт D.9 НЗХАШШ-д ажиллах шаардлагатай шүүгчийн тоо

№	Шүүх	ШЕЗ-ийн 2022 оны 58-р тогтоолоор батлагдсан шалгуур үзүүлэлтэд хамаарах өгөгдөлд хийсэн суурь судалгаа		Шүүгчийн тоо /2022 он/	Ажлын цагаар тооцсон шаардлагатай шүүгчийн тоо	
		Хувилбар 1	Хувилбар 2		Судалгааны дүнгээр	Санал болгох дүнгээр
1	Архангай	1	1	2	1	1
2	Баян-Өлгий	2	2	3	2	2
3	Баянхонгор	1	1	3	1	1
4	Булган	1	1	2	1	1
5	Говь-Алтай	1	1	2	1	1
6	Говьсүмбэр	1	1	2	0	0
7	Дархан-Уул	1	1	3	1	1
8	Дорноговь	1	1	3	1	1
9	Дорнод	1	1	2	1	1
10	Дундговь	1	1	2	1	1
11	Завхан	1	1	3	1	1
12	Орхон	1	1	3	1	1
13	Өмнөговь	1	1	3	1	1
14	Өвөрхангай	1	1	3	1	1
15	Сүхбаатар	1	1	3	1	1
16	Сэлэнгэ	1	1	3	1	1
17	Төв	1	1	3	1	1
18	Увс	2	2	2	1	1
19	Ховд	2	2	3	1	1
20	Хөвсгөл	1	1	2	1	1
21	Хэнтий	1	1	2	0	0
Дүн		24	24	54	20	20

Хүснэгт D.10 Аймгийн ЗХШ-д ажиллах шаардлагатай шүүгчийн тоо

№	Шүүх	ШЕЗ-ийн 2022 оны 58-р тогтоолоор батлагдсан шалгуур үзүүлэлтэд хамаарах өгөгдөлд хийсэн суурь судалгаа		Шүүгчийн тоо /2022 он/	Ажлын цагаар тооцсон шаардлагатай шүүгчийн тоо	
		Хувилбар 1	Хувилбар 2		Судалгааны дүнгээр	Санал болгох дүнгээр
1	Нийслэл	30	30	16	23	28

Хүснэгт D.11 НЭХДЗШ-д ажиллах шаардлагатай шүүгчийн тоо

№	Шүүх	ШЕЗ-ийн 2022 оны 58-р тогтоолоор батлагдсан шалгуур үзүүлэлтэд хамаарах өгөгдөлд хийсэн суурь судалгаа		Шүүгчийн тоо /2022 он/	Ажлын цагаар тооцсон шаардлагатай шүүгчийн тоо	
		Хувилбар 1	Хувилбар 2		Судалгааны дүнгээр	Санал болгох дүнгээр
1	Нийслэл	23	23	12	13	15

Хүснэгт D.12 НИХДЗШ-д ажиллах шаардлагатай шүүгчийн тоо

№	Шүүх	ШЕЗ-ийн 2022 оны 58-р тогтоолоор батлагдсан шалгуур үзүүлэлтэд хамаарах өгөгдөлд хийсэн суурь судалгаа		Шүүгчийн тоо /2022 он/	Ажлын цагаар тооцсон шаардлагатай шүүгчийн тоо	
		Хувилбар 1	Хувилбар 2		Судалгааны дүнгээр	Санал болгох дүнгээр
1	Нийслэл	28	28	14	28	28

Хүснэгт D.13 ЗХДЗШШ-д ажиллах шаардлагатай шүүгчийн тоо

№	Шүүх	ШЕЗ-ийн 2022 оны 58-р тогтоолоор батлагдсан шалгуур үзүүлэлтэд хамаарах өгөгдөлд хийсэн суурь судалгаа		Шүүгчийн тоо /2022 он/	Ажлын цагаар тооцсон шаардлагатай шүүгчийн тоо	
		Хувилбар 1	Хувилбар 2		Судалгааны дүнгээр	Санал болгох дүнгээр
1	Архангай	2	2	3	1	1
2	Баян-Өлгий	2	2	2	1	1
3	Баянхонгор	3	3	1	1	1



4	Булган	2	2	1	0	0
5	Говь-Алтай	1	1	3	1	1
6	Говьсүмбэр	1	1	3	1	1
7	Дархан-Уул	2	2	1	0	1
	Дархан-Уул	1	1	2	1	1
8	Дорноговь	2	2	3	1	2
9	Дорнод	2	2	2	1	1
10	Дундговь	1	1	2	0	0
11	Завхан	1	1	3	1	1
12	Орхон	2	2	3	1	2
	Орхон	2	2	3	1	1
13	Өмнөговь	2	2	2	1	1
14	Өвөрхангай	2	2	2	1	1
15	Сүхбаатар	1	1	3	1	1
16	Сэлэнгэ	3	3	3	2	2
17	Төв	2	2	3	1	1
18	Увс	1	1	3	1	1
19	Ховд	2	2	2	1	1
20	Хөвсгөл	2	2	3	1	1
21	Хэнтий	1	1	2	1	1
Дүн		40	40	55	20	24

Хүснэгт D.14 Аймгийн ДЗШШ-д ажиллах шаардлагатай шүүгчийн тоо

№	Шүүх		ШЕЗ-ийн 2022 оны 58-р тогтоолоор батлагдсан шалгуур үзүүлэлтэд хамаарах өгөгдөлд хийсэн суурь судалгаа		Шүүгчийн тоо /2022 он/	Ажлын цагаар тооцсон шаардлагатай шүүгчийн тоо	
			Хувилбар 1	Хувилбар 2		Судалгааны дүнгээр	Санал болгох дүнгээр
1	Эрүүгийн хэрэг	Төвийн дүүрэг	71	76	54	81	83
		Захын дүүрэг	4	5	11	6	6
		Аймаг	68	73	66	69	71
		Сум дунд	24	26	28	28	25
2	Зөрчлийн хэрэг	Төвийн дүүрэг	9	10	6	16	12
3	Иргэний хэрэг	Төвийн дүүрэг	110	118	78	141	119
		Захын дүүрэг	5	6	7	6	5
		Аймаг	84	90	71	129	105
4	Захиргааны хэрэг	Нийслэл	28	28	17	27	27
		Аймаг	24	24	54	20	20
Дүн			427	456	392	523	473

Хүснэгт D.15 Улсын хэмжээнд анхан шатны шүүхэд шүүхэд шаардлагатай шүүгчийн тоо

№	Шүүх		ШЕЗ-ийн 2022 оны 58-р тогтоолоор батлагдсан шалгуур үзүүлэлтэд хамаарах өгөгдөлд хийсэн суурь судалгаа		Шүүгчийн тоо /2022 он/	Ажлын цагаар тооцсон шаардлагатай шүүгчийн тоо	
			Хувилбар 1	Хувилбар 2		Судалгааны дүнгээр	Санал болгох дүнгээр
1	Эрүүгийн хэрэг	Нийслэл	30	30	16	23	28
		Аймаг	33	33	46	17	19
		Орхон, Дархан-Уул	4	4	4	1	3
3	Иргэний хэрэг	Нийслэл	23	23	12	13	15
		Орхон, Дархан-Уул	3	3	5	2	2
4	Захиргааны хэрэг		28	28	14	28	28
Дүн			121	121	97	84	95

Хүснэгт D.16 Улсын хэмжээнд давж заалдах шатны шүүхэд шаардлагатай шүүгчийн тоо

№	Шүүх		ШЕЗ-ийн 2022 оны 58-р тогтоолоор батлагдсан шалгуур үзүүлэлтэд хамаарах өгөгдөлд хийсэн суурь судалгаа		Шүүгчийн тоо /2022 он/	Ажлын цагаар тооцсон шаардлагатай шүүгчийн тоо	
			Хувилбар 1	Хувилбар 2		Судалгааны дүнгээр	Санал болгох дүнгээр
1	Анхан шат	Эрүү	167	180	159	184	185
		Зөрчил	9	10	6	16	12
		Иргэн	199	214	156	276	229
		Захиргаа	52	52	71	47	47
2	Давж заалдах шат	Эрүү	67	67	66	41	50
		Иргэн	26	26	17	15	17
		Захиргаа	28	28	14	28	28
Дүн			548	577	489	607	568

Хүснэгт D.17 Улсын хэмжээнд шат шатны шүүхэд шаардлагатай шүүгчийн тоо



ХАВСРАЛТ 7.

Хянан шийдвэрлэх хэргийн тооны прогноз

№	Шүүх	2022	2023	2024	2025	2026	R	Загвар
1	Баянзүрх	1490	1565	1640	1714	1789	0.76	$y = 147.6 + 74.6t$
2	Сүхбаатар	862	902	942	983	1023	0.79	$y = 137 + 40.26t$
3	Чингэлтэй	783	818	853	887	922	0.79	$y = 156.5 + 34.8t$
4	Баянгол	867	905	942	980	1017	0.79	$y = 192.4 + 37.5t$
5	Хан-Уул	636	665	695	724	754	0.81	$y = 104.5 + 29.5t$
6	Сонгинохайрхан	1077	1126	1175	1225	1274	0.79	$y = 189 + 49.3t$
7	Багануур	105	105	105	105	105	-	$MA(0): y_t = 105 + e_t$
8	Багахангай	18	19	20	21	21	0.63	$y = 1.6 + 0.9t$
9	Налайх	170	176	182	188	194	0.70	$y = 66 + 5.8t$
10	Архангай	236	244	252	259	267	0.57	$y = 97.6 + 7.7t$
11	Баян-Өлгий	168	174	181	187	194	0.69	$y = 50.6 + 6.4t$
12	Баянхонгор	315	329	343	357	371	0.86	$y = 63.4 + 14t$
13	Булган	200	206	212	218	224	0.58	$y = 70 + 1.7t$
14	Говь-Алтай	137	138	140	141	143	-	$ARIMA(0,1,0): y_t = 1.6 + y_{t-1}$
15	Говьсүмбэр	94	97	100	103	106	0.66	$y = 36 + 3.2t$
16	Дархан-Уул	334	329	326	323	322	-	$AR(1): y_t = 105 + 0.7y_{t-1}$
17	Дорноговь	160	160	160	160	160	-	$MA(0): y_t = 160 + e_t$
18	Дорнод	324	333	343	352	361	0.62	$y = 160.5 + 9.1t$
19	Дундговь	146	147	149	151	152	-	$ARIMA(0,1,0): y_t = 1.65 + y_{t-1}$
20	Завхан	174	195	217	242	267	-	$ARIMA(1,2,1): y_t = 2.2 + 2y_{t-1} - 0.43y_{t-2} - 0.8e_{t-1}$
21	Орхон	348	361	373	385	398	0.71	$y = 125 + 12.4t$
22	Өмнөговь	160	163	166	170	173	0.66	$y = 100.3 + 3.3t$
23	Өвөрхангай	193	190	188	188	187	-	$AR(1): y_t = 87 + 0.54y_{t-1}$
24	Сүхбаатар	204	212	219	227	235	0.79	$y = 61 + 7.9t$
25	Сэлэнгэ	159	144	129	114	99	-	$ARIMA(0,1,0): y_t = -15 + y_{t-1}$
26	Төв	436	453	471	489	506	0.83	$y = 119 + 17.6t$
27	Увс	172	156	156	156	156	-	$MA(1): y_t = 156 + 0.6e_{t-1}$
28	Ховд	193	185	191	187	191	-	$ARIMA(2,1,0): y_t = 0.75 - 0.22y_{t-1} + 0.42y_{t-2}$
29	Хөвсгөл	347	359	371	383	395	0.74	$y = 130.9 + 12t$
30	Хэнтий	232	214	208	206	205	-	$AR(1): y_t = 134 + 0.35y_{t-1}$
31	Замын-Үүд	127	127	127	127	127	-	$MA(0): y_t = 127 + e_t$
32	Тосонцэнгэл	73	80	87	94	101	0.91	$y = 16 + 7.1t$
33	Ханбогд	163	177	191	205	219	0.81	$y = 51.1 + 14t$
34	Хархорин	105	111	117	122	128	0.79	$y = 58.5 + 5.8t$
35	Мандал	145	145	145	145	145	-	$MA(0): y_t = 145 + e_t$
36	Сайхан	72	72	72	72	72	-	$MA(0): y_t = 72 + e_t$
37	Булган	85	94	103	112	121	0.76	$y = 14.9 + 8.8t$
38	Бор-Өндөр	69	74	79	85	143	0.74	$y = 26.3 + 5.3t$
Дүн		11579	11950	12370	12787	13267	-	-

Хүснэгт E.1 ЭХАШШ-д хянан шийдвэрлэх хэргийн тоо

№	Шүүх	2022	2023	2024	2025	2026	R	Загвар
1	Нийслэл	1212	1243	1274	1305	1336	0.78	$y = 650 + 31.2t$
2	Архангай	49	49	49	49	49	-	$MA(0): y_t = 49 + e_t$
3	Баян-Өлгий	44	42	42	42	42	-	$AR(1): y_t = 26 + 0.37y_{t-1}$
4	Баянхонгор	84	86	88	90	92	0.73	$y = 47.5 + 2t$
5	Булган	50	50	50	50	50	-	$MA(0): y_t = 50 + e_t$
6	Говь-Алтай	29	28	27	26	25	-	$ARIMA(1,1,1): y_t = -0.75 + 0.2y_{t-1} - 0.94e_{t-1}$
7	Говьсүмбэр	15	18	18	18	18	-	$MA(1): y_t = 18.2 + 0.41e_{t-1}$
8	Дархан-Уул	82	82	82	82	82	-	$MA(0): y_t = 82 + e_t$
9	Дорноговь	67	67	67	67	67	-	$MA(0): y_t = 67 + e_t$
10	Дорнод	52	52	52	52	52	-	$MA(0): y_t = 52 + e_t$
11	Дундговь	20	19	18	17	16	-	$ARIMA(0,1,1): y_t = -1.1 + y_{t-1} - 0.4e_{t-1}$
12	Завхан	20	18	16	14	12	0.77	$y = 52 - 1.8t$



13	Орхон	75	75	75	75	75	-	$MA(0): y_t = 75 + e_t$
14	Өмнөговь	66	68	69	70	72	0.42	$y = 41 + 1.4t$
15	Өвөрхангай	62	62	62	62	62	-	$MA(0): y_t = 62 + e_t$
16	Сүхбаатар	17	15	12	10	7	0.51	$y = 62 - 2.5t$
17	Сэлэнгэ	87	89	91	93	94	0.52	$y = 52.6 + 1.9t$
18	Төв	88	90	92	94	96	0.62	$y = 119 + 17.6t$
19	Увс	44	47	48	49	49	-	$AR(1): y_t = 20 + 0.6y_{t-1}$
20	Ховд	41	46	49	50	50	-	$AR(1): y_t = 28 + 0.44y_{t-1}$
21	Хөвсгөл	48	48	48	48	48	-	$MA(0): y_t = 48 + e_t$
22	Хэнтий	55	60	61	62	62	-	$AR(1): y_t = 41 + 0.34y_{t-1}$
Дүн		2307	2354	2390	2425	2456	-	-

Хүснэгт Е.2 ДЗШШ-д хянан шийдвэрлэх эрүүгийн хэргийн тоо

№	Шүүх	2022	2023	2024	2025	2026	R	Загвар
1	Баянзүрх	6461	6790	7119	7448	7777	0.92	$y = 543 + 329t$
2	Сүхбаатар	3820	3951	4082	4213	4344	0.67	$y = 1464 + 131t$
3	Чингэлтэй	3542	3702	3862	4023	4183	0.91	$y = 656.3 + 160.3t$
4	Баянгол	4500	4702	4903	5105	5306	0.91	$y = 871 + 202t$
5	Хан-Уул	4352	4555	4757	4959	5162	-	$ARIMA(0,1,0): y_t = 202 + y_{t-1}$
6	Сонгинохайрхан	4357	4569	4782	4994	5206	0.93	$y = 540 + 212t$
7	Багануур	580	613	613	613	613	-	$MA(1): y_t = 613 + 0.31e_{t-1}$
8	Багахангай	40	40	40	40	40	-	$MA(0): y_t = 40 + e_t$
9	Налайх	601	616	631	646	661	0.50	$y = 335 + 15t$
10	Архангай	860	881	902	922	943	0.69	$y = 489.6 + 20.6t$
11	Баян-Өлгий	899	920	941	962	983	0.60	$y = 521.2 + 21t$
12	Баянхонгор	924	944	963	982	1002	0.60	$y = 574 + 19.5t$
13	Булган	719	732	746	760	774	0.51	$y = 471.2 + 14t$
14	Говь-Алтай	595	608	621	634	647	0.50	$y = 360.8 + 13t$
15	Говьсүмбэр	229	229	229	229	229	-	$MA(0): y_t = 229 + e_t$
16	Дархан-Уул	1542	1575	1608	1641	1674	0.58	$y = 947.8 + 33t$
17	Дорноговь	490	557	557	557	557	-	$MA(1): y_t = 557 + 0.32e_{t-1}$
18	Дорнод	1152	1167	1182	1197	1212	0.41	$y = 882 + 15t$
19	Дундговь	595	609	622	636	650	0.55	$y = 346.3 + 13.8t$
20	Завхан	730	730	730	730	730	-	$MA(0): y_t = 730 + e_t$
21	Орхон	1496	1532	1569	1605	1641	0.81	$y = 844.5 + 36.2t$
22	Өмнөговь	502	502	502	502	502	-	$MA(0): y_t = 502 + e_t$
23	Өвөрхангай	559	567	575	583	591	-	$ARIMA(0,1,0): y_t = 7.9 + y_{t-1}$
24	Сүхбаатар	573	582	592	602	611	0.44	$y = 400 + 9.6t$
25	Сэлэнгэ	571	568	565	562	559	-	$ARIMA(0,1,0): y_t = -3.1 + y_{t-1}$
26	Төв	1362	1407	1453	1498	1544	0.70	$y = 542.7 + 45.5t$
27	Увс	807	824	840	856	873	0.55	$y = 514 + 16.3t$
28	Ховд	759	811	811	811	811	-	$MA(1): y_t = 810 + 0.44e_{t-1}$
29	Хөвсгөл	1484	1484	1484	1484	1484	-	$MA(0): y_t = 1484 + e_t$
30	Хэнтий	784	784	784	784	784	-	$MA(0): y_t = 784 + e_t$
31	Замын-Үүд	333	333	333	333	333	-	$MA(0): y_t = 33 + e_t$
32	Тосонцэнгэл	329	329	329	329	329	-	$MA(0): y_t = 329 + e_t$
33	Ханбогд	167	167	167	167	167	-	$MA(0): y_t = 167 + e_t$
34	Хархорин	426	426	426	426	426	-	$MA(0): y_t = 426 + e_t$
35	Мандал	517	543	570	597	623	0.82	$y = 304 + 26.6t$
36	Сайхан	228	224	223	223	223	-	$ARMA(1,1): y_t = 205 + 0.1y_{t-1} - 0.92e_{t-1}$
37	Булган	289	289	289	289	289	-	$MA(0): y_t = 289 + e_t$
38	Бор-Өндөр	255	255	255	255	255	-	$MA(0): y_t = 255 + e_t$
Дүн		48429	50117	51657	53197	54738	-	-

Хүснэгт Е.3 ИХАШШ-д хянан шийдвэрлэх хэргийн тоо

№	Шүүх	2022	2023	2024	2025	2026	R	Загвар
1	Нийслэл	2396	2513	2630	2747	2864	0.88	$y = 290 + 117t$
2	Архангай	20	21	22	22	23	-	$AR(1): y_t = 14.1 + 0.37y_{t-1}$
3	Баян-Өлгий	80	87	86	86	86	-	$ARMA(1,2): y_t = 44 + 0.5y_{t-1} - 0.32e_{t-1} - 0.54e_{t-2}$
4	Баянхонгор	22	21	21	21	21	-	$MA(1): y_t = 21.4 + 0.41e_{t-1}$
5	Булган	31	31	31	31	31	-	$MA(0): y_t = 31 + e_t$



6	Говь-Алтай	32	33	35	36	37	0.80	$y = 10 + 1.2t$
7	Говьсүмбэр	17	17	18	18	20	-	ARIMA(1,1,0): $y_t = 1 - 0.3y_{t-1}$
8	Дархан-Уул	145	149	153	157	161	0.56	$y = 73.2 + 4t$
9	Дорноговь	37	35	35	35	35	-	MA(1): $y_t = 34.8 - 0.54e_{t-1}$
10	Дорнод	31	30	30	30	30	-	MA(1): $y_t = 30 + 0.39e_{t-1}$
11	Дундговь	25	25	25	25	25	-	MA(0): $y_t = 25 + e_t$
12	Завхан	26	25	25	25	24	-	AR(1): $y_t = 9.1 + 0.62y_{t-1}$
13	Орхон	159	163	167	172	176	0.68	$y = 79.4 + 4.4t$
14	Өмнөговь	31	32	33	34	35	0.52	$y = 12.7 + t$
15	Өвөрхангай	28	28	28	28	28	-	MA(0): $y_t = 28 + e_t$
16	Сүхбаатар	16	16	16	16	16	-	MA(0): $y_t = 16 + e_t$
17	Сэлэнгэ	61	56	56	56	56	-	MA(1): $y_t = 56 - 0.27e_t$
18	Төв	27	27	27	27	27	-	MA(0): $y_t = 27 + e_t$
19	Увс	26	26	26	26	26	-	MA(0): $y_t = 26 + e_t$
20	Ховд	53	54	56	57	58	0.54	$y = 30 + 1.3t$
21	Хөвсгөл	30	30	30	30	30	-	MA(0): $y_t = 30 + e_t$
22	Хэнтий	26	26	26	26	26	-	MA(0): $y_t = 26 + e_t$
Дүн		3319	3445	3576	3705	3835	-	-

Хүснэгт E.4 ДЗШШ-д хянан шийдвэрлэх иргэний хэргийн тоо

№	Шүүх	2022	2023	2024	2025	2026	R	Загвар
1	Архангай	44	46	48	50	52	0.75	$y = 7.1 + 2t$
2	Баян-Өлгий	80	83	86	90	93	0.77	$y = 20.2 + 3.3t$
3	Баянхонгор	39	40	42	44	46	0.88	$y = 4.3 + 1.9t$
4	Булган	29	30	32	33	34	0.67	$y = 7.5 + 1.2t$
5	Говь-Алтай	38	40	42	44	47	0.82	$y = -1.8 + 2.2t$
6	Говьсүмбэр	15	15	16	16	17	0.49	$y = 5.8 + 0.5t$
7	Дархан-Уул	50	53	55	57	60	0.55	$y = 8.9 + 2.3t$
8	Дорноговь	28	29	30	31	32	0.71	$y = 6 + 1.2t$
9	Дорнод	32	33	34	35	36	0.57	$y = 13.7 + t$
10	Дундговь	30	32	34	36	38	0.71	$y = -4 + 1.9t$
11	Завхан	38	40	42	43	45	0.56	$y = 5.6 + 1.8t$
12	Орхон	31	32	32	32	32	-	MA(1): $y_t = 32 + 0.54e_{t-1}$
13	Өмнөговь	27	29	30	31	33	0.73	$y = 2 + 1.4t$
14	Өвөрхангай	17	18	19	20	21	-	ARIMA(0,1,0): $y_t = 0.94 + y_{t-1}$
15	Сүхбаатар	32	33	34	35	36	0.49	$y = 12.8 + t$
16	Сэлэнгэ	31	32	34	35	36	0.59	$y = 9.6 + 1.2t$
17	Төв	47	49	51	53	55	0.85	$y = 7 + 2.2t$
18	Увс	54	57	59	62	65	0.76	$y = 1.4 + 2.9t$
19	Ховд	47	50	52	55	57	0.73	$y = 2.2 + 2.5t$
20	Хөвсгөл	32	32	32	32	32	-	MA(0): $y_t = 32 + e_t$
21	Хэнтий	20	21	22	22	23	0.47	$y = 9.6 + 0.6t$
22	Нийслэл	1149	1209	1270	1331	1391	0.95	$y = 58 + 60.6t$
Дүн		1910	2003	2096	2187	2281	-	--

Хүснэгт E.5 ЗХАШШ-д хянан шийдвэрлэх хэргийн тоо

№	Шүүх	2022	2023	2024	2025	2026	R	Загвар
1	Архангай	13	14	15	16	16	0.76	$y = 0.75t$
2	Баян-Өлгий	28	29	31	32	33	0.62	$y = 8.5 + 1.1t$
3	Баянхонгор	10	11	11	12	13	0.76	$y = -0.93 + 0.6t$
4	Булган	8	8	9	9	9	0.42	$y = 2.5 + 0.3t$
5	Говь-Алтай	17	18	19	20	22	0.74	$y = -2.7 + 1.1t$
6	Говьсүмбэр	6	7	7	7	8	0.54	$y = 0.33 + 0.33t$
7	Дархан-Уул	19	20	20	21	22	0.46	$y = 4.4 + 0.8t$
8	Дорноговь	11	11	12	13	13	0.73	$y = 0.6 + t$
9	Дорнод	11	12	12	13	13	0.58	$y = 1.6 + 0.5t$
10	Дундговь	7	7	7	8	8	0.75	$y = -0.7 + 0.4t$
11	Завхан	16	17	18	19	20	0.71	$y = -1.6 + t$
12	Орхон	15	16	17	18	18	0.72	$y = 1.9 + 0.8t$
13	Өмнөговь	10	11	12	12	13	0.66	$y = -0.4 + 0.6t$
14	Өвөрхангай	6	7	7	7	7	0.73	$y = 2.9 + 0.2t$
15	Сүхбаатар	8	9	9	9	10	0.48	$y = 2.8 + 0.3t$
16	Сэлэнгэ	7	7	7	7	7	-	MA(0): $y_t = 7 + e_t$



17	Төв	16	17	18	18	19	0.65	$y = 1.5 + 0.8t$
18	Увс	18	19	20	21	22	0.74	$y = -2 + 1.1t$
19	Ховд	17	18	19	20	21	0.69	$y = -1.2 + t$
20	Хөвсгөл	11	11	11	11	11	-	MA(0): $y_t = 11 + e_t$
21	Хэнтий	4	4	4	4	4	-	MA(0): $y_t = 4 + e_t$
22	Нийслэл	567	599	631	663	695	0.91	$y = -8.7 + 32t$
Дүн		825	872	916	960	1004	-	--

Хүснэгт E.6 ЗХДЗШШ-д анхан шатны шүүхийн шийдвэрийг хянан шийдвэрлэх хэргийн тоо

Тайлбар: AR, MA, ARIMA, ARMA процессууд нь хугацааны цуваан дээр хийгддэг Эконометрикийн тусгай загварууд юм. Хугацаанаас хамаарсан шугаман, илтгэгч, парабол зэрэг энгийн загвараар илэрхийлэгдэх боломжгүй төвөгтэй процессыг эдгээр эконометрикийн загварын тусламжтай загварчилж прогнозын утгыг тодорхойлно. Анхан шатны мэдлэггүй, өөр салбарын хүмүүсийн хувьд загварын хэлбэрт анхаарах шаардлагагүй бөгөөд зөвхөн прогнозын утгыг ашиглахад хангалттай.

Гэсэн хэдий ч загварт орсон зарим нэг тэмдэглэгээг тайлбарлая. Үүнд: y_{t-1} — өмнөх оны хэргийн тоо, e_t — цагаан шуугианы алдаа, t — хугацаа, c — тогтмол тоо.